


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

# СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ



## ТОЙМ АГУУЛГА

- Эдийн засаг
- Нийгэм
- Эрх зүй, төрийн байгуулал

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“Судалгааны эмхэтгэл” (ХХҮІ боть)- ийг  
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Б.Эрдэнэбилэгт (Ph.D)  
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш



## ГАРЧИГ

### I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

1.1	Гадаадын зарим орны мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчин .....	6
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Д.Халиун, Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа</i>	
1.2	Хог хаягдлыг дахин боловсруулах, нүүрс баяжуулах үйлдвэрлэл болон Улаанбаатар хотын авто зам, давхар зам, метро барих асуудлын талаарх мэдээлэл .....	20
	<i>Ц.Болормаа, И.Жаргалзаяабямба, Б.Нандингэрэл</i>	
1.3	Худалдааны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага .....	46
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа</i>	

### II БҮЛЭГ. НИЙГЭМ

2.1	Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа .....	106
	<i>Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа</i>	
2.2	Их сургуулийн эрх зүйн зохицуулалтын талаарх бусад орнуудын туршлага .....	153
	<i>Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа</i>	
2.3	Багшийн хөгжил, багшийн мэргэжилд тавигдах шаардлага, стандарт, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн үнэлгээний талаарх эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын туршлага .....	179
	<i>Ц.Норовдондог (Ph.D), И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа</i>	
2.4	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмч, эрүүл мэндийн ажилтны нэр төрд халдах асуудлын талаарх бусад орнуудын эрх зүйн зохицуулалт, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ .....	207
	<i>Г.Алтан-Оч (Ph.D), Р.Оргилмаа</i>	
2.5	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх: онолын үндэслэл, бусад орнуудын туршлага .....	216
	<i>Ц.Болормаа</i>	

### III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

3.1	Гадаадын зарим орны Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт .....	242
	<i>Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл, Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа</i>	
3.2	Зарим улсын хотын Мэрийн эрх зүйн статус ба хотын бондын эрх зүйн орчны талаарх лавлагаа .....	263
	<i>Д.Халиун, Ц.Болормаа, Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа</i>	

3.3	Парламентын гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт: бусад орнуудын туршлага .....	272
	<i>Г.Билгээ, Ц.Болормаа, Д.Халиун</i>	
3.4	Гадаадын зарим орны Үндсэн хуульд яамдын нэрийг нэрлэн заадаг эсэх, Ерөнхий сайдын яам байгуулах эрх болон төрийн албаны төв байгууллагын талаарх зохицуулалт .....	299
	<i>Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ Д.Жигваагүнсэл, Д.Халиун</i>	

# 1 БҮЛЭГ

---

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл,  
Ц.Элбэгзаяа*

### АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН

НЭГ. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛС ОРНУУДЫН МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН  
ОРЧИН

ХОЁР. ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД ХЯЗГААР ТОГТООХ

ГУРАВ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ МЕХАНИЗМ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд зээлийн хүүгийн хувийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй улс орнуудын хууль эрх зүйн орчныг судалсан болно. Үүнд мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалт, зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон байдал, хариуцлага тооцох механизм зэргийг Европын холбооны гишүүн орнуудын хүрээнд нарийвчлан судаллаа.

Хууль зүйн ойлголтын хувьд “мөнгө хүүлэх” гэсэн нэр томъёог улс орон бүрт харилцан адилгүй байдлаар авч үзэж байгаа боловч ерөнхий ойлголтын хувьд авч үзвэл бусдын хэрэгцээ шаардлага, мэдлэг туршлагагүй, сул дорой байдлыг урвуулан ашиглаж хувь тэнцүү биш, хэт их, эсхүл шударга бус ашиг олох үйлдэл хэмээн ойлгож байна. Хүүлэлтийн эсрэг буюу anti-usury<sup>1</sup> хууль тогтоомж нь гол төлөв хэт өндөр зээлийн хүүг хязгаарлах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байдаг байна.

Дэлхийн банк, Европын холбооны судалгааны байгууллагуудаас гаргасан судалгааны тайланд дэлхийн 76 улс зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон тухай дурьджээ. Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох эрх бүхий субъектын хувьд дийлэнх орнуудад Төв банк нь тус эрхийг эдэлж байгаа бол цөөн тохиолдолд шүүх, хууль тогтоох дээд байгууллага, эсхүл Сангийн сайд нь хүүгийн дээд хэмжээг тогтоодог байна. Дийлэнх улс орнуудын хувьд бодит хүүгийн хувь, эсхүл жилийн хүүгийн хувиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож, түүнд шимтгэл, хураамжийг оруулан тооцдог бол цөөн хэдэн оронд нэрлэсэн хүүгийн хувиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоодог байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож буй аргачлалын хувьд 24 улсад үнэмлэхүй дээд хязгаар буюу тогтмол нэрлэсэн хувь хэмжээ (absolute ceilings)-г тогтоосон бол 32 улсад харьцангуй хязгаартай (relative ceilings) хүүгийн дээд хэмжээг зах зээлийн дундаж хүү, эсхүл хүүгийн суурь түвшин зэрэг хувьсах хэмжигдэхүүнтэй уялдуулан тогтоосон байна. Дийлэнх улс орнуудын хувьд хүүгийн дээд хэмжээг зээлийн дүн, төрөл, хугацаа зэргээс хамааран ялгаатай байдлаар тогтоож байна.

Европын Холбооны гишүүн орнуудын хувьд хүүгийн хэмжээг тодорхой байдлаар хязгаарлаж дээд хэмжээг тогтоосон. Хүүгийн дээд хэмжээний хувь хэмжээ нь хэлбэлзэл өндөртэй байна. Тухайлбал, Франц Улсын хувьд зээлийн төрлөөс хамаарч хүүгийн дээд хэмжээ 5,72- 21,63 хувийн хооронд, Словени Улсад зээлийн хэмжээ болон хугацаанаас хамаарч зээлийн хүүгийн дээд хэмжээ 13,2-453 хувийн хооронд тус тус хэлбэлзэж байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосноор зарим улсад сөрөг үр дагавар ажиглагдаж байгаа бол АНУ-д хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хүү буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж холбогдох судалгааны тайлангуудад дурьджээ. Тухайлбал;

- Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын хувьд зарим санхүүгийн байгууллагууд нь зээлдэгчийн амь насны даатгал, болон бусад үйлчилгээгээр дамжуулан зээлийн нийт өртгийг тооцох, ил тод байдлыг хангах боломжийг бууруулсан;
- Баруун Африкийн Эдийн засаг, мөнгөний холбооны гишүүн улс орнууд<sup>2</sup>-ын хувьд бичил санхүүгийн зээлд зээлийн хүүгийн дээд хэмжээг доогуур тогтоосноос болж буурай, алслагдмал бүсийн бичил санхүүгийн байгууллагууд уг сегментээс гарах, санхүүгийн байгууллагууд нь эргэлтээ нэмэгдүүлэх зорилгоор зээлийн дундаж хэмжээгээ нэмэгдүүлэх болсон;

a

<sup>1</sup> "usury" West's Encyclopedia of American Law, edition 2. 2008. The Gale Group 9 Oct. 2017 <https://legal-dictionary.thefreedictionary.com/usury>

<sup>2</sup> WAEMU (West Africa Economic and Monetary Union) Баруун Африкийн эдийн засаг, мөнгөний холбооны гишүүн орнууд: Бенин, Буркина Фасо, Кот Д'Ивуар, Гвиней Бисау, Мали, Нигер, Сенегал, Того.

- Зээлийн хүүгийн дээд хэмжээг доогуур тогтоосноос зээл олголт буурч, улмаар хууль бус зээлийн үйл ажиллагаа нэмэгдсэн (Япон болон АНУ);
- Боливи Улсад 2004 онд зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосноор шинээр байгуулагдах санхүүгийн байгууллагын тоо цөөрсөн;
- Армен Улсад зээлийн хүүг тооцох аргачлалыг нарийвчлан тогтоогоогүйгээс нэмэлт шимтгэл, хураамж хэлбэрээр зээлийн өртгийг нэмэгдүүлж, ил тод байдлыг бууруулсан (Армен, Никарагуа, Өмнөд Африк);
- Орлого багатай иргэдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүний төрөл багасах хандлагатай болсон (Франц, Герман);
- Харин АНУ-д хүүгийн дээд хэмжээг тогтоосноор хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хүү буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж тус тус дүгнэжээ.

Холбогдох судалгааны байгууллагуудаас хүүгийн дээд хэмжээг тогтоох тохиолдолд зээлийн хүүгийн хувь хэмжээг урт хугацаанд бууруулахад чиглэсэн дараах арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж дүгнэжээ. Эдгээр нь, санхүүгийн хэрэглэгчдийг хамгаалах, санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөн болон бүтээгдэхүүний шинэчлэлийг дэмжих, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, зээлийн хүүгийн мэдээллийг ил тод болгох, бичил зээлийн бүтээгдэхүүнийг дэмжих зэрэг юм.



## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

Зээлийн хүүгийн дээд хэмжээг Дэлхийн банкны бүс нутгийн 152 орны 40 хувь буюу 61 улсад тогтоосон зохицуулалт байгаа бол дэлхийн 76 улс зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон гэж Дэлхийн банк болон холбогдох судалгааны байгууллагуудаас гаргасан тайланд<sup>3</sup> дурьджээ. Зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож буй орнуудын дийлэнхийг Дэд Сахарын Африк болон Латин Америк, Карибын орнууд эзэлж байна. Хүүгийн дээд хэмжээг тогтоож буй улс орнуудын жагсаалтыг Хүснэгт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 1. Хүүгийн дээд хэмжээг тогтоож буй улс орнууд, бүс нутгаар

Дэд Сахарын Африк <sup>4</sup>	Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Европ болон төв Ази	Латин Америк болон Карибын орнууд	Ойрх дорнод, хойд Африкийн орнууд	Өмнөд Ази	Баруун Европ	Бусад
Эритри Этиоп Гана Гвиней Мавритани Намиби Нигери ӨАБНУ Судан Замби WAEMU* CEMAC*	БНХАУ Япон Лаос Мьянмар Филиппин Тайланд Вьетнам	Армен Эстони Киргиз Польш Словак Словени Турк	Аргентин Боливи Бразил Чили Колумби Эквадор Гватемал Гондурас Никарагуа Доминикан Уругвай Венесуэль	Алжир Египет Ливи Мальт Сири Тунис	Бангладеш Энэтхэг Пакистан	Бельги Франц Герман Грек Ирланд Итали Нидерланд Португал Испани Швейцар Их Британи	Австрали Багамын арлууд Канад АНУ

\*WAEMU (West Africa Economic and Monetary Union) Баруун Африкийн эдийн засаг, мөнгөний холбоо – Бенин, Буркина-Фасо, Кот Д'Ивуар, Гвиней Бисау, Мали, Нигер, Сенегал, Того.

\*CEMAC (The Economic and Monetary Community of Central Africa) Төв Африкийн эдийн засаг, мөнгөний хамтын нийгэмлэг - Камерун, Төв Африкийн БНУ, Чад, Конго, Экваторын Гвиней, Габон.

## НЭГ. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛС ОРНУУДЫН МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчныг Европын Холбооны гишүүн орнуудын хүрээнд нарийвчлан авч үзвэл мөнгө хүүлэлт нь хууль зүйн ухагдахууны хувьд 21 орны эрүү, иргэний хууль тогтоомжид тусгасан байна.

1. Дани, Финланд, Латви, Румын, Словени, Мальта - Эрүүгийн хуулиар;
2. Эстони, Франц, Унгар, Болгар, Испани - Иргэний хууль тогтоомжоор;
3. Чех, Бельги, Австри, Герман, Грек, Португал, Словак, Польш, Швед, Итали - эрүү болон иргэний хууль тогтоомждоо оруулсан байна.

Хууль зүйн ойлголтын хувьд “мөнгө хүүлэх” гэсэн нэр томъёог улс орон бүрт харилцан адилгүй байдлаар хэрэглэж байгаа боловч ерөнхий ойлголтын хувьд бусдын хэрэгцээ шаардлага, мэдлэг туршлагагүй, сул дорой байдлыг урвуулан ашиглаж хувь тэнцүү биш, хэт

а\_\_\_\_\_

<sup>3</sup> Interest Rate Caps around the World: Still Popular, but a Blunt Instrument, Samuel Munzele Maimbo and Claudia Alejandra Henriquez Gallegos, World Bank Group October 2014

ff/ZEW (2010): Study on interest rate restrictions in the EU, Final Report for the EU Commission DG Internal Market and Services, Project No. ETD/2009/IM/H3/87, Brussels/Hamburg/Mannheim.

<sup>4</sup> List of Sub-Saharan African Countries, <https://www.loc.gov/rr/amed/guide/afr-countrylist.html>

их, эсхүл шударга бус ашиг олох үйлдэл хэмээн ойлгож байна. Тухайлбал, Люксембургийн хууль тогтоомжид мөнгө хүүлэх гэх нэр томъёог тусгайлан томъёолоогүй боловч иргэний болон эрүүгийн хуулиудад зээлдэгчийн сул талыг ашиглан хэт өндөр хүү тогтоохыг хориглосон бол Испанийн хууль тогтоомжид мөнгө хүүлэхийг хориглосон боловч тухайн асуудлыг тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна.

Мөн Эрүүгийн хуулиудад мөнгө хүүлэх гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага харилцан адилгүй байна. Тухайлбал, Австри Улсын хууль тогтоомжоор мөнгө хүүлэхэд 3 хүртэл жилээр хорих бол Латви Улсад 5 хүртэл жилээр хорих, албадан ажил хийлгэх, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй мөнгөн торгууль оногдуулах зэргээр зохицуулсан байна. Практикт мөнгө хүүлэлтийн эсрэг хууль тогтоомжууд тэр бүр үр дүнтэй байгаагүй ба үүний нэг жишээ нь Дани Улс юм. Данийн шүүхийн практикт зөвхөн онцгой өндөр хүү тогтоосон тохиолдлуудыг мөнгө хүүлэхэд тооцон шийдвэрлэдэг байна.

Эрүүгийн хуулиас гадна Иргэний хуульд тусгасан зохицуулалтууд нь улс орнуудын хувьд мөн харилцан адилгүй байна. Зарим орнуудын хувьд хэт өндөр хүүтэй гэрээг бүхэлд нь хүчингүйд тооцох (Унгар) бол зарим нь зөвхөн хүүгийн хэмжээг бууруулах (Люксембург) зохицуулалтыг тусгасан байна.

Дотоодын хууль тогтоомждоо мөнгө хүүлэх нэр томъёог тусгахаас гадна Европын холбооны цөөн тооны гишүүн орнууд өөрсдийн нутаг дэвсгэр дээр илүү түгээмэл хэрэглэгдэх "sub-prime", "last resort loans", "fringe lending" гэх нэр томъёонуудыг мөн тусгасан байна.

Бельгид "sub-prime" зээл буюу хамгаалалттай зээлийг "орлого нь зээлээ төлөхөд хүрэлцэхгүй байгаа боловч түүний үл хөдлөх хөрөнгийн үнээр тооцон үнэлж өсгөөд зээл олгох зөвшөөрлийг өгөх гэж тодорхойлсон".

Румынд үндсэн хэрэглээний зээл гэдэг нь үндсэн хэрэглээний эд зүйл худалдан авахад зориулсан зээл бөгөөд мөнгө зээлдүүлэгчдийг хуулиар тогтоосон хувь хэмжээнээс өндөр хүүтэй зээл санал болгогч нар гэжээ.

Мөнгө зээлдүүлэгч нарын тухай хуулийн тодорхойлолтууд Болгар, Ирланд, Польш, Испани улсуудад байдаг.

Их Британид зах зээлийн судалгаа хийх, тэдгээр зах зээлд мөнгө зээлдүүлэгч нарт /гарын авлага/ заавар, журам тогтоосон хуулийн зохицуулалтад "sub prime" ба "non status" гэх нэр томъёонуудыг хэрэглэсэн байна.

Хүснэгт 2. Европын холбооны улс орнуудын мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалт

Улс	Нэрлэсэн байдал	Хэрэглэсэн байдал	Зээлийн хүүгийн дээд хэмжээг хуульд тусгасан эсэх	Бусад
Австри	Wucher	Иргэний хуулийн 879-р зүйл Эрүүгийн хуулийн 154,155-р зүйл, Мөнгө хүүлэлтийн эсрэг хуулийн 1-р зүйл	Үгүй	
Бельги	Woeker	Эрүүгийн хуулийн 494-р зүйл	Үгүй	
Болгар	Лихварство	Гэрээний болон үүргийн хуулийн 10.3-р зүйл	Үгүй	
Кипр	Tokoglifia	-	Үгүй	
Чех	Lichva	Иргэний хуулийн 3-р хэсэг Эрүүгийн хууль 40-2009	Дундаж хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх	Шүүхийн тайлбараар тогтоосон

Дани	Ager	-	Үгүй	
Эстони	Liigkasuvotmine	Иргэний хууль “ёс зүйн зохист хэмжээ”	Үгүй	
Финланд	Kiskominen	Эрүүгийн хууль	Үгүй	
Франц	Usure	Хэрэглэгчийн тухай хууль	Үгүй	
Герман	Wucher	Иргэний хуулийн 138, Эрүүгийн хуулийн 291	ёс зүйн зохист хэмжээ, дундаж хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх	
Грек	Tokoglifia	Эрүүгийн хуулийн 404-р зүйл	Үгүй	
Унгар	Uzsorokamat	-	Үгүй	
Ирланд	Excessive	Хэрэглээний зээлийн тухай хуулийн 45-р хэсэг “хэт өндөр”	Үгүй	
Итали	Usura	Эрүүгийн хуулийн 644-р зүйл	Үгүй	
Латви	Auglosana	Эрүүгийн хуулийн 201-р зүйл	Үгүй	
Литва	Lupikavimas	-	Үгүй	
Люксембург	usure	Иргэний хуулийн 1907-р зүйл, Эрүүгийн хуулийн 494-р зүйл, Иргэний хуулийн 1154-р зүйл (Анатоцизм/ нийлмэл хүү)	Үгүй	Шүүх хүүгийн хэмжээг бууруулах эрх хэмжээтэй
Мальт	Usury	Хууль бусад тооцох боловч мэргэжлийн байгууллагуудад хамараахгүй зохицуулалт олонтой	Үгүй	
Нидерланд	Woekeraar	Эрүүгийн хуулиар хориглосон	Үгүй	
Польш	Lichwa	-	Үгүй	
Португал	Usura	Иргэний хуулийн 282-р зүйл, Эрүүгийн хуулийн 226-р зүйл	Үгүй	
Румын	Camatarie	Эрүүгийн хуулийн 28-р зүйл	Үгүй	
Словак	Urok	Эрүүгийн хуулийн 235-р зүйл	Жилийн 30 хувь	
Словени	Oderustvo	Үүргийн тухай хуулийн 119-р зүйл, Эрүүгийн хуулийн 214-р зүйл	Үгүй	
Испани	Usura	Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль	Хэрэглээний зээлийн тухай хуулийн 19-р зүйл хуулиар “овердрафт зээлд -тогтоосон хүүгийн хэмжээнээс 2.5 дахин нэмэгдүүлсэн”	
Швед	Ockret	Гэрээний тухай хуулийн 31-р хэсэг	Үгүй	
Их Британи	Usury unfair	Хэт өндөр буюу үлэмж хэмжээний хүү	Үгүй	

**Австри.** Иргэний хуулийн 879-р зүйл, Эрүүгийн хуулийн 154-155-р зүйл, Мөнгө хүүлэлтийн эсрэг хуулийн нэгдүгээр зүйлээр тус тус зохицуулсан. Хувь хүний туршлагагүй, болгоомжгүй байдал, санхүүгийн хүндрэлтэй байдлыг ашиглан ердийн хэмжээнээс илүүгээр ашиг олохыг мөнгө хүүлэх гэж тайлбарласан.

**Бельги.** 1935 оноос Иргэний хуулиараа зохицуулж эхэлсэн. Энэхүү зохицуулалтыг зөрчсөнөөр гэрээгээр тогтоосон хүүг хуулиар тогтоосон хүүгийн хэмжээнд хүргэж шийдвэрлэх зохицуулалттай. Мөнгө хүүлэлт нь Эрүүгийн хуулийн 494-р зүйлээр хариуцлага хүлээхээр зохицуулсан. Хүүгийн дээд хэмжээг Иргэний хуулийн 1907-р зүйлээр тогтоосон ба бүх

төрлийн зээлийн хувьд санхүүгийн хараат этгээдийн эсрэг болон хэт өндөр хүүг мөнгө хүүлэх ойлголтод хамаарахаар заасан. Хэрэглээний зээлийн хуульд хуулиар тогтоосон хэмжээнээс дээгүүр хүүг төлөхгүй байж болохоор заасан байна.

**Болгар.** Үүрэг ба гэрээний тухай хуулийн 10 (3)-р зүйлээр мөнгө хүүлэлтийг хориглосон ба нэмэгдүүлсэн хүүг Төв банкнаас тогтоосон хүүгийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар зохицуулсан. Худалдааны тухай хуулийн 294-р зүйлд заасны дагуу нийлмэл хүүг арилжааны байгууллагууд хоорондоо хэрэглэж болохоор заасан.

**Кипр.** Мөнгө хүүлэлтийг 2011 онд Эрүүгийн хуулиар хориглосон ба зээлийн хүү нь Төв банкнаас тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

**Чех.** Мөнгө хүүлэлтийг тухайн харилцаанаас олж буй ашиг орлого нь хүлээж буй үүрэгтэй харилцан тохиромжгүй тохиолдлууд буюу ерөнхийдөө өндөр хүүтэй зээлийг ойлгодог. 2003 оны Дээд шүүхийн тайлбараар мөнгө хүүлэх гэрээ гэдэгт гэрээний нөгөө талаасаа хамааралтай, оюун ухааны хувьд сул дорой этгээдтэй, мөн хувь хүний туршлагагүй байдал зэргийг урвуугаар ашиглан гэрээгээр хүлээсэн үүрэг нь харилцан адилгүй буюу эрс ялгаа бүхий үүргийг гүйцэтгэхээр амласан, үүрэг хүлээхээр заасан гэрээг хамруулахаар тайлбарласан байна. Иргэний хууль дахь мөнгө хүүлэлтийн гэрээ нь гэрээний нэг тал нь дээр дурдсан нөхцөл байдлаар байгуулсан гэдгийг нөгөө тал нь мэдэж байсан, мэдэх боломжтой байсан гэрээг хамруулахаар заажээ. Энэ тохиолдолд гэрээг хүчингүйд тооцохоор заасан байна. 2004 оны Дээд шүүхийн тайлбараар зээлийн хүүгийн хэмжээг ёс зүйн зохист хэмжээтэй холбон үзсэн буюу тухайн зээлийн төрөлд арилжааны банкнуудаас тогтоосон ердийн хүүгийн хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн хэмжээг хууль бусад тооцож гэрээг хүчингүй гэж үзэхээр тогтоосон байна. Мөнгө хүүлэх асуудлыг эрүүгийн хуульд мөн тусгасан ба аливаа этгээд нь харилцан адилгүй буюу эрс ялгаа бүхий үүргийг амласан, үүрэг хүлээхээр заасан.

**Дани.** Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохоор заасан ба сүүлийн жилүүдэд мөнгө хүүлэлт гэх ойлголт дор өндөр хүүг ерөнхийлөн нэрлэх хандлага нэмэгдсэн.

**Эстони.** Тус улсад мөнгө хүүлэх нэр томъёог хуульчилсан, томъёолсон эрх зүйн зохицуулалт байхгүй боловч нийгэмд амар хялбар аргаар (гар утас, интернет гм.) зээл олгож, зээлийн хүүг ёс зүйн зохист хэмжээнээс хэтэрсэнийг мөнгө хүүлэлт гэж ойлгож байна. Хууль эрх зүйн хувьд дээрх нь Иргэний хууль дахь сайн ёс суртахууны зарчимд хамаарах юм.

**Финланд.** Ерөнхийдөө хувь хүний сул дорой хүнд нөхцөл байдлыг ашиглахыг ойлгодог. Зээлийн хэт өндөр хүүг Эрүүгийн хуульд тусгасан. Зээлдэгчийн сул дорой нөхцөл байдлыг ашиглан өндөр хүү авах, эсхүл зээлдүүлэгчийн гаргаж буй эрсдэл, зардалтай тохироогүй өндөр хүү тогтоохыг мөнгө хүүлэлт гэж томъёолдог байна.

**Франц.** Хэт өндөр хүүг ойлгодог. Зээлийн гэрээгээр олгож буй зээлийн жилийн хүүгийн хувь нь зээлийн байгууллагуудаас ижил төстэй эрсдэл бүхий төрлийн зээлд сүүлийн 3 сард олгосон хүүний дунджаас гуравны нэгээс дээших хувийг мөнгө хүүлэлтээр тооцно (Хэрэглэгчийн тухай хуулийн L313-3).

**Герман.** Мөнгө хүүлэлт нь Иргэний хуулийн 138-р зүйлд ёс зүйн зохист хэмжээг зөрчих гэсэн томъёоллоор илэрхийлэгдсэн.

1. Нийтийн бодлого, ёс суртахууны эсрэг аливаа хэлцэл, мөнгөн шилжүүлэг зэрэг нь хүчингүй байна.

2. Хэн нэгний хүндрэл бэрхшээлтэй, туршлагагүй, сул дорой нөхцөл байдлыг ашиглан түүнийг, эсхүл гуравдагч этгээдийг авч буй үр ашигтай нь илтэд үл тохирох аливаа үйлдэл хийлгэх, хийлгэхээр амлалт авах, өөртөө мөнгө болон санхүүгийн ашиг олж авах нь хориотой.

Эрүүгийн хуулийн 291-р зүйл. Бусдын хүндрэл бэрхшээл, туршлага дутмаг байдал, эрүүл бус, байдлыг ашиглан, материаллаг ашиг өөрт нь, эсхүл бусад этгээдэд олгогдохоор эсхүл тийм төрлийн амлалтыг орон байрны түрээс, эсхүл түүнтэй холбоотой бусад үйлчилгээний замаар, зээл олгох замаар, бусад төрлийн үйлчилгээний замаар, эсхүл дээр дурьдсан үйлчилгээ нь үзүүлж буй үйлчилгээний өртөг, олж авч буй ашигтай нь илтэд үл дүйцэж байвал 3 жил хүртэлх хугацаагаар хорих буюу торгууль ногдуулна.

**Грек.** Мөнгө хүүлэлтийн асуудлыг зохицуулахдаа Германы зохицуулалтыг суурь болгон Эрүүгийн хуулийн 404-р зүйлд авч хэрэглэсэн.

**Унгар.** Мөнгө хүүлэлтийг бусдын нөхцөл байдлыг урвуулан ашиглан хэт өндөр ашиг олохыг хэлдэг.

**Ирланд.** 1995 оны хэрэглээний зээлийн тухай хуульд хэт өндөр гэсэн байдлаар томъёолсон байх боловч энэ нь тус хуулийн дагуу зээлийн байгууллагуудад үйлчилдэггүй байна.

**Итали.** Мөнгө хүүлэлт нь өндөр хүүтэйгээр мөнгө зээлэхийг ойлгодог. Иргэний хуульд мөнгө хүүлэх гэдгийг тодорхойлж өгөөгүй ч *userious interest* буюу “хүүлэлтийн хүү” гэдэг ойлголтыг тусгасан байдаг. Эрүүгийн хуулиар өндөр хүү авах, авахаар амлалт авах, эсхүл бусад ямарваа нэгэн ашиг хонжоог ийм замаар олсныг хариуцлага хүлээлгэхээр заасан. Хууль бус хүү “*usura impropria*”-нээс бусад хүүлэлтийн хүүг хуулиар тогтооно гэж заасан. Шүүхээс зээлдэгч эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй, эсхүл зайлшгүй шаардлагатай үед нь олгосон зээлийн хүү нь тухайн нөхцөл байдалтай үл дүйцэхүйц байна гэж үзвэл мөнгө хүүлэлтэд тооцож болдог. Банк, эсхүл бусад санхүүгийн зуучлагчдын хувьд мөнгө хүүлэлтэд ногдуулах хариуцлага нь илүү чанга байдаг.

**Латви.** Ямар ч төрөл, хэлбэрийн зээл авсан үед зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг мэдсээр байж зээлийн хүүтэй харьцуулсны дүнд зээлдэгчид хэт өндөр санхүүгийн дарамт үүсгэсэн гэж үзвэл мөнгө хүүлэх гэж үзнэ. Эрүүгийн хуулийн 201-р зүйлд зааснаар 5 жил хүртэл хорих, баривчлах, албадан ажил хийлгэх, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох санкцтай байдаг.

**Литва.** Хуулиар зохицуулаагүй бөгөөд ямар нэгэн хязгаарлалт байдаггүй.

**Люксембург.** Иргэний хуульд зааснаар шүүхээс зээлдүүлэгч нь зээлдэгчийн туршлагагүй байдлыг ашиглан өөрийн гаргаж буй эрсдэлтэй харьцуулахад хэт өндөр хүү болон бусад илт өндөр ашиг орлого олохоор байна гэж үзвэл гэрээний хүүг хуулиар тогтоосон хэмжээнд буулгаж, шийдвэрлэх боломжтой. Эрүүгийн хуулиар 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл 500-25000 евро хүртэл торгох санкцтай. Банкнаас бусад этгээд нь нэг жил хүртэлх хугацааны зээлд нийлмэл хүү тооцохыг хориглодог.

**Мальт.** Хууль бус үйлдэлд тооцдог боловч банк, зээлийн байгууллагууд болон тодорхой бүтээгдэхүүний төрөлд хуулиар олон хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлдэг байна. Мөнгө хүүлэлтийг ихэвчлэн мэргэжлийн бус байгууллагууд хувь хүмүүсийн хүнд нөхцөл байдлыг (мөрийтэй тоглоомонд донтогсод, хар тамхи хэрэглэгчид) урвуу ашиглахыг ойлгодог.

**Нидерланд.** Зээлийн байгууллагууд (мэргэжлийн зээлдэгчид) нь тусгай зөвшөөрлийн үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг, хуулиар зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож өгсөн байдаг.

**Польш.** Зээлийн байгууллагууд төдийгүй хувь хүмүүсийн хооронд мөнгө хүүлэхийг хориглосон байна.

**Португал.** Нэг талаас хуулиар тогтоосон хэмжээнээс хэтэрсэн зээлийн хүүг мөнгө хүүлэх, нөгөө талаас хувь хүний тухайн үеийн нөхцөл байдлыг ашиглан, /туршлагагүй байдал, сэтгэцийн өвчтэй гэх мэт/ шударга бусаар өндөр ашиг орлого олох, өгөхөөр амлалт авах



талаарх гэрээ нь хүчингүй бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

**Румын.** Ерөнхийдөө зах зээлийн ханшнаас дээгүүр хүү тогтоохыг үздэг. Эрүүгийн хуулийн 450-р зүйлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй буюу эрх бүхий бус этгээд өнгөлөн далдлах замаар хуулиар тогтоосон хэмжээнээс дээгүүр хүүтэй зээл олгосон, нэг жилээс дооших хугацааны зээлд хүүгийн капиталжуулалт тогтоосон бол эрүүгийн хариуцлага хүлээнэ. Нийлмэл хүүг мөн мөнгө хүүлэлтийн төрөлд хамруулж үздэг байна.

**Словак.** Эрүүгийн хуулийн 235-р зүйлээр бусдын хүндрэлтэй нөхцөл байдлыг ашиглан, 2 талын харилцан гүйцэтгэж буй үүрэг нь гэрээний зүйлтэй харьцуулахад эрс зөрүүтэй үл дүйцэх нөхцөлд мөнгө хүүлэлтээр тооцдог. Мөн дээрх шаардлага, шаардах эрхийг шилжүүлж авсан этгээдэд мөн хариуцлага тооцдог. Хууль зүйн сайдын шийдвэрээр зээлийн хүүг оролцуулан жилийн 30 хувиас дээш хэмжээгээр төлөх аливаа зээлийг мөнгө хүүлэх гэж ойлгоно.

**Словени.** Иргэний хуульд 119-р зүйлд зааснаар хэн нэгний санхүүгийн хувьд яаралтай шаардлагатай, хүндрэлтэй нөхцөл байдлыг /яаралтай хэрэгцээ гарсан, орон байргүй, туршлагагүй, мэдлэггүй/ нь ашиглан өөрийн гүйцэтгэж буй үүрэгтэй харьцуулахад илэрхий өндөр ашиг олох хэмжээгээр хүү болон үнэ тогтоосон нөхцөлийг хамруулдаг.

**Испани.** Мөнгө хүүлэлтийн эсрэг хуульд зааснаар хүүгийн хэмжээг зөвшөөрөн гэрээ байгуулах нь чөлөөтэй зүйл боловч гэрээгээр тогтоосон хүү болон хууль тогтоомжоор тогтоосон хүүгийн хувь хэмжээ хоорондын харилцаа, зах зээлийн ханш гэх мэт олон зүйлийг харгалзан тогтоох ёстой. Харин хүний зайлшгүй шаардлагатай хэрэгцээт үеийг далимдуулан өндөр хүү тогтоосон бол тухайн гэрээг хүчингүйд тооцно.

**Швед.** Эрүүгийн хуулиар хэн нэгэн этгээд зээл олгох үйл ажиллагаа эрхлэхдээ болон бусад тогтмол үйл ажиллагаа явуулахдаа өөрийн гүйцэтгэж буй үүрэгтэй харьцуулахад үл дүйцэх их хэмжээний хүү ногдуулах болон бусад санхүүгийн ашиг орлого олсон бол хариуцлага хүлээнэ. Ноцтой гэмт хэрэгт 6 сараас 4 жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулдаг.

**Их Британи.** Хуулиар тодорхой зохицуулаагүй, ямарваа нэгэн хариуцлага байхгүй боловч Хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож өгсөн. Шүүхээс хэрэглээний зээлийн гэрээний хэрэг маргааныг шийдвэрлэхдээ зээлдүүлэгч, зээлдэгчийн хооронд шударга бус нөхцөл байдал байна гэж үзвэл хүүг буулган шийдвэрлэх бүрэн эрхтэй байдаг.

## **ХОЁР. ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД ХЯЗГААР ТОГТООХ (IRR)<sup>5</sup>**

Европын холбооны гишүүн 13 орны хувьд ердийн зээлийн гэрээгээр зээлийн хүүгийн боломжит төлбөрийн хэмжээг хязгаарладаггүй бол 14 оронд зарим нэг хэлбэрийн хүүгийн хязгаарлалтыг хүүгийн тааз (дээд хэмжээ) хэлбэрээр тогтоосон байдаг. Эдгээр орнуудаас 3 оронд үнэмлэхүй дээд хязгаар буюу тогтмол нэрлэсэн хувь хэмжээ (absolute ceilings)-г тогтоосон бол 11 оронд харьцангуй хязгаартай (relative ceilings) таазыг зах зээлийн дундаж хүү, эсхүл хүүгийн суурь түвшин зэрэг хувьсах хэмжигдэхүүнтэй уялдуулан тогтоодог байна. Харин Эстони, Герман зэрэг орнуудад зөвхөн де факто дээд хэмжээг хэрэглэж байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг Төв банк, төрийн захиргааны төв байгууллага, хууль тогтоох байгууллага болон шүүх байгууллагууд дангаар болон хамтран тогтоож болдог. Жишээ нь Итали, Португал, Мальта Улсад хүүгийн таазыг хууль тогтоох байгууллага тогтоодог бол Франц, Бельги, Польш Улсад Төв банк нь ийм эрхтэй байдаг. Мөн Грек, Испани Улсад Төв банк нь хууль ёсны зээлийн хүүгийн хязгаарлалтад суурилсан хүүгийн хувь хэмжээг тогтоодог үндсэн институци юм. Болгар, Ирланд Улсад Засгийн газар болон төрийн захиргааны

a\_\_\_\_\_

<sup>5</sup> Interest rate restriction

байгууллага хүүгийн таазыг тогтоодог. Герман Улсад шүүх байгууллага зээлийн хүүгийн ерөнхий таазыг тогтоодог бол Унгар, Чех Улсад шүүх байгууллага зөвхөн зарим төрлийн хүүгийн хязгаарыг тогтоож болдог байна.

Хүүгийн дээд хэмжээнд цаг хугацааны давтамжтай тохируулга хийж болдог. Польш, Герман Улсад сар бүр хүүгийн таазыг шинэчлэн тогтоож тохируулга хийдэг бол Европын Холбооны орнуудын гуравны нэгээс илүү нь тохируулга хийх цаг хугацааг тодорхойлоогүй, тогтмол давтамжтайгаар хүүгийн таазаа өөрчилдөггүй байна. Ирланд Улсад зээлийн хүүгийн хувь хэмжээнд жил бүр хяналт хийдэг бол Бельги Улс 1992 оноос хойш ердөө л 4 удаа хяналт хийсэн байна. Европын Холбооны ихэнх орнуудад зээлийн хүүг улирлаар хянан зохицуулдаг байна.

Зээлийн хүүгийн тааз буюу дээд хэмжээ бол зээлийн хүүгийн хязгаарлалт (IRR)-ын зөвхөн нэг төрөл юм. Экспертүүдийн тайланд, хүүгийн таазыг үнэмлэхүй, эсхүл харьцангуй байх эсэхээс үл хамааран хүүгийн түвшний хязгаар гэж авч үзсэн бөгөөд Европын Холбооны гишүүн орнуудын зээлийн хүүгийн хязгаарлалтыг Хүснэгт 5, 6-ээс үзнэ үү.

Хүснэгт 3. Европын Холбооны гишүүн орнуудад зээлийн хүүгийн хязгаарлалт тогтоосон байдал

Хүүгийн хэмжээг хязгаарласан орнууд /үнэмлэхүй хэмжээгээр/	Хүүгийн хэмжээг хязгаарласан орнууд /харьцангуй хэмжээгээр/	Хязгаар тогтоогоогүй орнууд
Грек Ирланд Мальта	Бельги Франц Герман Эстони Итали Нидерланд Польш Португал Словак Словени Испани	Австри Болгар Кипр Чех Дани Финланд Унгар Латви Литва Люксембург Румын Швед Их Британи

Source: Expert survey, iff /ZEW- Final Report on interest rate restrictions in the EU, 2010

Хүснэгт 4. Европын Холбооны гишүүн орнуудын зээлийн хүүгийн дээд хэмжээ (2010 оны 03 сарын байдлаар)

Гишүүн орнууд	Хэрэглээний зээлийн жилийн хүүний дээд хязгаар /APR/ <sup>6</sup>	Хүүгийн дундаж хувь хэмжээ	Хамрах хүрээ	Тайлбар
Бельги	10%-19,5%		Бүх зээл	Хамгийн дээд APR нь зээлийн хэмжээ болон төрөл (12 ангилал)-өөс шалтгаалан өөр өөр байдаг. 10% (1250 еврогоос дээш дүнтэй зээл)-аас 19.5% (1250 еврогоос бага дүнтэй зээл) хооронд хэлбэлздэг. Зээлийн нөхцөл нь хүүг ялгавартай тогтоох хүчин зүйл болохгүй.
Эстони	63,9%		Бүх зээл	Хамгийн дээд APR нь Төв банкнаас тооцож гаргасан дундаж APR (21,3%*3=63,9)-ийн 300%-д хүрдэг. Сар бүр шинэчлэгдэнэ.
Франц	5,72%-21,63%	8,12%-16,6%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь Төв банкнаас 3 сар тутамд зээлийн хэмжээ болон төрөлтэй уялдуулан тооцож гаргасан дундаж APR-ийн 133%-д хүрнэ. Тухайлбал, 5,72% (орон сууцны зээл)-аас 21,63% (1524 евро хүртэлх дүнтэй хэрэглээний зээл) хүртэл хэлбэлзэнэ. Моргейжийн зээлийн хүүгийн таазыг тусгайлан тогтооно.
Герман	8,18%-16,4%	4,09%-8,2%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь зээлийн төрөл, нөхцөлтэй уялдуулан Төв банкнаас тооцож гаргасан дундаж APR-ийн 200%-д хүрнэ. Хэлбэлзэл нь 8,18% (шинэ бизнес; 5-10 жилийн хугацаатай орон сууцны зээл)-аас 16,4% (шинэ бизнес; 5-аас дээш жилийн хугацаатай хэрэглээний зээл) байна. Хүүгийн таазыг дундаж APR-ыг 2 дахин нэмэгдүүлэх буюу 12 пунктээс илүүгүй байхаар тогтооно.
Грек	Зарим 6,75%		Зөвхөн ББСБ-ын зээл	Грек улс зээлийн хүүгийн лимит тогтоох систем, засаг захиргааны журмаар 1989 онд хүчингүй болгосон учраас банкны зээлийн хүүд хязгаар тавьдаггүй. Харин банк бус байгууллагын зээлийн хүүг жилийн 6.75%-иас хэтрүүлэхгүй байхаар хязгаарласан.
Ирланд	Зарим 187%		Зөвхөн хадгаламж зээлийн хоршоодын зээл	Зээлийн хоршоодод лиценз олгох үед хүүгийн дээд хязгаарыг зааж өгдөг. Зээлийн нэгдэл, хоршоодын сарын зээлийн хүү 1%-ээс хэтрэхгүй (APR-12,68%).
Итали	4,38-27,20%	4,38%-16,97%	Бүх зээл	Хамгийн дээд APR нь Эдийн засаг, санхүүгийн яамнаас зээлийн төрөл болон хэмжээтэй уялдуулан 3 жил тутамд тооцдог жилийн дундаж APR-ийн 150%-иас хэтрэхгүй. 4,38% (моргейжийн зээл)-аас 27,20% (гэр бүлийн бусад зээл)-ийн хооронд хэлбэлздэг. 23 төрлийн хүүгийн тааз тогтоосон.
Мальта	Зарим 8%		Зарим чөлөөлөлт	Бүх төрлийн зээлд хязгаар тогтоосон. Банкуудыг хязгаарлалтаас чөлөөлсөн.
Нидерланд	15%		Моргейж хамаарахгүй. 200 еврогоос бага дүнтэй зээл	Хамгийн дээд APR нь 12% пункт + хуулиар тогтоосон хүү. (Гэрээ зөрчсөн тохиолдолд нэмж төлөх хүүгийн хэмжээ 2010 оны 03 сарын байдлаар 3% байсан). Хүүгийн хэмжээг 6 сар тутамд шинэчлэн тогтооно.
Польш	20%		Бүх зээл	Зээлийн хүүгийн дээд хэмжээ нь Төв банкнаас тогтоосон ломбардын

а \_\_\_\_\_

<sup>6</sup> APR-Annual percentage rate /Жилээр тооцсон хүүгийн хувь/



				хүүгийн 400%-тай тэнцүү (5%, сар бүр шинэчлэгддэг) байна. Зээлийн төрөл, хэмжээнээс хамаарахгүй.
Португал	6,7%-31,6%	5,03%-23,75%		Хамгийн дээд APR нь Төв банкнаас 3 сар тутамд зөвхөн зээлийн төрлөөс хамааруулан тооцож гаргадаг жилийн дундаж APR-ийн 133%-тай тэнцүү байна. 6,7% (барилга, эрүүл мэнд, сэргээгдэх эрчим хүчний зээл)-аас 31,6% (зээлийн карт, зээлийн шугам, харилцах дансны зээл, овердрафт)-ийн хооронд хэлбэлзэнэ.
Словак	11,52%-79,8%			Хамгийн дээд APR нь тухайн хэрэглээний зээлийн төрлийн жилийн дундаж хүүгийн 200%-иас хэтрэхгүй байхаас гадна нийт хэрэглээний зээлийн төрөл тус бүрийн жигнэсэн дундаж хүүний 400%-иас хэтрэхгүй байна. Зээлийн төрөл, хэмжээ, нөхцөлөөс шалтгаалан 30 төрлийн хүүгийн тааз тогтоосон.
Испани	10%		Овердрафт (өөрчилж болно), нийгмийн орон сууцны зээл	Хамгийн дээд APR нь хуулиар тогтоосон хүүг 2.5 дахин нэмэгдүүлсэнээс хэтрэхгүй байна. Нийгмийн дэмжлэгтэй орон сууцны зээлийн хүүг хуулиар тогтоосон хүүгийн түвшнээс хамааруулан индексжүүлж тооцно.
Словени	13,2%-453%	6,6%-226%	Зөвхөн ББСБ-ийн зээл	Хамгийн дээд APR нь зээлийн хэмжээ болон нөхцөлтэй уялдуулан 6 сар тутамд Төв банкнаас тооцож гаргасан жилийн дундаж APR-ийн 200%-иас хэтрэхгүй. 13,2% (120 сар, 20000 евро)-аас 453% (2 сар, 200 евро)-ийн хооронд хэлбэлзэнэ.

## **ГУРАВ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ МЕХАНИЗМ**

Зээлийн хүүгийн хэмжээг хууль тогтоомжоор хязгаарлах эрх зүйн зохицуулалт нь зээлийн бодит өртгийг үнэн зөвөөр тодорхойлж боломжит хүүг зээлдэгчид санал болгох, тэдэнд зээлийн хүүгийн дарамт үзүүлэхээс сэргийлэх ач холбогдолтой юм. Дараах 3 төрлийн хариуцлагын механизмыг хууль, тогтоомжид тусгасан байдаг. Үүнд:

1. Иргэний хэргийн журмаар хариуцлага хүлээлгэх (Хэргийг шийдвэрлэх явцад гэрээнд тусгасан үндсэн зээлийн хүү болон хүүгийн хүүг хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд хүртэл буулгах буюу, эсхүл гэрээг хүчингүй болгох)
2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх (хорих буюу торгууль оногдуулах)
3. Захиргааны хариуцлага (үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох)

Европын холбооны зарим орнууд, тухайлбал Бельги, Франц, Итали Улсад дээрх 3 хариуцлагын механизмыг бүгдийг нь хэрэглэдэг. Зарим гишүүн орнуудад (Словак) зээлийн гэрээг хүчингүй болгохыг зээлдэгчийн зүгээс зөвшөөрсөн байх шаардлага тавигддаг бол зарим орнуудад энэ асуудал нь эрх бүхий байгууллагын шийдэх асуудал байдаг.

Мөнгө хүүлэхийг хуулиар хориглож, хуулийн ерөнхий ангийн хүрээнд авч үздэг Герман, Чех, Эстони, Унгар, Словени зэрэг орнуудын хувьд арай өөр зохицуулалттай байдаг. Эдгээр орнуудад хэргийг хянан хэлэлцэх явцад зээлийн хүүгийн хэмжээ нь "contra bonos mores" үр дагавар бий болгосон гэж үзвэл гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох шийдвэр гаргаж болдог. Герман Улсад шүүхээс зээлийг хэвээр үлдээхийг зөвшөөрч эргүүлэн төлөхөөс чөлөөлөх шийдвэр гаргаж болдог.

### **Мөнгө хүүлэх ажиллагаанд төрөөс хяналт тавих /хүүгийн түвшнийг хязгаарлах/**

Европт мөнгө хүүлэхийн эсрэг болон зээлийн хүүгийн хязгаарлалт тогтоосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хэрэглээний зээлийн институтуудын үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий олон субъектууд байдаг. Тухайлбал:

- Итали, Португал, Франц зэрэг орнуудад Төв банк нь банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр дамжуулан зээлийн хүүгийн хязгаарлалтад хяналт тавьдаг.
- Бельги Улсад тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий субъект нь яам байдаг бол Англи, Герман, Нидерланд, Эстони зэрэг орнуудад салбарын агентлагууд байдаг ба мөн тусгай зөвшөөрлөөр дамжуулан хяналт тавьдаг.
- Ирланд, Болгар, Латви зэрэг орнуудад Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах агентлаг, Словенид зах зээлийг хянан шалгах байгууллага дээрх хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг.
- Финланд Улсад санхүүгийн маргааныг шийдвэрлэх хяналтын чиг үүрэг бүхий Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах омбудсмэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг.

Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хэд хэдэн агентлагууд хяналт тавьж болох ба тухайлбал, Бельги Улсад хэрэглээний зээлийн институтын үйл ажиллагаанд Эдийн засгийн харилцааны яам, моргейжийн компанийн үйл ажиллагаанд Банк, Санхүү, Даатгалын хороо хяналт тавьдаг. Ирландад санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Төв банк, мөнгө зээлдүүлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог байх жишээтэй.

### **Мөнгө хүүлэх ажиллагаанд хяналт шалгалт явуулах /Омбудсмэн/**

Хүүгийн тааз тогтоосон Португал, Франц, Итали, Бельги зэрэг орнуудын хувьд омбудсмэн нь өртөг өндөртэй зээлийн асуудлыг шийдэх цорын ганц альтернатив субъект биш боловч Европын холбооны орнуудад санхүүгийн омбудсменүүд зах зээл дэх санхүүгийн

хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, зээл-зээлийн хүүгийн маргааныг хянан шийдвэрлэхэд чухал үүрэгтэй байдаг. Словак, Словени, Испани зэрэг орнуудад санхүүгийн омбудсмен үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч зээлийн үнэ өртгийг бууруулахад нөлөө үзүүлэхүйц туршлага хуримтлуулж хараахан чадаагүй байна. Европын холбооны орнуудаас Их британи улс санхүүгийн омбудсмен үйлчилгээний талаар арвин их туршлагатай.

### **Зээлийн нийт өртгийг тооцож хуулиас хэтэрсэн хүүгийн зардлыг нөхөн төлүүлэх болон гэрээний нөхцөлийг өөрчлөх шүүх байгууллагын чадамж**

Хүүгийн тааз тогтоосон (Бельги) болон тогтоогоогүй (Дани, Их Британи) орнуудын аль алинд шүүх байгууллагад ийм эрх мэдэл бий. Шүүх байгууллагууд гэрээний нөхцөл нь илэрхий хууль зөрчсөн буюу “contra bonos more” нөхцөл үүссэн (Герман, Эстони), эсхүл гэрээний нөхцөл нь “хэтэрхий шударга бус” (Дани), эсхүл “байж боломгүй, хэрээс хэтэрсэн “хүү тогтоосон (Швед) болохыг тогтоосон нөхцөлд энэхүү эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Жишээ нь, Словак Улсад зээлийн хүүгийн хэмжээ байх ёстой хэмжээнээс үлэмж хэмжээгээр хэтэрсэн гэж үзвэл шүүх байгууллага гэрээг хянан шийддэг бол Чех Улсад хүүгийн хэмжээ байх ёстой хэмжээнээс 4 дахин хэтэрсэн бол Дээд шүүхээс гэрээг хүчингүйд тооцох шийдвэр гаргаж болдог. Испанид мөн ижил төстэй зохицуулалт бий (жишээ нь, моргейжийн зээлийн хүү 5% байх ёстой байтал 20%-иар тогтоосон бол уг гэрээг хүчингүйд тооцно).

Гэвч шүүхээс шийдвэр гаргахдаа ихэвчлэн бодит нөхцөл байдлыг авч үздэг. Зарим тохиолдолд хүүгийн хэмжээ дундаж хүүгийн түвшнээс 2-3 дахин их байсан ч гэсэн санхүүгийн байгууллагыг шударга бус хүү тогтоосон гэж үздэггүй. Шүүх хэргийг шийдвэрлэхдээ нөхцөл байдлыг бүхэлд нь авч үзэх бөгөөд гэрээний нөхцөлийг шударгаар тогтоосон эсэх, талуудын зах зээл дээрх нөхцөл байдал ямар байгааг судалж байж шийдвэр гаргадаг. Жишээ нь, зээлдэгч тал туршлага багатай, найдваргүй байх гэх мэт... (Швед, Их Британи, Словени).

Германд шүүх нэг тал нь нөгөө талдаа хэтэрхий их шахалт үзүүлж зээлийн хүүг байх ёстой дундаж хэмжээнээс хэд дахин өндрөөр тогтоосон гэдгийг нотлон харуулдаг бол Английн шүүхэд ss140A-D, Хэрэглээний зээлийн тухай хууль (Consumer Credit Act)-ийн дагуу “шударга бус зээлийн харилцаа үүссэн” гэдгийг тогтоохын тулд гэрээний нөхцөлүүдийг нэг бүрчлэн хэлэлцэж, өөрчлөлт оруулах боломж олгодог байна.

Европын холбооны гишүүн орнууд “Хэрэглэгчтэй гэрээ байгуулах удирдамж”-ийг дагаж мөрдөх ёстой бөгөөд зээлийн хүүг өндрөөр тогтоосон асуудлыг энэхүү удирдамжийн шударга бус гэрээний нөхцөл гэдэгт хамаатуулан авч үздэг. Испанийн 1908 оны Мөнгө хүүлэхийн эсрэг хуулиар зээлдэгчийн эрх зөрчигдсөн нь тогтоогдвол зээлдэгч нь зээлийн хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөж болдог. 1903 оны Испанийн Иргэний хуулийн дагуу зээлдэгч үндсэн зээл болон хүүг төлөх үүрэгтэй боловч 1933 онд Испанийн дээд шүүхээс гаргасан тайлбарын дагуу тусгайлан зохицуулсан дээрх хуулийг дагаж мөрдөхөөр болж, шүүхийн практикт дагаж мөрдөж байна.

\*\*\*

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- DIRECTIVE 2008/48/EC OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL of 23 April 2008 on credit agreements for consumers and repealing Council Directive 87/102/EEC
- iff/ZEW (2010): Study on interest rate restrictions in the EU, Final Report for the EU Commission DG Internal Market and Services, Project No. ETD/2009/IM/H3/87, Brussels/Hamburg/Mannheim.
- Interest Rate Caps around the World: Still Popular, but a Blunt Instrument, *Samuel Munzele Maimbo and Claudia Alejandra Henriquez Gallegos*, World Bank Group, October 2014

# **ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМ, ДАВХАР ЗАМ, МЕТРО БАРИХ АСУУДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Ц.Болормаа, Б.Нандингэрэл  
И.Жаргалзаяабямба*

## **АГУУЛГА**

### **1. ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

1.1.Хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааны өнөөгийн байдал

1.2.Төрийн оролцоо:

- Зөвшөөрөл, татвар хураамж;
- Хяналтын тогтолцоо;
- Төрөөс үзүүлж буй дэмжлэг.

1.3.Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

1.4.Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийн эрх зүйн орчин

### **2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2.1.Өнөөгийн байдал

2.2.Монгол Улсын нүүрсний худалдааны нөхцөл байдал

2.3.Эрх зүйн орчин

### **3. УЛААНБААТАР ХОТЫН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АВТО ЗАМ, ДАВХАР ЗАМ, МЕТРО БАРИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ**

3.1.Өнөөгийн байдал

3.2.Тусгай замын автобус BRT

3.3.Улаанбаатар метро

3.4.Рейлбус

3.5.Улаанбаатар хотыг дэд бүтцийг хөгжүүлэх харилцааны эрх зүйн орчин

## **ХАВСРАЛТ /ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ/**

### **1. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын явцын талаар:**

1.1 Хог хаягдлын менежментийн тухай судалгаа;

1.2 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хоёрдогч түүхий эдээр хөдөлмөр эрхлэгчдийн үндэсний холбоотой хамтран ажиллах санамж бичиг;

1.3 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг;

1.4 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо ТББ, төсөл санхүүжүүлэгч Сектех Групп ХХК-ийн гурван талт хамтын ажиллагааны гэрээ;

1.5 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны хамтран ажиллах гэрээ;

1.6 Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл технологийн Эко-Парк төслийн таницуулга;

- 1.7 Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл технологийн Эко-Парк төслийн үйл ажиллагааны III-р улирлын тайлан;
  - 1.8 Эко-Парк төслийн дэд бүтцийн санхүүжилтийн ерөнхий тооцоолол;
  - 1.9 Дахин боловсруулж буй хог хаягдлын төрөл, хэмжээ;
  - 1.10 Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоонд гишүүнчлэлтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалт;
  - 1.11 Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл технологийн Эко-Парк төслийг хэрэгжүүлэх төслийн нэгжүүдийн мэдээлэл.
- 2. Нүүрс баяжуулах үйлдвэрлэлийн талаар:**
- 2.1 Нүүрс баяжуулах үйлдвэрлэлийн тухай мэдээлэл.
- 3. Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх авто зам, давхар зам, метро барих бүтээн байгуулалтын ажлын талаар:**
- 3.1 Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр-нэгдүгээр үе шат төсөл.

## ОРШИЛ

Судалгаанд хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, нүүрс угаах, баяжуулах үйлдвэр, Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд авто зам, давхар зам, метро барих зэрэг бүтээн байгуулалтын ажлуудын талаарх лавлагаа, мэдээллийг бэлтгэв.

**Мэдээллийн эх сурвалж:** Лавлагаа, мэдээллийг гаргахдаа [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) хууль эрх зүйн мэдээллийн сан, УИХ-ын Тамгын газрын хуулийн мэдээллийн дата сан дахь хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдээс холбогдох мэдээллийг авч түүвэрлэн боловсруулснаас гадна холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад албан бичиг явуулж, ирүүлсэн судалгаа, мэдээллийг ашигласан болно.

**Лавлагаа, мэдээллийн бүтэц:** Лавлагаа, мэдээлэл нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 1) Судалгааны албанаас боловсруулсан тойм мэдээлэл;
- 2) Холбогдох байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн хавсралт мэдээлэл.

Судалгааны албанаас боловсруулсан мэдээллийг гишүүнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу:

1. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэл;
2. Нүүрс баяжуулах үйлдвэрлэл;
3. Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд авто зам, давхар зам, метро барих бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээлэл гэсэн үндсэн 3 хэсгийн хүрээнд бэлтгэв.

Мэдээлэл лавлагааг гаргахдаа дээр дурьдсан асуудлуудын өнөөгийн байдал, бодлого, эрх зүйн орчин болон хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тоймлон бэлтгэлээ.

Эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэр, эрх зүйн орчны талаарх лавлагаа, мэдээллийг хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдээс түүвэрлэсэн болно.

Лавлагаа, мэдээлэлд дараах байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн мэдээллийг хавсаргав. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо;
- Ашигт малтмал, газрын тосны газар

## 1.ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

### 1.1. Хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааны өнөөгийн байдал

Монгол Улсын хэмжээнд хатуу хог хаягдлын нэгдсэн статистик мэдээг шоо метрээр тооцож гаргаж байсан бөгөөд 2005 оноос олон улсын стандартад нийцүүлэн зарим өөрчлөлт хийснээр илүү бодитой статистик мэдээ гарч байна гэж салбарын мэргэжилтнүүд дүгнэжээ. Тухайлбал, Улаанбаатар хотын нийт хатуу хог хаягдлын хэмжээ 2016 онд 1.710.909 тн байсан ба үүсгүүрийн хувьд гэр хорооллын, орон сууцны, зам талбайн, бусад гэсэн төрөлд ангилагдаж байна. Мэдээллийн задаргааг дараах хүснэгтээс үзнэ үү. /Хүснэгт 1/

2016 оны байдлаар нийт хатуу хог хаягдлын төрөл, хэмжээ

Нийт хог хаягдлын хэмжээ: 1.710.909 тн		
Гэр хорооллын хог хаягдал	Орон сууцны хог хаягдал	Зам талбай, бусад хог хаягдал
1.113.332тн	361.395тн	236.182тн

Судалгааны мэдээллээс үзэхэд, хот суурин газар амьдардаг нэг хүн жилд дунджаар 440 кг хатуу хог хаягдал үүсгэдэг бол хөдөө орон нутагт энэ тоо нь харьцангуй бага байдаг байна.

Монгол Улсын хэмжээнд суурин газрын дахин боловсруулах боломжтой нийт хог хаягдлын цуглуулалт 70 хувьтай, хөдөө орон нутагт дахин боловсруулах боломжтой хог хаягдлын цуглуулалт 40 хувьтай байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд хог хаягдлын цуглуулалт 90-95 хувь байна. Улаанбаатар хотын хэмжээнд Нарангийн энгэр, Морингийн даваа, Цагаан даваа гэсэн 3 томоохон хогийн цэг ажиллаж байгаагаас олон улсын стандартад нийцэхэд ойртсон хогийн цэг нь Нарангийн энгэрийн хогийн цэг юм /ЖАЙКА-ийн төслийн хүрээнд байгуулсан/.

Монгол Улсад дахин боловсруулах боломжтой хатуу хог хаягдлыг дараах 8 төрөлд ангилж байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн;
- Эрчим хүчний;
- Хөдөө аж ахуйн;
- Эрүүл мэндийн байгууллагын;
- Уул уурхайн;
- Барилгын;
- Аюултай;
- Цацраг идэвхит.

2017 оны 10 дугаар сарын байдлаар “Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо”-нд бүртгэлтэй 12 үйлдвэр ажиллаж, нийт хог хаягдлын 24 хувийг дахин боловсруулж байна. Энэ хэмжээг 85 хувьд хүргэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачилсан “Эко парк” төслийг хэрэгжүүлэхээр Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, “Сектех групп” ХХК-тай гурван талт гэрээг 2017 онд байгуулсан байна.

“Эко парк” төслийн хүрээнд 2 байршилд олгогдсон нийт 186,4 га газарт хог хаягдлыг дахин боловсруулах 20 үйлдвэр барьснаар 920 ажлын байр, 5 дэд бүтцийн байгууламж байгуулахаар төлөвлөсөн байна. Тухайн салбарын эдийн засгийн эргэлтийн хэмжээ жилд 70 тэрбум төгрөг байсан бол төсөл хэрэгжсэнээр жилд 232 тэрбум төгрөгт хүргэх боломжтой гэсэн тооцоо гаргасан байна.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй дээрх үйлдвэрүүдэд:

- ✚ төмөр, зэсийн хог хаягдлын 90 хувь;
- ✚ хайлш, хөнгөн цагаан, аккумуляторын хог хаягдлын 80 хувь;
- ✚ хуванцар, хэрэглээний гялгар уутны 60 хувийг дахин боловсруулж байгаа нь дахин боловсруулж буй хог хаягдлын дийлэнх хувийг эзэлж байна.

**1.2. Төрийн оролцоо:** Байгаль, орчин, аялал жуулчлалын яам нь хог хаягдлын менежментийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, аюултай хог хаягдал тээвэрлэхэд шаардлагатай дагалдах бичиг баримт, бүртгэлийн маягтыг батлах, улсын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх үүрэгтэй.

“Хог хаягдлын менежментийн тухай” 2012 оны хуулиар яам бүр өөрийн харьяа байгууллагуудын хог хаягдлын менежментийн стандарт, дүрэм журмыг боловсруулах тогтолцоог нэвтрүүлсэн. Орон нутгийн хог хаягдлын менежментийг аймаг, сумдын захиргаа, Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг нийслэл, дүүргийн захиргаа хариуцан хэрэгжүүлж байна. Аймгийн захиргаа нь өөрийн орон нутгийн хог хаягдлын менежментийн хөтөлбөрийг хариуцах бөгөөд сумдын үйл ажиллагаанд хяналт тавьж байх үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга нар нь хог хаягдлын менежментийн үйлчилгээг өөрсдөө, эсхүл хувийн



компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

**Зөвшөөрөл олгох, татвар хураамж:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгодог бол аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь хог хаягдлын цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож байна.

Хог хаягдлын хураамж болон сум, дүүрэг, аймгийн захиргаанаас олгодог татаас нь Монгол Улсад хог хаягдлын менежментийн үйлчилгээ үзүүлэх санхүүгийн эх үүсвэр болж байна. Орон сууцны хорооллын айл өрх сар бүр 2000 төгрөг, гэр хорооллын айл өрх сар бүр 2700 төгрөгийн хураамж төлж байна. Орон сууцны айл өрхүүдийн хог хаягдлын хураамж төлөлт 90 хувьтай, гэр хорооллын айл өрхүүдийнх 60 орчим хувьтай байна.

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд, эсхүл сууц өмчлөгчдийн хороод хураамжийг цуглуулж сум, дүүргийн холбогдох дансанд шилжүүлж байна. Харин улсаас нэг тонн тутамд 2080 төгрөгийн татаас олгож байна.

**Хяналтын тогтолцоо:** Засгийн газраас химийн бодисын зохицуулалттай хяналтыг бий болгох зорилгоор Засгийн газрын агентлагуудын химийн бодис импортлох, экспортлох журмыг баталсан. 2007 оноос өмнө орон нутгийн захиргаанд аюултай болон хортой химийн бодис, химийн бодисыг импортлох зөвшөөрлийг өгдөг байсан нь химийн бодисыг хяналт, зохицуулалтгүй импортлох, гаалиар аюултай химийн хорт бодисыг энгийн нэрээр оруулж ирэх нөхцөлийг бүрдүүлж байжээ. Тус журам хэрэгжсэнээр дээрх байдал арилж 2016 оны байдлаар 170 аж ахуйн нэгжид аюултай химийн бодис импортлох зөвшөөрөл олгосон байна.

**Төрөөс үзүүлж буй дэмжлэг:** 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлыг эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг дэмжихэд зориулан эдийн засгийн урамшууллыг тогтоох болон шаардагдах төсвийг батлах эрхийг УИХ-д олгосон нь тухайн салбарыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж холбогдох судалгааны байгууллагууд үзжээ<sup>7</sup>. Мөн хуулиар Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран хог хаягдлын менежментийн санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй байхаар шинээр хуульчилсан нь тухайн салбарт хөрөнгө татах нөхцөлийг бүрдүүлж байна.

### **1.3.Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа<sup>8</sup>**

1.Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

- ✓ Аюултай хог, хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийн зураг төслийг хийж эхэлсэн.
- ✓ Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх 32МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2018 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.

2.НҮБ-ын Олон Улсын хүрээлэн буй орчны технологийн төв болон Азийн технологийн институтын хамтарсан “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө 2017-2030” бодлогын баримт бичгийн төсөл боловсруулсан.

3.“Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж-Эрчим хүчний үйлдвэрлэл” төслийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах саналыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.

а\_\_\_\_\_

<sup>7</sup> Монголын хог хаягдлыг дахин боловсруулах Үндэсний холбооноос өгсөн мэдээлэл

<sup>8</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2017 оны 10 дугаар сарын 09 өдрийн 06/6206 тоот бичгээр ирүүлсэн мэдээлэл



4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачилсан “Эко парк” төслийг хэрэгжүүлэхээр Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, “Сектех групп” ХХК-тай гурван талт 17/06-168 тоот гэрээг 2017.05.24-ний өдөр байгуулсан. Төслийн хүрээнд Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт 8 үйлдвэр, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт 11 үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд “Сектех групп” ХХК нь 150 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Эко парк төслийн хүрээнд:

- ✓ Монголын хог хаягдлыг дахин боловсруулах Эко паркийн урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг 2016 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.
- ✓ Үйлдвэр барих газрын байршлыг нарийн тодорхой болгох, үйлдвэрүүдийн барилгын эскиз зургуудыг гаргаж байна.
- ✓ Төслийн хүрээнд 2018 онд 2-3 парк барихаар төлөвлөж, Эко паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөөд байна.

#### 1.4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийн эрх зүйн орчин

Хог хаягдлын менежментийн талаарх анхны эрх зүйн баримт бичиг нь 2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан “Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай” хууль юм. Хуулийг 2012 онд “Хог хаягдлын менежментийн тухай” хууль болгон өөрчилсөн. Энэ өөрчлөлтөөр хог хаягдлын менежментийн асуудлыг илүү нарийвчлан хог хаягдлыг багасгах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах зарчмыг журамласан. Хамгийн сүүлд уг хуулийг 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Хог хаягдлын тухай хууль нэртэйгээр шинэчлэн баталж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн дээр дурьдсан хог хаягдлын төрлөөс шалтгаалан холбогдох яамнаас гаргасан дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

#### **Хог хаягдлын менежмент, дахин боловсруулахтай холбоотой асуудлаар төрөөс баримталж буй бодлого, дэвшүүлсэн зорилтууд**

/Хүснэгт 1/

	Бодлогын баримт бичиг	Тусгасан зорилт
1	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010.07.15-ны өдрийн 48 дугаар тогтоол 7410С/Е	3.4.3.4. Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно. 3.5.4.3. Хог хаягдлаас эрчим хүч, нөөц баялаг, түүхий эд бий болгох технологи бүхий үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. Аюултай хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хортой, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлнэ.
2	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 УИХ-ын 2016.02.05-ны өдрийн 19 дүгээр тогтоол	<b>2.3.3. Эко системийн тэнцвэрт байдал</b> <b>Зорилт 2. Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.</b> <b>I үе шат (2016-2020):</b> Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох. <b>II үе шат (2021-2025):</b> Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх. <b>III үе шат (2026-2030):</b> Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх.

3	Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр <i>УИХ-ын 2016.09.09-ний өдрийн 45 дугаар тогтоол</i>	4.1.6.Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.
4	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө <i>Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол</i>	3.1.1.3 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх; 4.1.3.4 Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа хийх; 4.1.6.3 Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах; 4.1.6.4 Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, аюултай хог хаягдлын менежментийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах.
5	<b>Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого</b> <i>УИХ-ын 2015.06.19-ний өдрийн 62 дугаар тогтоол</i>	4.1.5.дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих.
6	Төрөөс экологийн талаар баримтлах бодлого <i>УИХ-ын 1997.12.26-ны өдрийн 106 дугаар тогтоол</i>	2.5.9.Хот байгуулалт, эрүүл мэнд: хот суурины амьдрах орчны чанарын болон эрүүл ахуйн стандарт, зөвшөөрөл, хяналт шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох, агаар, ус, хөрсийг бохирдуулагч бодисыг цэвэрлэх, хортой нөлөөллийг нь бууруулах техник, технологи судалж нэвтрүүлэх, эрчим хүч, түлш, шатахуун, дулаан, уур усыг хэмнэх, орчинд хаягдалгүй, утаагүй түлш бий болгох, үйлдвэр, ахуйн хог хаягдал, хоёрдогч түүхий эдийг боловсруулах, химийн хорт бодисын хэрэглээг багасгах, дуу чимээг намсгах арга, технологи нэвтрүүлэх, хот орчмын байгаль цаг уурын онцлог, экологийн даац, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах шаардлагыг нарийн тооцсон архитектурын зохиомж, барилгын бүтээц, хийц, инженерийн болон ногоон байгууламж, зам тээврийн бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлж хөгжүүлэх; 3.11.4. ахуйн бохир ус, хог хаягдлыг зайлуулах, цуглуулах ажлыг журамлаж, суурин газрын хөрсөн бүрхэвчийг бохирдлоос сэргийлж зүлэгжүүлэх, хот орчмын ногоон бүс байгуулах, элэгдэл, эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээж зохистой ашиглах зорилт тавина; 4.3.14. дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг, улс хоорондын хамтын ажиллагааны боломжид түшиглэн дэлхийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, олон улсын байгаль хамгаалах конвенцид нэгдэн орж эдийн засаг, гадаад худалдааг тэдгээрийн зарчимд нийцүүлэн зохистой хөгжүүлнэ. Озоны хомсдол, уур амьсгалын таагүй өөрчлөлтийн нөлөөг сааруулах, амьдрах орчинд аюултай хог хаягдал гадаадаас оруулж хадгалах, булшлахыг хориглох, хил дамжин нэвтэрч болзошгүй цацраг идэвхжил, агаар, усны бохирдлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх, байгалийн гамшиг, нөөц баялгийн хомсдлын уршгийг үнэлж мэдээлэх, хянан сэргийлэхЕбүс нутгийн тогтолцоог бүрдүүлэх замаар экологийн аюулгүй байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлнэ.

7	Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр. <i>Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн 98 дугаар тогтоол</i>	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх 32МВт-ын дулааны цахилгаан станц барих.
8	2014-2022 онд хэрэгжүүлэх Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр <i>Засгийн газрын 2014 оны 298 тоот тогтоол</i>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгох;</li> <li>2. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;</li> <li>3. Аюултай хог хаягдын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхийг бүрдүүлж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх;</li> <li>4. Хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх;</li> <li>5. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч үйлдвэрлэх зэргээр хог хаягдлын хэмжээг бууруулах.</li> </ol>

## 2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Нүүрс баяжуулах үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

2017 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсад нүүрс баяжуулах 3 үйлдвэр ажиллаж, 1 үйлдвэр баригдах шатандаа, 2 үйлдвэрийн ТЭЗҮ-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хүлээн аваад байна.

Үйл ажиллагаа явуулж буй нүүрс баяжуулах үйлдвэрүүд нь:

- 1) “Энержи-ресурс” ХХК-ийн Ухаа худаг дахь нүүрс угааж баяжуулах үйлдвэр (жилд 15 сая.тн нүүрс угаах хүчин чадалтай);
- 2) “МАК” ХХК-ийн Дорноговь аймаг дахь Элдэвийн уурхайн бага оврын хүчин чадлын хуурай баяжуулах үйлдвэр (0,5-2 сая.тн);
- 3) “МоЭнКо” ХХК-ийн Хөшөөтийн уурхайн бага оврийн хүчин чадлын хуурай баяжуулах үйлдвэр (0,5-2 сая.тн) байна.<sup>9</sup>

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байрлах “SGS” ХХК-ийн Овоот толгойн уурхайг түшиглэсэн нүүрс баяжуулах үйлдвэр баригдаж байгаа бол дараах 2 уурхайн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэн, хүлээн авсан байна. Үүнд:

1. Алаг-Өндөрийн нүүрсний ордын жилийн 0,3 сая.тн;
2. Шарын голын уурхайн жилийн 0,6 сая.тн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр.

#### Технологийн хувьд:

- нүүрс угааж баяжуулах;

а\_\_\_\_\_

<sup>9</sup> Ашигт малтмал газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтсээс ирүүлсэн мэдээлэл. Албан бичгийг хавсаргав. Хавсарлт

- нүүрс хуурай баяжуулах технологи байдаг бөгөөд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 үйлдвэрийн 1 нь угааж баяжуулах, 2 нь хуурай баяжуулах технологийг ашиглаж байна.

**Нүүрс угааж баяжуулах** технологи нь ус ихээр ашигладаг арга бөгөөд тус технологийн давуу тал нь нүүрсний үнслэг болон хүхэрлэгийн агуулгыг маш бага хэмжээнд хүртэл бууруулдаг байна. Тухайлбал үнслэгийн хэмжээг 60-80 хувь, хүхэрлэгийн хэмжээг 50-70 хувь бууруулдаг гэж салбарын судалгаанд дурьджээ.

**Нүүрс хуурай баяжуулах** технологи нь байгаль орчинд ээлтэй бөгөөд ус огт ашигладаггүй, өргөн хүрээний дэд бүтэц шаардагддаггүй тул эдийн засгийн хувьд үр ашигтай технологид тооцогддог байна. Мөн цаг уурын орчны хувьд хүйтэн орчинд ашиглах болон гадаргын ус багатай улс оронд ашиглахад нэн тохиромжтой гэж үздэг байна. Дэлхийн хэмжээнд усны нөөц багасаж байгаатай холбоотойгоор БНХАУ, Япон, АНУ, Энэтхэг, Украин, Турк, Испани, Колумб, Бразил зэрэг улс орнуудад нүүрс хуурай баяжуулах технологийн амжилттай хэрэгжүүлж байна.<sup>10</sup> Хуурай баяжуулах технологийг гол онцлог нь 0-50 мм бүхэллэгтэй нүүрсийг баяжуулах боломжтой байдаг байна.

Манай улсын хувьд БНСУ-ын КЕГАМ, Японы “Нагата инженеринг” зэрэг хөрөнгө оруулагч нартай хуурай баяжуулах үйлдвэрүүдэд хамтран ажиллах талаар Уул уурхайн яам, Ашигт малтмалын газартай санамж бичиг байгуулсан байна.

## 2.2. Монгол Улсын нүүрсний худалдааны нөхцөл байдал

Монгол Улсын хэмжээнд 2017.01.01-ны байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нүүрсний 49 уурхай байгаагаас:

- Төрийн болон орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж 8 уурхайд;
- Дотоодын болон хамтарсан 28 аж ахуйн нэгж 33 уурхайд;
- 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай 7 аж ахуйн нэгж 8 уурхайд нүүрс олборлож байна.<sup>11</sup>

Өөрөөр хэлбэл, үйл ажиллагаа явуулж буй 49 уурхайн **8 нь** төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшилд, **41 уурхай нь** хувийн өмчийн аж ахуйн нэгжийн эзэмшилд үйл ажиллагаагаа явуулж байна.

2016 онд Монгол Улс 35,096.5 мян.тн нүүрс олборлож, 33,831.7 мян.тн-ыг борлуулснаас 25,809.3 мян.тн нүүрс экспортод гаргажээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад олборлолт 146.4%, борлуулалт 152.9%, экспорт 178.4% болж өссөн үзүүлэлттэй байна.<sup>12</sup> Үүнийг зургаар үзүүлбэл дараах байдалтай байна:

ОИГ.МН  
СУДАЛГААНЫ САН


a\_\_\_\_\_

<sup>10</sup> “Mongolia Mining Journal”


<sup>11</sup> Нүүрсний судалгааны хэлтсийн мэдээ.

<sup>12</sup> <https://mrpam.gov.mn/article/99/>

**Зураг 2: 2013-2016 оны нүүрсний олборлолт, борлуулалт, экспортын харьцаа**



**Зураг 3: 2012-2016 онуудад хилийн боомтуудаар гарсан нүүрсний хэмжээ**



**Тайлбар:** Хилийн боомтуудаар:

- 2012 онд 19,378.6 мян.тн;
- 2013 онд 18,188.3 мян.тн;
- 2014 онд 19,512.3 мян.тн;
- 2015 онд 14,467.5 мян.тн,
- 2016 онд 25,809.3 мян.тн нүүрс тус тус экспортод гарсан байна.



Салбарын мэргэжилтний өгсөн мэдээллээр<sup>13</sup> нүүрсний экспортын хэмжээ нь Монгол Улсаас нүүрс импортлогч улс болох БНХАУ-ын нүүрсний эрэлт, худалдан авалтын бодлого зэргээс ихээхэн шалтгаалдаг байна.

Монгол банкнаас хийсэн судалгааны тайлангаас үзэхэд, Монгол Улсаас БНХАУ-д нийлүүлж буй нүүрсний дийлэнх хувийг түүхий нүүрс эзэлдэг<sup>14</sup> бөгөөд энэ нь Монгол Улсын хилийн боомтуудын ойролцоох БНХАУ-ын нутаг дэвсгэрт нүүрс баяжуулах 20 гаруй үйлдвэр байдагтай холбоотой байна.

**Эрх зүйн орчин:** Нүүрс баяжуулах үйлдвэрлэлийн эрх зүйн орчны хувьд “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” гол эрх зүйн акт нь болж байна.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт дурьдсанаар 2014, 2015 онуудад салбарын эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох дүрэм, журам, хөтөлбөр, төслийг боловсруулж, 2015 оноос хэрэгжүүлж эхлэхээр тусгасан байдаг. Үүний дагуу “Нүүрс” хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг ажиллаж, компаниуд, мэргэжлийн холбоодоос санал авсан байдаг. Гэвч энэ “Нүүрс хөтөлбөр”-ийн төслийн ажил зогссон байна.

2012 онд Засгийн газар иргэдийг хямд үнэтэй нүүрсээр хангахтай холбоотойгоор “Хөрөнгө гаргах тухай” А204 тогтоол баталсан боловч “Нүүрс” хөтөлбөр гэж нэрлэгдсэн энэ арга хэмжээ нь Багануурын нүүрсийг түлшинд ашиглаж, тоосонцор болон хүхрийн агууламжийг бууруулах зорилготой байсан ч түүхий нүүрсний хэрэглээг нэмэгдүүлсэн бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг зогсоосон байна.

Иргэдийг хямд үнэтэй нүүрсээр хангах зорилготой ч түүхий нүүрсний хэрэглээг нэмэгдүүлсэн гэх энэ хөтөлбөр нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор боловсруулж, санал авч байсан “Нүүрс” хөтөлбөр биш гэдгийг дурьдах нь зүйтэй юм.

Нүүрсний баяжуулах үйлдвэрлэлийн болон нүүрстэй холбогдуулан эрх бүхий байгууллагуудаас гаргасан эрх зүйн баримт бичгийг доорх хүснэгтээс үзнэ үү.

### **Нүүрсний салбарын бодлого, эрх зүйн орчны лавлагаа, мэдээлэл**

Хүснэгт 2

	Баримт бичгийн нэр	Холбогдох зүйл, заалт
1	<b>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал</b>  <i>Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол</i>	<b>3.2.4.Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого</b> 3.2.4.2.Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана. <b>3.4.3.Амьдрах орчны аюулгүй байдал</b> 3.4.3.1.Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно. 3.4.3.4.Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний <u>бохирдлыг бууруулж</u> , ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
2	<b>Монгол Улсын тогтвортой хөгжлийн</b>	<b>2.1.3.Аж үйлдвэрийн салбар</b> <b>Зорилт 1.Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид</b>

а

<sup>13</sup> Ашигт малтмал, газрын тосны газрын Нүүрсний судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн. Энэхүү мэдээлэл-лавлагааг боловсруулах явцад өгсөн мэдээлэл.

<sup>14</sup> Монгол банк. “Монгол Улсын нүүрсний экспортын судалгаа-II”. Судалгааны товхимол-7.2012 он. 235 дахь тал.

	<p><b>үзэл баримтлал – 2030</b></p> <p><i>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дугаар тогтоол</i></p>	<p><b>суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.</b></p> <p><b>I үе шат (2016-2020):</b> Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.</p> <p><b>II үе шат (2021-2025):</b> Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх.</p> <p><b>III үе шат (2026-2030):</b> Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх.</p>
3	<p><b>Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого</b></p> <p><i>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоол</i></p>	<p><b>Хоёр.Эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим</b></p> <p>2.1.2.олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих.</p> <p><b>3.3.Олборлох салбарын хүрээнд:</b></p> <p>3.3.1.Монгол Улсын хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулсан орчин үеийн, олон улсын стандартад нийцсэн, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын чиг хандлагатай, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах;</p> <p>3.3.4.олборлолт, боловсруулалтын хэмжээг улс орны эдийн засаг, аж үйлдвэржилтийн нөхцөл байдал, гадаад, дотоод зах зээлийн цаашдын хэтийн төлөвтэй уялдуулан оновчтой төлөвлөх.</p> <p><b>3.4.Боловсруулах салбарын хүрээнд:</b></p> <p>3.4.1.боловсруулах салбарыг хөгжүүлэхдээ зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэрэглээ болон үйлдвэрлэлээс гарах хорт хаягдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүчин зүйлийг цогцоор нь судалж, шийдвэр гаргах;</p> <p>3.4.2.боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p> <p>3.4.3.эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг бодлогоор дэмжих;</p> <p>3.4.4.нүүрс баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах, нүүрсний ордод түшиглэсэн цахилгаан станц барих, хүрэн нүүрснээс утаагүй, шингэн түлш, хий, шатдаг занараас шингэн түлш гарган авах зэрэг төслийг дэмжих;</p> <p>3.4.5.төрөөс боловсруулах үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжиж, ашигт малтмалын боловсруулалтын түвшинг дээшлүүлэх.</p> <p><b>Дөрөв.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн</b></p> <p><b>4.1.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам:</b></p> <p>4.1.1.Засгийн газар, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын холбогдох агентлаг, аж ахуйн нэгж төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу төлөвлөгөө батлан, биелэлтийг зохион байгуулах;</p> <p>4.1.2.Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хүрээнд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулж төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх, хяналт</p>

		<p>тавих ажлыг зохион байгуулах;</p> <p>4.1.3.Засгийн газар төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, стратегийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсөв, төрийн мөнгөний бодлогод тусган төлөвлөж хэрэгжүүлэх;</p> <p>4.1.4.уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт-шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэж, тухайн жилийн хэрэгжилтийг дараа жилийн эхний улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байх;</p> <p>4.1.5.хяналт-шинжилгээ, үнэлгээг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор хийж байх. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй байх;</p> <p>4.1.6.эрсдэл үүсч болзошгүй орчныг байнга хянаж, дунд болон богино хугацааны төлөвлөлтийн хүрээнд хариу арга хэмжээ авч, шуурхай шийдвэрлэж байх.</p> <p><b>4.2.Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат:</b></p> <p>4.2.1.эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох дүрэм, журам, хөтөлбөр, төслийг боловсруулах (2014, 2015 он);</p> <p>4.2.2.хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх (2014-2025 он);</p>
4	<p><b>Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай</b></p> <p>2015.06.19 Дугаар 63</p>	<p><b>Хоёр.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын алсын хараа тэргүүлэх чиглэл, баримтлах тулгуур зарчим</b></p> <p>...2.3.Төрөөс эрчим хүчний талаар баримтлах зорилго, зорилтыг тодорхойлоход дараах тулгуур зарчмыг баримталж байна:</p> <p>2.3.1.улс орны эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангасан байх;</p> <p>2.3.2.эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан байх;</p> <p>2.3.3.иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн байх;</p> <p><b>2.3.4.байгаль орчинд ээлтэй байх;</b></p> <p>2.3.5.үр ашиг, хэмнэлттэй байх;</p> <p>2.3.6.шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан байх.</p>
<p align="center"><b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛУУД</b> (2000 оноос хойших)</p>		
1	<p><b>Бүтээгдэхүүн хуваах гэрээ батлах тухай</b></p> <p>Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт орших газрын тосны хайгуулын Нэмэгт-ҮЙ, Борзон-ҮП гэрээт талбайн хэсэгт нүүрсний гаралтай метан хийтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны хэрэг эрхлэх газар, Канад Улсын “Сторм Кат Энержи Корпорэйшн” компанийн хооронд</p> <p>Батлагдсан огноо: 2004.05.05 Тогтоолын дугаар: 110</p>	
2	<p><b>Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай</b></p> <p>Батлагдсан огноо: 2008.03.12 Тогтоолын дугаар: 89</p> <p>Хүчингүй болсон огноо: 2013.02.02-ны өдрийн 43-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон</p>	
3	<p><b>Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай</b></p> <p>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг энержи ресурс ХХК-д</p> <p>Батлагдсан огноо: 2008.06.18 Тогтоолын дугаар: 252</p>	
4	<p><b>Авто замын тухай</b></p> <p>/Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын боомт хүртэлх хатуу хучилттай 245 км авто замыг өөрийн хөрөнгөөр барихыг “Говийн зам” ХХК-нд/</p>	



	Батлагдсан огноо: 2010.03.31 Тогтоолын дугаар:
5	<b>Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх тухай</b> Батлагдсан огноо: 2010.05.05
6	<b>Хөрөнгө гаргах тухай</b> /иргэдийг хямд үнэтэй нүүрсээр хангах/ Батлагдсан огноо: 2012.12.22 Тогтоолын дугаар: А204
7	<b>Налайхын нүүрсний ордод хувиараа нүүрс олборлож байгаа иргэдийн аюулгүй ажиллагааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай</b> Батлагдсан огноо: 2013.02.02 Тогтоолын дугаар: 43
8	<b>Төрийн өмчийн оролцоотой компани байгуулах тухай, Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих цахилгаан станц</b> Батлагдсан огноо: 2013.03.30 Тогтоолын дугаар: 129 Хүчингүй болсон огноо: 2013 оны 261 тогтоолоор 2 дахь заалтыг хүчингүйд тооцсон
9	<b>Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн гаалийн хяналтын бүс байгуулах ажлыг зохион байгуулах тухай</b> Батлагдсан огноо: 2013.06.22 Тогтоолын дугаар: 225
10	<b>Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх тухай</b> Батлагдсан огноо: 2013.07.06 Тогтоолын дугаар: 246
11	<b>Нүүрсний экспортыг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай</b> Батлагдсан огноо: 2013.08.16 Тогтоолын дугаар: 299
12	<b>Төслийн нэгж байгуулах тухай /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Синопек корпорацитай хамтран нүүрсийг хийжүүлэх технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий төслийн нэгж/</b> Батлагдсан огноо: 2014.03.07 Тогтоолын дугаар: 74
13	<b>Төслийн нэгжийг санхүүжүүлэх тухай /Нүүрс хийжүүлэх технологи нэвтрүүлэх/</b> Батлагдсан огноо: 2014.03.28 Тогтоолын дугаар: 104

### 3. УЛААНБААТАР ХОТЫН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АВТО ЗАМ, ДАВХАР ЗАМ, МЕТРО БАРИХ, ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

**3.1. Өнөөгийн байдал:** Сүүлийн 10 жилийн дотор нийслэлийн хүн ам 558,2 мянгаар өссөнөөс 56% нь механик өсөлт, 44% нь ердийн өсөлт байх бөгөөд Улаанбаатар хотын хүн ам энэ хугацаанд 437 мянгаар өссөн байна. Нийслэл хотын оршин суугчдын тоо богино хугацаанд асар хурдан нэмэгдэж, хүн амын хэт төвлөрөл үүссэнээс хот төлөвлөлтийн бодлого бүр мөсөн алдагдаж, түүнийг даган нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг бий болгосон байна.

Улаанбаатар хотын хөгжлийн тулгамдсан асуудлыг мэргэжлийн байгууллагууд дараах байдлаар томъёолсон байна:

- гэр хорооллын зохицуулалтгүй тэлэлт, зүй зохисгүй газар ашиглалт;
- хүрээлэн буй орчны доройтол, агаар, ус, хөрсний бохирдол;
- хотын санхүүжилтийн чадавх сул, институци ба хууль эрх зүйн орчин хангалтгүй;
- замын хөдөлгөөний түгжрэл;
- зохисгүй төвлөрөл;
- орон сууцны хүрэлцээ, амьдрах орчны нөхцөл муу;
- хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн;
- инженерийн дэд бүтцийн хомсдол;
- хот байгуулалт, газрын харилцаа сул тогтолцоо зэрэг асуудлууд нөлөөлж байна.

Эдгээр тулгамдсан асуудлаас дэд бүтэц, авто замтай холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх бүхий байгууллагуудаас дараах эрх зүйн актуудыг батлан гаргасан байна. Үүнд:

- “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” УИХ-ын 2010 оны 48-р тогтоол;
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” УИХ-ын 2016 оны 19-р тогтоол;
- “Монгол Улс Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” УИХ-ын 2016 оны 45-р тогтоол;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” УИХ-ын 2016 оны 71-р тогтоол;
- “Авто замын салбарын чадавхыг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” УИХ-ын 2011 оны 258-р тогтоол;
- “Шинэ бүтээн байгуулалтын дунд хугацааны зорилтот хөтөлбөр” УИХ-ын 2010 оны 36-р тогтоол;
- “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” УИХ-ын 2013 оны 23-р тогтоол;
- “Монгол Улсын нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” УИХ-ын 2016 оны 70-р тогтоол;
- “Төрөөс хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого” зэрэг болно. (дэлгэрэнгүйг Хүснэгт3-аас үзнэ үү)

Сүүлийн 10 жилд хотын автомашины тоо эрс нэмэгдэж, 215 мянган тээврийн хэрэгсэл, өдөр бүр хөдөлгөөнд оролцож, гол замаар зорчих дундаж хурд 20-30 км/ цаг болжээ. Судалгаагаар Улаанбаатар хот дотор иргэдийн нийт зорчих хөдөлгөөн 3,4 сая зорчилт/ өдөр болсоноос явганаар 30,6%, авто машинаар 24,2 %, таксигаар 9,2 %, автобусаар 33,4%, бусад тээврийн хэрэгслээр 2,6 % нь зорчдог гэсэн тооцоо гаргажээ.<sup>15</sup>

Хотын зам тээврийн сүлжээг сайжруулахын тулд нийт зорчих хөдөлгөөний дотор нийтийн а

<sup>15</sup>“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандага”

тээврийн эзлэх хувийн жинг тасралтгүй нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд нийтийн тээврийн ашигтай хэлбэрийг хөгжүүлэх зорилтод тусгасан тусгай замын автобусны (BRT) замыг байгуулж, том оврын автобусны парк шинэчлэлийг хийж, шинэ чиглэлүүдийг нэмэхээр төлөвлөсөн байна. Мөн тээврийн сүлжээний төлөвлөлтийг боловсронгуй болгож, орчин үеийн техник технологийн ололтыг үйлчилгээнд нэвтрүүлэх, одоо байгаа төмөр замыг хот дотор болон дагуул хот, тосгодыг холбосон нийтийн тээвэрт ашиглан, хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх, цаашид уг трассыг ашиглан Метро (LRT)-ны шугамыг барьж байгуулахаар төлөвлөсөн байна.

### **3.2.Тусгай замын автобус BRT**

Тусгай замын автобус бол нийтийн тээврийн багтаамж ихтэй төрөл бөгөөд хурд, нэвтрэх чадварыг эрс нэмэгдүүлдэг давуу талтай гэж үзсэн учраас Улаанбаатарт BRT системийг нэвтрүүлж, автозамын 2-4 дүгээр эгнээг тусгаарлан зөвхөн нийтийн тээврийн хэрэгслийг явуулах юм бол уг тусгай замаар цагт 8000-25000 зорчигч тээвэрлэх хүчин чадал бүрдэнэ гэж мэргэжлийн байгууллагууд тооцоолжээ. Энхтайваны өргөн чөлөөгөөр нэгдүгээр эгнээгээр зөвхөн нийтийн тээврийн хэрэгсэл зорчих болгосон хэдий ч автобуснууд 10-15 км/цагийн хурдтай л зорчдог байна. Тэгвэл тусгай замын автобусны сүлжээ ашиглалтад орох юм бол нийтийн тээврийн хэрэгсэл 40-45 км/цагийн хурдтай зорчих боломжтой болно гэсэн тооцоолол хийжээ. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн хэрэгслийн нэвтрэх чадвар, хурд 3-4 дахин нэмэгдэнэ гэсэн үг. Ингэснээр нийслэлчүүд авто замын түгжрэлгүй болно гэж үзэж байна.

Тусгай замын автобус нь дараах давуу шинж чанартай. Үүнд:

1. автозамын голд хоёр чиглэлд зорчдог;
2. төлбөрийн дэвшилтэт системтэй – смарт карт, цахим тасалбар гэх мэт;
3. автобустайгаа нэг түвшний зорчигчийн хүлээлгийн тавцантай;
4. өндөр настан, тэргэнцэртэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд шууд суух боломжтой;
5. уулзваруудын гэрлэн дохио нь автобус ойртмогц автоматаар мэдэрч ногоон болж өөрчлөгддөг гэх мэт.

Энэхүү тээврийн хэрэгслийг дэлхийн том хотуудын нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтэрсэн шилдэг туршлага, оновчтой шийдэл, загвар гэж үзсэн учраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банкт хамтран “Улаанбаатар хотын тээврийн чадавхыг бэхжүүлэх” төсөл хэрэгжүүлж байна. Уг төслийн зардал нь 215,9 сая ам.доллар байх бөгөөд Улаанбаатар метрогоос 7 дахин хямд зардлаар түгжрэлийг эрс бууруулж чадахуйц ажил хийгдэнэ гэж тооцсон байна. Техникийн туслалцааны багийнхан Улаанбаатар хотод тусгай замын автобусны шугам сүлжээг хэрхэн барьж байгуулах талаар нарийвчилсан судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэл, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөг урьдчилсан байдлаар гаргасан байна.

Улаанбаатар хотын хувьд Энхтайваны өргөн чөлөөнд тусгай замын автобусны шугам барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд үүн дээр нэмж хөдөлгөөний нягтрал ихтэй Намъяанжүгийн гудамж, Их тойруу, Долоон буудлын эцэс зэрэг зарим гудамж, өргөн чөлөө рүү салаалуулан тусгай замын автобусны шугам тавих боломжтой гэж үзсэн байна. Азийн хөгжлийн банкнаас төлөвлөж байгаагаар тусгай замын автобусны сүлжээг гурван хэсэг болгон хувааж, эхний хэсгийг ирэх 2018 онд, дараагийн хэсгийг 2019 он, гурав дахийг нь 2020 онд ашиглалтад оруулах юм байна<sup>16</sup>.

### **3.3.Улаанбаатар метро**

Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг - ЖАЙКА (JICA) энэхүү төслийн техник эдийн засгийн үндэслэл тооцоог 2013 оны 5 сард хийж дуусгасан байдаг. Толгойтоос Амгалан

а \_\_\_\_\_

<sup>16</sup>“ Монголын Ухаалаг Хөгжил ТББ”-ын тэргүүн, судлаач, тээвэр төлөвлөлтийн магистр Г.Бат-Эрдэнэ

хүртэл 17,6 км урт, нийтдээ 14 буудал бүхий өглөөний 6 цагаас үдшийн 11 хүртэл 9 минут тутамд явуулахаар тооцсон байна. Улаанбаатар метрог барихад 1,5 тэрбум ам.доллар хэрэгтэй. Үүнийг өнөөгийн ханшаар Монгол төгрөгт шилжүүлбэл 2,8 их наяд төгрөг болж байна. Үүнийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр төлөвлөжээ. Өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар метро барьсаны дараагаар төр өөрөө, эсхүл метрогоор зорчиж буй зорчигчдын тасалбараар энэхүү 2,8 их наяд төгрөгийг эргүүлж төлөхөөр тооцсон байна.

### **3.4.Рейлбус<sup>17</sup>**

Анх 1930-аад онд анхны загварыг гаргаж байжээ. Тогтмол хэрэглэгддэггүй төмөр замын дэд бүтцийг ашиглан зорчигч тээвэрлэдэгээрээ онцлогтой юм. Улаанбаатар Төмөр зам нийгэмлэг уг үйлчилгээг Оросын Метро, вагон үйлдвэрт үйлдвэрлэсэн РА-2 загварын дизель түлшээр ажилладаг рейлбусуудыг 2014 оны 5 сард авчирч, 6 сараас Улаанбаатар хотод үйлчилж эхэлсэн байна. Гэвч тус үйлчилгээг одоогоор түр зогсоосон бөгөөд Улаанбаатар-Дархан чиглэлд уг рейлбусуудыг хэрэглэхээр болсон байна. Тус үйлчилгээг зогсоох болсон учир нь “Улаанбаатарчууд гэр, ажлаасаа гараад хэрхэн рейлбусанд суух нь ойлгомжгүй, бүр боломжгүй байсан. Буудлуудын байршил, цагийн хуваарийн мэдээлэл нь тодорхойгүй, олон нийтэд хүртээмжгүй байсан байна. Хэрэв бүх буудлууд руу олны сайн мэдэх газруудаас хэрхэн очих тал дээр ажилласан бол рейлбус (маш бага зардлаар) өнөөдөр түгжрэлийг сааруулахад хувь нэмрээ оруулж чадах байсан” гэж тээвэр төлөвлөлтийн судлаачид дүгнэсэн байна.

### **3.5.Зам, тээврийн дэд бүтцийн эрх зүйн орчин**

Салбарын үндсэн зохицуулалт нь “Авто замын тухай” хууль бөгөөд тус хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт үндэсний авто замын сүлжээ төлөвлөх, авто зам, замын байгууламж барих, санхүүжүүлэх, тэдгээрийг өмчлөх, эзэмших, ашиглах, арчлах, засварлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна. Хуулийн 5-р зүйлд төрөөс үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэхэд баримтлах зарчмыг тодорхойлсон. Үүнд:

5.1.1.үндэсний авто замын сүлжээг хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэх;

5.1.2.авто зам, замын байгууламжийг эрх бүхий байгууллагаас батлагдсан стандарт, норм, нормативын дагуу барьж байгуулах;

5.1.3.авто зам барих, эзэмших, ашиглах, арчлах, хамгаалах, засварлах үеийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

5.1.4.үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэх, ашиглах удирдлагын нэгдмэл бүтэц, тогтолцоотой байх хэмээн тусгажээ.

Мөн 2014 онд Засгийн газраас санаачлан боловсруулсан **“Авто замын тээврийн салбарт төрөөс баримтлах бодлого”**-ын төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан ч батлагдаагүй байна.

“Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагаас ирүүлсэн саналд үндэслэн, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан боловсруулсан байна.

Мөн, Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болох мастер төлөвлөгөөг боловсруулж байна. Мастер төлөвлөгөөний зорилго нь хотын газар ашиглалт, авто зам, тээврийн төлөвлөлтийг цогцоор нь авч үзсэнээр зорчигчдын хувьд зорчих

а

<sup>17</sup> <http://www.ikon.mn/n/byh>

хөдөлгөөн, үйлчилгээний хүртээмж, аюулгүй байдлыг дээд зэргээр хангахад оршино. Мастер төлөвлөгөөний зорилтыг хангахын тулд дараах зорилтуудыг тавьсан<sup>18</sup>. Үүнд:

- Улаанбаатар хот, хот орчмын нутаг дэвсгэрийн авто замын сүлжээг хүртээмжтэй, нийгэм эдийн засгийн үр өгөөжтэй төлөвлөж, авто замын түгжрэлийг бууруулна.
- Замын хөдөлгөөний менежментийг хотын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- Хотын авто зам, тээврийн сүлжээ төлөвлөлт, хөдөлгөөний менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор гүүр, гүүрийн байгууламж, далан сувгийг оновчтой төлөвлөнө.
- Эрэлтэд суурилсан хүртээмжтэй нийтийн тээврийн сүлжээтэй болох.
- Ачаа тээвэр, логистикийн зөв менежментэй болох.
- Тээврийн хэрэгслийн хүртээмжтэй зогсоолтой байх зэрэг зорилтууд болно.

### Зам, тээврийн дэд бүтцийн талаарх бодлого, эрх зүйн орчны лавлагаа, мэдээлэл

IXүснэгт 3/

	Баримт бичгийн нэр	Холбогдох зүйл заалт
1	<p><b>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал</b></p> <p>(УИХ-ын 2010 оны 07-р сарын 15-ны өдрийн 48-р тогтоол )</p> <p>Эх сурвалж; <a href="http://www.nsc.gov.mn">www.nsc.gov.mn</a></p>	<p>3.4.3.2. Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, нийслэл орчмын бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар найдвартай хангаж холбоно.</p> <p>3.6.2.1. Мэдээлэл, мэдээллийн орчин, түүний дэд бүтцэд хууль бусаар нөлөөлөх, өөрчлөх үйлчлэлээс хамгаалснаар мэдээллийн бүрэн бүтэн байдал хангагдана.</p> <p>3.6.2.5. Цахим мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлэх, сүлжээ, систем, веб сайтын эмзэг байдлыг бууруулах, адилтган таних бат бэх систем, хортой кодоос хамгаалах удирдлага, өөрчлөлтийн удирдлагыг нэвтрүүлэх замаар дэд бүтэц, харилцаа холбоо, дамжуулалт, хандалтын нууцлал, хамгаалалтыг бүрдүүлнэ.</p> <p>3.6.3.4. Харилцаа холбооны шугам, сувгаас мэдээлэл алдагдах, гадагш урсахаас урьдчилан сэргийлэх, төрийн сүлжээ, өгөгдөл солилцооны хамгаалагдсан дэд бүтцийг байгуулах, утасгүй холбооны аюулгүй байдлыг хангана.</p> <p>3.6.3.6. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын цахим өгөгдлийг дамжуулах, хадгалахдаа шифрлэлт, тоон гарын үсэг, аюулгүй холболт ашиглана.</p> <p>3.6.4.1. Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана</p> <p>3.6.4.4. Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана.</p> <p>3.6.4.6. Үндэсний мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, халдлагыг сөрөн зогсох, даван гарах чадварыг бий болгож, тасралтгүй ажиллагааг хангах, сэргээн ажиллуулах төлөвлөлтийг хэвшүүлж, сүлжээний хяналт шинжилгээ, анхааруулгын төв байгуулж, компьютерын онцгой байдлын үед хариу үйлдэл хийх үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлнэ.</p>
2	<p><b>Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, 2030</b></p>	<p><b>2.1.Эдийн засгийн тогтвортой хөгжил</b></p> <p>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс,</p>

а

<sup>18</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирсэн бичгээс



<p>(УИХ-ын 2016 оны 02-р сарын 05 ны өдрийн 19-р тогтоол)</p> <p>Эх сурвалж: <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p>	<p>барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.</p> <p><b><u>2.1.5. Дэд бүтцийн салбар</u></b></p> <p>Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.</p> <p>I үе шат (2016-2020): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.</p> <p>II үе шат (2021-2025): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.</p> <p>III үе шат (2026-2030): Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох.</p> <p>Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.</p> <p>I үе шат (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг– Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх.</p> <p>II үе шат (2021-2025): Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.</p> <p>III үе шат (2026-2030): Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах.</p> <p>Зорилт 6. Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.</p> <p>I үе шат (2016-2020): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.</p> <p>II үе шат (2021-2025): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг хот, суурин газруудад хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 25 хувиар бууруулах.</p> <p>III үе шат (2026-2030): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг нутагшуулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот, суурин газруудыг хөгжүүлэх, барилгын дулааны алдагдлыг 40 хувиар бууруулах.</p> <p><b><u>2.1.7. Бизнесийн таатай орчин</u></b></p> <p>Зорилт 1. Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.</p> <p>I үе шат (2016-2020): Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.</p> <p>II үе шат (2021-2025): Тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах,</p>
---	--

		<p>татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулан, боловсронгуй болгож, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 18 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.</p> <p>III үе шат (2026-2030): Худалдаа, үйлчилгээний дэд бүтэц, ложистик сүлжээг хөгжүүлэн экспортын барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортын барааны тээвэрлэлтийн өртөг, зардлыг бууруулж, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 10 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах</p>
3	<p><b>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр</b></p> <p>(Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09-р сарын 09 ны өдрийн 45 дугаар тогтоол )</p> <p>Эх сурвалж <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p>	<p><b>Дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:</b></p> <p>2.86.Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.</p> <p>2.87.Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.</p> <p>2.89.Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.93.Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p><b>Зам тээврийн салбарын чиглэлээр:</b></p> <p><b>Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.</b></p> <p>2.111.Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ.</p> <p>2.112.“Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичиг” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна.</p> <p>2.113.“Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана.</p> <p>2.114.“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.115.Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.116.“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.117.Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.</p> <p>2.118.Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.</p> <p>2.119.Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.</p> <p>2.220.Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.</p> <p>2.221.Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.</p> <p>2.222.Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.</p> <p>2.223.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг,</p>

		<p>Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина.</p> <p>2.224.Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.</p> <p>2.225.Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлнэ.</p>
4	<p><b>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр</b></p> <p>(Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9-р сарын 29-ны өдрийн 3/08 тогтоол)</p> <p>Эх сурвалж: <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a></p>	<p><b><u>Хот байгуулалт, дэд бүтэц</u></b></p> <p>Нийслэлийн ирээдүйн хөгжлийг хангасан дэд бүтцийг хөгжүүлж, иргэдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд хот байгуулалтын үйл ажиллагааг чиглүүлнэ. Улаанбаатар хотод сэргээгдэх болон эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг бий болгож, газар зохион байгуулалтыг шинэчилж, дэд бүтцийн салбарт шинжлэх ухаанд суурилсан, ухаалаг шийдэл бүхий шинэ техник, технологи нутагшуулна.</p> <p><b><u>2.1 Эрх зүйн орчныг шинээр бүрдүүлнэ.</u></b></p> <p>2.1.1.Улаанбаатар хотын бүсчлэлийн тухай хууль, дүрэм боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>2.1.2.Хотын дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулна.</p> <p><b><u>2.2 Ухаалаг төлөвлөлт, ил тод газрын харилцаа</u></b></p> <p>2.2.1.Хотын инженерийн шугам сүлжээ, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулна.</p> <p>2.2.2 Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулна.</p> <p>2.2.5.Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудлын орчимд “Аэро сити” хот байгуулна.</p> <p><b><u>2.4. Найдвартай дэд бүтэц, хөгжлийн түлгүүр</u></b></p> <p>Эрчим хүчний хангамжийг сайжруулна.</p> <p>2.4.1 Цахилгаан станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, хотын дулаан, цахилгаан хангамжийн тогтвортой, найдвартай байдлыг сайжруулна.</p> <p>2.4.2 Улаанбаатар хотын гэр хороолол, дагуул хотууд, шинэ бүтээн байгуулалтын бүсүүдэд эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулна.</p> <p>2.4.11Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг Улаанбаатар хотын суурин газарт барьж, зохистой харьцаагаар хөгжүүлнэ.</p> <p><b><u>2.5 Түгжрэлгүй гудамж - Бүхимдалгүй хот</u></b></p> <p>Автозам, замын байгууламжид өргөтгөл, шинэчлэл хийнэ.</p> <p>2.5.1 Нийслэлийн Авто замын сүлжээг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөө боловсруулна.</p> <p>2.5.2 Хөшигийн хөндийн хурдны зам барьж, Туулын хурдны зам барих ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.5.3 Төмөр замтай огтлолцсон зам, уулзварт томоохон гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.5.4 Төмөр замаар тусгаарлагдсан гудамж, замуудыг холбосон нүхэн гарцуудыг шинээр барина.</p> <p>2.5.5 Гол гудамж, замуудын хөдөлгөөн нэвтрүүлэх чадварыг сайжруулж, Баруун, Зүүн 4 замын уулзварт олон түвшний огтлолцол байгуулна.</p> <p>2.5.6 “Гадна тойруу”, “Баруун тойруу” авто замын сүлжээг барих ажлыг эхлүүлнэ.</p> <p>2.5.7 Авто замын сүлжээний хэвтээ болон босоо тэнхлэгийн зэрэгцээ замуудыг нэмэгдүүлж, гол болон туслах гудамж замууд болон тэдгээрийг холбосон авто замуудыг шинээр барина.</p> <p>2.5.8 Авто замын сүлжээний техник ашиглалтын түвшинг сайжруулж, гол болон туслах гудамж замуудыг өргөтгөн шинэчлэнэ.</p> <p>2.5.9 Явган хүнд зориулсан нүхэн болон гүүрэн гарцуудыг барина.</p> <p>2.5.10Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замыг өргөтгөн шинэчлэнэ.</p> <p>2.5.11 Явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>



		<p>2.5.12 Орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар дээрх, доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.</p> <p><b><u>Нийтийн тээврийг шинэ шатанд гаргана.</u></b></p> <p>2.5.13 Нийтийн тээврийн үр өгөөжийг дээшлүүлэх мастер төлөвлөгөө шинээр боловсруулна.</p> <p>2.5.14 Улаанбаатар хотод ачаа тээврийн ложистикийн төвийн шинэ гарцуудыг /терминаль/ барина.</p> <p>2.5.15 Автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.</p> <p>2.5.16 Нийтийн тээврийн санхүүгийн бие даасан байдлыг хангах менежмент хэрэгжүүлнэ.</p> <p>2.5.17 Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж, иргэдийн эрэлтэд нийцсэн шинэ чиглэл бий болгоно.</p> <p>2.5.18 Нийтийн тээврийн хэрэгслийг байгальд ээлтэй технологид шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, эко автобус, троллейбусны хэрэглээг нэмэгдүүлнэ.</p> <p>2.5.19 Эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн ухаалаг системийг боловсронгуй болгоно.</p> <p>2.5.20 Улаанбаатар хотын такси үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2.5.21 Төмөр замын сүлжээг хотын нийтийн тээвэрт ашиглана.</p> <p>2.5.22 Замын хөдөлгөөний оновчтой системийг өргөжүүлэн, шинэчлэлт хийнэ.</p> <p>2.5.23 Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг Улаанбаатар хоттой төмөр замаар холбох, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлын судалгааг холбогдох байгууллагуудтай хамтарч хийнэ.</p> <p><b><u>Хүрэх үр дүн:</u></b></p> <p>Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэршүүлсэн усны түвшин 85-аас дээш хувьд хүрч, Туул голын бохирдол эрс буурна. 150 км авто зам шинээр баригдаж, түгжрэл буурна. Байгаль орчинд ээлтэй, аюулгүй, найдвартай их, дунд багтаамжийн эко автобус, троллейбусаар парк шинэчлэгдэнэ.</p>
5	<p><b>Төрөөс хувийн хэвшлийн түншлэл талаар баримтлах бодлого</b></p> <p><i>УИХ-ын 2009 оны 10-р сарын 15-ны өдрийн 64-р тогтоол, (2012 оны 8-р сарын 17 ны өдрийн 16-р тогтоолоор өөрчлөлт орсон)</i></p> <p><i>Эх сурвалж; <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></i></p>	<p><b>Нэг. Нийтлэг үндэслэл</b></p> <p>1.2.Түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого /цаашид” бодлого” гэх/ нь дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх, Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлэх замаар эдгээр салбар дахь төрийн оролцоог оновчтой болгох, суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.</p> <p>1.3.Бодлогын зорилт нь:</p> <p>1.3.2.дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, нэгдсэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;</p> <p>1.3.3.дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.</p> <p>5.Түншлэлийн талууд</p> <p>5.5.2.өөрийн мэдэлд байгаа дэд бүтцийн байгууламжийг хувийн хэвшлийн этгээдэд концессын гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>б/дэд бүтцийн үйлчилгээний тариф тухайн үйлчилгээг үзүүлэхэд гарч байгаа зардлаас бага байвал үйл ажиллагааны үр дүнд үндэслэн ажлын хөлс, төлбөр төлөх;</p> <p>5.6.5.дэд бүтцийн салбарын түншлэлд оролцогч нь тухайн салбарт техник, технологийн шинэчлэл хийх.</p>

6	<p><b>Эдийн засгийн сэргээх хөтөлбөр</b></p> <p>(УИХ-ын 2016 оны 11-р сарын 24-ны өдрийн 71-р тогтоол)</p> <p>Эх сурвалж; <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p>	<p>2.2.Бодит салбарын өсөлтийг дэмжих томоохон төслүүдийг эхлүүлж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;</p> <p>2.2.1.Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВТ-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВТ-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх;</p> <p>2.2.2.Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богд хан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх;</p> <p>2.2.3.Эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах хүрээнд цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх;</p> <p>2.2.4.Томоохон үйлдвэрлэл дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжиж, төрөлжсөн кластерыг бий болгох замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>2.2.5.Хөшигийн хөндийд баригдаж байгаа Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлэх.</p>
7	<p><b>Авто замын салбарын чадавхыг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр</b></p> <p>(УИХ-ын 2011 оны 258-р тогтоол )</p> <p>Эх сурвалж: <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p>	<p>2.Хөтөлбөрийн зорилго. Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлж, авто замын чанар, ашиглалтын бэлэн байдлыг хангаж чадахуйц орчин үеийн шаардлага хангасан, олон улсын түвшинд хүрсэн салбарын чадавхи бүрдүүлэхэд оршино.</p> <p>3.Хөтөлбөрийн зорилт. Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтуудыг дэвшүүлснээр хэрэгжүүлнэ.</p> <p>3.1. Авто замын салбарын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;</p> <p>3.2.Авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангах;</p> <p>3.3.Авто замын салбарын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх;</p> <p>3.4.Авто замын салбарын байгууллагуудыг бэхжүүлэх.</p> <p>Зорилт 2. Авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангах.</p> <p>8.1.Авто замын засвар арчлалтын менежментийг боловсронгуй болгох</p> <p>8.1.1.улсын болон нийслэл, орон нутгийн авто замын засвар арчлалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх. Одоо ашиглагдаж байгаа авто замын дийлэнх хувь нь их засвар хийх хугацаа өнгөрч ашиглалтын бэлэн байдлыг хангахгүй болсон байдалд судалгаа хийж дунд болон их засвар хийх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх. Улсын чанартай болон нийслэлийн хатуу хучилттай авто замд ээлжит болон их засварыг төлөвлөгөөний дагуу жил тутам хийж хэвшүүлэх.</p> <p>8.1.7.нийслэлийн авто замын урсгал засварын ажлыг гүйцэтгэж байгаа одоогийн зохион байгуулалт, арга хэлбэрийг боловсронгуй болгох. Нийслэлийн авто замын арчлалтын ажлыг дүүргийн тохижилт үйлчилгээний компаниуд, засварын ажлыг тендерт шалгарсан компаниуд гүйцэтгэж байгаа байдлыг өөрчилж засвар арчлалтын ажлыг байнга хариуцдаг тодорхой байгууллагатай болох.</p> <p>Зорилт 3.Авто замын салбарын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх.</p> <p>9.1.Замын барилгын ажлын хөрөнгө оруулалтыг нийгэм-эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэн төлөвлөлт хийж хэвшүүлэх. "Авто замын сүлжээг 2020 он хүртэл хөгжүүлэх" ерөнхий төлөвлөгөө, "Мянганы зам" төсөл, "Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд авто замын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх.</p> <p>9.1.1.авто замын мастер төлөвлөгөөг бүс нутаг, уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн бодлоготой уялдуулан шинэчлэх.</p>

		<p>Төрөөс баримталж байгаа бүс нутаг, уул уурхай, аялал жуулчлалын хөгжлийн бодлогод гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан Авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг шинэчлэх;</p> <p>9.1.2.төрөөс баримталж байгаа хөгжлийн бодлого, хэтийн төлөвлөгөөг үндэслэн салбарын хөрөнгө оруулалтын дунд хугацааны болон жилийн төлөвлөгөө боловсруулах.</p> <p>Зорилт 4. Авто замын салбарын байгууллагуудыг бэхжүүлэх.</p>
8	<p><b>Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны хөтөлбөр</b> (УИХ-ын 2010 оны 06-р сарын 25-ны өдрийн 36-р тогтоол)</p> <p>Эх сурвалж <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p>	<p><b>4.1.1.Хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр:</b></p> <p>4.1.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар хот, суурины газар ашиглалтыг сайжруулж, эрчим хүч, авто зам, инженерийн дэд бүтцийг шинэ түвшинд хөгжүүлэх;</p> <p>4.1.1.2. Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийн 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон шинээр төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх;</p> <p>4.1.1.3. хот байгуулалт, төлөвлөлтийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;</p> <p>4.1.1.4. хот, суурины газар ашиглалт, түүний олголтыг бодлогоор зохицуулах, гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх;</p> <p>4.1.1.5. уул уурхайг түшиглэсэн хот, сууриныг хөгжүүлэх.</p> <p><b>4.4.2.Дэд бүтцийн зорилтын хүрээнд:</b></p> <p>4.4.2.1.шинээр болон шинэчлэн баригдах суурин газар, орон сууцны цогцолбор хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн хамтаар бүтээн байгуулах;</p> <p>4.4.2.2.суурин газар болон орон сууцны цогцолбор хорооллуудын эрчим хүчний хангамжийн тодорхой хэсгийг тухайн нөхцөлд тохирсон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах замаар хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашигтай хэлбэрт шилжүүлэх;</p> <p>4.4.2.3.эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг барьж ашиглалтад оруулах;</p> <p>4.4.2.4.Улаанбаатар хотод цахилгааны 110 кВ-н "Их тойруу" цагираг шугам сүлжээ байгуулах;</p> <p>4.4.2.5.Улаанбаатар хотын "Дулааны цахилгаан станц-3" ТӨХК, "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-ийн үйлдвэрийн уурын нөөцийг дулаан үйлдвэрлэх зориулалтаар ашиглах, Буянт-Ухаа, 7, 14 дүгээр хороолол, Монголын олон нийтийн радио телевизийн орчим, Зүүн Сэлбэ хорооллын шугам сүлжээг барих, "Дулааны цахилгаан станц-4" ТӨХК-иас Баянгол амын чиглэлийн дулааны шугам сүлжээг ашиглалтад оруулах;</p> <p>4.4.2.6.Улаанбаатар хотын гэр хорооллын 2500 айл өрхийг төвлөрсөн дулаан хангамжид хэсэгчилэн холбох;</p> <p>4.4.2.7.Улаанбаатар хотод "Гацуурт", "Буянт-Ухаа" гүний усны эх үүсвэр, "Туул усан цогцолбор" далан барьж ашиглалтад оруулах;</p> <p>4.4.2.8.Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах;</p> <p>4.4.2.9.Улаанбаатар хотын хэмжээнд хаягдал (саарал) ус, лагийг дахин ашиглах технологийн шинэчлэл хийх;</p> <p>4.4.2.10.Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүдийг ойролцоох хилийн боомтуудтай холбосон 5572 км авто зам барих;</p> <p>4.4.2.11.Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны замыг барьж ашиглалтад оруулах;</p> <p>4.4.2.12.Улаанбаатар хотын авто замын 1, 2, 3 дугаар тойрог замыг шинээр бий болгох, тойрог замыг холбосон туслах зам, хотын алслагдсан дүүрэг, шинээр баригдсан орон сууцны цогцолбор хорооллуудыг холбосон авто зам барих, шинэчлэн сайжруулах, Хөшигийн хөндийн нисэх буудалтай холбосон шинээр нийт 212 км авто зам, шинэчилсэн 350 км авто зам, 2 түвшний гүүрэн 7 гарц барих.</p>

<p><b>Монгол Улсын нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл</b></p> <p>(УИХ-ын 2016 оны 11-р сарын 24-ны өдрийн 70-р тогтоол)</p> <p>Эх сурвалж: <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a></p> <p><u>Товчлол</u></p> <p>МУТХҮБ- МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал</p> <p>ЗГҮАХ- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>ТХХТ- төр хувийн хэвшлийн түншлэл</p>	<p><b>Хавсралт 2</b> <b>Нэг.Шинээр батлах хуулийн төслийн жагсаалт:</b> 1.Хотыг дахин хөгжүүлэх /төлөвлөх/ тухай хуулийн төсөл; 2.Хог хаягдлыг хаях, ангилах, устгах, дахин ашиглах тухай хуулийн төсөл 3.Авто зогсоолын тухай хуулийн төсөл; <b>Хоёр. Шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн жагсаалт:</b> 1.Хот байгуулалтын тухай хууль; 2.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; 3.Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль; 4.Автотээврийн тухай хууль; 5.Авто замын тухай хууль; <b>Гурав. Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл:</b> 1.“Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл <b>Зорилт 7. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зам, тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.</b> <b><u>7.1 МУТХҮБ-ын 2.1.5.</u></b> Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114, 2.116 дахь заалт Дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчныг сайжруулж, тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх  <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулах хэлэлцээрийн тоо</li> <li>Шинээр боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо</li> </ul> <b><u>7.2 МУТХҮБ-ын 2.1.5.</u></b> Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107 дахь заалт Олон улс, хот хооронд болон орон нутгийн чанартай авто замын төслүүдийг үргэлжлүүлэх  <ul style="list-style-type: none"> <li>Ашиглалтад орох хатуу хучилттай авто замын урт, 457 км (Улсын төсөв 4,0 тэрбум, хөгжлийн банк-16,2 тэрбум, гадаад эх үүсвэр- 57,9 тэрбум төгрөг)</li> </ul> <b><u>7.3 МУТХҮБ-ын 2.1.5.</u></b> Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.108 дахь заалт, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 3.2.4 дэх заалт Бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх  <ul style="list-style-type: none"> <li>Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 60 хувиар, 222,8 тэрбум төгрөг;</li> <li>Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 10 хувиар, 247,5 тэрбум төгрөг гадаад эх үүсвэр;</li> <li>Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн боомтын төмөр замын барилгын ажлын явц, 100 хувиар, 156,0 тэрбум төгрөг гадаад эх үүсвэр;</li> <li>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, 20 хувиар, 585,0 тэрбум төгрөг, ТХХТ;</li> <li>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийн явц 10 хувиар, 10,8 тэрбум төгрөг, ТХХТ;</li> <li>Богдхан төмөр замын төслийн хэрэгжилтийн явц, 10,хувиар, 3,4 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэр.</li> </ul> МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.117 дахь заалт</p>
---	---

## ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), Г.Алтан-Оч (Ph.D),  
Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа,  
Р.Нургүл, Ц.Элбэгзаяа*

### АГУУЛГА

#### НЭГ. ХУДАЛДААНЫ БОДЛОГО БА ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

- 1.1 Худалдааны бодлого
- 1.2 Олон талт худалдааны зохицуулалт

#### ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

##### 2.1. ОХУ-ын туршлага

- 2.1.1 “Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай” хууль
- 2.1.2 “Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай” хууль

##### 2.2. БНКаЗУ-ын туршлага

- 2.2.1. “Худалдааны үйл ажиллагааг зохицуулах тухай” хууль

##### 2.3. ЯПОН Улсын туршлага

- 2.3.1. Худалдааны тухай хууль
- 2.3.2. Гадаад валют болон гадаад худалдааны тухай хууль

##### 2.4. БНХАУ-ын туршлага

- 2.4.1. Гадаад худалдааны тухай хууль

##### 2.5. БНСУ-ын туршлага

- 2.5.1. Худалдааны тухай хууль
- 2.5.2. Гадаад худалдааны тухай хууль

##### 2.6. БНЧУ-ын туршлага

- 2.6.1. Худалдааны тухай хууль
- 2.6.2. Худалдааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

##### 2.7. ХБНГУ-ын туршлага

- 2.7.1. Худалдааны тухай багц хууль
- 2.7.2. Гадаад аж ахуйн тухай хууль

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## НЭГ. ХУДАЛДААНЫ БОДЛОГО БА ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

### 1.1 Худалдааны бодлого

Олон улсын худалдаанд үйлвэрлэгчид, хэрэглэгчид шууд оролцох боловч олон улсын худалдаанаас олох ашгийн хуваарилалтад тэдгээрээс гадна зуучлагч, борлуулагч, тээвэрлэгч, санхүүгийн байгууллагууд, Засгийн газар зэрэг олон субъектууд оролцдог. Засгийн газар нь импорт, экспортын татвар, хураамж, зөвшөөрөл, лиценз зэрэг хэрэгслүүдээр дамжуулан худалдааг зохицуулна.

Засгийн газраас дотооддоо үндэсний хэмжээнд эдийн засгийн харилцаагаа цогц байдлаар зохицуулах, үүнд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна дэлхийн бусад орнуудтай хамтран ажиллах, үндэснийхээ боломжид тохируулан эрх ашгаа хамгаалах, үндэсний үйлдвэрлэгчид, худалдаа эрхлэгчдийгээ дэмжин урамшуулах, эсхүл саад тотгор учруулах зэргээр тодорхой зорилго бүхий уян хатан арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд худалдааны бодлогоо чиглүүлнэ. Үндэсний боломж гэдэгт хүн ам, байгалийн баялаг, эдийн засгийн болон техник, технологийн чадавх, газар зүйн байрлал, уламжлал, ёс заншил зэрэг олон хүчин зүйлийг тооцож болно.

Гадаад худалдааны хувьд олон улсын худалдааны эрх зүйн орчин, бүс нутгийн орнуудын худалдаа, хамтын ажиллагаа, интеграцийн түвшин, томоохон орнууд, үндэстэн дамнасан корпорациудын баримталж байгаа бодлого зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг.

Үндэсний Засгийн газар бүр олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, ялангуяа Дэлхийн худалдааны байгуулага(ДХБ)-ын олон улсын хэлэлцээрүүдээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд гадаад худалдааны бодлогоо хэрэгжүүлэх бөгөөд үр дүн нь эерэг, сөрөг аль нь ч байж болох талтай. Олон улсын практикт Засгийн газраас дараах 2 төрлийн гадаад худалдааны бодлогыг явуулж байна. Үүнд:

- Худалдааны либераль бодлого;
- Худалдааны протекционист(хамгаалах) бодлого.

Худалдааны либераль бодлогын үед төрөөс олон улсын худалдаанд аливаа зохицуулалтыг хязгаарлагдмал хүрээнд буюу маш бага хэмжээгээр хийдэг. Давуу тал нь харьцангуй зардал бага, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд харьцангуй хямд үнээр хүргэх боломжтой, техник технологийг нэвтрүүлэхэд хялбар, захиргааны дарамт, хүнд суртал, хээл хахууль харьцангуй бага байдаг гэж үздэг.

Худалдааны протекционист бодлогын үед төрийн зохицуулалт их байдаг. Давуу тал нь үйлдвэрлэл, дотоодын зах зээлээ хамгаалах боломжтой, экспорт, импортын татвараас Засгийн газрын орлого нэмэгдэж, ажил эрхлэлт тогтвортой, өсөх хандлагатай байдаг байна.

Улс орон бүр өөрийн орны онцлог, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн бодлогыг сонгон хэрэгжүүлдэг. Худалдааны протекционист бодлогыг өндөр хөгжилтэй орнууд, либераль бодлогыг эдийн засаг нь гадаад худалдаанаас илүү хамааралтай хөгжиж буй орнууд түлхүү хэрэглэж байна.

ДХБ-аас гишүүн орнууддаа татвараас бусад аргаар худалдааг саармагжуулах, саад тотгор учруулахыг зарчмын хувьд хориглосон байдаг боловч одоогийн байдлаар улс орнуудаас протекционист бодлогыг хэрэгжүүлэхдээ импорт, экспортын татвар, тооны хязгаарлалт, лиценз, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээ, татаас, саармагжуулах, хамгаалах арга хэмжээ зэргийг тодорхой хэмжээнд хэрэглэсээр байна. Худалдааны бодлого боловсруулахад эдийн засгийн үр ашгаас гадна улс төрийн бодлого, интеграцчилал, байгаль орчны бодлого зэрэг олон асуудлуудыг харгалзан үздэг.



ДХБ-аас гишүүн орнуудын Засгийн газарт гадаад худалдааг зохицуулахдаа тарифын бус аргыг аль болох хэрэглэхгүй байх, тарифын бус зохицуулалтаа тарифын зохицуулалтад шилжүүлэх бодлого баримтлахыг шаарддаг. Улс орнууд ДХБ-ын хэлэлцээрээр авсан үүрэг амлалтынхаа хүрээнд тарифаа чөлөөтэй зохицуулан тогтоох эрхтэй боловч тарифын хэмжээ нь үүрэг авсан (bound tariff) тарифын хэмжээнээс давахгүй байх, онцгой тохиолдолд демпингийн эсрэг хамгаалалтын арга хэмжээний хүрээнд илүү өндөр тарифыг зөвшөөрөгдсөн хэмжээнд, тодорхой хугацааны хязгаар дотор хэрэглэхийг зөвшөөрдөг байна.

Импортын тариф буюу татвар нь гол төлөв дотооддоо үнийн түвшинг барих, зах зээл, үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилготой байдаг бол экспортын татвар нь бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах, байгалийн баялгийн экспортын орлогоос иргэдэд хүртээх зорилготой байдаг байна.

ДХБ-д экспортын тарифын зохицуулалт байхгүй учир улс орнууд өөрийн худалдааны бодлогын хүрээнд зохицуулах боломжтой.

Засгийн газруудын зүгээс тарифын зохицуулалтыг дараах зорилгоор ашигладаг.

- Худалдааны нөхцөлөө шаардлагатай түвшинд барих;
- Дотоодын зах зээлээ хамгаалах;
- Шинээр “төрж” буй үндэсний үйлдвэрээ дэмжих;
- Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх;
- Төлбөрийн балансыг зохих түвшинд байлгах үүднээс импортыг бууруулах;
- Макро-эдийн засгийн зорилтуудаа хэрэгжүүлэх... гэх мэт.

Улс орнуудын хэрэглэж байгаа тариф нь бараа бүтээгдэхүүний төрөл тус бүр дээр өөр өөр байх бөгөөд ДХБ-д элсэхэд үүрэг авсан тарифаас ихэвчлэн доогуур байна. Энэ нь Засгийн газрууд уян хатан, доогуур тариф тогтоож байгаад шаардлага гарвал тарифаа өсгөх, нөгөө талаас ДХБ-аас аль болох доогуур тариф тогтоохыг шаарддагтай холбоотой.

Засгийн газруудаас худалдааны бодлого хэрэгжүүлэхдээ а) тариф, б) тарифын бус арга хэмжээ, в) техникийн саад тотгорыг ашигладаг.

#### Тариф:

- Гаалийн тариф буюу экспорт, импортын тариф.

#### Тарифын бус арга хэмжээ:

- Татаас;
- Импорт, экспортын лиценз;
- Импорт, экспортын тооны хязгаарлалт;
- Сайн дурын хязгаарлалт;
- Бүтээгдэхүүний өртөгт эзлэх дотоодын хүчин зүйлийн хэмжээ, худалдан авалтын зохицуулалт;
- Мөнгө солилт, санхүүгийн шаардлага;
- Демпингийн эсрэг татвар;
- Хамгаалалтын арга хэмжээний татвар;
- Саармагжуулах арга хэмжээний татвар;
- Хил дээр авах урьдчилсан татвар;
- Эрүүл ахуй, эрүүл мэндийн шаардлага;
- Импортын бараанд борлуулалтын дээд болон доод үнийг зааж өгөх;
- Худалдааны хөнгөлөлт.

UIH.MN  
СУДАЛГААНИЛСАН

### Техникийн саад тотгор:

- Техникийн болон стандартын шаардлага тавих;
- ГШХО-тай компанид үндэсний норм, стандартыг хэрэглэхийг шаардах;
- Өрсөлдөөнийг хязгаарласан дотоодын эрх зүйн орчныг мөрдүүлэх;
- Оюуны өмчийг хамгаалах нийтлэг бус шаардлага тавих;
- Шилжин суурьших, визийн хатуу журам мөрдүүлэх;
- Засгийн газрын худалдан авалтад гадаадын компанийг ялгаварлан гадуурхах;
- Улсын худалдаанд онцгой эрх олгох, монополь эрхтэй байх;
- Гаалийн үнэлгээ, барааг гаалиас авахад хатуу журам тогтоох зэрэг арга хэмжээнүүд орно.

Түүнчлэн далайд гарцгүй байх, авто, төмөр замын хүчин чадал муу, хилийн боомтуудын тоо цөөн, валютын ханш, эрх зүйн орчин тогтворгүй байх нь худалдаанд саад болдог.

ДХБ-ын хүрээнд экспортын хязгаарлалтыг зөвхөн дараах тохиолдолд хэрэглэхийг зөвшөөрдөг. Үүнд:

- ✓ Олон улсын худалдаанд гарах бараа, бүтээгдэхүүний ангилал, чанар, стандартыг олон улсын норм, дүрэмд нийцүүлэх зорилгоор хязгаарлалт хийх;
- ✓ Хүнсний болон эдийн засагт чухал ач холбогдолтой тодорхой бүтээгдэхүүний хомсдол зах зээлд үүсэхээс болгоомжлох буюу тийм байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд хязгаарлалт хийх.

Дараах тохиолдолд хязгаарлалт хийхийг хориглоно. Үүнд:

- ✓ Үндэсний түүхий эдийг боловсруулах тодорхой үйлдвэрийг дэмжих үүднээс хязгаарлалт тогтоох;
- ✓ Экспортлогчдын хоорондын өрсөлдөөнийг багасгах үүднээс хязгаарлалт тогтоох.

Олон улсын худалдааг ДХБ-ын хэмжээнд тогтоосон олон талт эрх зүйн зохицуулалт, НҮБ болон бусад олон улсын байгууллагаас гаргасан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн орчин, олон улсын тусгай эрх зүйн хэм, хэмжээгээр зохицуулдаг бөгөөд эдгээр 3 чиглэлийн хэм, хэмжээ нь олон улсын худалдааны суурь эрх зүйн зохицуулалтад тооцогддог.

ДХБ-ын хэмжээнд тогтоосон олон талт эрх зүйн зохицуулалт нь олон улсын худалдааны зарчмуудыг тогтоож, гишүүн орнуудын төр засгаас баримтлах худалдааны бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлдог заавал дагаж мөрдөх эрх зүйн орчин юм.

НҮБ-ын хүрээнд боловсруулсан томоохон баримт бичиг, конвенциуд нь улс хоорондын харилцааны үндсэн зарчмуудыг тогтоож, олон улсын эрх зүй, ёс заншлыг нэгтгэн ижилтгэж, нэгдсэн эрх зүйн орчинг бий болгосон байдаг.

Олон улсын тусгай эрх зүй нь худалдаа, хамтын ажиллагааны техникийн асуудлуудыг зохицуулах, маргааныг шийдвэрлэх зэрэгт чиглэгдсэн байдгаараа онцлогтой.

### **1.2.Олон талт худалдааны зохицуулалт**

Олон талт худалдааны эрх зүйн орчныг Дэлхийн худалдааны байгууллага(ДХБ)-ын олон талт хэлэлцээний хүрээнд тогтоодог бөгөөд ингэснээр олон улсын худалдааны нэгдсэн тогтолцоог үүсгэдэг. ДХБ-ын худалдааны олон талт зохицуулалтын дүнд гишүүн орнууд худалдааны бодлогын ил тод, тогтвортой байдлаа хангаж, тарифыг аль болохоор бууруулах, худалдааг чөлөөтэй болгосноор бий болох давуу талуудыг нийтээр ашиглахаас гадна гишүүн орнууд үндэсний эрх ашгаа тэгш эрхтэйгээр хамгаалах бололцоог олгодгоороо давуу талтай.

ДХБ-ын гишүүн орнуудын олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь дараах

үндсэн 4 зарчимд тулгуурлана. Үүнд:

1. Үндэстний нэн тааламжтай байх зарчим гэж аливаа нэг гишүүн орноос нөгөө гишүүн оронд олгосон хөнгөлөлт, давуу талыг бусад гишүүн орнууд аяндаа эдлэх бололцоо олгохыг хэлнэ.
2. Худалдаанд ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь тухайн орны дотоодод үйлчлэх бөгөөд хамтын ажиллагаанд оролцогч орон, компани, барааг өөр хооронд нь гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог. Энэ зарчим нь хэсэг бүлэг орны хооронд, эсхүл бүс нутагт байгуулсан гаалийн холбоо, чөлөөт худалдааны бүсийн дотоод зохицуулалтад хамаарахгүй.
3. Хөгжиж байгаа орнуудад тусгайлан ялгавартай хандах зарчим нь ДХБ-ын зүгээс хөгжиж байгаа орнуудын хөгжлийн шаардлагыг харгалзан үзэж тэдэнд дэлхийн худалдаа, эдийн засгийн интеграцчилалд ороход нь дэмжлэг үзүүлэх үүднээс харилцан адил байхыг шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Дээрх зарчмын хүрээнд хөгжиж буй орнуудад зориулсан “Худалдааны хөнгөлөлтийн систем” бий болгож буурай хөгжилтэй, хөгжиж буй, шилжилтийн эдийн засагтай орнуудад техникийн хамтын ажиллагааны туслалцааг түлхүү авах эрхийг баталгаажуулсан.
4. Худалдааны бодлогын ил тод байдлыг хангаж, урьдчилан харах бололцоотой байлгах зарчим нь бизнесийн эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, бодлогын өөрчлөлтийг урьдчилан харах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлсэн. Гишүүн орнуудын тарифын хэмжээ тогтвортой, үндэсний хэм, хэмжээ тогтоосон эрх зүйн акт, худалдааны практик нь ил тод, олон нийт, бизнесийн хүрээнийхэн болон ДХБ-д мэдээллийг ил тод, нээлттэй байлгах аар зохицуулжээ.

ДХБ-ын хүрээнд байгуулсан олон талт хэлэлцээр, гишүүн орноос ДХБ-д элсэхдээ авсан үүрэг амлалт нь олон улсын гэрээний нэгэн адил хүчинтэй байдаг учраас Монгол Улсын дотоодод ч үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх учиртай. Хэрэв дотоодын хууль тогтоомжийн заалт олон улсын гэрээний заалттай зөрчилдвөл олон улсын гэрээний заалтыг баримтлахаар Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 2-т заасан байдаг.

Гишүүн орнуудаас ДХБ-д элсэхдээ орны жагсаалт<sup>19</sup>-аар авсан үүрэг амлалт нь олон талт хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг гэж тооцогддог учир тэдгээрийг мөн адил биелүүлэх үүрэг хүлээнэ. Гишүүн орны зүгээс ДХБ-ын хүрээнд авсан үүрэг амлалтаа өөрчлөхийг хүсвэл бүх гишүүн оронтой хэлэлцээнд орох, үүрэг амлалтыг шинэчлэн тогтоохдоо харилцан буулт хийх шаардлагатай болох тул хүндрэлтэй асуудалд тооцогддог байна.

ДХБ-ын бусад олон улсын байгууллагуудаас ялгарах онцлог нь олон талт зохицуулалтын хүрээнд авсан үүрэг амлалтаа заавал биелүүлэх үүрэгтэй байхаас гадна ДХБ шийдвэрийг хүчлэн хэрэгжүүлэх механизмтай байдаг оршино. Тийм ч учраас дэлхийн улс орнууд ДХБ-д элсэн орохдоо нухацтай, болгоомжтой ханддаг. Учир нь гишүүн орнууд хүлээсэн үүргээ өөрчлөх болон цуцлах шаардлагатай болсон бол бусад гишүүн орнуудын зөвшөөрлийг авах, харилцан буулт хийхээс гадна нэмэлт үүрэг амлалт авахад хүрдэг байна.

## **ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **2.1. ОХУ-ЫН ТУРШЛАГА**

ОХУ-д худалдааны салбарын харилцааг “Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай” хууль, “Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай” хууль зэрэг бие даасан хуулиудаар зохицуулж байна. Хуулийн зохицуулалтын дэлгэрэнгүйг доорх хуулийн бүрэн орчуулгаас үзнэ үү. (Албан бус орчуулга-Ц.Норовдондог (Ph.D))

а

<sup>19</sup> Улс орнууд ДХБ-д элсэх хүсэлт гаргасны дараа сонирхсон бүх гишүүн оронтой тарифын асуудлаар 2 талын хэлэлцээ явуулж дуусгаад хэлэлцээний хамгийн бага дүнг, мөн элсэгч орноос тодорхой асуудлаар тусгайлан авсан үүргүүдийг нэгтгэн жагсаалт гаргасныг орны жагсаалтаар авсан үүрэг гэж нэрлэдэг.

## 2.1.1 “ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” ОХУ-ЫН ХУУЛЬ<sup>20</sup>

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1-р зүйл. Хуулийн зорилго ба зохицуулалтын хүрээ

1. Энэ хуулиар ОХУ дахь худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах харилцааны үндсийг тодорхойлно (цаашид худалдааны үйл ажиллагаа гэх).
2. Хуулийн зорилго нь:
  - 1) ОХУ-ын хэмжээнд явуулж буй худалдааны үйл ажиллагаа, түүнийг эрхэлж буй байгууллагуудад тавигдах шаардлагыг тодорхой болгож, улсын хэмжээнд эдийн засгийн нэгдмэл байдлыг хангах;
  - 2) ОХУ-ын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй бараа бүтээгдэхүүнээр эдийн засгийн бүх салбарын хэрэгцээг хангах болон хүн амыг бараа таваараар хүртээмжтэй хангах зорилгоор худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, ОХУ-ын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих замаар өрсөлдөөнт нөхцөлийг бий болгох;
  - 3) Худалдан авсан болон үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах, үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгцээнд бараа бүтээгдэхүүн худалдан авах болон дамжуулан худалдах зэргээр худалдааны харилцаанд оролцож буй хувь хүн, хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолын тэнцвэртэй байдлыг хангах;
  - 4) Худалдааны харилцааг зохицуулах хүрээнд ОХУ-ын субъектуудын төрийн байгууллагууд болон ОХУ-ын төрийн байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын эрх, үүргийн зааг, ялгааг тогтоох.
3. Энэхүү хуулиар төрийн захиргааны байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй субъектуудын хоорондын худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, явуулахтай холбоотой харилцаа болон худалдаа эрхэлж буй субъектууд хоорондын худалдааны харилцааг зохицуулна.
4. Энэ хуулийн зохицуулалтанд дараах асуудлууд хамаарахгүй. Үүнд.
  - 1) Гадаад худалдааны харилцаа;
  - 2) Зохион байгуулалттай худалдааны харилцаа (21.11.2011 г. N 327-ФЗ нэмэлтээр орсон);
  - 3) Жижиглэнгийн зах зээл дээр бараа таваар худалдах харилцаа;
  - 4) Үнэт цаас худалдах-худалдан авах, үл хөдлөх хөрөнгө худалдах-худалдан авах, үйлдвэрлэл-технологийн зориулалттай бараа бүтээгдэхүүн, цахилгаан болон дулааны эрчим хүч зэрэг бүх төрлийн эрчим хүчний нөөцийг худалдах-худалдан авах ... гэх мэт;
  - 5) Хуулийн 13,14-р зүйл нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж байгаа боловч сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого нь 4,0 сая рублиэс хэтрэхгүй, мөн худалдааны үйл ажиллагаагаа сүлжээгээр дамжуулан явуулж байгаа боловч сүлжээний нэг сеть дэх борлуулалтын нийт орлого нь 4,0 сая рублиэс хэтрэхгүй байгаа ААН-үүдэд хамаарахгүй. (03.07.2016 г. N 264-ФЗ нэмэлтээр орсон).
5. Хязгаарлагдмал хүрээнд бараа бүтээгдэхүүн худалдаалж байгаа субъектуудын хоорондын бараа таваар худалдаалахтай холбоотой харилцааг энэ төрлийн таваарын эргэлтийг зохицуулах тухай хуулиар зохицуулна.
6. Хуулийн 3-р бүлэгт заасан монополийн эсрэг шаардлага, зохицуулалт, худалдааны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт зэргийг “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” (Федеральный закон от 26 июля 2006 года № 135-ФЗ "О защите конкуренции") хуулиар зохицуулна.

а

<sup>20</sup> [www.pravo.gov.ru](http://www.pravo.gov.ru) ФЗ “Об основах государственного регулирования торговой деятельности”

## 2-р зүйл. Хуулийн нэр томъёоны тайлбар, тодорхойлолт

- 1) *Худалдааны үйл ажиллагаа* (цаашид худалдаа гэх)- бараа таваарыг худалдах, худалдан авахтай холбоотой бизнесийн үйл ажиллагааны төрөл;
- 2) *Бөөний худалдаа*- бизнесийн зоригоор дамжуулан худалдах хэлбэрээр хийгдэж буй, хувийн, гэр бүлийн, бусад ийм төрлийн хэрэгцээнд зориулагдаагүй, бараа таваарыг худалдах- худалдан авах ажиллагаа;
- 3) *Жижиглэнгийн худалдаа* - бизнесийн зорилгоор бус хувийн, гэр бүлийн, эсхүл ийм төрлийн бусад хэрэгцээнд зориулан бараа таваар худалдах, худалдан авах ажиллагаа;
- 4) *Худалдааны объект* - бараа бүтээгдэхүүнийг дэлгэн тавих, худалдаалах, төлбөр тооцоо хийхэд зориулсан тоноглол бүхий барилга байгууламж, эсхүл барилга байгууламжийн хэсэг;
- 5) *Суурин худалдааны объект*- барилгын суурь фундамент нь газар, инженер-техникийн байгууламжтайгаа холбогдсон худалдааны барилга байгууламжийн объект, эсхүл барилга байгууламжийн хэсэг;
- 6) *Суурин бус (түр) худалдааны объект*- барилгын суурь нь газартай холбогдоогүй, худалдаа үйлчилгээнд түр ашиглах зориулалттай, эсхүл хөдөлгөөнт худалдааны байгууламж хэлбэртэй түр зуурын явуулын худалдааны объектыг хэлнэ. Инженерийн байгууламжид холбогдсон ч байж болно, холбогдоогүй ч байж болно;
- 7) *Худалдааны талбай*- бараа таваарыг лангуун дээр дэлгэн тавих, худалдан авагчдад санал болгох, худалдан авалтын үйлчилгээ үзүүлэх, худалдан авалтын төлбөр тооцоо хийх зориулалт бүхий байр;
- 8) *Худалдааны сүлжээ* - “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” ОХУ-ын хуулийн дагуу аж ахуйн нэгж дангаараа буюу хэд хэдээрээ групп болон нэгдэж дундаа эзэмшин үйл ажиллагаа явуулж буй 1 ба түүнээс дээших тооны худалдааны объектын сүлжээ, эсхүл бизнесийн нэгдмэл удирдлагатай, төрөлжсөн үйл ажиллагаа явуулж буй 1 ба түүнээс дээших тооны худалдааны объектын нэгдэл;
- 9) *Хүнсний бараа*- хүний хоол хүнсний хэрэгцээнд зориулагдан худалдаанд гаргаж буй натурал болон боловсруулсан бүтээгдэхүүнүүд (хүүхдийн хоол тэжээл, диет бүтээгдэхүүн), савлагаатай ундны ус, архи, пиво, ундаа жүүс, бохь, хоол амтлагч болон биологийн идэвхит хоолны нэмэлт зэрэг бүтээгдэхүүнүүд;
- 10) *Бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа* - хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдааны сүлжээнд нийлүүлэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр явуулж буй реклам, зар сурталчилгаа, тусгайлсан үзэсгэлэн худалдаа, хэрэглэгчийн эрэлтийг судлах, бараа бүтээгдэхүүний талаарх мэдээлэл цуглуулах, танилцуулга бэлтгэх зэрэг бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйлчилгээнүүд.

## 3-р зүйл. Худалдааны харилцааны эрх зүйн зохицуулалт

1. Худалдааны салбар дахь эрх зүйн харилцааг ОХУ-ын Иргэний кодекс, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай (1992, N 2300-I) хууль болон ОХУ, түүний субъектуудын холбогдох бусад хууль, түүнийг дагаж гарсан хэм, хэмжээ тогтоосон актуудаар зохицуулна.
2. Жижиглэнгийн худалдаа эрхлэх, жижиглэнгийн зах зээлд бараа таваар борлуулахтай холбоотой харилцааг ОХУ-ын “Жижиглэн худалдааны зах зээл ба ОХУ-ын Хөдөлмөрийн тухай кодекс төрчлөлт оруулах тухай” (2006, N 271-ФЗ) хуулиар зохицуулна.
3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс орон нутгийн иргэдийг худалдаа үйлчилгээгээр хангах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд энэ хууль болон Холбооны улсын бусад хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Холбооны субъектуудын хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай эрх зүйн актуудыг батлан гаргаж болно.



*4-р зүйл. Төрөөс худалдааны үйл ажиллагааг зохицуулах арга хэрэгслүүд*

1. Худалдааны салбар дахь төрийн зохицуулалтыг дараах арга хэрэгслүүдээр дамжуулан хэрэгжүүлнэ:

- 1) Худалдаа эрхлэх байгууллагын худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, явуулахтай холбоотой шаардлагыг тогтоох;
- 2) Худалдааны салбарт монополийн эсрэг зохицуулалт хийх;
- 3) Худалдааны салбарыг мэдээллээр хангах;
- 4) Төрийн болон орон нутгийн байгууллагуудаас хяналт шалгалт хийх.

2. Энэ бүлгийн 1-д заасан зохицуулалтын арга хэмжээнээс өөр хуульд заагаагүй аргаар төрөөс зохицуулалт хийхийг хориглоно.

*5-р зүйл. Худалдааны салбар дахь төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой ОХУ-ын Засгийн газар, Холбооны улсын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын эрх*

1. ОХУ-ын Засгийн газар нь энэ хуулиар худалдааны үйл ажиллагааг зохицуулах хүрээнд дараах эрхийг хэрэгжүүлнэ:

- 1) Худалдааны салбарт төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах;
- 2) ОХУ-ын субъектуудын нэгж хүн амд шаардагдах худалдааны талбарын минимум норматив, түүнийг тооцох журам болон тооцооны аргачлалыг батлах;
- 3) ОХУ-ын субъектуудын хэмжээнд хилийн дотор борлуулсан нийт хүнсний бүтээгдэхүүн, Москва болон Санктпетрбург хотууд, мөн орон нутгийн район, хотын тойргуудууд борлуулсан хүнсний бараа таваарыг тухайн санхүүгийн жилээр, мөнгөн дүнгээр, мөн борлуулсан нийт бараа таваарын дүнд жижглэнгийн худалдаа эрхлэгчид, ААН-үүд болон ААН-ийн худалдааны сүлжээ тус бүрийн эзлэх хувийн жин зэргийг тухайн бүс нутаг, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж тус бүрээр санхүүгийн жилээр нь, мөнгөн дүнгээр тооцоолж гаргах аргачлалыг батлах;
- 4) Энэ хууль болон Холбооны улсын бусад хууль тогтоомжоор олгосон эрх.

2. Дотоод худалдааны салбарт төрөөс баримтлах бодлого болон хууль эрх зүйн акт боловсруулах чиг үүрэг бүхий Холбооны улсын гүйцэтгэх засаглалын байгууллага дараах эрхийг хэрэгжүүлнэ:

- 1) Бүс нутгийн хэмжээнд дотоодын худалдааны салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, хөтөлбөр боловсруулах аргачилсан зөвлөмж батлах;
- 2) Худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй, бараа таваар бэлтгэн нийлүүлж буй (үйлдвэрлэгч хамаарахгүй) ААН-үүдийн бүртгэлийн маягт (реестр), ОХУ-ын субъектуудын газар нутаг дээрх худалдааны байгууллагуудын бүртгэлийн маягт (торговый реестр), түүнийг хөтлөх болон мэдээлэл цуглуулах журам зэргийг батлах;
- 5) Холбооны улсын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллагууд хамтран худалдааны салбарын статистик мэдээлэл цуглуулах, тайлан мэдээ гаргах, худалдааны байгууллагуудаас статистик мэдээлэл авах хугацааг тогтоох;
- 6) Холбооны улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжүүлэх бусад эрх.

*6-р зүйл. Худалдааны үйл ажиллагааг зохицуулах хүрээнд ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын эрх*

1. ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь худалдааны салбарт дараах эрхийг хэрэгжүүлнэ.

- 1) ОХУ-ын субъектуудын газар нутаг дээр худалдааны салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;



- 2) Энэ хуульд нийцүүлэн худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой ОХУ-ын субъектуудын хууль, бусад хэм, хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг боловсруулах, батлах;
  - 3) ОХУ-ын субъектын нэгж хүн амд ногдох худалдааны талбарын минимум хэмжээг тогтоох;
  - 4) ОХУ-ын субъектын газар нутаг дээрх тодорхой барааны зах зээлийн төлөв байдал, худалдааны үйл ажиллагааг судлан шинжлэх, статистик мэдээлэл гаргах;
  - 5) ОХУ-ын субъектын газар нутаг дээр худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, хэрэгжүүлэх;
  - 6) Холбооны улсын хуулиар тогтоосон бусад эрх.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь худалдааны үйл ажиллагааг зохицуулах хүрээнд нутгийн иргэдийг бараа таваараар хангах, орон нутгийн чанартай худалдаа эрхлэлтийг дэмжих, зохицуулах, худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх зэрэг эрхийг хэрэгжүүлнэ. Энэ эрхийг Москва, Санктпетрбург, Севастополь зэрэг хотын удирдлагууд мөн хэрэгжүүлнэ.
  3. Худалдааны салбарт нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх, үүргийг энэ хууль болон “ОХУ-ын нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай” хуулиар тогтооно.

*7-р зүйл. Худалдааны салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд худалдаа болон нийлүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах ашгийн бус байгууллагын оролцоо*

1. Дотоодын худалдааны салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах болон эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаанд худалдаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, тэдгээртэй зөвшилцөн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид тэдний саналыг тусгуулах үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр байгуулагдсан худалдаа, бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ашгийн бус байгууллага хэрэгжүүлнэ.
2. Худалдааны салбарт төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг тодорхойлоход оролцох үүрэг бүхий ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг дараах хэлбэрээр явуулна.
  - 1) Бүс нутгийн болон орон нутгийн чанартай худалдааны салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн акт боловсруулахад оролцох;
  - 2) ОХУ-ын субъектуудын газар нутаг дээрх худалдааны салбарын санхүү, эдийн засаг, нийгмийн болон бусад үзүүлэлтүүдийг судлан дүн шинжилгээ хийхэд оролцох, ОХУ-ын субъект болон орон нутгийн хэмжээнд төрөөс хэрэгжүүлж буй худалдааны салбарыг хөгжүүлэх талаар авсан арга хэмжээний үр дүн, үр ашгийг үнэлэх, цаашдын хөгжлийн прогноз гаргахад оролцох;
  - 3) Худалдааны үйл ажиллагааны ОХУ-ын болон гадаадын шинэ туршлага, арга барилыг нэвтрүүлэх;
  - 4) Худалдааны салбарт баримтлах төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах;
  - 5) Худалдааны үйл ажиллагааг болвсронгуй болгох чиглэлээр төрийн болон орон нутгийн удирдах байгууллагуудад санал хүргүүлэх;
  - 6) ОХУ-ын хууль болон түүнийг дагаж гарсан эрх зүйн актуудын хүрээнд олгогдсон бусад эрх.

### **Хоёр. Худалдааны байгууллага ба худалдаа эрхлэлтэнд тавигдах шаардлага**

*8-р зүйл. Худалдаа болон бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын эрх үүрэг, түүнийг хэрэгжүүлэх*

1. Хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол худалдааны үйл ажиллагааг ОХУ-ын энэ хуульд заасан шаардлагыг хангаж, хуульд заасан журмын дагуу бүртгүүлсэн аж ахуйн субъект эрхэлж болно.

2. Худалдааны үйл ажиллагаа зохион байгуулж байгаа аж ахуйн субъект нь энэ хууль болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол дараах асуудлыг бие даасан байдлаар шийдвэрлэх эрхтэй:

- 1) Бөөний болон жижиглэн худалдаагаар худалдаалах барааныхаа нэр төрлөө сонгох
- 2) Худалдах үйл ажиллагааны хэлбэрээ сонгох (зориулалтын болон зориулалтын бус талбарт, тухайлбал яармаг худалдаа, үзэсгэлэн худалдаа, зөөвөрлөн худалдаалах, зайнаас худалдаалах, автомат хэрэгсэл ашиглан худалдаалах болон бусад)
- 3) Худалдах ажиллагааны аргаа сонгох (худалдааны объект ашиглах болон эс ашиглах)
- 4) Худалдааг төрөлжүүлэх (бүх төрлийн болон төрөлжсөн худалдаа)
- 5) Худалдаа эрхлэхэд зориулагдах худалдааны объектоо сонгох (зориулалтын дагуу төхөөрөмжлөгдсөн эсхүл үгүй)
- 6) Худалдааны үйл ажиллагаа явуулж буй өмч хөрөнгийг эзэмших, ашиглах эрх (өмчлөх эрх болон бусад хууль ёсны эрх)
- 7) Худалдааны үйл ажиллагаа явуулах нөхцөл ба журмыг тогтоох. Тухайлбал,
  - худалдах бараа таваарын нэр төрлийг тогтоох;
  - үйл ажиллагааны дэг тогтоох;
  - худалдаа явуулах арга хэрэгслүүдээ тодорхойлох;
  - худалдааны үйл ажиллагаанд ашиглах технологийн багаж хэрэгсэл, агуулах складын тоо хэмжээ, тоног төхөөрөмжийн хэлбэр, загварыг тодорхойлох;
  - худалдан авагчдад худалдаанд байгаа бараа таваар, үзүүлж буй үйлчилгээ, худалдагчдын талаарх мэдээлэл хүргэх аргаа тодорхойлох;
  - худалдан борлуулж буй барааны үнийг тогтоох;
  - худалдааны объектод болон витринээр бараа таваарыг реклам явуулах арга хэлбэрийг тодорхойлох;
  - бараа таваарыг худалдах- худалдан авах гэрээ хэлэлцээрийн нөхцөлийг тодорхойлох;
  - худалдааны үйл ажиллагаа явуулахтай холбоотой бусад нөхцөл, журмыг тодорхойлох.

3. Төрийн болон орон нутгийн өмчит худалдааны байгууллагын үйл ажиллагааны журмыг эрх бүхий байгууллага тогтооно.

4. Хэрэв хуулиар тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ, худалдааны нэмэгдэл, түүний дээд ба доод хязгаар зэргийг тогтоохоор байвал эрх бүхий байгууллага холбогдох хууль, журмын дагуу тогтооно.

5. Хэрэв хүн амын зайлшгүй хэрэгцээт бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн үнэ календарын 30 хоног дараалан 30% ба түүнээс дээг хэмжээгээр өсөлттэй байх юм бол ОХУ-ын Засгийн газраас тухайн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зорилгоор ОХУ болон түүний субъектуудын нутаг дэвсгэр дээр тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах жижиглэнгийн үнийн дээд хязгаарыг календарийн 90 хоногоос дээшгүй хугацаагаар тогтоож мөрдүүлнэ.

6. Хүн амын нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээт бараа бүтээгдэхүүний жагсаалт, түүний жижиглэнгийн худалдаанд үнийн дээд хязгаар тогтоох тухай журмыг ОХУ-ын Засгийн газар батална.

*9-р зүйл. Хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэх болон худалдаалах үйл ажиллагаа эрхэлж буй субъектуудын хоорондын бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээн дэх талуудын эрх, үүрэг*

1. Зохион байгуулалттай худалдааны сүлжээгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн борлуулж буй аж ахуйн нэгж нь хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч субъектэд хамтран ажиллах худалдааны байгууллагаа сонгож гэрээ хэлэлцээр хийхэд нь зориулж гэрээний нөхцөлийн талаарх мэдээллээ интернэт дэх өөрийн вэб сайтдаа байршуулна.

2. Бараа таваар нийлүүлэгч байгууллага нь худалдааны сүлжээгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн борлуулж байгаа худалдааны байгууллагад хамтран ажиллах нийлүүлэгч

- байгууллагаа сонгож гэрээ хэлэлцээр хийх, худалдан авах барааныхаа чанар, аюулгүй байдлыг тодорхойлоход шаардагдах мэдээллийг интернэт дэх өөрийн вэб сайтдаа байршуулж мэдээллээр хангана.
3. Бараа таваар нийлүүлэгч болон худалдаа эрхэлж байгаа байгууллага хоорондын бараа таваар худалдах- худалдан авах үнийг талууд энэ хуулийн 4-р бүлгийн 4, 5, 8-р бүлэгт заасан нөхцөлийг харгалзан харилцан зөвшилцөх замаар тогтооно.
  4. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний үнэд худалдааны байгууллагад олгох урамшууллын дүнг тусгаж болно. Урамшууллын хэмжээ, нийлүүлэлтийн үнэд тусгах эсэх асуудлыг талууд тохиролцох ба бараа бүтээгдэхүүний үнийг тодорхойлоход оруулж тооцохгүй. Худалдагч талд бараа материал худалдан авч борлуулсан, борлуулалтын сурталчилгаа болон ложистик, сав баглаа боодол хийсэн зэрэг нэмэлт үйлчилгээ үзүүлсэнд нь олгох урамшууллын нийт хэмжээ нь худалдан авсан нийт хүнсний бараа бүтээгдэхүүний 5%-иас хэтрэхгүй байна. Урамшууллын нийт хэмжээг тооцохдоо ОХУ-ын "Татвар, хураамжийн тухай" хуульд заасны дагуу бараа нийлүүлэгч компаниас худалдан авагч компанид төлсөн НӨАТ-ыг оруулж тооцохгүй, акцизийн бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд акцизийн татварыг мөн оруулж тооцохгүй.
  5. Энэ бүлгийн 4-т заасан урамшуулал олгох заалт нь ОХУ-ын Засгийн газраас баталсан жагсаалтад орсон тодорхой нэр төрлийн нийгмийн ач холбогдол бүхий хүнсний бараа бүтээгдэхүүний худалдаа эрхэлж буй компаниудад хамаарахгүй.
  6. Хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлж буй компаниас зохион байгуулалттай худалдааны сүлжээгээр дамжуулан борлуулалт хийж буй компанид энэ хуульд заагаагүй бусад урамшуулал олгохыг хориглоно.
  7. Бараа таваар нийлүүлж байгаа болон худалдан борлуулж байгаа талуудын хооронд байгуулсан гэрээгээр худалдан борлуулж бу барааны үнийг тодорхо хугацааны дараа төлөхөөр гэрээ хийгдсэн бол барааны төлбөр хийх хугацааг дараах журмаар хийхээр гэрээнд тусгана:
    - 1) Ашиглах хугацаа нь 10-аас доош хоногтой хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байгаа компани бүтээгдэхүүнийг татан авсанаас хойш ажлын 8 хоногийн дотор төлбөр гүйцэтгэнэ.
    - 2) Ашиглах хугацаа нь 8-30 хоногтой хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж буй компани бараа бүтээгдэхүүнийг татан авснаас хойш календарийн 25 хоногийн дотор төлбөр гүйцэтгэнэ.
    - 3) Ашиглах хугацаа нь 30 хоногоос дээш хүнсний бараа бүтээгдэхүүн, архи дарс худалдан борлуулж буй компанийн хувьд бараа бүтээгдэхүүнийг татан авснаас хойш календарийн 40 хоногийн дотор төлбөр гүйцэтгэнэ.
  8. Дээр заасан дараа төлбөр гүйцэтгэхээр нийлүүлсэн бараа таваарын төлбөр гүйцэтгэх хугацааг худалдан борлуулах компани тухайн барааг татан авснаас хойших хугацаагаар тооцно. Бараа бүтээгдэхүүнийг нийлүүлснээс хойш ажлын 3 хоногт багтаан нийлүүлэгч тал төлбөрийн нэхэмжлэл гардуулах ба борлуулагч тал үүнийг үлээн авах үүрэгтэй.
  9. *(Энэ заалтыг 2016 оны өөрчлөлтөөр хүчингүй болгосон)*
  10. Хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд борлуулагч талын гэрээний үүргийг биелүүлэх этгээд солигдохыг хориглосон заалт оруулж болохгүй бөгөөд хариуцлагын заалт хэвээр хадгалагдана.
  11. Бараа бүтээгдэхүүнийг эргэлтэнд оруулах, сурталчлах, хайрцаглаж савлах зэрэг ажиллагааг борлуулагч тал гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.
  12. Хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, борлуулах гэрээ байгуулах, хэрэгжүүлэх явцад талууд бие биендээ бараа бүтээгдэхүүнийг эргэлтэнд оруулахтай холбоотой ямар нэгэн нэмэлт үйлчилгээ үзүүлэхийг хүчээр тулгаж болохгүй.
  13. Хүнсний бараа бүтээгдэхүүнийг сүлжээ дэлгүүрээр борлуулж байгаа болон нийлүүлж байгаа компаниудад дараах зүйлийг хориглоно.
    - 1) Үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр нээгдэж байгаа худалдааны объектод бараа бүтээгдэхүүн нийлүүлэх эрх олгосны төлөө ямар нэгэн төлбөр ногдуулах болон авах;

- 2) нийлүүлж буй хүнсний бараа бүтээгдэхүүний нэр, төрөл өөрчлөгдсөнд төлбөр ногдуулах болон авах;
  - 3) бараа бүтээгдэхүүнийн нийлүүлж байгаа компаниас бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, өмчийн эрх шилжсэний дараа сав баглаа боодолд гэмтэл учирсан, эсхүл дутсан тохиолдолд хохирол төлүүлэх;
  - 4) бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх тухай гэрээнд хамааралгүй, эсхүл бараа бүтээгдэхүүнийг цааш дамжуулан худалдахтай холбоотой гарсан зардлыг нийлүүлэгч талаас гаргуулах. (2016 оны өөрчлөлтөөр нэмэгдсэн)
14. Хуулийн энэ хэсэгт заасан нийлүүлэгч болон борлуулагч талын гэрээний нөхцөл нь “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” ОХУ-ын зохицуулалтанд хамаарах групп хэлбэрээр энэ төрлийн үйл ажиллагаа явуулж буй этгээдэд хамаарна.

*10-р зүйл. Түр үйл ажиллагаа явуулах худалдааны объектыг байршуулах*

1. Тухайн орон нутаг дахь хүн амын худалдааны хэрэгцээг хангах, 1 хүнд ногдох худалдааны объектыг минимум шаардлагыг биелүүлэх үүднээс төрийн болон орон нутгийн өмчийн газар болон барилга байгууламжид худалдааны объектыг тусгайлан зөвшөөрөгдсөн схемийн дагуу байршуулна.
2. Худалдааны түр объектыг байршуулах журмыг ОХУ-ын Засгийн газар тогтооно.
3. Худалдааны объектыг түр байршуулах схемийг ОХУ-ын субъектын эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллагаас тогтоосон журмыг дагуу нутгийн удирдах байгууллага боловсруулж батална.
4. Түр байршуулж байгаа нийт худалдааны объектын 60%-иас доошгүй объектын зөвшөөрлийг худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй жижиг болон дунд аж ахуйн нэгжүүдэд олгоно.
5. Худалдааны объектуудыг түр байршуулах схемийг орон нутгийн удирдах байгууллагаас гаргадаг хууль тогтоомжийн эмхэтгэл болон нутгийн удирдлагын байгууллагын албан ёсны вэб сайтад байршуулж олон нийтэд мэдээлэл хүргэнэ.
6. Худалдааны тэрхүү объект байршуулах схемийг баталсанаас хойш нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр схем баталсан нь уг схемийг батлагдахаас өмнө худалдааны объектоо байршуулж барилга, засварын ажил хийсэн, ашиглалтад оруулан үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны объектын байршлыг өөрчлөх үндэслэл болохгүй.
7. Хувийн эзэмшилд байдаг зориулалтын худалдааны газар, барилга байгууламж дотор түр худалдааны худалдааны объект нээх, ашиглахтай холбоотой харилцааг холбогдох хуулийн хүрээнд өмч эзэмшигч-ашиглагч талууд хоорондоо тохирно.

*11-р зүйл. Яармаг үзэсгэлэн худалдаа зохион байгуулах болон яармаг дээр худалдаа, үйлчилгээ үзүүлэх*

1. Яармаг худалдааг төрийн болон орн нутгийн байгууллага, хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгч (цаашид яармаг зохион байгуулагч гэх) зохион байгуулж болно. Яармаг зохион байгуулах, худалдаа хийх ажиллагааг тухайн яармагийг зохион байгуулж байгаа нутаг дэвсгэрийн хүрээнд мөрдөгдөж буй хууль, журам болон энэ хуулиар зохицуулна.
2. Яармаг зохион байгуулагчид яармаг худалдаа зохион байгуулахас өмнө зохион байгуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, яармагийн үйл ажиллагааны дэг, павильон олгох журам боловсруулан батална.
3. Яармаг худалдааны зохион байгуулалттай холбоотой мэдээллийг өөрийн вэб сайтад байршуулна.
4. Яармаг худалдааны лангуун дээр бараа бүтээгдэхүүн борлуулах, ажил үйлчилгээ гүйцэтгэх захиалга авах этгээд нь хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэн (хувийн болон фермерийн аж ахуй, газар тариалан, мал аж ахуй, гэр бүлийн жижиг аж ахуй эрхлэгч иргэн) хэн ч байж болно.
5. Бараа бүтээгдэхүүн борлуулах зориулалтаар яармаг худалдаан дээр тусгайлан тоноглогдсон павильон түрээслүүлэх төлбөрийн хэмжээг цэвэрлэгээ үйлчилгээ, харуул

хамгаалалтын үйчилгээ зэрэг зайлшгүй зардлыг тооцон яармаг зохион байгуулагч тогтооно.

6. Яармаг худалдаан дээр худалдан борлуулах бараа бүтээгдэхүүн, үзүүлэх ажил үйлчилгээнд тавигдах шаардлагыг ОХУ-ын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн яармаг зохион байгуулагч тогтоох бөгөөд тухайн яармагаар худалдаалах бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний жагсаалт, хэрэглэгчдийн эрх ашиг, ариун цэвэр халдваргүйжүүлэлт, галын аюул, байгаль орчны шаардлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомж, журам зааврыг баримтална.

*12-р зүйл. Бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын нэгдэл, ассоциаци, ашгийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хэлэлцээр*

1. Бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын нэгдэл, ассоциаци, ашгийн бус байгууллагууд нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын нэгдэл, ассоциаци, ашгийн бус байгууллагуудтай харилцан ойлголцлын гэрээ байгуулах хэрэгжүүлэх эрхтэй.
2. Энэхүү гэрээг ОХУ-ын “Монополийн эсрэг хууль”-д нийцүүлэн байгуулна.

#### **Гурав. Худалдааны салбар дахь монополийн эсрэг зохицуулалт ба төрийн болон орон нутгийн байгууллагуудын хяналт**

*13-р зүйл. Бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах болон бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын дагаж мөрдөх монополийн эсрэг журам*

1. Зохион байгуулалттай сүлжээ дэлгүүрээр дамжуулан бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагууд, хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн байгууллагуудад дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- 1) ОХУ-ын “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” хуулиар тодорхойлсон ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлэх;
- 2) Аж ахуйн байгууллагын таваарын зах зээлд гарч ирэх, зах зээлээс гарах үйл ажиллагаанд ямар нэгэн саад тотгор учруулах;
- 3) Хууль, эрх зүйн актуудаар зохицуулсан үнэ бүрдэлтийн журмыг зөрчих;
- 4) Түнш байгууллагадаа ямар нэгэн дарамт учруулах. Тухайлбал:

- бусад ижил төрлийн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагаанд нь саад тотгор учруулах, ижил болон өөр нөхцөлтэйгээр гэрээ хийхийг хориглох заалтыг гэрээнд тусгах;
- хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа компанийг бусад ижил төрлийн нийлүүлэлт хийж байгаа компаниудаас өөрт илүү ашигтай нөхцөлийг санал болгохыг шаардах, тулган хүлээлгэх, эсрэг тохиолдолд ямар нэгэн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг гэрээнд тусгах;
- гэрээ байгуулж байгаа нийлүүлэгч компанийг өөр бусад компанитай байгуулсан гэрээнийхээ талаар мэдээлэл өгөхийг шаардсан заалтыг гэрээнд тусгах;
- хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа түнш компанийн худалдааны нэмэгдэл орсон нийлүүлэлтийн үнийг дүн нь ижил төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэгч компанийн худалдан борлуулж буй үнийн минимум хязгаараас давахгүй байхаар гэрээнд тусгах;
- ОХУ-ын хуулиар зөвшөөрөөгүй бол нийлүүлэгчээс худалдан авсан бараагаа тодорхой хугацаа өнгөрсөний дараа борлогдоогүй бол нийлүүлэгчид буцаан олгох нөхцөлийг гэрээнд тусгах;



- гэрээний зохицуулалтад хамааралгүй бусад нөхцөлийг гэрээнд тусгах;
  - “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” ОХУ-ын хуульд заасны дагуу групп үүсгэн ажиллаж буй компаниудаас бусад компаниуд худалдан авалтын гэрээ хийхдээ бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах ажиллагааг гуравдагч этгээдээр өмчлөх эрх шилжүүлэхгүйгээр хийлгэх, комиссийн гэрээ хийх, ашиг хуваалцах гэрээ хийх, агентийн гэрээ хийх, эсхүл дээрх элементүүд хосолсон гэрээ хийх.
2. Энэ зүйлийн 1.1, 1.4-д заасан хориглох үйл ажиллагааг “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” ОХУ-ын хуульд нийцүүлэн явуулсан тухайгаа талууд нотлох эрхтэй.

*14-р зүйл. Зохион байгуулалттай худалдааны сүлжээгээр дамжуулан хүнсний бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхэлж буй субъект худалдааны объектын нэмэлт талбай худалдан авах, түрээслэхийг хязгаарлах*

1. Зохион байгуулалттай сүлжээ дэлгүүрээр дамжуулан хүнсний барааны жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн байгууллагын ( хөдөө аж ахуйн хэрэглээний хоршоо хамаарахгүй) худалдан борлуулж буй хүнсний бараа бүтээгдэхүүний борлуулалтын нийт орлогын хэмжээ мөнгөн дүнгээрээ ОХУ-ын субъектуудын тухайн нутаг дэвсгэрийн хязгаар, түүний дотор Москва, Санктпетрбург гэх мэт хот, район, хотын тойргийн өнгөрсөн оны нийт борлуултын 25%-иас хэтэрсэн тохиолдолд тухайн засаг захиргааны нэгжийн газар нутаг дээр шинээр худалдааны объект ажиллуулахыг хориглоно. Худалдааны объект барьж байгуулсан, ашиглалтанд оруулсан, дуудлагын худалдаагаар авсан гэх мэтийн ямар ч шалтгаанаар нэмэлт худалдааны талбай эзэмшихийг хориглоно.
2. Энэ зүйлийн 1-д заасан хориглох үйл ажиллагааг зөрчиж хийсэн хэлцэл хүчингүйд тооцогдоно. Хэлцлийг хүчингүйд тооцсоноос үүдэн гарах үр дагавартай холбоотой гомдлыг шүүхэд болон монополийн эсрэг хуулийн хэрэгжилтийг хариуцаж буй төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болно.

*15-р зүйл. Худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулж буй ОХУ-ын субъектуудын төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад монополийн эсрэг хуулийн хүрээнд тавигдах шаардлагууд*

ОХУ-ын субъектуудын төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдах байгууллага болон энэ салбарын үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий байгууллагууд нь хуулиар тогтоосон хэм, хэмжээг зөрчиж, худалдаа эрхлэгчдэд таваарын зах зээл дээр энэ хууль болон холбогдох бусад хуульд зааснаас өөрөөр үйл ажиллагаа явуулах, эсхүл эс үйлдэл хийх боломж олгосон агуулгатай хуульчилсан акт, журам заавар батлан гаргахыг хориглоно. Тухайлбал:

- 1) Бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч болон худалдан борлуулагч талуудын аль алинд мужийн болон орон нутгийн чанарын хяналтын систем дэх бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шалгалтанд бараа бүтээгдэхүүнийг дахин оруулахыг үүрэг болгох;
- 2) Бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах, нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг хуулиар тогтоосон журам, түүнд оруулсан нэмэлтийн дагуу хяналтын болон тусгай зөвшөөрөл олгох процедурын шалгалтанд орохыг албадах (худалдааны объектын аттестатчилал, ААН-ийн аттестатчилал, барааны сертификатчилал, худалдааны объектыг хуулийн шаардлагад нийцүүлэх);
- 3) Бараа бүтээгдэхүүний худалдаа, нийлүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд ОХУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу тогтоосон үнээр бараа бүтээгдэхүүн худалдахыг шаардах (хэрэв тухайн байгууллага нь хуулиар тогтоосон эрхийн дагуу үнийн асуудлыг зохицуулах эрхтэй бол энэ зохицуулалтад хамаарахгүй);
- 4) Дараах агуулга бүхий эрх зүйн акт, шийдвэр гаргахгүй байх. Үүнд:



- ОХУ-ын субъектын дотор болон субъект хооронд бараа бүтээгдэхүүн чөлөөтэй худалдаалахыг хязгаарлах болон хориглох;
- ОХУ-ын субъектын дотор болон орон нутгийн хязгаар дотор тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалахыг хязгаарлах;
- худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг тодорхой нийлүүлэгч компанитай, нийлүүлэгч компанийг тодорхой худалдан борлуулагч компанитай тэргүүн ээлжинд гэрээ байгуулахыг шаардах;
- худалдан борлуулах, нийлүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудад гэрээ хийх компаниа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлах;
- худалдан борлуулах, нийлүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудад зам, тээврийн дэд бүтэц ашиглахад саад учруулж ялгаварлан гадуурхах.

*16-р зүйл. Төрөөс хуулийн хэрэгжилтэнд тавих хяналт ба худалдааны асуудал хариуцсан орон нутгийн удирдах байгууллагын хяналт*

1. Энэ хуулиар тогтоосон худалдааны салбарын үйл ажиллагааны төрийн болон орон нутгийн хяналтыг ОХУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.
2. Хуулийн 9, 13-15-р зүйлд заасан төрийн хяналтыг Холбооны улсын Монополийн эсрэг хуулийн зохицуулалт, хэрэгжилтийг хангах эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллагууд, түүний орон нутаг дахь салбар байгууллагууд хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.
3. Монополийн эсрэг хуулийн зохицуулалт, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага түүний харьяа салбар байгууллагууд нь энэ хуулийн 9, 13-15-д заасан зөрчлийг илрүүлсэн тохиолдолд ОХУ-ын холбогдох хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. Худалдааны салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ**

*17-р зүйл. Худалдааны салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүд*

1. ОХУ-ын субъектуудын төрийн захиргааны удирдах байгууллагууд нь тухайн бүс нутгийн нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахдаа бүс нутгийн хэмжээнд худалдааны салбарыг хөгжүүлэх тухай зорилтуудыг тусгана.
2. ОХУ-ын субъектуудын эрх бүхий байгууллагууд хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд худалдааны салбарын үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 1) хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, хадгалах, хүнсний бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж буй байгууллагуудад тээвэрлэн хүргүүлэх ложистикийн дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжих, идэвхжүүлэх;
  - 2) хөдөө аж ахуйн хэрэглээний хоршоод, хөдөө орон нутаг дахь бараа бүтээгдэхүүн нийлүүлэх-худалдаалах хэрэглээний хоршоодыг дэмжих;
  - 3) худалдааны үйл ажиллагааг дэмжих хүрээнд ярмарка, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэргээр бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа, бараа бүтээгдэхүүн худалдаалж байгаа аж ахуйн байгууллагуудыг аль болохоор дэмжиж, бизнесийн идэвхжлийг нь нэмэгдүүлэх.
3. Нутгийн удирдах байгууллагууд орон нутгийн иргэдийн худалдаа үйлчилгээний хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 1) Орон нутгийн газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөө, холбогдох дүрэм журам, баримт бичгүүдэд худалдааны объект барьж байгуулах болон байршуулах талбайг оруулж тусгах;
  - 2) тухайн газар нутгийн хүн амд ногдох худалдааны талбайн минимум хэрэгцээ, нормативт тулгуурлан түр худалдааны объектуудыг байршуулах план зураг гаргаж батлах;

- 3) орон нутгийн мэдлийн өмч, худалдааны объектууд, худалдааны салбарын нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах, байршуулах, аль болохоор олон нийтэд хүртээмжтэй байлгах чиглэлд эдийн засгийн хөшүүргүүдийг ашиглаж дэмжлэг үзүүлэх;
- 4) орон нутгийн хэмжээнд явуулж буй худалдааны салбарын байгууллагуудын санхүү, эдийн засаг, нийгмийн болон бусад үзүүлэлтүүдийг тооцоолж дүн шинжилгээ хийх, цаашид газар нутгийн хэмжээнд худалдааны үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх талаар авах арга хэмжээ, түүний үр ашгийн тооцоолох.

*18-р зүйл. Бүс нутгийн болон орон нутгийн худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр*

1. ОХУ-ын төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас ОХУ-ын субъектууд болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөнд нийцүүлэн тухайн бшс нутаг, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, соёлын болон бусад онцлогийг харгалзсан худалдааны салбарыг хөгжүүлэх бүс нутгийн болон орон нутгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж болно.
2. Худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг ОХУ-ын субъектуудын холбогдох хууль тогтоомжоор тогтоосон журам болон энэ хуулиар тавьсан шаардлагад нийцүүлэн боловсруулна.
3. Худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөрт дараах асуудлуудыг тусгана. Үүнд:
  - 1) Хүн амыг зайлшгүй хэрэгцээт худалдааны талбайгаар хангах норматив хэрэгцээг хангах үүднээс худалдааны салбарт хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн;
  - 2) Худалдааны салбарт төрөөс баримтлах бодлогын зорилго, зорилтыг биелүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүний дотор хүн амын хэрэгцээг хангахад юуны өмнө Оросын үйлдвэрлэгч компаниуд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтыг дэмжих, өрсөлдөөнт нөхцөлийг бий болгох, хөдөө орон нутаг дахь худалдааны үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгах;
  - 3) Худалдааны салбарыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тусгах;
  - 4) Худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн үр ашгийг үнэлэх үзүүлэлтүүдийг тодорхойлох;
  - 5) Худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавих журмыг тодорхойлох.
4. Худалдааны салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн үр ашгийг дараах үзүүлэлтүүдээр хэмжинэ. Үүнд:
  - 1) хүн амыг худалдааны талбайгаар хангах нормативын минимум хэмжээнд хүрсэн эсэх;
  - 2) хүн амын бараа таваарын хангалт нэмэгдсэн эсэх;
  - 3) хүн амын хэрэгцээнд нийцүүлэн барьж байгуулсан худалдааны объектын төрөл хэлбэр, явуулж буй худалдаа борлуулалтын үйл ажиллагааны арга, хэлбэр, худалдааны дэд бүтцийн байгууламж;
  - 4) Оросын үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах эрэлтийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн эсэх.

*19-р зүйл. Хүн амыг худалдааны объектоор хангах минимум норматив*

1. Худалдааны салбарын хөгжлийн үндсэн зорилго нь хүн амын хэрэгцээт худалдааны объектын минимум нормативыг хангахад чиглэгдэнэ. Энэ үзүүлэлт нь хүн амын хэрэгцээт хүнсний болон хүнсний бус бараа таваарын хангамжийг нэмэгдүүлэх, энэ төрлийн бараа таваарын эрэлт хэрэгцээг хангах нь үндсэн шалгуур үзүүлэлтүүд юм.
2. ОХУ-ын субъектууд, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах нутаг дэвсгэр дэх хүн амыг зайлшгүй хэрэгцээт худалдааны объектоор хангах минимум хэмжээний нормативыг ОХУ-ын

гүйцэтгэх засаглалын эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага Засгийн газраас тогтоосон журам, аргачлалын дагуу тооцоолж гаргана.

3. Хүн амын хэрэгцээт худалдааны объектын минимум нормативыг ОХУ-ын субъектуудын эрх зүйн хэм, хэмжээ тогтоосон актаар батлах бөгөөд энэхүү нормативыг газар төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөө, бүс нутгийн болон орон нутгийн худалдааны салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, явуулын худалдааны объектуудыг байршуулах схем тусгаж батална.
4. Хүн амын хэрэгцээт худалдааны объектын минимум норматив батлагдсан нь уг нормативыг батлагдахаас өмнө байршуулсан, барилга, засварын ажил нь эхэлсэн болон дууссан суурин болон явуулын худалдааны объектыг шилжүүлэн байршуулах үндэслэл болохгүй.

#### *20-р зүйл. Худалдааны салбарын мэдээллийн хангамж*

1. Худалдааны салбарын хөгжлийг дэмжих, удирдлагын үр дүнг сайжруулах зорилгоор худалдааны салбарт төрийн мэдээлэл хангамжийн системийг байгуулна.
2. Худалдааны салбар дахь мэдээлэл хангамжийн системийн худалдааны салбарын үйл ажиллагаан дахь төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалт хийх үүрэг бүхий ОХУ-ын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага хариуцан Засгийн газраас тогтоосон журмын дагуу байгуулан ажиллуулна.
3. Дотоодын худалдааны салбарын талаарх төрийн бодлого боловсруулах, эрх зүйн зохицуулалтын актуудыг боловсруулах үүрэг бүхий гүйцэтгэх засаглалын эрх бүхий төрийн байгууллага улиралд 1-ээс доошгүй удаа худалдааны салбарын талаарх дараах албан ёсны мэдээллийг мэдээлэл-харилцаа холбооны интернэт сүлжээ, тухайн байгууллагын албан ёсны вэб сайтад заавал байршуулж, шинэчлэх үүрэгтэй. Үүнд:
  - 1) дотоодын худалдааны салбар дахь төрийн бодлого боловсруулах, эрх зүйн зохицуулалт хийх эрх бүхий байгууллагаас батлан гаргасан шийдвэрүүд;
  - 2) худалдааны салбарын үйл ажиллагаанд хамааралтай шинээр батлагдан гарсан эрх зүйн зохицуулалтын актууд;
  - 3) тодорхой нэрийн барааны төрөл бүрээр жигнэсэн үнийн дундаж түвшин
  - 4) холбогдох бусад мэдээлэл.
4. ОХУ-ын Засгийн газрын эрх бүхий байгууллагууд эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу худалдааны бүртгэл (торговый реестр) хөтлөх, худалдааны бүртгэлийн маягт батлах, бүртгэлийн мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үүрэгтэй. Худалдааны бүртгэлийн санд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдаа борлуулалтын үйл ажиллагаа явуулах (Үйлдвэрлэгч хамаарахгүй) бизнес эрхэлж буй аж ахуйн байгууллагуудын тухай мэдээлэл, мөн ОХУ-ын субъектуудын газар нутаг дээр явуулж буй худалдааны үйл ажиллагааны төлөв байдлын талаарх мэдээллийг төвлөрүүлнэ.
5. Энэ зүйлийн 4-т заасан мэдээллийг авахдаа төлбөр тогтоож болохгүй бөгөөд худалдаа борлуулалт, нийлүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас худалдааны реестрт бүртгүүлэхийн тулд үзүүлж буй баримт материалыг эргүүлэн олгохгүй байх, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны болон нийлүүлэлтийн компанийг улсын бүртгэлд бүртгэх явцад олж авсан тодорхой мэдээлэл, хийгдсэн хэлцэлүүдийн талаарх мэдээллийг ашиглан хараат байдал үүсгэх, үйл ажиллагаанд нь хориг саад учруулах зэргийг хориглоно. Нийлүүлэлт, худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээд нь ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу худалдааны регистрт мэдээллийг үнэ төлбөргүйгээр гаргаж ирүүлнэ.
6. Худалдааны бүртгэл хариуцсан ОХУ-ын субъектын төрийн захиргааны төв байгууллага нь улирал тутам, сар бүрийн 25-наас өмнө Холбооны улсын худалдааны салбар хариуцсан

гүйцэтгэх засаглалын байгууллага болон Холбооны улсын статистикийн төв байгууллагад худалдааны реестрт бүртгэсэн мэдээллийг нэгтгэн гаргаж хүргүүлнэ.

#### **Тав. Төгсгөлийн зүйл**

##### *21-р зүйл. Холбооны улсын энэ хуулийн хүлээлгэх хариуцлага*

Энэхүү хуулийг зөрчсөн этгээд ОХУ-ын холбогдох хуульд заасны дагуу иргэний эрх зүйн, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээнэ.

##### *22-р зүйл. Төгсгөлийн зүйл*

1. Энэхүү хууль нь 2010 оны 02 сарын 01-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
2. Энэ хууль батлагдахаас өмнө хийгдсэн хүнсний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээний нөхцөлийг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 180 хоногийн дотор хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчилнө.
3. Энэ хуулийн 14-р зүйлд заасан шаардлага нь энэ хууль батлагдахаас өмнө хийгдсэн хэлцэл, ашиглалтад оруулсан, худалдан авсан болон түрээсэлсэн худалдааны объектод хамаарахгүй.
4. Энэ хуулийн 14-т заасан орон нутгийн район, хотын тойргуудад хамаарал бүхий хязгаарлалтуудыг 2010 оны 7 сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлнэ.
5. Крымийн улсын нутаг дэвсгэр дэх нутгийн удирдах байгууллага энэ хуулийн 6-р зүйлийн 2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ 2017 оны 01 сарын 01-ныг хүртэл Крымийн улсын хууль тогтоомжийг баримтална. (2014 онд өөрчлөлт оруулсан)

**ОХУ-ын Ерөнхийлөгч**

**Д. Медведев**

Москва, Кремль  
28 декабря 2009 года  
N 381-ФЗ

#### **2.1.2 “ГАДААД ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ” ОХУ-ЫН ХУУЛЬ<sup>21</sup>**

(2003 оны 11 сарын 21-ны өдөр Төрийн Думаар батлагдаж, 2003 оны 11 сарын 26-ны өдөр Холбооны Зөвлөлөөр дэмжигдсэн)

##### **а) Хуулийн бүтэц, агуулга:**

*Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл*

- 1-р зүйл. Хуулийг хэрэглэх зорилго, хамрах хүрээ;
- 2-р зүйл. Хуульд заасан нэр томъёоны тайлбар, тодорхойлолт;
- 3-р зүйл. ОХУ-ын гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актууд;
- 4-р зүйл. Гадаад худалдааны салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн зарчмууд;
- 5-р зүйл. ОХУ-ын худалдааны бодлого.

*Хоёрдугаар бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь оху, оху-ын субъектуудын төрийн байгууллагууд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх*

6-р зүйл. Холбооны улсын төрийн байгууллагуудын гадаад худалдааны салбар дахь эрх.

6.1-р зүйл Холбооны улсын төрийн байгууллагаас гадаад худалдааны салбар дахь

а \_\_\_\_\_

<sup>21</sup> [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_law\\_45397/](http://www.consultant.ru/document/cons_doc_law_45397/)

ФЗ “Об основах государственного регулирования внешнеторговой деятельности”

эрхээ Холбооны улсын субъектуудад шилжүүлэх журам

7-р зүйл. Хүчингүй болсон;

8-р зүйл. ОХУ-ын субъектуудын төрийн байгууллагуудын гадаад худалдааны салбар дахь зохицуулалтын эрх;

9-р зүйл. ОХУ, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хамтын ажиллагаа.

*3-р бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогчид*

10-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч гадаад, дотоодын этгээд;

11-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагаанд ОХУ, ОХУ-ын субъектууд, нутгийн удирдах байгууллагуудын оролцоо.

*4-р бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт*

12-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах арга хэрэгсэлүүд;

13-р зүйл. ОХУ-ын төрийн байгууллагуудын гадаад худалдааны салбар дахь зохицуулалтын бүрэн эрх;

14-р зүйл. ОХУ-ын гадаад харилцааны салбарт олон улсын худалдааны болон бусад гэрээ хэлэлцээр хийх журам;

15-р зүйл. Гадаад худалдааны салбарыг төрөөс зохицуулалт арга хэмжээг ил тод болгох;

16-р зүйл. Гадаад худалдааны салбарт эрх зүйн хэм, хэмжээ тогтоосон актууд хүчин төгөлдөр болох;

17-р зүйл. Мэдээллийн нууцлал;

18-р зүйл. Төрийн байгууллага болон албан тушаалтны шийдвэр, үйлдэл, эс үйлдлийн талаар гомдол гаргах эрх.

*5-р бүлэг. Бараа таваарын гадаад худалдааг төрөөс зохицуулах*

19-р зүйл. Гааль-тарифын зохицуулалт;

20-р зүйл. Тарифын бус зохицуулалт;

21-р зүйл. ОХУ-ын олон улсын гэрээнд заасан онцгой тохиолдолд Засгийн газраас бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтэнд тооны хязгаар тогтоох журам;

22-р зүйл. Тооны хязгаарлалтыг ялгаварлалгүй хэрэглэх;

23-р зүйл. Квот хуваарилах;

24-р зүйл. Бараа таваарын гадаад худалдаанд лиценз олгох;

25-р зүйл. Тодорхой нэр төрлийн бараа таваарын экспорт, импортод хяналт тавих;

26-р зүйл. Тодорхой нэр төрлийн бараа таваарын экспорт, импорт хийх онцгой эрх;

27-р зүйл. Хамгаалалтын тусгай арга хэмжээ, демпингийн эсрэг арга хэмжээ ба нөхөн олговрын арга хэмжээ;

28-р зүйл. Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалт;

29-р зүйл. Гадаад орнуудаас гаралтай бараа таваартай холбоотой үндэсний дэглэм;

30-р зүйл. Бараа таваарын экспорт, импортын төлбөр;


31-р зүйл. Олон улсын транзитыг чөлөөтэй байлгах;

32-р зүйл. Үндэсний эрх ашгийн үүднээс бараа таваарын гадаад худалдаатай холбоотой авах арга хэмжээнүүд.

*6-р бүлэг. Үйлчилгээний салбарын гадаад худалдааг төрөөс зохицуулах*

33-р зүйл. Үйлчилгээний салбарын гадаад худалдаа;

34-р зүйл. Гадаад худалдааны үйлчилгээний салбар дахь үндэсний дэглэм;





35-р зүйл. Үндэсний эрх ашгийн үүднээс гадаад худалдааны үйлчилгээний салбарт авах арга хэмжээнүүд.

*7-р бүлэг. Оюуны өмчийн гадаад худалдааг төрөөс зохицуулах*

36-р зүйл. Оюуны өмчийн гадаад худалдаа

*8-р бүлэг. Бараа таваар, үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдаанд тавих хориглолт, хязгаарлалт*

37-р зүйл. ОХУ-аас олон улсын санкцийг хэрэгжүүлэх үүднээс бараа таваар, үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдаанд тавих хориглолт, хязгаарлалт;

38-р зүйл. ОХУ-ын төлбөрийн тэнцлийг тогтворжуулах үүднээс бараа таваар, үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдаанд тавих хориглолт, хязгаарлалт;

39-р зүйл. Валютын ханшийг зохицуулах үүднээс бараа таваар, үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдаанд тавих хориглолт, хязгаарлалт;

40-р зүйл. Хариу арга хэмжээ.

*9-р бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь онцгой дэглэм*

41-р зүйл. Хилийн худалдаа;

42-р зүйл. Эдийн засгийн онцгой бүс.

*10-р бүлэг. Гадаад худалдааны бартерын хэлцлийг төрөөс зохицуулах*

43-р зүйл. Гадаад худалдааны бартерын хэлцлийн талаар авах арга хэмжээнүүд; 44-р зүйл. Гадаад худалдааны бартерын хэлцэл болон түүний төлбөр тооцоонд хяналт тавих журам;

45-р зүйл. Гадаад худалдааны бартерын хэлцэл хийх, хэрэгжүүлэхтэй холбоотой онцлог зохицуулалтууд.

*11-р бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх*

46-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээнүүд;

47-р зүйл. Гадаад худалдааны салбар дахь мэдээллийн хангамж;

48-р зүйл. Гадаад худалдааны статистик;

49-р зүйл. ОХУ-ын этгээд гадаад зах зээл дээр гарахад таатай нөхцөл бүрдүүлэх;

50-р зүйл. ОХУ-ын гадаадын улс орон дахь гадаад эдийн засгийн харилцааны ашиг сонирхолыг хангах;

51-р зүйл. Гадаад орноос ОХУ-д худалдаа-эдийн засгийн харилцааны чиглэлээр төлөөлөгчийн газар ажиллуулах.

*12-р бүлэг. Гадаад худалдааны үйл ажиллагаанд тавих хяналт, гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой оху-ын хууль тогтоомжийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага*

52-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагаанд тавих хяналт;

53-р зүйл. Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой ОХУ-ын хууль тогтоомжийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага.

*13-р бүлэг. Төгсгөлийн болон шилжилтийн зүйл*

54-р зүйл. Хууль хүчин төгөлдөр болох



## **6) Хуулийн зохицуулалт**

### **Ерөнхий зүйл**

*Хуулийн зорилго ба зохицуулалтын хамрах хүрээ*

ОХУ-ын гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай хуулиар ОХУ болон түүний субъектуудын гадаад худалдааны харилцааг төрөөс зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлж, гадаад худалдааны салбар хөгжих таатай орчинг бүрдүүлэх, ОХУ-ын гадаад худалдааны салбар дахь эдийн засгийн болон улс төрийн ашиг сонирхолыг хамгаалах, зохицуулах үүрэг бүхий эрх бүхий төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлсон. Энэ хуулийн зохицуулалтанд цэрэг, дайны зориулалттай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээлэл, оюуны өмчийн гадаад худалдааны үйл ажиллагаа хамаарахгүй.

*Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулж буй ОХУ-ын эрх зүйн актууд*

ОХУ-д гадаад худалдааны үйл ажиллагааг Үндсэн хууль, энэ хууль болон ОХУ-ын олон улсын эрх зүй, гэрээ хэлэлцээрт нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн актуудаар зохицуулна.

### **Гадаад худалдааны салбар дахь төрийн зохицуулалт**

*Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчмууд*

ОХУ нь гадаад худалдааны үйл ажиллагаанд энэ хуулиар тогтоосон дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- 1) Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцож буй субъектууд болон ОХУ-ын үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг төрөөс хамгаалах;
- 2) Хуульд өөрөөр заагаагүй бол гадаад худалдаанд оролцогчдод тэгш байдал олгох, ялгаварлан гадуурхахгүй байх;
- 3) Бусад улс орнуудтай харилцан хамтран ажиллах;
- 4) ОХУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх, энэ хүрээнд олгогдсон эрхээ эдлэх;
- 5) Гадаад худалдааны салбарт төрөөс явуулж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь оролцогчдод аль болох дарамт, хүндрэл учруулахгүй байх;
- 6) Гадаад худалдааны талаар гаргаж буй бодлого, шийдвэр, хэрэгжилт нь ил тод байх;
- 7) Төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь үндэслэлтэй, бодитой байх;
- 8) Төрийн оролцоо, зохицуулалт нь гадаад худалдаанд оролцогчид болон ОХУ-ын эдийн засагт хор хохирол учруулахгүй байх;
- 9) Гадаад худалдаанд оролцогчид ОХУ-ын төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн талаар шүүхийн журмаар гомдол гаргах, хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах эрхтэй байх;
- 10) Гадаад худалдааны үйл ажиллагаа болон төрийн зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах;
- 11) ОХУ-ын нутаг дэсвэрийн хязгаар дотор гадаад худалдаа болон төрийн зохицуулалтын арга хэрэгслүүдийн нэгдмэл байдлаар явуулах.

*Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах, хяналт тавихтай холбоотой Холбооны улсын төрийн байгууллагуудын эрх*

- 1) ОХУ-ын гадаад худалдааны бодлогын концепц, стратеги, үндсэн зарчмуудыг тодорхойлох;
- 2) ОХУ-ын эдийн засгийн бие даасан байдал, ашиг сонирхолыг хамгаалах;
- 3) Гадаад худалдааны харилцаан дахь төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, тухайлбал гааль-тарифын болон тарифын бус зохицуулалт, бараа нийцлийг хянах;

- 4) ОХУ руу оруулж, гаргаж буй бараа бүтээгдэхүүний хүн, амьтан, ургамал, байгаль орчны аюулгүй байдлын стандартыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
- 5) ОХУ-ын олон улсын гэрээ, Гаалийн холбооны хорооны шийдвэрийн дагуу ОХУ-ын нутаг дэвсгэрт цөмийн зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах бодис болон биологийн идэвхит материал зэрэг онц аюултай бараа бүтээгдэхүүнийг оруулж, гаргах үйл ажиллагааг зохицуулах, хянах;
- 6) ОХУ-ын нутаг дэвсгэрт Олон улсын гэрээ, Гаалийн холбооны шийдвэрийн дагуу үнэт металл, үнэт чулуу оруулж гаргах үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих;
- 7) Сансар судлал, сансрын үйл ажиллагааны чиглэлээр ОХУ-аас бусад орнуудтай хамтран ажиллах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах;
- 8) ОХУ-ын нутаг дэвсгэрт явуулж буй гадаад худалдааны үйл ажиллагааны нэгдсэн статистик мэдээлэл гаргах;
- 9) Гадаад эдийн засгийн харилцааны хүрээнд гэрээ хэлэлцээр хийх;
- 10) Гадаад оронд ОХУ-ын худалдааны төлөөлөгчийн газар ажиллуулах, татан буулгах;
- 11) Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаанд оролцох, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 12) Улсын нууцтай холбоотой мэдээлэл агуулсан бараа бүтээгдэхүүнийг ОХУ-ын нутаг дэвсгэрээс гаргах журам тогтоох;
- 13) ОХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаад худалдааны талаарх мэдээллээр хангах;
- 14) Гадаад худалдааны салбарт даатгалын болон баталгааны сан байгуулах.

*Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах, хяналт тавихтай холбоотой Холбооны улсын субъектуудын төрийн байгууллагуудын эрх*

- 1) Холбооны бусад улсууд, гадаад орнуудын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн удирдах байгууллагууд болон ОХУ-ын Засгийн газрын зөвшөөрсөнөөр гадаадын бусад орнуудын төрийн байгууллагуудтай хэлэлцээр хийх, гэрээ хэлэлцээр байгуулах;
- 2) Гадаад оронд байгаа ОХУ-ын худалдааны төлөөлөгчдийн газарт өөрийн төлөөлөгчөө суулгах;
- 3) ОХУ-ын хуулиар тогтоосон журмын дагуу гадаад эдийн засгийн харилцааны хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор гадаад улсад худалдааны төлөөлөгч ажиллуулах;
- 4) Гадаад худалдааны салбарт хэрэгжүүлэх бүс нутгийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;
- 5) ОХУ-ын субьектын газар нутагт гадаад худалдааны мэдээллээр хангах ОХУ-ын субьектын газар нутагт гадаад худалдааны үйл ажиллагааны даатгалын болон барьцааны сан байгуулах.

*Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогчид*

ОХУ-ын болон гадаадын дурын иргэн, хуулийн этгээд гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Энэхүү эрхийг ОХУ-ын олон улсын хэлэлцээр, энэ хууль болон холбогдох бусад хуулиар хязгаарлаж болно.

*Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах*

Хуулийн 12-р зүйлд гадаад худалдааг төрөөс зохицуулах арга хэрэгслүүд болон гадаад худалдааны салбарыг зохицуулах, хянах үүрэгтэй төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлсон. ОХУ-д гадаад худалдааны төрийн зохицуулалтанд дараах арга хэрэгслүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- Гааль-тарифын зохицуулалт
- Тарифын бус зохицуулалт

- Тодорхой нэр төрлийн ажил үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдааг хязгаарлах болох хориглох
- Хуульд заасан гадаад худалдааны үйл ажиллагааш дэмжих эдийн засгийн болон захиргааны шинжтэй арга хэмжээнүүд

Хуулийн 13-р зүйлд дараах эрх бүхий төрийн институци, байгууллагуудын гадаад худалдааны салбарт хэрэгжүүлэх, эрх, үүргийг тодорхойлсон. Үүнд:

- ОХУ-ын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулиар олгогдсон эрх;
- ОХУ-ын Засгийн газрын эрх, үүрэг;
- ОХУ-ын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын эрх, үүрэг;

## **Бараа бүтээгдэхүүний гадаад худалдааг төрөөс зохицуулах**

### *Гааль-тарифын зохицуулалт*

Бараа таваарын гадаад худалдаанд, ялангуяа ОХУ-ын дотоодын зах зээлийг хамгаалах, Гаалийн холбооны гишүүн орнуудын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нийцүүлэх үүднээс хууль тогтоомжоор ОХУ-ын нутаг дэвсгэрт бараа таваарыг оруулах болон гаргахад гаалийн татвар тогтооно.

### *Тарифын бус зохицуулалт*

Тарифын бус зохицуулалтанд бараа таваарыг хамруулах нөхцөлийг энэ хуулийн 21-24, 26-27-р зүйлд тусгайлан заасан.

### *Тооны хязгаар тогтоох буюу хориглох*

Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа таваарын экспорт, импортод тооны хязгаар тогтоохгүй. Гэвч ОХУ-ын Засгийн газраас олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн дараах тохиолдолд 6 сараас дээшгүй хугацаагаар тооны хязгаарлалт тогтоож болно. Үүнд

- 1) Дотоодын зах зээлд хомсдол үүссэн хүн амын хэрэгцээнд туйлын чухал ач холбогдолтой хүнсний болон бусад бараа таваарыг экспортлохыг түр хугацаагаар хязгаарлаж болно. Хязгаарлалтанд хамрагдах бараа таваарын жагсаалтыг Засгийн газар батална.
- 2) Хэрвээ хязгаарлах шаардлагатай гэж үзвэл дараах хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, усны биологийн нөөцийг импортлохыг хязгаарлана. Үүнд:
  - а) Оросын гарал үүсэлтэй бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах хэмжээг багасгах;
  - б) Оросын гарал үүсэлтэй, импортын ижил төрлийн бараа бүтээгдэхүүнээр орлуулах боломжтой бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдаалах хэмжээг багасгах;
  - в) Оросын гарал үүсэлтэй, зах зээл дээр илүүдэл үүсгэж буй бараа бүтээгдэхүүний илүүдэл хэсгийг хэрэглэгчдэд зах зээлийн үнээс доогуур үнээр худалдаалах буюу үнэгүй өгөх замаар багасгах;
  - г) Оросын гарал үүсэлтэй, импортын бараа бүтээгдэхүүнээр орлуулж болохуйц, илүүдэл үүсгэж буй бараа бүтээгдэхүүнийг оросын хэрэглэгчдэд зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулах буюу үнэгүй өгөх замаар багасгах;
  - д) ОХУ дахь үйлдвэрлэгдэж буй хэмжээ нь бага, үйлдвэрлэл нь импортоос шалтгаалах амьтны гаралтай бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг хязгаарлах;

Хүнсний болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хязгаарлалтын хэмжээг Засгийн газар тогтооно.

### *Тооны хязгаарыг ялгавартай тогтоохгүй байх*

ОХУ-ын хууль тогтоомжоор бараа бүтээгдэхүүний экспорт, импортод хязгаарлалт тогтоохдоо хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол улс орны гарал үүсэл хамааралгүйгээр тогтооно. Хэрэв сонирхож буй улс орнуудад квот тогтоох шаардлагатай гэж үзвэл тухайн улс оруудын өмнөх импортын хэмжээг харгалзан үзнэ. Хуулийн энэ зохицуулалт нь ОХУ-тай бусад орнуудад үзүүлж байгаа нөхцөлөөс илүү таатай нөхцөлөөр гадаад худалдаа хийх гэрээний үүрэг хүлээгээгүй орнуудад хамаарахгүй.

### *Квот хуваарилах*

ОХУ-ын Засгийн газраас квот хуваарилахдаа эхний ээлжинд квот хуваарилах аргаа тодорхойлно. Квотыг конкурс, аукционы зарчмаар хуваарилна. Ингэхдээ гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцох сонирхолтой бүх оролцогчдод өмчийн хэлбэр, оршин байгаа эсхүл бүртгүүлсэн газар орон хамааралгүйгээр ямар нэгэн ялгаварлал үүсгэхгүйгээр хуваарилах зарчмыг баримтална.

### *Бараа бүтээгдэхүүний гадаад худалдаанд лиценз олгох*

Дараах тохиолдолд бараа бүтээгдэхүүний гадаад худалдаанд лиценз олгоно. Үүнд:

- 1) Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнд экспорт, импортын тооны хязгаарлалт тогтоосон бол;
- 2) Улс орны аюулгүй байдал, хүн, амьтан, мал, ургамал, байгаль орчин, төрийн болон орон нутгийн өмч, хувь хүн болон хуулийн этгээдийн өмч хөрөнгөд сөрөг нөлөө, хор хохирол учруулж болохуйц, заавал зөвшөөрөл авч нийлүүлэх ёстой бараа таваар;
- 3) Онцгой эрхтэйгээр нийлүүлэх тодорхой нэт төрлийн бараа таваар;
- 4) ОХУ-ын олон улсын гэрээний үүргийн дагуу хийгдэж буй худалдаа.

### *Тодорхой нэр төрлийн бараа таваарын экспорт, импортод хяналт тавих*

Тодорхой нэр төрлийн зарим барааны экспорт, импортод хяналтыг тухайн нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортын динамикт мониторинг хийх цаг зуурын арга хэмжээ болгон хэрэглэнэ. Хяналтыг ОХУ-ын олон улсын гэрээ, Гаалийн комиссын шийдвэрт нийцүүлэн тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортод зөвшөөрөл олгох замаар хэрэгжүүлнэ.

### *Тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортод онцгой эрх олгох*

Тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортод ОХУ-ын олон улсын гэрээ, Гаалийн холбооны комиссын шийдвэрийн дагуу экспорт, импортын онцгой эрх олгоно. Онцгой эрх олгох журам болон бараа бүтээгдэхүүний нэр төрлийг Засгийн газар тогтооно.

### *Хамгаалалтын тусгай арга хэмжээ, демпингийн эсрэг арга хэмжээ ба нөхөн олговрын арга хэмжээ*

ОХУ-ын дотоодын үйлдвэрлэгчдийн эдийн засгийн ашиг сонирхолыг хамгаалах, дотоодын зах зээлийг дэмжих үүднээс олон улсын гэрээ болон Гаалийн холбооны комиссын шийдвэр, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хамгаалалтын тусгай арга хэмжээ, демпингийн эсрэг арга хэмжээ, нөхөн олговрын арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

### *Тээвэрлэхийн өмнөх гаалийн хяналт шалгалт*

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, ОХУ руу оруулж буй бараа бүтээгдэхүүний үнийг зохимолоор бууруулж бичих зэрэг зөрчлийг илрүүлэх үүднээс тээвэрлэлтийн баримт бичигт хяналт шалгалт хийж болно. Тухайлбал, тодорхой нэр төрлийн бараа таваарын импортын

бараанд тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалт хийсэн тухай сертификат олгох гэх мэт. Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтыг тодорхой нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд хийх ба 3 жилээс дээшгүй хугацаагаар хяналт хийнэ. Засгийн газраас хяналт шалгалтын хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн барааны импортод хяналт хийсэн дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж авсан арга хэмжээний практик үр дүн ямар байсныг судалж дүгнэсэний үндсэн дээр шийдвэр гаргана.

Тээвэрлэлтийн өмнөх хяналтаар оруулах бараа бүтээгдэхүүний жагсаалтыг Засгийн газар батлах ба хяналт шалгалт хийхтэй холбогдон гарсан зардлыг импортлогч хариуцна. Засгийн газраас тээвэрлэлтийн өмнөх хяналтаар оруулах барааны жагсаалтыг батлахдаа уг бараа бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн татварын хэмжээг бууруулан батална.

Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтыг хариуцан гүйцэтгэх байгууллагыг Засгийн газраас тендер зарлан сонгон шалгаруулах ба Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэнэ. Хяналт шалгалт гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа дараах шалгуурыг хангаж байгаа эсэхийг харгалзан үзнэ. Үүнд:

- 1) Мэргэжлийн салбар дахь нэр хүнд, байр суурь;
- 2) Үйл ажиллагааны болон мэргэшсэн боловсон хүчний хангалттай нөөцтэй эсэх;
- 3) Тээвэрлэлтийн өмнөх гаалийн урьдчилсан хяналт шалгалтын ажил үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай эсэх;
- 4) Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх үнийн санал.

Засгийн газраас тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх журмыг батлах бөгөөд уг журмаар хяналт шалгалтын ажлыг хэрхэн гүйцэтгэх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцож буй субъектуудын эрх үүрэг, импортлогч болон хяналт гүйцэтгэгч байгууллагын хооронд гарсан маргааныг хэрхэн шийдвэрлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих зэрэг асуудлуудыг журамлан тогтооно.

Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтыг явуулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 1) Ил тод, нээлттэй байх;
- 2) Тээвэрлэлтийн өмнөх хяналт шалгалтыг явуулах процедур, тавигдах шаардлага зэрэг нь бодитой байхаас гадна импортлогч бүрт тэгш үйлчлэх;
- 3) Бараа бүтээгдэхүүний тоо, чанарын хяналтыг ОХУ-ын хуулиар тогтоосон шаардлагад нийцүүлэн тавих;
- 4) Импортлогчийг бараа бүтээгдэхүүний урьдчилсан хяналт шалгалтанд хамруулах тухай ОХУ-ын хуулиар тогтоосон шаардлагын талаарх мэдээллээр хангах;
- 5) Урьдчилсан хяналт шалгалт явуулж байх үед олж авсан бараа бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийн нууцлалыг хадгалах.

Бараа бүтээгдэхүүнийг гаалийн урьдчилсан хяналтанд хамруулж байгаа импортлогч этгээд бараа бүтээгдэхүүнийхээ импортын мэдүүлгийг гаргаж өгөх бөгөөд хяналт шалгалтын байгууллагын зүгээс хяналт шалгалтыг явуулсаны үндсэн дээр бараа бүтээгдэхүүний хяналт шалгалт хийгдсэн тухай сертификат олгох буюу, эсхүл татгалзах үндэслэлээ гаргаж сертификат олгохоос татгалзана.

Хяналт шалгалтыг ажлын 3 өдөрт багтаан явуулах ба гаалийн урьдчилсан хяналтаар оруулах ёстой импортын бараа бүтээгдэхүүнийг зөвхөн хяналт шалгалтад хамрагдсан тухай сертификатыг үндэслэн хилээр оруулна.

*Гадаад улсаас гаралтай бараанд тогтоох үндэсний дэглэм*

ОХУ-ын татвар, хураамжийн тухай хуулиар бараа таваар нь аль улсаас гаралтайгаас



хамааруулан ялгавартай татвар, хураамж тогтоохыг хориглоно.

Техникийн, эмийн, ариун цэврийн, мал эмнэлгийн, халдвар хамгааллын болон экологийн шаардлага, мөн нийцлийн шаардлага зэрэг шаардлагууд гадаад орнуудаас гаралтай бараа таваар болон оросын гарал үүсэлтэй таваарт ижлээр тавигдана. Гадаадын бараа таваарыг худалдахыг санал болгох, худалдан борлуулах, худалдан авах, тээвэрлэх, хуваарилах болон дотоодын зах зээлд ашиглахад оросын гаралтай бараа бүтээгдэхүүнээс дутахааргүй таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Тээвэрлэлтийн өртөгөөс шалтгаалан ялгавартай төлбөр хураамж төлөхөд энэ журам хамаарахгүй.

Гадаадын аль нэг орноос гаралтай бөгөөд оросын бараа бүтээгдэхүүнтэй ижил дэглэм тогтоох ОХУ-ын ОУ-ын гэрээнд тусгагдаагүй бараа бүтээгдэхүүнд холбогдох хуулийн дагуу өөр дэглэм тогтоож болно. Дээрх зохицуулалт нь ОХУ-ын төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа таваарт хамаарахгүй.

#### *Бараа таваарын экспорт, импортын төлбөр*

ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон, гаалийн татвар болон бусад төрлийн татварын төрөлд хамаарахгүй төлбөрийн нийт хэмжээ нь үзүүлж байгаа ажил үйлчилгээний өртөгөөс хэтэрч болохгүй бөгөөд дотоодын гаралтай бараа таваарын зах зээлийг хамгаалах, төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгыг агуулна.

Экспорт, импортын төлбөр хураамжийг дараах төрлийн бараа таваараас авна. Үүнд:

- 1) тооны хязгаарлалт тавьсан бараа;
- 2) лицензтэй гаргах бараа;
- 3) валютын хяналт зохицуулалтанд нөлөөлөх бараа;
- 4) статистикийн үйлчилгээ;
- 5) зайлшгүй шаардлагын нийцлийг тодорхойлох бараа;
- 6) эксперт болон гаалийн урьдчилсан хяналтанд хамрагдах бараа;
- 7) карантин, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх бараа.

#### *Олон улсын транзитыг чөлөөтэй нэвтрүүлэх*

Хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол олон улсын транзит барааг төмөр зам, усан зам, агаарын зам, автозам зэрэг олон улсын тээврийн боломжтой бүх сувгуудаар чөлөөтэй нэвтрүүлнэ. Олон улсын тээвэрлэлтэд улс орнуудын далбаа, бүртгүүлсэн газар, хөлөг онгоцны гарал үүсэл, тээвэр эхлүүлсэн болон буулгах боомт, бараа таваарын өмчлөлтэй холбоотой нөхцөл байдал, усан онгоц болон тээврийн хэрэгслийн өмчлөл зэрэгт хуульд тусгайлан заагаагүй ямар нэгэн ялгавартай байдал үүсгэхийг хориглоно.

Гаалийн холбооны гаалийн хууль тогтоомж болон ОХУ-ын гаалийн тухай хууль тогтоомжоор тодорхой нэр төрлийн бараа таваар болон тээврийн хэрэгслийг ОХУ-ын нутагт оруулж, гаргахад тодорхой шаардлага тавьж болох бөгөөд ОХУ-ын хилийн тодорхой пунктаар нэвтрүүлэх, тодорхой маршрутаар явуулах арга хэмжээ авч болно. Энэ зохицуулалт агаарын тээвэрт хамаарахгүй.

*Үндэсний эрх ашгийн үүднээс бараа таваарын гадаад худалдааны талаар авах арга хэмжээнүүд*

Энэ хуулийн зохицуулалтаас үл хамааран гадаад худалдаанд дараах тохолдолд эдийн засгийн бус тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) нийгмийн ёс суртахуун, эмх журмыг сахиулах шаардлагаар;
- 2) хүний амьдрал болон эрүүл мэнд, амьтан, ургамал, байгаль орчныг хамгаалах үүднээс;



- 3) алт, мөнгөний экспортод;
- 4) соёлын үнэт зүйлс, соёлын өвд;
- 5) нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн нөөцийг дуусахаас сэргийлэх, үүний зэрэгцээ хязгаарлагдмал нөөцтэй тухай байгалийн баялгийн нөөцийг дотооддоо үйлдвэрлэх, олборлох, ашиглахыг хязгаарлах үүднээс;
- 6) нийтийн болон орон нутгийн хэмжээнд хомсдол үүсгэж буй бараа таваарыг олж нийлүүлэх, хуваарилахад;
- 7) ОХУ-ын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах;
- 8) Улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс;
- 9) Олон улсын хэлэлцээрт нийцүүлэн ОХУ-ын Гаалийн тухай эрх зүйн актуудаар зохицуулсан зарим тохиолдлууд.

### **Үйлчилгээний салбар дахь гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах нь**

#### *Үйлчилгээний салбарын гадаад худалдаа*

Үйлчилгээний салбарын гадаад худалдаа нь дараах хэлбэртэй байна. Үүнд

- 1) ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадаад орны нутаг дэвсгэрт явуулах ажил үйлчилгээ;
- 2) Гадаад орны нутаг дэвсгэрээс ОХУ-ын нутаг дэвсгэрт явуулах ажил үйлчилгээ;
- 3) ОХУ-ын нутаг дэвсгэрт гадаадын захиалагчид үзүүлэх ажил үйлчилгээ;
- 4) Гадаад орны нутаг дэвсгэрт ОХУ-ын захиалагчид үзүүлэх ажил үйлчилгээ;
- 5) Гадаад орны нутаг дэвсгэрт оросын гүйцэтгэгч байгууллага ба түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үзүүлж буй ашгийн бус ажил үйлчилгээ;
- 6) ОХУ-ын газар нутаг дээр гадаадын гүйцэтгэгч байгууллага ба түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үзүүлж буй ашгийн бус ажил үйлчилгээ;
- 7) Оросын гүйцэтгэгч байгууллагын гадаад орны нутаг дэвсгэрт явуулж буй ашгийн төлөөх ажил үйлчилгээ;
- 8) Гадаадын гүйцэтгэгч байгууллагын ОХУ-ын нутаг дэвсгэрт явуулж буй ашгийн төлөөх ажил үйлчилгээ.

Хэрэв олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу зарим тодорхой салбарын, эсхүл үйлчилгээний секторын ажил үйлчилгээг хориглох, хязгаарлах зэрэг арга хэмжээ авч болно.

Хуулийн 6-р бүлгийн 34-р зүйлд үйлчилгээний салбар дахь гадаад худалдаанд үндэсний дэглэм тогтоох асуудлыг зохицуулсан. Зохицуулалтын зарчим нь бараа бүтээгдэхүүний гадаад худалдаанд үндэсний дэглэм тогтоохтой ижил.

Хуулийн 6-р бүлгийн 35-р зүйлд үндэсний эрх ашгийн үүднээс үйлчилгээний салбарын гадаад худалдааны талаар авах арга хэмжээнүүдийг тусгасан. Үүнд:

- нийгмийн ёс зүй, хэв журмыг сахих;
- хүн, амьтан, мал, ургамал, байгаль орчны хор хөнөөлийг бодолцох;
- ОХУ-ын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх;
- улсын аюулгүй байдал, батлан хамгаалах зорилгод нийцүүлэх;
- санхүүгийн зах зээлийн бүрэн бүтэн, тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, хадгаламж эзэмшигч, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах;
- гадаадын үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчилгээний арга хэлбэрт тэгш эрхийн зарчмаар ялгаваргүй татвар ногдуулах;
- давхар татвараас зайлсхийх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ;
- энэ хууль болон бусад хуультай нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын хүрээнд авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээ. Үүнд:

- a) Гэмт хэргийн шинжтэй, шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд яваа асуудалд харилцан дэмжлэг үзүүлэх;
- b) Үйлчилгээ үзүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй, эсхүл хууран мэхэлсэн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- c) Хувь хүний нууцад нэвтрэхээс сэргийлэх, хувийн мэдээлэл болон хувийн данс, хуулиар нууцын зэрэглэлд багтаасан мэдээллийг хамгаалах.

Дээрх арга хэрэгслүүдийг ямар нэгэн улс орны хувьд үндэслэлгүйгээр, эсхүл дур мэдэн, ялгавартай хэрэглэж болохгүй. Хуулийн энэ зохицуулалтууд ОХУ-тай гадаад худалдааны үйлчилгээний салбарт тааламжтай нөхцөл олгох тухай гэрээтэй орнуудаас бусад орнуудад хамаарахгүй.

### **Оюуны өмчийн салбар дахь гадаад худалдааг Төрөөс зохицуулах**

ОХУ-ын аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын эрх ашгийн үүднээс болон ОХУ-ын олон улсын гэрээгэр хүлээсэн үүргийг биелүүлэх, ОХУ-ын хууль тогтоомжийн хүрээнд хүн, амьтан, ургамал, байгаль орчны хэвийн байдлыг хамгаалах, нийгмийн хэв журам, ёс зүйн хэм, хэмжээг сахиулах зорилгоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл хуульд заасан тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болно.

*Оюуны өмчийн гадаад худалдаанд тавих тусгайлсан хориглолт, хязгаарлалт Олон улсын санкцийн хүрээнд*

ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний гадаад худалдаанд НҮБ-ын дүрэмд заасан олон улсын санкцийн дагуу тодорхой хэмжээний хязгаарлалтын арга хэмжээ авч болно.

*ОХУ-ын төлбөрийн балансын тэнцлийг хангах үүднээс оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаанд хязгаарлалт тавих*

ОХУ-ын гадаад дахь санхүүгийн байдлыг хамгаалах, төлбөрийн тэнцлийн тэнцвэрийг тогтвортой хадгалах үүднээс Засгийн газраас оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд дараах зорилгоор тодорхой хязгаарлалт тавьж болно. Үүнд:

- 1) Валютын нөөцийн хомсдолыг зогсоох;
- 2) Валютын нөөцийг зохист түвшинд хүргэж нэмэгдүүлэх.

Эдгээр шалтгааны улмаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг Холбооны улсын Засгийн газрын холбогдох байгууллага авч хэрэгжүүлэх бөгөөд тавьсан зорилгодоо хүрэх хугацаагаар хэрэгжүүлнэ. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг ОХУ-ын Төв банкны өргөн мэдүүлснээр Засгийн газар гаргана.

*Валютын зохицуулалттай холбоотойгоор оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хязгаарлалт тавих*

Оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний гадаад худалдаанд валютын зохицуулалт хийх, валютын хяналт хийхтэй холбоотой арга хэмжээг Олон улсын валютын сантай байгуулсан зөвшилцлийн гэрээний заалтууд болон ОХУ-ын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлнэ.

### **Хариу арга хэмжээ**

ОХУ-ын Засгийн газраас оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний гадаад худалдаанд дараах тохиолдлуудад хязгаарлалтын хариу арга хэмжээ авч болно. Үүнд:

- 1) Хэрэв гадаад орны зүгээс Олон улсын болон ОХУ-тай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй тохиолдолд;
- 2) Хэрэв гадаад орны зүгээс ОХУ, түүний субъектууд болон орон нутгийн байгууллагуудын, мөн ОХУ-ын иргэн, хуулийн этгээдийн эдийн засгийн ашиг сонирхолыг зөрчсөн, ОХУ-ын улс төрийн эрх ашгийг хөндсөн, тухайлбал, ОХУ-ын этгээд гадаад зах зээл дээр гарахыг үндэслэлгүйгээр хориглосон, эсхүл ямар нэгэн хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд;
- 3) Хэрэв гадаад орны зүгээс ОХУ-ын этгээдийн тухайн орон дахь хууль ёсны эрх ашгийг хамгаалах зохистой, үр ашигтай арга хэмжээ авахгүй байх, тухайлбал, бусад этгээдийн зүгээс үзүүлж буй өрсөлдөөний эсрэг ажиллагаанаас хамгаалахгүй байх... гэх мэт тохиолдолд;
- 4) Хэрэв гадаад орны зүгээс ОХУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй тухайн орны харьяат хувь хүн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоохын төлөө зохистой арга хэмжээ авахгүй байгаа тохиолдолд.

Дээр дурьдсан хариу арга хэмжээг олон улсын эрх зүйн хэм, хэмжээ, зарчим, ОХУ-ын эдийн засгийн ашиг сонирхолыг хамгаалах чиглэлээр байгуулсан олон улсын гэрээнд нийцүүлэн авч хэрэгжүүлнэ. ОХУ-ын эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллага энэ хуулийн дагуу ОХУ, түүний субъект, орон нутаг, хуулийн этгээд, иргэний хууль ёсны эрх ашгийг гадаад орнуудын зүгээс хохироож, зөрчиж буй тохиолдлуудын талаарх статистик мэдээллийг цуглуулж хариу арга хэмжээ авах шаардлагатай эсэх талаар дүгнэлт гарган Засгийн газарт танилцуулна. Хариу арга хэмжээ авах шаардлага бий болсон эсэх асуудлыг Засгийн газарт танилцуулахдаа Гадаад харилцааны яамтай санал солилцож зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газарт санал оруулна.

Хариу арга хэмжээ авах тухай шийдвэрийг Засгийн газар гаргах бөгөөд шийдвэр гаргахаас өмнө Засгийн газраас тухайн оронтой хэлэлцээрийн журмаар асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

### **Гадаад худалдааны онцгой дэглэм**

#### *Хилийн худалдаа*

Хилийн худалдааны үйл ажиллагааг ОХУ-ын олон улсын гэрээний дагуу хилийн шугамаар зааглагдаж буй хөрш оронтой хийж болох бөгөөд уг худалдааны онцлог нь тухайн улсын хил орчмын нутаг дэвсгэр дэх бараа таваар, үйлчилгээний хэрэгцээг хангах үүднээс гадаад худалдааны илүү тааламжтай дэглэм тогтоох, хил орчмын үйлдвэр аж ахуйн газрын бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлж, тухайн газар нутагт амьдарч буй хүн ам, үйлдвэр аж ахуйн газруудыг хэрэгцээт бараа таваар, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах зорилготой. Хил худалдааны энэхүү онцгой дэглэм нь ОХУ-тай гадаад худалдааны тааламжтай дэглэм тогтоох гэрээтэй бусад орнуудад хамааралгүй.

Хилийн худалдааг ОХУ-ын хил орчмын нутаг дэвсгэр байнгын харьяалалтай оршин суугч этгээд болон гадаад орны тухайн бүс нутагт мөн оршин суух байнгын харьяалал бүхий этгээдүүд хил худалдааны ОХУ-ын олон улсын гэрээнд тусгайлан заасан газар нутагт, тухайн газар нутагт оршин суугчдын хэрэгцээнд зориулан явуулна.

Хилийн худалдааг хэрхэн явуулах тухай журам, хилийн худалдааны онцгой дэглэм тогтоох нутаг дэвсгэрийн хязгаарыг Засгийн газраас тогтоох бөгөөд хилийн худалдааны онцгой дэглэмийг ОХУ-ын олон улсын гэрээний дагуу нөгөө оронтойгоо харилцан тохиролцож, холбогдох хууль, журмын дагуу явуулна.

#### *Эдийн засгийн онцгой бүс*

Эдийн засгийн онцгой бүсэд аж ахуйн үйл ажиллагаа явуулах онцгой ээглэм, ялангуяа гадаад

худалдааны онцгой эзлэм тогтоохтой холбоотой харилцааг ОХУ-ын “Эдийн засгийн онцгой бүсүүдийн тухай хууль”-иар зохицуулна.

### **Гадаад худалдааны бартерын хэлцлийг төрөөс зохицуулах**

*Гадаад худалдааны бартерын хэлцлийн талаар авах арга хэмжээ*

Энэ хуульд заасан бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийн холбогдолтой гадаад худалдааны хориг, хязгаарлалтууд бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийн бартерын хэлцэлд мөн адил мөрдөгдөнө. Засгийн газраас бартерын хэлцэлд тавигдах хориг, хязгаарлалтыг тогтооно.

*Гадаад худалдааны бартерын хэлцлийн хэрэгжилт, төлбөр тооцоонд хяналт тавих*

Бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийн бартерын хэлцлийг гадаад худалдаанд хийхдээ ижил өртөгтэй бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийг харилцан солилцох зарчмыг баримтална. Хэрэв солилцоо хийж байгаа бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмч нь үнэ өртөгийн хувьд зөрүүтэй байвал зөрүүг тухайн тал төлөхөөр гэрээ хийнэ.

Гадаад худалдааны бартерын хэлцэлд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно. Бартерын солилцооны зөрүүг мөнгөөр хийж байгаа тохиолдолд төлбөр тооцооны хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар болон Төв банк холбогдох хуулийн дагуу тогтооно.

*Гадаад худалдааны бартерын хэлцлийг хэрэгжүүлэх журам*

Гадаад худалдааны бартерын хэлцэл хийсэн ОХУ-ын этгээд болон түүний төлөөлөл хэлэлд заасан хугацаанд ОХУ руу ижил өртөгтэй бараа бүтээгдэхүүн оруулах, эсхүл гадаад улсад ажил үйлчилгээ үзүүлэх эсхүл ижил өртөгтэй оюуны өмчийн эрхийг шилжүүлэх буюу оюуны өмчийг бүтээгдэхүүнийг өмчлөх, ашиглах эрхийг шилжүүлэх үүрэгтэй. Бартерын объектыг солилцоходоо тухайн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсан, ажил үйлчилгээ үзүүлсэн, эсхүл оюуны өмчийн эрх шилжүүлсэн баримт нотолгоог бүрдүүлэх, түүнчлэн хэрэв бартерын үнийн зөрүүг мөнгөөр тооцохоор тохиролцсон бол зөрүү мөнгийг ОХУ-ын харилцагчийн дансанд шилжүүлсэнийг нотлох баримтыг бүрдүүлэх ёстой. Хэрэв бартерын хэлцлийг гадаадын хэлцэлд оролцогч хэлцлийн объектыг ОХУ-ын нутаг дэвсгэр рүү оруулахгүйгээр хилийн чанадад хийхээр тохиролцсон бол эдгээр бараа, ажил үйлчилгээ, эрхийг хилийн чанадад ОХУ-ын этгээд хүлээн авсаны дараагаар энэ хуулийн 5-р зүйлд заасны дагуу хэлцэл биелсэнд тооцно.

Хилийн чанадад ОХУ-ын этгээдийн хийсэн бартерын хэлцэл, түүнийг гүйцэтгэх ажиллагааг ОХУ-ын нутаг дэвсгэрт хэлцлийн объектыг оруулахгүйгээр дараах тохиолдолд хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсан нь бартерын хэлцэлд заасан нөхцөлийн дагуу баримтаар нотлогдсон байх;
- 2) ОХУ-ын этгээд бартерын хэлцлээр хүлээн авсан бараа таваарыг хүлээн авсанаас хойш 1 жилийн дотор, эсхүл хэлцэлд заасан хугацааны дотор уг бараа таваарыг худалдан борлуулах бөгөөд бараа таваарыг борлуулсанаас орсон орлого, борлуулалтаар хүлээн авсан төлбөрийн хэрэгслийг банкин дахь өөрийн харилцах дансандаа төвлөрүүлсэн байх.

### **Гадаад худалдааг дэмжин хөгжүүлэх**

*Гадаад худалдааны хөгжлийг дэмжих арга хэмжээнүүд*

ОХУ-ын Засгийн газар, түүний субъектуудын гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллагууд нь ОХУ-ын олон уулсын гэрээнд нийцүүлэн гадаад худалдааг дэмжин хөгжүүлэх дараах арга

хэмжээнүүдийг (санхүүжилтийг шийдвэрлэсэн байх) авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Гадаад худалдааны харилцаанд оролцогчдод зээл олгох;
- 2) Экспортын зээлийг гарант, даатгалд хамруулах тогтолцоог бүрдүүлэх;
- 3) Олон улсын үзэсгэлэн, ярмарк худалдаа, төрөлжсөн симпозиум, конференц зохион байгуулах;
- 4) Оросын бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийг олон улсын зах зээлд гаргах, сурталчлан таниулахад чиглэсэн кампанит (реклам сурталчилгаа гэх мэт) ажлуудыг зохион байгуулах.

#### *Гадаад худалдааны мэдээллийн хангамж*

Гадаад худалдааны үр ашгийг дээшлүүлэх, дэмжин хөгжүүлэх зорилгоор энэ хуулийн 3.13-р зүйлд заасан ОХУ-ын гүйцэтгэх засаглалын байгууллага хариуцан гадаад худалдааны мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

Гадаад худалдааны мэдээллийн санд дараах мэдээллүүдийг төвлөрүүлнэ. Үүнд:

- 1) ОХУ-ын зах зээлд гадаад худалдааны харилцаанд оролцогч гадаад, дотоодын этгээдийн талаарх мэдээлэл;
- 2) Квот болон лиценз авсан гадаад, дотоодын этгээдийн талаарх мэдээлэл
- 3) Олон улсын худалдааны гэрээнүүд болон ОХУ-ын гадаад худалдааны салбарт байгуулсан бусад гэрээнүүд;
- 4) Гадаад худалдааны салбарт хамааралтай ОХУ-ын болон гадаад орнуудын хууль эрх зүйн актууд;
- 5) Гадаад улсад байгаа ОХУ-ын худалдааны төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 6) Гадаад худалдааны салбарт үйлчилгээ үзүүлж буй ОХУ-ын экспорт-импортын банк, зээлийн болон даатгалын үйлчилгээ үзүүлж буй бусад байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 7) ОХУ-ын гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл
- 8) Гадаад зах зээл дээр борлуулагдаж буй үндсэн нэрийн бараа таваарын бүлэг тус бүрээр зах зээлийн конъюнктур;
- 9) Техникийн зохицуулалтад холбогдох ОХУ-ын хууль эрх зүйн актууд;
- 10) Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь хууль зөрчсөн үйлдлүүдийн талаарх мэдээлэл;
- 11) ОХУ-ын нутаг дэвсгэрт оруулах, гаргахыг хориглосон бараа таваарын жагсаалт;
- 12) Гадаад худалдаа эрхлэгчдэд хэрэгтэй бусад мэдээллүүд.

ОХУ-ын эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллага нь гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч оросын болон гадаадын этгээдэд аль болох хурдан хугацаанд шаардлагатай мэдээллийг төлбөртэй гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд төлбөрийн хэмжээ нь тухайн мэдээллийг гаргаж өгөхөд гаргасан зардлаас хэтрэхгүй байх ёстой. Төлбөртэй мэдээллээс орсон орлогыг улсын төсөвт шилжүүлнэ.

ОХУ-ын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гадаад худалдааны салбарыг зохицуулах эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллага нь гадаад улс орон болон олон улсын байгууллагад гадаад худалдааны салбарын үйл ажиллагааг зохицуулах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг гаргаж өгнө.

#### *Гадаад худалдааны статистик*

ОХУ-ын Засгийн газар, Төв банк хамтран олон улсын статистик мэдээллийн практикт нийцүүлэн гадаад худалдааны статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах тогтолцоог олон улсын нэгдсэн аргачлалын дагуу, харьцуулах боломжтой байхаар гаргаж



статистик мэдээллийн сан бүрдүүлнэ. Статистик мэдээллийн сан нь дараах мэдээллүүдээс бүрдэнэ. Үүнд:

- 1) ОХУ-ын гадаад худалдааны талаарх Улсын статистикийн ерөнхий газраас гаргасан статистик, Гаалын ерөнхий газраас гаргасан статистик, ОХУ-ын худалдааны баланс;
- 2) ОХУ-ын төлбөрийн баланс, үүний дотор бараа таваар, ажил үйлчилгээ, оюуны өмчийн болон капиталын шилжилт хөдөлгөөний талаар статистик мэдээлэл.

ОХУ-ын Засгийн газар, Төв банк хамтран сар, улирал, жилээр дээрх статистик мэдээллүүдийг гарган албан ёсоор эмхэтгэл болгон гаргаж хэвлүүлнэ.

*ОХУ-ын этгээд гадаадын зах зээлд гарах таатай нөхцөлийг бүрдүүлэх*

ОХУ-ын Засгийн газраас оросын этгээдүүд гадаад орнуудын зах зээлд гарч худалдааны үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхдээ хоёр талын болон олон талын хэлэлцээр хийх, олон улсын гэрээ байгуулах, олон улсын байгууллага хамтран байгуулах, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, гадаад худалдааны үйл ажиллагаагаа сайжруулах санаачилга гаргасан бусад орнуудтай хамтран ажиллах хүрээнд Засгийн газар хоорондын комисс байгуулах зэргээр хэрэгжүүлнэ.

*Гадаадын улс оронд ОХУ-ын гадаад эдийн засгийн ашиг сонирхолыг хангах*

ОХУ-ын гадаад улс орон дахь эдийн засгийн гадаад ашиг сонирхолыг тус орон дахь ОХУ-ын Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газрууд болон ОХУ-ын олон улсын гэрээний дагуу байгуулагдсан худалдааны төлөөлөгчийн газрууд төлөөлөн хэрэгжүүлнэ.

Гадаад улс оронд худалдааны төлөөлөгчийн газар байгуулах шийдвэрийг ОХУ-ын Засгийн газар гаргана.

*ОХУ дахь гадаад орнуудыг худалдаа-эдийн засгийн асуудал хариуцсан төлөөлөгчийн газрууд*

Гадаад орнуудын худалдаа-эдийн засгийн асуудал хариуцсан төлөөлөгчийн газрыг ОХУ-ын тухайн улстай байгуулсан олон улсын гэрээний дагуу ОХУ-ын нутаг дэвсгэрт байгуулна.

**Гадаад худалдааны үйл ажиллагаанд тавих хяналт ба гадаад худалдааны хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага**

*Гадаад худалдааны үйл ажиллагаанд тавих хяналт*

Энэ хууль болон холбогдох бусад хуулийн тогтоомжийн хүрээнд гадаад худалдааны үйл ажиллагаанд хяналт тавих, ОХУ, түүний субъектууд, орон нутгийн байгууллагууд болон ОХУ-ын гадаад худалдаанд оролцогч этгээдийн эдийн засгийн болон улс төрийн ашиг сонирхолыг хангах, хамгаалахтай холбоотой асуудлыг ОХУ, түүний субъектуудын эрх бүхий төрийн байгууллагууд өөр өөрийн үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

*ОХУ-ын гадаад худалдааны хууль тогтоомжийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага*

Гадаад худалдааны үйл ажиллагааны явцад ОХУ-ын гадаад худалдааны хууль тогтоомж зөрчсөн этгээдэд ОХУ-ын холбогдох хуулийн дагуу иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

**Төгсгөлийн болон шилжилтийн зүйл**

Энэ хууль нь 2003 оны 12-р сарын 8-нд ОХУ-ын Төрийн Думаар батлагдсан бөгөөд хуулийн 4-р бүлгийн 45-р зүйлээс бусад зүйл заалтуудыг хууль батлагдсанаас хойш 6 сарын дараа



хүчин төгөлдөр мөрдөхөөр заасан.

Энэ хууль батлагдсантай холбогдуулан дараах хуулиуд хүчингүй болсонд тооцогдоно. Үүнд:

- “Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай” хууль (от 13 октября 1995 года N 157-ФЗ “О государственном регулировании внешнеторговой деятельности”);
- “Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” (от 8 июля 1997 года N 96-ФЗ “О внесении изменений в Федеральный закон “О государственном регулировании внешнеторговой деятельности”);
- “Бараа таварын гадаад худалдаанд ОХУ-ын эдийн засгийн ашиг сонирхолыг хамгаалах талаар авах арга хэмжээний тухай” хуулийн зарим зүйл, заалтууд (от 14 апреля 1998 года N 63-ФЗ “О мерах по защите экономических интересов Российской Федерации при осуществлении внешней торговли товарами”);
- “Бүтээгдэхүүн хуваах хэлцлийн тухай” ОХУ-ыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн зарим зүйл, заалтууд (от 10 февраля 1999 года N 32-ФЗ “О внесении в законодательные акты Российской Федерации изменений и дополнений, вытекающих из Федерального закона “О соглашениях о разделе продукции”);
- “ОХУ-ын татварын тухай хууль болон холбогдох зарим хууль эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн зарим зүйл, заалтууд (от 24 июля 2002 года N 110-ФЗ “О внесении изменений и дополнений в часть вторую Налогового кодекса Российской Федерации и некоторые другие акты законодательства Российской Федерации”.

ОХУ-ын гадаад худалдааны үйл ажиллагаанд дагаж мөрдөх эрх зүйн хэм, хэмжээ тогтоосон актуудыг энэ хуульд нийцүүлэн гаргана.

**ОХУ-ын Ерөнхийлөгч В.ПУТИН**

Москва, Кремль  
8 декабря 2003 года  
N 164-ФЗ

## **2.2.БНКаЗУ-ЫН ТУРШЛАГА**

Казахстан улс худалдааны тухай бие даасан хуультай бөгөөд “Худалдааны үйл ажиллагааг зохицуулах тухай” хууль нь 2004 онд батлагдсан. Уг хууль нь дараах 7 бүлгээс бүрддэг. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйлийн талаар;
- Хоёрдугаар бүлэг. Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай;
- Гуравдугаар бүлэг. Дотоод худалдааны талаар;
- Гуравдугаар бүлгийн 1. Дотоод худалдааг хөгжүүлэх, түүнийг дэмжих талаар;
- Дөрөвдүгээр бүлэг. Гадаад худалдааны тухай;
- Тавдугаар бүлэг. Худалдааны бусад төрлүүдийн талаар;
- Зургаадугаар бүлэг. Худалдааны субъектууд болон бараа бүтээгдэхүүнд тавигдах шаардлагуудын талаар;
- Долдугаар бүлэг. Худалдааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах тухай

**Хуулийн 1 дүгээр бүлэгт** ерөнхий зүйлүүд болон хуульд хэрэглэсэн нэр томьёо, ойлголтууд,

худалдааны үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжууд, хуулийн зорилго болон зарчмууд, хамрах хүрээний талаар тусгасан. Хуульд худалдааны үйл ажиллагааг зохицуулах зорилго, зарчмыг дараах байдлаар тодорхойлсон<sup>22</sup>.

Зорилго:

- хүн амыг бараа бүтээгдэхүүнээр хангах, худалдааны үйл ажиллагааг дэд бүтцээр хангах;
- худалдааны үйлчилгээ болон нийтийн хоолны зохион байгуулалт;
- Казахстан улсын худалдааны үйл ажиллагааг сайжруулах, түүнийг дэмжих;
- Казахстан улсыг дэлхийн худалдааны системд нэгдэх нөхцөлийг бүрдүүлэх;
- гадаад зах зээл дэх дотоодын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

Зарчим:

- худалдааны байгууллагын эрх тэгш байдал;
- хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд худалдааны үйл ажиллагаанд төрийн байгууллагууд хөндлөнгөөс үл оролцох;
- бизнес эрхлэхэд чөлөөт, шударга байх зарчмыг дэмжих;
- дотоодын түүхий эд үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- худалдааны үйлчилгээний чанар;
- худалдааны субъектуудыг худалдаа эрхлэхэд чөлөөт сонголт хийх боломж бололцоогоор хангах;
- худалдааны бодлого нь Казахстан улсын эдийн засгийн бодлогын салшгүй нэг хэсэг байх;
- хэрэглэгч, худалдааны субъектууд болон улс орны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг адил тэгш хамгаалах;
- Бүгд Найрамдах Казахстан Улсын нутаг дэвсгэрт гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулах нэгдмэл арга хэлбэртэй байх;
- гадаад худалдаан дахь төрийн зохицуулалтыг боловсруулах, батлах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг олон нийтэд сурталчлан таниулах;
- гадаад худалдааны төрийн зохицуулалт нь үндэслэлтэй, бодитой, тодорхой, ил тод байх зэрэг болно.

Худалдааны тухай хууль нь Казахстан улсын нутаг дэвсгэрт худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг бүх субъектуудад үйлчилнэ. Гэхдээ тусдаа хуулиар зохицуулагддаг бараа бүтээгдэхүүний хувьд үйлчлэхгүй. Мөн санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн хэрэгслүүдтэй холбоо бүхий харилцааг үүгээр зохицуулахгүй.

**Хуулийн 2 дугаар бүлэгт** худалдааны үйл ажиллагаанд төрөөс хийх зохицуулалтын талаар оруулсан. Үүнд: худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах арга болон хэлбэр, төрийн эрх мэдэл, эрх бүхий байгууллагын эрх мэдэл, орон нутгийн эрх бүхий байгууллагын эрх мэдэл, үнэ тогтоох зэрэг асуудлыг хамруулсан.

Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах арга, хэлбэрийг дараах байдлаар тодорхойлсон<sup>23</sup>.

Зохицуулах аргууд:

- гадаад худалдааны гаалийн тарифыг зохицуулах;

а

<sup>22</sup> [http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544_)

Худалдааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2

<sup>23</sup> [http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544_)

Худалдааны тухай хууль Хоёрдугаар бүлэг 5 дугаар зүйл

- гадаад худалдааны тарифын бус зохицуулалт;
- хууль журмын дагуу бараа бүтээгдэхүүн худалдаалахыг түр зогсоох, эсвэл хориглох;
- тусгай хамгаалалт, демпингийн эсрэг болон нөхөн төлбөр зэрэг арга хэмжээ авах;
- олон улсын эдийн засгийн хориг арга хэмжээнд оролцох зэрэг болно.

#### Зохицуулах хэлбэрүүд:

- Худалдааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх дүрэм журмыг тодорхойлох;
- Казахстан улстай хил залгаа Евроазийн эдийн засгийн холбооны хил гаалиар бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх нөхцөлийг тодорхойлох; Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнууд хоорондоо худалдаа хийхэд бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх нөхцөлийг тодорхойлох;
- худалдааны үйл ажиллагааны хөгжил дэвшлийг урамшуулан дэмжих;
- худалдааны салбарын хяналт шалгалт;
- гэрчилгээ олгох зэрэг болно.

Эдгээрээс гадна худалдааны салбарын үнэ тогтоох асуудлыг тодорхойлсон байна. Доорхоос бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүний үнийг худалдааны субъект өөрөө тогтооно. Үүнд:

- Муж, томоохон хотууд, нийслэл хотын хүрээнд нийгмийн ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүний жижиглэн худалдааны босго үнийг нэмэх тохиолдолд эрх бүхий байгууллага нь хуанлийн 90 хоног дотор босго үнийг тогтооно. Хэрэв хууль дүрэм зөрчвөл худалдааны субъект нь хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- Нийлүүлэгчийн шаардлагаар талуудын харилцан тохиролцсоны дагуу хүнсний бүтээгдэхүүн худалдаалах үнийн хязгаарыг нийлүүлэлтийн гэрээгээр тогтооно. Нийгмийн ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээ байгуулах үед худалдаалах үнийн хязгаарыг заавал тусгасан байх ба энэхүү шаардлагыг хангаагүй тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр бус байна.

**Хуулийн 3 дугаар бүлэг нь** дотоод худалдааг зохицуулна. Үүнд: дотоод худалдааны объектууд болон төрлүүд, бөөний худалдаа, жижиглэн худалдаа, нийтийн хоол, мөн худалдан авах-худалдах гэрээ хэлцлийн талаар тусгасан.

Дотоод худалдаанд худалдааны болон нийтийн хоолны объектууд хамаарна. Худалдааны объектыг суурин болон суурин бус гэж ангилдаг. Суурин худалдааны объектыг эзлэх талбайн хэмжээгээр 5 ангилалд хуваана. Суурин худалдааны төрөл, түүнд тавигдах шаардлагыг эрх бүхий байгууллагаас тогтоодог.

Суурин бус худалдааны объектод:

- Автомат- бараа бүтээгдэхүүн худалдаалах зориулалттай автомат төхөөрөмж;
- Хөдөлгөөнт тавиур- зөвшөөрөгдсөн орон зайд худалдаа хийх зориулалт бүхий зөөврийн байгууламж;
- Автохудалдаа- Худалдааны зориулалтаар тоноглогдсон автотээврийн хэрэгсэл;
- Павилон- зөвшөөрөгдсөн байрлалд байршилтай, худалдааны зориулалтаар тоноглогдсон, худалдааны агуулахтай нэг эсвэл хэд хэдэн худалдаа эрхлэх талбай бүхий хялбар угсрах-хураах бүтэцтэй байгууламж;
- Киоск- худалдааны зориулалтаар тоногдлогдсон ч хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын талбай болон байргүй, нэг эсвэл хэд хэдэн худалдаа эрхлэх талбай бүхий хялбар бүтэцтэй зөөврийн байгууламж орно.

Бараа бүтээгдэхүүнийг авто-дэлгүүрээр худалдаалах тохиолдолд тээврийн хэрэгсэл нь техникийн шаардлагыг сайтар хангасан байна.

Эдгээрээс гадна хуулийн энэ бүлэгт худалдааны захын талаарх зохицуултыг оруулсан. Худалдааны захуудын хувь худалдаалах бүтээгдэхүүний төрлөөс хамаарч олон төрөлтэй /универсальные/, дагнасан /специализированные/ гэж ангилагддаг<sup>24</sup>.

Олон төрөлтэй нь янз бүрийн бараа бүтээгдэхүүн худалдаалдаг зах юм. Харин дагнасан захын хувьд нийт бараа бүтээгдэхүүний 70 ба түүнээс дээш хувь нь нэг төрлийн бараа бүтээгдэхүүн байна.

Худалдааны захын үйл ажиллагааг зохион байгуулах зарчим, хамрах нутаг дэвсгэр, зориулалтын тоног төхөөрөмж болон хэрэгслээр хангагдсан байдалд тавих шаардлагыг төрөөс зохицуулдаг.

Худалдааны зах нь дараах шаардлагуудыг хангаж ажиллана. Үүнд:

- Худалдаа эрхлэх талбайг байршлын схемын дагуу зориулалтын тоног хэрэгслээр хангах, удирдлага буюу захиргааны ажилтнууд байрлах өрөө тасалгаа, агуулах байр, нийтийн зориулалттай байр талбайгаар хангана.
- Дараах мэдээллийг байршуулсан байна: худалдаа эрхлэх талбайн байршлын схем, аваарын болон бусад онцгой нөхцөлд нүүлгэн шилжүүлэлт хийх схем, худалдаа эрхлэх талбай түрээслэх эсвэл ашиглах гэрээ болон дүрэм журмын талаар, худалдаа эрхлэх сул талбай байгаа эсэх, түрээсийн эсвэл ашиглалтын гэрээ байгуулах тохиолдолд холбогдох этгээдтэй харьцах утас, электрон шуудан зэрэг мэдээллийг харагдахуйц газар байршуулна.
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг тавина.

Дотоод худалдаанд бөөний болон жижиглэн худалдаа, нийтийн хоол, хуульд тодорхойлсон бусад төрлүүд багтана. Бөөний худалдааг суурин худалдааны объект болон худалдааны захуудад хийнэ. Жижиглэн худалдааг суурин, суурин бус худалдааны объект, худалдааны захуудад явуулна. Дотоод худалдааны бүрэлдэхүүн хэсгийн нэг нийтийн хоолны үйлчилгээ юм. Нийтийн хоолыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- ресторан;
- кафе;
- цайны газар;
- баар орно.

Худалдааны тухай хуульд бараа бүтээгдэхүүнийг худалдан авах – худалдах асуудлыг ерөнхий байдлаар тусгасан бөгөөд Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

**Хуулийн 3-1 дүгээр бүлэгт** дотоод худалдааны хөгжлийг дэмжих асуудлыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;
- худалдааны мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, хөдөлмөрийн зах зээлийг бий болгох;
- худалдааны субъектууд, түүн дотор дотоодын хүнсний үйлдвэрлэгчдийг эдийн засгийн хувьд урамшуулах;
- электрон худалдааг хөгжүүлэх;
- хил орчмын худалдааг хөгжүүлэх;
- дотоод худалдааны сүлжээг хөгжүүлэх зэрэг болно.

а\_\_\_\_\_

<sup>24</sup>[http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544_)

**Хуулийн 4 дүгээр бүлэгт** гадаад худалдааны талаар зохицуулсан ба дараах асуудлуудыг хамруулсан. Үүнд:

- гадаад худалдааны гааль - тарифын зохицуулалт;
- тарифын квот;
- гадаад худалдааны тарифын бус зохицуулалт;
- тусгай /отдельных товаров/ бараа бүтээгдэхүүнийг оруулах гаргахыг хориглох, тоо хэмжээний хувьд хязгаар тогтоох;
- зөвшөөрөл олгох нөхцөл;
- хариу арга хэмжээ;
- хориглох, хязгаарлах онцгой төрлүүд /Особые виды запретов и ограничений/;
- зөвшөөрөл олгох зарчим болон журам;
- хариу арга хэмжээ;
- бараа бүтээгдэхүүний тусгай /отдельных товаров/ төрлийн онцгой эрх;
- тусгай /отдельных товаров/ төрлийн барааны автомат тусгай зөвшөөрөл;
- тусгай хамгаалалт, демпингийн эсрэг арга хэмжээ авах, нөхөн олговор олгох зэрэг асуудлыг зохицуулна.

**Хуулийн 5 дугаар бүлэгт** худалдааны бусад төрлүүдийн талаар тодорхойлсон бөгөөд электрон худалдааны талаарх зохицуулалтыг оруулсан. Бусад төрөлд дараах худалдааны төрлүүд хамаарна. Үүнд: Дуудлага худалдаа, комиссын худалдаа, захиалгат худалдаа, хил орчмын худалдаа, явуулын худалдаа, үзэсгэлэн худалдаа, электрон худалдаа орно.

**Хуулийн 6 дугаар бүлэгт** дараах зохицуултыг хийсэн.

- Худалдааны субъектууд болон бараа бүтээгдэхүүнд тавигдах шаардлагуудыг тодорхойлсон.
- Татвар төлөгч- хувиараа бизнес эрхлэгч болон хуулийн этгээдэд худалдааны объект, худалдааны объект дотор, худалдааны захад худалдаа эрхлэх талбай түрээслэхэд /ашиглахад/ тавигдах шаардлагын талаар оруулсан.
- Мөн бараа бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд, худалдааны субъектуудын эрхийн талаар тус тус заасан байна.

**Хуулийн 7 дугаар бүлэг нь** худалдааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах, худалдааны сүлжээ болон томоохон худалдааны объектод бараа бүтээгдэхүүний хүргэлтийг хянах, нийгмийн ач холбогдолтой хүнсний бүтээгдэхүүний жижиглэн худалдаанд тогтоосон үнийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээг дагаж мөрдөх явдлыг хянах, маргаан шийдвэрлэх, Худалдааны тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлагын талаар зохицуулсан.

### **2.3. ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА**

Япон Улсын хувьд худалдааны тухай бие даасан хуультай бөгөөд Худалдааны тухай хууль (Commercial Code) нь 1899 оноос хэрэгжиж эхэлсэн.

Одоогийн хүчин төгөлдөр хууль нь 851 зүйл, 3 хэсгээс бүрддэг. Хуулийн 1 дүгээр хэсэгт- Ерөнхий зүйл, 2 дугаар хэсэгт - Худалдаа арилжааны үйл ажиллагааны талаар, 3 дугаар хэсэгт- Далайн худалдааны талаар зохицуулсан. Японы Худалдааны тухай хуулийн хамгийн анхны хувилбарыг герман хүн боловсруулсан учир уг хуулийг батлах үед германы хуулийн нөлөө их байсан байна. 1950 онд хийгдсэн хуулийн шинэчилсэн найруулгад Америкийн Корпорацийн тухай хуулиас ТУЗ-ийн тогтолцоо, дериватив арга хэмжээ, эрх бүхий хөрөнгө зэрэг зарим ойлголтуудыг оруулжээ.

2005, 2008 онуудад Компаний тухай хууль, Даатгалын тухай хуулиуд батлагдан гарснаар Худалдааны тухай хуулиас холбогдох хэсгүүд хасагдаж хуулийг шинэчлэн найруулсан байна.

Худалдааны тухай хуульд ерөнхий анги, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоо бүхий заалтууд, худалдааны эрх зүйн үндсэн зохицуулалтуудыг тусгаснаас гадна компани, даатгал, далайн худалдааны талаар зохицуулсан заалтууд ч байдаг.

Японы Худалдааны тухай хуулийг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулсан хууль гэж үздэг. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өдөр тутам шинэчлэгдэн хөгждөг учраас Худалдааны тухай хуулийг нийгмийн өөрчлөлттэй нийцүүлэн тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах хэрэгцээ шаардлага өндөр байдаг. Мөн хууль тогтоогчийн зүгээс аливаа бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор ч өөрчлөх тохиолдол байна.

Худалдааны тухай хуульд худалдааны хэлцэл, худалдаачин, компани зэрэг үндсэн ойлголтуудыг хуульчилсан. Аж ахуйн нэгжийн гол зорилго ашиг олох учраас эдгээр ойлголтын хувьд мөн адил ашгийг урьтал болгодог. Иймд Худалдааны тухай хуулийн нэг онцлог бол ашгийн төлөө гэх шинжээр тодорхойлогддог<sup>25</sup>. Энэхүү ашгийн гэх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд олон тооны хэлцлийг богино хугацаанд хийх шаардлагатай. Тиймээс Худалдааны тухай хуульд хэлцэл байгуулах, түүнийг дуусгавар болгоход хялбаршуулсан зарчмыг баримталсан зохицуулалтыг хуульчилж өгсөн<sup>26</sup>.

Мөн худалдаа буюу хэлцлийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор худалдааны үйл ажиллагааны бүртгэл, компаний мэдээллийн тогтолцоо зэргийг уг хуулиар бий болгосон нь чухал ач холбогдолтой. Ингэснээр худалдааны талаарх чухал мэдээллийг олон нийтэд ил болгож, бусад этгээдийн хувьд таамаглах боломжгүй хохирол хүлээхээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг Худалдааны тухай хууль болон Компаний хуульд тусгасан байна<sup>27</sup>.

**Японы гадаад худалдааны асуудлыг** Гадаад валют болон гадаад худалдааны тухай хуулиар (Foreign Exchange and Foreign Trade Act) зохицуулна. Энэ хууль нь 1949 онд батлагдсан бөгөөд 9 бүлэгтэй.

- Хуулийн нэгдүгээр бүлэгт ерөнхий зүйл;
- Хоёрдугаар бүлэгт Японы энх тайван, аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийн талаар;
- Гуравдугаар бүлэгт төлбөрийн тухай;
- Дөрөвдүгээр бүлэг капиталын гүйлгээ (Capital Transactions);
- Тавдугаар бүлэг дотоодын шууд хөрөнгө оруулалтын талаар;
- Зургаадугаар бүлэг гадаад худалдааны талаар,
- Зургаагийн 2-р бүлэг тайлангуудын талаар;
- Долоодугаар бүлэг энэ хууль Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай хэрхэн холбогдох талаар;
- Долоогийн 2-р бүлэг давж заалдах тухай;
- Наймдугаар бүлэг бусад зүйлийн талаар;
- Есдүгээр бүлэг хууль зөрчсөн тохиолдолд ямар шийтгэл хүлээх талаар тус тус зохицуулна.

Худалдааны үйл ажиллагааг эдгээрээс гадна Компаний хууль, Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль, Дампуурлын тухай хууль, Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг.

а

<sup>25</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2135&re=02&vm=02>

Худалдааны тухай хуулийн 512, 513, 514 -р зүйл

<sup>26</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2135&re=02&vm=02>

Худалдааны тухай хуулийн 508, 509, 522, 524, 525, 566-р зүйл

<sup>27</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2135&re=02&vm=02>

Худалдааны тухай хуулийн 8-р зүйл,

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2456&vm=2&re=>

Компаний хуулийн 907-р зүйл, Компаний хуулийн 939-р зүйл



## **Худалдааны үйл ажиллагааны бүртгэл**

Худалдааны асуудлыг зохицуулахад Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль ([Commercial Registration Act](#)) чухал үүрэгтэй. Энэ хуулийн зорилго нь Худалдааны тухай хууль, Компаний тухай хууль болон холбогдох бусад хуулийн заалтад үндэслэн заавал бүртгүүлэх хүчин зүйлсийг ил болгоход холбоотой бүртгэлийн системийг хуульчилснаар аж ахуйн нэгжийн нэр, компани хоорондын итгэлцлийг хадгалах мөн худалдаа арилжаа аюулгүй бөгөөд саад бэрхшээлгүй явагдахад хувь нэмэр оруулах юм.

Үүнээс үзэхэд, Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн систем нь бүх төрлийн үйл ажиллагаа явуулж буй компани болон хувиараа аж ахуй эрхлэгчдийн худалдаа үйлчилгээ эрхлэхэд чухал шаардлагатай хүчин зүйлсийг Худалдааны үйл ажиллагааны бүртгэлд бүртгэж, нийтэд ил болгох зорилготой тогтолцоо болно. Японд аж ахуй эрхлэгчид нь компани болон хувь хүмүүс байдаг.

Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн гол үүрэг ил тод байх явдал бөгөөд энэ тогтолцоо нь ялангуяа, шинээр худалдаа явуулах гэж байгаа тохиолдолд нэн чухал үүрэгтэй. Хэрэв бүртгэлийн тогтолцоо байдаггүй бол компани болон хувь этгээдтэй худалдаа арилжаа хийх гэж буй этгээд нь тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй эсэх, төлөөлөн удирдагч нь хэн болох, хаана үйл ажиллагаа явуулдаг зэрэг мэдээллийг урьдчилан судлах боломжгүй байх ба үүнд их хэмжээний зардал, цаг хугацаа зарцуулах хэрэгтэй болно. Энэ нь худалдаа арилжааг шуурхай явуулахад хүндрэл үүсгэнэ. Иймээс японд худалдаа арилжааны аюулгүй болон түргэн шуурхай байдалд хувь нэмэр оруулах үүднээс худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн системийг бий болгосон юм.

Сүүлийн үед бүртгэлтэй холбоотой мэдээллийг цахим санд байршуулж, компаний бүртгэлийн мэдээллийг харах бололцоог сайжруулснаар өмнө байсан төвөг, чирэгдэлтэй асуудлууд багассан байна.

Худалдааны тухай хууль<sup>28</sup> болон Компаний тухай хуулийн<sup>29</sup> аль алинд итгэлцлийн зарчмыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: “Санаатай болон санамсаргүйгээр үнэн бус байдлыг бүртгүүлсэн этгээд тус бүртгэлийн үнэн бус гэдэг үндэслэлээр гэм буруугүй гуравдагч этгээдэд хандан шаардлага гаргах эрхгүй болно” хэмээн тусгасан. Энэ нь үнэн бус бүртгэлд итгэсэн гэм буруугүй гуравдагч этгээдийн эрхийг хамгаалсан заалт юм.

Японд Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль нь хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой процедурыг зохицуулсан бөгөөд бүртгэл хийгдэх хүчин зүйлсийг Худалдааны тухай хууль, Компаний тухай хууль, Дампуурлын тухай хуульд тус тус заасан байна.

### **Японы гадаад худалдааны талаарх зарим зохицуулалтууд<sup>30</sup>**

Японы Эдийн засаг, Худалдаа, Үйлдвэрийн Яам нь олон тооны агент, хороонуудаас бүрддэг. Тэдгээр нь эдийн засаг, үйлдвэр, худалдааны чиглэлээр өргөн хүрээний бодлого боловсруулж хэрэгжүүлдэг бөгөөд японы гадаад худалдаа болон хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ бизнесийн таатай орчин бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах ач холбогдолтой.

а

<sup>28</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2135&re=02&vm=02>  
Худалдааны тухай хуулийн 9.2

<sup>29</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2456&vm=2&re=>  
Компаний хуулийн 907-р зүйл, Компаний хуулийн 939-р зүйл

<sup>30</sup> <http://hong-kong-economy-research.hktdc.com/business-news/article/Small-Business-Resources/Trade-Regulations-of-Japan/sbr/en/1/1X000000/1X006N03.htm>  
Trade Regulations of Japan

## Худалдааны бодлого

Яамны харьяа Худалдааны бодлогын хороо нь газар зүйн бүс нутгийн асуудал хариуцсан, мөн худалдааны бүх түншүүдтэй талууд хоорондын худалдааны асуудлаар олон талт харилцаатай байх асуудлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий салбаруудаас тогтдог.

## Импортын зөвшөөрөл олгох

Ихэнх бараа бүтээгдэхүүний хувьд импортын зөвшөөрөл шаардлагагүй бөгөөд чөлөөтэй импортлогддог. Энэхүү зөвшөөрлийг аюултай материал, ан амьтан, ургамал, хурдан гэмтэж мууддаг бараа бүтээгдэхүүн, өндөр өртөгтэй зарим төрлийн худалдааны зүйл зэрэг зарим бараа бүтээгдэхүүнд олгоно. Мөн импортын квот бүхий зарим төрлийн загасан бүтээгдэхүүн, Озоны давхаргыг задлах бодисын тухай Монтреалын протоколд (*Montreal Protocol on Substances that Deplete the Ozone Layer*) заасан хяналт бүхий бодисуудын хувьд шаардлагатай.

## Импортын хориг ба хязгаарлалт

Япон Улс нь мансууруулах бодис, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хуурамч валют, порнограф, болон оюуны өмчийн хуулийг зөрчсөн бараа бүтээгдэхүүн импортлохыг хориглодог. Түүнээс гадна эмнэлэгийн зориулалттай бүтээгдэхүүн, эмийн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, химийн бодис зэрэг эрүүл мэндтэй холбоотой зарим бүтээгдэхүүний борлуулалт болон хэрэглээг хязгаарладаг.

Импортын зарим бараа бүтээгдэхүүн нь Япон Улсын үйлдвэрлэл, эдийн засаг, эрүүл ахуй, нийгмийн аюулгүй байдал, ёс суртахууны хувьд сөрөг нөлөөтэй байж болзошгүй. Ийм бараа бүтээгдэхүүнийг дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу "импортын хязгаарлалт"-д оруулдаг. Эдгээр бараа бүтээгдэхүүний хувьд импортын зөвшөөрөл авах, хяналт шалгалт болон бусад холбогдох шаардлагууд тавигддаг.

Хориглосон зүйлүүдэд зарим төрлийн хөдөө аж ахуйн болон махан бүтээгдэхүүн, ховордсон ургамал амьтан, олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хориг тавьсан зааны яс, амьтны эд зүйл, арьс үс, үслэг эдлэл, мөн хувийн хэрэгцээнд зориулсан 2 сараас дээш хугацаатай эм, гоо сайхны бүтээгдэхүүн хамаарна. Эдгээр бүтээгдэхүүний хувьд Японы гаалийн байгууллага нь Япон руу тээвэрлэхээс өмнө импортлох боломжтой эсэхийг хянаж үнэлдэг.

ATA Carnet буюу Олон Улсын Гаалийн бичиг баримтын дагуу арилжааны болон үзэсгэлэнгийн дээж, мэргэжлийн тоног төхөөрөмжийг татваргүй оруулна.

## Гаалийн тариф болон татварууд

Японы тариф дэлхийд хамгийн багад тооцогдох бөгөөд хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүний хувьд ойролцоогоор 2% байна. Япон Улс нь *Most-Favoured Nation* буюу улс төр, эдийн засгийн хувьд хамгийн тааламжтай үндэстэнд давуу эрх олгодог, мөн дараах шаардлагыг хангасан улс орон, бүс нутагт хөнгөлөлт үзүүлдэг. Үүнд:

- Олон Улсын Худалдааны байгууллагын гишүүн байх;
- Гаалийн тарифын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж Засгийн газрын шийдвэрээр зохицуулагдсан байх;
- Япон Улстай 2 талын гэрээ байгуулсан байх шаардлагатай.

Япон Улс нь ихэнх мэдээлэл технологийн бүтээгдэхүүнд тарифыг тэглэх талаар Дэлхийн Худалдааны байгууллагатай Мэдээлэл Технологийн гэрээнд (*WTO Information Technology Agreement*) гарын үсэг зурсан. Ихэнх бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнд гаалийн татвар, 8%-ийн хэрэглээний татвар ногдуулдаг. Хэрэглээний татварын хэмжээг 2019 оны 10-р сараас

10%-д хүргэхээр төлөвлөсөн байна. Архи, тамхины төрлийн бүтээгдэхүүнд нэмэгдэл татвар ногдуулдаг.

Хэдийгээр татварын хувь хэмжээ бага боловч гадаадын импортын бараа бүтээгдэхүүний хүндрэл, тухайлбал, япончуудын хувьд ойлгомжгүй ер бусын техник стандартууд, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний талаарх зохицуулалтууд, албан болон албан бус картел, соёлын болон хувийн харилцаанууд зэрэг зарим бэрхшээлтэй асуудлууд байнга гардаг.

### **Гаалийн шаардлага ба бичиг баримтууд**

Японд гаалийн бүрдүүлэлт хийхэд хэд хэдэн бичиг баримт шаардлагатай. Импортын (Гаалийн татвар төлөх) мэдүүлгийн маягт бөглөхөд гаалийн газарт дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө. Үүнд:

- нэхэмжлэл;
- ачааны зардлын тооцооны хуудас;
- гарал үүслийн гэрчилгээ;
- гаалийн хөнгөлөлттэй татварын нэгдсэн систем – Форм А;
- баглаа боодлын жагсаалт, ачааны бүртгэл тооцоо, даатгалын гэрчилгээ;
- гаалийн тухай хуулиас гадна бусад холбогдох хууль дүрэмд заасан зөвшөөрөл, гэрчилгээнүүд;
- гаалийн татвар, онцгой татвараас чөлөөлөх тухай нарийвчилсан мэдээлэл;
- гаалийн татвар төлөх хуудас зэрэг болно.

### **Хаяг шошго болон тэмдэглэгээнд тавигдах шаардлагууд**

Японы Хэмжилтийн тухай хуулиар (*Measurement Law*) импортын бүх бараа бүтээгдэхүүн, тэдгээрийн ачаа тээвэрлэлтийн баримт бичигт жин болон бусад хэмжигдэхүүний талаар заасан байх ёстой. Бөс бараа, ахуйн цахилгаан бараа болон тоног төхөөрөмж, хуванцар эдлэл, төрөл бүрийн гэр ахуйн болон хэрэглээний бараанууд нь хуульд заасны дагуу заавал хаяг шошготой байна. Ер нь ихэнх бараа бүтээгдэхүүн хаяг шошготой байх эсэх нь зөвхөн гаальд биш, тэдгээрийг худалдаалах үед зайлшгүй шаардлагатай.

Хаяг шошгон дээр тухайн улсын нэрийг худал эсвэл алдаатай бичих, далбааны оронд өөр улсынхыг оруулах, мөн үйлдвэрлэгчийн, эсвэл зохион бүтээгчийн нэр зэргийн гарал үүслийг худал мэдүүлж болохгүй.

### **Стандартууд**

Импортын бүтээгдэхүүнийг эхлээд туршиж шинжилж үздэг бөгөөд хууль дүрмэнд заасан стандартын дагуу гэрчилгээ олгогдоогүй тохиолдолд худалдаалахгүй. Стандартыг техник зохицуулалт буюу заавал дагаж мөрдөх стандарт, сайн дурын гэж ангилдаг. Импортын бараа бүтээгдэхүүнийг зохицуулдаг гол хуулиудыг нэрлэвэл:

- Ахуйн цахилгаан хэрэгсэл болон материалын аюулгүй байдлын тухай хууль (*Electrical Appliance and Material Safety Law*);
- Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль (*Consumer Product Safety Law*);
- Ахуйн хэрэглээний хийн тухай хууль (*Gas Utility Industry Law*);
- Хүнсний эрүүл ахуйн тухай хууль (*Food Sanitation Law*);
- Эмийн тухай хууль (*Pharmaceutical Affairs Law*);
- Зам тээврийн тухай хууль (*Road Vehicles Law*) зэрэг болно.
- Барилга байгууламжийн стандартын тухай хууль */Building Standard Law/*.

Японы Үйлдвэрлэлийн стандартын хороо нь стандарт тогтооход гол үүрэгтэй байдаг. Харин

Хөдөө аж ахуйн стандарт нь сайн дурынх боловч бүтээгдэхүүний чанар болон хаяг шошгонд өргөн хэрэглэгддэг. Энэхүү стандартыг уух ундны зүйл, боловсруулсан хүнс, ойн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, малын гаралтай бүтээгдэхүүн, өөх тос, загас агнуурын үйлдвэрлэлд дагаж мөрдөхөөс гадна, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын түүхий эд зэрэгт хэрэглэнэ.

## **2.4. БНХАУ-ЫН ТУРШЛАГА**

Хятад улс Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-д 2001 оны 12 сарын 11-нд гишүүнээр элссэн бөгөөд ДХБ-ыг байгуулсан Марракешийн гэрээний XII зүйлд заасан “нэгдсэн амлалт үүрэг авах дүрмийн” дагуу Олон талт худалдааны тогтолцоо (ОТХТ) гэх багц гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөх үүргийг мөн хүлээсэн байдаг. Үүний дараа худалдааны системээ либеральчилж нээлттэй худалдааны бодлого явуулахыг чухалчилжээ.

Тус улс худалдаа, аж үйлдвэрийн аливаа харилцааг 2004 оны “БНХАУ-ын Гадаад худалдааны тухай хууль”<sup>31</sup> (Foreign Trade Law of The People's Republic of China) “БНХАУ-ын Барааны импортын болон экспортын тухай хууль”<sup>32</sup> (Law of the People's Republic of China on Import and Export Commodity Inspection), 1992 оны “БНХАУ-ын Худалдааны холбооны тухай хууль” (Trade Union Law of the People's Republic of China) зэрэг бусад холбогдох хууль эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Үүнээс Гадаад худалдааны тухай хуулийн зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзлээ.

Гадаад худалдааны тухай хууль нь бараа, үйлчилгээний улс хоорондын хөдөлгөөнийг зохицуулсан, тухайлбал бүртгэл, гааль, чанарын шалгалт, стандарт, демпингийн эсрэг, татаас, хамгаалах арга хэмжээ, янз бүрийн үйлчилгээ, төрөл бүрийн оюуны өмчийн эрхүүд, шударга худалдааны дүрэм, гадаадын хөрөнгө оруулалтын тухай дүрэм зэрэг олон асуудалтай холбоотой олон төрөлжсөн хууль тогтоомжийн эх хууль юм. Тус хууль нь 11 бүлэг 68 зүйлтэй. Тухайлбал,

*I бүлэг. Ерөнхий заалтууд;*

*II бүлэг. Гадаад худалдаа эрхлэгчид;*

*III бүлэг. Бараа бүтээгдэхүүн, технологийн импорт, экспорт;*

*IV бүлэг. Олон улсын үйлчилгээний гадаад худалдаа;*

*V бүлэг. Худалдаатай холбоотой оюуны өмчийн эрхийн асуудлууд;*

*VI бүлэг. Гадаад худалдааны журам;*

*VII бүлэг. Гадаад худалдааны шалгалт;*

*VIII бүлэг. Гадаад худалдааны remedies (эмчилгээ, засах, залруулах);*

*IX бүлэг. Гадаад худалдааг дэмжих;*

*X бүлэг. Хууль зүйн хариуцлага;*

*XI бүлэг. Нэмэлт заалтууд.*

### **I бүлэг. Ерөнхий заалтууд**

1. Энэ хууль нь гадаад худалдааг хөгжүүлэх, гадаад харилцаанд хүрээгээ тэлэх, гадаад худалдааны дэг журмыг тогтоох, гадаад худалдаа эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, социалист зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

а\_\_\_\_\_

<sup>31</sup> <http://english.mofcom.gov.cn/article/policyrelease/internationalpolicy/200705/20070504715845.html> Foreign Trade Law of The People's Republic of China(2004)

<sup>32</sup> <http://english.mofcom.gov.cn/article/policyrelease/internationalpolicy/200703/20070304474577.shtml> Law of the People's Republic of China on Import and Export Commodity Inspection

2. Тус хууль нь гадаад худалдаа болон гадаад худалдаатай холбоотой оюуны өмчийн эрхийн тухай асуудлуудыг хамгаалахад хэрэглэгдэнэ. Энэхүү хуулийн хүрээнд гадаад худалдаа гэдэгт бараа бүтээгдэхүүний импорт, экспорт болон технологи, олон улсын худалдааг хэлнэ.
3. Хуульд заасны дагуу улсын гадаад худалдааг Төрийн зөвлөлд харьяалагдах Гадаад худалдааны яам (хэлтэс) хариуцна.
4. Улс нь гадаад худалдаа болон гадаад худалдааг хөгжүүлэхийг дэмжих, эрх тэгш чөлөөт гадаад худалдааны журмыг хадгалах нэгдсэн системтэй байна.
5. БНХАУ нь эрх тэгш харилцан ашигтай байх зарчмын дагуу бусад орон, бүс нутагтай худалдааны харилцааг дэмжин хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засаг, худалдааны аливаа тарифын гэрээ, хэлэлцээр болон чөлөөт худалдааны бүсийн гэрээ хэлэлцээр, бүс нутгийн эдийн засгийн байгууллагуудад нэгдэн орно.
6. Гадаад худалдааны талбарт БНХАУ-ын нэгдэн орсон, гарын үсэг зурсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн дагуу бусад хүлээн зөвшөөрсөн, нэгдэн орсон орнуудад харилцан ашигтай байх зарчмын дагуу хамгийн тааламжтай орон болон үндэсний хэмжээнд хандана.
7. Ямарваа нэг улс орон, бүс нутаг БНХАУ-ын худалдаанд хязгаарласан, ялгаварласан түүнтэй ижил төстэй арга хэмжээ авсан тохиолдолд БНХАУ бодит байдлыг харгалзан үзэж тухайн улс орон, бүс нутагт эсрэг арга хэмжээ авна.

## **II бүлэг Гадаад худалдаа эрхлэгчид**

8. Энэ хуульд заасны дагуу гадаад худалдаа эрхлэгчид гэдэг нь энэ хуулийн дагуу болон бусад холбогдох хууль, захиргааны журам зэргийн дагуу гадаад худалдаатай холбоотой үйлдвэрлэл, арилжаа болон бусад бүртгэлийг хийдэг хууль ёсны иргэд болон байгууллагууд, хувь хүнийг хэлнэ.
9. Бараа бүтээгдэхүүн болон технологийн импорт, экспорт хийх хүсэлтэй гадаад худалдаа эрхлэгч нь Төрийн зөвлөлийн харьяа Гадаад худалдааны яам (хэлтэс), эсвэл хуулийн дагуу зөвшөөрөгдсөн бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх ёстой. Бүртгэл хийх нарийн аргуудыг яамнаас боловсруулж гаргасан байх ёстой. Гадаад худалдаа эрхлэгч нь журмын дагуу бүртгүүлээгүй бол гаалийн байгууллага бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хяналт шалгалт, зөвшөөрлийг хийж өгөхгүй.
10. Гадаад худалдаа эрхлэн явуулагч, гадаад худалдааны үйлчилгээ үзүүлэгч нэгж, хувь хүмүүс энэ хуулийг дагаж мөрдөх ёстой. Гадаадын төсөлтэй гэрээ байгуулж, бусад улс оронтой хамтран ажиллах гэрээ байгуулсан нэгж нь тодорхой шалгуурыг хангасан байх ёстой. Тэдгээр шалгуурыг Төрийн зөвлөлөөс боловсруулсан байна.
11. Төрөөс тодорхой бараа бүтээгдэхүүний импорт, экспортыг хянаж болно. (Үүнийг төрийн зохицуулалттай худалдаа (арилжаа) гэнэ.) Ийм барааг зөвхөн эрх бүхий зөвшөөрөгдсөн энтерпрайз аж ахуйн нэгжүүдэд импортлох, экспортлох ба зөвшөөрөгдөөгүй аж ахуйн нэгжүүдэд төрийн зохицуулалттай арилжааны хүрээнд тодорхой заасан тоо хэмжээгээр экспорт, импортыг хийнэ. Төрийн зохицуулалттай бараа бүтээгдэхүүн, зөвшөөрөгдсөн аж ахуйн нэгжүүд нь Төрийн зөвлөлийн харьяа Гадаад худалдааны яамаар тогтоогдсон (зааж өгсөн) байна. Энэ бүлгийн эхний хэсэгт зааснаар экспорт, импортын зөвшөөрлийг аваагүй тохиолдолд гаалиас бүрдүүлэлт зөвшөөрөл өгөхгүй.
12. Гадаад худалдаа эрхлэгч нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг гадаад худалдаанд явуулахын тулд өөр этгээдийг итгэмжилж болно.



13. Гадаад худалдаа эрхлэгч нь энэ хуулийн дагуу мөн Төрийн зөвлөлийн харьяа Гадаад худалдааны яам болон бусад холбогдох яамдуудад өөрийн гадаад худалдааны үйл ажиллагаанд хамаарах бичиг баримт, мэдээллүүдийг өгч байх ёстой. Хүлээн авагч нь тухайн хүний (бичиг баримт бүрдүүлэгчийн) бизнесийн нууцыг чандлан хадгалах ёстой.

### **III бүлэг. Бараа бүтээгдэхүүн, технологийн импорт, экспорт**

14. Төр нь хууль тогтоомж, захиргааны журамд зааснаас бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүн, технологийн чөлөөт экспорт, импортыг зөвшөөрнө.
15. Гадаад худалдааны яам нь чөлөөт импорт, экспортыг хянах, автомат импорт экспортын лицензжүүлэх системийг хэрэгжүүлэхийн тулд каталог нийтэлж болно. Захиалагч болон хүлээн авагч нь гаалийн мэдүүлэгт орохоос өмнө автомат лицензжүүлэлтэд өргөдлөө өгч Гадаад худалдааны яам болон түүний бусад итгэмжлэгдсэн байгууллага шийдвэрийг гаргана.
16. Эдгээр шалтгаанаар улсаас импорт, экспортыг цуцлах болон хориглож болно.
- 1) Улсын аюулгүй байдал, нийтийн эрх ашиг болон үндэстнийг хамгаалахын төлөө хориглох шаардлагатай бол;
  - 2) Хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, ан амьтад ургамлын болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор;
  - 3) Алт, мөнгөний импорт, экспорттой авсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор;
  - 4) Дотоодын зах зээлийн нийлүүлэлтийн хомсдол мөн шавхагдах нөөцийг хамгаалах зорилгоор;
  - 5) Импортлож буй орон бүс нутгийн хязгаарлагдмал зах зээлийн чадамжаас шалтгаалан;
  - 6) Экспортын дэг журмын эмх замбараагүй ачаалалтай бол;
  - 7) Тодорхой нэг дотоодын үйлдвэрлэлийг хурдасгах, бий болгох зорилгоор;
  - 8) Хөдөө аж ахуй, ан агнуур, загасны бүтээгдэхүүнийг хамгаалах зорилгоор хориглох шаардлагатай бол;
  - 9) Улсын олон улсын санхүүгийн байр суурийг хадгалах, олон улсын орлого тооцооны тэнцвэрийг хадгалах зорилгоор;
  - 10) Бусад бараа бүтээгдэхүүний экспорт, импортыг хууль захиргааны журмаар хориглосон бол;
  - 11) Бусад бараа бүтээгдэхүүний экспорт импортыг БНХАУ-ын ямар нэг нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт хориглосон бол.

### **IV бүлэг. Олон улсын үйлчилгээний гадаад худалдаа**

Хуулийн энэхүү бүлэгт олон улсын үйлчилгээний гадаад худалдааны аливаа харилцааг зохицуулсан байна. Тухайлбал,

25. БНХАУ-ын гарын үсэг зурсан, нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу бусад нэгдэн орсон талуудын зах зээлд улсын хэмжээнд хүндэтгэн авч үзнэ.

26. Дараах шалтгаанаар улсаас олон улсын үйлчилгээний гадаад худалдааг цуцлах болон хориглоно. (16-р зүйлд заасан шалтгаануудтай ижил нөхцөлөөр.)

### **V бүлэг. Худалдаатай холбоотой оюуны өмчийн эрхийн асуудлууд**

Хуулийн 5-р бүлэгт зааснаар улс нь гадаад худалдаатай холбоотой аливаа оюуны өмчийн асуудлыг хууль, захиргааны журмын дагуу хамгаална. Оюуны өмчийн асуудалтай холбоотой импортын бараа бүтээгдэхүүн нь гадаад худалдааны дэг журмыг алдагдуулж буй тохиолдолд Гадаад худалдааны яамнаас тодорхой хугацаанд барааг үйлдвэрлэх, худалдаалахыг



хориглож болно.

## **VI бүлэг. Гадаад худалдааны журам**

Гадаад худалдааны аливаа үйл ажиллагаанд монопольчлолыг хууль, захиргааны журмын дагуу үл зөвшөөрнө. Гадаад худалдаанд ямар нэгэн монопольчлолын үйл ажиллагаа явуулж, шударга өрсөлдөөнд нөлөөлж байгаа тохиолдолд монополийн эсрэг хууль, захиргааны журмаар шийдвэрлэнэ.

Гадаад худалдааны үйл ажиллагаанд эдгээр үйлдэл байж болохгүй. Тухайлбал,

- 1) бараа бүтээгдэхүүний шошго тэмдэг болон гэрчилгээ, экспорт, импортын зөвшөөрөл гэрчилгээ зэргийг хуурамчаар үйлдэх;
- 2) экспортын татварын буцаан олголтыг залилан мэхлэх замаар олж авах;
- 3) хууль бусаар хил нэвтрүүлэх;
- 4) хууль тогтоомж, захиргааны журмын баталгаажуулалт, хяналт, хорио цээр зэргээс зайлсхийх;
- 5) хууль тогтоомж, захиргааны бусад журам актуудыг зөрчсөн.

## **VII бүлэг. Гадаад худалдааны шалгалт**

Гадаад худалдааны дэг журмыг хадгалахын тулд Гадаад худалдааны яам нь бусад холбогдох яамд газруудтай хамтран хууль захиргааны журмын дагуу шалгалт явуулж болно.

## **VIII бүлэг. Гадаад худалдааг залруулах нь**

Энэхүү бүлэгт татаас, демпингийн эсрэг болон саармагжуулах татвар, хамгаалах арга хэмжээний тухай дүрмүүдийг хамарсан байна. Тухайлбал,

40.Төр нь гадаад худалдааны хяналт шалтгалтаас олсон мэдээлэлдээ тулгуурлан гадаад худалдааг залруулахын тулд тодорхой арга хэмжээ авна.

41.Тухайн гадаад орны бараа бүтээгдэхүүн нь дотоодын зах зээлд хэвийн хэмжээнээс доогуур үнээр худалдаалагдаж, түүнээс шалтгаалан тухайн орон бүс нутгийн дотоодын үйлдвэрлэгчид хохирол учруулж байгаа тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авна.

42.Гадаад улсын бараа бүтээгдэхүүн гуравдагч оронд зах зээлийн үнээс хэт доогуур үнээр экспортлогдож байгаа болон дотоодод байгуулагдсан үйлдвэрт аюул учруулж байгаа тохиолдолд яам нь гуравдагч орны дотоодын үйлдвэртэй тохирох арга хэмжээ авахыг санал болгох, эсвэл хэлэлцэнэ.

44.Импортын бүтээгдэхүүний тоо хэмжээг ихээр нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэгчийг импортлогчтой шууд өрсөлдөөн бий болгож байгаа тохиолдолд төрөөс шаардлагатай хамгаалах арга хэмжээ авч, тодорхой дэмжлэг туслалцаа үзүүлж болно.

## **IX бүлэг. Гадаад худалдааг дэмжих нь**

51.Төрөөс гадаад худалдаа, механизм, гадаад худалдааг дэмжих стратеги боловсруулна.

52. Төр нь гадаад худалдааг дэмжихэд шаардлагатай хөгжлийн сан, эрсдэлийн санг бий болгоно.

53.Төр нь гадаад худалдааны экспорт, импортын татварын буцаан олголтыг хөгжүүлнэ.

54.Төр нь гадаад худалдааны нийтийн мэдээллийн үйлчилгээ явуулж, гадаад худалдаа эрхлэгчид болон мэдээллийн үйлчилгээ явуулна.

55.Төр нь гадаад худалдаа эрхлэгчдийг олон улсын зах зээлд гарахад дэмжих, гадаадын хөрөнгө оруулалт авах, гадаад оронд бүтээн байгуулалт хийх төслүүдийн гэрээ хэлэлцээр, гэрээт ажлын үйлчилгээний хамтын ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

#### **Х бүлэг. Хууль зүйн хариуцлага**

Хуулийн энэ бүлэгт гадаад худалдааны дүрэм, журмыг зөрчсөн аливаа харилцаанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан байна. Тухайлбал,

60. Гадаад худалдааны яам нь энтерпрайзыг 50,000 юань-с хэтрэхгүй мөнгөн торгууль оногдуулна.

#### **ХI бүлэг. Нэмэлт заалтууд**

67. Бусад хууль, захиргааны журамд цэргийн хангамжийн материалын гадаад худалдааны талаар өөрөөр заагаагүй тохиолдолд бусад холбогдох хуулиараа зохицуулагдана.

68. БНХАУ-тай хиллэдэг бүсүүд болон хөрш орнуудтай, хилийн иргэдэд уян хатан арга хэмжээ авна.

69. Энэ хууль нь БНХАУ-ын гаалийн нутаг дэвсгэрт хамаарахгүй.

70. Энэ хууль нь 2004 оны 7 сарын 1-с хэрэгжинэ.

### **2.5. БНСУ-ЫН ТУРШЛАГА**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь 1995 онд Дэлхийн Худалдааны байгууллагын гишүүнээр элссэн бөгөөд 1967 оноос Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт нэгдэж, түүнчлэн Бүсийн худалдааны хэлэлцээрүүд зэрэг дагалдах гэрээ хэлэлцээрүүдийг бусад улс орнуудтай байгуулан худалдааны салбарт хамтран ажилладаг байна. БНСУ-д худалдаа, үйлчилгээтэй холбогдох харилцааг “Худалдааны тухай” хууль (Commercial Act)<sup>33</sup>, “Худалдааны тухай хуулийг хэрэгжүүлэх журам” (Enforcement decree of the Commercial Act)<sup>34</sup>, “Гадаад худалдааны тухай” хууль (Foreign Trade Act)<sup>35</sup> “Гадаад худалдааны тухай хуулийг хэрэгжүүлэх журам” (Enforcement decree of the Foreign Trade Act)<sup>36</sup> болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

#### **2.5.1 “ХУДАЛДААНЫ ТУХАЙ” ХУУЛЬ**

“Худалдааны тухай” хууль нь 1962 онд батлагдаж, 1963 оноос хүчин төгөлдөр болсон бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэний дотор Олон Улсын Валютын сангийн дүрэмд нийцүүлэн томоохон өөрчлөлтүүд хийгдсэн байна.<sup>37</sup> Эдгээр өөрчлөлтүүд нь 1998 онд БНСУ-д болсон гадаад валютын хямралын үеэр хийгдсэн байна. Хяналтыг үр дүнтэй болгосноор компанийн удирдлагын хариуцлага болон ил тод байдлыг сайжруулах, бүтцийн өөрчлөлтийг дэмжихийг нэмж тусгасан байна. Компанийн захирлуудын үнэнч шударга байх тухай ухагдахууныг хуульд нэмэлтээр оруулж, хувьцаат компанийн захирлуудад хуулиар үүрэг оногдуулсан байна. Түүнчлэн компанийн захирлууд тодорхой нөхцөлд учирсан хохиролд хариуцлага хүлээнэ гэсэн нэмэлт оруулсан байна. Энэ нь захирлуудыг төлөөлөн ажиллаж буй менежерүүдийн хариуцлагыг нэмэгдүүлж, тэдэнд өөрийн хийсэн буруу үйлдэлдээ хариуцлага хүлээх үүргийг тодорхойлж өгсөн байна. Мөн түүнчлэн компанийн хувьцаа эзэмшигчдийн санал гаргах эрхийг баталгаажуулж өгчээ. Ингэснээр цөөн хувьцаа

а\_\_\_\_\_

<sup>33</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=37127&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37127&lang=ENG),

[https://en.wikisource.org/wiki/Translation:Commercial\\_Act\\_of\\_South\\_Korea#PART\\_I\\_GENERAL\\_PROVISIONS](https://en.wikisource.org/wiki/Translation:Commercial_Act_of_South_Korea#PART_I_GENERAL_PROVISIONS)

<sup>34</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=45095&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45095&lang=ENG)

<sup>35</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=37529&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37529&lang=ENG)

<sup>36</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46087&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46087&lang=ENG)

<sup>37</sup> [https://simple.wikipedia.org/wiki/Commercial\\_Act\\_of\\_South\\_Korea](https://simple.wikipedia.org/wiki/Commercial_Act_of_South_Korea)

эзэмшигчдийн нөхцөл байдал сайжирч, компанийн захирлуудын зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хурал дээр тодорхой асуудлуудыг санал болгох, хэлэлцүүлэх эрхийг баталгаажуулж өгсөн байна. Тус хууль нь 6 хэсэг, 37 бүлэг, 935 заалтаас бүрдэнэ. Тухайлбал,

- |                   |   |
|-------------------|---|
| <i>I хэсэг.</i>   | <i>Нийтлэг үндэслэл;</i>                  |
| <i>II хэсэг.</i>  | <i>Худалдаа, арилжааны үйл ажиллагаа;</i> |
| <i>III хэсэг.</i> | <i>Компани;</i>                           |
| <i>IV хэсэг.</i>  | <i>Даатгал;</i>                           |
| <i>V хэсэг.</i>   | <i>Далай, тэнгисийн худалдаа;</i>         |
| <i>VI хэсэг.</i>  | <i>Агаарын тээвэр.</i>                    |

Тус хуулийн 1 дүгээр хэсэгт худалдаа эрхлэгч, тэдэнд олгох зөвшөөрөл, бүртгэл, худалдааны ажилтнууд, тэдгээрийн эрх, үүрэг, худалдаа үйлчилгээний нэр, худалдаа үйлчилгээ эрхлэгч компаниудын ангилал, худалдаа эрхлэгчийн байнга хөтөлж байх шаардлага бүхий хөрөнгө, ашиг орлого болон алдагдлыг бүртгэх санхүүгийн бүртгэл зэрэгтэй холбоотой асуудлуудыг хуульчилсан байна.

Хуулийн 2 дугаар хэсэгт худалдааны үйл ажиллагааны төрлүүдийг тодорхойлсон байна.<sup>38</sup> Түүнчлэн худалдаа эрхлэгчдийн дундын данс, худалдаа эрхлэгчдийн хамтын холбоо, худалдааны байгууллагууд, брокер, комиссын байгууллага, тээврийн байгууллага, тээвэрлэх бизнес, үйлчилгээний бизнес, бараа бүтээгдэхүүн хадгалах, агуулах бизнес, санхүүгийн түрээсийн бизнес, үнэт цаасны худалдааны бизнес зэргийн талаар тодорхой зохицуулалтуудыг хийсэн байна.

Худалдааны үндсэн үйл ажиллагаанд:

- Хөдлөх, үл хөдлөх, үнэт цаас болон бусад хөрөнгийн худалдаа;
- Хөдлөх, үл хөдлөх, үнэт цаас болон бусад хөрөнгийн түрээс;
- Үйлдвэрлэл, боловсруулалт, засвар үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа;
- Цахилгаан, цахилгаан долгион, хий болон усан хангамжтай холбоотой үйл ажиллагаа;
- Ажил, үйлчилгээ туслан гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллах;
- Хэвлэн нийтлэх, зураг авахтай холбоотой үйл ажиллагаа;
- Мэдээлэл, холбоо, зар сурталчилгаатай холбоотой үйл ажиллагаа;
- Санхүүгийн гүйлгээтэй холбоотой үйл ажиллагаа;
- Брокертой холбоотой үйл ажиллагаа;
- Комиссын байгууллага болон бусад зуучлалын байгууллагуудтай холбоотой үйл ажиллагаа;
- Тээврийн үйл ажиллагаа;
- Худалдан авах ажиллагаа;
- Хамтарсан хадгаламжийн данс;
- Даатгал;
- Ашигт малтмал, хөрс, чулуу олборлохтой холбоотой үйл ажиллагаа;
- Машин техник болон бусад хөрөнгийн санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
- Худалдааны нэр, барааны тэмдэгтийг ашиглах зөвшөөрөлтэйгээр бизнес эрхлэх үйл ажиллагаа;
- Бизнесийн авлагаар худалдан авах болон нөхөн сэргээх гэх мэт үйл ажиллагаа зэрэг орно.

Хуулийн 3 дугаар хэсэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч компаниудын талаар тодорхой хуульчилсан байна. Компанийн дотоод болон гадаад харилцаа холбоо, компанийн гишүүнээр

а \_\_\_\_\_  
<sup>38</sup> [http://www.koreanlii.or.kr/w/index.php/Commercial\\_Act?ckattempt=1](http://www.koreanlii.or.kr/w/index.php/Commercial_Act?ckattempt=1)

элсүүлэх болон гишүүнээс эргүүлэн татах асуудал, компанийн удирдлага, зохион байгуулалт, компанийн хувьцаа, үнэт цаас, компанийг нэгтгэх, салбар компани байгуулах, компанийг тараах нөхцөл, компани дампуурах зэрэг асуудлуудыг хуульчилсан байна.

Худалдаа, үйлчилгээ эрхлэгч компаниудыг дотор нь:

- Хамтын нөхөрлөлийн компани;
- Хязгаарлагдмал хамтын нөхөрлөлийн компани;
- Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
- Хувьцаат компани;
- Хязгаарлагдмал компани;
- Гадаадын компани гэж ангилна.

Хуулийн 4 дүгээр хэсэгт даатгалын талаар холбогдох зохицуулалтуудыг хуульчилсан байна. Даатгуулагч, даатгалын бодлого, давхар болон хэсэгчилсэн даатгал, нөхөн төлбөр зэргийг тодорхой авч үзсэн байна. Даатгалыг дотор нь:

- Эд хөрөнгийн даатгал;
- Гал түймрийн даатгал;
- Тээврийн даатгал;
- Далай тэнгисийн аюул ослын даатгал;
- Хариуцлагын даатгал;
- Авто машины даатгал;
- Хариуцагчийн даатгал;
- Хувийн даатгал;
- Ослын даатгал гэж ангилна.

Хуулийн 5 дугаар хэсэгт Далай тэнгисийн худалдааны талаар холбогдох харилцааг хуульчилсан бөгөөд 6 дугаар хэсэгт Агаарын тээвэртэй холбогдон гарах харилцааг зохицуулсан байна. Тээвэр, иргэний тээвэр, бараа, бүтээгдэхүүний тээвэр, тээврийн ослын хариуцлага, агаарын замын хуудас зэрэгтэй холбогдон гарах харилцааг зохицуулсан байна.

## 2.5.2. “ГАДААД ХУДАЛДААНЫ ТУХАЙ” ХУУЛЬ

“Гадаад худалдааны тухай” хууль нь 1986 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийгдсэн байна. Энэ хуулийн зорилго нь гадаад худалдааг дэмжин, шударга худалдааны тогтолцоог бий болгон, олон улсын төлбөрийн тэнцвэрийг тогтворжуулж, худалдаа, үйлчилгээг өргөжүүлснээр улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино. Худалдаа гэдэгт экспорт, импортын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ болон биет бус буюу цахим бараа, бүтээгдэхүүнийг хамруулж ойлгоно. Тус хууль нь 6 бүлэг, 59 заалтаас бүрдэнэ. Тухайлбал,

<i>I бүлэг</i>	<i>Нийтлэг үндэслэл;</i>
<i>II бүлэг</i>	<i>Худалдаа, үйлчилгээг дэмжих тухай;</i>
<i>III бүлэг</i>	<i>Экспорт ба импорт;</i>
<i>IV бүлэг</i>	<i>Импортын бүтээгдэхүүний тоо хэмжээний хязгаар;</i>
<i>V бүлэг</i>	<i>Экспорт ба импортын бүтээгдэхүүний зохицуулалт;</i>
<i>VI бүлэг</i>	<i>Нэмэлт заалтууд.</i>

Тус хуулийн 1 дүгээр бүлэгт гадаад худалдаа нь БНСУ-ын “Үндсэн хууль” болон олон улсын хууль, дүрэм журамд нийцүүлэн баталсан чөлөөт болон шударга худалдааны зарчмын үндсэн дээр явагдах ёстой гэж заажээ. Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайд нь экспорт болон импортын бараа бүтээгдэхүүнийг тасралтгүй нэмэгдүүлэх бодлогыг баримтлах шаардлагатай

бөгөөд үүний тулд худалдаа, үйлчилгээний салбарт зөвлөх үйлчилгээ, гадаад сурталчилгаа, үзэсгэлэн яармаг, сургалт, бизнес уулзалт зэрэг үйл ажиллагаа эрхлэн явуулдаг хүмүүсийг дэмжин ажиллах шаардлагатай байна. Барааны экспорт, импортыг хязгаарлах, хориглох тохиолдлуудыг мөн энэ бүлэгт хуульчилсан байна. Үүнд;

- БНСУ-д буюу худалдааны түнш оронд дайн, үймээн самуун дэгдсэн, эсхүл байгалийн гамшиг тохиосон бол;
- Худалдааны түнш орон нь гэрээнд зааснаар болон олон улсын хууль, дүрмийн дагуу БНСУ-ын эрх ашиг, сонирхолыг хүндэтгэн үзээгүй тохиолдолд;
- Худалдааны түнш орон нь БНСУ-ын худалдаанд шударга бус хязгаарлалт хийж, дарамт шахалт үзүүлсэн бол;
- Олон улсын энхтайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүргээ хэрэгжүүлэх шаардлага гарсан тохиолдолд;
- Хүмүүс болон амьтан, ургамлын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хадгалах, хамгаалах болон хүрээлэн буй орчин, байгалийн баялгийг хадгалах, хамгаалах шаардлагатай тохиолдолд гэж заажээ.

Хуулийн 2 дугаар бүлэгт Худалдаа, үйлчилгээг дэмжих бодлогын талаар хуульчилсан бөгөөд Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайд жил бүр ирэх жил хэрэгжүүлэх бодлогыг баталдаг байна. Худалдаа, үйлчилгээг дэмжих бодлогыг батлахдаа олон улсын худалдааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын төлөв байдлыг тодорхойлох, гадаад дахь корпорациудын үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон худалдаа, үйлчилгээтэй холбоотой гэрээ, хэлэлцээрийг дэмжин ажиллах, гадаад дахь зах зээлээ өргөжүүлэх, зөвлөх болон зааварчлах үйлчилгээ үзүүлэх, дотооддоо болон гадаадад түүхий эдийг ханган нийлүүлэх хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээг авах зэрэг асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай байна.

Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайд нь худалдаа үйлчилгээг дэмжих бодлого боловсруулахдаа гадаадад бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Солонгосын компаниудаас мэдээлэл хүсч, шаардлагатай тохиолдолд дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж болох юм гэжээ. Бодлого боловсруулахдаа аймаг, хотын засаг дарга нарын саналыг харгалзаж, бодлогодоо тусгах нь зүйтэй байна. Худалдааг дэмжих бодлого боловсруулсны дараа аймаг, хотын засаг дарга нар нь өөрийн хариуцаж буй орон нутаг, бүсийн хэмжээнд тохирсон, нарийвчилсан худалдааны бодлогыг боловсруулах шаардлагатай байдаг байна. Худалдааны байгууллагуудтай хамтран хувийн секторуудыг гадаад зах зээлээ хөгжүүлэхэд нь дэмжин ажиллах талаар хуульчилжээ. Гадаад худалдааг өргөжүүлэх төв буюу Солонгосын Худалдаа-Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийг хуулийн дагуу байгуулж Солонгосын корпорациудын гадаад дахь үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, удирдамж, судалгаа зэргийг гүйцэтгэн, дэмжин ажиллах талаар заасан байна. Экспортын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжин, бараа бүтээгдэхүүнийг нь экспортлоход туслах мэргэшсэн худалдааны компанийг тодорхойлох, дэмжих талаар мөн хуульчилсан байна.

Хуулийн 3 дугаар бүлэгт экспорт, импортод тавигдах зарчим, хязгаарлах нөхцөлүүд, түүхий эд болон машин, тоног төхөөрөмжийг импортлох зөвшөөрөл, тэдгээрийн тоо хэмжээ, стратегийн ач холбогдол бүхий зүйлсийн экспорт болон импорт, түүний зөвшөөрөл, стратегийн ач холбогдол бүхий зүйлсийн ангилал, стратегийн бус өндөр ач холбогдол бүхий бараа материал, түүний зөвшөөрөл, импортлож буй бараа бүтээгдэхүүний зорилгыг баталгаажуулсан бичиг, стратегийн ач холбогдол бүхий зүйлсийн тээвэрлэлтийг зогсоох нөхцөл, зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөлүүд, Стратегийн ач холбогдол бүхий зүйлсийн экспорт, импортыг хянах зөвлөл, Засгийн газар хоорондын экспортын гэрээ зэргийг хуульчилжээ. Импортоор оруулж ирсэн түүхий эд, тоног төхөөрөмжийг зайлшгүй шаардлагаар анх оруулж ирсэн зорилгоосоо өөрөөр ашиглах тохиолдолд Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайдын зөвшөөрлийг авах шаардлагатай байдаг байна. Бараа материалыг



худалдаалж буй хүн бүр, үүн дотор технологи дамжуулж, зөөвөрлөж буй этгээд нь тухайн зөөвөрлөж буй технологи стратегийн, эсхүл стратегийн бус эсэхийг тодорхойлсон тодорхойлолтыг авах ёстой бөгөөд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байна.

Хуулийн 4 дүгээр бүлэгт импортын барааны тоо хэмжээнд хязгаарлалт тавих, тавьсан хязгаарлалтыг үргэлжлүүлэх нөхцөл, хугацааны талаарх зохицуулалтыг хийсэн байна. Тодорхой импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт хэтэрснээс тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрлэгчид зах зээлээ алдах, хохирох, алдагдалд орох нөхцөл үүссэн тохиолдолд дотоодын үйлдвэрлэлээ сэргээх зорилгоор тухайн төрлийн импортын барааны тоо хэмжээнд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийх бөгөөд хязгаарлалтын хугацааг 8 хүртэлх жилээр сунгаж болно гэж заажээ.

Хуулийн 5 дугаар бүлэгт худалдаа эрхлэгч экспорт, импортын барааг өөрийн дураар үнэлэхийг хориглох, дотоодын худалдаа эрхлэгчдийн хооронд болон дотоод, гадаадын худалдаа эрхлэгчдийн (худалдааны түнш орны худалдаа эрхлэгч) хооронд гарсан маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн өмнөх үзлэгийн зөвшөөрлийн дагуу экспортын бараа бүтээгдэхүүний үзлэгтэй холбогдон гарсан маргааныг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтуудыг хуульчилсан байна.

## **2.6. БНЧУ-ЫН ТУРШЛАГА**

### **Бүгд Найрамдах Чех Улсын Худалдааны тухай хууль (Commercial code) No. 513/1991<sup>39</sup>**

Бүгд Найрамдах Чех улсын Худалдааны тухай хууль нь 1991 онд батлагдан, 1992 оноос мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 1992-2000 оны хооронд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж, 2000 онд Европын холбооны хууль тогтоомжтой нийцүүлэх үүднээс хамгийн өргөн хүрээтэй томоохон өөрчлөлтүүдийг оруулж, нилээд хэдэн зүйл, заалтыг хүчингүй болгосон байна. Тус хуулиар урьд хүчин төгөлдөр үйлчилж байсан Эдийн засгийн тухай, Эдийн засгийн төлөвлөлтийн тухай, Хувьцаат компанийн тухай, Гадаад худалдааны тухай зэрэг хэд хэдэн хуулиудыг хүчингүйд тооцож, тус хуулиудаар зохицуулж байсан харилцааг нэгтгэн зохицуулах болсон байна.

Энэ хуулиар бизнес эрхлэх ерөнхий нөхцөлүүд, Бүгд Найрамдах Чех улсын болон гадаадын иргэдийн бизнес, компанийн бүтэц, төрлүүд, бизнесийн олон төрлийн гэрээний асуудлыг зохицуулж, тус хуулиар зохицуулаагүй бусад асуудлуудыг Иргэний хуулиар зохицуулахаар заасан байна. Худалдааны хууль нь 4 хэсэг, 10 бүлэг бүхий 775 зүйлтэй.

#### **1 дүгээр хэсэг. Ерөнхий зохицуулалт**

- 1 дүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл;
- 2 дугаар бүлэг. Гадаадын бизнесийн үйл ажиллагаа;
- 3 дугаар бүлэг. Худалдааны бүртгэл;
- 4 дүгээр бүлэг. Бизнесийн нягтлан бодох бүртгэл;
- 5 дугаар бүлэг. Эдийн засгийн өрсөлдөөн;

#### **2 дугаар хэсэг. Бизнесийн компани, нөхөрлөл, хоршоо**

- 1 дүгээр бүлэг. Бизнесийн компаниуд болон нөхөрлөл;
- 2 дугаар бүлэг. Хоршоо;

а \_\_\_\_\_

<sup>39</sup> (Commercial code) No. 513/1991, [http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file\\_id=198074#LinkTarget\\_639](http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=198074#LinkTarget_639)



### **3 дугаар хэсэг. Бизнесийн үүрэг, хариуцлага**

1 дүгээр бүлэг. Үндсэн нөхцөл;

2 дугаар бүлэг. Зарим бизнесийн гэрээний үүргийн тусгай заалтууд;

3 дугаар бүлэг. Олон улсын худалдааны гэрээний үүргийн тусгай заалтууд;

### **4 дүгээр хэсэг. Төгсгөлийн заалтууд**

Мөн Бүгд Найрамдах Чех улс нь 2004 онд Европын Холбооны гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орнууд нь Европын Холбооны гадаад худалдааны нийтлэг бодлого, арга хэмжээнүүдийг дагаж мөрддөг.

Нэгдүгээр хэсэгт тус хуулийн үйлчлэх хүрээг бизнес эрхлэгчдийн эрх зүйн байдал, бизнесийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүрэг болон бизнесийн үйл ажиллагаатай холбогдох бусад асуудлыг зохицуулахаар тодорхойлсон бөгөөд тус хуулиар зохицуулаагүй асуудлыг Иргэний хууль тогтоомжоор зохицуулахаар заажээ.

Бизнес гэж ашиг олох зорилгоор бие даан өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээдэг системтэй үйл ажиллагаа гэж тодорхойлоод тус хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийг компани, худалдааны тусгай зөвшөөрөл бүхий этгээд, бусад хууль тогтоомжоор худалдааны тусгай зөвшөөрлөөс бусад эрх олгогдсоны дагуу бизнес эрхэлж буй этгээд, холбогдох хуулийн дагуу хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн гэж тодорхойлсон байна. Тус хэсгийн 1-р бүлэгт бизнес эрхлэх, бизнесийн нэр, бизнесийн хөрөнгө, бизнесийн нууц зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Хоёрдугаар бүлэгт тус улсад оршин суудаггүй болон гадаадад бүртгэлтэй иргэд хуулийн этгээдээс явуулах бизнесийн үйл ажиллагаа, тэдний хөрөнгийг хамгаалах, гадаадаас тус улсад бизнесийн үйл ажиллагааг шилжүүлэн ирүүлэх /компанийн бүртгэл/, тэдний эрх үүргийн байдал зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Гуравдугаар бүлгээр бизнес эрхлэгчдийн бүртгэлтэй холбогдох асуудлуудыг, Дөрөвдүгээр бүлэгт бизнесийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлтэй холбогдох асуудлуудыг зохицуулжээ.

Тавдугаар бүлэгт эдийн засгийн өрсөлдөөний асуудал буюу шударга бус өрсөлдөөн, хээл хахууль, хуурамч төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, бизнесийн нууц задруулах, худал мэдээлэл тараах, бараа бүтээгдэхүүний бодит мэдээлэлтэй холбогдох асуудлууд багтсан байна.

Хуулийн хоёрдугаар хэсгийн бүлэг, дэд бүлгүүдэд компани, тэдгээрийг үүсгэн байгуулах, өөрийн хөрөнгө, нөөц, хөрөнгө, хөрөнгө оруулах, хувьцаа, түүний төрөл, компанийг татан буулгах, өөрчлөн байгуулах, компанийн төрлүүд, гишүүдийн эрх үүрэг, компанийн удирдлага, эрх барих байгууллага, тэдгээрийн эрх үүрэг, шийдвэр гаргах, хүчингүй болгох, хувьцаа эзэмшигчдээс гомдол гаргах, ногдол ашиг, компанид хохирол учруулах, аудит, санхүүгийн тайлан зэрэг асуудлуудыг компанийн төрөл тус бүрээр нарийвчлан зохицуулж өгсөн байна.

Хуулийн 3-р хэсгээр бизнесийн үүрэг хариуцлагын асуудлыг зохицуулсан бөгөөд нэгдүгээр бүлэгт бизнес эрхлэх явц дахь гэрээний ерөнхий нөхцөлүүд, гэрээ байгуулах, гэрээний хэлбэр, гэрээний санал гаргах, тендер зарлах, банкны баталгаа гаргах, үүрэг гүйцэтгэх, гэрээнээс гарах, татгалзах, гэрээний үүргийг зөрчих, түүний үр дагавар, хор уршиг учруулах зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Энэ хуулиар төрөл бүрийн гэрээний нарийвчилсан зохицуулалтуудыг хийж өгсөн бөгөөд Худалдааны хуулиар зохицуулагдаагүй гэрээг Иргэний хуулиар зохицуулахаар тусгасан байна. Хоёрдугаар бүлгээр тодорхой гэрээний төрлүүдэд тавигдах тусгай шаардлагыг тогтоож

өгсөн байна. Тухайлбал, худалдах, худалдан авах гэрээ, худалдагч, худалдан авагчийн эрх, үүрэг, барааг хүргэх, барааны мэдээлэл, чанар, тоо хэмжээ, барааны дагалдах бичиг баримт, барааны доголдол, чанарын баталгаа, барааны доголдолд гомдол гаргах, барааны шошго, таних тэмдэг, барааг хадгалах, бараа устгах, гэмтэхтэй холбогдох асуудлыг зохицуулж өгсөн байна. Мөн бизнес буюу компанийг худалдах буюу шилжүүлэн өгөх, түрээслүүлэх, түрээсийн гэрээний зүйлийг худалдан авах, зээлийн болон хадгаламж, хадгалалт, зуучлал, хяналт, шинжилгээ үнэлгээний гэрээ, тээвэрлэлт, илгээмжийн гэрээ, худалдааны төлөөлөгчийн гэрээ, хөрөнгө оруулалтын, банкны баталгааны гэрээ, банкны хадгаламжийн гэрээний асуудлыг тус тус зохицуулсан байна.

Хуулийн гуравдугаар бүлгээр олон улсын худалдааны гэрээний асуудлыг зохицуулсан байна. Хуульд зааснаар гэрээний нэг тал нь гадаад улсын иргэн, эсхүл гадаадад бүртгэлтэй компани бөгөөд хэрэв талууд тохиролцсон бол тус хуулийн зохицуулалтыг хэрэглэхээр заасан байна. Мөн тус бүлэгт гэрээний агуулгад харшлаагүй бол гадаад худалдааны гэрээнд тухайн төрлийн худалдаанд тогтсон заншлын хэм, хэмжээг хүндэтгэн үзэж, анхаарах ёстой болохыг заажээ.

Талууд нь тухайн гэрээг байгуулахдаа экспорт, импортын болон дамжин өнгөрөх тусгай зөвшөөрөл зэрэг шаардлагатай зөвшөөрлийг олж авсан эрх бүхий этгээд байх бөгөөд зөвшөөрөлтэй холбогдох шалтгаанаар гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд нөгөө талд учруулсан хохирлыг арилгах үүрэгтэй байна.

Талууд гэрээгээр тохиролцсон валютаар үүргээ гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд өөр төрлийн валютаар гүйцэтгэснээс учирсан алдагдлыг нөхөн төлөх үүрэгтэй байдаг байна. Хуульд тухайн гэрээнд олон улсын худалдааны заншлын хэм, хэмжээг хэрэглэж болохоор заасан бол барааны үнэ, төлбөрийн асуудалд тухайн хэм, хэмжээг анхааран авч хэлэлцэх үүрэгтэй гэж заасан байна. Валютаар гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлээгүй буюу тухайн үүргийг хүчингүй болгосон нөхцөлд тухайн үүргээ биелүүлээгүй талын оршин суух улс дахь арилжааны банкны зээлийн хүүгээс нэг хувиар илүү хэмжээгээр хүү бодож нөгөө талдаа төлөх үүрэгтэй байхаар зохицуулжээ.

Худалдан авагч нь худалдагч талын зөвшөөрөлгүйгээр гэрээгээр тохиролцсон нутаг дэвсгэрээс бусад газарт барааг дахин экспортлосон тохиолдолд түүнтэй холбоотойгоор худалдагч талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй байна. Худалдагч талаас тухайн барааг дахин экспортлоогүй болохыг нотлохыг шаардсан нөхцөлд худалдан авагч нь тухайн барааг байрлах газрыг, эсхүл ямар хэмжээгээр борлуулагдсан байгааг үзүүлж нотлох үүрэгтэй.

Дахин экспортлохыг хориглосон газрын тухайд маргаантай байгаа нөхцөлд худалдагч талаас барааг илгээсэн орон буюу худалдан авагч талын албан ёсны бүртгэлтэй газрыг тухайн экспортыг зөвшөөрөх газар нутгаар тооцно.

Тус бүлэгт худалдааны хязгаарлалтын талаар мөн тусгаж өгсөн байна. Худалдагч тал нь тодорхой барааг тодорхой нутаг дэвсгэрт тодорхой хүрээний хэрэглэгчдэд, эсхүл тодорхой барааг тодорхой хэмжээгээр гэрээнд заасан нөхцөлийн дагуу худалдах, эсхүл худалдахгүй байж болно. Тус гэрээг хугацаа зааж заавал бичгээр байгуулсан байхаар тусгасан байна. Бараа бүтээгдэхүүнийг нийлүүлснээс хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн, эсхүл худалдан авагч тал нь гэрээний үүргээ зөрчсөн бол дээрх гэрээний заалтыг мөрдөхгүй байж болно.

Талууд гэрээний үүргийг гүйцэтгэх валютыг өөр тодорхой нэг валюттай хөрвүүлэхэд тодорхой түвшинд байлгахгаар тохиролцсон бол хоёр валютын солилцооны ханш өөрчлөгдвөл хариуцагч тал нь өөрчлөгдсөн хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй байдаг байна.

Онцгой худалдааны гэрээг талууд байгуулж болно. Тус гэрээгээр худалдагч тал нь худалдан авагч талаас бусад этгээд, газар нутагт гэрээгээр тохиролцсон барааг нийлүүлэхгүй байх

үүрэгтэй. Тус гэрээг бичгээр байгуулаагүй, эсхүл барааны нэр төрөл, газар нутгийг тодорхойлж өгөөгүй бол хүчингүй байна. Тус гэрээ нь нийлүүлэгч талын бараа бүтээгдэхүүнээ олон нийтэд танилцуулах, сурталчлах, зах зээлийн судалгааны ажил явуулах эрхийг хязгаарлахыг хориглоно. Гэрээг хугацаагүй байгуулсан бол гэрээ байгуулснаас хойш нэг жилийн дараа дуусгавар болно. Худалдан авагч тал нь бараа бүтээгдэхүүнийг өөр бусад этгээдээс худалдан авсан тохиолдолд нийлүүлэгч нь мөн гэрээг цуцлах эрхтэй байдаг байна.

Тус хэсгийн 4-р бүлэгт хууль хүчин төгөлдөр болох зэрэг бусад асуудлыг зохицуулжээ.

Чех улс нь 1991 онд Худалдааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг<sup>40</sup> (The Trade Licensing Act No.455/1991/) баталсан бөгөөд тусгай зөвшөөрөлтэйгээр худалдаа эрхлэх асуудлыг зохицуулсан 81 зүйл бүхий хууль байна. 140/2014 тоот хуулиар 2014 онд томоохон нэмэлт өөрчлөлт оруулж, 2015 оноос эхлэн даган мөрдөж байна. БНЧУ-ын Үйлдвэр худалдааны яамнаас боловсруулсан худалдааны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь бизнес эрхлэгчдэд учирдаг захиргааны дарамтыг багасгахад чиглэгдэж мөн худалдааны бүртгэлийн системд орсон, хадгалагдаж буй бизнес эрхлэгчдийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалахын тулд нээлттэй мэдээлэлд оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг хийж өгсөн байна.

### **Хуулийн бүтэц:**

#### **1 дүгээр хэсэг. Нийтлэг үндэслэл**

- Худалдаа, худалдаа хийх;
- Худалдаа эрхлэх эрхтэй аж ахуйн нэгж;
- Худалдаа хийх ерөнхий нөхцөл;
- Худалдааны онцгой нөхцөл;
- Худалдааны ангилал;
- Худалдааны зөвшөөрөл;
- Хариуцлагатай төлөөлөгчөөр дамжуулан худалдаа хийх;

#### **2 дугаар хэсэг. Худалдааны ангилал**

- Зөвшөөрөлтэй худалдаа;
- Бүртгэвэл зохих худалдаа;

#### **3 дугаар хэсэг. Худалдааны зөвшөөрлийн хамрах хүрээ**

- Бизнес эрхлэгчийн үүрэг хариуцлага;
- Зөвшөөрлийн хамрах хүрээ;

#### **4 дүгээр хэсэг. Худалдааны зөвшөөрлийн бүртгэл, худалдааны зөвшөөрөл олгох, өөрчлөх, цуцлах**

- Худалдааны зөвшөөрлийн бүртгэл;
- Худалдааны зөвшөөрөл дуусгавар болох, цуцлах;
- Концессийн үйл ажиллагаа;

#### **5 дугаар хэсэг. Худалдааны хяналт, шалгалт**

- Худалдааны хяналт;
- Зөрчил;

а\_\_\_\_\_

<sup>40</sup> The Trade Licensing Act No.455/1991/, <https://www.mpo.cz/en/business/licensed-trades/legislation/trade-licensing-act--172390/>

## **6 дугаар хэсэг. Ерөнхий, шилжилтийн болон төгсгөлийн заалтууд**

Худалдааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар худалдаа эрхлэх эрх бүхий хувь хүн хуулийн этгээд хэн байх, худалдаа эрхлэгчийн эрх үүрэг, худалдаа хийхэд тавигдах шаардлага, худалдаа эрхлэх ерөнхий нөхцөл, тусгай худалдаа, худалдааны ангилал, тусгай зөвшөөрөл, худалдааны зөвшөөрөл авах, бүртгэх, хадгалах, хүчингүй болгох, цуцлах зэргээс гадна худалдааны хяналт шалгалт, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлуудыг нарийвчлан зохицуулсан байна.

Хуулийн 2 дугаар зүйлээр “Худалдаа” гэдгийг ашиг олох зорилгоор өөрийн нэрээр гүйцэтгэж, өөрийн биеэр хариуцлага хүлээдэг цогц үйл ажиллагаа гэж томъёолоод дараах зүйлсийг худалдаанд тооцохгүй байхаар заажээ. Үүнд:

- Хуулиар хамгаалагдсан оюуны бүтээлийн хэрэглээ, ашиглалт
- Хуулиар олгогдсон зохиогчийн эрхийн болон түүнтэй холбогдох бусад эрх
- Урлагийн хүрээнд түүх соёлын дурсгалт зүйлсийг нөхөн сэргээх үйл ажиллагаа
- Төрийн болон тодорхой хуулийн этгээдэд зориулан гүйцэтгэх үйл ажиллагаа
- Археологийн судалгаа шинжилгээтэй холбогдох үйл ажиллагаа

Мөн хувь хүний зүгээс хийж гүйцэтгэж байгаа дараах ажил үйлчилгээг худалдаанд тооцохгүй байна. Үүнд:

- Хуульч, өмгөөлөгч нотариат;
- Аудитор татварын зөвлөх үйлчилгээ;
- Шинжээч, хэлмэрч;
- Зуучлагч, арбитрч;
- Мал эмнэлгийн ажилтан, малын үржилтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмч, шүдний эмч, эм зүйч, эм ханган нийлүүлэх ажилтан;
- Албан ёсны лицензтэй судлаач;
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцож буй архитектор, эрх бүхий инженерүүд;
- Чөлөөт архитектор, чөлөөт инженер;
- Эрх бүхий хянан шалгагч, байцаагч;
- Замын аюулгүй байдлын аудитор.

Мөн хуулиар банкны үйл ажиллагаа, электрон мөнгө олгох үйл ажиллагаа, валют арилжааны үйл ажиллагаа, даатгал, аюулгүй байдлын сан, даатгалын зуучлагч, тэтгэврийн компаниуд, тарих, үржүүлэх, далайн тээвэрлэлт ба далайн загасчлал зэрэг 50 гаруй нэр төрлийн ажил үйлчилгээг худалдааны үйл ажиллагаанд хамруулан үзэхгүй байхаар хуульчилжээ.

Хуульд зааснаар худалдааны үйл ажиллагаа эрхлэх хувь хүнд тавигдах ерөнхий шаардлагад эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд зан харьцааны хувьд эерэг байхаар тогтоож өгсөн байна. Санаатай гэмт хэрэг үйлдсэн бөгөөд үйлдсэн гэмт хэрэг нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байсан бол зан харьцааны хувьд эерэг гэж үнэлэх боломжгүй гэж тодорхойлжээ. Худалдааны зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дээрх шаардлагыг холбогдох хуулийн байгууллагуудын лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн тогтоодог байна.

Худалдааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах тусгай шаардлага гэдэгт мэргэжлийн болон бусад хуулиар тогтоосон шаардлагыг хамруулахаар заасан байна. Мэргэжлийн холбогдолтой шаардлагад өөрчлөлт орсон тохиолдолд худалдаа эрхлэгч холбогдох сертификат бичиг баримтаар нотлох үүрэгтэй бөгөөд шаардлагатай бол холбогдох мэргэжлийн ур чадвар тогтоох байгууллагын тусламжийг авч болно.

Худалдаа эрхлэхэд тавигдах мэргэжлийн шаардлагыг хангаж буй эсэхийг Чех Улсад болон Европын Холбооны улсуудад тодорхой салбарт ажилласан жилээс нь хамааран харилцан адилгүй байхаар хуульд тусгасан байна.

Хуульд зааснаар худалдааг тодорхой шаардлага хангаж, бүртгүүлсний дүнд хийгдэж болох бүртгэвэл зохих худалдаа, харилцан тохиролцооноор хийгдэж болох зөвшөөрөгдсөн худалдаа гэж 2 ангилдаг байна. Бүртгэвэл зохих худалдаанд тус хуулийн 21, 22 дугаар зүйлийн шаардлагыг хангасан хуулийн 1, 2 дугаар хавсралтад дурьдаж заасан худалдааг хамруулдаг байна.

Хуульд зааснаар мэргэжлийн худалдаа эрхлэхэд худалдаа эрхлэгч нь тухайн мэргэжлийн шаардлагыг ерөнхий боловсролын гэрчилгээ, дээд боловсролын гэрчилгээ, мэргэжлийн боловсролын гэрчилгээ зэрэг бичиг баримтаар нотолно. Зөвшөөрөгдсөн худалдааны төрлийг хуулийн 3-р хавсралтаар тогтоож өгсөн байна.

Бүртгэвэл зохих худалдааны төрлийг эрхлэхийг хүсэгчид энэ талаарх хүсэлтээ худалдааны зөвшөөрлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад гаргах ба хавсаргах баримт бичиг, хүсэлт шийдвэрлэх журмыг хуулиар тогтоож өгсөн байна.

Бизнес эрхлэгч аж ахуйн нэгж нь хариуцлагатай төлөөлөгчөөрөө дамжуулан худалдаа эрхэлж болохоор заасан байна. Хариуцлагатай төлөөлөгч нь тухайн аж ахуйн нэгжээс албан ёсоор томилогдон гэрээ байгуулсан, худалдааны зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй хувь хүн байна.

Үйлдвэр, худалдааны яамнаас худалдааны зөвшөөрлийн бүртгэлийн нэгдсэн системийг хариуцан гүйцэтгэдэг. Тус бүртгэлээр бизнес эрхлэгчдийн холбогдох мэдээлэл, худалдааны төрөл, зөвшөөрөл, үйл ажиллагаа эрхлэх хугацаа зэрэг мэдээллийг оруулдаг байна.

Худалдааны хяналт, шалгалттай холбогдох асуудлыг Худалдааны хяналтын тухай<sup>41</sup> (Czech Trade Inspection act No. 64/1986 Coll) хуулиар зохицуулж байна.

## **2.7. ХБНГУ-ЫН ТУРШЛАГА**

Германд худалдаа аж үйлдвэрийн салбарын дотоод худалдааны үйл ажиллагааг Худалдааны тухай багц хуулиар (ХТБХ), харин гадаад худалдааг Гадаад аж ахуйн тухай хууль (ГААТХ)-аар тус тус зохицуулж байна. Үүнд:

### **2.7.1. ХУДАЛДААНЫ ТУХАЙ БАГЦ ХУУЛЬ<sup>42</sup>**

Энэ хуулийг 1897.05.10-ны өдөр баталж, 1900.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн, хамгийн сүүлд 2017.07.18-ний өдөр хуулийн 11-дүгээр зүйлд өөрчлөлт оруулж, 2017.07.29-ний өдрөөс эхлэн мөрдсөн.

Худалдааны тухай багц хууль (ХТБХ) нь Герман Улсын худалдааны эрх зүйн зохицуулалтын цөм юм. Худалдаачин хүний хувьд ХТБХ-ийн дэргэд Иргэний тухай багц хууль (ИТБХ)-ийн ач холбогдол доогуур юм.

Түүнээс гадна ХТБХ нь Нээлттэй худалдааны<sup>43</sup> аж ахуйн нэгж [ААН] (хоёр, эсхүл түүнээс олон хүн хувь нийлүүлж байгуулсан пүүс), Командит ААН<sup>44</sup> (дор хаяхад нэг бүрэн болон хязгаарлагдмал хариуцлага хүлээх хувь нийлүүлэгч бүхий хувиараа эрхлэх аж ахуй [ХЭАА])

а

<sup>41</sup> Czech Trade Inspection Authority Act, No. 64/1986 Coll, <https://www.mpo.cz/en/consumer-protection/legal-regulations-applicable-to-consumer-protection/czech-trade-inspection-authority-act--no--64-1986-coll---as-amended--225822/>

<sup>42</sup> Худалдааны багц хууль-Handelsgesetzbuch-*германаар* <https://de.wikipedia.org/wiki/Handelsgesetzbuch>

<sup>43</sup> Offene Handelsgesellschaft-*германаар* [https://de.wikipedia.org/wiki/Offene\\_Handelsgesellschaft](https://de.wikipedia.org/wiki/Offene_Handelsgesellschaft)

<sup>44</sup> Kommanditgesellschaft (Deutschland)-*германаар* [https://de.wikipedia.org/wiki/Kommanditgesellschaft\\_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Kommanditgesellschaft_(Deutschland))



болон Дөлгөөн ААН<sup>45</sup> (худалдааны бус үйл ажил эрхлэх хувь хүмүүсийн нэгдэл)-ийн үйл ажиллагааг зохицуулдаг. Хөрөнгийн<sup>46</sup> ААН-ийн хувьд уг хуульд тайлан тэнцлийн талаарх зохицуулалт тусгагдсан байдаг. Нэмэлт журмаар Даатгалын компани, Зээлийн байгууллага болон хоршооны үйл ажиллагааг зохицуулдаг байна. Ял шийтгэлийн журам багатай учир ХТБХ нь эрүүгийн дагалдах эрх зүйд хамаардаг.

Өнөө үед Германы худалдааны эрх зүй нь Европын холбооны эрх зүйн нөлөөнд хүчтэй автагдаад байна.

Германы ХТБХ-ийг 1939 оноос хойш Австри улсын ихэнх нутагт мөрдөж байсан бөгөөд 2007.01.01-ний өдрөөс эхлэн Австрийн ХТБХ-ийг шинэчилж, нэрийг нь өөрчлөн Компаний тухай багц хууль болгон мөрдөж байна.

ХТБХ-ийн дагуу Худалдааны бүртгэлийг<sup>47</sup> шүүх, харин Компаний бүртгэлийг<sup>48</sup> Холбооны хууль зүйн яам тус тус эрхлэхээр зохицуулжээ.

Худалдаачдын хоорондох маргааныг ерөнхийдөө Муж улсын дэргэдэх Худалдааны танхим анхан шатанд нь хариуцдаг. Худалдааны бүртгэлтэй холбогдох хэргийг Захиргааны шүүх хариуцдаг. Практикаас харахад, дотоод болон олон улсын түвшинд улсын шүүхээс гадна арбитрын шүүх чухал ач холбогдолтой байдаг.

Тус хуулийн бүтцийг авч үзвэл:

- Нэгдүгээр боть:** Худалдааны байдал<sup>49</sup> (1-104а дугаар зүйл)  
**Хоёрдугаар боть:** Худалдааны байгууллага ба бүрэн хариуцлагатай аж ахуйн нэгж (ААН)<sup>50</sup> (105-237 дугаар зүйл)  
**Гутгаар боть:** Худалдааны ня-бо бүртгэл<sup>51</sup> (238-342е дүгээр зүйл)  
**Дөтгөөр боть:** Худалдаа арилжааны үйл ажил (343-475h дүгээр зүйл)  
1. Ерөнхий журам  
2. Худалдан авах  
3. Комиссийн үйл ажил (бизнес)  
4. Ачаа тээврийн үйл ажил (бизнес)  
5. Чингэлэг тээврийн үйл ажил (бизнес)  
6. Агуулахын үйл ажил (бизнес)  
**Тавдугаар боть:** Далайн худалдаа (476 дугаар зүйлээс хойш)

Эндээс үзэхэд, дотоод худалдааг 4-р боть буюу худалдаа арилжааны үйл ажиллагаа гэсэн хэсгээр үндсэнд нь зохицуулдаг байна.

## 2.7.2. ГАДААД АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬ<sup>52</sup>

Энэ хуулийг анх 1961.04.28-ний өдөр баталж, 1961.09.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн бөгөөд 2013.06.06-ний өдөр шинэчлэн найруулж, мөрджээ. Хамгийн сүүлд 2017.07.20-нд өөрчлөлт оруулж, 2017.07.29-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Гадаад аж ахуйн тухай хууль нь (ГААТХ) гадаадтай хийх валют, бараа, үйлчилгээ, хөрөнгө болон бусад аж ахуйн ачаа барааны эргэлтийг зохицуулдаг.

а

<sup>45</sup> Stille Gesellschaft-*германаар* [https://de.wikipedia.org/wiki/Stille\\_Gesellschaft](https://de.wikipedia.org/wiki/Stille_Gesellschaft)

<sup>46</sup> Kapitalgesellschaft-*германаар* <https://de.wikipedia.org/wiki/Kapitalgesellschaft>

<sup>47</sup> Handelsregister-*германаар*

<sup>48</sup> Unternehmensregister-*германаар*

<sup>49</sup> Handelsstand-*германаар*

<sup>50</sup> Handelsgesellschaften und stille Gesellschaften-*германаар*

<sup>51</sup> Handelsbuecher-*германаар*

<sup>52</sup> Гадаад аж ахуйн тухай хууль-Außenwirtschaftsgesetz-*германаар*  
<https://de.wikipedia.org/wiki/Au%C3%9Fenwirtschaftsgesetz>



ГААТХ-аар зохицуулдаг матер нь сүүлийн үед Европын эрх зүйн нөлөөнд хүчтэй автах боллоо. Тиймдээ ч тус хуульд ЕХ-ноос гаргасан үндэстнээс дээгүүрх<sup>53</sup> удирдамжийн дагуу олон удаа өөрчлөлт орсон байна.

Бүр 1957 оны Европын аж ахуйн бүсийн *Хамтын зах зээлээс* эхлэн хожим 1992 онд хэрэгжсэн Европын дотоод зах зээл байгуулах тухай Амстердам болон Маастрихтийн хэлэлцээрийн үр дүнд Европын нийгэмлэгийн хүрэн доторх аж ахуй, ялангуяа худалдааг зохицуулах асуудал нь гишүүн улсуудын Гадаад аж ахуйн тухай хуулийн хүрэнээс хальж, харин ч ЕХ-ны үндэстнээс дээгүүрх хууль эрх зүйн асуудал болон хувирсан. Өнөөдөр ЕВРО (ЕХ-ны аж ахуйн болон валютын нэгдэл)-гийн хамтаар ЕХ-ны дотоод зах зээл нь дотоод хил хязгааргүй дотоод аж ахуй болон дотоод худалдааны нэг нэгдмэл бүс нутгийг (дотоод улс) бий болгоод байна. Тэгэхээр үүний бүрэлдэхүүн болсон ХБНГУ нь энэхүү дотоод зах зээл дотроо “гадаад” буюу “гадаад улс” биш тул Германы ГААТХ-ийг мөрдөж үл болох буюу бүр ч Үндсэн хуульд харш юм.

ЕХ нь 1971 онд *Хамтын худалдааны бодлого* хэрэгжүүлж эхэлсэнтэй зэрэгцэн ЕХ-ны бус улс буюу Гуравдагч улс орон (шинэ “гадаад улс”)-той харьцах ЕХ-ны гаалийн тариф болон ЕХ-ны гадаад худалдаа (импорт болон экспорт)-ны олон зохицуулах журмууд бүхий янз бүрийн нэртэй, эрх зүйн хувьд дээд зэрэглэлийн “ЕХ-ны гадаад аж ахуйн эрх зүй” хэмээх ЕХ-ны гадаад аж ахуйн бүрэн төгс дэглэмийг тогтоосон. Ингэснээр ЕХ-ны гишүүн улсуудын өмнөх үндэсний гадаад аж ахуйн хууль (түүнд нь Германы ГААТХ хамаарна)-ийг Гуравдагч орнуудад хэрэглэх боломжгүй буюу эрх зүйн зөрчилтэй болсон.

Тус хуулийн бүтцийг авч үзвэл:

**Нэгдүгээр бүлэг:** Эрх зүйн үйл ажил болон ажиллагаа<sup>54</sup>

1-р зүйл. Үндсэн дүрэм<sup>55</sup>

2-р зүйл. Нэр томъёоны тайлбар<sup>56</sup>

3-р зүйл. Салбарын болон үйлдвэрийн газрын байршил<sup>57</sup>

4-р зүйл. Нийтийн аюулгүй байдал болон гадаад хэргийн сонирхолыг хамгаалахад тавигдах хязгаарлалт ба үйл ажиллагаанд хүлээх үүрэг<sup>58</sup>

5-р зүйл. Хязгаарлах зүйлс<sup>59</sup>

6-р зүйл. Ганцаарчилсан халдлага<sup>60</sup>

7-р зүйл. Германы эргийн далайгаас гадуур далайн тээвэр дэх ганцаарчилсан халдлага<sup>61</sup>

8-р зүйл. Зөвшөөрөл олгох<sup>62</sup>

9-р зүйл. Үнэмлэх олгох<sup>63</sup>

**Хоёрдугаар бүлэг:** Нэмэлт журмууд<sup>64</sup>

**Гуравдугаар бүлэг:** Шийтгэл, мөнгөн торгууль болон хяналт шалгалтын журмууд<sup>65</sup>

Эндээс үзэхэд, гадаад худалдааны асуудлыг үндсэндээ 1-р бүлэг буюу Эрх зүйн үйл ажил болон ажиллагаа гэсэн бүлгээр зохицуулдаг байна.

а

<sup>53</sup> supranational-германаар

<sup>54</sup> Rechtsgeschäfte und Handlungen-германаар

<sup>55</sup> Grundsatz-германаар

<sup>56</sup> Begriffsbestimmungen-германаар

<sup>57</sup> Zweigniederlassungen und Betriebsstätten-германаар

<sup>58</sup> Beschränkungen und Handlungspflichten zum Schutz der öffentlichen Sicherheit und der auswärtigen Interessen-германаар

<sup>59</sup> Gegenstand von Beschränkungen-германаар

<sup>60</sup> Einzeleingriff-германаар

<sup>61</sup> Einzeleingriff im Seeverkehr außerhalb des deutschen Küstenmeeres-германаар

<sup>62</sup> Erteilung von Genehmigungen-германаар

<sup>63</sup> Erteilung von Zertifikaten-германаар

<sup>64</sup> Ergänzende Vorschriften-германаар

<sup>65</sup> Straf-, Bußgeld- und Überwachungsvorschriften-германаар

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Казахстаны Худалдааны тухай хууль
- [http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544\\_](http://adilet.zan.kz/kaz/docs/Z040000544_)
- Японы Худалдааны тухай хууль
- <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2135&re=02&vm=02>
- Японы Компаний хууль
- <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2456&vm=2&re=>
- Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль  
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1863&vm=2&re=>
- Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдааны /арилжааны/ эрх зүй. Илтгэлийн эмхэтгэл
- Trade Regulations of Japan
- <http://hong-kong-economy-research.hktdc.com/business-news/article/Small-Business-Resources/Trade-Regulations-of-Japan/sbr/en/1/1X000000/1X006N03.htm>
- Foreign Trade Law of The People's Republic of China(2004)  
<http://english.mofcom.gov.cn/aarticle/policyrelease/internationalpolicy/200705/20070504715845.html>
- Law of the People's Republic of China on Import and Export Commodity Inspection
- <http://english.mofcom.gov.cn/article/policyrelease/internationalpolicy/200703/20070304474577.shtml>
- (Commercial code) No. 513/1991, <https://www.mpo.cz/en/consumer-protection/legal-regulations-applicable-to-consumer-protection/czech-trade-inspection-authority-act--no--64-1986-coll---as-amended--225822/>
- The Trade Licensing Act No.455/1991/, <https://www.mpo.cz/en/business/licensed-trades/legislation/trade-licensing-act--172390/>
- <http://www.czechtradeoffices.com>
- <https://ec.europa.eu/migrant-integration/librarydoc/the-trade-licensing-act-no-455/1991>
- <https://www.wto.org/english/>
- [http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file\\_id=198074#LinkTarget\\_639](http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=198074#LinkTarget_639)
- Б.Санжмятав. Олон улсын худалдаа/ онол, эрх зүйн зохицуулалт, техник, баримт бичгүүд, 2015 он, Улаанбаатар, 44-48-р тал
- [www.pravo.gov.ru](http://www.pravo.gov.ru) ФЗ “Об основах государственного регулирования торговой деятельности”
- [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_law\\_45397/](http://www.consultant.ru/document/cons_doc_law_45397/) ФЗ “Об основах государственного регулирования внешнеторговой деятельности”
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=37127&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37127&lang=ENG)
- [https://en.wikisource.org/wiki/Translation:Commercial\\_Act\\_of\\_South\\_Korea#PART\\_I\\_GENERAL\\_PROVISIONS](https://en.wikisource.org/wiki/Translation:Commercial_Act_of_South_Korea#PART_I_GENERAL_PROVISIONS)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=45095&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45095&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=37529&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37529&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=46087&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46087&lang=ENG)
- [https://simple.wikipedia.org/wiki/Commercial\\_Act\\_of\\_South\\_Korea](https://simple.wikipedia.org/wiki/Commercial_Act_of_South_Korea)
- [http://www.koreanlii.or.kr/w/index.php/Commercial\\_Act?ckattempt=1](http://www.koreanlii.or.kr/w/index.php/Commercial_Act?ckattempt=1)

# 2

## БҮЛЭГ

---

НИЙГЭМ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Д.Жигваагүнсэл  
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа, И.Жаргалзаяабямба*

### АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

НЭГ.САЙН ДУРЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЕРӨНХИЙ  
ОЙЛГОЛТ БА ТҮҮХЭН ТОЙМ

ХОЁР.САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН  
ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1.Люксембург

2.2.Герман

2.3.БНСУ

2.4.Филиппин

2.5.Македон

2.6.Чех

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБСДБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сайн дурын байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЕХ	Европын Холбоо
ЕЗПА	Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
СХЗБ	Салбар хоорондын зөвлөх байгууллага

## УДИРТГАЛ

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгааны нэгдүгээр хэсэгт, сайн дурын ажил, үйлчилгээний үүсэл хөгжил болон сайн дурын үйл ажиллагааны талаарх ерөнхий ойлголт, хоёрдугаар хэсэгт, судалгааны захиалгад дурьдсан Солонгос, Герман түүнчлэн, Люксембург, Филиппин, Македон, Чех зэрэг улсын сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчинг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно. Мөн сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй Солонгос, Филиппин, Македон болон Чех улсын холбогдох хууль тогтоомжийг тойм байдлаар орчуулан хүргүүлж байна.

Судалгааны сэдвийн хүрээнд дээр дурьдсан орнуудаас бие даасан зохицуулалт бүхий орнуудын хууль тогтоомжийг хуулийн агуулга, бүтцийн хүрээнд (зохицуулж буй харилцаа, нийтлэг асуудлууд, сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолт, хуулийн хамрах хүрээ болон сайн дурын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, сайн дурын үйл ажиллагааг урамшуулах, хамгаалах механизм, сайн дурын үйл ажиллагааны харилцаанд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлага, татвар гэх мэт) судалж, судалгааны мэдээллийг Хүснэгт 1-т хураангуйлан үзүүлэв.

### **Судалгааны үр дүнгийн тойм**

Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй зохицуулалтын хувилбаруудын хувьд улс орон бүр өөрийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалдаа тохируулан харилцан адилгүй зохицуулалттай байна. Турк, Албани зэрэг улсад сайн дурын ажил, үйлчилгээг зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа бол бусад улс орнуудын зохицуулалтыг (Европын холбооны хэмжээнд) үндсэн 3 ангилалд хувааж болохоор байна.

*Эхний ангилалд* зан заншлын, өөрөө өөрийгөө зохицуулах хэм, хэмжээ бүхий, сайн дурын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хууль тогтоомж гаргаагүй улс орнууд орж байна Тус ангилалд: Сайн дурын үйл ажиллагаа эртнээс хөгжсөн Скандинавын улс орнууд болон Их Британи, Ирланд зэрэг улс орж байна.

*Хоёрдугаар ангилалд* сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг бие даасан хуулиар бус тус асуудлыг хамаарах олон хуулиар зохицуулсан улс орнууд багтаж байна. Тухайлбал, Латвид “сайн дурын ажилтан”, “сайн дурын үйл ажиллагаа” гэх нэр томъёог Иргэний нийгмийн байгууллагуудыг зохицуулж буй хууль тогтоомжид, Польш Улсад Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль тогтоомжид, Швейцарт Эрх үүргийн тухай хуулиар тус тус зохицуулсан байна. Зарим улсын хувьд зөвхөн залуучуудын сайн дурын үйл ажиллагаан дахь оролцоог дэмжсэн, зохицуулсан зохицуулалтууд тусгагдсан (Косово, Беларусь), эсхүл сайн дурын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хөдөлмөрийн хууль, татварын хууль тогтоомжид тусган зохицуулж байна.

*Гуравдугаар ангилалд* сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй улс орнууд орж байгаа бөгөөд Европын орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хувилбар юм. Үүнд: Бельги, Литва, Македон, Молдов, Словак, Серб, Украин, ОХУ, Гүрж, Хорват, Чех, Унгар, Итали, Люксембург, Португал, Испани зэрэг улс орнууд багтаж байна.

Дэлхийн улс орнуудын хувьд 2001 оныг НҮБ-аас Олон улсын сайн дурын ажилтны жил болгон зарлаж, холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн ач холбогдлыг онцолсноос хойш сайн дурын үйл ажиллагааг хуулиар тусгайлан зохицуулах нь нэмэгдсэн юм.

Сайн дурын ажиллагааны төв /зөвлөл, агентлаг/ (National Volunteer services)-ийг байгуулах нь сайн дурын үйл ажиллагааг дэмжих гол хэрэгслүүдийн нэг болж байна. Эдгээр байгууллагуудаар дамжуулан мэдээлэл олгох, төвлөрүүлэх, сургалт явуулах, зуучлах зэрэг үйл ажиллагаа явагдах бөгөөд Австрали, Аргентин, Барбадос, Бразил, Хорват, Кипр, Египет, Сальвадор, Ливан, Люксембург, Мадагаскар, Перу, БНСУ, Украин, АНЭУ, Замби, Тайланд зэрэг орнууд энэ талаар туршлага хуримтлуулжээ. Улс орон бүрийн хувьд тэдгээрийг байгуулсан зорилго, үйл ажиллагааны хүрээ зэргээс хамааран тэдгээрийн



бүтэц, зохион байгуулалт нь ялгаатай байна. Ихэнхдээ дээрх байгууллагын удирдлагад бүхий л салбарын хэрэгцээ, шаардлага, оролцоог хангах үүднээс төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөгчдөөс бүрддэг байна.

**Хууль тогтоомжоор тусгайлан зохицуулсан байдал, зохицуулалтын хамрах хүрээ:** Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд Чех 2002 онд, БНСУ 2005 онд, Филиппин болон Македон Улс 2007 онд тус тус сайн дурын ажиллагааг зохицуулсан бие даасан хууль тогтоомжийг баталсан байна.

Чех Улсын хувьд Сайн дурын үйлчилгээний тухай хуулиар урамшуулал, хөлсгүй сайн дурын ажил үйл ажиллагаа явуулж, зохион байгуулахад төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх нөхцөлүүдийг тогтоож өгсөн боловч үүнийг сайн дурын үйл ажиллагааг зохицуулах суурь хууль гэж үздэггүй бөгөөд бусад төрлийн сайн дурын үйл ажиллагаа нь дээрх хуулийн үйлчлэх хүрээнээс гадуур явагдаж болохоор байгаа юм.

#### **Сайн дурын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт:**

**БНСУ:** Сайн дурын ажиллагааны байгууллага, төвүүд нь сургалт, аюулгүй байдлын менежментийг тогтмол хэрэгжүүлэх ёстой бөгөөд сургалтын үйл ажиллагаанд холбогдох боловсролын байгууллагуудыг дайчлан ажиллуулж болно.

- *Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх хороо:* Сайн дурын ажиллагааны бодлогыг тодорхойлох үүрэг бүхий Хороог Ерөнхий сайдын дор байгуулж, бүрэлдэхүүнд нь удирдлага, шинжээчдийг оруулна.

- *Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл:* Сайн дурын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд хөгжүүлэх зорилгоор Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөлийг ашгийн бус байгууллагын статустай байгуулж болно. Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл нь сайн дурын ажиллагааны төслүүдийг дэмжих, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, олон нийтийн дэмжлэгийг эрэлхийлэх, олон улсын солилцоог бэхжүүлэх, бодлого тодорхойлох, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгүүлэх, мэдээлэл солилцох, засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

- *Сайн дурын ажиллагааны төвүүд:* Үндэсний засгийн газар нь ашгийн бус байгууллагын статустай сайн дурын ажиллагааны төвүүдийг байгуулж, санхүүжүүлэх арга хэмжээг авч болно. Сайн дурын ажиллагааны төвийг Удирдах зөвлөл (сангийн хэлбэрээр байгуулсан бол Захирлуудын зөвлөл) удирдана. Сөүл болон бусад томоохон хотууд, мужуудын сайн дурын ажиллагааны төвүүд дараах үүрэгтэй: Бусад хот, мужийн байгууллага, бүлгүүдтэй хамтран ажиллах байнгын хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох; сайн дурын ажиллагааны менежер, удирдах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх; сайн дурын ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх; сайн дурын ажиллагааны судалгаа шинжилгээ хийх; сайн дурын ажиллагааны мэдээллийн төвийг ажиллуулах; бүс нутгийн төвүүдийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог идэвхжүүлэх, төслүүдийг дэмжих; сайн дурын ажиллагааг хөгжүүлэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Хот, бие даасан дүүргийн сайн дурын ажиллагааны төвүүд дараах үүрэгтэй: Бусад хот, бие даасан дүүргүүдийн байгууллага, бүлгүүдтэй байнгын хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох; сайн дурын ажиллагааг сурталчлах; сайн дурынхныг дайчлах, бэлтгэх; сайн дурын ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, дэмжих, хэрэгжүүлэх; сайн дурын ажиллагааны мэдээллийг цуглуулах, түгээх; бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

**Филиппин:** Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь Филиппиний *Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг* байх ба сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

- *Салбар хоорондын зөвлөх байгууллага* нь Үндэсний эдийн засаг, хөгжлийн газар, Боловсролын яам, Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам, Дотоодын ба орон нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөлөл, Нийгмийн халамж, хөгжлийн газар, Дээд боловсролын

комисс, Ерөнхийлөгчийн Тамгын газар, аж ахуйн нэгж, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ. Салбар хоорондын зөвлөх байгууллага нь Үндэсний сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, сайн дурын үйл ажиллагааны асуудлаар зөвлөх болон техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, нийгэм, сайн дурын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, сайжруулах чиг үүргийг гүйцэтгэнэ.

**Македон:** Сайн дурын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий төрийн агентлаг, хороо байхгүй. Сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтэд Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам хяналт тавина. Хяналт удирдлагыг Төрийн хөдөлмөрийн хяналтын алба, хөдөлмөрийн хяналтын байцаагч нараар дамжуулан гүйцэтгэнэ.

**Чех:** Сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийг Дотоод хэргийн яам хариуцна (Сайн дурын ажиллагааны Алба).<sup>66</sup> Дотоод хэргийн яам нь Хэрэгжүүлэгч байгууллагад магадлан итгэмжлэл олгоно. Магадлан итгэмжлэлийг Гадаад хэргийн яам, Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам, Хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн яам, Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам болон ТББ-ын асуудлаарх Засгийн газрын Зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн Магадлан итгэмжлэлийн хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн 3 жилээр олгоно.

- *Хэрэгжүүлэгч байгууллага* (Илгээгч байгууллага) нь Чех Улсын нутаг дэвсгэрт байрладаг ТББ байх бөгөөд сайн дурын ажилтныг сонгон шалгаруулах, бүртгэх, сургалт зохион байгуулах, сайн дурын ажилтныг даатгалд хамруулах болон сайн дурын ажилтантай гэрээ байгуулах үүргийг хүлээнэ. Гагцхүү магадлан итгэмжлэл бүхий хэрэгжүүлэгч (илгээгч) байгууллага нь хуульд заасан санхүүгийн дэмжлэг олгоно.

- *Хүлээн авагч байгууллага* нь үйлчилгээ шаардлагатай байгаа, эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах, тухайн гэрээний дагуу үүргээ хэрэгжүүлэх чадвар бүхий этгээдийг хэлнэ. Байгууллагатай гэрээ байгуулж, тохиролцооны дагуу үүргээ биелүүлэх чадвартай байна. Хүлээн авагч байгууллага нь ТББ байх албагүй бөгөөд төр, эмнэлэг, сургууль, хот байж болох юм.

**Сайн дурын үйл ажиллагааны урамшуулал:** БНСУ-ын Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуульд заасны дагуу улс, нийгэмд нэн тустай сайн дурын ажил хийж гүйцэтгэсэн сайн дурын ажилтнууд, сайн дурын байгууллагууд болон төвүүдэд Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас шагнал урамшуулал олгож болно. Филиппиний сайн дурын үйл ажиллагааны тухай хуульд Төрийн болон төрийн бус байгууллагуудын сайн дурын ажилтанд тэтгэмж, даатгал, сургалт, Филиппиний гадаад дахь ажиллах хүчинд олгох давуу эрхтэй адил эрхийг Филиппиний гадаад дахь сайн дурын ажилтанд олгох зэрэг болон бусад байдлаар урамшуулал олгож болохоор заасан байна.

**Сайн дурын ажилтантай гэрээ байгуулах заалтыг** Македон, Чех Улс холбогдох хуульдаа тусгасан байна.

Македоны Сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн 13-р зүйлд заасны дагуу Хувь хүний орлогын татварын тухай хуулийн дагуу Сайн дурын ажлын гэрээнд тодорхойлсон ажилд **хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй**. Сайн дурын ажлын гэрээ байгуулсан нь Ажил эрхлэлт ба даатгалын тухай хуульд заасан ажилгүйдлийн тэтгэмж авах эрхээ алдах үндэслэл болохгүй гэж заажээ.

БНСУ-ын хуулиар, Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуульд заасан дэмжлэгийг авч буй сайн дурын байгууллага, төвүүд нь **улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх** үүргээ зөрчсөн бол Олон нийтийн албан ёсны Сонгуулийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ гэж заажээ.

<sup>66</sup> <http://www.kansalaisareena.fi/Volunteering%20in%20the%20Czech%20Republic.pdf>

**Хүснэгт 1.Сайн дурын ажиллагааг зохицуулж буй бие даасан хууль тогтоомж бүхий орнуудын эрх зүйн орчны харьцуулалт**

Д/д	Асуудал	БНСУ	Филиппин	Македон	Чех
1	Хууль тогтоомж	- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль 2005 он; - Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн зарлиг 2006 он.	- Сайн дурын үйл ажиллагааг бэхжүүлэх, Хөдөөгийн хөгжлийг дэмжих стратегийг тогтоох тухай 9418 тоот хууль 2007 он; - Сайн дурын үйл ажиллагааны тухай №9418 хуулийг хэрэгжүүлэх журам.	- Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль 2007 он.	- Сайн дурын үйлчилгээ үзүүлэх тухай хууль, 2002 он
2	Хуулийн зорилго, цар хүрээ	Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулиар сайн дурын ажил, сайн дурын ажилтан, сайн дурын байгууллага, Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо, Үндэсний сайн дурын төвийн эрх, үүргүүдийг тодорхойлж, сайн дурын ажилтай холбогдох харилцааг зохицуулж байна.	Филиппиний нийгмийн олон салбаруудын оролцоо, түүнчлэн нийтийн болон иргэний асуудлаарх олон улсын болон гадаадын сайн дурын байгууллагуудын оролцоог дэмжих, үндэсний хөгжил, олон улсын харилцан ойлголцлыг бий болгох үүднээс сайн дурын үйл ажиллагааны стратегийг батлах, сайн дурын үйл ажиллагааны практик нөлөөг сайжруулах нь төрийн бодлого мөн.	Тус хуулиар сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны нөхцөл, арга хэлбэр, сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй ажилтан болон зохион байгуулагчийн эрх, үүрэг, сайн дурын ажлын гэрээ ба сайн дурын ажлын бүртгэл, тэмдэглэл зэргийг зохицуулж байна.	Тус хуулиар урамшуулал, хөлсгүй сайн дурын ажил үйл ажиллагаа явуулж, зохион байгуулахад төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэх нөхцөлүүдийг тогтооно.
3	Нэр томьёо	- Сайн дурын ажил; - Сайн дурын ажилтан; - Сайн дурын үйл ажиллагааны төв.	- Сайн дурын үйлс; - Сайн дурынхан; - Сайн дурын байгууллага; - Сайн дурын салбар; - Бүртгэл; - Сайн дурын ажиллагааны үндэсний хөтөлбөр.	- Сайн дурын үйл ажиллагаа; - Сайн дурын ажилтан.	-Сайн дурын ажиллагаа; -Сайн дурын ажилтан; - Хэрэгжүүлэгч байгууллага; -Хүлээн авагч байгууллага.
4	Гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалт	Дурьдаагүй	Дурьдаагүй	4-р бүлгээр гэрээтэй холбоотой асуудлыг зохицуулсан: Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь сард 40 цагаас дээш хугацаагаар ажиллах дотоодын (Македон Улсын иргэн) сайн дурын ажилтантай сайн дурын ажлын гэрээг бичгээр байгуулна.	3-р зүйлийн 3-р хэсэгт сайн дурын ажилтан хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр сайн дурын үйл ажиллагаа эрхэлнэ; Богино, урт хугацааны, мөн хилийн чандад сайн дурын үйл ажиллагаа явуулах гэрээг бичгээр үйлдэнэ. Гэрээтэй холбоотой асуудлыг хуулийн 5-р зүйлд нарийвчлан тогтоосон.

Д/д	Асуудал	БНСУ	Филиппин	Македон	Чех
5	Эрх үүрэг	-Сайн дурын ажилтны эрх үүрэг, холбогдох албан байгууллагын эрх үүрэг: Дурьдаагүй	3-р бүлэг Журмын 4-р бүлэгт Сайн дурын үйл ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн байгууллагын эрх, үүргийг тусгасан.	3-р бүлэгт сайн дурын ажилтан ба сайн дурын ажил зохион байгуулагчийн эрх, үүргийг тусгасан.	Хэрэгжүүлэгч байгууллагын эрх үүргийг 7-р зүйлд тусгасан.
6	Сайн дурынхны урамшуулал/ хамгаалал	Улс, нийгэмд нэн тустай сайн дурын ажил хийж гүйцэтгэсэн сайн дурын ажилтнууд, сайн дурын байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагааны төвүүдэд Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас шагнал урамшуулал олгож болно. <i>Сайн дурынхны хамгаалал:</i> ЗГ болон орон нутгийн засаг захиргаа нь сайн дурын үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулж иргэдийг сайн дурын ажилд оролцоход дэмжиж, аюулгүй орчин бүрдүүлэх, туслах үүрэгтэй. Сайн дурын ажилтнуудыг хамгаалах арга хэлбэр, нарийвчилсан зохицуулалт, үүнд, даатгалд хамруулах зэрэг асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.	Төрийн болон төрийн бус байгууллагуудын сайн дурын ажилтанд тэтгэмж, даатгал, сургалт, Филиппиний гадаад дахь ажиллах хүчинд олгох давуу эрхтэй адил эрхийг Филиппиний гадаад дахь сайн дурын ажилтанд олгох зэрэг болон бусад байдлаар урамшуулал олгож болохоор заасан.	Сайн дурын ажлын гэрээ байгуулсан нь Ажил эрхлэлт ба даатгалын хуулийн заалтуудын дагуу ажилгүй болсны тэтгэмж авах эрхээ алдах үндэслэл болохгүй.	Санхүүжилт хэсгээс үзнэ үү. Сайн дурын ажилтнаар үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээс өмнө, хэрэгжүүлэгч байгууллага нь сайн дурын ажилтанд өөрөө, эсхүл гуравдагч этгээдэд учруулсан материаллаг хохирол, эрүүл мэндийн хор уршиг учирсан нөхцөлд үзүүлэх даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй.
7	Удирдлага, зохион байгуулалт	- Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх хороо - Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл - Үндэсний сайн дурын төвүүд	Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг Салбар хоорондын зөвлөх байгууллага	Хөдөлмөр, нийгмийн бодлогын яамны зөвшөөрөл, Бүгд Найрамдах Македон Улсад оршин суух хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын иргэн нь Бүгд Найрамдах Македон Улсад сайн дурын ажил хийж болно. Сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтэд Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам	Энэ хуулийн 6-р зүйлд Хэрэгжүүлэгч байгууллагад Дотоод Хэргийн Яамнаас магадлан итгэмжлэл олгоно. Магадлан итгэмжлэлийг Гадаад Хэргийн Яам, Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам, Хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн яам, Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам болон ТББ-ын асуудлаарх

Д/д	Асуудал	БНСУ	Филиппин	Македон	Чех
				хяналт тавина. Хяналт удирдлагыг Төрийн хөдөлмөрийн хяналтын алба хөдөлмөрийн хяналтын байцаагч нараар дамжуулан гүйцэтгэнэ.	ЗГ-ын Зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн Магадлан итгэмжлэлийн Хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн олгоно;
8	Санхүүжилт	<p>- Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын байгууллагууд болон төвүүдийг доорх төслүүдийг хэрэгжүүлсэн тохиолдолд улсын болон олон нийтийн өмч хөрөнгийг үнэгүй ашиглах болон зээлэхийг зөвшөөрнө.</p> <p>Олон улсыг хамарсан төслүүд; Гамшгийн үеэр тусламж дэмжлэг үзүүлэх, сэргээн босгох төслүүд; Сайн дурын байгууллага болон төвүүдээс хэрэгжүүлж буй бусад төслүүд. Энэ тохиолдолд улсын болон нийтийн өмч хөрөнгийг үнэгүй түрээслэх болон ашиглах хугацаа 1 жилээс хэтрэхгүй байна; Улсын болон нийтийн өмчийг үнэгүй түрээслэх болон ашиглах асуудал нь Улсын эд хөрөнгийн тухай хууль, Нийтийн өмч ба үйлчилгээний менежментийн тухай хуулиар зохицуулагдана.</p> <p>- Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлнэ. Тухайлбал, "Ашгийн бус, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх тухай хууль"-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсийг</p>	Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг нь байгууллагын харьяа бүх сангийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	Дурьдаагүй	<p>11-р зүйлд заасны дагуу Яам нь хэрэгжүүлэгч байгууллагад дараах зориулалтаар татаас олгоно.</p> <p>а) 7-р зүйлийн 1 дэх хэсэгт даасны дагуу хэрэгжүүлэгч байгууллага даатгалын гэрээ байгуулсны үндсэн дээр даатгалын төлбөр;</p> <p>б) сайн дурын ажилтны бүртгэл хөтлөлттэй холбоотой зардал, сайн дурын үйл ажиллагаа, гүйцэтгэлийг зохион байгуулахад үүссэн зардлуудад хэсэгчлэн;</p> <p>в) 5-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу урт хугацааны турш долоо хоногт дунджаар 20 цагаас дээш ажиллаж буй сайн дурын ажилтны тэтгэврийн доод хэмжээнд тохирох тэтгэврийн даатгалын шимтгэл.</p>

Д/д	Асуудал	БНСУ	Филиппин	Македон	Чех
		нөхөн олгоно.			
9	Олон улсын сайн дурынхны асуудлыг зохицуулсан эсэх	Дурьдаагүй	6-р зүйлд гадаадын сайн дурын байгууллагын сайн дурын үйл ажиллагаанд оролцох хэлбэрийг тусгасан. 17-р зүйлд Гадаадын сайн дурын ажилтанд виз олгох асуудлыг тусгасан.	8-р зүйлд заасны дагуу гадаадын иргэн тухайн улсад сайн дурын үйл ажиллагаанд оролцож болно.	7-р зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу сайн дурын ажилтныг хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаа явуулахын өмнө, хэрэгжүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн даатгал хамруулна. Ингэхдээ сайн дурын үйл ажиллагааны шинж чанар, хилийн чанад дахь тухайн нөхцөл байдал, улс орон, нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ. (3) Хэрэв сайн дурын үйл ажиллагаа байнгын оршин суугаа газраас гадна явагдах бол, хэрэгжүүлэгч байгууллага сайн дурын ажилтны эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй нөхцөл бүхий орон сууц, нийгмийн баталгааг хангана.
10	Татвар	Дурьдаагүй	Дурьдаагүй	Хуулийн 13-р зүйлд заасны дагуу Хувь хүний орлогын татварын тухай хуулийн дагуу Сайн дурын ажлын гэрээнд тодорхойлсон ажлын зардлуудад хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй.	Дурьдаагүй
11	Хариуцлага	Хуульд заасан дэмжлэг авч буй сайн дурын байгууллага, төвүүд нь улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх үүргээ зөрчсөн бол Олон нийтийн албан ёсны сонгуулийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.	Дурьдаагүй	Хуульд хариуцлагатай холбоотой асуудлыг 7-р бүлэгт зохицуулсан.	Сайн дурын ажилтан нь зөвхөн санаатайгаар бусдад хор хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.



## НЭГ. САЙН ДУРЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ БА ТҮҮХЭН ТОЙМ

Олон улсын туршлагаас үзэхэд сайн дурын үйл ажиллагааг хуулиар тусгайлан зохицуулах нь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа бөгөөд холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн ач холбогдлыг НҮБ, Европын Парламент, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей (ЕЗПА) зэрэг олон улсын байгууллагууд онцолсон байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56 дугаар чуулганаар баталсан “Сайн дурын үйл хэргийг дэмжих тухай зөвлөмжүүд” 56/38 дугаар тогтоолд<sup>67</sup>:

“(е) сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй хамт олонд суурилсан болон ашгийн бус байгууллагуудад төсөв, эрх зүй болон бусад хүрээг дараах байдлаар тогтооно:

i) Сайн дурын үйл хэргийг дэмжсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх. Зорилго нь: Иргэдийн сайн дурын үйл ажиллагаа явуулах эрмэлзэл, сонирхлыг дэмжих, сайшаах, ингэхдээ сонголт хийх эрхийг иргэн, байгууллагад олгох. Ажлын дадлага олгох сайн дурын үйл ажиллагаа (*employee volunteering*)-г дэмжиж болно. Тухайн нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгууллагуудад татварын хөнгөлөлт үзүүлэх, татаас, дэмжлэг олгох, мөн боломжит эрсдэлээс хамгаалах зэрэг юм.

ii) иргэний нийгмийн сайн дурын үйл хэрэгт суурилсан үйл ажиллагаанд хамтарсан төлөвлөлт, хэрэгжилт болон хяналт зэрэг чиглэлээр түншлэл бий болгох. Энэ нь хувийн секторын ажлын дадлага олгох сайн дурын үйл ажиллагааг багтааж болно.” гэж заажээ.

Европын Зөвлөлөөс сургалтын шинж чанарыг агуулсан болон нийгэмд үзүүлэх ач тус зэргийг харгалзан сайн дурын үйлчилгээг дотоодын хууль тогтоомждоо тусгах, томьёолох зөвлөмжийг гаргасан байна. ЕЗПА нь Сайд нарын хороод гишүүн орнууддаа “дотоодын хууль тогтоомж, практикт сайн дурын үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж буй, мөн тухайн үйл ажиллагаа явуулахад татварын дарамт үзүүлж буй заалт, хэсгүүдийг тогтоох, саад тотгорыг арилгах” болон “сайн дурын ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлж, тэдгээрийн хараат бус байдлыг хүндэтгэхийн сацуу тохирсон нийгмийн хамгааллаар хангах, санхүүгийн саад тотгорыг арилгах”-ыг уриалсан байна.

НҮБ-ын Сайн дурын байгууллагаас гаргасан “Сайн дурын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх тухай” удирдамжид сайн дурын ажиллагааны талаар нийтлэг ойлголттой байх нь ажиллагааны үнэлгээнд нөлөөлөх ба сайн дурын ажилтнуудыг дэмжих, хамруулах, удирдах, хүлээн зөвшөөрөх бодлого, процедурыг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. Сайн дурын ажиллагааг ямар зорилгоор дэмжиж байгааг тодорхойлоогүй байгууллагуудын хувь нэмэр, цар хүрээ нь хязгаарлагдмал байдгийг дурьджээ.

“Сайн дурын ажиллагаа” нь дэлхийн бүх улс орны нийгэмд оршиж буй нийгмийн чадавх, уян хатан байдлыг бэхжүүлэх үндсэн эх үүсвэр гэж НҮБ-аас томьёолсон. НҮБ-ын Ерөнхий ассамблей “Сайн дурын ажиллагаа”-г иргэд өөрийн хүсэлтээр, олон нийтийн ашиг тусын тулд (энэ нь нийгэм болон тухайн сайн дурын ажилтанд хамаарах), мөнгөн орлогыг тулгуур хүчин зүйл хэмээн үзэхгүй нийгэмд хүчин зүтгэх нэгэн хэлбэр, “Сайн дурын ажиллагаа”-ны үнэт зүйлсийг хүнлэг хандлага, хамтын ажиллагаа, эв нэгдэл хэмээн тодорхойлсон.

“Сайн дурын ажиллагаа” нь харилцан туслалцаа үзүүлэх, өөрийн хөгжлийг дэмжих, хүмүүнлэгийн үйлс, кампанит сурталчилгаа зэрэг иргэний оролцооны уламжлалт болон уламжлалт бус олон арга хэлбэрээр хэрэгждэг. “Сайн дурын үйлдэл (Voluntary action)” нь иргэний нийгэм дэх нийгмийн ажиллагааны гол хэрэгсэл юм. Энэхүү ажиллагаа нь, тухайлбал үер, газар хөдлөлт, ойн түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд тусламж а

<sup>67</sup> Resolution Adopted by the General Assembly of the UN: 56/38, 2002  
<https://www.unv.org/publications/recommendations-support-volunteering>

үзүүлэх иргэдийн сайн дурын гэнэтийн үйлдэл, эсхүл ИНБ-ын ажиллагаагаар голдуу илэрдэг. ИНБ-ууд өргөн цар хүрээтэй, нийгмийн янз бүрийн давхаргыг хамарсан ажиллагаа явуулдаг боловч тэдний нийтлэг зарчим нь сайн дурын зарчим, үндэслэл юм. Хүмүүс Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд сайн дураар олон салбарт ажиллах сонирхлын үүднээс ТББ, байгууллагуудын захиргаанд ажилд ордог. Сайн дурын ажиллагаа нь дэлхийн өнцөг бүрт ажиллаж буй доод шатны нийгэмлэгүүдийн гишүүнчлэлээр мөн илэрлээ олдог байна.

### *1. Сайн дурын үйл ажиллагааны ач холбогдол, ашиг тусын талаарх нийтлэг ойлголт*

Сайн дурын үйл хэргийн нийгэм, тэр дундаа иргэний нийгэмд оруулж буй хувь нэмэр их юм. Тэдгээрийг тоймолбол: Сайн дурын үйл ажиллагаа нь иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн сүлжээ бий болгох, орон нутгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн үүрэг оролцоо, хариуцлагыг ухамсарлуулах үүрэгтэй. 35 улсад явуулсан судалгаагаар иргэний нийгмийн ажилтнуудын 43 хувийг сайн дурын ажилтан, Польш Улсад ИНБ-ын 87 хувь нь сайн дурын ажилтнууд байна гэж тооцоолсон байна. Түүнчлэн сайн дурын ажилтнуудын оруулсан хувь нэмрийг тэдгээрийн оролцож буй салбарын дундаж цалингаар тооцвол дүн нь мөнгөн хандиваас давж байгаа юм. 24 улсад явуулсан судалгаагаар дунджаар ашгийн бус хандивын орлогын 65 хувийг сайн дурын үйл ажиллагаа, харин үлдсэн 35 хувийг мөнгөн хандив, тусламж эзэлдэг байна. Сайн дурын үйл ажиллагааг мөнгөн дүнгээр тооцвол улс орнуудын ДНБ-ийн 8 хувь, зарим орнуудад 14 хувьд хүрч байна. 2015 оны тоо мэдээгээр АНУ-ын ахмад сайн дурынхны эдийн засагт оруулсан хувь нэмрийг 75 тэрбум ам.доллараар үнэлсэн байна.<sup>68</sup>

Сайн дурын үйл ажиллагаа нь нийгэмд ач тусаа өгөөд зогсохгүй сайн дурын ажилтнуудад мөн ач холбогдолтой юм. Тухайлбал залуучууд, эсхүл ажилгүйчүүд ажилд ороход шаардагдах мэдлэг, чадвар эзэмших боломжоор хангагдах бол ахмадуудад өөрсдийн мэдлэг чадвараа ашиглан нийгэмд оролцох, өөрсдийн хэрэгцээ шаардлагыг мэдрэх, сэтгэл санаагаар өөдрөг байхад нь тусалдаг ба үе хоорондын хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг нэмэгдүүлдэг байна.

### *2. Сайн дурын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн үзүүлэх нөлөө*

Улс орнуудын холбогдох хууль эрх зүйн орчны судалгаанаас үзэхэд хууль эрх зүйн таагүй орчин нь сайн дурын үйл ажиллагаанд ноцтой хүндрэл учруулах аюултай, цөөнгүй орнуудын эрх зүйн орчин нь сайн дурын үйл ажиллагаанд саад болж, эсхүл шаардлагатай дэмжлэг үзүүлэхгүй байна гэж дүгнэсэн байна. Сайн дурын үйл ажиллагаа тухайн улс орны соёлын нэг хэсэг болон төлөвшөөгүй орнуудад дээрх хүндрэл түгээмэл байгаа бол ХБНГУ зэрэг сайн дурын үйл хэрэг өргөн дэлгэрсэн, уламжлал болсон орнуудад сайн дурын үйл ажиллагааг дэмжих болон сайн дурын ажилтнуудыг хамгаалахтай холбоотой заалтууд олон тооны хууль тогтоомжуудад тусгагдаж баталгаажсан.

Хууль эрх зүйн зохицуулалт нь өдөр тутам, удаан хугацаанд үргэлжлэх сайн дурын ажиллагааг явуулах харилцааг зохицуулсан байх шаардлагатай. Урт хугацааны сайн дурын үйл ажиллагаа нь хөдөлмөр, татвар, хариуцлага зэрэг олон салбар хуультай шууд болон шууд бусаар холбогддог. Энэ төрлийн үйл ажиллагаанд түгээмэл тулгардаг саад бэрхшээлүүд нь хөдөлмөрийн хуулийг буруу хэрэглэх, сайн дурын ажилтанд татвар ногдуулах, ажилгүйдлийн тэтгэмжээ алдах, мөн үүрэг, хариуцлагатай холбоотой асуудлууд орж байна.

Сайн дурын үйл ажиллагааг дотоодын хууль тогтоомждоо тодорхой байдлаар томъёолж, тусгаснаар сайн дурын үйл ажиллагааг хөдөлмөрийн харилцаанаас ялгахад тустай юм. Сайн дурын ажилтанг тодорхойлсон томъёолол, сайн дурын ажиллагааны гэрээний онцлогийг

а\_\_\_\_\_

<sup>68</sup><https://www.nationalservice.gov/newsroom/press-releases/2015/value-senior-volunteers-us-economy-estimated-75-billion>

харгалзан үзээгүйн улмаас сайн дурын ажилтныг гэрээт ажилтантай адилтган үзэх, сайн дурын ажилтнуудад зардлын нөхөн төлбөр олгохыг хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зөрчсөн гэж тооцох тохиолдлууд элбэг гардаг байна. Тухайлбал, Хорват Улсын хууль тогтоомжуудад “сайн дурын үйлчилгээ”-г томьёолоогүйн улмаас зарим байгууллагууд үйл ажиллагааны чиглэлдээ сайн дурын үйл ажиллагааг тусгах, бүртгүүлэх боломжгүй байдаг байна. Латви Улсад ИНБ-д сайн дурын ажилтнуудад зардлын нөхөн төлбөр олгох тохиолдолд хөдөлмөрийн гэрээ байгуулж, хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ зэрэг шаардлагуудыг хангахыг шаарддаг байна. Хорват, Македон Улсад мэргэжлийн хяналтын байгууллага нь талуудыг хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй бол сайн дурын үйл ажиллагааг нь түр зогсоох эрхтэй байна. Түүнчлэн, сайн дурынхны эрх зүйн байдал нь тодорхойгүйн улмаас ажилгүйдлийн тэтгэмжээ алдах тохиолдлууд цөөнгүй гардаг, тухайлбал, Чех Улсад цалин болон ямарваа нэгэн мөнгөн олговоргүй сайн дурын ажил хийж буй ажилгүй этгээдийг холбогдох байгууллагаас хууль бус ажил хийж байна гэж тооцон ажилгүйдлийн тэтгэмж олгохоо зогсоож болдог бол Македон Улс нь сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй хуульдаа сайн дурын үйл ажиллагаа нь ажилгүйдлийн тэтгэмж алдах үндэслэл болохгүй гэж тусгасан байна.

Сайн дурын үйл ажиллагаанд учирч буй өөр нэгэн саад бэрхшээл нь нөхөн олговорт ногдуулах татварын асуудал юм. Олон улсын экспертүүд сайн дурын үйл ажиллагааны явцад гаргасан зардлын нөхөн төлбөрт татвар ногдуулах ёсгүй гэдэгт санал нэгддэг байна.

Дээрхийг тоймолбол сайн дурын үйл ажиллагааг хуулиар томьёолж, тодорхойлох нь сайн дурын үйл ажиллагааны явцад сайн дурын ажилтны эрхийг хангах, тэдгээрийг гэрээт, эсхүл байгууллагын ажилтнаас ялгаж өгдөг байна.

### *3. Сайн дурын үйл ажиллагааны хууль тогтоомжийн зохицуулалтын хэм, хэмжээ*

Олон улсын туршлагаас үзэхэд сайн дурын үйл ажиллагааг хууль тогтоомжоор зохицуулахад дараах асуудлыг анхаарах нь зүйтэй байна.

Нэгдүгээрт, сайн дурын үйл ажиллагаа олон янзын хэлбэртэй байж болно. Үүнд: асуудал, нөхцөл байдлыг даган үүссэн, эсхүл тогтмол шинжтэй (хөршийн санаачилга гм.), зохион байгуулалттай, албан ёсны, мөн гэрээнд суурилсан тогтмол, эсхүл үргэлжилсэн зэрэг хэлбэртэй байж болох юм. Түүнчлэн сайн дурын ажилтнууд нь баг, бүлэг, олон улсын хөтөлбөрийн хүрээнд, өөрсдийн санаачилгаар, эсхүл гуравдагч этгээдийн урилгаар оролцож болох юм. Иймээс дээрх бүх хэлбэр, төрлийн үйл ажиллагааг бүгдийг хуульчлах нь боломжгүй юм. Энэхүү асуудлаар “тодорхой зорилго бүхий хууль тогтоомжууд нь сайн дурын үйл ажиллагааны орчинг бүрдүүлэх, хөгжүүлэхийг хязгаарлаж болохгүй” гэж эрдэмтэд санал нэгддэг байна. Хууль тогтоомж боловсруулахдаа сайн дурын үйл ажиллагааг зохицуулснаар хүрэх үр дүн, зорилгоо тодорхой тогтоож, нэг хэлбэрийн сайн дурын үйл ажиллагааг зохицуулснаар бусад төрлийн, ялангуяа албан бус, *ad hoc* сайн дурын үйл ажиллагааг хязгаарлахгүй байхад анхаарах;

Хоёрдугаарт, сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн орчин нь тус үйл ажиллагааг хянах бус, зохицуулах, дэмжихэд чиглэсэн байна. Хууль тогтоомжууд нь сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх, хамгаалах, сайн дурын үйл ажиллагаанд аль болох саад тотгор учруулахгүй байх ёстой юм. Хэт их зохицуулалт нь сайн дурын санаачилгууд (*spontaneous initiatives*) болон жижиг ИНБ-д хүндрэл учруулах, сайн дурын үйл ажиллагаанд оролцох идэвх, санаачилгыг бууруулж болзошгүй юм.

Гуравдугаарт, улс орон бүр өөрийн нийгэм, соёл, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулах сайн дурын үйл ажиллагааг зохицуулах ёстой. Сайн дурын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг боловсруулахад ЗГ, ИНБ зэрэг бүхий л оролцогч талуудын оролцоог хангах нь чухал юм.

## **Сайн дурын ажил, үйлчилгээний түүхэн тойм**

Сайн дурын алба<sup>69</sup>, эсхүл хөдөлмөрийн алба<sup>70</sup> нь орон тооны бус албаны ажил үүргийн албажсан хэлбэр юм. Гэхдээ үргэлжлэх цаг хугацааны хувьд тодорхой, ажил үйлчилгээний цар хүрээ болон хэлбэрийн талаар урьдчилан тохиролцсон байдалтай юм. Ингэхдээ ихэвчлэн маш бага хөлсөөр, эсхүл огт цалин хөлсгүйгээр нийгмийн эрх ашгийн төлөө ажиллах үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад олон төрлийн орон тооны бус ажлаас сайн дурын алба нь зорилго болон арга хэрэгслүүдийг илүү хүчтэй албажуулан тодорхойлдоор ялгаатай. Тиймээс сайн дурын алба нь ерөнхийдөө илгээгч буюу зохицуулагч байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн байгууллага дахь зочин байгууллагын хэлбэрээр хэрэгждэг. Сайн дурын албыг дотоодын буюу олон улсын түвшинд, нарийн мэргэжилтэй буюу мэргэжилгүй хүний хүрээнд, бүлэг хамтлаг буюу хувь хүн тодорхой хугацаагаар хашдаг.<sup>71</sup>

Сайн дурын албыг ихэвчлэн залуучуудад зориулан тэдгээрийг сурган хүмүүжүүлэх зорилгоор хөгжүүлж ирсэн түүхтэй бөгөөд хөгжүүлсээр байна. Тиймээс сайн дурын албыг нийгмийн хөдөлгөөн буюу ард түмэн, улс орон, олон улсын ойлголцол (ард түмнүүдийн ойлголцол, ард түмнүүдийн найрамдал г.м.)-ын төлөө нийгэмлэгийн алба байдалтайгаар хуульчилсан байдаг.

Өнөөдөр нэгэнт хэвшсэн сайн дурын албыг *хөдөлмөрийн алба* гэж нэрлэвэл, Герман Улсын хувьд энэ нь сөрөг утгатай байдаг. Учир нь үндсэрхэг социалист дэглэмийг дэмжин үйл ажиллагаа явуулдаг байсан “эзэнт гүрний хөдөлмөрийн алба”<sup>72</sup> (ЭГХА) гэдэг утгыг шууд илэрхийлдэг. Иймээс 1920-иод болон 1930-аад оны хөдөлмөрийн албууд нь 1933-45 онд эзэнт гүрний засгийн газрын бүтцэд байсан дээрх ЭГХА-тай нэр нь л адилхан болохоос биш үзэл баримтлал нь тэс ондоо юм.

Дэлхийн I дайны дараа 1920 онд Швейцарийн иргэн Пиер Кересоль энх тайвны төсөл санаачилж, Дайныг эсэргүүцэгчид<sup>73</sup> нэртэйгээр анхны олон улсын сайн дурын албыг байгуулж байжээ. Тэрээр Францад европын өнцөг булан бүрээс залуучуудыг цуглуулан дайны хөлд нэрвэгдсэн тосгодыг сэргээн босгох ажил хийлгэж байв. Ингэж хамтдаа хөдөлмөрлөж, цугтаа амьдран европ дахь ирээдүйн сэргөлдөөнийг намжаан ард түмнүүдийн харилцан ойлголцолд хувь нэмэр оруулж байв.

Ийм үзэл санааны дор ихэвчлэн шашин шүтлэгтэй залуучууд нэгдэн Service Civil International<sup>74</sup> (SCI), Internationaler Versöhnungsbund<sup>75</sup> und Youth Action for Peace<sup>76</sup> зэрэг байгууллагуудыг байгуулжээ. Албандаа аль ч хүйстнийг элсүүлдэг болон цэргийн дэглэм, сахилга батын оронд иргэний нийгмийн зарчмуудад голчлон анхаарлаа төвлөрүүлдэг онцлогтой байв. Олон улсын сайн дурын бүлгэмүүдийн зохион байгуулсан эдгээр төслүүдийг тэр үед Workcamps<sup>77</sup> гэдэг байлаа.

Дэлхийн I дайны төгсгөлд хийгдсэн 1919 оны хэлэлцээрийн дагуу цэргийн албыг хориглох болсон тул Австри, Герман, Унгар, Болгар зэрэг улсуудад 1920 оноос эхлэн цэргийн албыг орлох хөдөлмөрийн албыг байгуулж, эрэгтэй залуучуудыг татан оролцуулж ажиллуулах болсон. Болгар Улс л гэхэд 1920 онд нийгэм, улс төрийн сэдлээр Албан журмын хөдөлмөрийн албыг<sup>78</sup> байгуулж, хүн амын 30% нь жил бүр татагдаж, нийгэмд тустай ажил үүрэг гүйцэтгэдэг байв.

а

<sup>69</sup> Freiwilligendienst-германаар

<sup>70</sup> Arbeitsdienst-германаар

<sup>71</sup> Сайн дурын алба-Freiwilligendienst-германаар <https://de.wikipedia.org/wiki/Freiwilligendienst>

<sup>72</sup> Reichsarbeitsdienst-германаар

<sup>73</sup> Pazifisten-германаар

<sup>74</sup> Олон улсын иргэний алба-үгчилбэл

<sup>75</sup> Олон улсын эв нэгдлийн холбоо-үгчилбэл

<sup>76</sup> Энх тайвны төлөө залуусын хөдөлгөөн-үгчилбэл

<sup>77</sup> Хөдөлмөр зуслан/хөдөлмөрийн лагерь-үгчилбэл

<sup>78</sup> Zwangsarbeitsdienst-германаар



Болгарын энэ туршлага Германд консерватив болон зүүний үзэлт нэлээдгүй улстөрчдийг хамруулан нэлээн өргөн хүрээнд анхаарал татаж байв. Ажилгүйчүүд гудамжинд байхгүй болж, хамгийн бага зардлаар зайлшгүй шаардлагатай ажил, үйлчилгээг хийлгэж, цаашилбал унших, бичих, эрүүл ахуй зэрэгт суралцахын зэрэгцээ “Za Balgarija trud” (Болгарын төлөө хөдөлмөр) уриан дор залуу хүнийг журамт<sup>79</sup> иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байсан нь хөдөлмөрийн албыг ардын бага сургууль мэт санагдуулж улстөрчдөд ихээхэн таалагдаж байсан юм.

Ингээд 1924 онд Германд Холбооны залуучуудын бүлэг<sup>80</sup> хэмээх байгууллага үүсч 200 ахимаг насны удирдагчдыг бэлтгэн хөдөлмөрийн зуслан зохион байгуулж хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх ажил хийж эхэлсэн байдаг.

1929 онд эхэлсэн дэлхийн эдийн засгийн хямралын улмаас ажилгүйчүүдийн тоо маш их болсон тул олон оронд залуу ажилгүйчүүдэд зориулан орлуулах зорилгоор сайн дурын албаны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг.

Герман Улсад 1931.08.08-ний өдөр “Сайн дурын хөдөлмөрийн алба” байгуулах тухай хууль батлагдаж, 25-аас доош настай ажилгүй иргэн 20 гараг (долоо хоног) хүртэл хугацаагаар давын өмнө нийгмийн, эсхүл залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжтой болсон. Залуучуудын холбоо нь дээрх хөдөлмөрийн албаны хүрээнд 1933 он хүртэл нийгэмд тустай 454 төслийг амжилттай хэрэгжүүлсэн байдаг. Гэвч үндсэрхэг социалистууд 1933 онд Засгийн эрхэнд гарснаар уг Залуучуудын холбоог хориглож, сайн дурын хөдөлмөрийн алба нь илүүтэйгээр суртал ухуулга болон цэрэг армийн зорилгоор ашиглагдах болсон. Улмаар 1935 онд нэрийг нь өөрчилж ЭГХА болгосон бөгөөд цэрэг армийн бэлтгэл нөөц хүч болон үндсэрхэг социализмын үзлээр сурган хүмүүжүүлэх үйлсэд ашиглагдах болсон.

АНУ-д 1933 оны хавар “Civilian Conservation Corps”<sup>81</sup> (CCC) байгуулагдаж, 1942 он хүртэл мөн л ажилгүй залуучуудад зориулсан ажлын байр бий болгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Эдийн засгийн хямралыг сөрөх энэхүү төсөлд Нэгдсэн Улсын армийн 3,463,766 бэлтгэл офицер сайн дураараа нийтийн дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын ажилд оролцсон нь хамгийн цар хүрээтэй нь юм.

Дэлхийн I дайны дараах үетэй адилаар дэлхийн II дайн дууссан 1945 онд мөн л ард түмнүүдийн харилцан ойлголцол болон сэргээн босгох ажлын хэрэгцээ их байсан. Олон улсын сайн дурын байгууллагууд олноор бий болж, улмаар 1948 онд НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэргэд энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын дээвэр байгууллага болох “Co-ordinating Committee for International Voluntary Service”<sup>82</sup> (CCIVS) байгуулагдсан юм. Германд ЭГХА байхгүй болсон ч хөдөлмөрийн албаны анхны суурь зарчмуудын зарим элементүүд олон газарт оршсоор байж, Олон улсын залуучуудын нийгэмлэгийн алба, Хөгжлийн туслалцаа г.м. олон улсын сайн дурын үйл ажиллагааны хэлбэрт шилжсэн байв. АНУ-д өөрөө өөртөө туслах үзэл баримтлал болон нийгмийн халамж хүртэгсдийг дэмжих үүднээс нийгмийн тустай ажлыг зохицуулах зорилгоор Peace Corps<sup>83</sup> байгуулагджээ. Мөн 1952 онд БНАГУ-д Хөдөлмөрийн албаны эерэг талыг залгамжлан “Германы төлөө алба”<sup>84</sup> (ЗХУ-ын “зөвлөмж”-ийн дагуу, түүний туршлага бөгөөд Польшийн Sluzhba төстэй) байгуулагдсан байдаг.

Европ даяар барагцаалбал, 100 сая орчим (Германд ойролцоогоор 23 сая) байгаа сайн дурынхны ач холбогдлыг тэмдэглэх, алдаршуулах зорилгоор Европын зөвлөлөөс 2011 оныг “Европын сайн дурын ажил үүргийн жил” хэмээн зарлан тунхаглаж байжээ.<sup>85</sup>

а \_\_\_\_\_

<sup>79</sup> loyal-германаар

<sup>80</sup> Bündische Jugendgruppen-германаар

<sup>81</sup> Иргэний нөөц корпус-үгчилбэл

<sup>82</sup> Олон улсын сайн дурын албыг зохицуулах хороо-үгчилбэл

<sup>83</sup> Энх тайвны корпус-үгчилбэл

<sup>84</sup> Dienst für Deutschland-германаар

<sup>85</sup> Орон тооны бус алба-Ehrenamt-германаар <https://de.wikipedia.org/wiki/Ehrenamt>

# ХОЁР.САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 2.1.ЛЮКСЕМБУРГ

Орон тооны бус алба<sup>86</sup> (герман хэлнээс үгчилбэл “Хүндэт алба” гэнэ) болон сайн дурын алба<sup>87</sup> нь хувь хүний эрхэлдэг албан ёсны ажил үүргийн хоёр өөр хэлбэр юм. Аль ч албыг хашсан ялгаагүй сайн сайхан үйлсийн төлөө өөрийн цагийг үрж, эрчмийг зарцуулж байдаг. Гэхдээ дээрх хоёр ажил үүрэг зарчмын ялгаатай юм.

Орон тооны бус алба гэж гэр бүл буюу найз нөхдийн хүрээн дэх жирийн харилцан туслалцахаас хальж, бусдын буюу нийгмийн эрх ашгийн төлөө ямар нэг байгууллагад **сайн дураараа** болон **цалин хөлсгүйгээр** ажил үүрэг гүйцэтгэхийг хэлнэ.

Сайн дурын алба нь гурван сараас 12 сар хүртэлх хугацаагаар **бүтэн цагаар** болон **тасралтгүйгээр** нийгэмд ашиг тустай ямар нэгэн төсөлд оролцож ажил үүрэг гүйцэтгэх сонирхолтой дунд сургуулийн сурагч биш, 30 насанд хүрээгүй залуучуудад чиглэсэн байдаг. Сайн дурын ажилтан нь тухайн төслийн удирдагч нь биш, харин эсрэгээр ажил үүрэг гүйцэтгэхдээ заавар чиглэл авч байдаг. Сайн дурын алба нь нийгмийн буюу нийтийн салбарт хэрэгждэг. Залуучууд албан бус боловсролын хүрээнд хязгаарлагдмал цаг хугацааны туршид Люксембург, эсхүл гадаад оронд бүтэн цагаар нийгмийн төслүүдэд ажил үүрэг гүйцэтгэх боломжтой юм.<sup>88</sup>

Люксембургт сайн дурын албыг 2007.10.31-ний өдрийн хуулиар зохицуулж, халаасны мөнгө болон амьжиргааны зардлын нөхөн олговрыг тогтоон нийгмийн даатгалын гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэдэг. Үндэсний залуучуудын холбоо<sup>89</sup> (ҮЗХ) нь сайн дурын албыг тохируулан зохицуулж байдаг.

ҮЗХ-ноос 4 сайн дурын албаны хөтөлбөр санал болгож хэрэгжүүлдэг. Үүнд:

- Сайн дурын чиглүүлэх алба
- Европын сайн дурын алба
- Хөгжлийн хамтын ажиллагаан дахь сайн дурын алба
- Иргэний сайн дурын алба

**Сайн дурын чиглүүлэх алба.** Энэ хөтөлбөр нь 16-30 настай, дунд сургуулиа төгсгөж чадалгүй орхисон залуучуудыг нийгмийн асрамжаас авахуулаад соёл урлаг, бүр цаашилбал байгаль орчин хүртэлх төрөл бүрийн салбарт сонирхлын дагуу дахин чиглүүлэх зорилготой юм. Уг хөтөлбөрт оролцогч нь 3-12 сарын хугацаанд нийгмийн төсөлд бүтэн цагаар хамрагдах бөгөөд үйлдвэрийн дадлага хийж, хувийн сургагч багшийн удирдлага дор орон тооны ажилчин болох, улмаар мэргэжил эзэмшиж суралцах бэлтгэлээ хангадаг.

**Европын сайн дурын алба.** Энэ хөтөлбөрийн оролцогч нь 2-12 сарын хугацаанд нийгмийн халамжаас авахуулаад соёл урлаг, байгаль орчин, бүр цаашилбал спорт хүртэлх төрөл бүрийн салбарт ажиллана. Төгсгөлд нь сайн дурын алба түүнд европ даяар түнш олоход нь тусалдаг.

Европын сайн дурын алба (ЕСДА) нь практикум ч биш, сургалт ч биш, ажил олгож буй ч биш.

а\_\_\_\_\_

<sup>86</sup> Ehrenamt-германаар

<sup>87</sup> Freiwilligendienst-германаар

<sup>88</sup> “Орон тооны бус алба болон сайн дурын албаны ялгаа”-UNTERSCHIED ZWISCHEN EHRENAMT UND FREIWILLIGENDIENST-германаар

<http://www.benevolat.public.lu/de/espace-benevole/difference-benevolat-volontariat/index.html>

<sup>89</sup> Das Nationale Jugendwerk-германаар



ЕСДА-ыг гадаад хэл сурангаа зуны амралт эдэлж байгаа мэтээр ойлгож үл болно, харин ч цалин хөлстэй ажил гэж хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Оролцогч нь мэргэжилтэй байх шаардлагагүй, харин хувийн хүсэл эрмэлзэлтэй<sup>90</sup> байх хэрэгтэй.

**Хөгжлийн хамтын ажиллагаан дахь сайн дурын алба (ХХАСДА).** Энэ хөтөлбөр нь залуучуудыг хөгжиж буй улс оронд ажиллах боломж олгодог. Тусгай зөвшөөрөл бүхий илгээгч байгууллага болон Хөгжлийн туслалцааны төрийн бус байгууллага буюу Сайн дурын албаны байгууллага нь оролцогчийн өөрийн хайж олсон хүмүүнлэгийн төсөлд ажиллуулахаар залуучуудыг илгээдэг.

Хөтөлбөрийн оролцогч нь 18-30 настай, 3-12 сарын хугацаанд хөгжлийн хамтын ажиллагаанд оролцох хүсэлтэй байх ёстой.

Уг хөтөлбөрийг Гадаад хэргийн яамны Хөгжлийн хамтын ажиллагааны хэлтэс болон Хөгжлийн туслалцааны төлөө ТББ-ын Хамтын ажиллагааны дугуйлантай хамтран санаачилсан болно.

**Иргэний сайн дурын алба.** Энэ хөтөлбөр нь залуу хүмүүст иргэний чиглэлээр ажил үүрэг гүйцэтгэх бодит боломжуудыг олгож, залуучуудын дунд орон тооны бус ажил үүргийг хөхиүлэн дэмжих зорилготой юм. Эхний ээлжинд залуучуудад улсын хэмжээнд тодорхой төслүүдэд тогтсон хугацаагаар ажиллуулаад дараа нь орон тооны бус ажилтан болгох санаачилга юм.

## 2.2. ГЕРМАН

Германд сайн дураар, нийгэмд тустай болон цалин хөлсгүй хөдөлмөрлөх үйлсийг дэмжих санаачилга гарч 2011 онд Холбооны сайн дурын алба (ХСДА)-ны тухай хуулийг баталсан юм.<sup>91</sup> Уг албаны үндсэн зорилго нь нийтийн сайн сайхны төлөө, нэн ялангуяа нийгэм, экологи болон соёл, цаашилбал спортын салбарт нэгдэн нийлэх, иргэний болон гамшгаас хамгаалахад оршино. ХСДА нь 2011 онд цэргийн алба хаших журамт үүргийг цуцалснаас үүдэн Холбооны ЗГ-ын санаачилгаар байгуулагдсан юм. Тэрээр оршин байсан Сайн дурын нийгмийн жил<sup>92</sup> болон Сайн дурын экологийн жил<sup>93</sup> хэмээх сайн дурын албуудыг шинэчилж, иргэний үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм. Мөн өөр нэг зорилго бол ХСДА-ыг зөвхөн 27 хүртэл настай насанд хүрэгч гэж хязгаарлахгүйгээр нийгмийн өргөн хүрээнд хамруулах юм.

ХСДА нь Иргэний албаны<sup>94</sup> хөдөлмөрийн зах зээлийн саармагжуулалтын үндсэн зарчмыг уламжлан баримтална. Түүнд Гэр бүл болон иргэний нийгмийн асуудал хариуцсан Холбооны газар<sup>95</sup> (агентлаг) хяналт тавина. Тус агентлаг нь Иргэний албаны Холбооны газрын залгамжлагч бөгөөд төвлөрсөн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Тус алба нь насан туршид суралцах үүргийг дэмжинэ (хуулийн 1-р зүйл: Үүрэг чиглэл).

Боломжит сайн дурын ажилтан нь ЕБС-ийг дүүргэсэн, дээшээ насны хязгааргүй хүн байна (хуулийн 2.1 дэх хэсэг).

Хөдөлмөр эрхлэлт нь бүтэн цагаар явагдана. Гэхдээ 27-оос дээш настай хүний ажлын цагийг гарагт 20 цагаас доош оруулахгүйгээр бууруулж болно (хуулийн 2.2 дахь хэсэг).

Алба хаших хугацаа ердийн нөхцөлд 12 сар, онцгой төслийн хувьд 6-24 сар байж болно. Мөн 3 сарын хугацаатай блок байдлаар ширхэгчилж болно (хуулийн 2.3 ба 3.2 дахь хэсэг).

<sup>90</sup> Motivation-германаар

<sup>91</sup> Холбооны сайн дурын алба-Bundesfreiwilligendienst-германаар  
<https://de.wikipedia.org/wiki/Bundesfreiwilligendienst>

<sup>92</sup> Freiwilliges Soziales Jahr-германаар

<sup>93</sup> Freiwilliges Ökologisches Jahr-германаар

<sup>94</sup> Zivildienst-германаар

<sup>95</sup> Bundesamt für Familie und zivilgesellschaftliche Aufgaben (BAFzA)-германаар

27-оос дээш настай насанд хүрэгч 5 жил тутамд нэг удаа сайн дурын хөдөлмөр эрхлэх боломжтой (хуулийн 3.2 дахь хэсэг).

Байр, хоол, хувцас болон халаасны мөнгийг Залуучуудын сайн дурын алба (ЗСДА)-ны жишгээр олгоно (хуулийн 2.4 дэх хэсэг).

Ажлын газар нь нийгмийн болон байгаль орчны салбарт багтах бөгөөд нийгмийн сайн сайхны (зөвхөн нийгэмд ашиг тустай биш) төлөө институт байвал зохино (хуулийн 3.1 дэх хэсэг).

Семинарт суух хугацаа нь Залуучуудын сайн дурын албаны жишгээр гарагийн ажлын цагаас үл хамааран жилд 25 хоногоос хэтрэхгүй байна. 12 сараас ялгаатай алба хаших хугацааны хувьд сар тутамд семинарын 1 хоногоор нэмэгдүүлэх буюу хорогдуулна (хуулийн 4.3 дахь хэсэг).

Семинарын нэг гарагийг төрийн өмчийн Иргэний албаны сургуульд улс төрийн боловсрол эзэмшихэд зарцуулбал зохино (хуулийн 4-р зүйлийн тайлбар).

Сайн дурын ажилтанд сургагч багш оногдуулбал зохино. Гэхдээ хэнийг, хэрхэн томилохыг тодорхой заагаагүй (хуулийн 4.1 ба 2 дугаар зүйл). Ахмадын асрамжийн газруудад харин заавал анхаарах асуудал мөн (хуулийн 4-р зүйлийн тайлбар).

Нийгмийн даатгал нь ЗСДА-тай адил бөгөөд сайн дурын ажилтан нь халаасны мөнгөний дүнгээс үл хамааран хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчтай адил (ажлын газар нь ажил олгогчид ногдох хэсгийг төлнө) даатгуулна (хуулийн 17-р зүйл). Иймээс 2017.01.01-ний байдлаар шимтгэлийн хэмжээ доорх байдалтай байна. Үүнд: Тэтгэврийн даатгал 18.7%, Эрүүл мэндийн даатгал 14.6%, Халамжийн даатгал 2.55% (хүүхэдгүй бол 2.8%), Ажилгүйдлийн даатгал 3.0%.

Бүх ажлын газар нь Холбооны улсаар<sup>96</sup> хүлээн зөвшөөрөгдсөн байвал зохино. Өмнөх Иргэний албаны ажлын газруудыг автоматаар хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Харин шинэ ажлын газрыг Холбооны улс шууд хүлээн зөвшөөрөх, эсхүл тухайн Муж улсын зөвшөөрлөөр холбогдох Сайн дурын алба хүлээн зөвшөөрнө (хуулийн 7-р зүйл).

Ажлын газар болон Сайн дурын ажилтан хоёрын хамтын саналаар Холбооны улс болон Сайн дурын ажилтны хооронд хөдөлмөрийн хэлцэл хийгдэнэ. Энэ нь хоёр талтай албаны харилцаа бөгөөд нарийвчлан үзвэл, хөдөлмөрийн харилцаа биш юм. Учир нь сайн дурын алба нь гэрээний тал биш, харин Холбооны улсын үүрэг гүйцэтгэгч юм (хуулийн 9-р зүйл).

Бүх сайн дурын ажилтан нь тэдгээрийн эрх ашгийг Холбооны газар буюу агентлаг болон яамны эсрэг төлөөлөх 7 спикер болон тийм тооны орлогчийг жил бүр сонгодог. Сонгуулийг цахим хуудсаар он-лайнаар явуулдаг.

Ажлын газар нь сайн дурын ажилтан бүрт мэргэжил дээшлүүлсэн тухай тодорхойлолт гаргаж өгөх үүрэг хүлээдэг (хуулийн 11-р зүйл).

**Халаасны мөнгө.** Сайн дурын ажилтан (СДА) нь нийцтэй (хэмжээ тааруу) халаасны мөнгө авдаг. 2016 оны байдлаар, дээд хэмжээ нь 372 евро байна. Энэ нь ердийн тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох дээд хязгаарын 6%-тай тэнцүү юм. Хэрэв богиносгосон цагаар ажиллаж байгаа бол түүнд нь харгалзуулан хувь тэнцүүлэн хорогдуулна. Үүнээс гадна СДА нь хоол, байр болон хувцас авч болно, эсхүл холбогдох үнийн дүнг хүлээн авна. Нийгмийн даатгалын нөхөн олговрын журмын дагуу 2016 оны байдлаар, эдгээр үнийн дүнг сар тутамд дараах байдлаар тогтоосон байна. Үүнд: хоол 236 евро, байр 223 евро. Эдгээр мөнгөн болон эдийн дүн нь нийгмийн даатгал шимтгэл тооцогдох орлого юм. Сайн дурын алба хаах нь сайн

а \_\_\_\_\_

<sup>96</sup> Bund-германаар

дурын үүргийн хувьд цалин хөлсгүй ажил тул халаасны мөнгө нь цалин хөлс биш, харин зардлын нөхөн олговрыг илэрхийлдэг. Ажлын газар нь халаасны мөнгөний хэмжээг тогтоох бөгөөд нэмэгдэл мөнгө өгөх эсэхийг шийднэ. Ажлын газар нь тэтгэврийн, ослын, эрүүл мэндийн, халамжийн болон ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төлдөг.

**Санхүүжилт.** Нэг талаас Холбооны улс (зарим тохиолдолд бүхэлд нь), нөгөө талаас ажлын газар, эсхүл түүний холбогдох Сайн дурын алба зардлыг хариуцдаг. Сайн дурын албаны ажлын байр бүрт Холбооны улсаас 250 евро (25 хүртэл нас) буюу 350 евро (25-аас дээш нас)-ны татаас өгдөг. Гэхдээ үүнд зөвхөн халаасны мөнгө болон нийгмийн даатгалын шимтгэл (нийт дүнгийн ойролцоогоор 40%) багтсан байна. Хоол, байр болон хувцсыг ажлын газар хариуцах бөгөөд заавал өгөх үүрэг хүлээнэ.

**Шүүмж.** Иргэний албатай адилгүй, шүүмжлэл дагуулдаг нэг асуудал бол ажлын байранд ирж, буцах унааны зардал юм. Ажлын газар үүнийг олгох албагүй байдаг. Иймд сайн дураар алба хаагч маань энэ төрлийн зардалд халаасны мөнгөнийхөө дөрөвний нэгийг үрэх хэрэг гардаг.

### 2.3.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс нь дэлхийн хэмжээнд сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай бие даасан хуультай 70 гаруй орны нэг юм. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулийг 2005 онд, Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн зарлигийг 2006 онд тус тус баталжээ. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих үүднээс Үндэсний сайн дурын төв<sup>97</sup>, Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо зэргийг байгуулсан байна.

Солонгосын Үндэсний сайн дурын төв нь 139 гишүүн байгууллага, 250 харилцагч байгууллагатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг ба БНСУ-д сайн дурын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагууд гишүүнээр бүртгэгдсэн байна. Тус төв нь олон улсын сайн дурын байгууллагуудын гишүүн бөгөөд үндэсний хэмжээнд, цаашлаад олон улсын хэмжээнд сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах, сайн дурын ажилтны эрх ашгийг хуулиар хамгаалах зэрэгт төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулиар сайн дурын ажил, сайн дурын ажилтан, сайн дурын байгууллага, Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо, Үндэсний сайн дурын төвийн эрх, үүргүүдийг тодорхойлж, сайн дурын ажилтай холбогдох харилцааг зохицуулж байна.

Хуульд сайн дурын үйл ажиллагааг төрөөс хэрхэн дэмжих талаар тодорхой заалтуудыг оруулсан байна. Сайн дурын ажлыг дэмжих үндсэн бодлогыг хэлэлцэх зорилгоор Ерөнхий сайдын хяналтан доор Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороог холбогдох яам, агентлагуудын албан хаагчид болон шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байгуулна гэж заажээ. Хуулийг хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн зарлигаар тус хорооны бүтэц бүрэлдэхүүн, гишүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй заасан байна. Мөн түүнчлэн сайн дурын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах болон хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тодорхой тусгасан байна.

Аюулгүй байдал, төрийн захиргааны сайд нь Сайн дурын ажиллагааг дэмжих Үндэсний суурь төлөвлөгөөг таван жил тутам холбогдох төр захиргааны агентлагуудын удирдлагуудтай хамтран боловсруулах бөгөөд 2013 онд Сайн дурын ажлыг дэмжих үндэсний 2 дахь хөтөлбөрийг баталсан байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг хариуцсан албан хаагчид боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн биелэлтийг хариуцсан албан тушаалтнуудад хуульд тодорхой заасан хугацаанд танилцуулах үүргийг хуулиар ногдуулжээ.

а \_\_\_\_\_

<sup>97</sup> National Volunteer Center-Volunteering Korea [http://www.vkorea.or.kr/contents/english.html?sm=8\\_1](http://www.vkorea.or.kr/contents/english.html?sm=8_1)

Иргэдийн сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих, сайн дурын ажилтнуудын идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор улсаас жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдрийг Олон улсын сайн дурынхны өдөр, энэ өдрөөс эхлэн нэг долоо хоногийг Сайн дурын ажлыг дэмжих долоо хоног болгон зарласан байна. Байгууллагын удирдлагууд болон, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн захиргаанаас нийт ажилтнууд, суралцагч оюутан залуусыг сайн дурын ажилд оролцуулах, чиглүүлэх, зохион байгуулах, сайн дурын ажилд оролцох идэвхийг нэмэгдүүлэх, урамшуулах талаар хуульд заасан байна.

Сайн дурын ажилтнуудыг хамгаалах талаар сайн дурын байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагааны төвүүд нь сайн дурын ажилтнуудад зориулсан боловсрол, сургалт, аюулгүй байдлын цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд сайн дурын ажилтнуудыг аюулгүй орчинд сайн дурын үйл ажиллагаа явуулахад анхаарах ёстой гэж хуульд заажээ. Сайн дурын ажилтнуудыг даатгалд хамруулах, бэртэж гэмтсэн тохиолдолд нөхөн төлбөр олгох зэрэг бусад үйлчилгээг үзүүлэх ба Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа асуудалд хяналт тавьж ажилладаг байна.

БНСУ-д сайн дурын үйл ажиллагааг Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль болон Олон нийтийн албан ёсны сонгуулийн тухай хууль, Ашгийн бус, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх тухай хууль, Шагналын тухай хууль, Нийтийн өмч ба үйлчилгээний менежментийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулж байна.

(Дэлгэрэнгүйг доорх хуулиас үзнэ үү)

## САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ <sup>98</sup>

### 1 дүгээр зүйл. Зорилго

Энэ хуулийн зорилт нь сайн дурын ажлыг дэмжин, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Нийтлэг үндэслэл

Сайн дурын ажил нь доорх зарчмын дагуу явагдана:

1. Сайн дурын ажлыг иргэд, олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулна;
2. Сайн дурын ажил нь төлбөргүй, албадлагын бус, арилжааны бус зарчмын үндсэн дээр сайн дурын ажлыг нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, улс төр болоод шашны төвийг сахисан байр сууринаас зохион байгуулна;
3. Сайн дурын ажилд иргэд нийтээрээ нас, хүйс, мэдлэг, боловсрол, нийгмийн байдал, хөгжлийн бэрхшээл, оршин суугаа газар зэргийг үл харгалзан хамрагдах боломжтой байх;
4. Сайн дурын ажлыг төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

### 3 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

- **Сайн дурын ажил** гэдэг нь хувь хүмүүс болоод байгууллагууд нийгэм, үндэстэн хийгээд хүн төрөлхтний сайн сайхны төлөө өөрсдийн хүслээр, цаг хугацаа, хүчин чармайлт гарган, үнэ төлбөргүй явуулж буй үйл ажиллагааг хэлнэ.

а\_\_\_\_\_

<sup>98</sup> Framework act on volunteer service activities

[https://elaw.klri.re.kr/kor\\_service/lawView.do?hseq=31741&lang=ENG](https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=31741&lang=ENG)

- **Сайн дурын ажилтан** гэдэг нь сайн дурын ажил хийж буй хүнийг хэлнэ.
- **Сайн дурын байгууллага** гэдэг нь сайн дурын үйл ажиллагааг явуулах болон дэмжих зорилготой байгуулагдсан байгууллагыг хэлнэ.
- **Сайн дурын үйл ажиллагааны төв** гэдэг нь сайн дурын ажлыг дэмжих, хөгжүүлэх, харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой бизнес үйл ажиллагаа явуулахаар хууль, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу байгуулагдсан байгууллагыг хэлнэ.

#### **4 дүгээр зүйл. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны хүлээх үүрэг**

Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа нь сайн дурын үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулж иргэдийг сайн дурын ажилд оролцоход дэмжиж, туслах үүрэгтэй.

#### **5 дугаар зүйл. Улс төрийн болон бусад үйл ажиллагааг хориглох**

(1) Энэ хуулийн 14, 18, 19 дүгээр зүйлүүдэд заасан дэмжлэг авч буй сайн дурын байгууллага, сайн дурын үйл ажиллагааны төвүүд нь тухайн байгууллагынхаа нэрийн өмнөөс, байгууллагаа төлөөлөн, тодорхой нам, хувь хүний сонгуулийн кампанит ажилд оролцохыг хориглоно.

(2) “Сонгуулийн кампанит ажил” гэдэг нь Олон нийтийн албан ёсны сонгуулийн тухай хуулийн 58.1 дүгээр зүйлд заасны дагуу ямар ч сонгуулийн кампанит ажлыг хэлнэ.

#### **6 дугаар зүйл. Бусад хуультай холбогдох байдал**

Бусад хуульд өөрөөр заагаагүй бол сайн дурын ажилтай холбоотой бүхий л үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

#### **7 дугаар зүйл. Сайн дурын ажлын хамрах хүрээ**

Энэ хуулиар зохицуулах сайн дурын ажлын хамрах хүрээ:

1. Нийгмийн сайн сайхан, нийтийн эрүүл мэндийн төлөөх ажлууд;
2. Олон нийтийн хөгжил дэвшлийн төлөөх ажлууд;
3. Байгаль хамгаалах болон хүрээлэн буй орчноо хадгалах, хамгаалах ажлууд;
4. Хүүхэд хамгаалах, хөхиүлэн дэмжих болон нийгмийн зорилтот бүлгийнхний эрх ашиг, сонирхлыг хамгаалах ажлууд;
5. Мэдлэг боловсролыг дэмжих, зөвлөх ажлууд;
6. Энх тайвныг бэхжүүлэх, хүний эрхийг хамгаалах ажлууд;
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тодорхой заавар зөвлөмж гаргах ажлууд;
8. Замын хөдөлгөөний дүрэм, нийтийн хэв журам сахиулах дүрэм, журмын хэрэгжилтийг хянах ажлууд;
9. Гамшгийн үеийн тусламж, зохион байгуулалтын ажлууд;
10. Соёл урлаг, спорт, аялал жуулчлалыг дэмжих ажлууд;
11. Авлигаас урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлууд;
12. Шударга сонгууль явуулах кампанит ажлууд;
13. Гадаадын улс орнуудын болон олон улсын сайн дурын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах ажлууд;
14. Төрийн захиргааны салбарт захиргааны дэмжлэг үзүүлэх ажлууд.

#### **8 дугаар зүйл. Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо**

- (1) Сайн дурын ажлыг дэмжих үндсэн бодлогыг хэлэлцэх зорилгоор Ерөнхий сайдын хяналтан дор Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороог холбогдох яам, агентлагуудын албан хаагчид болон шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байгуулна.
- (2) Сайн дурын ажлыг дэмжих хороо нь дараах асуудлуудаар зөвлөлдөнө:



1. Сайн дурын үйл ажиллагаа, түүний зохицуулалт, хамтын ажиллагааг дэмжих бодлого боловсруулах асуудлаар;
  2. Сайн дурын ажиллагааг дэмжих Үндэсний суурь төлөвлөгөө болон жил бүрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө;
  3. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог сайжруулах асуудлаар;
  4. Сайн дурын үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой бусад шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар;
- (3) Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо нь (2) дугаар заалтад дурьдсан асуудлаар холбогдох агентлагуудтай зөвлөлдөн, тухайн асуудлаар ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.
- (4) Ерөнхийлөгчийн зарлигаар Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо болон ажлын хэсгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг шийдвэрлэнэ.

#### **9 дүгээр зүйл. Сайн дурын ажиллагааг дэмжих Үндэсний суурь төлөвлөгөө батлах**

- (1) Аюулгүй байдал, төрийн захиргааны сайд нь Сайн дурын ажиллагааг дэмжих Үндэсний суурь төлөвлөгөөг (цаашид “хөтөлбөр” гэнэ) таван жил тутам холбогдох төр захиргааны агентлагуудын удирдлагуудтай хамтран боловсруулах шаардлагатай.
- (2) Хөтөлбөр нь дараах асуудлуудыг хамарна:
1. Сайн дурын ажлыг дэмжих үндсэн чиглэл;
  2. Сайн дурын ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө (журам);
  3. Сайн дурын ажилтай холбоотой холбогдох төр захиргааны агентлагуудаас хэрэгжүүлэх бодлого;
  4. Сайн дурын ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүү бүрдүүлэх арга хэлбэр;
  5. Сайн дурын ажлыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах бусад асуудлууд.

#### **10 дугаар зүйл. Сайн дурын ажлыг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг боловсруулах**

Үндэсний хөтөлбөрт заасны дагуу холбогдох төр захиргааны байгууллагын тэргүүн орон нутгийн удирдлагатай хамтран сайн дурын ажлыг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

#### **11 дүгээр зүйл. Сургууль болон байгууллагуудаар сайн дурын ажлыг дэмжүүлэх нь**

- (1) Сургуулиуд нь сурагч, оюутнуудын сайн дурын үйл ажиллагааг дэмжин, чиглүүлж, зохион байгуулна.
- (2) Ажил олгогчид ажилтнуудынхаа сайн дурын үйл ажиллагааг дэмжинэ.
- (3) Сургууль, албан байгууллагуудын удирдлагууд сайн дурын ажилд оролцож буй сурагч, оюутнууд болон ажилтнуудаа сайшааж, урамшуулж болно.

#### **12 дугаар зүйл. Шагнал, урамшуулал**

Ерөнхийлөгчийн зарлигт зааснаар улс, нийгэмд нэн тустай сайн дурын ажил хийж гүйцэтгэсэн сайн дурын ажилтнууд, сайн дурын байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагааны төвүүдэд Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас шагнал урамшуулал олгож болно.

#### **13 дугаар зүйл. Сайн дурынхны өдөр болон Сайн дурын ажлыг дэмжих долоо хоног**

- (1) Иргэдийн сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжих, сайн дурын ажилтнуудын идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор улсаас жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдрийг Сайн дурын ажлыг дэмжих өдөр, энэ өдрөөс эхлэн нэг долоо хоногийг Сайн дурын ажлыг дэмжих долоо хоног болгон зарлана.



- (2) Сайн дурын өдөр болон Сайн дурын ажлыг дэмжих долоо хоногийн үйл ажиллагаатай асуудлаар Ерөнхийлөгч зарлиг гаргана.

**14 дүгээр зүйл. Сайн дурын ажилтнуудыг хамгаалах нь**

- (1) Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын ажилтнуудыг аюулгүй орчинд сайн дурын үйл ажиллагаа явуулахад анхаарна.
- (2) Сайн дурын ажилтнуудыг хамгаалах арга хэлбэр, нарийвчилсан зохицуулалт, үүнд, даатгалд хамруулах зэрэг асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

**15 дугаар зүйл. Сайн дурын ажлын зохион байгуулалтын талаар**

Сайн дурын байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагааны төвүүд нь сайн дурын ажилтнуудад зориулсан боловсрол, сургалт, аюулгүй байдлын талаар цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

**16 дугаар зүйл. Төрийн болон олон нийтийн өмчийг сайн дурын ажилд ашиглах нь**

Төрийн өмчийн тухай хууль, Нийтийн өмч ба бараа бүтээгдэхүүний менежментийн тухай хуулиудын тодорхой заалтуудыг үл харгалзан, Ерөнхийлөгчийн зарлигт онцгойлон тусгасан сайн дурын төслийг хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд, сайн дурын ажлыг дэмжих зорилгоор Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагааны төвүүдэд улсын хийгээд олон нийтийн өмчийг ашиглах, үнэ төлбөргүй түрээслэх боломжийг олгоно.

**17 дугаар зүйл. Солонгосын Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл**

- (1) Сайн дурын байгууллагууд нэгдэн Солонгосын Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөлийг байгуулж болно. Энэхүү байгууллага нь үндэсний хэмжээнд сайн дурын үйл ажиллагаа явуулахад доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
1. Гишүүн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, хэрэгжүүлж буй төслүүдийг дэмжих;
  2. Сайн дурын ажлыг дэмжих зорилгоор дотоод дахь олон нийтийн харилцаа холбоо болон гадаад дахь хамтын ажиллагааг сайжруулах;
  3. Сайн дурын ажлыг дэмжих талаар бодлого боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх;
  4. Сайн дурын ажлын асуудлаарх бодлогын баримт бичиг санаачлах;
  5. Сайн дурын ажилтай холбоотой мэдээлэл солилцох, дэмжлэг тусалцаа үзүүлэх;
  6. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны сайн дурын ажлыг дэмжихтэй холбоотой гаргасан төслүүдийг дэмжих.
- (2) Солонгосын сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл нь хамтын байгууллага юм.
- (3) Солонгосын сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл нь Аюулгүй байдал, төрийн захиргааны сайдын зөвшөөрөлтэйгөөр бүртгэгдэж үйл ажиллагаагаа эхэлнэ.
- (4) Солонгосын сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх шаардлагатай бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулна.

**18 дугаар зүйл. Сайн дурын байгууллагуудад үзүүлэх дэмжлэг**

Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлнэ. Тухайлбал, “Ашгийн бус, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх тухай хууль”-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсийг нөхөн олгох.

## **19 дүгээр зүйл. Сайн дурын үйл ажиллагааны төвүүдийн бүтэц, үйл ажиллагаа**

- (1) Засгийн газрын харьяа агентлагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд сайн дурын үйл ажиллагааны төв байгуулж болно. Энэ тохиолдолд сайн дурын үйл ажиллагааны төвүүд нь бие даасан байгууллага, эсхүл итгэмжлэгдсэн бусад ашгийн бус байгууллагуудын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.
- (2) Шаардлагатай тохиолдолд дээрх заалтыг үл харгалзан сайн дурын үйл ажиллагааны төвүүдийг Засгийн газрын харьяа агентлагууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд удирдан зохион байгуулна.
- (3) Засгийн газрын зүгээс сайн дурын үйл ажиллагааны төвүүд байгуулах болон сайн дурын үйл ажиллагаа явуулахыг дэмжих нь зүйтэй бөгөөд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь сайн дурын үйл ажиллагааны төвүүдэд шаардлагатай зардлыг олгох боломжтой.
- (4) Сайн дурын үйл ажиллагааны төвийн удирдлага (дарга)-д тавигдах шаардлага болон төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар бусад шаардлагатай асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

## **20 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

Энэ хуулийн 5 дугаар зүйлд зааснаар улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх үүргээ зөрчсөн сайн дурын байгууллага болон сайн дурын үйл ажиллагааны төв нь Олон нийтийн албан ёсны сонгуулийн тухай хуулийн 255 (1) 11-д заасан хариуцлага хүлээнэ.

## **САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ<sup>99</sup>**

### **2 дугаар зүйл. Сайн дурын ажлыг хөгжүүлэх хорооны бүтэц, бүрэлдэхүүн**

- (1) Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороо нь (цаашид “хороо” гэх) Сайн дурын ажлын тухай хуулийн (цаашид “хууль” гэх) 8.1-д зааснаар 1 дарга, 2 дэд даргын бүрэлдэхүүнтэй 30-аас доошгүй гишүүдээс бүрдэнэ.
  1. Албан тушаалын дагуу томилогдох (*Ex-officio*) гишүүд: Санхүү, эдийн засгийн сайд, Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн сайд, Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Жендэрийн эрх тэгш байдал, гэр бүлийн асуудал хариуцсан сайд, Төлөвлөлт ба төсвийн сайд, Төрийн бодлого зохицуулалтын сайд, Засгийн газрын мэдээллийн агентлагийн тэргүүн болон Засгийн газрын залуучуудын хорооны дарга нараас бүрдэнэ.
  2. Энгийн гишүүд: 13 дугаар зүйлд заасан Солонгосын сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөлөөс санал болгосон, сайн дурын ажлын талаар мэдлэг, туршлага бүхий этгээд, Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Жендэрийн эрх тэгш байдал, гэр бүлийн асуудал хариуцсан сайд, Засгийн газрын залуучуудын хорооны даргын санал болгосноор Ерөнхий сайдын томилсон бусад гишүүд.
- (2) Хорооны дарга нь Ерөнхий сайд байх ба дэд даргыг энгийн гишүүд болон Төрийн захиргаа, дотоод хэргийн сайд зөвшилцөн сонгоно.
- (3) Энгийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

### **3 дугаар зүйл. Хорооны үйл ажиллагаа**

- (4) Төрийн захиргаа, дотоод хэргийн яамны сайн дурын үйл ажиллагаа хариуцсан албан хаагч нь хорооны бичиг хэргийн ажлыг зохицуулж ажиллана.

a\_\_\_\_\_

<sup>99</sup> Enforcement decree

[http://www.vkorea.or.kr/contents/english\\_32.html?sm=8\\_3](http://www.vkorea.or.kr/contents/english_32.html?sm=8_3)

- (5) 5 дугаар зүйлд заасны дагуу Төрийн захиргаа, дотоод хэргийн яамнаас сайн дурын ажлын мэдлэг, туршлага бүхий мэргэжлийн зөвлөх томилон ажиллуулна. Энэ тохиолдолд судалгааны зардал болон замын зардлыг төсвөөс санхүүжүүлж болно.

#### **4 дүгээр зүйл. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

- (1) 8 (3)-д зааснаар Сайн дурын үйл ажиллагааг дэмжих ажлын хэсэг нь 25-аас доош тооны гишүүдээс бүрдэнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сонгох зарчим нь хорооны бүрэлдэхүүнтэй адил байна.
- (2) Ажлын хэсгийн дарга нь Төрийн захиргаа, дотоод хэргийн 2 дахь дэд сайд байх бөгөөд, дэд дарга нь энгийн гишүүд болон Төрийн захиргаа, дотоод хэргийн яамнаас томилогдон ажиллаж буй албан тушаалтан нар зөвшилцөн сонгоно.

#### **5 дугаар зүйл. Сайн дурын ажиллагааг дэмжих Үндэсний суурь төлөвлөгөө**

- (1) Төрийн захиргаа, дотоод хэргийн яам нь энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Сайн дурын ажлыг дэмжих үндсэн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхээс 1 жилийн өмнө батална.

#### **6 дугаар зүйл. Хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх**

- (1) 10 дугаар зүйлд зааснаар жил бүрийн 12 дугаар сарын сүүлчээр хотын захирагч, мужийн удирдлагууд нь сайн дурын ажлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан танилцуулна.
- (2) 1 дүгээр сарын сүүлээр Засгийн газрын харьяа холбогдох байгууллагуудын удирдлагууд, хотын захирагч болон засаг дарга нар Төрийн захиргаа, дотоод хэргийн сайдад тухайн онд хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө танилцуулна. Төрийн захиргаа, дотоод хэргийн сайд эдгээр төлөвлөгөөг нэгтгэн Сайн дурын ажлыг хөгжүүлэх хороогоор хэлэлцэн 3 дугаар сарын сүүлчээр эргэн мэдэгдэнэ.
- (3) Хотын захирагч, муж, дүүргийн удирдлагууд жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор өнгөрсөн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан Засаг дарга нарт танилцуулсны дараа 1 дүгээр сарын сүүлч гэхэд Төрийн захиргаа, дотоод хэргийн сайдад танилцуулсан байх шаардлагатай.
- (4) 3 дугаар зүйлд зааснаар Ерөнхий сайд нь Төрийн захиргаа, дотоод хэргийн сайдад төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх эрхийг олгож, үр дүнг хороонд танилцуулахыг зөвшөөрч болно. Шаардлагатай тохиолдолд сайд нь судалгааны байгууллагуудтай зөвлөлдөн судалгаа хийлгэж болно.

#### **7 дугаар зүйл. Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар**

5, 6 дугаар зүйлд заасны дагуу шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын ажлыг дэмжих ерөнхий болон жилийн ажлын төлөвлөгөөг батлахад шаардлагатай мэдээлэл, санал авах зэргээр төрийн байгууллагууд, хувийн хэвшил болон сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

#### **8 дугаар зүйл. Шагнал урамшуулал**

Сайн дурын ажлын тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар шагналын эзнийг тодруулах процесс, одонгийн зэргийг “Шагналын тухай хууль”-аар зохицуулна.

#### **10 дугаар зүйл. Сайн дурын ажилтны даатгал**

- (1) Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа нь сайн дурын байгууллагууд болон төвүүдийг сайн дурын ажлын аюулгүй байдалтай холбоотой сургалт явуулах зэрэг

шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулахыг зөвшөөрч болно.

- (2) 14.2-т заасан сайн дурын ажилтнуудад үзүүлэх хамгаалал нь дараахад хамаарна:
1. Сайн дурын ажилтнуудыг сайн дурын үйл ажиллагаа явуулж байх явцад биед нь гэмтэл учрахаас;
  2. Сайн дурын ажилтнуудын үйл ажиллагааны явцад учрах эдийн засгийн хохирлоос;
  3. Сайн дурын ажилтан үйл ажиллагаа явуулж байх явцах гуравдагч этгээдийн бие болон эд хөрөнгөд хохирол учруулахаас.
- (3) Ашгийн бус байгууллагыг дэмжих хуулийн дагуу, Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас сайн дурын ажилтнуудыг хамгаалах зорилгоор даатгалд хамруулах болон бусад үйлчилгээ үзүүлж болно. Үүнд:
1. Сайн дурын үйл ажиллагаанд хамрагдаж явцад нас барсан, бэртэж гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгох, эмчилгээний зардал, эмнэлгийн төлбөр, хагалгааны төлбөр зэргийг олгоно.
  2. Сайн дурын үйл ажиллагааны явцад гуравдагч этгээдийн бие болон эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөр олгоно.
- (4) 3 дугаар зүйлд заасны дагуу Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд сайн дурын ажилтнуудыг даатгалд хамруулах асуудлыг журмаар тогтооно.

## **11 дүгээр зүйл. Сургалт**

Сайн дурын байгууллага болон төвүүд нь 15 дугаар зүйлд заасны дагуу сайн дурын ажилтнуудад сайн дурын үйл ажиллагаа явуулах аюулгүй байдлын сургалтын захиалгыг холбогдох боловсрол, сургалтын байгууллагад гаргаж болно.

## **12 дугаар зүйл. Улсын болон олон нийтийн өмчийг сайн дурын ажилд ашиглах тухай**

- (1) Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа сайн дурын байгууллагууд болон төвүүдийг доорх төслүүдийг хэрэгжүүлсэн тохиолдолд улсын болон олон нийтийн өмч хөрөнгийг үнэгүй ашиглах болон зээлэхийг зөвшөөрнө.
1. Олон улсыг хамарсан төслүүд;
  2. Гамшгийн үеэр тусламж дэмжлэг үзүүлэх, сэргээн босгох төслүүд;
  3. Сайн дурын байгууллага болон төвүүдээс хэрэгжүүлж буй бусад төслүүд. Энэ тохиолдолд улсын болон нийтийн өмч хөрөнгийг үнэгүй түрээслэх болон ашиглах хугацаа 1 жилээс хэтрэхгүй байна;
  4. Улсын болон нийтийн өмчийг үнэгүй түрээслэх болон ашиглах асуудал нь Улсын эд хөрөнгийн тухай хууль, Нийтийн өмч ба үйлчилгээний менежментийн тухай хуулиар зохицуулагдана.

## **13 дугаар зүйл. Солонгосын сайн дурын байгууллагын гишүүд**

- (1) Хуулийн 17 дугаар зүйлд заасан Солонгосын Сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэнэ) гишүүд нь:
1. Сайн дурын үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагын төлөөлөгчид;
  2. Солонгосын Сайн дурын ажлыг хөгжүүлэх хорооны Удирдлагын зөвлөлөөс санал болгосон ажилтан байна.
- (2) Зөвлөл нь 20-оос багагүй, 50-аас ихгүй ажилтнуудтай байх бөгөөд 1 гүйцэтгэх захирал, 2 ажиглагчтай байна.
- (3) Зөвлөлийн ажилтан хорооноос баталсан дүрмийн дагуу сонгогдоно.
- (4) Зөвлөлийн ажилтнуудын бүрэн эрхийн хугацаа 2 жил байх ба дахин сонгогдож болно.
- (5) Ажилтны мэдлэг чадвар, сонгох зарчим, Зөвлөлийн үйл ажиллагааг Зөвлөлийн дүрмээр шийдвэрлэнэ.

## 2.4. ФИЛИППИН

Филиппин Улс нь сайн дурын үйл ажиллагааг 2007 онд батлагдсан "Сайн дурын үйл ажиллагааг бэхжүүлэх, Хөдөөгийн хөгжлийг дэмжих стратегийг тогтоох тухай 9418 тоот хууль" болон тус дагаж гарсан хэрэгжүүлэх журмаар зохицуулагдаж байна. Сайн дурын үйл ажиллагааг зохицуулсан тус хууль нь холбогдох нэр томьёо болон сайн дурын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын хүрээг тогтоосон 16 зүйл, Сайн дурын үйл ажиллагааны тухай №9418 хуулийг хэрэгжүүлэх журам нь нарийвчилсан зохицуулалт бүхий 8 бүлэг 22 зүйлээс бүрдэж байна.

Тус улс нь сайн дурын үйл ажиллагааг өргөн хүрээнд тодорхойлж, нарийвчлан зохицуулдаг бөгөөд хүн бүр сайн дурын үйлсийг амьдралынхаа хэв маяг болгон хөгжүүлэх нь нийгмийн шударга ёс, эв нэгдэл, тогтвортой хөгжил, сайн сайханд хүргэх нэг үндэс гэж тодорхойлон "Сайн дурын ажиллагааны үндэсний хөтөлбөр"-ийг батлан, хэрэгжүүлж байна.

Хуульд сайн дурын үйл ажиллагааг төрөөс бүхий л талаар дэмжих, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий төрийн байгууллагууд болох Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг, салбар хоорондын зөвлөлдөх байгууллагуудын эрх үүрэг, оролцоог дэлгэрэнгүй тусгаж өгсөн байна. Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг нь сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар заасан байна.

Дотоодын болон гадаадын сайн дурын байгууллага нь хөтөлбөр, үйл ажиллагаагаа Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон заавар, журмын дагуу хэрэгжүүлдэг байна.

Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь сайн дурынхан болон сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх, сайн дурын үйл ажиллагааны мэдээлэл, туршлага хуваалцах үүднээс үндэсний бүртгэл, мэдээллийн сүлжээг үүсгэж хөгжүүлэхээр хуульд тусгасан байна.

Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын сайн дурын ажилтан болон түүний гэр бүл, үр хүүхдэд олон удаа нэвтрэх виз олгож, визийн болон холбогдох бусад хураамжаас чөлөөлж болохоор хуульд заасан бөгөөд уг шийдвэр нь нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь өөрийн болон харьяа нутаг дэвсгэрт нь хэрэгжүүлсэн сайн дурын үйл ажиллагааны талаарх мэдээллийг сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

Төрийн бус байгууллагууд нь гадаадын сайн дурын ажилтныг ажиллуулах тохиолдолд сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад мэдэгдэж сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь гадаадын ажилтныг бүртгэх, бичиг баримтын болон үйл ажиллагаагаа тайлагнахтай холбогдсон нэмэлт журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна.

### **"САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙГ ТОГТООХ" ТУХАЙ 9418 ТООТ ХУУЛЬ**

#### **1 дүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл.** Энэхүү хууль нь Сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөдөөгийн хөгжлийн стратегийг тогтоох тухай хууль (Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль 2007/-ийн 14 дүгээр зүйлд заасны дагуу батлагдсан.



Хуулийн хоёр, гуравдугаар зүйлд бодлого, зорилго зорилтоо тодорхойлсон бөгөөд Филиппиний нийгмийн олон салбаруудын оролцоо, түүнчлэн нийтийн болон иргэний асуудлаарх олон улсын болон гадаадын сайн дурын байгууллагуудын оролцоог дэмжих, үндэсний хөгжил, олон улсын харилцан ойлголцлыг бий болгох үүднээс сайн дурын үйл ажиллагааны стратегийг батлах, сайн дурын үйл ажиллагааны практик нөлөөг сайжруулах нь төрийн бодлого мөн гэж үзжээ. Сайн дурын үйлсийг амьдралын хэв маяг болгон хөгжүүлэх нь “Филиппиний иргэн бүрийг нийгмийн шударга ёс, эв нэгдэл, тогтвортой хөгжилд хүргэх нэг үндэс юм” гэж тодорхойлжээ.

**3 дугаар зүйл.** Дээр дурьдсан бодлогыг хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлжээ.

- a) Орон нутгийн болон үндэсний хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, тэдгээрийн талаарх ойлголтыг бэхжүүлэх үүднээс улс орны сайн дурын салбарын үйл ажиллагааг үр өгөөжтэй хамтын ажиллагаанд шилжүүлэх, түүний үндсэн зарчмуудыг онцлон тэмдэглэсэн сайн дурын үйл ажиллагааны үндсэн хүрээг тодорхойлох;
- b) Нийгэмд үзүүлэх сайн дурынхан болон сайн дурын байгууллагуудын үүрэг, хувь нэмрийг онцлон тэмдэглэх, тэдний эрх, эрх чөлөөг хамгаалах механизмыг тогтоох замаар сайн дурын үйл ажиллагааны байгууллагуудад таатай орчинг бүрдүүлэх;
- c) Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагийн (*The Philippine National Volunteer Service Coordinating Agency-PNVSCA*) бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хуулийн биелэлтэд хяналт тавих нөхцөл, боломжоор хангах.

**4 дүгээр зүйл.** Сайн дурын үйл ажиллагааны (Volunteer act) хуулийн 4-р зүйлд дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгохоор заасан байна.

**Сайн дурын үйлс** гэж хариу нэхэхгүйгээр, нийтийн сайн сайхны төлөө нийгмийн хөгжил, бизнес, компанийн чиг баримжаа, амлалт зэргээс урган гарч тусламж үзүүлж байгаа болон хүлээн авч буй талуудад хөгжлийн боломжит орчныг хангахад чиглэсэн оролдлого, харилцан тусалцааны уламжлалт хэлбэрийг багтаасан өргөн хүрээ бүхий үйл ажиллагаа, үйлдлийг;

**Сайн дурынхан** гэж явуулж буй үйл ажиллагаа нь нийтийн сайн сайхан байдлын төлөө бусдад болон өөрсдөд нь ач холбогдолтой, үр өгөөжтэй гэдэгт итгэсэн нийгмийн хөгжил, бизнес, аж ахуйн нэгжийн чиг баримжаа, амлалт, эсхүл итгэл үнэмшлээс үүдэлтэй шалтгааны улмаас бүрэн болон бүрэн бус хэлбэрээр нийгмийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн, бүлгийг;

**Сайн дурын байгууллага** гэж нийгмийн сайн сайхны төлөө мэдээлэл, чадавх суулгах, өмгөөлөл, сүлжээ үүсгэх зэргээр хязгаарлагдахгүйгээр өөрсдөө, эсхүл бусад байгууллагаар дамжуулан үйлчилгээ үзүүлдэг өөрсдийн болон бусад байгууллага, бүлгийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт сайн дурын ажилтнуудыг хамруулж, сургах, байршуулах, ажиллуулах үйл ажиллагаа явуулдаг дотоодын болон гадаадын бүлгийг;

**Сайн дурын салбар** гэж сайн дурынхны зохион байгуулалтад орж, орон нутгийн болон үндэсний хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, тэдгээрийн талаарх ойлголтыг таниулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй нийгмийн салбарыг;

**Бүртгэл** гэж хамтын ажиллагаа, мэдээлэл хуваалцах, баримтжуулах зорилгоор сайн дурын ажилтан, эсхүл сайн дурын байгууллагуудыг Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагаас бүртгэх үйл явцыг;

**Сайн дурын ажиллагааны үндэсний хөтөлбөр** гэж сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан үндэсний хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, түүний талаарх ойлголтыг



түгээх, түүнд хүрэхэд чиглэсэн хамтын үйл ажиллагааг хэлнэ хэмээн тодорхойлсон байна.

## **2 дугаар бүлэг. Сайн дурын үйл ажиллагааны арга хэлбэр**

### **5 дугаар зүйл. Хувийн хэвшил дэх сайн дурын үйл ажиллагааны үүрэг, хэрэгжүүлэх арга зам:**

Академийн хүрээн дэх сайн дурын үйл ажиллагаа нь сайн дурын ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэхийн зэрэгцээ зорилтот бүлгүүд, үйлчлүүлэгчид, академийн хүрээнд техник, технологи хуваалцах, техникийн туслалцаа үзүүлэх, боловсролын чанар, сургалтын хөтөлбөрийн арга зүй, аргачлалыг сайжруулах зэрэг болон бусад арга хэмжээг хамаарна.

Нийгмийн хариуцлагын илэрхийлэл болох бизнесийн салбар дахь сайн дурын үйл ажиллагаа нь ажилчдаас компанийн гадаад дотоод харилцаа, хүрээлэлд өөрийн цаг хугацаа, ур чадвар, мэдлэгээ зориулан ажиллах, тухайн компаниас хүлээн зөвшөөрсөн аливаа үйл ажиллагаа юм. Эдгээр сайн дурын үйл ажиллагаанд материаллаг зүйлсээр туслах, мөнгөн хөрөнгө босгох; нэг удаагийн үйл ажиллагаа тусламжийн үйл ажиллагаа; байгаль орчинд чиглэсэн ажлууд; эрүүл мэнд, эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа, тэтгэлэгт хөтөлбөр; тодорхой бизнес, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр туршлага хуваалцах, тодорхой тохиолдол дээр суурилан зөвлөгөө өгөх, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг болон бусад үйл ажиллагааг хамаарна.

Ашгийн бус байгууллагын сайн дурын үйл ажиллагаанд нийгмийн эмзэг бүлгүүдийн асуудлуудыг тогтоох, бий болж буй шалтгааныг тайлбарлан таниулах, тухайн бүлгүүд дахь хувь хүний хөгжих боломжийг нээхэд чиглэсэн нэмэгдэл үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаанууд хамаарна.

### **6 дугаар зүйл. Гадаадын сайн дурын байгууллагын сайн дурын үйл ажиллагаанд оролцох хэлбэр**

Гадаадын сайн дурын байгууллагуудын сайн дурын үйл ажиллагаа гэдэгт нийгэм-соёлын солилцоо, техникийн хамтын ажиллагааны хүрээн дэх хөгжлийн хувьд хоцрогдмол, хязгаарлагдмал орон нутгуудад техникийн туслалцаа үзүүлэх болон бусад арга хэмжээг хамруулна. Гадаадын сайн дурын байгууллага нь хөтөлбөр, үйл ажиллагаагаа Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон заавар, журмын дагуу хэрэгжүүлнэ.

### **3 дугаар бүлэг. 7 дугаар зүйл. Засгийн газрын үүрэг**

Сайн дурын үйл ажиллагаан дахь төрийн чиг үүргийг хуулийн 3-р бүлэгт заахдаа: “Засгийн газар нь үндэсний хөгжил, олон улсын хамтын ажиллагааны хүрээн дэх сайн дурын салбарын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх, зохицуулах, хөнгөвчлөх, дэмжих чиглэлээр ажиллана. Үүнийг сайн дурын салбарын үйл ажиллагаа хэрэгжих таатай орчныг бий болгож, хэрэгжүүлнэ” гэж заажээ.

### **4 дүгээр бүлэг. Сайн дурын үйл ажиллагаатай холбоотой асуудал эрхэлсэн төрийн байгууллагын чиг үүрэг**

### **8 дугаар зүйл. Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг**

Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг байна.

### **9 дүгээр зүйл. Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагийн бүрэн эрх**

Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг нь сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллагааг хуульд заасан байна. Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг нь дараах бүрэн эрхтэй байна:

- 1) Үндэсний хөгжлийн үзэл баримтлалтай нийцсэн сайн дурын үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн бодлого, зөвлөмжийг боловсруулах, хяналт тавих;
- 2) Үндэсний хөгжлийн зорилгод сайн дурын үйл ажиллагааг нийцүүлэх үүднээс сайн дурын үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг хянах, үнэлэх;
- 3) Олон улсын сайн дурын үйлчилгээнд хамаарах мэдээллийн дүн шинжилгээ хариуцсан нэгжийг байгуулах;
- 4) Байгууллага, олон нийтийн зүгээс хэрэгжүүлж болох сайн дурын үйл ажиллагааны загвар, хэлбэрийг боловсруулах, хэрэгжүүлэх;
- 5) Сайн дурын байгууллагын үйл ажиллагааг чадавхжуулах, техникийн туслалцаа үзүүлэх;
- 6) Сайн дурын үйлсийг сурталчлах, хүлээн зөвшөөрөх талаар ухуулга сурталчилгаа явуулах;
- 7) Сайн дурын байгууллагуудын үндэсний сүлжээ байгуулах, НҮБ-ын Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн байгууллага зэрэг орон нутгийн болон гадаадын засгийн газар, хувийн хэвшлийн сайн дурынхны хооронд харилцаа тогтоох;
- 8) Байгууллагын харьяа бүх сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэх.

**10 дугаар зүйл.** Агентлаг нь энэхүү дүрмийг төрийн албан ёсны хэвлэлд хэвлэгдсэнээс хойш 90 хоногийн дотор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны санхүүжилтийн төлөвлөгөөг гарган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад хүргүүлнэ.

#### **5 дугаар бүлэг. 11 дүгээр зүйл. Салбар хоорондын зөвлөх байгууллага**

Салбар хоорондын зөвлөх байгууллага (*Multi-Sectoral Advisory Body-MSAB*) нь дараах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ:

- Үндэсний эдийн засаг, хөгжлийн газар (*NEDA*);
- Боловсролын яам (*DepEd*);
- Гадаад хэргийн яам (*DFA*);
- Хууль зүйн яам (*DOJ*);
- Дотоодын ба орон нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөлөл (*DILG*);
- Нийгмийн халамж, хөгжлийн газар (*DSWD*);
- Дээд боловсролын комисс (*CHED*);
- Ерөнхийлөгчийн Тамгын газар (*PMS*);
- Аж ахуйн нэгжийн салбарын төлөөлөл;
- Хувийн хэвшлийн салбарын төлөөлөл;
- Төрийн бус байгууллагын төлөөлөл.

Төрийн байгууллагыг төлөөлөх гишүүд нь байнгын, бусад салбарыг төлөөлөх гишүүд нь 2 жилийн хугацаагаар тус тус томилогдоно. Төрийн байгууллагыг төлөөлөх гишүүн нь тухайн яам, агентлагийн дэд сайд, дарга бусад салбарыг төлөөлөх гишүүн нь тухайн байгууллагын дээд албан тушаалтан байхаар хуульд заажээ.

Салбар хоорондын зөвлөх байгууллага (СХЗБ)-ыг энэхүү дүрэм хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор зарлан хуралдуулна. СХЗБ-ын байнгын гишүүд нь бусад төлөөлөгчдийг сонгоно. Төрийн байгууллагаас бусад салбараас сонгогдох гишүүд нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- 1) Нэр хүнд бүхий үндэсний байгууллага байх;
- 2) Үнэт цаасны асуудал эрхэлсэн төрийн байгууллагад бүртгэлтэй байх;

- 3) Улс, орон нутгийг хамарсан газар зүйн болон боловсон хүчний сүлжээ, нөөцтэй байх;
- 4) Байнгын гишүүдээс тогтоосон бусад шалгуур.

СХЗБ-ын тэргүүн нь сонгогдсон байгууллагад албан ёсоор урилга илгээх бөгөөд урилгыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд дараагийн хамгийн өндөр санал авсан байгууллагыг урина. СХЗБ-ын тэргүүнийг гишүүд дундаас 2 жилийн хугацаагаар сонгоно. Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагийн дарга (*ex-officio* буюу албан тушаалын дагуу) нь СХЗБ-ын Дэд дарга байх бөгөөд Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлаг нь СХЗБ-ын Тамгын газрын үүргийг гүйцэтгэнэ.

СХЗБ нь өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах холбогдох журмыг батална.

## **12 дугаар зүйл. Салбар хоорондын зөвлөх байгууллагын чиг үүрэг**

Салбар хоорондын зөвлөх байгууллага нь Үндэсний сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, сайн дурын үйл ажиллагааны асуудлаар зөвлөх болон техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, нийгэм, сайн дурын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, сайжруулах чиг үүргийг гүйцэтгэнэ.

## **6 дугаар бүлэг. Тусгай зохицуулалт**

### **13 дугаар зүйл. Үндэсний сайн дурын үйл ажиллагааны бүтэц, хэлэлцүүлэг**

1. Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь сайн дурынхан болон сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх, сайн дурын үйл ажиллагааны мэдээлэл, туршлага хуваалцах үүднээс үндэсний бүртгэл, мэдээллийн сүлжээг үүсгэж, хөгжүүлнэ. Энэ журмын 4.3-т зааснаар орон нутгийн болон гадаадын сайн дурын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд нь сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон журмын дагуу бүртгүүлнэ.

2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь өөрийн болон харьяа нутаг дэвсгэрт нь хэрэгжүүлсэн сайн дурын үйл ажиллагааны талаарх мэдээллийг сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

Гадаадын сайн дурын ажилтан нь дараах зүйлийг баримтална. Үүнд:

- a) Төрийн захиргааны байгууллагууд нь гадаадын сайн дурын ажилтныг ажиллуулах тохиолдолд Филиппиний Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагтай зөвшилцөн, сайн дурын ажилтныг холбогдох ажилд хуваарилах ба сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь гадаадын ажилтныг бүртгэх, бичиг баримтын болон үйл ажиллагаагаа тайлагнахтай холбогдох нэмэлт журмыг боловсруулан гаргасан байна.
- b) Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудтай гадаадын сайн дурын ажилтны бүртгэл, хяналттай холбогдох асуудлаар санамж бичиг байгуулна.
- c) Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй мөн дээрхтэй адил санамж бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Дээрх санамж бичгийг байгуулах хүртэлх хугацаанд гадаадын сайн дурын ажилтантай холбогдох бүртгэл, хяналтын асуудлыг сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь эрхлэн гүйцэтгэнэ.

Орон нутгийн болон гадаадын сайн дурын үйл ажиллагааны байгууллагуудын мэдээлэл, үйл ажиллагааны товхимлыг жил бүр хэвлэн гаргадаг.

Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь сайн дурын үйл ажиллагааны байгууллагуудын дунд сайн дурын үйл ажиллагаатай холбогдох мэдээлэл хуваалцах, сүлжээ байгуулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулна.

#### **14 дүгээр зүйл. Сайн дурын үйл ажиллагааг боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах**

- 1) Сайн дурын үйл ажиллагаа, түүний агуулга нь боловсролын бүх шат, салбар түвшинд холбогдож, тусгагдсан байна;
- 2) Боловсролын яам, Дээд боловсролын болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд нь боловсролын бүх түвшинд сайн дурын үйл ажиллагааг тусгах гол чиглэлүүдийг тодорхойлно;
- 3) Дээрх байгууллагууд нь сайн дурын үйл ажиллагааны талаар сургалт, арга зүйн материал Сайн дурын үйл ажиллагааны үндэсний зохицуулах агентлагтай хамтран боловсруулна;
- 4) Дээрх байгууллагууд нь төрийн болон хувийн их, дээд сургууль, сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн сургалтын төвүүд зэрэг албан болон албан бус боловсролын бүхий л шатанд мөрдөгдөх сайн дурын үйл ажиллагааны сургалтын хөтөлбөр, гарын авлага зааварчилгаа гаргах, мөрдүүлэх удирдамж боловсруулна;
- 5) Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь дээрх байгууллагуудтай хамтран боловсролын салбар дахь сайн дурын үйл ажиллагааны сургалт, арга зүйн материалд хяналт тавьж, шинэчлэх арга хэмжээ авна.

#### **15 дугаар зүйл. Төрийн байгууллагууд болон орон нутгийн захиргааны байгууллагууд дахь сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр**

Төрийн албаны сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр нь төрийн байгууллага, орон нутгийн удирдлагын нэгж дахь хувийн хэвшлийн сайн дурын үйл ажиллагааны үндэс суурь болно. Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албанд мөрдөгдөх сайн дурын үйл ажиллагаатай холбогдох заавар, журмыг батлан мөрдүүлж, төрийн албан дахь сайн дурын үйл ажиллагаанд оролцсон байгууллага, албан хаагчдын мэдээллийн бүртгэж, төрийн салбар дахь сайн дурын үйл ажиллагааны сайн туршлагыг баримтжуулна.

#### **16 дугаар зүйл. Сайн дурын үйл ажиллагааны урамшуулал**

Төрийн болон төрийн бус байгууллагуудын сайн дурын ажилтанд тэтгэмж, даатгал, сургалт, Филиппиний гадаад дахь ажиллах хүчинд олгох давуу эрхтэй адил эрхийг Филиппиний гадаад дахь сайн дурын ажилтанд олгох зэрэг болон бусад байдлаар урамшуулал олгож болохоор заасан байна.

Сайн дурын ажилтан нь энэхүү дүрэмд заасан, эсхүл сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон журмын дагуу бүртгэлд хамрагдсанаар сайн дурын ажилтны эрх, үүргийг хүлээнэ.

Гадаадын сайн дурын ажилтныг ажиллуулж байгаа, эсхүл гадаадад сайн дурын үйл ажиллагаа явуулдаг сайн дурын үйл ажиллагааны байгууллага нь өөрийн ажилтан, хэрэгжүүлэх гэж байгаа сайн дурын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хөтөлбөрт зөвшөөрөл авах, хяналт хийлгэх зорилгоор сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад урьдчилан танилцуулна.

Дээрх зорилгоор сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь сайн дурын үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлан мөрдүүлнэ.

## **17 дугаар зүйл. Гадаадын сайн дурын ажилтанд виз олгох**

Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын сайн дурын ажилтан болон түүний гэр бүл, үр хүүхдэд олон удаа нэвтрэх виз олгож, визийн болон холбогдох бусад хураамжаас чөлөөлж болно.

Гадаадын сайн дурын ажилтанд олон удаа нэвтрэх виз олгож, холбогдох хураамжаас чөлөөлсөн шийдвэр нь нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд дараах тохиолдолд дахин виз хүснэ.

- а) Гадаадын сайн дурын ажилтан нь сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад бүртгэл бүхий гадаадын сайн дурын байгууллагын гишүүн, эсхүл энэ журмын 13.2-т заасан бол;
- б) Гадаадын сайн дурын ажилтны ажиллаж байгаа орон нутгийн сайн дурын байгууллага нь сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан бол;
- в) Гадаадын сайн дурын үйл ажиллагааны байгууллага нь сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон журмаар гадаадын сайн дурын ажилтныг ажиллуулах бол.

Гадаадын сайн дурын ажилтанд дараах журмаар холбогдох ангиллын виз олгоно.

- а) Гадаадын сайн дурын үйл ажиллагааны байгууллага нь сайн дурын ажилтны хувийн мэдээлэл, бичиг баримтыг сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагад хүргүүлнэ;
- б) Сайн дурын ажилтан сайн дурын үйл ажиллагаанд тэнцэх эсэх болон орон нутгийн сайн дурын байгууллагаас тухайн ажилтныг хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгана;
- в) Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллага нь сайн дурын ажилтанд холбогдох ангиллын виз олгохыг Гадаад хэргийн яаманд хүснэ.
- г) Гадаад хэргийн яамнаас холбогдох элчин сайдын яам, консулын газарт материалыг хүргүүлнэ. Элчин сайдын яам, консулын газраас сайн дурын ажилтанд виз олгоно.

Филиппин Улсад оршин сууж байгаа, сайн дурын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргаж, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын иргэнд дээрх ангиллын визийг Сайн дурын үйл ажиллагаа эрхэлсэн төрийн байгууллагаас Гадаад хэргийн яаманд хүсэлт илгээсэн тохиолдолд олгож болно.

## **7 дугаар бүлэг. Судалгаа, баримтжуулалт болон сайн туршлагын загвар боловсруулах, хүлээн зөвшөөрөх механизм**

### **18 дугаар зүйл. Судалгаа шинжилгээний тогтвортой механизм үүсгэх**

Энэ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн хөтөлбөр, төсөл, хүмүүнлэгийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болох Сайн дурын үйл ажиллагааны туршлага судлах, баримтжуулах, үргэлжилсэн судалгаа явуулах, загварчлах тогтвортой механизмыг бий болгоно.

## **2.5. МАКЕДОН<sup>100</sup>**

Тус улс нь нийгмийн сайн сайхны тусын тулд сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажилладаг ба энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулдаг бие даасан хуультай орнуудын нэг юм. Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль (*Law on volunteering*) нь 2007 оны 7 сарын 9-нд

а

<sup>100</sup> LAW ON VOLUNTEERING Official Gazette of Republic of Macedonia no. 85 from 09.07.2007

[www.mvcr.cz/soubor/makedonsky-zakon-pdf](http://www.mvcr.cz/soubor/makedonsky-zakon-pdf).

батлагдсан бөгөөд 8 бүлэг 26 зүйлтэй байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Сайн дурын үйл ажиллагааны нөхцөл ба арга хэлбэр
3. Сайн дурын ажилтан болон сайн дурын ажлыг зохион байгуулагчийн эрх, үүрэг
4. Сайн дурын ажлын гэрээ
5. Сайн дурын ажлын бүртгэл, тэмдэглэл ба сайн дурын ажлын тухай товхимол
6. Хяналт
7. Зөрчлийн тухай заалтууд
8. Нэмэлт заалтууд

Энэхүү хуулиар сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны нөхцөл, арга хэлбэр, сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй ажилтан болон зохион байгуулагчийн эрх, үүрэг, сайн дурын ажлын гэрээ ба сайн дурын ажлын бүртгэл, тэмдэглэл зэргийг зохицуулж байна.

Хуульд “Сайн дурын үйл ажиллагаа” гэж бусад хүмүүс, хуулийн этгээд, байгууллагууд ба бусад институтуудын ашиг тусын төлөө хувь хүний ажил үйлчилгээ, мэдлэг, ур чадвар ба бусад үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэ төлбөргүй сайн дураараа өгөх үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлжээ. Харин сайн дурын ажилтан гэдэг нь өөрийн ажил үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг бусад хүмүүс, хуулийн этгээд, байгууллагууд ба бусад институтуудын ашиг тусын төлөө ямарваа санхүүгийн, эсхүл хувийн ашиггүйгээр өгч буй хүнийг хэлэх бөгөөд энэ нь Македон улсын иргэн болон гадаад улсын иргэн ч байж болдог байна.

Македон Улсад сайн дурын үйл ажиллагааг Сайн дурын үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулахаас гадна Үүргийн харилцааны тухай хууль, Хөдөлмөрийн харилцааны хуулиудыг баримтлахыг чухалчилдаг.

Сайн дурын үйл ажиллагааны тухай хуульд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах хуулийн этгээд нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн байгууллага, гадаад улсын зөвшөөрөл бүхий иргэн байж болно гэж заажээ.

Мөн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулагч болон сайн дурын ажилтны эрх үүргийг тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал сайн дурын ажилтан нь өөрийн хариуцсан ажлын аюулгүй, таатай нөхцөл байдлаар хангагдах эрхтэй байдаг бол сайн дурын ажлыг зохион байгуулагч нь энэ нөхцөл байдлыг хангах үүрэг хүлээдэг байна.

Хуульд сайн дурын үйл ажиллагаа явуулах гэрээг хэрхэн байгуулах, гэрээний нөхцөл агуулгыг хуульд нарийвчлан заасан ба гэрээнд талуудын эрх, үүрэг, үйл ажиллагааны төрөл, явагдах газар, байршил, ажилтны даатгал, эхлэх дуусах хугацаа, зардал мөнгө зэргийг тодорхой тусгасан байна.

Сайн дурын ажлыг зохион байгуулагч болон ажилтанд хүлээлгэх хариуцлагын хувьд сайн дурын ажлын зохион байгуулагч, хариуцагч этгээдийн зөрчилд 500-1000 евро, түүнтэй дүйцэх хэмжээний динарын торгууль ногдуулдаг. Харин сайн дурын ажилтны зөрчилд 50-200 евро, түүнтэй дүйцэх хэмжээний динарын торгууль ногдуулахаар тус тус хуульчилсан байна.

(Дэлгэрэнгүйг доорх хуулиас үзнэ үү)



## **САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ**

Македон улсын албан ёсны сэтгүүл № 85, 2007 оны 07 дугаар сарын 09

### **1-р бүлэг. Нийтлэг үндэслэл**

#### **Нэгдүгээр зүйл**

Энэхүү хуулиар сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны нөхцөл, арга хэлбэр, сайн дурын үйл ажиллагаа эрхэлж буй ажилтан болон зохион байгуулагчийн эрх, үүрэг, сайн дурын ажлын гэрээ ба сайн дурын ажлын тэмдэглэл зэргийг зохицуулна.

#### **Хоёрдугаар зүйл**

Сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь Македоны Бүгд Найрамдах Улсын эрх ашигт нийцсэн, хүн ардыг нийгмийн амьдрал ба хүмүүнлэг эрх тэгш ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцуулж, амьдралын чанарыг сайжруулахад хувь нэмэр болдог үйл ажиллагаа мөн.

#### **Гуравдугаар зүйл**

Сайн дурын үйл ажиллагаа гэж бусад хүмүүс, хуулийн этгээд, байгууллагууд ба бусад институтуудын ашиг тусын төлөө хувь хүний ажил үйлчилгээ, мэдлэг, ур чадвар ба бусад үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэ төлбөргүй сайн дураараа өгөх үйл ажиллагааг хэлнэ.

Тогтмол бус, эсхүл санамсаргүй тохиолдлын шинжтэй сайн дурын ажил үйлчилгээг үнэ төлбөргүй бөгөөд сайн дураараа гүйцэтгэх боломжийг энэ хуулиар хязгаарлахгүй.

Энэ хуулийн сайн дурын үйл ажиллагаа гэдэг нэр томъёо нь Хөдөлмөрийн харилцааны хуулийн (*Law on Labor Relations*) дагуу сайн дураараа туршлага хуримтлуулах утгыг илэрхийлэхгүй.

#### **Дөрөвдүгээр зүйл**

Сайн дурын ажилтан гэж өөрийн ажил үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг бусад хүмүүс, хуулийн этгээд, байгууллагууд ба бусад институтуудын ашиг тусын төлөө ямарваа санхүүгийн, эсхүл хувийн ашиггүйгээр өгч буй хүнийг хэлнэ.

### **2-р бүлэг. Сайн дурын үйл ажиллагааны нөхцөл ба арга хэлбэр**

#### **Тавдугаар зүйл**

Сайн дурын ажилтан нь дотоодын, эсхүл гадаадын хувь хүн байж болно.

Сайн дурын ажилтан нь эцэг/эх, эсхүл асран хамгаалагчийн бичгээр үйлдсэн зөвшөөрөл бүхий насанд хүрээгүй хүн байж болно. Насанд хүрээгүй хүмүүсийг сайн дурын үйл ажиллагаанд оролцуулахдаа Хөдөлмөрийн харилцааны хуулийн 15-18 насны хүмүүсийг хамгаалах тухай заалтуудыг зохистойгоор хэрэглэнэ.

#### **Зургадугаар зүйл**

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь:

- иргэд болон сангийн нийгэмлэг;
- шашны нэгдэл, эсхүл бүлэг;
- олон нийтийн байгууллага; ба
- төрийн байгууллага зэрэг байж болно.

Энэхүү зүйлийн эхний догол мөрд заасан сайн дурын ажлыг зохион байгуулагч гэх нь сайн дурын ажилтнуудын оролцооны эрэлт хэрэгцээ, үйлчилгээний төрөл ба тэдгээрийг ханган биелүүлэх арга хэлбэр, үйл явцыг сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн тодорхойлно.

### **Долдугаар зүйл**

Бүгд Найрамдах Македон Улсын иргэн нь бусад улс оронд тухайн улсынхаа хууль болон олон улсын батлагдсан хэлэлцээрийн дагуу сайн дурын ажил хийж болно.

### **Наймдугаар зүйл**

Хөдөлмөр, нийгмийн бодлогын яамны зөвшөөрөл, Бүгд Найрамдах Македон Улсад оршин суух хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын иргэн нь Бүгд Найрамдах Македон Улсад сайн дурын ажил хийж болно.

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь энэ зүйлийн эхний догол мөрд заасан зөвшөөрлийг олгосон өдрөөс 60 өдрийн дотор гадаадын иргэнийг сайн дурын ажил хийлгэхээр шийдвэрлэсэн тухайгаа Хөдөлмөр, нийгмийн бодлогын яаманд мэдэгдэх үүрэг хүлээнэ. Энэхүү зүйлийн эхний догол мөрд дэх зөвшөөрлийг олгох арга хэлбэр, үйл явц ба тэмдэглэлийг Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам тодорхойлно.

### **Есдүгээр зүйл**

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь сайн дурын ажилтныг гарал үүсэл, арьсны өнгө, хүйс, нас, эрүүл мэндийн байдал, шашин, улс төр, эсхүл бусад итгэл үнэмшил, үндэстний болон нийгмийн уг гарал, гэр бүлийн байдал, хөрөнгө чинээний байдал, эсхүл хувь хүний бусад нөхцөл байдлуудад үндэслэн шударга бус нөхцөлд томилж болохгүй.

### **3-р бүлэг. Сайн дурын ажилтан ба сайн дурын ажил зохион байгуулагчийн эрх ба үүрэг**

#### **Аравдугаар зүйл**

Сайн дурын ажилтан нь дараах эрхтэй:

- сайн дурын ажил хийж эхлэхээсээ өмнө өөрийн эрх, үүргийн тухай тодорхойлолтыг бичгийн хэлбэрээр авч, сайн дураар хийх ажлынхаа нөхцөл, эрсдэл зэрэгтэй танилцах;
- ажил үйлчилгээг зохион байгуулагчийн ерөнхий хууль, дүрэм журамтай, тухайлан өөрийн хийх гэж буй сайн дурын ажилтай холбогдох хэсгүүдтэй танилцах;
- ажлын байрны аюулгүй байдал хамгаалалтын талаар хуулийн заалтуудын дагуу ажил хийж байх үедээ хамгаалах хэрэгсэл хэрэглэх;
- хэрвээ ажил үйлчилгээний шаардлагатай нөхцөл болж гэрээнд заагдсан бол сургалтад хамрагдах;
- сайн дурын ажил хийх үедээ хэрвээ харгалзан үзэх учир шалтгаантай бол чөлөө авах;
- өдөр тутмын амралт завсарлага авах;
- ажил үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрийн тухай шийдвэр гаргах үед зөвлөлдөх ба мэдээлэл авах;
- урьдчилан тохиролцсон сайн дурын ажилтай холбоотойгоор гарсан зардлыг (хоол хүнсний мөнгө, сайн дурын ажил хийх газар руу ирж очих тээврийн зардал, албан томилолтоор явсан аяллын зардал ба сургалтын зардал) нөхөж авах;
- хувийн мэдээллийг нууцлуулах ба хамгаалуулах.

Энэ зүйлийн эхний догол мөрийн 8 дугаар мөрд заасан зардлууд сайн дурын ажилтанд сайн

дурын ажил хийж байх үед нь гарч болох ба, тэдгээрийг сайн дурын ажлыг зохион байгуулагчийн ажилтан албан хаагчидтай адил хэмжээгээр төлнө.

Гадаад улсын сайн дурын ажилтан энэ зүйлийн 1 дүгээр догол мөрд заасан эрхүүдээс гадна байр, эрүүл мэндийн даатгал, буцах зардал зэргээ төлүүлэх эрхтэй.

### **Арван нэгдүгээр зүйл**

Сайн дурын ажилтны хүлээх үүрэг нь:

- өвдсөн, эсхүл ажил үйлчилгээгээ тасалдуулах өөр бусад учир шалтгааныхаа тухай сайн дурын ажлыг зохион байгуулагчид мэдэгдэх;
- сайн дурын ажлыг хууль, сайн дурын ажлын гэрээ, түүнд урьдчилан танилцуулсан зохион байгуулагчийн ерөнхий дүрэм журмын дагуу хийх;
- ажил үйлчилгээг биечлэн, шууд гүйцэтгэх;
- чанартай сайн ажил үйлчилгээ үзүүлэх үүднээс сургалтад хамрагдах;
- сайн дурын ажлыг зохион байгуулагчийн түүнд урьдчилан танилцуулсан нууц мэдээлэл гэх зэрэг мэдээллийн нууцыг хадгалах;
- сайн дурын ажил зохион байгуулагч, сайн дурын ажилтныг өөрийг нь, эсхүл ямарваа гуравдагч этгээдийг гэмтээн хохироож болзошгүй үр дагаврын тухай сайн дурын ажлыг зохион байгуулагчид мэдээлэх.

Хэрвээ сайн дурын ажилтан энэ зүйлийн 1 дүгээр догол мөрийн 6 дугаар мөрд заасан гэмтэл учруулах үр дагаврын тухай зохион байгуулагчид урьдчилан мэдэгдэж байсан бол тэрээр учирсан гэмтэл хохирлыг хариуцахгүй.

### **Арванхоёрдугаар зүйл**

Сайн дурын ажилтан сайн дурын ажил хийж байх үедээ санаатайгаар, эсхүл сайн дурын ажлыг зохион байгуулагчид мэдэгдээгүйн улмаас хохирол учруулсан тохиолдолд Үүргийн харилцааны тухай хуулийн (*Law on Obligatory Relations*) дагуу сайн дурын ажлыг зохион байгуулагчид учруулсан хохирлоо барагдуулах үүрэгтэй.

Сайн дурын ажлын үеэр, эсхүл түүнтэй хамааралтайгаар сайн дурын ажилтанд ямарваа нэгэн хохирол учирвал түүнийг сайн дурын ажлыг зохион байгуулагч нь Үүргийн харилцааны тухай хуулийн дагуу төлж барагдуулна.

Сайн дурын ажлынхаа үеэр, эсхүл түүнтэй холбоотойгоор сайн дурын ажилтан гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд Үүргийн харилцааны тухай хуулийн дагуу түүнийг төлж барагдуулна.

### **Арвангуравдугаар зүйл**

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь дараах үүрэгтэй:

- Сайн дурын ажлын тухай хууль болон гэрээний дагуу сайн дурын ажлыг хийх нөхцөлөөр хангах;
- сайн дурын ажилтанд зориулсан энэ хуулиар журамласан мэдээллүүд бүхий сайн дурын ажлын тухай гарын авлагаар хангах;
- сайн дурын ажлыг хийх эд материал болон багаж хэрэгслээр хангах;
- урьдчилан тохиролцсон зардлуудыг цаг тухайд нь олгох;
- мэдээллийн нууц ба хувийн нууцыг хамгаалах;
- энэ хуулиар заасан, эсхүл харилцан тохиролцсон бусад нөхцөлүүдээр хангах;

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

- сайн дурын ажлын үеэр мэргэжлийн өвчний болон ажлын байран дахь гэмтэл бэртлийн даатгалыг тэтгэврийн болон хөдөлмөрийн чадвараа алдах даатгалын заалтууд, хэрвээ ийнхүү тохиролцсон бол эрүүл мэндийн даатгалын заалтуудын дагуу даатгалд хамруулна.

Хувь хүний орлогын татварын тухай хуулийн (*Law on Personal Income Tax*) дагуу Сайн дурын ажлын гэрээнд тодорхойлсон ажлын зардлуудад үндэслэж, хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй.

#### **4-р бүлэг. Сайн дурын ажлын гэрээ**

##### **Арван дөрөвдүгээр зүйл**

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь сард 40 цагаас дээш хугацаагаар ажиллах дотоодын (Македон Улсын иргэн) сайн дурын ажилтантай сайн дурын ажлын гэрээг бичгээр байгуулах үүрэгтэй.

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь сард 40 цагаас доош хугацаагаар ажиллах дотоодын (Македон Улсын иргэн) сайн дурын ажилтантай сайн дурын ажлын гэрээ байгуулж болно.

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь бүх төрлийн сайн дурын ажил хийх гадаадын сайн дурын ажилтантай сайн дурын ажлын гэрээг бичгээр байгуулах үүрэгтэй.

Сайн дурын ажлын гэрээнд дараах зүйлсийг тусгана:

1. Гэрээ байгуулагч талууд:
  - сайн дурын ажлыг зохион байгуулагч (нэр ба албан тушаал)
  - сайн дурын ажилтан (нэр, овог, байнгын хаяг, оршин суух хаяг)
2. Гэрээний зүйл;
3. Сайн дурын ажлын газар ба хугацаа, 1-ээс дээш албаны тухай, түүний ажил үйлчилгээ үзүүлэх газрууд;
4. Сайн дураар үзүүлэх ажил үйлчилгээ;
5. Талуудын эрх, үүрэг;
6. Сайн дурын ажил хийж байх үеийн, сайн дурын ажил үйлчилгээ үзүүлэх газарт ирэх, буцах, бусад сайн дурын ажил хийх үед төлөвлөгдсөн үйл ажиллагааны үеийн даатгалын төрөл зүйл;
7. Сайн дурын ажлын тухайд урьдчилан тохиролцсон зардал ба тэдгээрийг нөхөн олгох арга хэлбэр;
8. Сайн дурын ажлын гэрээг дуусгавар болгох ба цуцлах арга хэлбэр;
9. Гэрээг байгуулсан огноо.

##### **Арван тавдугаар зүйл**

Сайн дурын ажлын холбогдолтойгоор үүсч болох энэ хуулиар зохицуулагдаагүй асуудлуудад Үүргийн харилцааны хуулийн заалтуудыг хэрэглэнэ.

##### **Арван зургадугаар зүйл**

Сайн дурын ажлын гэрээг дараах нөхцөлүүдэд дуусгавар болгоно:

- гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон, эсхүл гэрээгээр тохиролцсон нөхцөл хангагдсан;
- харилцан зөвшилцөж тохирсны үндсэн дээр цуцлан дуусгавар болгох;

- сайн дурын ажлын зохион байгуулагч нь ажил эрхлэхээ больсон ба хууль ёсны залгамжлагчгүй болсон;
- сайн дурын ажилтан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд;
- Бүгд Найрамдах Македон Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсноор.

Гэрээ цуцлах нь сайн дурын ажил зохион байгуулагчийн, эсхүл гуравдагч этгээдийн ажил хэрэгт ноцтой хохирол бүхий үр дагавартай биш л бол сайн дурын ажилтан гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээгээ цуцлах тохиолдолд ямар нэгэн тайлбар хийх үүрэг хүлээлгүйгээр бичгээр хүсэлт гарган гэрээгээ цуцалж болно.

Сайн дурын ажил зохион байгуулагч нь дараах нөхцөлүүдэд сайн дурын ажлын гэрээг цуцалж болно:

- сайн дурын ажлыг зогсоох шаардлага гарсан бол;
- сайн дурын ажлынхаа нөхцөлийг ханган биелүүлж чадахгүй болсон бол;
- сайн дурын ажилтан нь гэрээний үүргээ биелүүлж чадахгүй байна гэж үзвэл;
- зарим зүйл сайн дурын ажилд тавигдах ёс зүйн хэм, хэмжээг зөрчсөн тохиолдолд.

Гэрээ байгуулсан талууд гэрээг цуцлах тухайгаа таван өдрийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

### **Арван долдугаар зүйл**

Сайн дурын ажил зохион байгуулагч нь сайн дурын ажлын гэрээг ажил олгох гэрээ байгуулахаас зайлсхийх зорилгоор байгуулах ёсгүй.

### **Арван наймдугаар зүйл**

Сайн дурын ажлын гэрээ байгуулсан нь Ажил эрхлэлт ба даатгалын хуулийн заалтуудын дагуу ажилгүй болсны тэтгэмж авах эрхээ алдах үндэслэл болохгүй.

## **5-р бүлэг. Сайн дурын ажлын бүртгэл, тэмдэглэл ба сайн дурын ажлын тухай товхимол**

### **Арван есдүгээр зүйл**

Сайн дурын ажлыг зохион байгуулагч нь бүх сайн дурын ажилтнуудынхаа сайн дурын үйл ажиллагааны тухай бүртгэл, тэмдэглэл хөтлөх үүрэгтэй.

Энэ зүйлийн 1 дүгээр догол мөр дэх бүртгэл, тэмдэглэл хөтлөх арга хэлбэрийг Хөдөлмөр, нийгмийн бодлогын яамнаас тодорхойлно.

### **Хорьдугаар зүйл**

Сайн дурын ажилтны дэвтэр бол улсын баримт бичиг мөн.

Сайн дурын ажилтны дэвтэрт сайн дурын ажлын төрөл зүйл ба хугацаа, сайн дурын ажил хийж байх үедээ сайн дурын ажилтны хамрагдсан сургалтын төрөл зүйл зэргийн тухай мэдээллийг агуулсан байна.

Сайн дурын ажилтны дэвтрийн агуулга болон хэлбэр, түүнийг олгох ба мэдээллийн бүртгэл, тэмдэглэл хөтлөх зааврыг Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам тодорхойлно.

## **6-р бүлэг. Хяналт**

### **Хорин нэгдүгээр зүйл**

Энэ хуулийн хэрэгжилтэд Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам хяналт тавина.

Хяналт удирдлагыг Төрийн хөдөлмөрийн хяналтын алба хөдөлмөрийн хяналтын байцаагч нараар дамжуулан гүйцэтгэнэ.

## **7-р бүлэг. Зөрчлийн тухай заалтууд**

### **Хорин хоёрдугаар зүйл**

Дараах зөрчилд 500-1000 евро, түүнтэй дүйцэх хэмжээний динарын торгуулийг сайн дурын ажлын зохион байгуулагч, хариуцагч этгээдэд ногдуулна:

- Хөдөлмөр, нийгмийн бодлогын яаманд гадаадын иргэнийг сайн дураар ажиллуулж эхэлсэн тухайгаа мэдэгдээгүй;
- Энэ хуулийн 9-р зүйл ийг зөрчсөн үйлдэлд;
- Сайн дурын ажилтанд нөхөн олгох хохирлыг олгоогүй;
- Энэ хуулийн 13-р зүйлийг зөрчсөн үйлдэлд;
- сайн дурын ажлын гэрээг бичгийн хэлбэрээр байгуулаагүй;
- сайн дурын ажлын тухай бүртгэл, тэмдэглэл хөтлөөгүй.

### **Хорин гуравдугаар зүйл**

Сайн дурын ажлын зохион байгуулагч, хариуцагч этгээдийн сайн дурын ажлын гэрээг ажил олгох гэрээ байгуулахаас зайлсхийх зорилгоор байгуулсан зөрчилд 1500-2000 евро, түүнтэй дүйцэх хэмжээний динарын торгууль ногдуулна.

### **Хорин дөрөвдүгээр зүйл**

Сайн дурын ажилтны дараах зөрчилд 50-200 евро, түүнтэй дүйцэх хэмжээний динарын торгууль ногдуулна:

- энэ хуулийн 11-р зүйлийн 1-р догол мөрийн заалтыг зөрчсөн;
- хохирлыг нөхөн төлөөгүй.

## **8-р бүлэг. Нэмэлт заалтууд**

### **Хорин тавдугаар зүйл**

Энэ хуулиар зохицуулагдах дагалдах зохицуулалтуудыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс гурван сарын дотор батална.

### **Хорин зургадугаар зүйл**

Энэ хууль "Бүгд Найрамдах Македон Улсын Албан ёсны сэтгүүл" дээр хэвлэгдэн гарсан найман өдрөөс хүчин төгөлдөр болно.

## **2.6. ЧЕХ**

Бүгд Найрамдах Чех Улс нь сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй орны нэг юм. Сайн дурын үйлчилгээний тухай хууль<sup>101</sup> (Volunteer Services Act)-ийг 2002 онд баталжээ.

Сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага (*delegating organization*) эрхлэх ба тус

а

<sup>101</sup> Volunteer Services Act, Czech Republic. 2002 <http://www.legislationline.org/documents/action/popup/id/5788>



байгууллагыг Дотоод хэргийн яам магадлан итгэмжилнэ. Магадлан итгэмжлэлийн хороо нь Гадаад хэргийн яам, Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам, Дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн яам, Байгаль, орчны яам, Соёлын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам болон төрийн бус, ашгийн бус байгууллагын асуудлаарх Засгийн газрын зөвлөлийн төлөөллөөс бүрдэнэ. Дотоод хэргийн яам Магадлан итгэмжлэлийн хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн магадлан итгэмжлэл олгоно. Магадлан итгэмжлэлийн хороо нь Засгийн газарт зөвлөх үүрэг гүйцэтгэнэ.

Дотоод хэргийн яам нь иргэний нийгэм, олон нийтэд тустай байгууллага, сүм хийд, шашны байгууллага, нийгэмлэг зэрэг хуулийн этгээдэд тухайн байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх тодорхой төсөл, санхүүгийн чадавх зэргийг харгалзан, тухайн сайн дурын үйл ажиллагааны төсөл хөтөлбөрийг зохион байгуулж, хэрэгжүүлэх чадвар, чадавх зэргийг харгалзан магадлан итгэмжлэлийг гурван жилийн хугацаагаар олгодог байна.

Магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагуудын жагсаалт олон нийтэд нээлттэй байх ба цахим хэлбэртэй байна. Тус жагсаалт нь сайн дурын үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хэрэгжүүлэгч байгууллагын талаарх мэдээллийг тусгасан байна.

Сайн дурын ажилтан дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг сайн дурын үйл ажиллагаа гэнэ. Үүнд:

- а) ажилгүйчүүд, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, үндэстний цөөнх, цагаачид, хорих ял эдэлж байсан хүмүүс, мансууруулах бодисонд донтогч, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дэмжлэг туслалцаа үзүүлэх, болон хүүхэд, залуучууд, тэдний гэр бүлд чөлөөт цагаараа дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- б) хүрээлэн буй орчин, хүмүүнлэгийн болон байгалийн гамшгийн үед, соёлын өвийг хамгаалах, хандивын үйл ажиллагаанд бэлтгэх;
- с) олон улсын байгууллагууд, түүний дотор олон улсын төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөр, арга хэмжээнд дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг хамарна.

Сайн дурын үйл ажиллагааны төрлөөс хамааран хугацааны хувьд богино, 3 сараас дээш хугацаагаар үргэлжлэх бол урт хугацаатай байж болно. Сайн дурын ажилтан нь хувь хүн байж болох ба Бүгд Найрамдах Чех Улсын нутаг дэвсгэр дээр сайн дурын үйл ажиллагаа явуулж байгаа бол 15-аас дээш насны, хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаа явуулж байгаа бол 18 нас хүрсэн байх бөгөөд өөрийн ур чадвар, мэдлэг чадварыг харгалзан сайн дурын үйл ажиллагаа явуулах шийдвэрийг сайн дурын үндсэн дээр гаргасан байна.

Сайн дурын ажилтан нь хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлнэ. Хилийн чандад богино болон урт хугацааны үйл ажиллагаа эрхлэх гэрээг бичгээр үйлдэнэ.

Богино хугацааны сайн дурын үйл ажиллагаа явуулахад (хилийн чандад сайн дурын үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд) сайн дурын ажилтан, эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллагын хооронд сайн дурын үйл ажиллагааны агуулга, хугацаа, байршил зэргийг тохиролцоно. Үйлчилгээний шинж чанараас хамааруулан, сайн дурын ажилтныг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах бөгөөд сайн дурын ажилтан нь сүүлийн 3 сарын хугацаанд цагдаагийн байгууллагаас олгосон тодорхойлолт, эрүүл мэндийн магадалгаа зэргийг бүрдүүлнэ.

Урт болон богино хугацаанд сайн дурын үйл ажиллагаа явуулах талаар сайн дурын ажилтан, хэрэгжүүлэгч байгууллага хооронд байгуулах гэрээнд тодорхой нөхцөлүүдийг нарийвчлан тусгана.

Хэрэгжүүлэгч байгууллага нь сайн дурын ажилтнаар үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээс өмнө сайн дурын ажилтан өөрөө, эсхүл гуравдагч этгээдэд учруулсан материаллаг хохирол, эрүүл мэндийн хор уршиг учирсан нөхцөлд үзүүлэх даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй. Сайн дурын ажилтан нь зөвхөн санаатайгаар хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

Сайн дурын ажилтныг хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаа явуулахын өмнө, хэрэгжүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн даатгал хамруулна. Ингэхдээ сайн дурын үйл ажиллагааны шинж чанар, хилийн чанад дахь нөхцөл байдал, улс орон, нутаг дэвсгэрийн нөхцөл байдал зэргийг харгалзан үзнэ.

Хэрэв сайн дурын үйл ажиллагаа байнгын оршин суугаа газраас гадна явагдах бол, хэрэгжүүлэгч байгууллага сайн дурын ажилтны эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй нөхцөл бүхий орон сууц, нийгмийн (үйлчилгээнээс гадна) баталгааг хангана.

Хэрэгжүүлэгч байгууллага нь сайн дурын ажилтан 18 нас хүрээгүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчийн нотариатаар баталгаажуулсан зөвшөөрөл, эсхүл хууль ёсны төлөөлөгчийн гаргасан зөвшөөрлийг баримтжуулсан төлөөлөгчийн байгууллагын протоколыг үндэслэн гэрээ байгуулна. Ийм зөвшөөрөл аваагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна. 18 нас хүрээгүй сайн дурын ажилтны бие махбодь, сэтгэл зүйн онцлогт тохироогүй ажил, үйлчилгээ хийлгүүлснээр осол, эрүүл мэнд, амь насанд эрсдэл учирч болзошгүй тул насанд хүрээгүй ажилтанг хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаанд явуулахыг хориглоно.

Дотоод хэргийн яам нь хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилтийг олгоно.

(Дэлгэрэнгүйг доорх хуулиас үзнэ үү)

## **САЙН ДУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ**

**(Зарим зохицуулалтыг өөрчлөх тухай)**

**2002 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр №198**

Бүгд Найрамдах Чех Улсын Парламент дараах хуулийг батлав.

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

#### **Сайн дурын үйл ажиллагаа**

##### **1 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо**

- (1) Энэхүү хуулиар урамшуулал, хөлсгүй сайн дурын ажил үйл ажиллагаа явуулж, зохион байгуулахад төрөөс дэмжлэг туслалцаа үзүүлэх нөхцөлүүдийг тогтооно.
- (2) Энэхүү хуульд нь дараах асуудал хамаарахгүй. Үүнд:
  - а) энэхүү хуульд заасан сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолтод хамаарч буй хэдий ч тусгай хуулиар зохицуулагддаг үйл ажиллагаа;
  - б) сайн дурын ажилтнууд гүйцэтгэдэг хэдий ч энэхүү хуульд заасан сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолтод хамаарахгүй үйл ажиллагаа.

##### **2 дугаар зүйл. Тодорхойлолт**

- (1) Сайн дурын ажилтан дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг сайн дурын үйл ажиллагаа гэнэ. Үүнд:
  - а) ажилгүйчүүд, нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, үндэстний цөөнх, цагаачид, хоригдох ял эдэлж байсан хүмүүс, мансууруулах

бодисонд донтогч, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дэмжлэг тусалцаа үзүүлэх, болон хүүхэд, залуучууд, тэдний гэр бүлд чөлөөт цагаараа дэмжлэг тусалцаа үзүүлэх;

- б) хүрээлэн буй орчин, хүмүүнлэгийн болон байгалийн гамшгийн үед, соёлын өвийг хамгаалах, хандивын үйл ажиллагаанд бэлтгэх явцад а) эсхүл;
- с) олон улсын байгууллагууд, түүний дотор олон улсын төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөр, арга хэмжээнд дэмжлэг тусалцаа үзүүлэх үед;

(2) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сайн дурын арга хэмжээнд аж ахуйн буюу орлого бий болгох үйл ажиллагаа, эсхүл ажил олгогчтой байгуулсан, үйлчилгээ үзүүлэх болон гишүүнчлэлийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааг буюу хувийн ашиг сонирхлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа хамаарахгүй.

(3) үйл ажиллагааныхаа шинж чанараас хамааран, сайн дурын үйлчилгээ нь богино эсхүл, хэрэв 3 сараас дээш хугацаагаар үргэлжлэхээр бол урт хугацаатай байж болно.

### **3 дугаар зүйл.**

(1) Сайн дурын ажилтан нь хувь хүн байж болно.

- а) Бүгд Найрамдах Чех Улсын нутаг дэвсгэр дээр сайн дурын үйл ажиллагаа явуулж байгаа бол 15-аас дээш насны;
- б) хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаа явуулж байгаа бол 18 нас хүрсэн байх бөгөөд; өөрийн ур чадвар, мэдлэг чадварыг харгалзан сайн дурын үйл ажиллагаа явуулахыг явуулах шийдвэрийг сайн дурын үндсэн дээр гаргасан байна.

(2) Сайн дурын ажилтан нь хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр сайн дурын үйл ажиллагаа эрхэлнэ. Богино буюу урт хугацааны, хилийн чанад дахь үйл ажиллагаа эрхлэх гэрээг бичгээр үйлдэнэ.

(3) Хэрэв тухайн хувь хүн нь хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, эсхүл гишүүнчлэлийн гэрээнд хамаарч байгаа, эсхүл тухайн хүн суралцдаг бол, түүний сайн дурын үйл ажиллагаа нь тухайн гэрээнд хамаарахгүй.

(4) Цэргийн алба буюу цэргийн нөөцийн албан хаагч сайн дурын үйл ажиллагаа эрхлэх нь хориотой.

### **4 дүгээр зүйл.**

(1) Энэхүү хуулийн дагуу төлөөлөх (хэрэгжүүлэх) эрх бүхий байгууллага нь Бүгд Найрамдах Чех Улсын нутаг дэвсгэрт байрладаг хуулийн этгээд бөгөөд сайн дурын ажилтныг сонгон шалгаруулах, бүртгэх, үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэх, магадлан итгэмжлэгдсэн нөхцөлдөө нийцүүлэн сайн дурын ажилтантай гэрээ байгуулна. (6-р зүйл)

(2) Энэхүү хуулийн дагуу үйлчилгээ хүлээн авагч гэдэг нь үйлчилгээ шаардлагатай байгаа, эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулах, тухайн гэрээний дагуу үүргээ хэрэгжүүлэх чадвар бүхий этгээдийг хэлнэ. Байгууллагатай гэрээ байгуулж, тохиролцооны дагуу үүргээ биелүүлэх чадвартай байна.

(3) Эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллага нь үйлчилгээ хүлээн авагч байгууллагуудтай гэрээ байгуулахаас гадна өөрийн ашиг сонирхлын хүрээнд сайн дурын ажилтантай гэрээ байгуулж болно. Энэ нь хүлээн авагч байгууллагатай болон сайн дурын ажилтантай байгуулсан гэрээнээс хамааран, тухайн сайн дурын үйл ажиллагаатай адил шинж чанартай, сайн дурын ажилтан нь тухайн хэрэгжүүлэгч байгууллагын гишүүн бус, буюу эрх зүйн хувьд ямарваа нэгэн хамааралгүй байх ёстой. Энэ нөхцөлд сайн дурын ажилтан болон байгууллага хоорондын харилцаа нь тухайн сайн дурын үйл ажиллагааны ашиг тусын хүрээнд сайн дурын ажилтны

болон хүлээн авагч байгууллагын эрх, үүргийн талаарх заалтуудын хүрээнд зохицуулагдана.

## 5 дугаар зүйл. Гэрээ

(1) Богино хугацааны сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ (хилийн чандад сайн дурын үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд) сайн дурын ажилтан, эрх бүхий хэрэгжүүлэгч байгууллагын хооронд сайн дурын үйл ажиллагааны сэдэв, хугацаа, байршил зэргийг тохиролцох ёстой. Үйлчилгээний шинж чанараас хамааруулан, сайн дурын ажилтныг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах бөгөөд сайн дурын ажилтан нь сүүлийн 3 сарын хугацаанд цагдаагийн байгууллагаас олгосон тодорхойлолт, эрүүл мэндийн магадалгаа зэргийг бүрдүүлнэ. (2-р хэсэг б, 3-р зүйл)

(2) Урт ба богино хугацаанд сайн дурын үйл ажиллагаа явуулах талаар сайн дурын ажилтан, хэрэгжүүлэгч байгууллага хооронд байгуулах гэрээнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- а) нэр, овог, төрсний гэрчилгээний дугаар, төрсөн он, сар, өдөр (хэрэв төрсний гэрчилгээний дугаар олгоогүй бол), сайн дурын ажилтны байнгын оршин суугаа газар, хэрэгжүүлэгч байгууллагын нэр, хаяг;
- б) дараах асуудлаар тохиролцсон байна. Үүнд:
  - хэрэгжүүлэгч байгууллагаас явуулдаг бэлтгэл сургалтад хамрагдсан байх; бэлтгэл сургалт нь (сайн дурын үйл ажиллагааны шинж чанараас хамааран) сайн дурын ажилтны амь нас, эрүүл мэндэд аюул занал учруулж болзошгүй эрсдэлүүдийн талаар мэдээллийг агуулсан байна;
  - цагдаагийн байгууллагаас 3 сараас дээшгүй хугацааны өмнө олгосон тодорхойлолт, тухайн гэрээ байгуулах үед сайн дурын ажилтанд (сайн дурын үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан) эрүүгийн хэрэгт холбогдолгүй болохыг бичгээр нотолсон байх;
  - эрүүл мэндийн тодорхойлолтыг 3 сараас доошгүй хугацааны өмнөх байдлаар (сайн дурын үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан) олгох бөгөөд уг тодорхойлолт хэрэв сайн дурын ажилтанд үзлэг хийсний үндсэн дээр тухайн хүн тухайн сайн дурын ажил гүйцэтгэх боломжгүй болохыг тодорхойлсон байх;
  - сайн дурын ажилтанд халдварт өвчний талаар мэдэгдсэн (сайн дурын үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан) байх;
  - сайн дурын үйл ажиллагаанд оролцох нөхцөл.
- в) тусгайлсан хөтөлбөр, төслийн хүрээнд явуулах сайн дурын үйл ажиллагаа явуулах байршил, сэдэв, үргэлжлэх хугацаа;
- г) сайн дурын ажилтанд орон байраар хангах, болон үзүүлэх бусад дэмжлэг туслалцааны хэлбэр;
- д) сайн дурын ажилтныг сайн дурын үйл ажиллагааг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нөхцөлд хэрэгжүүлэгч байгууллагаа оруулсан хөрөнгө оруулалтын өөрт ногдох хэсгийн буцаан төлөх үүрэг;
- е) сайн дурын үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан, сайн дурын ажилтны сайн дурын үйлчилгээний тусгай хөтөлбөр, төсөлд оролцох бэлтгэлийг хангахад шаардлагатай зардлыг нөхөн төлөх, хилийн чанад руу явах, буцаж ирэхтэй холбоотой тээврийн зардлын нөхөн төлөх, өдөр тутмын зардал, ажлын хэрэгсэл болон хувийн хамгааллын хэрэгслийн нөхөн төлбөрийн талаарх тохиролцоо;
- ё) сайн дурын ажилтны үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан, ажиллах цагийн үргэлжлэл, завсарлах хугацаа, чөлөө олгох нөхцөл, сайн дурын үйл ажиллагааг цаг хугацаанаас өмнө дуусгавар болгох зэрэг нөхцөл.

(3) Сайн дурын ажилтан ба төлөөлөгч байгууллага хоорондын урт хугацааны сайн дурын үйл ажиллагаа явуулах тухай гэрээнд дараах зүйлсийг багтааж болно. Үүнд: (2) зохицуулалт

хийхээс өмнө сайн дурын ажилтан нь тусгайлсан хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан нөхцөлд тэтгэврийн даатгалд бүртгүүлэх эсэхтэй холбогдсон заалтад; (3) хэрэв сайн дурын урт хугацааны үйл ажиллагааны үргэлжлэл долоо хоногт дунджаар 20 цагаар илүү байсан тохиолдолд, хэрэгжүүлэгч байгууллага нь тэтгэврийн даатгалын төлбөрийг хамгийн багаар тогтоосон дүнгээс үүдэн төлсөн байх;

(4) Сайн дурын ажилтанд сайн дурын үйл ажиллагаа явуулсны төлөө цалин олгохгүй.

(5) Ажлын цаг, завсарлага, амралт, аюулгүй байдлын нөхцөлийн талаарх гэрээгээр тохирсон тохиролцоонд хөдөлмөрийн нөхцөлүүдийг хамааруулах бөгөөд хилийн чанадад явахад олгох зам хоногийн мөнгийг олгоход мөн зохих зохицуулалтыг мөрдөнө.

## **6 дугаар зүйл. Хэрэгжүүлэгч байгууллага**

(1) Хэрэгжүүлэгч байгууллага нь Дотоод хэргийн яам (цаашид "яам" гэх)-наас магадлан итгэмжлэгдсэн байгууллага байна. Тус яам нь Гадаад хэргийн яам, Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам, Хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн яам, Байгаль орчны яам, Соёлын Яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам болон ТББ-ын асуудлаарх Засгийн газрын Зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн Магадлан итгэмжлэлийн Хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн магадлан итгэмжлэл олгоно. Магадлан итгэмжлэлийн хороо нь Засгийн газарт зөвлөх үүрэг гүйцэтгэнэ.

(2) Яам нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэний нийгэм, олон нийтэд тустай байгууллага, сүм хийд, шашны байгууллага, нийгэмлэгийн хуулийн этгээдэд магадлан итгэмжлэлийг олгодог бөгөөд тухайн байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх тодорхой төсөл, санхүүгийн чадавх зэргийг харгалзан, тухайн сайн дурын үйлчилгээний төслүүдийг зохион байгуулах, хэрэгжүүлэх чадвар, энэ хуульд заасан үүргийг хүлээх чадвар зэргийг харгалзан магадлан итгэмжлэлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

(3) Яам нь магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагуудын жагсаалтыг олон нийтэд нээлттэй, цахим хэлбэрээр гаргана. Тус жагсаалт нь сайн дурын үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хэрэгжүүлэгч байгууллагын талаарх мэдээллийг агуулсан байна.

## **7 дугаар зүйл.**

(1) Сайн дурын ажилтнаар үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээс өмнө, төлөөлөөллийн байгууллага нь сайн дурын ажилтанд өөрөө, эсхүл гуравдагч этгээдэд учруулсан материаллаг хохирол, эрүүл мэндийн хор уршиг учирсан нөхцөлд үзүүлэх даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй. Сайн дурын ажилтан нь зөвхөн санаатайгаар хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

(2) Сайн дурын ажилтныг хилийн чанадад сайн дурын үйл ажиллагаа явуулахаас өмнө, хэрэгжүүлэгч байгууллага нь эрүүл мэндийн даатгалд хамруулна. Ингэхдээ сайн дурын үйл ажиллагааны шинж чанар, хилийн чанад дахь нөхцөл байдал, улс орон, нутаг дэвсгэрийн нөхцөл байдал зэргийг харгалзан үзнэ.

(3) Хэрэв сайн дурын үйл ажиллагаа сайн дурын ажилтны байнгын оршин суугаа газраас гадна явагдах бол, хэрэгжүүлэгч байгууллага сайн дурын ажилтны эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй нөхцөл бүхий орон сууц, нийгмийн (үйлчилгээнээс гадна) баталгааг хангана.

(4) Хэрэгжүүлэгч байгууллага нь сайн дурын ажилтан 18 нас хүрээгүй тохиолдолд, 5-р зүйлийн дагуу, түүний хууль ёсны төлөөлөгчийн нотариатаар баталгаажуулсан зөвшөөрөл, эсхүл төлөөлөгчийн тухайн зөвшөөрлийг олгож буй хэрэгжүүлэгч байгууллагын протоколыг үндэслэн гэрээ байгуулна. Ийм зөвшөөрөл аваагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

(5) 18 нас хүрээгүй сайн дурын ажилтнаар бие махбодь, физиологийн болон сэтгэл зүйн



онцлогт тохироогүй сайн дурын үйлчилгээг хийлгүүлснээр аюул осолд өртөх болон өвчлөх эрсдэл нэмэгдэж болзошгүй тул насанд хүрээгүй сайн дурын ажилтанг хилийн чандад сайн дурын үйл ажиллагаанд явуулахыг хориглоно.

(6) Гэрээ байгуулах сайн дурын ажилтныг сонгохдоо, хэрэгжүүлэгч байгууллага нь, тухайн сайн үйл ажиллагааны шинж чанараас хамааруулан, адил тэгш харьцах зарчмыг мөрдлөг болгоно.

## **8 дугаар зүйл.**

(1) Сайн дурын ажилтныг үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээс өмнө, хэрэгжүүлэгч байгууллага нь сайн дурын үйл ажиллагааны нөхцөлийг тодорхойлсон гэрээг хүлээн авагчтай (хүлээн авагч байгууллагатай харилцан тохирсон тодорхой хөтөлбөр, сайн дурын үйл ажиллагааны төслийн мөн чанарыг харгалзан үзнэ) бичгээр байгуулна. Гэрээнд орон сууц, дотуур байр, ажлын хэрэгсэл бүхий тоног төхөөрөмж, хамгааллын хэрэгсэл, сайн дурын үйл ажиллагааны хяналт, гэрээний хэрэгжилтийг үнэлэх зэрэг асуудлуудыг тусгана. Хэрэгжүүлэгч байгууллага болон хүлээн авагч байгууллагын хооронд байгуулсан гэрээнд сайн дурын ажилтны ажил үүргийн гүйцэтгэлийн явцад сайн дурын ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд аюул занал учруулж болох эрсдэлүүдийн талаар төлөөлөгчдөд мэдэгдэх үүрэг, хүлээсэн үүргийнхээ талаар мэдэгдэх заалтыг тусгана. Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлж хамгаалах, арилгах арга хэмжээ авна.

(2) Хэрэгжүүлэгч байгууллага нь бизнесийн үндсэн үйл ажиллагаатай шууд хамааралтай сайн дурын үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулж болохгүй.

(3) Хэрэгжүүлэгч байгууллагууд нь үйл ажиллагааныхаа жилийн тайланг дараа жилийн 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж, зохих журмын дагуу хэвлэн нийтлэх үүрэгтэй байна.

## **9 дүгээр зүйл.**

(1) Яамнаас магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллага нь энэ хуульд (5-р зүйл, 2-р зүйл) заасан нөхцөл шаардлагыг хангаагүй, эсхүл үүргээ биелүүлээгүй тохиолдолд, Яам, Магадлан итгэмжлэх Хороотой зөвшилцсөний үндсэн дээр магадлан итгэмжлэлийг цуцална. Ингэхдээ яам гэрээгээр хүлээсэн үүргүүдийн биелэлт нь гэрээний хэрэгжилтэд нөлөөлөхгүй байхад анхаарна.

(2) Хэрэв сайн дурын ажилтан нь хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, тухайн байгууллага нь татан буугдсан нөхцөлд, энэхүү гэрээгээр хүлээх эрх, үүргийг тухайн байгууллагын өв залгамжлагчид шилжүүлэх буюу хэрэв залгамжлагч байхгүй тохиолдолд Төрийн байгууллагад шилжүүлнэ. Яам нь эдгээр эрх, үүргийг зохих өөр хэрэгжүүлэгч байгууллагад нэн даруй шилжүүлнэ.

(3) Яам нь энэ хуулийн дагуу тухайн хэрэгжүүлэгч байгууллага энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах эрхтэй. Яамны энэ үйл ажиллагааг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулдаг.

## **10 дугаар зүйл.**

Төр болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь энэхүү хуулийн 2-р зүйлд заасан зорилгоор сайн дурын үйл ажиллагаа явуулж болох бөгөөд хуульд заасны дагуу дээрх нэгжүүдийн статус нь хүлээн авагч байгууллагын статустай ижил байна. Түүнчлэн, хилийн чандад сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад хүлээн авагч байгууллага болон хэрэгжүүлэгч байгууллага хооронд гэрээ байгуулахад хураамж, шимтгэлгүй зуучлалын үүрэг гүйцэтгэж болно.



## 11 дүгээр зүйл. Татаас

(1) Яам нь хэрэгжүүлэгч байгууллагад дараах зориулалтаар татаас олгоно.

- а) 7-р зүйлийн 1 дэх хэсэгт даасны дагуу хэрэгжүүлэгч байгууллага даатгалын гэрээ байгуулсны үндсэн дээр даатгалын төлбөр;
- б) сайн дурын ажилтны бүртгэл хөтлөлттэй холбоотой зардал, сайн дурын үйл ажиллагаа, гүйцэтгэлийг зохион байгуулахад үүссэн зардлуудыг хэсэгчлэн;
- в) 5-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу урт хугацааны турш долоо хоногт дунджаар 20 цагаас дээш ажиллаж буй сайн дурын ажилтны тэтгэврийн доод хэмжээнд тохирох тэтгэврийн даатгалын шимтгэл.

\*\*\*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Law on volunteering, Official Gazette of Republic of Macedonia no. 85 from 09.07.2007  
[http://ecnl.org/dindocuments/157\\_Macedonia%20Law%20on%20Volunteering%20\(eng\).pdf](http://ecnl.org/dindocuments/157_Macedonia%20Law%20on%20Volunteering%20(eng).pdf)
- “Volunteer Act of 2007.” [REPUBLIC ACT NO. 9418]  
<http://www.pnvsca.gov.ph/resources/references/RA9418.pdf>
- Implementing rules and regulations of republic act no. 9418 “an act institutionalizing a strategy for rural development, strengthening volunteerism and for other purposes  
[http://www.pnvsca.gov.ph/resources/references/RA9418\\_IRR.pdf](http://www.pnvsca.gov.ph/resources/references/RA9418_IRR.pdf)
- Framework act on volunteer service activities,  
[https://elaw.klri.re.kr/kor\\_service/lawView.do?hseq=31741&lang=ENG](https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=31741&lang=ENG)
- Enforcement decree, [http://www.vkorea.or.kr/contents/english\\_32.html?sm=8\\_3](http://www.vkorea.or.kr/contents/english_32.html?sm=8_3)
- Volunteering Korea, [http://www.vkorea.or.kr/contents/english.html?sm=8\\_1](http://www.vkorea.or.kr/contents/english.html?sm=8_1)
- Volunteer Services Act, Czech Republic. 2002  
<http://www.legislationline.org/documents/action/popup/id/5788>
- National report, Czech Republic [http://ec.europa.eu/citizenship/pdf/national\\_report\\_cz\\_en.pdf](http://ec.europa.eu/citizenship/pdf/national_report_cz_en.pdf)
- VOLUNTEERING: EUROPEAN PRACTICE OF REGULATION1 June 30, 2014, European Center for Not-for Profit Law
- VOLUNTEERING IN THE EUROPEAN UNION, Educational, Audiovisual & Culture Executive Agency (EAC-EA) Directorate General Education and Culture (DG EAC), 2010  
[http://ec.europa.eu/citizenship/pdf/doc1018\\_en.pdf](http://ec.europa.eu/citizenship/pdf/doc1018_en.pdf)

## ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл  
Р.Оргилмаа,Ц.Элбэгзаяа*

### АГУУЛГА

#### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

#### СУДАЛГААНЫ ХЭСЭГ

#### ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

- КАНАД УЛСЫН ТУРШЛАГА
- БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛСЫН ТУРШЛАГА
- ФИНЛАНД УЛСЫН ТУРШЛАГА
- БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА
- ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТУРШЛАГА
- ИРЛАНД УЛСЫН ТУРШЛАГА
- МАЛАЙЗ УЛСЫН ТУРШЛАГА

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## **СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ:**

Судалгаанд Ази болон Европын орнуудын төлөөлөл болгон ОХУ, Чех, Унгар, Солонгос, Болгар, Япон, Австрали, АНУ, Их Британи, Канад, Малайз, Ирланд, Финланд, Эстони зэрэг орнуудыг хамруулан, эдгээр орнуудын их, дээд сургуулийн хууль, эрх зүйн орчны туршлагыг судалсан болно.

Судалгаанаас үзэхэд ихэнх улс оронд тухайлбал, Чех, Унгар, Солонгос, Болгар, Япон зэрэг орнуудад их, дээд сургуулийн үйл ажиллагааг Боловсролын салбарын суурь хууль болон Дээд боловсролын тухай хуулиар зохицуулж байна.

Харин Ирланд, Финланд, Малайз, Эстони, ОХУ зэрэг орнуудад Их сургууль, түүний харьяа коллежуудын эрх зүйн статус, үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан бие даасан хуультай байгаа бол зарим оронд тухайлбал, Канад, АНУ, Австралид их сургуулийн эрх зүйн байдлыг муж улсын хэмжээнд зохицуулах, эсхүл тухайлсан их сургуулийн үйл ажиллагааг зохицуулах нэрлэсэн хуультай байна.

Судалгааны мэдээлэл хайх явцад, Их сургуулийн тухай бие даасан хуультай орнууд харьцангуй цөөн байсан бол Дээд боловсролын тухай хуулиар их, дээд сургуулийн үйл ажиллагааг зохицуулсан байдал харьцангуй нийтлэг байна.

Их сургуулийн харилцааг бие даасан хуулиар зохицуулсан орнуудын хуулийн зохицуулалтын ерөнхий агуулгаас үзэхэд уг хуулиар их сургуулиудын статус, их сургууль байгуулах, татан буулгах, их сургуулийн удирдлагын бүтэц, эрх үүрэг, удирдах бүрэлдэхүүн болон багш, ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сэлгэн ажиллуулах, их сургуулийн сургалт-судалгааны үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх, үүрэг, академик эрх чөлөө, бие даасан байдал, санхүү-эдийн засгийн харилцаа, гадаад харилцаа, суралцагч болон дээд боловсролын салбар дахь олон нийтийн байгууллагын асуудал, эрдмийн зэрэг цол олгох, аттестатчилах, сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ, үйл ажиллагааны хяналт-аудит зэрэг асуудлуудыг нарийвчлан зохицуулсан байна.

Их, дээд сургуулийн харилцааг Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуулиар зохицуулсан орнуудын хувьд их, дээд боловсролын асуудлыг тусгайлан бүлэг болгон оруулсан байх ба уг бүлэгт дээр дурьдсан асуудлуудыг хэрхэн зохицуулах талаар ерөнхий тусгасан байна. Нарийвчилсан зохицуулалтыг холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд болон их, дээд сургуулийн дүрмээр зохицуулахаар заасан байна.

Мужийн болон тухайлсан их сургуулийн тухай нэрлэсэн хуультай орнуудын хувьд их сургуулийн дотоод болон гадаад үйл ажиллагааг нэлээд тодорхой байдлаар нарийвчлан зохицуулсан байна.

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу энэхүү судалгаанд их сургуулийн тухай бие даасан хуультай орнуудын эрх зүйн зохицуулалтыг түлхүү оруулсан бөгөөд зарим орны хуулийг бүрэн эхээр нь орчуулах, зарим томоохон хуультай орнуудын хуулийн бүтэц, агуулгыг тоймлох хэлбэрээр судалгааны мэдээллийг бэлтгэсэн болно.

## КАНАД УЛСЫН ТУРШЛАГА

### ***Йорк их сургуулийн тухай хууль, 1965***<sup>102</sup>

Канадын Онтарио мужийн Йорк их сургууль 1959 онд байгуулагдсан, Үйл ажиллагааг нь бие даасан хуулиар тусгайлан зохицуулдаг. Анх 1959 онд Йорк их сургуулийн тухай хууль батлагдаж, 1965 онд шинэчлэгдсэн. Канадын Онтарио мужийн хууль тогтоох байгууллагаар хэлэлцэн баталсан энэхүү хууль нь 28 заалттай.

*Өнөөдрийн байдлаар, Йорк их сургууль нь Канадад гуравдугаарт ордог томоохон их сургууль бөгөөд дэлхийн 178 орны 52000 гаруй оюутан суралцдаг. Йорк их сургууль нь олон хэл дээр сургалт, судалгаа явуулдаг дэлхийн стандартад нийцсэн сургалтын бааз, хөтөлбөртэй бөгөөд орчин үеийн 11 факультеттэй. Йорк сургууль нь олон-хэлт сургалтын хөтөлбөр, олон-кампус үйл ажиллагаа явуулдагаараа бусад их сургуулиудаас онцлог, давуу талтай гэж үздэг. Эдгээрээс Glendon campus бол олон улсын хөтөлбөрөөр тэргүүлэх кампус бөгөөд 2-оос дээш хэл дээр сургалтын үйл ажиллагаа явуулж, олон улсын бакалаврын зэрэг олгож байна. Hyderabad, India, Costa Rica-д кампустай бөгөөд 2021 онд Торонтод City of Markham шинэ кампус нээхээр төлөвлөж байна. Дэлхийн 300 гаруй институттай хамтран ажилладаг.*

*Хуулийн бүтэц, агуулгыг тоймлобол:*

1. Нэр томъёоны тайлбар, тодорхойлолт;
2. Йорк их сургууль, түүний ТУЗ, Канцлер, Ерөнхийлөгч, Сенат болон холбогдох бусад бүх харилцааг энэ хуулиар зохицуулна;
3. Их сургуулийн статус, дүрэм, үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтнуудын томилгоотой холбоотой асуудлууд, тэдгээрийн эрх, үүрэг зэргийг тус хуулиар тогтооно;
4. Их сургуулийн үйл ажиллагааны зорилго, зорилт нь:
  - (a) мэдлэг олж авах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх;
  - (b) хамт олны гишүүн болгоны ухамсар, оюун санаа, ёс суртахуун болон бие бялдарын хөгжлийг дээд түвшинд хүргэх;
5. Их сургууль нь харьяа салбар факультет, сургууль, институт, газар хэлтэс, тэнхим, курс зэргийг байгуулан ажиллуулж болно;
6. Их сургуулийн харьяанд сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бүх салбар нэгжүүд боловсролын зэрэг, диплом, сертификат олгоно;
7. Йорк их сургуулийн удирдлагын зөвлөл нь дараах этгээдүүдээс бүрдэнэ; Үүнд:
  - (a) Канцлер;
  - (b) Ерөнхийлөгч;
  - (c) Нийт гишүүдийн 30%-аас илүүгүй гишүүдийг 4 жилийн хугацаатайгаар Удирдлагын зөвлөлийн гишүүдийг сонгох журмын дагуу сонгох;
8. Удирдах зөвлөлийн гишүүдээс 1 хүнийг их сургуулийн захирлаар 7 жилийн хугацаатайгаар сонгох ба уг этгээд 1 удаа дахин сонгогдох эрхтэй;
9. Удирдлагын зөвлөлийн гишүүн бүрт мэдэгдэл хүргүүлсэнээс 30 хоногийн дараа, УЗ-ийн гишүүдийн 2/3-ын саналаар баталсан шийдвэрийн дагуу сул байгаа орон тоон дээр гишүүн сонгон шалгаруулах тухай нээлттэй зарлана;

a

<sup>102</sup> <http://secretariat.info.yorku.ca/governance-documents/york-university-act-1965/>

10. Энэ хуулиар их сургуулийн үйл ажиллагааг удирдах, үйл ажиллагааг нь хөтлөн явуулах менежментийн болон хяналтын эрхийг Сенатад тусгайлан олгохоос гадна их сургуулийн өмч хөрөнгийг захиран зарцуулах, орлого, зарлага, бизнесийн болон гадаад харилцааны үйл ажиллагааны чиглэлээр шийдвэр гаргах эрхийг Удирдах зөвлөлд олгоно. Удирдах зөвлөл нь үүргээ хэрэгжүүлэх зайлшгүй болон шаардагдах бүх эрхээр хангагдах ба дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- (a) Канцлерийг томилох болон чөлөөлөх;
- (b) Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг томилох болон чөлөөлөх;
- (c) Удирдах зөвлөлийн зүгээс их сургуулийн эрх ашгийн үүднээс сургуулийн удирдах бүрэлдэхүүн, багш нар болон бусад ажилтан албан хаагчдыг томилох, чөлөөлөх асуудалд оролцох шаардлагатай гэж үзвэл оролцож болох авч сургуулийн үйл ажиллагааг удирдах үүрэгтэйгээр тодорхой хугацаагаар сонгогдсон Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр Ерөнхийлөгчөөс бусад багшлах бүрэлдэхүүн болон удирдах бүрэлдэхүүний гишүүдийг томилох болон чөлөөлөхгүй;
- (d) Ажилтан, албан хаагчдын тоо, ажил үүргийн хуваарь, цалин хөлс болон шагнал урамшууллын хэмжээг тогтоох;
- (e) Хэрэв шаардлагатай гэж үзвэл Гүйцэтгэх хороо болон бусад ийм төрлийн хороо байгуулж гишүүдийг томилох, эдгээр хороодын хурал хүчинтэй байх ирцийн хувь, шийдвэр гаргах саналын хувь хэмжээг тогтоох, Гүйцэтгэх захиралд шийдвэрлэх саналын эрх олгох болон олгохгүй байх, Удирдах зөвлөлийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг уг хорооны бүрэлдэхүүнд оруулах эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэх;
- (f) Удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзвэл, их сургуулийн үйл ажиллагаанд зориулан хэдий хэмжээний мөнгийг, ямар нөхцөлтэйгээр, ямар хувь хүн, фирм, корпорациас зээлээр авч болохыг тодорхойлох;
- (g) Өрийн бичиг болон вексель гаргах, шилжүүлэх, батламжлах;
- (h) Удирдах зөвлөлийн шийдвэрээр өрийн бичиг болон вексель гаргасан тохиолдолд үнэт цаасны баталгааг хангах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор их сургуулийн өмч хөрөнгийг бүхэлд нь болон хэсэгчлэн үл хөдлөх хөрөнгийн зээлийн барьцаанд тавих, батлан даалт гаргах;
- (i) Бонд, урт хугацааны баталгаагүй облигаци, өрийн бичиг гаргасан тохиолдолд дээрх үнэт цаасыг гаргах болон үүргийн гүйцэтгэлийг хангах нөхцөлийг Удирдах зөвлөлөөс тогтоох ба дээрх үнэт цаасны барьцаа, баталгааг хэрхэн хангах, хэрхэн худалдан борлуулах, хэдий хэмжээтэй, ямар үнэтэй гаргах, их сургуулийн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн барьцаалах, баталгаа гаргах зэрэг асуудлыг Удирдах зөвлөлөөс шийдэх;
- (j) Хуулийг дагаж гарах дүрэм, журмын хүрээнд Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн явуулах, хурал хүчинтэй байх ирцийн хувь хэмжээ ямар байх, зөвлөлийн гишүүдийг сонгох болон сул орон тоонд хэрхэн нэр дэвшүүлэх, хэрхэн сонгох зэрэг асуудлуудыг журамлах;
- (k) Сенаттай зөвшилцсөний үндсэн дээр их сургуулийн харьяанд шинээр факультет, сургууль, институт байгуулах.

11. Их сургуулийн Сенат дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- (a) Канцлер;
- (b) Удирдах зөвлөлийн дарга;
- (c) Ерөнхийлөгч;
- (d) Glendon коллежийн захирал;
- (e) Бүх факультетийн декан;

- (f) Atkinson коллежийн захирал;
- (g) Номын сангийн захирал;
- (h) Их сургуулийн дэд ерөнхийлөгчид;
- (i) Факультетийн хэлтэс, газрын захирлууд;
- (j) Удирдах зөвлөлийн гишүүдээс 2-оос доошгүй, 4-өөс ихгүй төлөөлөгч;
- (k) Сенатаас зөвшөөрсөн мөн ийм тооны бусад хүмүүс;

Бүтэн цагаар багшилдаг багш нарын баг, бүрэлдэхүүний төлөөллөөс Сенатын бүрэлдэхүүний дийлэнх хувь нь бүрдэнэ.

12. Сенат нь их сургуулийн академик үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох үүрэгтэй байх бөгөөд Удирдах зөвлөлд шинээр факультет, сургууль, институт болон факультет дотор шинэ салбар, тэнхим байгуулах талаар зөвлөмж гаргах эрхтэй. Мөн факультет, салбар сургууль, институтэд итгэмжлэгдсэн зөвлөлийг байгуулж болох ба уг зөвлөлийн эрх үүрэг, үйл ажиллагааны журмыг ерөнхий эрхийг нь хязгаарлахгүйгээр дараах хүрээнд тогтооно. Үүнд:
  - (a) Их сургуулийн Канцлер болон Ерөнхийлөгчийг томилох асуудлаар Удирдах зөвлөлд санал, зөвлөмж хүргүүлэх;
  - (b) Их сургуульд оюутан элсүүлэхэд тавигдах шаардлага, элсэлтийн журам, бүх сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын хөтөлбөр, төгсөгчдөд тавигдах шаардлагыг тодорхойлох;
  - (c) Шалгалтыг удирдан явуулах, шалгалт авах багш нарыг томилох;
  - (d) Fellowship, scholarship хөтөлбөр хэрэгжүүлэх, академик амжилт гаргасан оюутнуудад медаль, цом, өргөмжлөл, шагнал олгох;
  - (e) Бакалавр, магистр, докторын болон бусад зэрэг олгох, их сургуулийн харьяа бүх сургалтын институт төгсөгчдөд диплом, сертификат олгох;
  - (f) Удирдах зөвлөлтэй зөвшилцсөний дагуу их сургуулийн хүндэт зэрэг, цол олгох;
13. (1) Их сургуулийн үйл ажиллагааг Удирдах зөвлөлөөс Сенаттай зөвшилцөж томилсон Ерөнхийлөгч удирдах бөгөөд Удирдах зөвлөлийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.
  - (2) Ерөнхийлөгч нь Дэд-Канцлер бөгөөд Их сургуулийн гүйцэтгэх захирлын статустай байх бөгөөд дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
    - (a) Канцлергүй байх, эсхүл Канцлерийн оффист орон гарсан тохиолдолд Канцлерийн үүрэг гүйцэтгэх;
    - (b) Их сургуулийн хэмжээнд сургалтын бодлого хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, гүйцэтгэх удирдлагаар хангах, багшлах баг бүрэлдэхүүн, ажилтан албан хаагчид, үйлчилгээний ажилтнууд болон оюутнуудыг удирдлагаар хангаж их сургуулийн ерөнхий удирдлагыг хэрэгжүүлэх;
    - (c) Оюутнууд болон оюутны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах дүрэм, журам гаргаж хэрэгжилтийг хангуулах;
    - (d) Их сургуулийн багш, ажилтан, албан хаагчдыг томилох, шилжүүлэх, дэвшүүлэх, чөлөөлөх талаар Удирдах зөвлөлд санал гаргах;
    - (e) Их сургуулийн Удирдах зөвлөл болон Сенатад шинээр факультет, сургууль, институт байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал гаргах;
    - (f) Дээд боловсрол олгох үйл ажиллагаа болон Их сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
    - (g) Их сургуулийн факультет, харьяа сургууль, институтууд болон багшлах боловсон хүчин, оюутнуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар Удирдах зөвлөл болон Сенатад санал хүргүүлэх;



- (h) Ерөнхийлөгчийн дэргэд сургалтын асуудлаар зөвлөх зөвлөл байгуулах, их сургуулийн үйл ажиллагааг сайжруулах талаар чиглэл өгөх;
- (i) Удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд их сургуулийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой бусад эрх, үүргээ хэрэгжүүлэх;
- (3) Удирдах зөвлөлөөс 1 ба түүнээс дээш тооны дэд ерөнхийлөгчийг томилж болох бөгөөд тэдгээр нь Ерөнхийлөгчөөс олгосон эрх, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдгээрээс 1 Дэд ерөнхийлөгчид Ерөнхийлөгчийг орлох эрх олгох бөгөөд Ерөнхийлөгчийг эзгүйд, эсхүл Ерөнхийлөгчийн орон гарсан тохиолдолд томилогдсон Дэд ерөнхийлөгч Ерөнхийлөгчийн бүх эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
14. Их сургууль нь Канцлертай байх бөгөөд түүнийг Удирдах зөвлөлөөс Сенаттай зөвшилцөн томилно. Канцлер нь Удирдах зөвлөлийн таалалд нийцсэн, Их сургуулийн бэлэгдлийн төдий нэрлэсэн (titular) удирдлага байх бөгөөд бүх төрлийн цол, зэрэг олгох зэрэг үүрэгтэй. Канцлер нь 3 жил хүртэлх хугацаагаар томилогдож өөрийн оффистой байх ба дараагийн залгамжлагч томилогдох хүртэл ажиллана.
15. Их сургуулийн профессор, лектор, багш, ажилтан, албан хаагчдад шашин шүтлэгтэй холбоотой ямар нэгэн шаардлага тавихгүй бөгөөд тодорхой шашны урсгал, шашны зан үйлийг дагаж мөрдөхийг шаардах эрхгүй.
16. Их сургууль нь Тайлбар хууль /Interpretation act/-ийн 26-р зүйлд заасны дагуу нэмэлт эрх мэдэл, эрх болон давуу байдлыг эдлэнэ. Тухайлбал, бүх төрлийн өмч хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийг худалдан авах, бэлэг хандиваар хүлээн авах, өгөх, гэрээслэлийн дагуу өмч хөрөнгө хүлээн авах, эсхүл өвлүүлэх, эдгээр өмч хөрөнгийг эзэмшиж, ашиглах зэрэг эрхтэй. Тухайн өмч хөрөнгө нь биет хөрөнгө үү, хувь хүний хөрөнгө үү гэдгээс үл хамааран уг хөрөнгийг өмчлөх, эзэмших, захиран зарцуулах эрхтэй байх хугацаандаа худалдан борлуулах, барьцаа баталгаанд тавих, үл хөдлөх хөрөнгийн зээлд барьцаалах, түрээслүүлэх зэрэг бүр эрхийг хэрэгжүүлнэ.
17. Их сургууль, түүний факультет, харьяа сургууль, тэнхимүүдийн эрх ашгийн үүднээс өмч хөрөнгө шилжүүлэх, буцалтгүй тусламжаар олгох, гэрээслэлийн дагуу хэн нэгэн этгээдэд шилжүүлэх зэрэг эрхтэй.
18. Их сургуулийн үйл ажиллагаанд зориулан олгосон, өөрийн эзэмшиж байгаа болон түрээслүүлсэн өмч хөрөнгө, газрыг түрээслэснээс олсон орлогоос татвар авахгүй.
19. Их сургуулийн өмчлөл, эзэмшлийн биет хөрөнгийг орон нутгийн засаг захиргааны байгууллагаас өөр хэн нэгэн этгээд, корпораци ашиглах болон авах, албадан хураах, улсын өмч болгох эрхгүй.
20. Их сургуулийн хэрэгцээнд тусгайлан олгосон бүх хөрөнгө нь Онтарио мужийн нийтийн хэрэглээний өмч хөрөнгөд тооцогдоно.
21. Их сургуулийн хөрөнгө, орлого, үнэт цаас гаргаснаас олсон орлого, ашиг зэрэг нь гагцхүү их сургуулийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд зориулагдана.
22. Их сургуулийн санд орсон хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны зориулалтаар шууд ашиглахаас өмнө Удирдах зөвлөлд танилцуулж, сургуулийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, дахин хөрөнгө оруулалтанд ашиглах эсэх асуудлыг Удирдах зөвлөлөөр шийднэ.
23. Их сургуулийн Удирдах зөвлөл нь Сенаттай зөвшилцсөний дагуу бусад их сургууль, коллеж, институттай сургалтын үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллах эсэх, ямар нөхцөлөөр, ямар хугацаанд хамтран ажиллах зэрэг асуудлыг шийднэ.
24. Их сургуулийн санхүүгийн тайланд жилд дор хаяж 1 удаа аудит хийнэ.
25. Хотын захиргааны даргын хүсэлтээр Их сургуулийн жилийн тайлан, холбогдох бусад тайланг гаргаж өгч болно.

26. Йорк их сургуулийн тухай хууль /York University Act, 1959/-ийг хүчингүй болсонд тооцсон.
27. Энэхүү хууль нь хааны зөвшөөрлийг авсан өдрөөс эхлэн хүчинтэй.
28. Энэ хуулийг Йорк их сургуулийн тухай хууль 1965 гэж нэрлэсэн.

## **БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛСЫН ТУРШЛАГА**

Бүгд Найрамдах Эстони Улс (БНЭсУ)-д их сургуультай холбогдох харилцааг 1995 онд баталсан “Их сургуулийн тухай”<sup>103</sup> хуулиар зохицуулдаг байна. Энэ хуулиар их сургууль байгуулах, нэгтгэх, салбар сургууль байгуулах, их сургуулийн үйл ажиллагааны үндэс, үйл ажиллагааг зогсоох, их сургуулийн бүрэн эрх, зохион байгуулалтын зарчим, дээд боловсрол эзэмших нөхцөл, их сургуулийн эд хөрөнгө, их сургуулийн санхүүжилт, багш, сурган хүмүүжүүлэгч болон оюутан суралцагчдын үндсэн эрх, үүрэг, түүнчлэн их сургуулийн үйл ажиллагааг төрөөс хянах, зохицуулахтай холбоотой харилцааг зохицуулна. Тус хууль нь нийт 8 бүлэг 59 зүйлтэй. Тухайлбал:

### **Бүлэг 1 Нийтлэг үндэслэл:**

- Хуулийн зорилт;
- Хуулийн хамрах хүрээ;
- Их сургуулийн магадлан итгэмжлэл;
- Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ;
- Гадаад улсад суралцахыг дэмжих.

### **Бүлэг 2 Бүтэц, зохион байгуулалт:**

- Их сургуулийн зөвлөл;
- Их сургуулийн зөвлөлийн дүрэм;
- Ректор;
- Их сургуулийн бүтэц.

### **Бүлэг 3 Сургалтын бүтэц, зохион байгуулалт:**

- Их сургуулийн элсэлтэд тавигдах шаардлага;
- Дээд боловсролын стандарт;
- Сургалтын бүтцэд тавигдах ерөнхий шаардлага;
- Хамтарсан сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага;
- Шинэ хичээлийн хөтөлбөр боловсруулах, заах эрх олгох;
- Академик түвшин (Мэргэжлийн дээд боловсрол, Бакалаврын болон Магистрын сургалт).

### **Бүлэг 4 Их сургуулийн гишүүд:**

- Багшлах боловсон хүчин, судлаач багш нар;
- Оюутнууд, тэдний эрх, үүрэг;
- Оюутны зөвлөл.

### **Бүлэг 5 Их сургууль “Иргэний хууль”-ийн субъект болох нь:**

- Их сургуулийн хөрөнгө;
- Хөрөнгийн хэрэглээ;
- Хөрөнгийн борлуулалт;
- Их сургуулийн хууль эрх зүйн чадамж;
- Их сургуулийн иргэний эрхийн хязгаарлалтууд.

### **Бүлэг 6 Санхүүжилт:**

- Их сургуулийн санхүүжилт;

а\_\_\_\_\_

<sup>103</sup> <https://www.riigiteataja.ee/en/eli/521032014002/consolide>

- Улсын төсвөөс боловсролын байгууллагуудад дээд боловсролын түвшний сургалт явуулахад болон их сургуулийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүжилт олгох ;
- Их сургуулийн төсөв;
- Их сургуулийн санхүүгийн төлөвлөгөө.

**Бүлэг 7 Аудит, хяналт болон тайлан:**

- Улсын хяналтын байгууллага, түүний эрх хэмжээ;
- Хянан шалгах үйл ажиллагааны тухай заавар;
- Тайлан.

**Бүлэг 8 Хуулийг хэрэгжүүлэх.**

**ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Хуулийн 1-р бүлэгт: хуулийн хамрах хүрээг тодорхойлж, их сургуулийг байгуулах, нэгтгэх, салбар сургууль байгуулах, их сургуулийн үйл ажиллагааг зогсоох, тараах, их сургуулийн нэрийг өөрчлөх зэрэг асуудлыг БНЭсУ-ын Засгийн газрын санаачилгаар парламент (Рийгикогу) шийдвэрлэнэ гэжээ. Их сургуулийн эрх зүйн байдал, магадлан итгэмжлэл, магадлан итгэмжлэлийг олгох Эстониин дээд боловсролын чанарын агентлаг, түүний үйл ажиллагаа, их сургуульд оюутан элсүүлэх, их сургууль төгссөнийг гэрчлэх төрөөс олгох баримт бичиг буюу дээд боловсролын дипломыг хэнд, ямар нөхцөлд олгох, сургалтын төлбөр, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, хөнгөлөлт эдлэх нөхцөл, сургалтын төлбөрийн дээд хязгаарыг Засгийн газраас тогтоох тухай, мөн түүнчлэн Боловсрол, судалгааны яам нь оюутнуудыг гадаад улсад суралцахад хэрхэн дэмжлэг үзүүлж болох талаар хуульчилсан байна.

Хуулийн 2-р бүлэгт: их сургуулийн зөвлөлийг бүрдүүлэх үйл явц, зөвлөлийн үйл ажиллагааны үндэс, зөвлөлийн дүрэм, зөвлөлийн эрх, үүрэг, их сургуулийн удирдлага, түүнд тавигдах шаардлага хийгээд удирдлагаар ажиллах хугацааг тодорхой хуульчилсан төдийгүй их сургуулийн бүтэц, зорилго, үйл ажиллагааны цар хүрээ болон өвөрмөц онцлог зэрэг асуудлыг энэ хууль болон тухайн их сургуулийн дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ гэжээ.

Хуулийн 3-р бүлэгт: их, дээд сургуулиуд Бүгд Найрамдах Улсын Засгийн газраас баталсан “Дээд боловсролын стандарт”-ыг баримтлах хийгээд их сургуулиуд дангаар болон дотоод, гадаадын их сургуулиудтай хамтран сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, гэрээний нөхцөл, шинээр хичээлийн хөтөлбөр боловсруулах зэрэгт дээрх стандартыг баримтлахаар заажээ. Шинээр хичээлийн хөтөлбөр боловсруулж буй их сургууль нь тухайн хүсэлтээ шинэ хичээлийн жил эхлэхээс 9 сарын өмнө Боловсрол, судалгааны яаманд танилцуулах бөгөөд хүсэлтийн дагуу яамнаас мэргэжилтэн томилогдон тухайн хичээлийн хөтөлбөр болон түүнийг эзэмшүүлэх багшид үнэлгээ өгч, шаардлага хангасан тохиолдолд эрхийг олгоно гэж хуульчилсан байна.

Хуулийн 4-р бүлэгт их сургуулийн багш ажилтнууд болон оюутнуудтай холбогдох харилцааг зохицуулахаар заажээ. Багшлах боловсон хүчний бүрэлдэхүүнд профессор, эрдэм шинжилгээний ажилтан, илтгэгч, туслах ажилтан болон багш нар орно. Багшлах боловсон хүчин болон судлаач багш нар их сургуулийн тухайн орон тоон дээр өрсөлдөөнт шалгаруулалтаар 5 хүртэлх жилийн хугацаатай сонгогдон ажиллана. Хичээлийн жилийн үеэр их сургуулийн багшлах боловсон хүчинтэй байгуулсан гэрээг цуцалж орон тооны цомхотголд оруулж болохгүй. Багшлах боловсон хүчинд 5 жил тутамд нэг удаа ур чадвараа дээшлүүлэхэд нь зориулж тэтгэмж олгоно.

Хуулийн 5-р бүлэгт: зааснаар Их сургууль нь өөрийн хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эзэмших эрхтэй. Их сургууль нь өөрийн хөрөнгөө өмчлөх, ашиглах,

захиран зарцуулах эрхтэй. Их сургууль нь аливаа сангийн үйл ажиллагааг ивээн тэтгэх, зээл олгох, тухайн санд хандив өгөх эрхгүй. Их сургууль нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд үнэ төлбөртэйгөөр үйлчилгээ (мэргэжлийн сургалт, гэрээт судалгаа, мэргэжлийн зөвлөгөө) үзүүлж болох бөгөөд үүнээс олсон орлогоо их сургуулийн төсөвт байршуулна.

Хуулийн 6-р бүлэгт: их сургуулийн санхүүжилттэй холбоотой асуудлыг зохицуулна. Их сургуулийн санхүүжилт нь улсын төсвөөс хуваарилсан мөнгө, оюутнуудын сургалтын төлбөр, судалгаа, шинжилгээ болон бусад үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ. Дээд боловсролын түвшний сургалтанд зориулж улсын төсвөөс хуваарилсан мөнгөний 70-75%-ийг сургалтын цар хүрээ, чанар, үр ашгийг сайжруулахтай холбоотой үйл ажиллагааг дэмжихэд, 25-30%-ийг үндэсний хэмжээний ач холбогдол бүхий сургалтын хөтөлбөрийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах шаардлагатай. Бүгд Найрамдах Улсын Засгийн газраас баталсан журмын дагуу оюутны тэтгэлэгт хамрагдах нөхцөл, тэтгэлгийн төрөл, хэмжээг тогтооно. Их сургуулийн орлого, зарлагаас хамааран их сургуулийн төсвийг тэнцвэртэйгээр батлах шаардлагатай. Их сургуулийн зөвлөл нь их сургуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хянаж, ирэх жилийн төсвийн төслийг батална. Их сургууль нь “Улсын төсвийн тухай” хуульд заасны дагуу жил бүр санхүүгийн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Тус төлөвлөгөө нь тухайн жилийн их сургуулийн төсвийг батлах үндэс болно.

Хуулийн 7-р бүлэгт: “Улсын аудитын газрын тухай” хуулийн дагуу Улсын аудитын газар нь их, дээд сургуулийн үйл ажиллагаанд аудит хийнэ. Их сургуулийн эдийн засаг, санхүүтэй холбоотой үйл ажиллагааг их сургуулийн зөвлөлөөс тогтоосон байнгын болон тусгай аудитаар хянана.

Боловсрол, шинжлэх ухааны яам нь (цаашид Улсын хяналтын байгууллага гэнэ) их сургуулиудын үйл ажиллагааны хууль эрх зүйн байдалд хяналт тавина.

Хэрэв хууль зөрчсөн нь тогтоогдвол зөрчлийг арилгах заавар боловсруулж тухайн сургуульд илгээнэ. Хэрэв зааврыг мөрдөхөөс татгалзвал Улсын хяналтын байгууллага нь тухайн сургуульд торгууль тавих эрхтэй. Их сургууль нь хуулийн хүрээнд зарцуулсан төсвийнхөө тайланг болон үйл ажиллагааныхаа статистик мэдээллийг Улсын хяналтын байгууллагад илгээх үүрэгтэй.

Хуулийн 8-р бүлэгт: энэхүү хуулийг батлагдахаас өмнөх их сургуультай холбогдон бий болсон харилцааг хууль батлагдсанаас хойш хэрхэн зохицуулах талаар хуульчилжээ.

## **ФИНЛАНД УЛС**

Финланд улс нь их сургуулийн үйл ажиллагааг 2009 онд батлагдсан **Их сургуулиудын хууль**<sup>104</sup> 558/2009 бие даасан хуулиар зохицуулдаг бөгөөд тус хууль нь 11 бүлэг 93 зүйлтэй. Үүнд:

1-р бүлэг. Нийтлэг үндэслэл

2-р бүлэг. Судалгаа, сургалт

3-р бүлэг. Байгууллага

4-р бүлэг. Албан хаагч, албан хаагчдын харилцах хэл

5-р бүлэг. Оюутан

6-р бүлэг. Их сургуулийн удирдлага, санхүүжилт

7-р бүлэг. Их сургуулийн санхүү

8-р бүлэг. Хельсенкийн их сургуульд хамаарах тусгай зохицуулалт

а

<sup>104</sup> Universities act, <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2009/en20090558.pdf>

9-р бүлэг. Або Академийн их сургуульд хамаарах тусгай зохицуулалт

10-р бүлэг. Гомдол гаргах журам

11-р бүлэг. Бусад

## **ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Нийтлэг үндэслэл: Нэгдүгээр бүлгээр хуулийн хамрах хүрээ, зорилго, их сургуулийн эрх зүйн байдал, бүрэлдэхүүн зэргийг тодорхойлсон байна. Энэ хууль нь Финланд улсын Боловсрол ба Соёлын яамны дэргэдэх нэр бүхий 12 улсын сургуульд хамаарна. Их сургуулиудын зорилгыг бие даасан эрдэм шинжилгээний судалгаа, эрдэм шинжилгээний болон уран сайхны боловсролыг санал болгох, судалгаанд үндэслэсэн дээд боловсролыг олгох, оюутнуудыг эх орон болон хүн төрөлхтний тусын тулд үйлчлэхэд сургах явдал гэж хуулийн 2-р зүйлд тодорхойлжээ. Их сургууль нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд өөрийн дотоод асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй. Бие даасан байдал нь их сургуулиудад тэдгээрийн дотоод удирдлагын асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг олгодог.

Хууль тогтоомжийг боловсруулан гаргахад их, дээд сургууль нь энэ талаарх саналаа илэрхийлэх боломжийг олгодог байна. Их сургуулийн бүрэлдэхүүн нь багш, эрдэм шинжилгээний ажилтан, бусад ажилчид, оюутнуудаас бүрдэнэ. Улсын сургуулиуд нь үүрэг амлалт авах, өөрийн нэрээр эрх олж авах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхтэй. Их сургуулиуд нь өөрийн үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр хариуцаж, шүүхэд нэхэмжлэл гаргах, маргаанд оролцох эрхтэй. Мөн их сургуулиуд нь зорилгоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно.

Сургалт, судалгаа: Хуулийн 2-р бүлэгт их сургуулиудын сургалт, судалгаа, боловсролын зэрэглэл, түүний хүрээ, хэлний болон бусад бэлтгэл хөтөлбөр, мэргэжлийн гүнзгийрүүлсэн хөтөлбөр болон мэргэжлийн боловсрол, сургалтын болон бусад төлбөр, сургалт явуулах хэлний талаар тусгасан байна. Их сургуулиуд нь өөрийн үйл ажиллагаандаа боловсролын болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана. Их сургууль нь бакалавр, магистрын болон дипломын дараах сургалтын зэрэг олгоно. Мөн зэрэг олгохгүйгээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлж болно. Бакалавр, магистр, докторын зэрэг нь шаталсан зарчмаар явагдах бөгөөд харин Засгийн газраас шаардлагатай мэргэжлийг баталсан бол заавал тухайн мэргэжлээр бакалаврын зэрэг шаардахгүйгээр өөр чиглэлээр магистрын зэрэг олгож болдог байна.

Их сургуулиуд нь сургалт болон элсэлтийн шалгалтын хураамжаас оюутнуудыг чөлөөлдөг боловч хэлний болон бусад их сургуулиудтай харилцаа холбоо тогтоон хамтран ажиллах чиглэлээр оюутнуудад төлбөр тогтоож болно. Мөн Швед, Фин хэлнээс бусад хэл дээр суралцах Европын холбооны иргэдээс бусад оюутнуудын бакалавр, магистрын сургалтанд жилдээ 1500 еврогоос доошгүй төлбөр тогтоож болно. Европын холбооны хөх карттай, эсхүл Европын холбооны улсад байнга, эсхүл удаан хугацаагаар оршин суух эрхтэй иргэд тэдгээрийн гэр бүлд сургалтын төлбөр тогтоохыг хориглодог. Их сургуулиуд нь төлбөр төлөн суралцах оюутнуудад зориулсан сургалтын тэтгэлэгтэй байна. 2012 оны нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар их сургуулиудад сургалт явуулах хэлийг Швед, Фин хосолсон, эсхүл дангаар зэргээр тодорхой зааж өгсөн байна. Хуулийн 12 дугаар зүйлд нэр бүхий 4 их сургууль нь улсын хэрэгцээ шаардлагын дагуу Швед хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн хангалттай тооны оюутнуудыг бэлтгэн гаргах үүрэгтэй гэж заасан байна.

Их сургуулийн бүтэц: Тус хуулийн 3-р бүлэгт сургуулийн удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, огцруулах, чөлөөлөх, ректор, удирдлагын үүрэг, захирал болон удирдах зөвлөлийн гишүүдийн хариуцлага, коллеги гэх мэт сургуулийн бүтэцтэй холбоотой асуудлуудыг зохицуулсан байна. Тухайлбал, хуулийн 13-р зүйлд зааснаар их сургуулийн захиргааны бүтэц нь удирдах зөвлөл, ректор, коллеги байх



ба их сургуулийн дүрэмд заасан бол канцлер болон бусад нэгж байж болно. Удирдах зөвлөл нь их сургуулийн зарчим, стратеги, үйл ажиллагаа, санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, ректорыг томилох, чөлөөлөх зэрэг асуудлаар дээд шийдвэр гаргах эрх бүхий нэгж байна. Удирдах зөвлөл нь 7, эсхүл 9-14 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн тоог коллегийос тогтоохоор заасан байна. Удирдах зөвлөл нь профессор, багш нар болон бусад албан хаагчид болон оюутны төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлд ректор, проректор, тэнхимийн эрхлэгч болон үйл ажиллагааны хувьд удирдах зөвлөлөөс шууд хамааралтай этгээд орохыг хориглоно. Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

Ректор нь удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, удирдах зөвлөлөөр хэлэлцэх асуудлыг хариуцан бэлтгэх, тайлагнах, их сургуулийн дүрмээр тогтоосон бусад нэгжтэй харилцах ажлаас бусад чиглэлээр их сургуулийн үйл ажиллагааг удирдан явуулах, албан хаагчдыг томилох, чөлөөлөх зэрэг асуудлыг хариуцан гүйцэтгэнэ. Их сургууль нь өөрийн дүрэмдээ заасан тооны дэд ректортой байж болно. Ректор нь докторант байх бөгөөд удирдах ажлын ур чадвар бүхий байна. Бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

Их сургууль нь 50 хүртэлх тооны гишүүд бүхий коллегитэй байна. Коллегид профессор, багш болон бусад ажилчид, оюутнууд гэсэн 3 бүлгээс төлөөлөн сонгогдох ба аль нэг бүлгийн төлөөлөл нийт гишүүдийн талаас дээшгүй байна. Коллеги нь удирдах зөвлөлийн гишүүд, санхүүгийн аудиторыг томилох, чөлөөлөх, санхүүгийн тайланг баталгаажуулах бүрэн эрхтэй байна.

Их сургууль нь өөрийн үйл ажиллагааг гүйцэтгэх профессор, багш нар болон бусад албан хаагчдыг авч ажиллуулах ба тэдгээрт тавигдах шаардлагыг их сургуулийн дүрмээр тогтооно. Эрхлэн гүйцэтгэх ажил үүргийг хөдөлмөрийн гэрээгээр тодорхойлно. Албан хаагчдад хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Эрүүгийн хуулийн 40-р бүлэгт зааснаар шийдвэрлэнэ. Албан хаагчдын үйл ажиллагаагаа явуулах хэлийг сургууль бүрт адилгүй байдлаар Швед, эсхүл Фин хэл байхаар заасан байна.

Оюутан: 5-р бүлгээр дараах асуудлуудыг зохицуулсан байна. Үүнд:

Элсэлт, элсэлт хамтран зохион байгуулах, элсэгчийн байр хадгалах, элсэлтэд тавигдах шаардлага, элсэгчийг бүртгэх, хичээлийн жил, түүний хугацаа, бүртгэл, боловсролын зэрэг олгох хугацаа норматив, суралцагчийн эрх, сургалтын үнэлгээ, суралцагчдад хүлээлгэх хариуцлага, оюутны зөвлөл гэх мэт. Оюутныг элсүүлэх шийдвэрийг их сургуулиас гаргах ба элсэлтийн шалгуурыг их сургуулиас тогтооно. Нэг салбарт суралцах оюутнуудад тавигдах шаардлага харилцан адилгүй байхыг хориглодог байна.

Дипломын дараах зэрэг олгохоос бусад бакалаврын элсэлтийг дээд боловсролын байгууллагууд хамтран зохион байгуулна. Хэрэв хамтарсан элсэлтийн шалгалт зохион байгуулах хугацаанд багтах боломжгүй, их сургууль тусдаа өөрийн шалгуур тавьсан, эсхүл зохих нийгмийн эмзэг, хязгаарлагдмал бүлэгт зориулсан, гадаад хэл дээр суралцах тохиолдолд их сургууль дангаараа элсэлтийн шалгалтыг зохион байгуулж болно. Хуулийн 36Б зүйлд зааснаар их сургууль гадаад хэл дээр зэргийн сургалт явуулахгүй бол Финландын боловсролын системийн дагуу дээд боловсрол эзэмшсэнд үл тооцогдох оюутнуудад зориулж, зохих квотыг зайлшгүй үлдээх ёстой байдаг байна.

Хуулийн 37-р зүйлд зааснаар дээд сургуулийн элсэлтийн шалгалтын тухай хуульд заасан шалгалтыг өгсөн, гадаадын оронд суралцсан бол тухайн улсын дээд боловсрол эзэмшихэд тавигдах шаардлагыг хангасан, 3-аас доошгүй жил суралцаж тусгай дунд боловсрол эзэмшсэн гэж элсэгчдэд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлсон байна. Эрүүл мэндийн хувьд тухайн чиглэлээр эзэмших практик сургалтыг сургалтын аюулгүй байдлын шаардлагын үүднээс хангах боломжгүй тохиолдолд элсэгчээр бүртгэхээс татгалзаж болно. Энэ нөхцөл байдлыг тогтоох үүднээс элсэгч нь шаардсан хувийн болон эрүүл мэндийн холбогдох



материалуудыг гаргаж өгөх үүрэгтэй байдаг байна.

Хуульд мөн хичээлийн жил эхлэх, дуусах мөн хичээлийн жилийн улирлын хугацааг зааж өгсөн байна. Хичээлийн жил 8 дугаар сарын 1-нд эхлэн дараа жилийн 7 дугаар сарын 31-нд дуусна. Элссэн оюутнууд нь жирэмсэн, өвчтэй, цэргийн албаны зэрэг шалтгаанаар тухайн хичээлийн жилд суралцах боломжгүй бол энэ талаараа бүртгүүлэх үүрэгтэй.

Дээд боловсрол эзэмших хугацааг мөн зааж өгсөн байна. Урлагийн чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшихэд 3 жил хагас, бусад чиглэлээр 3 жил, магистрын сургалтад анагаахын чиглэлээр 3 жил, хөгжим, сэтгэл зүйн чиглэлээр 2 жил хагас, бусад чиглэлээр 2 жил байхаар тогтоосон. Хуулийн нэг онцлог нь суралцагчдад хүлээлгэх хариуцлагыг тогтоосон байна. 45-р зүйлд зааснаар суралцагч нь сургалтын үйл ажиллагааг тасалдуулах, заналхийлсэн, хүчирхийлсэн үйлдэл гаргах, сургуульд тогтоосон журам зөрчих, согтууруулах ундаа хэрэглэх зэрэг тохиолдолд түүнд бичгээр сануулга өгөх, тухайн зөрчлийг давтан гаргасан бол нэг жилийн хугацаагаар суралцахыг хойшлуулдаг байна. Мөн сургуулийн зүгээс зохих үндэслэл байвал тухайн суралцагчийг цаашид суралцах боломжтой эсэхийг тогтоох үүднээс мансууруулах бодисын хэрэглээний талаар мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж тогтоолгодог зохицуулалт байна. Бичгийн сануулгыг ректороос, суралцахыг хойшлуулах асуудлыг удирдах зөвлөлөөс шийдвэрлэдэг байна.

### **ОХУ-ЫН ТУРШЛАГА**

*ОХУ-ын дээд боловсролын систем:* ОХУ-ын боловсролын систем сүүлийн үед томоохон хэмжээний өөрчлөн байгуулалтын үе шатандаа явж байна. Энэхүү өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд боловсролын салбарын хууль тогтоомжийг өөрчлөх замаар хүлээгдэж байгаа үр дүнд хүрэх зорилт дэвшүүлж, боловсролын салбарын бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүдийг тодорхойлж байна. Тухайлбал, ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 599-р зарлигаар батлагдсан “Шинжлэх ухаан, боловсролын салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол, 2013 оны 01 сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн “ОХУ-ын боловсролын тухай” хууль, “ОХУ-ын боловсролын салбарыг хөгжүүлэх 2013-2020 оны төрийн бодлогын хөтөлбөр”, “2014-2020 онд шинжлэх ухаан ба шинжлэх ухааны багшлах боловсон хүчнийг бэлтгэх талаар баримтлах инновацийн зорилтот хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг нэрлэж болно.

*ОХУ-ын дээд ба мэргэжлийн дээд боловсролын тогтолцоо:* ОХУ-ын 2012 оны 01 дүрээр сарын 01-ний өдрийн статистикийн мэдээгээр, ОХУ-д дээд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж буй 1046 боловсролын байгууллага байгаагаас төрийн өмчит- 609, төрийн бус өмчит- 437 их, дээд сургууль байна. Эдгээр сургуулиуд нь нийтдээ 2100 салбараар дамжуулан 36767 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж, 6,0 сая орчим оюутныг сургаж байна.

1990 оны өөрчлөлт, шинэчлэлээс өмнө ОХУ-д зөвхөн төрийн өмчит их, дээд сургуульд боловсролын асуудал хариуцсан удирдлага дор үйл ажиллагаа явуулж байсан бол 1993 оноос эхлэн хувийн өмчит ИДС-иудын тоо эрс өсч, нийт дүнгээрээ 1,5 дахин өссөн гэсэн статистик байна. Улсын болон хувийн хэвшлийн ИДС-ийн тоо өсөхийн зэрэгцээ салбар сургууль олноор нээгдэх болсон байна. Ялангуяа 2000-2012 онд эдийн засаг, хууль, нийгмийн ухааны чиглэлийн ИДС-иудын тоо эрс өсч 20000-аас 36000-д хүрсэн байна. 1993 онд ОХУ-ын ИДС-д нийт 2,5 сая орчим оюутан суралцаж байсан бол 2008 он гэхэд 7,8 сая болж 3 дахин өсчээ.

Сүүлийн үед дээд боловсролын системд холбооны улсын статустай, мөн үндэсний хэмжээний статустай судалгааны их сургууль зэрэг шинэ категорийн ИДС-иуд бий болж эхэлсэн бөгөөд эдгээр сургуулиуд нь ОХУ-ын дээд боловсролын системийн гол чиглүүлэгч субъектууд болж эхэлсэн байна. Үүний улмаас дээд боловсролын салбарт удирдлагын шинэ практикийг нэвтрүүлэх, шинэ загвар боловсруулах хэрэгцээ шаардлага бий болсон.

- Холбооны улсын статустай их сургууль- Одоогоор ийм статустай 9 ИДС-д холбооны улсын тойрог, муж улсуудын эдийн засаг-нийгмийн хөгжлийн төлөвлөгөөт зорилтод нийцүүлэн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр өндөр хэмжээнд мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэж байна.
- Үндэсний статустай судалгааны их сургууль- Одоогоор ийм статустай 29 ИДС-д шинжлэх ухаан, техник, өндөр технологийн тэргүүлэх чиглэлээр мэргэжлийн өндөр түвшинд боловсон хүчин бэлтгэх зорилт тавин ажиллаж байна.
- Тусгай статустай их сургууль - М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургууль, Санкт-Петербургийн Улсын Их сургууль нь тусгай статустай их сургуульд тооцогддог бөгөөд өөрийн баталсан загвараар диплом олгох эрхтэй байдаг.

ОХУ-д их сургуулийн эрх зүйн статус, үйл ажиллагаатай холбоотой харилцааг “Дээд боловсрол ба дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын тухай” (О высшем и послевузовском профессиональном образовании) хуулиар зохицуулдаг.

### **ОХУ-ЫН “ДЭЭД БОЛОВСРОЛ БА ДЭЭД БОЛОВСРОЛЫН ДАРААХ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХОЛБООНЫ УЛСЫН ХУУЛЬ”, 1996, 125-ФЗ<sup>105</sup>**

Энэхүү хууль нь анх 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдөр ОХУ-ын Төрийн Думаар батлагдсан. Нийт 7 бүлэг, 31 зүйлтэй. Хууль нь дараах бүтэц, агуулгатай байна. Үүнд:

#### **1-р бүлэг. Нийтлэг зүйл:**

1. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын талаар төрөөс баримтлах бодлого ба иргэний эрхийн баталгаа;
2. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсрол ба шинжлэх ухааны уялдаа холбоо, хамтын ажиллагаа;
3. Дээд боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал ба академик эрх чөлөө.

#### **2-р бүлэг. Дээд боловсрол ба дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын тогтолцоо:**

4. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын тогтолцоо;
5. Холбооны улсын дээд боловсролын стандарт ба дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролд тавигдах шаардлага. Дээд болон ДБДМБ-ийн үндсэн хөтөлбөрүүд;
6. Мэргэжлийн дээд боловсролын түвшин ба хугацаа, сургалтын хэлбэрүүд;
7. Дээд болон ДБДМБ эзэмшигчид олгох бичиг баримт;
8. Дээд боловсролын байгууллага, түүний бүтэц, үүрэг;
9. Дээд боловсролын байгууллагын хэлбэр, нэр төрөл;
10. Дээд боловсролын байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах процедур, дээд боловсролын байгууллагын үйлажиллагаандаа мөрдөх журам;
11. Их, дээд сургуульд элсүүлэх, дээд болон дипломын дараах боловсролтой мэргэжилтэн бэлтгэх;
12. Дээд боловсролын байгууллагын удирдлага;
13. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын систем дахь шинжлэх ухаан-судалгааны болон бусад байгууллагууд;
14. Дээд болон ДБДМБ-ийн систем дэх мэргэжлийн нийгэмлэг, холбоод;
15. Дээд болон ДБДМБ-ийн систем дэх олон нийтийн байгууллага, төр-олон нийтийн хамтарсан байгууллагууд.

а \_\_\_\_\_  
<sup>105</sup> <https://минобрнауки.рф/документы/885>

**3-р бүлэг. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн сургалтын систем дэх сургалт, шинжлэх ухааны үйл ажиллагаанд хамрагдаж буй субъектууд, тэдгээрийн эрх, үүрэг:**

16. Дээд сургуулийн оюутан;
17. Дээд сургуульд сурахын зэрэгцээ ажил хавсран эрхэлж буй оюутнуудад олгох тэтгэлэг, нөхөн олговор;
18. Дээд болон ДБДМБ-ийн байгууллагад суралцаж буй сонсогч;
19. Докторант, аспирант, горилогч;
20. Ассистент-стажер;
21. Дээд боловсролын байгууллагын ажилтан;
22. Багш болон судалгаа шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх;
23. Эрдмийн зэрэг, цол олгох.

**4-р бүлэг. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн сургалтын байгууллагын системийн удирдлага:**

24. Дээд болон ДБДМБ-ийн байгууллагыг удирдах холбооны улсын төрийн байгууллагын эрх, үүрэг.

**5-р бүлэг. Дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн сургалтын боловсролын системийн эдийн засаг:**

25. Өмчлөх эрхийн харилцаа;
26. Их, дээд сургуулийн үйл ажиллагааны санхүүжилт;
27. Их, дээд сургуулийн төлбөртэй үйл ажиллагаа;
28. Их, дээд сургуулийн ажилтнуудын хөдөлмөрийн хөлс;
29. Их, дээд сургуулийн ня-бо бүртгэл, тайлан, санхүүгийн хяналт.

**6-р бүлэг. Их, дээд сургуулийн олон улсын болон гадаад эдийн засгийн харилцаа**

30. ОХУ-ын дээд болон ДБДМБ-ийн сургалтын систем дахь олон улсын харилцаа, хамтын ажиллагаа.

**7-р бүлэг. Төгсгөлийн зүйл**

31. Хууль хүчин төгөлдөр болох.

**ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Их, дээд сургууль, түүний бүтэц, чиг үүрэг:

1. Их, дээд сургууль гэж ОХУ-ын Боловсролын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулж, дээд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг хэлнэ;
2. Их, дээд сургуулийн зорилго, зорилтыг тус хуулиар зохицуулна;
3. Хуульд өөрөөр заагаагүй бол ИДС-ийн статус, салбар нэгжүүдийн үйл ажиллагааны журмыг дүрмээр тогтооно. Тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд ИДС-ийн харьяа сургалтын үйл ажиллагаа явуулдаг бүтцийн байгууллагууд нь ерөнхий боловсролын, бүрэн дунд, мэргэжлийн анхан болон дунд шатны, нэмэлт боловсрол олгох зэрэг үйл ажиллагаа явуулж болно. ИДС-ийн харьяа салбар гэж байршлын хувьд өөр газарт үйл ажиллагаа явуулж буй бие даасан салбар байгууллагыг хэлнэ. ИДС-ийн салбар

байгуулахад үүсгэн байгуулагчид боловсролын салбарын бодлого, зохицуулалтын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

Их, дээд сургуулийн хэлбэр, төрөл:

ОХУ-ын хуулиар дараах дээд боловсролын байгууллагуудыг хуульчлан тогтоосон. Үүнд: Холбооны улсын статустай их сургууль, их сургууль, академи, институт:

1. Холбооны улсын статустай их сургууль- гэж дэлхийн боловсролын системд интеграцчилалд орох хэмжээнд боловсролын инновацийн хөтөлбөр хэрэгжүүлж буй, дээд болон дээд боловсролын дараах сургалтын системээ олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн шинэчилж буй, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн цогц хөгжлийн бодлогод нийцүүлэн орчин үеийн боловсролын шинэ технологийг ашиглан дээд боловсрол олгох үйл ажиллагаа явуулж буй, шинжлэх ухааны өргөн спектрээр суурь болон хавсарга судалгаа явуулж буй, шинжлэх ухаан-боловсрол-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлж оюуны бүтээл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг практикт хэрэгжүүлж шинжлэх ухаан, арга зүйн томоохон төв хэлбэрээр ажиллаж буй дээд боловсролын байгууллагыг хэлнэ.
2. Их сургууль- гэж мэргэжлийн олон чиглэлээр дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулж буй, дээд боловсролтой мэргэжилтнүүдийг бэлтгэх, дахин бэлтгэх, мэргэшүүлэх болон шинжлэх ухаан, шинжлэх ухаан- сургалтын ажилтнуудыг бэлтгэх, мэргэшүүлэх, шинжлэх ухааны өргөн салбар, чиглэлээр суурь болон хавсарга судалгаа хийх, эрхэлж буй үйл ажиллагааныхаа хүрээнд шинжлэх ухаан-арга зүйн тэргүүлэх төв хэлбэрээр ажиллаж буй дээд боловсролын байгууллагыг хэлнэ.
3. Үндэсний статустай судалгааны институт- ОХУ-ын Засгийн газраас үйлдвэрлэлд өндөр технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологи, техник, салбарын эдийн засаг, нийгмийн салбарыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулиудаас сонгон шалгаруулж 10 жилийн хугацаатайгаар энэхүү статусыг олгоно. Сонгон шалгаруулалтын журмыг Засгийн газар тогтооно.
4. Академи- гэж дээд болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлж буй, шинжлэх ухаан болон шинжлэх ухаан-сургалтын тодорхой чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, дахин бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагаа явуулж буй, шинжлэх ухаан-соёлын салбарт суурь болон хавсарга судалгаа явуулж буй, үйл ажиллагааныхаа салбар шинжлэх ухаан-арга зүйн тэргүүлэх төв хэлбэрээр ажиллаж буй дээд боловсролын байгууллагыг хэлнэ.
5. Институт-гэж тодорхой салбар чиглэл, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, дахин бэлтгэх, мэргэшүүлэх дээд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж буй, суурь болон хавсарга судалгаа явуулж буй дээд боловсролын байгууллагыг хэлнэ.
6. Дээд боловсролын байгууллагын статусыг тухайн байгууллагын хэлбэр, эрх зүй-зохион байгуулалтын хэлбэр, аттестатчилалд хамрагдаж тусгай зөвшөөрөл авсан эсэхээс хамааруулан тогтооно. Уг байгууллагын нэр нь статусыг тодорхойлно. Тухайн байгууллагыг байгуулах үед нэр олгох ба статус өөрчлөгдвөл нэр зайлшгүй өөрчлөгдөнө. Хэрэв ИДС-ийн нэр нь консерватор, дээд сургууль зэрэг тусгайлсан нэртэй байвал давхар дээд сургуулийн төрлийг зааж өгнө.

7. М.В. Ломоносовын нэрэмжит Улсын их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулна.

Их, дээд сургуулийн удирдлага:

1. Их, дээд сургуулийн удирдлагын үйл ажиллагааг энэ хууль, дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах бусад хууль тогтоомж болон дүрмээр зохицуулна. Их сургуулийн дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг багш нарын хамт олон, шинжлэх ухааны ажилтнууд, бусад ажилтан албан хаагчид болон суралцагчдыг хамруулсан бүх нийтийн хурлаар батална. Цэргийн дээд сургуулиудын үйл ажиллагааг ОХУ-ын хуулиар зохицуулна.
2. Төрийн болон орон нутгийн өмчит ИДС-ийн үйл ажиллагааг сонгогдох зарчмаар байгуулагдсан төлөөллийн байгууллага- Ученый совет удирдана. Уг зөвлөлийн бүрэлдэхүүнд ректор (Зөвлөлийн дарга), проректорууд, хэрэв дүрмээрээ ерөнхийлөгчтэй байх бол ерөнхийлөгч нар орно. Бусад гишүүдийг бүх нийтийн хурлаас нууц санал хураалтын зарчмаар сонгоно.
3. Улсын аттестатчилалд орж тусгай зөвшөөрөл авсан ИДС Удирдах зөвлөл байгуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүнд ИДС-ийн ажилтнууд, суралцагсад, үүсгэн байгуулагчид, ажил олгогч буюу ОХУ-ын гүйцэтгэх засаглалын болон орон нутгийн удирдах байгууллагын төлөөлөл зэрэг дүрэмд заасан төлөөллүүд орно. Энэхүү зөвлөлийн үүрэг нь:
  - ИДС-ийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг хэлэлцэх;
  - ИДС-ийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах асуудлыг шийдвэрлэх;
  - ИДС-ийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн дээд боловсрол олгох болон төгсөлтийн дараах мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах асуудалд дэмжлэг үзүүлэх.
4. Хуулиар зохицуулаагүй бусад ИДС-ийн удирдах байгууллагын үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.
5. ИДС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ректор удирдана. Дүрэмд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит ИДС-ийн ректор нэр дэвшиж буй хүнийг эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллага болон орон нутгийн удирдах байгууллагын дэргэдэх аттестатчилалын комиссоор оруулан хэлэлцэнэ. Ректорын албан тушаалд өөрөө өөрийгөө нэр дэвшүүлэх боломж нээлттэй.
6. Аттестатчилах комиссийн үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүийг эрх бүхий байгууллага батална. Комиссийн бүрэлдэхүүнд дараах этгээдүүд орно. Үүнд:
  - ОХУ-ын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ИДС-ийн ректорыг сонгоход төрийн удирдах байгууллагын төлөөлөл-50%, их, дээд боловсролын салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус олон нийтийн байгууллагын төлөөлөл, тухайн ИДС-ийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн байгууллагын төлөөлөл (50%);
  - ОХУ-ын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ИДС-ийн ректорыг сонгоход эрх бүхий төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (50%), дээд боловсролын систем дэх олон нийтийн байгууллага, төр-олон нийтийн түншлэлийг байгууллагын төлөөлөл (50%);
  - Орон нутгийн өмчит ИДС-ийн ректорыг сонгоход орон нутгийн өөрөө удирдах (ИТХ) болон засаг захиргааны байгууллагын төлөөлөл (50%), дээд боловсролын



салбар дахь олон нийтийн байгууллага болон төр-олон нийтийн түншлэлийн байгууллагын төлөөлөл (50%).

7. Төрийн болон орон нутгийн өмчит ИДС-ийн ректорыг Аттестатчилалын комисстой зөвшилцсөний дагуу нэр дэвшигчдээс нууц санал хураалтаар сонгон шалгаруулж 5 жилийн хугацаагаар томилж эрх бүхий байгууллага 5 жилийн хугацаатай Хөдөлмөрийн гэрээ байгуулна.
8. Холбооны улсын статустай ИДС-ийн ректорыг ОХУ-ын Засгийн газраас 5 жилийн хугацаатай томилно.
9. М.В.Ломоносовын Их Сургууль, Санкт–Петербургийн их сургуулийн ректорыг ОХУ-ын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

Их, дээд сургуулийн бие даасан байдал, академик эрх чөлөө:

1. ИДС-ийн хараат бус, бие даасан байдал гэдэгт бие даасан байдлаар боловсон хүчнийг сонгох, байршуулах, сургалт боловсролын үйл ажиллагаа явуулах, санхүү-аж ахуйн болон бусад үйл ажиллагаагаа хууль тогтоомж болон дүрмийн хүрээнд явуулах боломжтой байхыг ойлгоно.
2. ИДС нь өөрийн үйл ажиллагаанаас үүдэн гарах хариуцлагыг хувь хүн, нийгэм, хамт олон, төрийн өмнө хүлээнэ. Их сургууль нь дүрмийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд өөрийн эрх хэмжээний хүрээнд үүсгэн байгуулагчид болон тусгай зөвшөөрөл олгосон холбогдох төрийн хяналтын байгууллага хяналт тавина.
3. Сургалтын үйл ажиллагаа явуулж буй багш нар болон профессорын багууд, эрдэм шинжилгээ- судалгааны ажилтнууд, оюутнуудад сургуулийн зүгээс академик эрх чөлөө олгоно. Тухайлбал, багшлах үйл ажиллагаандаа ашиглах зүйлээ өөрөө бие даан сонгох, судалгаа шинжилгээний ажлын сэдвээ өөрөө сонгох, арга зүйгээ өөрөө сонгон ашиглах, оюутан хүн өөрийн сонирхол болон хэрэгцээндээ нийцүүлэн мэдлэг олж авах гэх мэт. Эдгээр олгосон академик эрх чөлөө нь шинжлэх ухааны мэдлэгийг аль болох оновчтой аргаар олж авах, боловсруулах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдэнэ.

ОХУ-ын дээд боловсролын салбар дахь олон улсын хамтын ажиллагаа:

1. Их, дээд сургуулиуд нь дээд боловсролын салбар дахь ОХУ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд дараах байдлаар оролцох эрхтэй. Үүнд:
  - Хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд оюутан, аспирант, докторант, багшлах боловсон хүчин, эрдэм шинжилгээ, судалгааны ажилтан солилцох хөтөлбөрт хамрагдах;
  - Хамтарсан судалгаа шинжилгээний ажил хийх, конгресс, конференц, симпозиум болон бусад арга хэмжээ зохион байгуулах;
  - Гадаадын хуулийн этгээдийн захиалгаар суурь болон хавсарга судалгааны ажил болон туршилт-зохион бүтээх ажил гүйцэтгэх;
  - Дээд боловсрол болон дээд боловсролын дараах мэргэжлийн боловсролын салбарыг боловсронгуй болгох хүрээнд олон улсын хөтөлбөрт хамрагдах.
2. Гадаадын иргэнийг ОХУ-ын их, дээд сургуульд сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, улс хоорондын гэрээ хэлэлцээр, Холбооны улс болон орон нутгийн удирдах байгууллага хооронд байгуулсан гэрээний дагуу ОХУ-ын Засгийн газраас олгосон квотын хүрээнд, мөн гадаадын их, дээд сургуультай шууд байгуулсан гэрээний дагуу багш, эрдэм шинжилгээ-судалгааны ажилтнуудыг гадаадад ажиллуулах.
3. Гадаад харилцааны хүрээнд их, дээд сургуулиуд дараах эрхтэй. Үүнд:



- Засгийн газрын бус олон улсын байгууллагад гишүүнчлэлтэй болох;
- Олон улсын түншүүдтэй хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийх; (ОХУ-ын ЗГ-ын гэрээ хэлцэлд тооцогдохгүй)
- Гадаад түншүүдтэйгээ хамтран салбар нэгж (төв, лаборатор, техникийн парк гэх мэт) байгуулах.

4. ОХУ-ын хууль тогтоомжоор их, дээд сургуулиуд нь энэхүү хуулиар тогтоосон хүрээ болон ИДС-ийн дүрмээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд үндсэн үйл ажиллагааны зорилтуудаа биелүүлэх зорилгоор гадаад эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, олон улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх эрхтэй.

## **БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д Их сургуультай холбоотой харилцааг “Дээд боловсролын тухай хууль”<sup>106</sup> болон Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Дээд боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”<sup>107</sup> - аар зохицуулдаг байна.

Дээд боловсролын тухай хуулийг 1997 онд баталж, түүнийг хэрэгжүүлэх журмыг 1998 онд баталсан байна.

### **ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Дээд боловсролын тухай хууль нь 4 бүлэг 64 зүйлтэй бөгөөд уг хуулийн 3 дугаар бүлгийн 2 дугаар хэсэгт Их сургуультай холбогдох харилцааг зохицуулжээ.

**3-р бүлэг:** Сургууль:

**2 дугаар хэсэг:** Их сургууль, коллеж, аж үйлдвэрийн коллеж;

**2-р хэсгийн 1 дүгээр дэд хэсэг:** Их сургууль, коллеж.

*28-р зүйл /Зорилго/*

Их сургууль болон коллежийн зорилго нь оюутнуудыг хувь хүнийх нь хувьд хөгжүүлэх, улс, нийгмийн хөгжилд зайлшгүй шаардлагатай шинжлэх ухаан болон танин мэдэхүйн барагдашгүй онолоос зааж сургах, судлах болон тэрхүү мэдлэгийг ашиглах арга замыг олгоход оршино.

*29-р зүйл /Боловсролын зэрэг олгох сургууль/*

Их сургууль болон коллежууд (аж үйлдвэрийн коллеж, багшийн коллеж, цахим коллеж) боловсролын зэрэг олгох сургууль байгуулж болно. Боловсролын зэрэг олгох сургуулиуд нь зэрэг олгох сургалтаас гадна зэрэг олгох шаардлагагүй судалгаа шинжилгээний сургалтууд явуулж болно.

*29-2-р зүйл /Боловсролын зэрэг олгох сургуулийн төрлүүд/*

Боловсролын зэрэг олгох сургуулиудыг үндсэн сургалтын зорилгоор нь Ерөнхий боловсролын зэрэг олгох, тусгайлсан мэргэшлийн боловсролын зэрэг олгох, тусгай боловсролын зэрэг олгох (ажиллахын хажуугаар үргэлжлүүлэн сурч буй болон энгийн насанд хүрэгчдэд зориулсан) гэж ангилна.

*29-3-р зүйл /Зэрэг олгох хамтарсан сургалт/*

а\_\_\_\_\_

<sup>106</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=42696&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42696&lang=ENG)

<sup>107</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=43975&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=43975&lang=ENG)

Боловсролын зэрэг олгох сургуультай их сургууль болон коллежууд нь бакалаврын болон магистрын зэргийн хамтарсан, магистрын болон докторын зэргийн хамтарсан сургалтууд явуулж болно.

*30-р зүйл /Боловсролын зэрэг олгох их сургууль болон коллеж/*

Тодорхой салбарт тусгай мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай тохиолдолд боловсролын зэрэг олгох сургуультай их сургууль болон коллеж нь (цаашид боловсролын зэрэг олгох их сургууль болон коллеж гэнэ) тухайн сургуулийг байгуулж болно.

*31-р зүйл /Сургалтын хугацаа/*

Сургалтын хугацаа нь суралцагч сургуулийн дүрэмд заасны дагуу тухайн зэргийг авахад шаардагдах кредит онооноос илүү оноо авсан тохиолдолд багасах боломжтой.

*32-р зүйл /Суралцах оюутны тооны хязгаар/*

Ерөнхийлөгчийн зарлигт зааснаар тухайн сургуулийн суралцагчдын тооны дээд хязгаарыг сургуулийн дүрмээр батална.

*33-р зүйл /Элсэгчдэд тавигдах шаардлага/*

Ахлах сургуулийн буюу түүнээс дээш боловсролтой элсэгч нь их сургууль болон коллежид элсэх боломжтой. (Үүнд: боловсролын зэрэг олгох сургуулиудаас бусад буюу аж үйлдвэрийн коллеж, багшийн коллеж, цахим коллеж, өсвөрийн коллеж зэрэг орно.) Дээрх шаардлага болон сургуулийн дүрэмд заасан стандартыг хангасан элсэгч нь бакалаврын болон магистрын зэргийн хамтарсан сургалтанд элсэх боломжтой. Бакалаврын зэрэгтэй буюу түүнээс дээш боловсролтой элсэгч нь магистрын сургалт болон магистрын болон докторын хамтарсан сургалтанд элсэх боломжтой. Магистрын зэрэгтэй болон түүнээс дээш боловсролтой хүн боловсролын зэрэг олгох сургуулийн докторын зэргийн сургалтанд элсэх боломжтой.

*34-р зүйл /Оюутнуудыг элсүүлэх арга/*

Их сургууль болон коллежийн удирдлагууд элсэгчдийг энгийн болон тусгай шалгаруулалтаар элсүүлнэ. Ерөнхийлөгчийн зарлигаар элсэлтийн шалгаруулалтын арга барилыг тодорхойлох бөгөөд Боловсролын сайд нь тухайн шалгалтыг зохион байгуулна.

*34-5-р зүйл /Их сургууль, коллежид оюутан шалгаруулж, элсүүлэх тухай зар/*

Их сургууль болон коллежийн сургалтын алба нь элсэгчдийг сонгохтой холбоотой үндсэн асуудлуудаар хичээлийн жил эхлэхээс доод тал нь 6 сарын өмнө, элсэлтийн жил бүрээс 2 жилийн өмнө олон нийтэд зарлах ёстой.

*36-р зүйл /Эчнээ сургалт/*

Их сургууль болон коллежууд нь (Үүнд: аж үйлдвэрийн коллеж, өсвөрийн коллеж, цахим коллеж) энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан элсэгчдийг оройн болон эчнээ ангид суралцуулах боломжтой.

## **ИРЛАНД УЛСЫН ТУРШЛАГА**

Тус улс нь их, дээд сургуулийн үйл ажиллагааг “Их, дээд сургуулийн тухай хууль<sup>108</sup>” /Universities act 1997/ бие даасан хуулиар зохицуулж байна. Уг хууль нь 1908 онд батлагдаж, 1997 онд нэмэлт өөрчлөлт орсон ба 6 хэсэг, 9 бүлэг 52 зүйлтэй. Үүнд:

### **1-р хэсэг: Өмнөх ба нийтлэг зүйл.**

- Товч агуулга;
- Эхлэл;
- Нэр томъёоны тайлбар;
- Зарцуулалт.

### **2-р хэсэг: Их сургуулийг байгуулах.**

- Бүрэлдэхүүн коллежийг дахин байгуулах;
- Боловсролын институтуудыг Их сургуулиудтай нэгтгэх;
- Нэмэлт (салбар) сургууль байгуулах;
- Их сургуулийн нэрийг өөрчлөх;
- Дублин хотын Их сургуулийн тухай хууль, Лаймерикийн Их сургуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт.

### **3-р хэсэг: Их сургуулиудын ерөнхий зохицуулалт.**

*I бүлэг- Зорилт ба үүрэг, үйл ажиллагаа:*

- Их сургуулийн зорилт;
- Их сургуулийн зорилго;
- Их сургуулийн үүрэг, үйл ажиллагаа;
- Академик эрх, эрх чөлөө.

*II бүлэг- Захиргаа:*

- Захиргааны эрх мэдэлтэн;
- Захиргааны эрх мэдэлтний бүтэц;
- Захиргааны эрх мэдэлтний тэргүүн;
- Захиргааны үүрэг, үйл ажиллагаа;
- Зочин;
- Айлчлал;
- Захиргааны эрх мэдэл дуусгавар болох.

*III бүлэг- Түр зуурын зохицуулалтууд:*

- Коллежиудын удирдлагууд нь анхны захиргаа бүрэлдэх хүртэл ажил албаа үргэлжлүүлэх;
- Анхны захиргааны албыг бүрэлдүүлэх тодорхойлолт.

*IV бүлэг- Их сургуулийн ажилтнууд:*

- Ахлах ажилтан;
- Ажилтнууд;
- Маргааныг шийдвэрлэх нь.

*V бүлэг- Академик зөвлөл:*

а\_\_\_\_\_

<sup>108</sup> UNIVERSITIES ACT, 1997

<http://www.irishstatutebook.ie/eli/1997/act/24/enacted/en/pdf>

- Академик зөвлөлийн бүрэлдэхүүн;
- Академик зөвлөлийн ажил үүрэг;
- Академик зөвлөлийн ажиллах хугацааг сунгах.

*VI бүлэг- Дүрэм журам:*

- Үндсэн болон нэмэлт дүрмүүд;
- Дүрмийг хадгалах нь;
- Журам.

*VII бүлэг- Төлөвлөлт ба үнэлгээ:*

- Стратегийн хөгжлийн төлөвлөгөө;
- Чанарын итгэмжлэл;
- Тэгш байдлын бодлого.

*VIII бүлэг- Санхүү, эд хөрөнгө болон тайлан:*

- Төсөв;
- Зээл авах болон зээл олгох баталгаа;
- Нягтлан бодох бүртгэл ба тэмдэглэл;
- Төлбөр тооцоо;
- Тайлан ба мэдээ мэдээлэл;
- Газар борлуулах.

*IX бүлэг- Ирландын Үндэсний их сургууль, Мэйноот:*

- Ирландын Үндэсний их сургууль болон Мэйноотыг үүсгэн байгуулах;
- Ажилтан, албан хаагчдыг шилжүүлэн ажиллуулах;

**4-р хэсэг: Ирландын үндэсний их сургууль.**

- Ирландын үндэсний их сургуулийн дүрмийн нэмэлт өөрчлөлт;
- Ирландын үндэсний их сургуулиудын 1908 оны хуулийн нэмэлт, өөрчлөлт;
- Ирландын үндэсний их сургуулийн бүрэлдэхүүн их сургуулиудын харилцаа хамаарал;
- Бүрэлдэхүүн их сургуулиудын гишүүнчлэл.

**5-р хэсэг: An tUdaras.**

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Гарын авлага, зааварчилгаа;
- Ажилтнуудыг мэдээллээр хангах.

**6-р хэсэг: Бусад.**

- Боловсролын институтыг их сургуульд тооцохгүй.

**ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Энэхүү хуулиар их, дээд сургуулийг байгуулах, татан буулгах, санхүү, бүтэц зохион байгуулалт болон салбар сургууль байгуулах зэрэг бусад харилцааг зохицуулж байна. Хуулийн ерөнхий бүтэц, агуулга болон тухайн хэсэг, бүлгийн зарим гол зохицуулалтыг тоймлон авч үзвэл:

Хуулийн 1-р хэсэгт: зарим нэр томъёог энэ хуулийн хүрээнд хэрхэн ойлгож хэрэглэхийг тайлбарласан бөгөөд санхүүгийн эрх мэдлийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхой заасан байна.

Тухайлбал, захиргааны эрх мэдэлтэн гэж хорин нэгдүгээр зүйлийн дөрөвд заасан захиргааны эрх мэдэлтний үүрэг, үйл ажиллагааг дагаж мөрдөх бие болон хувь хүнийг хэлнэ.

Хуулийн 2-р хэсэгт: коллеж болон их сургууль үүсгэн байгуулахтай холбоотой асуудлуудыг зохицуулсан. Тухайлбал, Их сургууль, коллежийг дахин болон нэмж байгуулах тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн нэр дээр бүртгэх ба холбогдох бичиг баримтын бүрдүүлбэрийг Яам хянан үзээд ямар нэгэн асуудалгүй бол бүртгэнэ. Мөн боловсролын байгууллага болон түүний салбар байгууллага нь Их, дээд сургуультай нэгдэх тохиолдолд Боловсролын сайд, Сангийн сайдын хамтарсан захирамж, тушаалаар шийдвэрлэдэг байна.

3-р хэсгийн 1-р бүлэгт тусгаснаар их сургуулийн үйл ажиллагаа нь сургалт, шинжлэх ухааны судалгаа, судалгааны ур чадварыг дээшлүүлэх, олон нийтэд түгээх, байгууллага болон суралцагчийн нийгэмд суралцах явдлыг дэмжих, дээшлүүлэх, бие даасан, сэтгэх чадварыг хөгжүүлэх, Ирланд улсын хэл, соёлыг сурталчлах, хадгалах, тасралтгүй боловсрол олгоход оршино. Мөн их сургууль нь энэхүү хууль болон бусад дүрэм журамд нийцүүлэн сургалтын үйл ажиллагаа явуулах, судалгаа шинжилгээ хийх, салбар сургууль байгуулах, түншлэл тогтоох, их сургуулийн эд хөрөнгийг захиран зарцуулах, удирдах, төгсөгчдийн асуудлыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хуулийн 3-р хэсгийн 2-р бүлэгт захиргааны талаар тусгасан бөгөөд их сургуулийн нэрийн өмнөөс гаргасан аливаа шийдвэрийг их сургууль гаргасан гэж үздэг байна. Захиргаа нь эрх бүхий байгууллагыг удирдлагаар хангаж буй хүмүүсийг хэлнэ. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд удирдах ажилтан, дарга, эрдэм шинжилгээ, сургалт, санхүү, захиргаа хариуцсан тус бүр 1-2 ахлах ажилтан байх ба тэдгээрийг дарга удирдана. Мөн багш ажилчид, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл, оюутан болон төгсөгчдийн төлөөллөөс оруулж болдог.

Их сургуулийн захиргааны ажилтнууд нь Удирдах зөвлөлд байх ба ерөнхий захирал, ня-бо, бусад ахлах ажилтнууд ордог. Их сургуулийн ажилтнууд нь их сургуульд хагас цагаар болон бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнууд орно.

3-р хэсгийн 5-р бүлэгт тодорхойлсноор удирдах зөвлөлийн шийдвэрээр их, дээд сургууль нь Академик (эрдмийн) зөвлөлтэй байх бөгөөд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд зөвлөх болон хяналт тавих чиг үүрэгтэй байна. Зөвлөлийн гишүүдийг удирдах зөвлөлийн гишүүд болон бүрэлдэхүүн сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр сонгоно. Гишүүд нь шинжлэх ухааны асуудал хариуцсан ахлах ажилтан болон бусад гишүүдээс бүрдэнэ. Ахлах ажилтан нь зөвлөлийн хорооны бүх хурлыг тэргүүлэх, эсвэл өөрийн оронд тэргүүлэх хүнийг томилдог байна.

Их сургууль болон эрдэм шинжилгээний байгууллага нь энэхүү хуульд нийцүүлэн өөрийн дүрэм, журамдаа сургалтын үйл ажиллагааг дэмжих, хяналтыг сайжруулах болон бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн асуудлаар тусган мөрдөж болно.

Удирдах зөвлөл, эрх бүхий албан тушаалтан нь томилогдсоноосоо хойш аль болох богино хугацаанд байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилт, түүнийг биелүүлэх стратеги төлөвлөгөөг 3 жилийн хугацаатайгаар гаргана. Эрх бүхий захиргааны байгууллагын эрх мэдэлтэн нь ахлах түшмэлүүдтэй зөвлөлдсөний дараа төлөвлөгөөг батлах боломжтой бол баталж болно. Мөн эрх бүхий байгууллагаас Академик зөвлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр сургалтын чанарын үнэлгээг 10 жил тутам 1-ээс доошгүй, эсвэл их сургуулиас тогтоосон тодорхой хугацаанд хийнэ.

Хуулийн 3-р хэсгийн 8-р бүлэгт зохицуулснаар Санхүүгийн жилийн эхэнд (3-р сарын 1) санхүүгийн тайлан тооцоо, төсвийн төлөвлөгөөг хийж, хэрэгцээт зардлын тооцоог гарган өгнө. Захирлуудын зөвлөлөөс эрх бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа санхүүжилтийг Дээд боловсролын тухай хуулийн 12-р хэсэгт заасны дагуу tU dara's (дээд боловсролын

байгууллага) - тай тохиролцоно. Их сургуулийн төсөв тодорхойлогдсон тохиолдолд эрх бүхий байгууллагын албан тушаалтан захиран зарцуулах эрхтэй. Энэ бүлэгт мөн төсвөөс гадуурх зардал, зээллэг, баталгаа гаргах, санхүүгийн хяналтын асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Ирландын үндэсний их сургуулийн бүрэлдэхүүнд багтдаг коллежиудын ажилтнуудын цалин хөлсийг Парламентаас баталсан төсвийн хүрээнд эрх мэдэл бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоодог байна. Эдгээр коллежийн ажилтнууд нь Ирландын үндэсний их сургуулийн ажилтан мөн бөгөөд шилжүүлэн ажиллуулах тохиолдолд Их, дээд сургуулиудад үйл ажиллагаа явуулдаг Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр ажил үүргийн дахин хуваарилалт хийдэг.

Их сургуулийн тухай хуульд нийцүүлэн Ирландын үндэсний их сургуулийн дүрмэнд зарим нэмэлт өөрчлөлтийг хийх боломжтой.

### **МАЛАЙЗ УЛСЫН ТУРШЛАГА**

Малайз улсын “Их сургууль, Их сургуулийн харьяа коллежийн тухай” хууль<sup>109</sup> 1971 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан. Энэ хуулиар Их Сургууль болон Их сургуулийн харьяа коллежийг шинээр байгуулах, үйл ажиллагааг нь дэмжин явуулах, удирдлагыг хэрэгжүүлэх болон холбогдох бусад харилцааг зохицуулна. Хууль 5 бүлэг, 27 зүйлтэй.

#### ***Бүлэг 1 Өмнөх хэсэг:***

- Товч агуулга ;
- Нэр томъёоны тайлбар.

#### ***Бүлэг 2 Дээд боловсрол:***

- Сайдын үүрэг;
- Сайдын хянан шалгах субъектыг томилох эрх;
- Сайдад томилгооны асуудлаар зөвлөх хороо;
- Сайдын Их сургуулийн багш, ажилтныг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах эрх.

#### ***Бүлэг 2а. Удирдлага:***

- Дээд боловсролын байгууллагын Ерөнхий захирлын үүрэг ба томилгоо;
- Сайдын эрх үүрэг, үйл ажиллагааг төлөөлөн хэрэгжүүлэх.

#### ***Бүлэг 3 Их сургууль:***

- Их сургууль байгуулахыг хориглох;
- Энэ хуулиар үйл ажиллагааг нь зохицуулахгүй их сургуулиуд;
- Их сургууль ба Их сургуулийн нэгтгэл (incorporation) байгуулах;
- Их сургуулийн статустай дээд боловсролын институтын нийтлэг эрх эрх олгох;
- Их сургуулийн дүрэм;
- Малайз улсын Их сургууль заавал өөрийн хаяг, оффистой байх;
- ИС-ийн оффист бичиг баримт, түүний хуулбарыг заавал хадгалах;
- ЗГ-ын грант тусламж ба санхүүгийн бүртгэл;
- Их сургуулийн кампус байгуулах;
- Их сургуулийн зориулалтаар газар худалдан авах;
- Их сургуулийг хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөх нь;
- Оюутан, оюутны нийгэмлэг, холбоодын үйл ажиллагаа эрхлэх этгээд;

а\_\_\_\_\_

<sup>109</sup> <https://legal.usm.my/v3/phocadownload/act%2030%20-%20universities%20and%20university%20colleges%20act%201971amended%202012.pdf>



- Оюутны холбоо, нийгэмлэг зэрэг этгээдүүд оюутнууд болон бусад байгууллага, этгээдээс мөнгө цуглуулахыг хориглох;
- Оюутан, оюутны бүлэг, холбоодын үүрэг хариуцлага;
- Оюутан, оюутны бүлэг холбоодыг татан буулгах, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх Дэд канцлерийн эрх.

**Бүлэг 4 Их сургуулийн харьяа коллеж:**

- Их сургуулийн харьяа коллеж байгуулахыг хориглох;
- Их сургуулийн харьяа коллеж үүсгэн байгуулах;
- Их сургуулийн харьяа коллежийн Үндсэн дүрэм;
- Энэ хэсгийн 3-р хэсэгт заасан заалтыг хэрэглэх.

**Бүлэг 4а Бүртгэл мэдээлэл:**

- Бүртгэл хөтлөх үүрэг;
- Мэдээллийн сан хадгалах үүрэг.

**Бүлэг 5 Ерөнхий зүйл:**

- Их сургууль, их сургуулийн коллежийг үүсгэн байгуулахтай холбоотой гэмт хэрэг;
- Их сургууль, их сургуулийн коллежид хориглох зүйл;
- Сервис үйлчилгээ;
- Төрийн захиргааны байгууллагын зохицуулалт;
- Шударга ёсны зохицуулалт;
- Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны зохицуулалт
- Сайдын зохицуулалтын эрх мэдэл;
- Зохицуулалтанд хамаарах их сургуулиуд;
- Хөнгөлөлт, чөлөөлөлт.

**ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР:**

Энэхүү хуулийн 1-р бүлэгт: хуулиар зохицуулах асуудлын хүрээ болон зарим нэр томъёоны тайлбар, тодорхойлолтыг оруулсан. Тухайлбал, Захирлуудын зөвлөл (board), ИС-ийн орчин (campus), Канцлер буюу ИС-ийн захирал (chancellor), Дэд захирал (vice chancellor), Үндсэн дүрэм (constitution), Ерөнхий захирал (director general), ИС-ийн салбар нэгжүүд (faculty), ИС-ийн Сенат (Senat), Дээд боловсрол, Дээд боловсролын байгууллага, Дээд боловсрол хариуцсан сайд, Их Сургууль, Их сургуулийн харьяа коллеж, ИС, түүний харьяа коллежийн боловсрол гэх зэрэг нийтлэг болон онцлог зохицуулалтын нэр томъёог энэ хуулийн хүрээнд хэрхэн ойлгож хэрэглэхийг тайлбарласан.

Мөн хуульд зааснаар Сайд үндэсний хэмжээнд дээд боловсролын чиглэлээр баримталж буй бодлого, стратегийн хүрээнд хууль тогтоомжоор олгосон эрхээ хэрэгжүүлнэ. Сайд эрхийнхээ хүрээнд дээд боловсрол олгох институтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж гаргах эрхтэй этгээдийг томилж болно. Сайд ИДС-ийн удирдах албан тушаалд тохирох мэргэшсэн хүнийг томилохын тулд түүнд томилгооны асуудлаар зөвлөх эрхтэй хороо байгуулж болно.

Хэрэв аль нэгэн их, дээд сургууль болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ИДС-ийн тодорхой чиглэлийн багш, ажилтныг татан ажиллуулах хүсэлт гаргасан тохиолдолд сайдын зүгээс дээд боловсролын салбарын судалгаа, боловсролын ажлыг дэмжих эрх ашгийн үүднээс тухайн ажилтантай зөвшилцсөний дагуу санал болгосон ажил албан тушаалд ажилтныг түр хугацаагаар томилох, шилжүүлэн ажиллуулах шийдвэр гаргах эрхтэй. Сайдын шийдвэртэй санал нийлэх эсэхээс үл хамааран хүсэлт гаргасан байгууллага, албан тушаалтан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3-р бүлэгт зааснаар Сайд дээд боловсролын байгууллагын Ерөнхий захирал болон Дэд захирлуудыг томилох ба Ерөнхий захирал нь сайдад дээд боловсролын асуудлаар зөвлөх үүрэгтэй. Ерөнхий захирал энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд, Сайдаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулна. Ерөнхий захирлыг эзгүйд Дэд захирал түүний эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Хуульд заасан шилжүүлж болохгүй сайдын зарим тодорхой эрх үүргээс бусдыг нь Ерөнхий захирал төлөөлөн хэрэгжүүлнэ. Ерөнхий захирал сайдын нэрийн өмнөөс, Сайдаас тавьсан шаардлага, хязгаарлалтын хүрээнд удирдлагыг хэрэгжүүлнэ. Сайдын зүгээс Ерөнхий захирлын үйл ажиллагаанд саад учруулах ёсгүй бөгөөд хуульд заасан журмын дагуу эргүүлэн татах боломжтой.

Энэ хууль болон Дээд боловсролын хувийн институтийн тухай /1996/ хуулиас гадуур Их сургуулийн статустай дээд боловсролын институт байгуулахыг хориглоно.

Yang di-Pertuan Agong<sup>110</sup>-аас гаргасан шийдвэрийн дагуу Их сургуулийн статустайгаар байгуулагдсан дээд сургууль болон “Дээд боловсролын хувийн институтийн тухай” хуулиар байгуулагдсан их сургууль, түүний харьяа коллежууд энэ хуулийн зохицуулалтад хамрагдахгүй. Yang di-Pertuan Agong-ийн зүгээс сайдын зөвлөмж болон Gazette-д хэвлэгдсэн шийдвэрийн дагуу их сургуулийн статустай дээд боловсролын институтыг байгуулж болно. Энэ нь ямар ч нэр, хэлбэртэй байж болох ба гагцхүү цаг үеийн шаардлага, үндэсний эрх ашигт нийцсэн байх ёстой. Хэрэв Yang di-Pertuan Agong-ийн зүгээс их сургууль байгуулах нь үндэсний эрх ашиг, цаг үеийн шаардлагад нийцсэн гэж үзвэл тухайн их сургуулийн статус, нэр, үйл ажиллагааны хэлбэр, байрлах газар нутаг зэргийг тогтоосон шийдвэр гаргана. Yang di-Pertuan Agong шийдвэрээ өөрчлөх, нэмэлт оруулах, цуцлах эрхтэй. Парламентын 2 танхимаар хэлэлцэн баталсан журмын дагуу эрх олгох шийдвэр буюу Incorporation order гаргана.

Их сургуулийн статустайгаар дээд боловсролын институт байгуулах шийдвэр гарч, канцлер болон дэд канцлерууд, захирлуудын зөвлөл болон сенатын гишүүд томилогдсоноор Үндсэн дүрэмд заасан үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлэх эрх үүснэ. Тухайлбал, бүх шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, тамга тэмдэг хийлгэх, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах, түрээслэх, хандив авах гэх мэт. Эдгээр бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх, цуцлах асуудлыг энэ хууль, түүний хүрээнд баталсан дүрмээр зохицуулна.

Их сургуулийн Үндсэн дүрмээр энэ хуулийн 1-р бүлэгт заасан дараах асуудлуудыг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлно. Үүнд:

- Хэрэв хуулийн 1-р бүлэгт заасан эрхийг хэрэгжүүлэх асуудлыг дүрмэнд тусгаагүй, эсхүл дүрэмд тусгасан зохицуулалт нь хуулийн дээрх заалтуудтай зөрчилдөж байвал Захирлуудын зөвлөлөөс дүрэмд өөрчлөлт оруулах санаачлага гаргана;
- Yang di-Pertua Agong-ийн зүгээс ямар ч үед дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж хуульд нийцүүлэх эрхтэй;
- Дүрмийн нэмэлт өөрчлөлт нь Yang di-Pertua Agong –аас тогтоосон өдрөөс эхлэн хуулийн хүчин төгөлдөр болно.

Малайз улсын их сургууль бүр Малайз улсын нутаг дэвсгэрт өөрийн оффис, сургалт явуулах баазтай байна.

а \_\_\_\_\_

<sup>110</sup> Малайз улсын хаан

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://secretariat.info.yorku.ca/governance-documents/york-university-act-1965/>
- <https://www.riigiteataja.ee/en/eli/521032014002/consolide>
- Universities act, <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2009/en20090558.pdf>
- <https://минобрнауки.рф/документы/885>
- UNIVERSITIES ACT, 1997
- <http://www.irishstatutebook.ie/eli/1997/act/24/enacted/en/pdf>
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=42696&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=42696&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=43975&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=43975&lang=ENG)
- <https://legal.usm.my/v3/phocadownload/act%2030%20-%20universities%20and%20university%20colleges%20act%201971amended%202012.pdf>

**БАГШИЙН ХӨГЖИЛ, БАГШИЙН МЭРГЭЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, СТАНДАРТ,  
НИЙГМИЙН БАТАЛГАА, ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН  
ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл,  
И.Жаргалзаяабямба, Р.Оргилмаа Ц. Элбэгзаяа*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**СУДАЛГААНЫ ТОЙМ**

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН БАГШИЙН МЭРГЭЖИЛД  
ТАВИГДАХ ШААРДЛАГА, СТАНДАРТ, НИЙГМИЙН БАТАЛГАА, ХӨДӨЛМӨРИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн орнууд (СНГ)
  - 1.1 Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн орнуудын Багшийн статусын тухай загвар хууль / орчуулга бүрэн эхээрээ/
  - 1.2 Багшийн цалин хөлсний системийн шинэчлэл, багшийн цалин хөлс тооцох загвар схем
2. Бүгд Найрамдах Польш Улс
3. Бүгд Найрамдах Филиппин Улс
4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
5. Бүгд Найрамдах Солонгос Улс
6. Бүгд Найрамдах Чех Улс

**ХАВСРАЛТ**

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## УДИРТГАЛ

Судалгаанд бусад орнуудын Багшийн хөгжлийн тухай бие даасан хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалт, багшийн нийгмийн баталгаа, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлдэг байгууллага, багшийн мэргэжилд тавигдах үндсэн шаардлага, стандарт, багшийн хөдөлмөрийн үнэлгээний систем болон шинэчлэлийн талаарх гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судалсан болно.

Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад багшийн хөгжил, нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудлыг хуульчилсан эрх зүйн актуудаас гадна олон улсын гэрээ конвенц, олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, холбогдох бусад баримт бичиг, тайлан, судалгаа зэргийг үзэж танилцан, эдгээр эх сурвалжуудаас Монгол Улсад туршлага болохуйц зарим орныг сонгон авч судалгааны ажлыг гүйцэтгэв. Мөн УИХ-д өргөн барьсан хуулийн төслийн танилцуулгад дурьдсан зарим орны туршлагыг нарийвчлан судалж үзлээ.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Судалгаанд Азийн орнуудаас БНХАУ, БНСУ, Европын орнуудаас Польш, Чех, ОХУ болон Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудыг хамруулав. Судалгааны хүрээнд эдгээр орнуудын багшийн хөгжлийн асуудлыг хуульчилсан эрх зүйн орчин, багшийн хөгжил, нийгмийн баталгаа, цалин хөлс, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхтэй холбоотой асуудлуудыг холбогдох эрх зүйн орчны хүрээнд судалсан болно.

Ажлын хэсгийн гишүүдийн зүгээс судалгааны тайланд дурьдсан мэдээллүүдээс гадна нэмэлт мэдээлэлтэй танилцахыг хүсвэл OECD, ILO, EU, UNESCO зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан багшийн цалин хөлс, хөнгөлөлт, урамшуулал, багшийн хөдөлмөрийн үнэлгээтэй холбоотой дараах тайлан, дүн шинжилгээний материалтай танилцаж нэмэлт мэдээлэл авах боломжтой. Тухайлбал,

- Teachers' and School Heads' Salaries and Allowances in Europe 2015/16 European Commission/EACEA/Eurydice, 2016-  
[https://webgate.ec.europa.eu/fpfis/mwikis/eurydice/images/2/22/Teacher\\_salaries.pdf](https://webgate.ec.europa.eu/fpfis/mwikis/eurydice/images/2/22/Teacher_salaries.pdf)
- Teachers and educational quality: Monitoring Global Needs for 2016  
[http://uis.unesco.org/sites/default/files/documents/teachers-and-educational-quality-monitoring-global-needs-for-2015-en\\_0.pdf](http://uis.unesco.org/sites/default/files/documents/teachers-and-educational-quality-monitoring-global-needs-for-2015-en_0.pdf)
- Education at a Glance 2017 OECD INDICATORS TEACHERS AND EDUCATIONAL QUALITY: Monitoring Global Needs for 2015- <http://www.oecd-ilibrary.org/docserver/download/9617041e.pdf?expires=1512550158&id=id&accname=guest&checksum=E24872E5570F5C738269FB42ABD9F125>

Дэлхийн улс орнуудад Багшийн хөгжлийг дэмжих, тэдний нийгмийн баталгаа, багшийн ажилд тавигдах шаардлага, стандарт, багшийн хөдөлмөрийн үнэлгээтэй холбоотой аливаа асуудлыг Олон улсын Хөдөлмөрийн байгууллага болон ЮНЕСКО-гоос хамтран 1966 онд гаргасан “Багшийн статусын тухай зөвлөмж”-ийн дагуу бие даасан болон холбогдох салбарын хууль, тогтоомжоор зохицуулж ирсэн байна.

ЮНЕСКО-гоос жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдрийг Дэлхийн багш нарын өдөр болгон 1994 онд зарласан. 1966 оны энэ өдөр ЮНЕСКО ба Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага хамтран Багш нарын статусын тухай Засгийн газар хоорондын тусгай бага хурал зохион байгуулж (*Special Intergovernmental Conference on the Status of Teachers*) “Багш нарын статусын тухай зөвлөмж”-ийг (*The ILO/UNESCO Recommendation concerning the Status of Teachers*) батлан гаргасан юм.

Уг зөвлөмж нь багшийн мэргэжлийн олон улсын стандартыг тодорхойлж өгсөн бөгөөд хууль

зүйн заавал дагаж мөрдөх баримт биш боловч боловсролын чанарыг сайжруулах зорилгоор багш нарын статусыг дээшлүүлэх чухал эрх зүйн баримт бичигт тооцогддог байна.

“Багшийн статусын тухай зөвлөмж”<sup>111</sup>-д боловсрол эзэмших нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд хувь хүний болон орчин үеийн нийгмийн хөгжилд багш онцгой үүрэг гүйцэтгэдэг гэж заасан бөгөөд багшийн хөгжил, эрх үүрэг, мэргэшлийн тавигдах шаардлага, багшийн нийгмийн баталгаа, цалин хөлс, багшийн ажлын үнэлгээ, Түүнчлэн багш нар болон боловсролын үйлчилгээ хоорондын харилцаа, үр дүнтэй багшлах болон сургах орчин нөхцөлүүдийн талаар тодорхой өгүүлсэн байна.

Тухайлбал, Багшийн ажлын цаг, цалин хөлсийг тооцоход баримтлах зарчмуудыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

#### **Ажлын цагийг тогтоохдоо:**

- Багшийн 1 өдөрт болон долоон хоногт ажиллах цагийг багш нарын байгууллагатай зөвлөлдөж тогтоох;
- Тогтмол цалинг тогтоохдоо багшийн ажлын ачаалал болон бусад хүчин зүйлийг харгалзан тооцох.

#### **Багшийн цалинг тогтоохдоо:**

- Багш нарын байгууллагатай тохиролцсон цалингийн шатлалын үндсэн дээр багш нарт цалин олгох;
- Цалингийн бүтэц нь шударга бус маргаан, зөрөлдөөн үүсгэхгүй байхаар төлөвлөгдсөн байх;
- Заах хичээлийн цагийн дээд хэмжээг тогтоосон нөхцөлд багшийн хичээл заах байнгын цаг ердийнхөөс илүү гарсан тохиолдолд баталсан шатлалын дагуу нэмэгдэл цалин олгох;
- Цалингийн ялгаа мэргэжлийн түвшин, ажлын дадлага туршлага, ажилласан жил буюу үүрэг хариуцлагын түвшин зэрэг бодит шалгуурт тулгуурласан байх боловч цалингийн дээд доод хэмжээний харьцаа үндэслэлтэй байх;
- Эрдмийн цолгүй техникийн буюу мэргэжлийн багшийн цалингийн шатлалыг тогтоохдоо түүний практик сургалт, туршлагыг харгалзан үзэх;
- Багш нарын цалинг нэг жилийн хугацаагаар тооцох ба ингэхдээ:
  - зэрэг дэвийн хүрээнд дээшлүүлсэн өөрчлөлтийг цалингийн нэмэгдлээр дамжуулан тогтсон хугацаанд олгох;
  - үндсэн цалингийн шатлалын доод хэмжээнээс дээд хэмжээ рүү өсгөх хугацаа 10-15 жилээс хэтэрч болохгүй;
  - туршилтын буюу түр хугацаагаар ажиллах хугацаандаа багш нар нэмэгдэл цалин авна.
- Амьдралын өртгийн өсөлт, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэх хүчин зүйлүүд буюу цалин хөлсний хэмжээ нэмэгдэх ерөнхий хандлага зэрэг хүчин зүйлүүдийг анхаарч багш нарын цалингийн шатлалыг үе үе эргэн хянаж байх хэрэгтэй;
- Амьдралын өртгийн индекстэй шууд уялдуулан цалингийн системийн өөрчлөлтүүд хийгддэг газруудад индексийг сонгож авахдаа багш нарын байгууллагуудыг заавал оролцуулна;
- Цалин тодорхойлохдоо ямар ч гавьяа шагналын системийг бий болгож болохгүй буюу багш нарын байгууллагын урьдчилсан зөвшөөрөл, зөвлөмжгүйгээр хэрэглэж болохгүй.

Мөн зөвлөмжид багш нарын **нийгмийн баталгааны** талаар тусгасан. Тухайлбал,

а\_\_\_\_\_

<sup>111</sup> The ILO/UNESCO Recommendation concerning the Status of Teachers 1966  
<http://unesdoc.unesco.org/images/0012/001260/126086e.pdf>



- Бүх багш нар ажиллаж буй сургуулиасаа үл хамааран адил буюу ойролцоо нийгмийн баталгаагаар хангагдах ёстой.
- Нийгмийн баталгаа нь багшийн туршилтын хугацаа болон сургалтын хугацааг оруулан тооцно.
- Багш нарын нийгмийн баталгаа нь 1952 онд баталсан Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Нийгмийн даатгалын (доод түвшин) конвенцид орсон эрүүл мэндийн тэтгэмж, өвчтэй байх хугацааны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, өндөр настны тэтгэмж, ажил дээрх ослын тэтгэмж, гэр бүлийн тэтгэмж, хүүхэд төрүүлсний тэтгэмж зэрэг нөхцөлүүдийг бүгдийг багтаасан байх ёстой гэх мэтчилэнгээр багшийн тэтгэвэр тэтгэмж авах нөхцөл, ажлын байрны тогтвортой ажиллах нөхцөлөөр хангуулах, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах багшийн хөгжлийг дэмжсэн нарийн асуудлуудыг тусгасан байна.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага ба ЮНЕСКО-гоос Багшийн статусын тухай зөвлөмжийг багшийн хөгжлийг дэмжихэд аль болох хэрэгжүүлэхийг улс орнуудад уриалж, жил бүрийн Олон улсын багш нарын өдрөөр илгээлт явуулдаг байна. Тиймээс ч дэлхийн улс орнуудад багшийн хөгжлийн асуудлыг чухалчлан авч үзэж холбогдох хууль тогтоомжид зөвлөмжийн агуулгыг тусгаж иржээ.

Судалгаанд хамруулсан орнуудын багшийн хөгжлийн хууль эрх зүйн орчныг судлан үзэхэд Тусгаар улсуудын Хамтын нөхөрлөлийн орнуудын загвар хууль, Хятад Улс “Багшийн хөгжлийн тухай хууль”, Польш Улс “Багшийн эрх зүйн байдлын тухай хууль” зэрэг бие даасан хуультай бол БНСУ, Филиппин, Чех, ОХУ, Сингапурт салбарын болон холбогдох бусад хуулиар багшийн хөгжлийн асуудлыг зохицуулсан байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 1. ТУСГААР УЛСУУДЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛИЙН ОРНУУД (СНГ)-ЫН ТУРШЛАГА

*(Албан бус орчуулга- Ц.Норовдондог)*

#### 1.1 БАГШИЙН СТАТУСЫН ТУХАЙ ХУУЛЬ

*(Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн орнууд (СНГ)-ын дагаж мөрдөх загвар хууль)*

Энэхүү загвар хуулиар багшийн үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлогыг тодорхойлж, багшийн эрх зүйн статусыг дээшлүүлэх, нийгмийн хамгааллын баталгааг сайжруулахад чиглэсэн эрх зүйн болон нийгэм-эдийн засгийн харилцааг зохицуулна.

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1-р зүйл. Багшийн статус

- “Багш” гэж багшийн ажил эрхлэх үндсэн болон шаардагдах бусад мэргэжлийн боловсрол, мэргэжлийг эзэмшсэн, мэргэжлээрээ ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх, сургуулиас гадуур, анхан шатны болон мэргэжлийн боловсрол олгох аль нэг сургалтын байгууллагад ажилладаг, сургалт, эрдэм шинжилгээ, арга зүй, хүмүүжил, зохион байгуулалтын болон удирдах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг хэлнэ.
- Багшийн ажлын нөхцөл байдал, шинж чанараас шалтгаалан багшийн статусыг ялгаатай тогтоох ба багшийн эрх, үүрэг, хариуцлага, түүнийг хэрэгжүүлэх баталгаа нь харилцан адилгүй байна.

- Багш нь Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг бүрэн эдэлнэ.

## **2-р зүйл. Багшийн статус бүхий этгээд**

- Багшийн ажил эрхлэхэд шаадлагатай мэргэжлийн боловсрол, мэргэжил эзэмшин, өмчийн бүх хэлбэрийн, тухайлбал, ерөнхий боловсролын, сургуулийн өмнөх, сургуулиас гадуур, анхан шатны болон дунд мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа этгээдэд багшийн статус олгоно.
- Багшийн мэргэжлийн боловсрол, мэргэжил эзэмшээгүй хүн багшийн ажил эрхлэхийг хүсвэл багш дахин бэлтгэх сургалтанд хамрагдаж, аттестатчилах шалгалт өгсөний дараа сургуулийн багш нарын зөвлөлийн хурлын шийдвэрээр багшлах үйл ажиллагаа эрхэлж болно.
- Мэргэжлийн шаардлагыг хангахгүй, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд үл нийцэх ёс зүйн алдаа гаргасан багшийн статусыг үндэсний хэмжээний хууль тогтоомжид заасны дагуу хүчингүй болгож болно.

## **3-р зүйл. Багшийн статусын тухай хууль тогтоомж**

- Багшийн статусын тухай хууль тогтоомж нь тухайн улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, энэхүү загвар хууль болон багшийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон бусад хуульчилсан актуудаас бүрдэнэ.

## **4-р зүйл. Багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчим**

Багш сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Суралцагчдыг сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг хувь хүний арга барилд тулгуурлан явуулах;
- Суралцагчдын эрх, эрх чөлөө, үндэсний болон соёлын онцлогийг харгалзан хүндэтгэж, сургалт- хүмүүжлийн үйл ажиллагаандаа хүнлэг, энэрэнгүй зарчим баримтлах;
- Ёс суртахууны нийтлэг хэм, хэмжээ, үнэт зүйлийг дээдлэх;
- Суралцагчдыг хувийн болон нийгмийн шинжтэй ямар нэгэн онцлох нөхцөл байдал, үндэс угсаа, нас, хүйс, гарал үүсэл, хэл, соёл, шашны үзэл хандлагаар нь шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхахгүй байх;
- Суралцагчдыг эх орноо хайрлах, дээд зэргээр иргэншсэн, ард түмний найрамдалт харилцааг хүндэтгэн үзэх үзэл хандлагаар хүмүүжүүлэх;
- Боловсролын уламжлалт харилцааг хадгалах;
- Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны арга зүй, хэлбэрээ чөлөөтэй сонгох;
- Сургалт- хүмүүжлийн ажлыг нэгтгэн явуулах;
- Шинжлэх ухаан, техник, технологи, соёлын шинэ дэвшлийн талаарх мэдлэгээ ямагт сайжруулж байх;
- Суралцагчид болон тэдгээрийн гэр бүл (хууль ёсны асран хамгаалагч) нартай нягт холбоотой ажиллах;
- Үндэсний хууль тогтоомжоор хориглоогүй бол хамтран ажиллахыг хүссэн хүүхэд, залуучуудын байгууллага, хөдөлмөрийн хамт олон, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАГШИЙН ЭРХ**

### **5-р зүйл. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой багшийн эрх**

Багшийн мэргэжил, боловсрол эзэмшиж, хуулиар тодорхойлсон багшлах үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь яс үндэс, нас, хүйс, хэл, соёл, нийгмийн гарал, шашин шүтлэг харгалзахгүйгээр дараах эрх эдэлнэ. Үүнд:

- Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, заах арга болон хэлбэр, сурах бичиг, сургалтын гарын авлагаас сонголт хийх;
- Шинээр сургалтын хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага боловсруулахад оролцож ажиллах;
- Шинэлэг арга зүй, аргачлал боловсруулах, шинжлэх ухаан- сургалтын туршилт хийх, заах аргын тэргүүн туршлагыг практикт нэвтрүүлэх, ашиглах;
- Сургалтын үйл ажиллагаанд шинэлэг арга зүй, аргачлал нэвтрүүлсэн, ашигласан, шинээр бий болгосныхоо төлөө урамшуулал хүртэх;
- Хууль тогтоомжид заасан журмын дагуу ганцаарчилсан сургалтын үйл ажиллагаа явуулах;
- Зэрэг ахиулахын тулд хугацаанаасаа өмнө аттестатчилалд хамрагдах;
- 5 жилд нэгээс доошгүй удаа мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах;
- Суралцагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах.

Багш нь Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, эрх зүйн актаар зохицуулсны дагуу багшийн ажлыг өөр ажилтай хавсран эрхлэх эрхтэй.

Багш сургалтын удирдах үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

Сургуулийн бүтэц, зохион байгуулалт бүрэн болон хэсэгчлэн өөрчлөгдсөн ч гэсэн багшийн албан ажлын тогтвортой байдал хадгалагдах баталгаагаар хангагдана.

#### **6-р зүйл. Багшийн бахархал, нэр төрийг хамгаалах**

- Иргэн хүний хувьд багшийн бахархал, нэр төрийг хамгаалах баталгаагаар хангана.
- Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх, сургуулийн гадуурх боловсролын байгууллагад ажилладаг багш нарыг үндсэн ажлаас гадуур мэргэжлийн үйл ажиллагаанд нь хамааралгүй ажилд дайчлахыг хориглоно.
- Суралцагчдын эцэг, эх багшийн мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой асуудалд хууль бусаар хөндлөнгөөс оролцох эрхгүй.

#### **7-р зүйл. Багшийн материаллаг хэрэгцээгээ хангуулах эрх**

Багшид Хөдөлмөрийн гэрээ (контракт)-нд заасны дагуу албан ажил, үүргээ гүйцэтгэсний төлөө цалин хөлс болон албан тушаалын цалин олгоно. Хууль тогтоомжид зааснаас бусад, үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үүрэгт ногдох цалин хөлсийг нэмэлт гэрээний дагуу олгоно.

Багшийн цалин хөлсний хэмжээг боловсрол, ажилласан жил, аттестатчилалын дүн, ажлын үр дүн, мэргэжил дээшлүүлсэн сертификат, эрдмийн зэрэг олгосон болон төрийн шагнал олгосон үнэмлэх зэргийг үндэслэн тогтооно. Цалингийн доод хэмжээг улсын хэмжээний цалингийн дундаж хэмжээнээс дээш байхаар тогтооно.

Багш нарт үндсэн цалингийн хувиар нэмэгдэл олгоно. Нэмэгдлийн хэмжээ нь 5 жил ажилласан бол-10%, 10 жил-20%, 15 ба түүнээс дээш жил-30% байна.

Багшийн алдар хүндийн цол авсан бол цалингийн хэмжээг 50%, “Ардын багш” цол авсан бол 100% нэмэгдүүлэн олгоно.

- Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх, сургуулийн гадуурх сургалтын байгууллагад ажилладаг, эрдмийн зэрэг цолтой багшид хууль тогтоомжид заасан нэмэгдэлийг олгоно.
- Байгаль цаг уурын хүнд нөхцөлд ажилладаг багш нарт Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх буюу цалин хөлсний нэмэгдэл олгоно.

Сургуулийн байгууллага нь өөрийн төсөв, санхүүгийн боломжид тулгуурлан багш нарт шагналт цалин, материаллаг урамшуулал, нөхөн олговор олгох ба сурах бичиг, арга зүйн болон шинжлэх ухааны ном хэвлэл худалдан авч болно.

Стандарт нормоос давсан багшийн ажлын хөлсийг нэмж олгоно.

Анги удирдсан багшийн цалингийн нэмэгдэлийг дараах байдлаар тогтооно. Үүнд,

- 1-4 дүгээр ангид стандарт норм (цалин)-ын 20%-иар;
- 5-10 дугаар ангид стандарт норм (цалин)-ын 30%-иар.

Хөдөөний сургуульд багшлахаар ирсэн шинэ залуу мэргэжилтэнд орон нутгийн төсвөөс үндсэн цалинг 10 дахин өсгөсөн хэмжээтэй тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламжийг суурьшихад зориулан олгоно.

Хөдөө орон нутгийн төрийн өмчийн сургууль, боловсролын байгууллагад ажиллаж буй ажилтнуудын цалин хөлсийг хот суурин газар ажиллаж, амьдарч буй багш, ажилтнуудаас 25%-иас дээш өндрөөр тогтооно.

Төрийн сангийн зээлээр суралцаж багш мэргэжлээр төгссөн залуу багш нар хөдөө орон нутагт 5-аас доошгүй жил ажилласан бол төрийн сангийн зээлээс чөлөөлөгдөнө.

Багш нарт дэвтэр шалгасан, бичгийн ажил хийсэн, сургалтын кабинет хариуцсан, анги удирдсаны нэмэгдэл олгохоос гадна боловсролын салбар хариуцсан эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусад нэмэгдэл олгоно.

#### **8-р зүйл. Багшийн нийгмийн хамгааллын эрх**

Төрийн зүгээс багш нарт хууль тогтоомжид заасны дагуу шаардлага хангасан хөдөлмөрийн болон ахуйн нөхцөлөөр хангаж, нийгмийн хөнгөлөлт үзүүлнэ.

Боловсролын салбарын ажилтнууд 25 ба түүнээс дээш жил ажилласан тохиолдолд тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс орон нутгийн удирдах байгууллагууд холбогдох хууль, журмын дагуу багшид байр орон сууцны ашиглалтын зардалын төлбөрийг хөнгөлөх, амины орон сууц барихад нь хүүгүй зээл олгох үүрэгтэй.

#### **9-р зүйл. Багшийн амрах эрх**

Багшийн амрах эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сургалтын ачааллын төлөвлөлтөнд нийцүүлэн долоо хоног тутмын амралт, жил тутмын цалинтай амралт хэлбэрээр олгоно.

Төрийн зүгээс багш нарт 10 жил тасралтгүй багшилсаны дараа 1 жилийн хугацаатай шинжлэх ухаан- сурган хүмүүжүүлэх, сургалт-арга зүйн чиглэлээр бүтээл туурвиж, бие даан ажиллах бүтээлийн амралт олгоно.

Ажлын өдөр болон ажлын 7 хоногийн үргэлжлэх хугацааг Боловсролын тухай хуулиар тогтооно.

#### **10-р зүйл. Багшийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх**

- Багш нарын эрүүл мэндийг хамгаалах эрхийг хэрэгжүүлэхдээ ариун цэвэр-халдваргүйжүүлэлт, халдварт өвчний эсрэг арга хэмжээ, эмчилгээ- урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

- Төрийн өмчийн эмнэлэг- урьдчилан сэргийлэх байгууллагын амбулаторид багш нарыг жил тутам заавал үзүүлэх хэлбэрээр 1 удаа үнэгүй үзлэг, оношлогоо хийнэ.
- Багш нар хууль журамд заасны дагуу амралт- сувиллын газарт амрах, амралт-жуулчны баазуудад хөнгөлөлттэй үнээр амрах эрхтэй.

#### **11-р зүйл. Багшийн газар өмчлөх, эзэмших эрх**

- Хөдөө орон нутагт амьдарч, ажиллаж байгаа багш нарт хууль тогтоомжид заасны дагуу тариачин, фермерийн аж ахуйтнуудтай ижил эрхтэйгээр газар, үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгийг эзэмшүүлж, өмчлүүлнэ.
- Районын төв, хот хэлбэрийн тосгон, районы болон бүсийн чанартай хот суурин газарт ажиллаж, амьдарч буй багш нарт дугаар харгалзахгүйгээр амины орон сууц барих эрх олгох ба зуслангийн газар хуваарилна.

#### **12-р зүйл. Дээд болон дунд мэргэжлийн багш бэлтгэх сургууль төгсөгчдийг цэргийн албанаас чөлөөлөх, хугацаа хойшлуулах тухай**

- Дээд болон дунд мэргэжлийн багшийн сургууль төгсөөд хөдөө орон нутагт хуваарилагдсан багшийг хөдөө орон нутагт ажиллаж байх хугацаанд нь цэргийн жинхэнэ албанд татагдах хугацааг хойшлуулах буюу чөлөөлнө.

#### **13-р зүйл. Багшийг шагнаж урамшуулах**

Сурган хүмүүжүүлэх ажлын үр дүнгээр онцгой амжилт үзүүлсэн багш, сурган хүмүүжүүлэгчдийг эрх бүхий байгууллагын шагнал, төрийн дээд шагналд тодорхойлж шагнуулна.

#### **14-р зүйл. Багшийг дэмжих сан**

Багшийг дэмжих сан нь хууль, тогтоомжоор тогтоосон журмын дагуу гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүмүүсээс сайн дурын үндсэн дээр авсан хураамжаас бүрдэнэ.

Өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд багш нар хууль тогтоомжид заасны дагуу олон нийтийн байгууллага, ассоциаци, сан, багш нарын бүлгэм байгуулж болно.

#### **15-р зүйл. Багшид хориглох үйл ажиллагаа**

- Сургууль, боловсролын газарт шашны суртал ухуулга хийх, шашны зан үйл үйлдэх;
- Сургууль, боловсролын газарт нам, улс төрийн бүлгийн арга хэмжээ зохион байгуулах;
- Үндсэрхэг үзэл, нэг хүнийг тахин шүтэх, цэрэг дайны үзэл суртлыг дэлгэрүүлэх;
- Суралцагчдыг тэмцэл хөдөлгөөн, улс төрийн акцид татан оролцуулах;
- Суралцагчдад хүчирхийлэл үйлдэх, хүч хэрэглэх.

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАГШИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

##### **16-р зүйл. Багшийн үүрэг**

- Сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд явуулах, боловсролын стандарт нормоос дээш түвшинд суралцагсдад сургалтын хөтөлбөрийг эзэмшүүлэх;
- Суралцагчдын эцэг эхээ хүндлэх, эелдэг, хөдөлмөрч, улс орныхоо соёл-түүхийг хүндлэх, төрийн байгуулал төрт ёсны уламжлалаа хүндлэх, хүрээлэн буй орчноо хайрлах үзэл баримтлалаар хүмүүжүүлэх;
- Сурган хүмүүжүүлэх мэдлэг, чадвар, ёс суртахуунаа байнга дээшлүүлэх;
- Суралцагчдын үнэт зүйл, бахархалыг хүндлэх;
- Суралцагчдыг ард түмэн хооронд бие биенээ ойлгох, энхтайвныг эрхэмлэх, харилцан ойлголцох үзэл суртлаар хүмүүжүүлж, ухамсарт амьдралд бэлтгэх;

- Суралцагчдын бие даасан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх;
- Багшийн ёс зүй болон албан ажлын ёс зүйг дагаж мөрдөх.

#### **17-р зүйл. Багшид захиргааны болон эрүү-эрх зүйн хариуцлага хүлээлгэх**

Хууль зөрчсөн үйлдлийнхээ төлөө багш хүн тухайн улсын үндэсний хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАГШ БЭЛТГЭХ, БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, ДАВТАН СУРГАХ**

**18-р зүйл.** Тухайн улс орон бүрт багшлах мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг төрийн болон хувийн өмчийн мэргэжлийн багш бэлтгэх дунд болон дээд боловсролын байгууллага хариуцан гүйцэтгэнэ. Мэргэжлийн багш бэлтгэх сургалтын байгууллага нь үйл ажиллагааныхаа төлөө хувь хүн, улс, нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ. Багшлах мэргэжилтэн бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тухайн байгууллагын дүрмийн хүрээнд явуулах үйл ажиллагаанд Үүсгэн байгуулагчид (Төлөөлөн удирдах зөвлөл) болон боловсролын салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, сургалт боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагууд хяналт тавина.

Төрийн өмчийн багшийн сургуульд элсэгчдийг улсын захиалгаар тодорхой квотод багтаан ихэвчлэн улсын төсвийн хөрөнгөөр суралцуулахаар элсэлт авна.

#### **19-р зүйл. Багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх**

Төрийн зүгээс төрийн өмчийн сургууль, сургуулийн өмнөх болон сургуулийн гадуурх боловсролын байгууллагын багш нарыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах нөхцөлөөр хангана.

Багш нарын мэргэжил дээшлүүлэх ажиллагааг төвлөрсөн болон бүс нутгийн чанартай багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудтай хийсэн гэрээний үндсэн дээр улсын төсвөөс болон байгууллагын санхүүжилтээр зохион байгуулна.

Төрийн зүгээс багш нар болон шинжлэх ухаан-арга зүйн үйл ажиллагаа явуулдаг ажилтнуудад шинжлэх ухаан-заах аргын мэдлэгээ дээшлүүлэх, сургалтын арга зүй боловсруулах, зохион бүтээх, туршилт судалгаа явуулах, туршин шинжих үйл ажиллагаа явуулахад зориулан бүтээлийн чөлөө өгөх баталгаа гаргаж өгнө.

Багшийн мэргэжил дээшлүүлэх, шинжлэх ухаан-сурган хүмүүжүүлэх заах арга зүй хариуцсан ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх хэлбэр, арга, холбогдох журмыг тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор зохицуулаагүй бол Засгийн газар хариуцан шийдвэрлэнэ.

#### **ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ХЭСЭГ**

#### **20-р зүйл. Загвар хуулийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдах байгууллага, боловсролын байгууллага, албан тушаалтны үүрэг, хариуцлага**

Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, боловсролын салбарын байгууллага, албан тушаалтнууд нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэхүү загвар хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Багш нарын эрхийг хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаагүй албан тушаалтан, буруутай этгээд тухайн улсын үндэсний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Дээрх байгууллагуудын албан тушаалтан захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх албаны үүргээ



гүйцэтгэх явцдаа багшийн эрхийг зөрчиж хохирол учруулсан бол тухайн улсын үндэсний хууль тогтоомжид заасан журмын дагуу хохирлыг бүрэн барагдуулна.

*СНГ-ийн орнуудын Парламент хоорондын  
24-р нэгдсэн чуулганаар хэлэлцэн батлав.  
(Тогтоолын дугаар: 24-13 от 4 декабря 2004)*

## **1.2 БАГШИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ БА ЦАЛИН ХӨЛС ТООЦОХ ЗАГВАР СХЕМ (ОХУ-ЫН ТУРШЛАГА)**

Сүүлийн үед сургуулиудын нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд ОХУ-ын боловсролын салбарт багш нарын цалин хөлсийг дэвшилтэт байдлаар тооцоолох Хөдөлмөрийн хөлсний шинэ систем (Новая система оплаты труда) буюу НСОТ системийг нэвтрүүлж байна. 2007-2009 онд боловсролын салбарыг шинэчлэх иж бүрэн төсөл хэрэгжүүлэх явцад ОХУ-ын бүх бүс нутагт энэхүү системийг боловсруулах ажиллагаа явагдсан бөгөөд үүний үр дүнд тухайн бүс нутгуудын онцлогийг харгалзан багш нарын цалин хөлсийг тооцох 3 төрлийн загвар схемийг боловсруулсан байна. Эдгээр схемүүдийг нийтлэг зарчим дээр тулгуурлан боловсруулсан боловч тус тусдаа өөр, өөрийн ялгарах онцлогтой юм.

### ***Хөдөлмөрийн хөлсний шинэ системийн НСОТ загварыг боловсруулахад баримталсан нийтлэг зарчим***

- Сургууль бүрийн цалингийн санг нийт багш, ажилтнуудын цалингийн нормативаар тооцно. Сургууль тус бүр төрөөс өгсөн даалгаврын дагуу суралцаж байгаа хүүхдийн тоогоор 1 хүүхдэд ногдох сургалтын нормативт зардал авна. Сургуулийн зүгээс аль болохоор сурагч бүрийг сурч боловсрох таатай нөхцөлөөр хангахын төлөө тэмүүлнэ, ингэхдээ тухайн сургуульд ямар багшлах боловсон хүчин хэрэгтэй байгааг өөрсдөө шийднэ.  $ФОТ = N \times Y$  ( $N$ - ОХУ-ын субъектуудад тогтоосон 1 сурагчид оногдох нормативт зардал,  $Y$ -ерөнхий боловсролын дун сургуульд суралцаж буй суралцагчдын тоо)
- Сургууль нь хуваарилагдсан төсвийн хүрээнд сургалтын төлөвлөгөө, хуваариа бие даан боловсруулна. Сургуулийн зүгээс аль болох үр ашигтай байдлаар боловсролын хөтөлбөрөө боловсруулах бөгөөд сургалтын хөтөлбөрийн онцлог, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн сургалтын төлөвлөгөөгөө, хуваариа боловсруулна. Ингэхдээ эхний ээлжинд үндсэн багш нарынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх зарчим баримтална.
- Сургалтын байгууллагын цалин хөлсний сан нь суурь фонд болон урамшууллын фондоос бүрдэнэ. Хөдөлмөрийн хөлсний суурь фонд нь ажиллагсадын цалин хөлсний тогтмол хэсгээс (хариуцан гүйцэтгэж буй ажлын хэмжээ болон ажлын нөхцөлөөс хамааруулан тогтоосон үндсэн цалин) бүрдэнэ. Урамшуулалт цалингийн фонд нь тухайн багшийн ажлын чанарыг үнэлэх батлагдсан үзүүлэлтийн дагуу Сургуулийн зөвлөлийн шийдвэрээр (ажлын ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр) хуваарилагдана.
- Багшийн цалинг тооцохдоо сургалтын цагаас гадна сургалтаас гадуурх бусад үйл ажиллагаа, тухайлбал, кабинет удирдсан, дэвтэр шалгасан, үзүүлэн таниулах материал бэлтгэсэн, давтлага өгсөн, эцэг эхтэй ажилласан зэрэгт олгох хөлсийг оруулан тооцно.
- Сургуулийн захирлын цалинг тогтоохдоо нийт багш нарын дундаж цалингийн хэмжээтэй пропорциональ байхаар тогтоох бөгөөд захирлын зүгээс багш сурган хүмүүжүүлэгчдийг зайлшгүй нормоос хэтрүүлэн дайчлахгүй байх, багш нарыг цалин хөлсний зохистой түвшинд ажиллуулах зарчим барьж ажиллах ёстой.

## **БАГШ НАРЫН ЦАЛИН ХӨЛСИЙГ ТООЦОХ 3 ЗАГВАР**

### **ЗАГВАР 1. “СУУРЬ ЦАЛИН +” ХУВИЛБАР**

Энэхүү загвар нь суурь цалин болон өсөн нэмэгдүүлэх коэффициентээс бүрдэх бөгөөд цалингийн тогтмол хэсэг буюу суурь цалинг тооцохдоо бүс нутгийн түвшинд батлагдсан суурь цалингийн хэмжээг баримтална. Ингэхдээ ижил албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудын цалин хөлс ижил байна гэсэн зарчмыг баримтална. Багш тус бүрийн ажлын ачаалалаас хамааруулан (сургалтын цагийн тоо хэмжээ, хичээлээс гадуурх үйл ажиллагааны төрлүүд гэх мэт) суурь цалин дээр өсөн нэмэгдүүлэх коэффициентээр урамшуулалт цалин олгоно. Багш бүрт ногдох суралцагчийн тоо харилцан адилгүй өөр өөр байдгийг энэхүү загвараар цалин хөлс тооцохдоо харгалзан үзнэ. Ингэхийн тулд тусгай коэффициент ашиглана. (ХАВСРАЛТ 1-ИЙГ ҮЗНЭ ҮҮ)

### **ЗАГВАР 2. “БҮГДИЙГ ТООЦСОН” ХУВИЛБАР**

Энэхүү загвар нь 1 багшийн долоо хоногт ажиллах цагийг 36 цагаар тооцож үндсэн цалингийн хэмжээг тогтоосноороо нөгөө 2 загвараасаа ялгаатай. Энэхүү 36 цагийн цалин хөлсөнд багшийн үндсэн сургалтын цагийн төлбөр болон бусад бүх нэмэгдлүүдийг шингээсэн байдгаараа онцлогтой. Багш тус бүрийн сургалтын болон сургалтын бус үйл ажиллагааны харьцаа, хувь хэмжээг ажил олгогч-сургуулийн захиргаа болон багшийн хооронд хийсэн гэрээгээр зохицуулна. Сургалтын болон сургалтын бус цагийн үнэлгээг сургууль, орон нутгийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд бүхэлд нь тогтоож болно. (ХАВСРАЛТ 2-ыг үзнэ үү.)

### **ЗАГВАР 3. “СУРАГЧ-ЦАГ” ХУВИЛБАР**

Энэхүү загвар нь “сурагч-цаг” зарчим дээр үндэслэсэн бөгөөд ингэхдээ багшийн цалин хөлсний тогтмол хэсгийг тооцохдоо багш тус бүрийн сургалтын цаг болон сурагчдын тоог харгалзан үздэгээрээ онцлогтой. Сургууль болгон Цалин хөлсний сандаа багтаан “сурагч-цаг”-ийн хэмжээг тооцоолох ба ингэхийн тулд сургалтын 1 академик цагийн хугацаанд багшийн зүгээс 1 сурагчтай ажиллах ажлын өртгийг тооцоолно. Багш тус бүрээр академик цагийн ачаалалын хэмжээг тооцон гаргах замаар нийт цалингийн санд нь багтаан хуваарилна. Энэхүү загвараар багшийн цалин хөлсийг тооцоолоход багшийн ажлын ачаалалыг цалин хөлс тооцохдоо харгалзан үздэгээрээ онцлогтой. (ХАВСРАЛТ 3-ыг үзнэ үү)

## **2. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ТУРШЛАГА**

Польш Улсад багшийн хөгжлийн талаарх бие даасан хууль байхгүй бөгөөд Багшийн мэргэжилд тавигдах үндсэн шаардлага, багшийн хөдөлмөрийн үнэлгээ, багшийн нийгмийн баталгааны талаарх асуудлуудыг 1982 онд батлагдсан "Багшийн эрх зүйн байдлын<sup>112</sup>" тухай хуулиар зохицуулдаг байна. Тус хууль нь 12 бүлэг, 102 зүйлтэй.

Багшийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар багшийн албан тушаалд тавигдах шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Заах арга зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, эсхүл багш мэргэжилтэй, мэргэжлээрээ ажиллаж байсан;
- Ёс суртахууны шаардлага хангасан;
- Эрүүл мэндийн хувьд мэргэжлээрээ ажиллах боломжтой хүнийг багшаар ажиллуулахаар заасан байна.

Мөн хуулийн 9а зүйлд зааснаар багш нарыг:

а\_\_\_\_\_

<sup>112</sup>Act of 26 January 1982, Teacher's charter

<https://www.global-regulation.com/translation/poland/2986066/act-of-26-january-1982%252c-teachers-card.html>

- Дадлагын багш;
- Гэрээт багш;
- Үндсэн багш;
- Мэргэшсэн багш гэж 4 ангилдаг байна.

Хуульд зааснаар сургуульд хөдөлмөрийн гэрээгээр анхлан ажил эрхлэх аливаа этгээдийг дадлагын, дээд боловсролын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, эсхүл мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан бол гэрээт, багшийн мэргэжилтэй, ахлах сургуульд 3-аас доошгүй жил ажилласан, эсхүл нийгмийн ажилтны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн бол үндсэн багшид хамааруулдаг байна.

14 дүгээр зүйлд зааснаар Багш нартай байгуулах хөдөлмөрийн гэрээнд ажлын байр, чиг үүрэг, цалингийн хэмжээг зайлшгүй тусгана. Үндсэн багшийг зайлшгүй шаардлагаар шилжүүлэн ажиллуулах бол 2 сургуулийн удирдлага урьдчилан тохиролцсон байна. Энэ тохиолдолд багшийн зөвшөөрөл шаардлагагүй боловч 3 жилээс хэтрэхгүй хугацаанд ажилласны дараа хуучин ажиллаж байсан ажлын байрандаа эргэн ажиллах эрхтэй байдаг байна.

Багшийг өөр хотод шилжүүлэн ажиллуулах бол тухайн багш нь:

- 7 хоногт ажлын 4 өдөр ажиллах;
- Үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх тэтгэмж сар бүр авах;
- Амьдрах орон байраар хангуулах эрхтэй;
- Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдөх бол 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж авах эрхтэй байхаар заажээ.

Дараах тохиолдолд багшийн хөдөлмөрийн гэрээг цуцална.

- Өөрийн хүсэлтээр;
- Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон;
- Ёс зүйн хувьд тэнцэхгүй болсон;
- 182 өдрөөс дээш хугацаагаар ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;
- Гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх бол тухайн хичээлийн жил дууссаны дараа, бусад шалтгаанаар бол тухайн хуанлийн сарын сүүлийн өдрөөр тооцож цуцлана.

Хуулийн 29 дүгээр зүйлд ажлын нөхцөл цалингийн асуудлыг зохицуулсан байна.

Сургуулийн захиргаанаас багшийн үүрэгт ажлаа гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах үүрэгтэй. Боловсролын яамнаас багш сургуулийн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн нөхцөлийг тогтоон мөрдүүлнэ.

Багш нарын цалин нь үндсэн цалин, урамшуулал, тэтгэврийн, ажлын нөхцөлийн илүү цагийн болон ажлын цаг орлон тооцох нэмэгдэл болон шагнал, ажил үүрэг гүйцэтгэснээс үүсэх ашиг орлого зэргээс бүрдэнэ.

Хуулийн 30 дугаар зүйлд зааснаар багшийн үндсэн цалин нь багшийн зэрэг боловсрол, ажилласан хугацаа, долоо хоног тутмын нормт ажлын цаг, ажлын нөхцөл, ажлын чанар, нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсэн байдал зэрэг хүчин зүйлсээс хамаарч тогтоогдоно.

Жил бүрийн Төсвийн тухай хуульд заасан багшийн дундаж цалин нь:

- Дадлагын багш 100%;

- Гэрээт багш 111%;
- Үндсэн багш 144%;
- Мэргэшсэн багш 184 хувиар тус тус тооцно.

Боловсрол болон хөдөлмөрийн яамнаас хамтран багшийн хүнд хөдөлмөрийн жагсаалтыг батлан гаргадаг байна. Багшийн 7 хоногийн үндсэн ажлын цаг 40-өөс хэтрэхгүй байхаар хуульчилсан байна. Сургуулийн захиргаанаас үндсэн цагийг багасгах нөхцөл байдлыг тогтоосон журам гаргаж болох ба энэ тохиолдолд үндсэн цалинг бууруулахыг хориглодог байна.

Шөнийн цагаар ажилласан цаг тутамд цалингийн 15 хувийн нэмэгдэл олгоно. Өдөр тутмын сургалттай сургуульд багшлах багшийг 2 долоо хоногт багадаа 2 дараалсан өдөр амраах бөгөөд Ням гариг давхцуулан амраана. Амралтын өдөр ажилласан нөхцөлд нөхөж амраана.

Багшаар тогтвортой ажилласны урамшууллыг дараах байдлаар олгохоор хуулийн 46-р зүйлд заасан байна.

- 1) 20 хүртэлх жилд сарын цалингийн 75%;
- 2) 25 хүртэлх жилд сарын цалингийн 100%;
- 3) 30 хүртэлх жилд сарын цалингийн 150%;
- 4) 35 хүртэлх жилд сарын цалингийн 200%;
- 5) 40 хүртэлх жилд сарын цалингийн 250%;

49 дүгээр зүйлд Багшийн мэргэжлийн амжилт, ур чадварын санг байгуулах бөгөөд энэ нь сургуулийн төсвийн 1-ээс багагүй хувийг жил тутмын багш, боловсон хүчний шагналд зарцуулж болохоор тусгасан байна.

Газарзүйн байршил: (амьжиргааны өндөр өртөг, эсвэл алслагдсан газар)

5000 хүртэлх оршин суугчтай хөдөө орон нутагт ажиллах багшид сар бүр цалингийн 10 хувийн нэмэгдэл олгох бөгөөд сургуулийн захиргаанаас дээрх хэмжээг нэмж болно. Хөдөө орон нутагт ажиллах багш нь 0.25 га-гаас багагүй хэмжээний тариалангийн талбай хүсэх эрхтэй. Сургуулийн орон сууцанд зөвхөн сургуулийн багш ажилчид амьдрах эрхтэй байдаг байна. Мөн Орон сууцны тэтгэмжийг орон нутгийн засаг захиргаанаас баталсан дүрэмд заасан хэмжээнээс хэтрэхгүй байх хэмжээнд олгоно.

Хувийн хэвшлийн хараат бус, бие даасан сургуулиудад багшийн үндсэн цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль, түүнчлэн сургуулийн дүрэмд заасан цалин хөлсний дүрмээр тодорхойлдог. Тухайн багш хамгийн их үндсэн цалин авахын тулд ажиллах ёстой дундаж жил нь 20 байна.

<b>Улсын сургуульд бүтэн цагаар ажилладаг багшийн жилийн нийт цалин</b>						
	<b>Дундаж цалин</b>				<b>Дундаж бодит</b>	
	<b>Хамгийн бага</b>		<b>Хамгийн их</b>		<b>цалин</b>	
	<b>злот</b>	<b>евро</b>	<b>злот</b>	<b>евро</b>	<b>злот</b>	<b>евро</b>
<b>Сургуулийн өмнөх</b>	22805	5450	38054	9095	49856	11916
<b>Бага</b>	22805	5450	38054	9095	57738	13799
<b>Дунд</b>	25687	6139	43390	10370	58907	14079
<b>Ахлах</b>	29043	6941	49666	11870	57837	13823

Эх сурвалж: *Teachers' and School Heads' Salaries and Allowances in Europe – 2015/16*

Багшийн мэргэжлээр анх удаа ажиллахад 2 сарын үндсэн цалин, профессор цол авахад 6 сарын үндсэн цалин, өөр сургууль уруу шилжин ажиллахад хүнд нөхцөлийн нэмэгдэл 20 хувийг тус тус авдаг байна.

Аливаа шагнал урамшууллыг тухайн сургуулийн удирдах байгууллага болон орон нутгийн захиргаанаас гаргасан дүрэм журмын хүрээнд сургуулийн удирдлага шийдвэрлэнэ.

### **3. БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН УЛСЫН ТУРШЛАГА**

Филиппин Улсад “Багшийг мэргэшүүлэх тухай” хуулиар багш нарын мэргэжлийн ур чадвар, хөгжлийг дэмжих, сайжруулах зорилгоор багш нарт мэргэжлийн багшийн зэрэг олгох, улмаар багш нарын ур чадвар, чансаа тогтоох шалгалтанд хамрагдах, ингэснээр цалин, урамшуулал, албан тушаал, тэтгэлэгт хамрагдах зэрэг харилцааг зохицуулдаг байна. Багшийг мэргэшүүлэх тухай хууль<sup>113</sup> нь 1994 онд батлагдсан бөгөөд 4 бүлэг 36 зүйлтэй.

Тус хууль нь багш, багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх болон тусгай зөвшөөрөл олгох шалгалтанд хяналт тавих, зохицуулалт хийх зорилготой.

Хуульд зааснаар Филиппин Улсын Ерөнхийлөгчөөс томилогддог 5 гишүүн бүхий мэргэжлийн багш нарын зөвлөл нь багш нарын мэргэжлийн шалгалт зохион байгуулах, шалгалт авах бүрэлдэхүүнийг томилох, шалгалт авах газар, өдөр, давтамжийг тогтоох, мэргэжлийн багшийн гэрчилгээ олгох, хүчингүй болгох, сэргээх, багшийн ёс зүй, мэргэжлийн стандарттай холбогдох журам гаргах зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна. /6 дугаар зүйл/

Хуулийн 15-р зүйлд зааснаар мэргэжлийн багшийн эрх олгох шалгалтыг жил бүр зохион байгуулах бөгөөд анхан болон дунд сургуулийн багш нар хамрагддаг. Бага сургуулийн багш нар ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын, дунд сургуулийн багш нар ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэшлийн гэсэн бичгийн шалгалтыг өгдөг байна.

Шалгалтанд оролцохыг хүссэн багш нарт тавигдах ерөнхий шаардлага нь:

- 18 нас хүрсэн;
- Эрүүл мэндийн болон ёс зүйн шаардлага хангасан;
- Ёс зүйтэй холбогдох гэмт хэрэгт ял шийтгүүлээгүй;
- Багшийн мэргэжилтэй байна.

Шалгалтанд тэнцсэн багш нарыг мэргэжлийн багш нарын нэгдсэн жагсаалтанд хамруулж, гэрчилгээ олгодог. Улмаар мэргэжлийн багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 5 жил тутам мэргэжлийн багшийн ур чадвар, чансаа тогтоох шалгалтыг зохион байгуулдаг байна. /19 зүйл/

Хуулийн 21-р зүйлд зааснаар багшийн шаардлага хангаж, шалгалтанд тэнцсэн багш авсан онооны дарааллаар буюу багш нарын цуглуулсан оноог харгалзан:

- Удирдах зөвлөлөөс диплом олгоно;
- Тухайн багшийн цалин нэмэгдэх, албан тушаал дэвших үндсэн шалгуур болдог;
- Тухайн шалгалтын онооны дарааллаар багш нарыг Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах нэгдсэн жагсаалтад бүртгэдэг;
- Удирдах зөвлөлөөс баталсан бусад тэтгэмжийг олгодог байна.

а\_\_\_\_\_

<sup>113</sup>Philippine Teachers Professionalization Act of 1994

[http://pcw.gov.ph/sites/default/files/documents/laws/republic\\_act\\_7836.pdf](http://pcw.gov.ph/sites/default/files/documents/laws/republic_act_7836.pdf)

#### **4. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ТУРШЛАГА**

Тус улсад багшийн хөгжлийн асуудлыг 1993 онд батлагдсан Бүгд Найрамдах Хятад Ард улсын “Багшийн тухай хууль” (Teachers Law of the People's Republic of China)-аар зохицуулдаг.

Хуулийн гол зорилго нь багш нарын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, ёс зүйн төлөвшил сайтай, мэргэжлийн ур чадвар өндөртэй багш боловсон хүчнийг бэлтгэх, социалист боловсролын хөгжлийг сурталчилахад оршино.

Багшийн тухай хуулиар багшийн эрх үүрэг, ажил эрхлэлт болон түүнд тавигдах шаардлага, багшийн хөгжил, нийгмийн баталгаа ба урамшуулал, хариуцлага зэргийг зохицуулсан ба энэхүү хууль нь бүх шатны сургууль, эсхүл бусад боловсролын байгууллагуудын боловсрол, сургалтанд оролцож байгаа бүхий л багш нарт хамаарна.

Хуулийн 3-р зүйлд зааснаар: Багш нар бол боловсрол, сургалтын үйл ажиллагааг эрхлэгч мэргэжилтнүүд бөгөөд хүн ардад мэдлэг түгээж, социализмын эх үндсийг бүтээн байгуулагчид ба түүнийг залгамжлагчдыг сургах, улс үндэстний эрдэм чадлыг бадруулах үүрэгтэй бөгөөд багш нар өөрсдөө хүн ардын боловсрол гэгээрлийн эх булаг байх ёстой.

Мөн түүнчлэн бүх шатны Ардын засаг нь багш нарын үзэл санаа ба улс төрийн боловсрол, мэргэжлийн сургалтыг бэхжүүлэх, тэдний ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах, хууль ёсны эрх ба ашиг сонирхлыг хамгаалах, тэдний нийгмийн байр суурийг өсгөх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Багш нарыг бүхэл нийгэм хүндэтгэх ёстой.

#### ***Төрийн Зөвлөлийн дэргэдэх Боловсролын удирдлагын газар:***

Төрийн Зөвлөлийн дэргэдэх Боловсролын удирдлагын газар нь улсын багш нартай хамааралтай бүх ажлыг хариуцна. Харин Төрийн Зөвлөлийн дэргэдэх бусад газрууд нь тус тусын эрх мэдэл, үүрэг үйл ажиллагааны хүрээн дэх багш нартай хамаарах ажлыг хариуцдаг. Сургууль болон бусад боловсролын байгууллагууд нь өөрсдийн багш нарын хэргийг Төрийн холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрхлэн удирдана<sup>114</sup>.

Хууль ёсоор жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдөр бол Багш нарын өдөр байна.

#### ***Багшийн мэргэшлийн шалгуур, ажил эрхлэлт:***

Хуулийн 3-р бүлэгт мэргэшил, ажил эрхлэлтийн талаар хуульчилсан байна. Багш нарын мэргэшлийн системийг төрөөс тогтоон байгуулдаг байна.

Багшийн мэргэшлийн үнэмлэх авахын тулд дор дурьдсан албан ёсны сургууль, сургалтыг төгссөн байх шаардлагатай. Үүнд:

- (1) Цэцэрлэгийн багшийн мэргэшилтэй болохын тулд сургуулийн өмнөх насныхны багшийн сургууль, эсхүл түүнээс дээд шатны багшийн сургуулийг төгссөн байх;
- (2) Бага сургуулийн багшийн мэргэшилтэй болохын тулд дунд сургуулийн багшийн сургууль, эсхүл түүнээс дээд шатны багшийн сургууль төгссөх байх;
- (3) Бага дунд сургуулийн багшийн, эсхүл мэргэжлийн боловсролын анхан шатны сургуулийн ерөнхий мэдлэгийн болон тусгай мэргэжлийн хичээлүүдийн багш мэргэшилтэй болохын тулд тусгай мэргэжлийн багшийн дээд сургуулийг төгссөн, эсхүл бусад хоёр эсхүл гурван жилийн сургалттай эсхүл түүнээс дээш хугацааны сургалттай

а

<sup>114</sup> Багшийн тухай хууль 5-р зүйл (Teachers Law of the People's Republic of China)  
<https://www.chinaeducenter.com/en/cedu/tlc.php>



коллеж, эсхүл их сургуульд суралцсан байх;

(4) Ахлах дунд сургуулийн, эсхүл мэргэжил үйлдвэрлэлийн дунд сургууль, техникийн сургууль, эсхүл мэргэжлийн дээд сургуулийн ерөнхий мэдлэгийн болон тусгай мэргэжлийн хичээлүүдийн багш мэргэшилтэй болохын тулд дөрөв буюу түүнээс олон жилийн сургалттай багшийн коллеж, эсхүл бусад коллеж, их сургуулийг төгссөн ба мэргэжил үйлдвэрлэлийн дунд сургууль, техник мэргэжлийн сургууль, эсхүл мэргэжлийн дээд сургууль дахь оюутны дадлага ажлыг удирдах зааварлагчийн мэргэшлийн албан ёсны сургалтын тэмдэглэлийн тухайд Төрийн зөвлөлийн дэргэдэх боловсролын удирдлагын газар тодорхойлно.

(5) Дээд сургуулийн багшийн мэргэшилтэй болохын тулд их сургуулийн дипломын дараах сургалтыг дүүргэсэн, эсхүл их сургууль дүүргэсэн байх;

(6) Насанд хүрэгчдийн боловсролын багш болохын тулд насанд хүрэгчдийн боловсролын аль шат түвшин, ангилал гэдгээс хамааран дээд сургууль, дунд сургууль эсхүл түүнээс дээд шатны сургууль төгссөн байх.

Энэ хуульд заасан багшийн мэргэшлийн албан ёсны сургууль сургалтын сертификатгүй иргэд улсын багшийн мэргэшлийн шалгалтуудыг өгөх ёстой. Улсын багш нарын мэргэшлийн шалгалтын тогтолцоог Төрийн Зөвлөлөөс тодорхойлон тогтооно.

12-р зүйлд зааснаар Төрийн Зөвлөлийн дэргэдэх боловсролын удирдлагын газраас энэ хууль батлагдахаас өмнө сургууль, эсхүл бусад боловсролын байгууллагуудад багшилж эхэлсэн боловч энэ хуульд заасан албан сургалтын сертификатгүй багш нарын мэргэшлийн тухайд шилжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

13-р зүйлд зааснаар Бага болон дунд сургуулийн багш нарын мэргэшлийг орон нутгийн ардын засгийн газрын, эсхүл түүнээс дээд улсын түвшний засгийн дэргэдэх боловсролын удирдлагын газраас үнэлэн шалгаж зөвшөөрөл өгнө. Мэргэжил үйлдвэрлэлийн дунд сургуулиуд, техникийн сургуулиудын багш нарын мэргэшлийг орон нутгийн ардын засгийн газрын, эсхүл түүнээс дээд улсын түвшний засгийн дэргэдэх боловсролын удирдлагын газрын тэтгэлэг дор холбогдох эрх бүхий газраас үнэлэн шалгаж зөвшөөрөл өгнө. Дээд боловсролын институтын багш нарын мэргэшлийг Төрийн Зөвлөлийн, эсхүл мужийн, автономит бүс нутгийн, эсхүл Төв Засгийн газрын шууд удирдлага дахь том хотууд, эсхүл тэдгээр газруудын албан ёсоор эрх олгосон сургуулиуд үнэлэн шалгаж, зөвшөөрөл өгнө.

Хэрвээ энэ хуульд заасан албан ёсны сургалтын тэмдэглэлтэй (a record of formal schooling), эсхүл улсын багш нарын мэргэшлийн шалгалтуудыг өгчихсөн иргэн өөрийн багшийн мэргэшлийг үнэлэн шалгаж, зөвшөөрөл өгөхийг хүсвэл тухайн газрууд энэ хуульд заасан шалгуурын дагуу үнэлгээ, зөвшөөрлийг өгнө.

Багшийн мэргэшилтэй боловч анх удаа багш болж байгаа иргэдэд туршилтын хугацаа тогтооно.

Харин улс төрийн эрхээ хасуулсан, эсхүл тодорхой хугацаанд хоригдсон, эсхүл санаатай гэмт хэргийн улмаас хүнд ял эдэлсэн иргэдэд багшийн мэргэшил олгохыг зөвшөөрөхгүй ба багшийн мэргэшлийн эрх авсан бол түүнийг нь цуцлана.

Бүх шатны багшийн сургууль төгсөгчид нь боловсрол, сургалтын үйл ажиллагаанд Төрийн холбогдох хууль, журмын дагуу оролцоно.

Төрөөс дээд боловсролын багшийн бус сургуулиудыг төгсөгчдийг бага, дунд сургуулиуд эсхүл мэргэжлийн боловсролын сургуулиудад багшлахыг дэмжинэ.

16-р зүйлд зааснаар Төрөөс багш нарын мэргэжлийн цол, зэргийн системийг тогтооно. Төрийн Зөвлөлөөс тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Сургууль, бусад боловсролын байгууллагууд нь аажмаар багш нарыг томилдог системийг бүрэлдүүлнэ. Багш нарыг томилох нь хоёр талаас тэгш зарчимд тулгуурлана. Сургууль ба багш нь нэг нь нөгөөгийнхөө эрх, үүрэг ба хариуцлагыг харилцан тодорхойлох гэрээнд үзэглэнэ. Багш нарыг томилох системийг хэрэгжүүлэх алхам ба арга хэмжээнүүдийг Төрийн Зөвлөлийн дэргэдэх боловсролын удирдлагын газраас боловсруулна.

### ***Багшийг бэлтгэх ба сургах (Cultivation and Training)***

Хуулийн 4-р бүлэгт багш нарыг бэлтгэн сургах асуудлыг хуульчлан зохицуулжээ. 4-р бүлгийн 18-р зүйлд зааснаар Бүх шатны Ардын засаг ба түүний газрууд багшийн сургуулийн боловсролыг амжилттай сайн байлгах тухайд анхаарч шилдэг сайн залуусыг бүх шатны багшийн сургуульд суралцахад нь урамшуулан ухуулна. Бүх шатны ахисан түвшний сургалт бүхий багшийн сургуулиуд бага, дунд сургуулийн багш нарыг бэлтгэх зорилгыг хангах ёстой.

Багшийн бус сургуулиуд бага, дунд сургуулийн багш нарыг бэлтгэх зорилтыг хангах ёстой. Бүх шат түвшний багшийн сургуулийн оюутнуудад мэргэжлийн тэтгэлэг олгоно.

Мөн бүх шатны Ардын засгийн газруудын дэргэдэх Боловсролын удирдлагын газрууд, Сургуулийн хэрэг ба сургууль хариуцсан газруудаас багш нарыг сургах хөтөлбөрүүдийг боловсруулж, багш нарт олон талт үзэл суртлын, улс төрийн ба мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулна.

20-р зүйлд зааснаар Төрийн байгууллагууд, аж ахуйн нэгж, институт ба бусад нийгмийн байгууллагууд багш нарын нийгмийн судалгаа, нийгмийн практикт нь дэм, тус болж байх ёстой. Бүх шатны Засгийн газрууд нь үндэсний цөөнх, зах хязгаар болон ядуурал ихтэй бүс нутгуудын багш нарыг сурган бэлтгэх тухайд арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

### ***Багшийн мэргэшлийн үнэлгээ /Assessment/***

Хуулийн 5-р бүлэгт багшийн мэргэшлийн үнэлгээний талаар хуульчилсан бөгөөд 22-р зүйлд зааснаар сургууль, эсхүл бусад боловсролын байгууллагууд нь багш нарын улс төрийн ухамсар ба үзэл санааны түвшин, мэргэжлийн чадвар, ажилдаа хандах хандлага ба ажлын гүйцэтгэлээр нь үнэлж шалгана. Боловсролын удирдлагын газрууд багш нарын үнэлгээний ажлыг удирдан чиглүүлнэ.

Үнэлгээний ажлыг объектив, шударга бөгөөд зөв арга хэлбэрээр хийж, үнэлгээний явцад багш нарын өөрсдийнх нь санал бодол, тэдний хамт олон ба сурагч оюутнуудынх нь санал бодлыг бүрэн дүүрэн харгалзан үздэг.

Үнэлгээний дүн нь багш нарыг томилох, цалин нэмэх ба шагнаж урамшуулах, сахилгын хариуцлага (шийтгэл) ногдуулах үндэс болдог байна.

### ***Багшийн цалин, нийгмийн баталгаа, тэтгэмж***

Хуулийн 6-р бүлэгт багшийн нийгмийн баталгаа болон материаллаг тэтгэмжийн талаар зохицуулсан байна.

25-р зүйлд зааснаар Багш нарын дундаж цалин төрийн албан хаагчийнхаас багагүй буюу түүнээс их байх ба аажмаар нэмэгдүүлэх зарчмыг баримтална. Энэхүү арга хэмжээг Төрийн зөвлөлөөс зохион байгуулна.

Бага, дунд, мэргэжлийн боловсролын сургуулийн багш нарт багшилсан хугацаа ба бусад урамшуулалтай нь дүйцэхүйц хэмжээний урамшуулал олгох ба, Төрийн Зөвлөлийн дэргэдэх

Боловсролын удирдлагын газраас бусад холбогдох газруудтай хамтран тусгай арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Орон нутгийн бүх шатны Ардын засгийн газраас үндэстний цөөнх, зах хязгаар нутаг ба ядуурал ихтэй бүс нутгийн багш нар, мэргэжлийн боловсролын дунд сургууль төгсөгчид, дээд түвшний сургууль төгсөгчдөд нэмэлт урамшуулал тэтгэлэг олгоно.

Хуулийн 28-р зүйлд зааснаар Бүх шатны орон нутгийн Ардын засгийн газрууд ба Төрийн зөвлөлийн дэргэдэх газар, албадууд хотын багш нарт зориулж барилга барих, байр түрээслэх ба худалдах зэргийг илүү чухалчлан таатай нөхцөлөөр хангаж өгнө.

Сум ба жижиг хотын Ардын засгийн газрууд нь хөдөө орон нутагт бага, дунд сургуулийн багш нарын байрны асуудлыг шийдвэрлэх тухайд илүү таатай хандах шаардлагатай.

Мөн багш нар эмнэлгийн үйлчилгээнд тухай тухайн оршин суух газрынхаа төрийн албан хаагчидтай адил тэгш хамрагдана. Эмнэлгийн үзлэгт тогтмол хамрагдаж орон нутгийнхаа нөхцөлтэй уялдуулан эмчилгээ, сувилгааны амралт эдлэх эрхтэй. Орон нутаг дахь эмнэлгийн газрууд багш нарын эмчилгээнд таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

30-р зүйлд зааснаар багш нар тэтгэвэрт гарах, эсхүл ажлаас гарсан тохиолдолд Төрөөс тогтоосон материаллаг тэтгэмжийг олгоно.

Сумын түвшний болон түүнээс дээших түвшний орон нутгийн Ардын засгийн газрууд боловсрол, сургалтын салбарт удаан жил ажилласан бага, дунд сургуулийн багш нарын тэтгэврийг зохих хувь хэмжээгээр нэмж тогтоож болно.

Бүх шатны Ардын засгийн газрууд нь Төрийн урамшууллыг хандивлагчдаас (collectors) авсан бага болон дунд сургуулийн багш нарын материаллаг тэтгэмжийг сайжруулах, аажмаар тэдний цалинг Төрөөс цалин авч буй багш нарынхтай адил тэнцүү болгох арга хэмжээнүүдийг авна. Тийм учраас бүх шатны орон нутгийн Ардын засгийн газрууд тухайн орон нутгийн нөхцөлд тохирсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Харин хувийн хэвшлийн сургууль, байгууллагын багш нарын материаллаг тэтгэмжийг ивээн тэтгэгчид өөрсдөө тогтоож баталгаажуулна.

### ***Багшийн шагнал, урамшуулал***

Хуулийн 33-р зүйлд зааснаар боловсрол, сургалтын ажил, хүн сургах, эрдэм шинжилгээний ажил, боловсролын шинэчлэл, сургуулийн хөгжил, нийгмийн үйлчилгээ ба ажил-сурлагын хөтөлбөрүүдэд онцсайн дүн үзүүлсэн багш нарыг харьяа сургууль нь урамшуулан шагнана. Мөн онцгой гавьяа байгуулсан багш нарыг Төрийн Зөвлөл, бүх шатны орон нутгийн Ардын засгийн газар ба тэдгээрийн харьяа албадуудаас шагнаж урамшуулна.

Боловсролын үйл ажиллагаанд онцгой хувь нэмэр оруулсан багш нарт Төрийн холбогдох хууль, журмын дагуу хүндэт дээд цол шагнах зэрэг байдлаар хуульчилжээ.

Багш нарыг шагнаж урамшуулах тухайд хууль ёсоор үүсгэн байгуулагдсан санд мөнгө хандивласан нийгмийн байгууллага ба хувь хүмүүсийг Төрөөс урамшуулан дэмждэг байна.

## **5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА**

Бүгд Найрамдах Солонгос Улсад багшийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг “Боловсролын тухай хууль” (Framework Act on Education), “Боловсролын ажилтны тухай хууль” (Educational Officials Act), Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Боловсролын ажилтны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”, “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль” (The Early

Childhood Education Act), “Бага болон дунд боловсролын тухай хууль” (The Elementary and Secondary Education Act), “Дээд боловсролын тухай хууль” (The Higher Education Act) зэрэг хуулиудаар зохицуулдаг байна.<sup>115</sup>

Тус улсад багшийн мэргэжлийг хүндэтгэн үздэг бөгөөд Солонгос залуучуудын эзэмших дуртай мэргэжлүүдийн нэг юм. Энэ нь багшийн цалин харьцангуй өндөр, ажлын байр тогтвортой, ажиллах нөхцөл сайн байдагтай холбоотой. Багшийн мэргэжлийн нэр хүнд өндөр байдаг нь багшийн мэргэжилд тавигдах шаардлага өндөр байдагтай холбоотой. Багшийн мэргэжлээр ажиллах хүсэлтэй хүн бүр багшлах эрхийн үнэмлэхтэй байх ёстой. Багшлах эрхийн үнэмлэхийг багшийн коллеж, коллеж, их сургуульд 4 жил суралцан, аль нэг салбараар мэргэшин, сурган хүмүүжүүлэх онолыг эзэмшин, Бакалаврын зэрэгтэй төгссөн төгсөгчид эзэмших эрхтэй. Үүнээс гадна 9 долоо хоногийн хугацаанд 4 сэдвийн хүрээнд дадлага хийсэн байх шаардлагатай байна. Үүнд:

- Ажиглалтын дадлага
- Оролцооны дадлага
- Багшлах дадлага
- Захиргааны ажлын дадлага зэрэг болно.

Ингэснээр “Багшлах II зэргийн эрх”-тэй болох бөгөөд ажлын шалгаруулалтанд орох эрхтэй болно. Мэргэжлээрээ 3 жил ажиллан 15 кредит цагийн ажлын байран дахь сургалтанд хамрагдсан багш нар “Багшлах I зэргийн эрх”-тэй болдог байна.

Шинээр ажилд орох багш нарт туршилтын хугацаа байхгүй боловч 2 долоо хоногийн хугацаанд ажилд орохын өмнөх дадлага хийдэг бөгөөд ажилд орсны дараа 6 сарын хугацаанд дадлагажуулж авдаг байна. Улсын сургуулийн багш нар ажилд орохын өмнө Нийслэлийн болон орон нутгийн боловсролын газраас зохион байгуулдаг ажилд тэнцэх шалгалт өгдөг байна. Дээрх боловсролын газрууд нь улсын сургуульд шаардлагатай байгаа багш нарыг шалгалтанд авсан оноогоор шалгаруулан ажилд авдаг байна. Харин хувийн сургуулийн хувьд багш нарыг өөрсдийн тогтоосон журмаар ажилд авдаг бөгөөд сүүлийн үед Засгийн газраас тавьж буй шаардлагын дагуу багш нараас шалгалт авч, үүнээсээ шалгаруулан ажилд авдаг журмыг хэрэгжүүлж эхэлж байна.

Багш нар ажилласан жил, ур чадвар, хийсэн судалгаа, шинжилгээний ажлууд, авсан үнэлгээ зэргээс хамааран Дэд эрхлэгч, Хичээлийн эрхлэгч зэрэг албан тушаалд дэвшин ажилладаг. Солонгос улсад багшийн мэргэжлийн нэр хүнд өндөр байдагтай холбоотой энэ нь маш өрсөлдөөнтэй байдаг байна. Багш нар ажиллах хугацаандаа ажлын үр дүнгээсээ хамааран оноо цуглуулдаг бөгөөд хөдөө орон нутагт болон тусгай сургуулиудад багшилсан хугацаандаа нэмэлт оноо авдаг байна.

Багшлах болон манлайлах өндөр ур чадвартай багш нарыг “Ахлах багш”-аар томилох бөгөөд эдгээр багш нар нь өөрийн ажиллаж буй сургууль, дүүргийн хэмжээнд бусад сургуулийн багш нарт өөрийн багшлах аргаас зааж зөвлөх үүрэгтэй. “Ахлах багш”-аар томилогдон ажиллахын тулд багш нар мэргэжлээрээ 10-15 жил ажилласан туршлагатай, “Багшлах I зэргийн эрх”-тэй байх шаардлагатай. Мужийн боловсролын газраас багш нарын дунд 3 үе шаттай шалгаруулалт явуулсны эцэст “Ахлах багш”-ийг томилно. Ахлах багш нарыг сар бүр үндсэн цалин дээр нь 150 ам доллараар нэмж цалинжуулна.

Тодорхой хугацаанд ажилласан бага сургуулийн багшийн жилийн дундаж цалин 52,699 ам доллар байгаа нь 41,701 ам доллар бүхий дундаж цалинтай Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын (ЭЗХХАБ) гишүүн орнуудтай харьцуулахад хамаагүй дээгүүр

а

<sup>115</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=39748&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39748&lang=ENG)

байна.

*БНСУ, АНУ, ЭЗХХАБ-ын гишүүн орнуудын бага сургуулийн багш нарын цалинг нэг хүнд ноогдох ДНБ-д харьцуулсан харьцаа (2015 оны байдлаар)*



БНСУ-д багш мэргэжлийн өөрчлөлтийн бодлогыг эргэн харж, нийгмийн янз бүрийн салбарынхны үзэл бодлыг тусгасан “Багш мэргэжлийг хөгжүүлэх олон талт төлөвлөгөө”-г боловсруулжээ. Уг төлөвлөгөөнд нэгдүгээрт, багшийг хөгжүүлэх нийгмийн уур амьсгал бүрдүүлэх, хоёрдугаарт, багшид хандах хандлага болон тэдний ажлын нөхцөл байдлыг дээшлүүлэх, гуравдугаарт, багшийн статусыг мэргэжилтэн болгож бэхжүүлэх үүднээс мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна. БНСУ-ын Засгийн газраас багш нарыг мэргэжлээр нь хөгжүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлдэг. Үүнд мэргэшлийн сургалт, ажлын байран дахь сургалт, тусгай сургалт (мэдээллийг тоон хэлбэрт оруулах, сургалтын хөтөлбөр боловсруулах) зэрэг орно. Ажлын байран дээрх сургалт нь доод тал нь 180 цаг буюу 30 хоног үргэлжлэх бөгөөд багшийн үйл ажиллагааг 100 оноогоор үнэлж, сургалтаа амжилттай дуусгасан багшид үнэмлэх олгоно. Энэ нь цаашлаад багш нарын албан тушаал ахих, цалин нэмэх зэрэгт нөлөө үзүүлнэ.<sup>116</sup>

### **Боловсролын тухай хууль**

#### **15 дугаар зүйл (Багш нарын байгууллага)**

1. Сургуулийн багш нар хамтран боловсролыг дэмжих, соёлыг түгээх талаар хүчин чармайлт гарган ажиллах хэрэгтэй. Багш нар нь Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны харьяа багш нарын эдийн засаг, нийгмийн байдлыг сайжруулах зорилго бүхий “Багш нарын байгууллага”-ыг байгуулан ажиллуулж болно.

a

<sup>116</sup> <http://ncee.org/what-we-do/center-on-international-education-benchmarking/top-performing-countries/south-korea-overview/south-korea-teacher-and-principal-quality/>  
<http://timssandpirls.bc.edu/timss2015/encyclopedia/countries/korea/teachers-teacher-education-and-professional-development/>

## **Боловсролын ажилтны тухай хууль**

### *13 дугаар зүйл (Тушаал дэвшүүлэх)*

Боловсролын ажилтныг дэвшүүлэн ажиллуулахад дараах зүйлсийг анхаарна. Тухайн ажилтныг ижил үүрэг хариуцлага хүлээсэн ажилтнуудын дотроос сургалтын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадвар зэргээр нь сонгон шалгаруулна.

Үүнийг Ерөнхийлөгчийн зарлигаар нарийвчлан тодорхойлсон.

### *29-4 дүгээр зүйл (Ахлах багшийг томилон ажиллуулах)*

1. Боловсролын сайдын шийдвэрээр ахлах багш нарыг томилно.
2. Ахлах багш нар томилогдсоноосоо хойш 4 жил тутам өөрийн ажлын амжилт, хүрсэн үр дүн, сургалтын үр дүн зэргээр дахин үнэлгээнд хамрагдана. Хэрэв үнэлгээний шалгуурыг хангаж чадахгүй тохиолдолд хүлээсэн үүрэг, сар бүрийн цалингийн нэмэгдэл зэргийг хязгаарлана. Үүнийг Ерөнхийлөгчийн зарлигаар нарийвчлан тодорхойлсон.
3. Ахлах багш нь ажиллах хугацаандаа хичээлийн эрхлэгч, дэд эрхлэгч, цэцэрлэгийн эрхлэгч зэрэг албыг давхар хашихыг хориглоно.

### *34 дүгээр зүйл (Цалин хөлс)*

1. Боловсролын төрийн албан хаагчид тохиромжтой цалин хөлс авах ёстой.
2. Боловсролын төрийн албан хаагчийн цалин, урамшууллыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Цалин урамшууллыг ажилтны ур чадвар, туршлага, үүрэг хариуцлагын хэм, хэмжээнээс хамаарч тогтооно.

### *36 дугаар зүйл (Өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарах)*

1. Боловсролын төрийн албан хаагч доод тал нь 20 жил ажилласны дараа тэтгэвэрт гарах наснаас өмнө өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарах боломжтой. Энэ тохиолдолд төсөвт багтаан тэтгэврийн тэтгэмж олгоно.

### *37 дугаар зүйл (Сургалтад хамрагдах боломж)*

Боловсролын төрийн албан хаагч нь сургалтын төвүүдээс зохион байгуулж байгаа сургалтанд тэгш эрхтэй оролцоно.

### *38 дугаар зүйл (Сургалтын зардал)*

1. Боловсролын төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрийгөө зогсолтгүй хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.
2. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагаас боловсролын төрийн албан хаагчдыг хөгжүүлэхэд анхаарч төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Энэ төлөвлөгөөнд сургалт зохион байгуулахыг дэмжих, зардлыг төлөх зэрэг багтана.

### *39 дүгээр зүйл (Сургалтын төвүүдийг үүсгэн байгуулах)*

1. Боловсролын төрийн албан хаагчдыг дахин сургах сургалтын төвүүд байгуулах нь зүйтэй.

## **6. БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ТУРШЛАГА**

Чех Улсад багшийн хөгжлийн асуудлыг “Сурган хүмүүжүүлэх ажилтны тухай” (Pedagogical



Staff and on the Amendment to Some Other Acts<sup>117</sup>) хуулиар зохицуулж байна. Тус хууль нь 2004 оны 9 дүгээр сарын 24-нд батлагдсан бөгөөд 5 бүлэг, 41 зүйлтэй. Энэхүү хуулиар багшийн мэргэжлийн тавигдах шаардлага, багшийн хөгжлийн шалгуур зэргийг зохицуулсан байдаг.

Хуульд зааснаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэргэшлийн тавигдах шаардлага нь анги бүрээс хамаарч өөр байна. Тухайлбал,

Бага сургуулийн багш нар (1-5 анги):

- багшийн мэргэжлийн их, дээд сургууль төгссөн;
- магистрын зэрэг эзэмшсэн байх;
- нийт 5 жилийн хугацаатай (бакалаврын зэрэг 2 жил, магистрийн зэрэг 2 жил багтаасан) хөтөлбөрт хамрагдсан байна;
- анхан шатны түвшинд бүх хичээлийг заах чадвартай байхаас гадна сонгосон сэдвээр мэргэшсэн байна.

Дунд (6-9 анги) болон ахлах анги (10-13 анги)-ийн багш нар

- заавал магистрын зэрэгтэй байх шаардлагатай ба хоёр хичээл заах чадвартай байх;
- Багш нарыг бэлтгэх ISCED (Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал) -ын 7-р түвшний сургалтанд хамрагдаж, улсын шалгалтанд тэнцэж, диплом хамгаалах ба нэмэгдэл, зэрэг авсан байна.

Мэргэшсэн багш нарт зориулсан албан ёсны зааварчилгааг зарим сургуулиуд индукцын хөтөлбөрөөр хангадаг.

2004 оны 563 дугаартай “Сурган хүмүүжүүлэх ажилтны тухай” хуульд зааснаар багшлах эрх бүхий ажилтнууд нь хичээлийн жилд 12 хүртэлх өдрийг мэргэжлийн хөгжилд ашиглах боломжтой байдаг. Мэргэжлийн хөгжлийг олон тооны байгууллага санал болгодог ба Боловсрол, залуучууд, спортын яам мэргэжлийн хөгжилд зориулагдсан боловсролын институт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.

Боловсролын сургуулийн захирал нь холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран төлөвлөгөө боловсруулан түүний дагуу боловсролын ажилтны мэргэжил дээшлүүлэх боломжийг олгодог.

2013-2014 онд Чехийн Боловсролын хяналтын байгууллагын шалгалтын дүнгээр; үндсэн багш нарын 74 хувь нь төрөл бүрийн сургалт, семинарт оролцсон бол үлдсэн 20 хувь нь ямар нэгэн мэргэжлийн сургалтад оролцоогүй байна гэж дүгнэгджээ.<sup>118</sup>

Хуулийн 2-р зүйлд “Сурган хүмүүжүүлэх ажилтан гэдэг нь хичээл заах чиг үүрэгтэй, тусгай боловсролын хэрэгцээ шаардлагыг хангах үйл ажиллагаа буюу сурган хүмүүжүүлэх тусгайлсан эрх зүйн зохицуулалтын дагуу боловсрол, сургалтын ажлыг хэрэгжүүлэхэд шууд нөлөөлдөг сурган хүмүүжүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хүн (цаашид "чиг үүргийг хэрэгжүүлэгч")-ийг хуулийн этгээд, төрийн албан хаагч бус эсвэл багшийн ажил эрхэлдэг ажилтан юм. Сурган хүмүүжүүлэх ажилтан нь нийгмийн халамжийн үйлчилгээг хангаж буй боловсролын чиг үүргийг гүйцэтгэнэ” гэж заажээ.

Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу сурган хүмүүжүүлэх ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а\_\_\_\_\_

<sup>117</sup> БНЧУ-ын Боловсрол, Залуучууд, Спортын тамирын яамны вэб сайт

<http://www.msmt.cz/dokumenty-3/act-no-563-2004-collection-of-law-on-pedagogical-staff-and>

<sup>118</sup> TIMSS&PIRLS <http://timssandpirls.bc.edu/timss2015/encyclopedia/countries/czech-republic/use-and-impact-of-timss/>

- а / багшийн ажил, боловсролын үүргийг гүйцэтгэх бүрэн чадвартай байх;
- б) эрүүгийн гэмт хэрэгт холбогдоогүй байх;
- в) эрүүл мэндийн шаардлагад нийцсэн байх;
- г) чех хэлтэй байх гэсэн шалгууруудыг хангасан байна.

Энэ хуулийн 6-р зүйлд: сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгийн багш нарын эзэмшсэн ур чадваруудын шалгуур үзүүлэлтэд дараах хөтөлбөрүүдийг эзэмшсэн байхыг шаарддаг. Үүнд:

- мэдлэг боловсрол дээшлүүлэхэд чиглэсэн шинжлэх ухааны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр;
- дээд боловсролын мэргэжлийн багш нарын хөтөлбөр;
- мэргэжлийн багш бэлтгэх замаар гуравдагч боловсрол, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх багш нарыг бэлтгэх сургуулийн суурь хөтөлбөр.

Боловсролын тусгай сургууль, цэцэрлэгийн багш нар мэргэжлийн тусгай ур чадварыг эзэмшсэн байх ёстой.

#### **Чех Улсын багш нарын үндсэн болон нэмэлт цалин хөлс олгох зохицуулалт**

Төрийн өмчийн сургуулиудын сургуулийн өмнөх, бага боловсрол, ерөнхий боловсролын дунд болон ахлах боловсролын багш нарын үндсэн цалингийн суурь хэмжээг багш нарын цалин хөлсний сүлжээний дундаж түвшингээс багагүй байхаар тогтооно.

Хувийн өмчийн сургуулиудын багш нарын үндсэн цалингийн хэмжээг Хөдөлмөрийн гэрээгээр тогтоох боловч Засгийн газраас тогтоосон цалин хөлсний доод хэмжээний түвшингээс бууруулахгүй байх баталгаагаар хангана.

#### **Төрийн өмчийн сургуулиудад бүтэн цагаар ажилладаг мэргэшсэн багш нарын цалингийн сүлжээ**

Нэрс	Үндсэн цалин				Дундаж цалин	
	Доод хэмжээ		Дээд хэмжээ			
	CZK	EUR	CZK	EUR	CZK	EUR
Сургуулийн өмнөх анги	196500	7203	300700	11023	275292	10092
Бага анги	252000	9238	332100	12174	324853	11909
Дунд анги	252000	9238	332100	12174	324440	11893
Ахлах анги	252000	9238	332100	12174	339726	12454

Жич: Багшийн мэргэжлээр 32 жил ажилласан багш цалингийн сүлжээний хамгийн өндөр түвшин (maximum)-д цалин хөлс авах боломжтой. Өмнө нь 27 жилээс дээш ажилласан багш цалингийн сүлжээний хамгийн өндөр зэрэглэлийн цалин авч байсан бол 2017 оноос эхлэн 32 жилээс дээш хугацаанд ажилласан багш нарт зориулан цалингийн сүлжээнд нэмэлт түвшинг тусгаж өгсөн байна.

#### **Багш нарт цалингийн нэмэгдэл олгох зохицуулалт**

2015/2016 оноос эхлэн төрийн байгууллагад ажиллагсад болон багш нарын цалин хөлсний шинэчлэл хийх хүрээнд цалингийн сүлжээнд өөрчлөлт оруулсан. Энэхүү шинэчлэлийн хүрээнд сургуулийн удирдах албан тушаалтан, боловсролын байгууллагын үндсэн болон туслах ажилтнуудын цалинг 3%-иар нэмэгдүүлсэн. Ингэхдээ боловсролын салбарт удаан жил ажилласан багш нарын цалин хөлсний шатлалыг нэмэгдүүлэх бодлого баримталсан.

Суралцагчдын сурлагын амжилтад үндэслэн багш нарт дараах нэмэгдлийг олгоно. Үүнд:

- Багшийн хувийн амжилтыг харгалзан цалингийн шатлал дотроо цалингийн сүлжээний дээд хэмжээнд хүртэл (50-100%) нэмэгдэл олгох ба ингэхдээ багш нарын цалингийн хувийн амжилтын урамшуулал жилийн цалингийн нийт хэмжээний 2,8%-иас хэтэрдэггүй байна.

*Нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд дараах нэмэгдлийг олгоно. Үүнд:*

- Манлайлах ур чадвартай, бусдыгаа хошуучлан ажилласан багш нарт тухайн цалингийн сүлжээний ангилал дотроо 5-40%-ийн нэмэгдэл;
- Машин, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэлтэй ажиллаж буй сурагчдын аюулгүй байдал, эрсдэлд хийсэн шалгалтын дүнгээр сар тутам CZK 400-1 000 крон;
- Анги удирдсаны нэмэгдэл сар бүр 400-1000 крон;
- Тусгай ур чадвар шаардсан ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн, сургуулийн үндсэн хөтөлбөрөөс гадна хамтарч ажиллах бусад хөтөлбөр, арга хэмжээнд оролцсон, бүтэн болон хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй тусгайлан ажилласан бол сар бүр CZK 1 000-2 000 крон тус тус олгодог.

*Тусгай хэрэгцээт боловсролын салбарт болон тусгай хэрэгцээт сурагчидтай ажилладаг багш нарт дараах нэмэгдлийг олгоно. Үүнд:*

- Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, анги, бүлгийн оюутан, сурагчидтай ажилладаг багш нарт сар бүр 600-2000 крон;
- Харилцан адилгүй насны сурагчидтай ажилладаг бол сар тутам CZK 600-2000 крон тус тус олгоно.


Мөн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцсон багш нарт тухайлсан нэмэгдэл олгоно.

*Илүү цагийн хөлсийг дараах зарчмаар олгоно. Үүнд:*

Багш нарын 7 хоногт ажиллах цагийн хэмжээг хууль болон Засгийн газрын журмаар тогтооно. (ЗГ-ын 75/2005 журам) Тогтоосон хэмжээнээс илүү цагаар ажилласан цагийг бүртгэж, багш тус бүрээр илүү цагийн тооцоог гаргах ба илүү цагийн хөлсийг тооцохдоо цагийн ажлын хөлсийг 2 дахин нэмэгдүүлж тооцно.

*Бусад нэмэгдэл*

Ажил олгогчоос багшийн жилийн ажлын үр дүнг харгалзан үндсэн цалингаас гадна үр дүнгийн урамшуулал олгож болно. Нэмэлт цалин олгох системийг Засгийн газар хариуцан тодорхойлох бөгөөд сургуулийн удирдлагын зүгээс багш нарын ажлын үр дүн, амжилтыг үнэлж нэмэлт цалин, бонус олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Ердийн сургуулийн тусгай хэрэгцээт боловсрол, сургалтын арга барил шаарддаг хүүхдүүдтэй ажилладаг багш нар хуулиар тусгайлсан нэмэгдэл авах эрх зүйн зохицуулалт байхгүй тул сургуулийн захиргааны зүгээс тэдгээр багш нарт тусгайлсан нэмэгдэл олгох баталгаа гаргаж өгөх ёстой.



# МОДЕЛЬ НОВОЙ СИСТЕМЫ ОПЛАТЫ ТРУДА УЧИТЕЛЕЙ

1

## «БАЗОВЫЙ ОКЛАД+»

УСТАНОВЛИВАЕТСЯ МИНИМАЛЬНЫЙ «БАЗОВЫЙ ОКЛАД» ЗА 18 УРОКОВ  
В НЕДЕЛЮ, А ВСЕ ОСОБЕННОСТИ ТРУДА КОНКРЕТНОГО УЧИТЕЛЯ  
УЧИТЫВАЮТСЯ С ПОМОЩЬЮ ПОВЫШАЮЩИХ КОЭФФИЦИЕНТОВ

### ФОРМИРОВАНИЕ ОКЛАДА УЧИТЕЛЯ

$$\text{ОКЛАД УЧИТЕЛЯ} = O_6 * (1 + K_1 + K_2 + K_3 + K_4 + K_5)$$

$O_6$  БАЗОВЫЙ ОКЛАД

$K_{1-5}$  КОЭФФИЦИЕНТЫ

### КОЭФФИЦИЕНТЫ

КЛАССНОЕ РУКОВОДСТВО  
ЗАВЕДОВАНИЕ КАБИНЕТОМ  
ПРОВЕРКА ТЕТРАДЕЙ  
ВНЕУРОЧНАЯ РАБОТА

КАТЕГОРИЯ  
КОЛИЧЕСТВО УЧЕНИКОВ  
БОЛЬШАЯ НАГРУЗКА

### ПРИМЕР ФОРМИРОВАНИЯ ЗАРПЛАТЫ УЧИТЕЛЯ

УЧИТЕЛЬ ФИЗИКИ, ВЫСШАЯ КАТЕГОРИЯ,  
НАГРУЗКА 18 ЧАСОВ В НЕДЕЛЮ

СТИМУЛИРУЮЩИЕ  
ВЫПЛАТЫ

1 УЧЕНИК-ПОБЕДИТЕЛЬ ГОРОДСКОЙ ОЛИМПИАДЫ 10 БАЛЛОВ	180 БАЛЛОВ
1 УЧЕНИК-ПРИЗЕР ОБЛАСТНОЙ ОЛИМПИАДЫ 30 БАЛЛОВ	1 БАЛЛ = 30 РУБ.
ОТСУТСТВИЕ ЖАЛОБ РОДИТЕЛЕЙ, ОТСУТСТВИЕ ДЕТСКИХ ПРАВОНАРУШЕНИЙ 50 БАЛЛОВ	5400 РУБ.
ВЫСОКИЕ РЕЗУЛЬТАТЫ ЕГЭ 90 БАЛЛОВ	

СПЕЦИАЛЬНЫЕ  
ВЫПЛАТЫ

УСЛОВИЯ ТРУДА, ОТКЛОНЯЮЩИЕСЯ ОТ НОРМЫ 13%	580 РУБ.
КАТЕГОРИЯ 75%	3370 РУБ.
КЛАССНОЕ РУКОВОДСТВО 20%	900 РУБ.
ПРОВЕРКА ТЕТРАДЕЙ 10%	450 РУБ.
ЗАВЕДОВАНИЕ КАБИНЕТОМ 15%	675 РУБ.
РАБОТА С РОДИТЕЛЯМИ 10%	450 РУБ.
РАЗРАБОТКА ДИДАКТИЧЕСКИХ МАТЕРИАЛОВ 15%	675 РУБ.

ОКЛАД

18 ЧАСОВ	4500 РУБ.
ИТОГО:	17000 РУБ.

### РЕГИОНЫ С МОДЕЛЬЮ «БАЗОВЫЙ ОКЛАД+»

47 РЕГИОНОВ

\*СРЕДНЕМЕСЯЧНАЯ ЗАРПЛАТА УЧИТЕЛЕЙ,  
ТЫС.РУБ. (СЕНТЯБРЬ-НОВЯБРЬ 2011 Г.)

КАМЧАТСКИЙ КРАЙ (37,8)\*  
МАГАДАНСКАЯ ОБЛАСТЬ (29,7)  
ПРИМОРСКИЙ КРАЙ (19,0)  
САХАЛИНСКАЯ ОБЛАСТЬ (38,6)  
ХАБАРОВСКИЙ КРАЙ (25,5)  
КИРОВСКАЯ ОБЛАСТЬ (13,4)  
ОРЕНБУРГСКАЯ ОБЛАСТЬ (14,0)  
ПЕНЗЕНСКАЯ ОБЛАСТЬ (16,7)  
РЕСПУБЛИКА МАРИЙ ЭЛ (12,9)  
УЛЬЯНОВСКАЯ ОБЛАСТЬ (13,4)  
АРХАНГЕЛЬСКАЯ ОБЛАСТЬ (21,6)  
ЛЕНИНГРАДСКАЯ ОБЛАСТЬ (23,2)  
МУРМАНСКАЯ ОБЛАСТЬ (32,2)

НЕНЕЦКИЙ АВТОНОМНЫЙ  
ОКРУГ (49,6)  
НОВГОРОДСКАЯ ОБЛАСТЬ (20,0)  
ПСКОВСКАЯ ОБЛАСТЬ (14,7)  
РЕСПУБЛИКА КОМИ (24,8)  
САНКТ-ПЕТЕРБУРГ (27,6)  
КАРЧАЕВО-ЧЕРКЕССКАЯ  
РЕСПУБЛИКА (10,4)  
РЕСПУБЛИКА ДАГЕСТАН (10,6)  
РЕСПУБЛИКА ИНГУШТИЯ (12,8)  
СТАВРОПОЛЬСКИЙ КРАЙ (14,3)  
ЧЕЧЕНСКАЯ РЕСПУБЛИКА (11,1)  
ЗАБАЙКАЛЬСКИЙ КРАЙ (18,7)

ИРКУТСКАЯ ОБЛАСТЬ (19,0)  
КРАСНОЯРСКИЙ КРАЙ (22,8)  
ОМСКАЯ ОБЛАСТЬ (17,4)  
РЕСПУБЛИКА ТЫВА (20,0)  
РЕСПУБЛИКА ХАКАСИЯ (19,3)  
ТОМСКАЯ ОБЛАСТЬ (21,5)  
КУРГАНСКАЯ ОБЛАСТЬ (12,4)  
ХАНТЫ-МАНСКИЙ АВТОНОМНЫЙ  
ОКРУГ - ЮГРА (43,1)  
ЯМАЛО-НЕНЕЦКИЙ АВТОНОМНЫЙ  
ОКРУГ (49,6)  
ВЛАДИМИРСКАЯ ОБЛАСТЬ (15,5)  
КОСТРОМСКАЯ ОБЛАСТЬ (13,8)

КУРСКАЯ ОБЛАСТЬ (14,5)  
ЛИПЕЦКАЯ ОБЛАСТЬ (16,7)  
МОСКОВСКАЯ ОБЛАСТЬ (27,3)  
ОРЛОВСКАЯ ОБЛАСТЬ (13,7)  
РЯЗАНСКАЯ ОБЛАСТЬ (15,1)  
СМОЛЕНСКАЯ ОБЛАСТЬ (13,1)  
ТВЕРСКАЯ ОБЛАСТЬ (16,0)  
ТУЛЬСКАЯ ОБЛАСТЬ (16,7)  
ЯРОСЛАВСКАЯ ОБЛАСТЬ (15,2)  
АСТРАХАНСКАЯ ОБЛАСТЬ (14,4)  
ВОЛОГДСКАЯ ОБЛАСТЬ (16,2)  
РОСТОВСКАЯ ОБЛАСТЬ (16,2)



# МОДЕЛЬ НОВОЙ СИСТЕМЫ ОПЛАТЫ ТРУДА УЧИТЕЛЕЙ

2

## «ВСЁ ВКЛЮЧЕНО»

КАЖДОМУ УЧИТЕЛЮ УСТАНАВЛИВАЕТСЯ СВОЙ ДОЛЖНОСТНОЙ ОКЛАД,  
ВКЛЮЧАЮЩИЙ ОПЛАТУ ЗА ВСЕ ВИДЫ УЧЕБНОЙ И ВНЕУЧЕБНОЙ РАБОТЫ  
С УЧЕТОМ ОСОБЕННОСТЕЙ ЕГО ТРУДА

### ФОРМИРОВАНИЕ ОКЛАДА УЧИТЕЛЯ

$$\text{ОКЛАД УЧИТЕЛЯ} = Ч_1 + Ч_2 + Ч_3$$

$Ч_{1-3}$  ЧАСЫ ЗАНЯТОСТИ

### ВИДЫ ЗАНЯТОСТИ

КЛАССНОЕ РУКОВОДСТВО  
ЗАВЕДОВАНИЕ КАБИНЕТОМ  
ПРОВЕРКА ТЕТРАДЕЙ  
ВНЕУРОЧНАЯ РАБОТА

КАТЕГОРИЯ  
КОЛИЧЕСТВО УЧЕНИКОВ  
УСЛОВИЯ ТРУДА,  
ОТКЛОНЯЮЩИЕСЯ ОТ НОРМЫ

### ПРИМЕР ФОРМИРОВАНИЯ ЗАРПЛАТЫ УЧИТЕЛЯ

УЧИТЕЛЬ ФИЗИКИ, ВЫСШАЯ КАТЕГОРИЯ,  
НАГРУЗКА 18 ЧАСОВ В НЕДЕЛЮ

СТИМУЛИРУЮЩИЕ  
ВЫПЛАТЫ

1 УЧЕНИК-ПОБЕДИТЕЛЬ ГОРОДСКОЙ ОЛИМПИАДЫ 10 БАЛЛОВ	180 БАЛЛОВ
1 УЧЕНИК-ПРИЗЕР ОБЛАСТНОЙ ОЛИМПИАДЫ 30 БАЛЛОВ	1 БАЛЛ = 30 РУБ.
ОТСУТСТВИЕ ЖАЛОБ РОДИТЕЛЕЙ, ОТСУТСТВИЕ ДЕТСКИХ ПРАВОНАРУШЕНИЙ 50 БАЛЛОВ	5400
ВЫСОКИЕ РЕЗУЛЬТАТЫ ЕГЭ 90 БАЛЛОВ	РУБ.

ОКЛАД

КЛАССНОЕ РУКОВОДСТВО 8 ЧАСОВ	1500 РУБ.
ПРОВЕРКА ТЕТРАДЕЙ 3 ЧАСА	500 РУБ.
ЗАВЕДОВАНИЕ КАБИНЕТОМ 1 ЧАС	750 РУБ.
РАБОТА С РОДИТЕЛЯМИ 2 ЧАСА	1500 РУБ.
РАЗРАБОТКА МАТЕРИАЛОВ И ВНЕУРОЧНАЯ РАБОТА 4 ЧАСА	750 РУБ.
КАТЕГОРИЯ	1650 РУБ.
УСЛОВИЯ ТРУДА, ОТКЛОНЯЮЩИЕСЯ ОТ НОРМЫ	450 РУБ.
18 УЧЕБНЫХ ЧАСОВ	4500 РУБ.

ИТОГО:	17000
	РУБ.

### РЕГИОНЫ С МОДЕЛЮ «ВСЁ ВКЛЮЧЕНО»

11 РЕГИОНОВ

\*СРЕДНЕМЕСЯЧНАЯ ЗАРПЛАТА УЧИТЕЛЕЙ,  
ТЫС.РУБ. (СЕНТЯБРЬ-НОЯБРЬ 2011 Г.)

ЧУКОТСКИЙ АВТОНОМНЫЙ ОКРУГ (51,6)\*  
НИЖЕГОРОДСКАЯ ОБЛАСТЬ (17,0)  
РЕСПУБЛИКА БАШКОРТОСТАН (16,5)  
РЕСПУБЛИКА ТАТАРСТАН (17,3)  
УДМУРТСКАЯ РЕСПУБЛИКА (13,4)  
ВОЛОГОДСКАЯ ОБЛАСТЬ (16,2)

КЕМЕРОВСКАЯ ОБЛАСТЬ (19,7)  
ЧЕЛЯБИНСКАЯ ОБЛАСТЬ (15,9)  
ТАМБОВСКАЯ ОБЛАСТЬ (13,3)  
РЕСПУБЛИКА КАЛМЫКИЯ (12,0)  
ЧУВАШСКАЯ РЕСПУБЛИКА (14,7)

# МОДЕЛЬ НОВОЙ СИСТЕМЫ ОПЛАТЫ ТРУДА УЧИТЕЛЕЙ

3

## «УЧЕНИКО-ЧАС»

ЗАРПЛАТА РАССЧИТЫВАЕТСЯ В ШКОЛЕ, ИСХОДЯ ИЗ ОБЪЕМА ПОСТУПИВШИХ  
ПО НОРМАТИВУ СРЕДСТВ, И ПОЗВОЛЯЕТ НАИБОЛЕЕ ПРОЗРАЧНО  
И СПРАВЕДЛИВО РАСПРЕДЕЛИТЬ ФОНД ОПЛАТЫ ТРУДА МЕЖДУ УЧИТЕЛЯМИ

### ФОРМИРОВАНИЕ ОКЛАДА УЧИТЕЛЯ

$$\text{ОКЛАД УЧИТЕЛЯ} = \text{Р} * \text{Ч} * \text{К} * \text{А} + \text{Д}$$

<b>Р</b>	СТОИМОСТЬ УЧЕНИКО-ЧАСА	<b>Ч</b>	КОЛИЧЕСТВО УЧАЩИХСЯ
<b>Ч</b>	ЧАСЫ ЗАНЯТОСТИ ПО ПРЕДМЕТУ	<b>А</b>	КОЭФФИЦИЕНТ ЗА КАТЕГОРИЮ
<b>К</b>	КОЭФФИЦИЕНТ ЗА СЛОЖНОСТЬ ПРЕДМЕТА	<b>Д</b>	НЕАУДИТОРНАЯ ЗАНЯТОСТЬ

### ПРИМЕР ФОРМИРОВАНИЯ ЗАРПЛАТЫ УЧИТЕЛЯ

УЧИТЕЛЬ ФИЗИКИ, ВЫСШАЯ КАТЕГОРИЯ,  
НАГРУЗКА 18 ЧАСОВ В НЕДЕЛЮ

СТИМУЛИРУЮЩИЕ ВЫПЛАТЫ	1 УЧЕНИК-ПОБЕДИТЕЛЬ ГОРОДСКОЙ ОЛИМПИАДЫ 10 БАЛЛОВ 1 УЧЕНИК-ПРИЗЕР ОБЛАСТНОЙ ОЛИМПИАДЫ 30 БАЛЛОВ ОТСУТСТВИЕ ЖАЛОБ РОДИТЕЛЕЙ, ОТСУТСТВИЕ ДЕТСКИХ ПРАВОНАРУШЕНИЙ 50 БАЛЛОВ ВЫСОКИЕ РЕЗУЛЬТАТЫ ЕГЭ 90 БАЛЛОВ	180 БАЛЛОВ 1 БАЛЛ = 30 РУБ. <b>5400</b> РУБ.
	УСЛОВИЯ ТРУДА, ОТКЛОНЯЮЩИЕСЯ ОТ НОРМЫ 13%	<b>702</b> РУБ.
КОМПЕНСАЦИОННЫЕ ВЫПЛАТЫ	НЕАУДИТОРНАЯ ЗАНЯТОСТЬ (К=1,36) КАТЕГОРИЯ (К=1,25) ПРИОРИТЕТНОСТЬ ПРЕДМЕТА (К=1,4) КОЛИЧЕСТВО ЧАСОВ ПО ПРЕДМЕТУ 18 75 УЧЕНИКОВ УЧЕНИКО-ЧАС 3 РУБ. 1800 УЧЕНИКО-ЧАСОВ	1988 РУБ. 1350 РУБ. 2160 РУБ. <b>5400</b> РУБ.
	ОКЛАД	<b>17000</b> РУБ.
ИТОГО:		<b>17000</b> РУБ.

### РЕГИОНЫ С МОДЕЛЮ «УЧЕНИКО-ЧАС»

25 РЕГИОНОВ

\*СРЕДНЕМЕСЯЧНАЯ ЗАРПЛАТА УЧИТЕЛЕЙ,  
ТЫС.РУБ. (СЕНТЯБРЬ-НОЯБРЬ 2011 Г.)

АМУРСКАЯ ОБЛАСТЬ (20,7)\*  
ЕВРЕЙСКАЯ АВТОНОМНАЯ  
ОБЛАСТЬ (20,8)  
РЕСПУБЛИКА САХА (ЯКУТИЯ) (30,1)  
ПЕРМСКИЙ КРАЙ (17,5)  
САМАРСКАЯ ОБЛАСТЬ (17,6)  
САРАТОВСКАЯ ОБЛАСТЬ (16,6)

КАЛИНИНГРАДСКАЯ  
ОБЛАСТЬ (19,0)  
РЕСПУБЛИКА НАРЯНИЯ (19,2)  
КАБАРДИНО-БАЛКАРСКАЯ  
РЕСПУБЛИКА (13,5)  
РЕСПУБЛИКА СЕВЕРНАЯ  
ОСЕТИЯ-АЛАНИЯ (12,8)

АЛТАЙСКИЙ КРАЙ (14,5)  
РЕСПУБЛИКА АЛТАЙ (14,6)  
РЕСПУБЛИКА БУРЯТИЯ (18,4)  
СВЕРДЛОВСКАЯ ОБЛАСТЬ (24,0)  
ТЮМЕНСКАЯ ОБЛАСТЬ (19,9)  
БЕЛГОРОДСКАЯ ОБЛАСТЬ (18,1)  
БРЯНСКАЯ ОБЛАСТЬ (11,5)

ВОРОНЕЖСКАЯ ОБЛАСТЬ (14,9)  
ИВАНОВСКАЯ ОБЛАСТЬ (15,1)  
КАЛУЖСКАЯ ОБЛАСТЬ (22,4)  
МОСКВА (45,9)  
НОВОСИБИРСКАЯ ОБЛАСТЬ (19,1)  
КРАСНОДАРСКИЙ КРАЙ (18,1)  
РЕСПУБЛИКА АДЫГЕЯ (12,9)  
РЕСПУБЛИКА МОРДОВИЯ (12,0)



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.openclass.ru/node/270034>
- <http://www.kpmo.ru/kpmo/info/nsotnormbaza.html>
- [www.parliament.am](http://www.parliament.am)
- TIMSS&PIRLS <http://timssandpirls.bc.edu/timss2015/encyclopedia/countries/czech-republic/use-and-impact-of-timss/>
- Teachers Law of the People's Republic of China  
<https://www.chinaeducer.com/en/cedu/tlc.php>
- <http://ncee.org/what-we-do/center-on-international-education-benchmarking/top-performing-countries/south-korea-overview/south-korea-teacher-and-principal-quality/>
- БНЧУ-ын Боловсрол, Залуучууд, Спортын тамирын яамны вэб сайт  
<http://www.msmt.cz/dokumenty-3/act-no-563-2004-collection-of-law-on-pedagogical-staff-and>
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=39748&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39748&lang=ENG)
- Philippine Teachers Professionalization Act of 1994  
[http://pcw.gov.ph/sites/default/files/documents/laws/republic\\_act\\_7836.pdf](http://pcw.gov.ph/sites/default/files/documents/laws/republic_act_7836.pdf)
- Act of 26 January 1982, Teacher's charter <https://www.global-regulation.com/translation/poland/2986066/act-of-26-january-1982%252c-teachers-card.html>

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЭМЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЖИЛТНЫ НЭР ТӨРД ХАЛДАХ АСУУДЛЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЭРХ  
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛДЭГ АРГА ХЭМЖЭЭ**

Г.Алтан-Оч (Ph.D),  
Ц.Болормаа, Р.Оргилмаа

**НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**1. Нэр төрийн халдашгүй эрх**

Монгол Улсын хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нэр төр, алдар хүндийн халдашгүй байдал гэж аль алиныг нь нэрлэн зааж, хамгаалалтад авсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт тунхагласан халдашгүй эрхийн хүрээнд нэр төрийн халдашгүй байдлыг нэрлэн заасан бөгөөд Иргэний хуулиар илүү өргөн хүрээнд зохицуулсан байдаг.

Жам ёсны эрхийн онолын үүднээс хүний нэр төрийн халдашгүй эрх гэдэг нь хүн бүр ямар ч нөхцөл байдалд, элдэв ялгаваргүйгээр өөртэй нь бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн хүнлэг ёсоор хандах мөн чанарыг агуулж байдаг<sup>119</sup>.

Нэр төр, алдар хүнд нь иргэний эрх зүй болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн судлагдахуун болохын хувьд Иргэний хуулийн 20, 21 дүгээр зүйлд “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах” тухай заасан. Энэ зүйлээр:

- иргэний нэр;
- нэр төр;
- алдар хүнд;
- ажил хэргийн нэр хүнд гэх 4 тусдаа ойлголтыг хуулиар хамгаалсан.

Эдгээр ойлголтууд нь өөр хоорондоо нягт уялдаатай боловч бие даасан агуулгатай байна. Нэр төр, алдар хүнд нь иргэнд хамааралтай байдаг бол ажил хэргийн нэр хүнд нь иргэн, хуулийн этгээдийн аль алинд хамааралтай ойлголт.

**Иргэний нэр:** Иргэн өөрийн нэртэй байх явдал нь иргэний салшгүй эрх юм. Нэр гэдэг нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан, хүн төрснөөр түүнийг бодьгалжуулж буй нэгэн төрөл элемент юм. Иргэн нэртэй байхыг иргэний хуулиар хүлээн зөвшөөрч байгаа нь түүнийг эрх зүйн харилцаанд оролцох нөхцөлийг хангадаг<sup>120</sup>. Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн иргэний өөрийн нэрээр олж авсан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаврыг бий болгодог тул хуулиар хамгаална.

**Нэр төр:** нэр төр нь иргэний зан суртахуун, ёс зүй, ажил үйлс, мэргэжлийн шинжийн талаарх эерэг үнэлгээ юм.

**Алдар хүнд:** Алдар хүнд нь нэр төртэй салшгүй холбоотой ойлголт юм. Алдар хүнд нь тухайн иргэнд нийгэм, найз нөхөд, хамт олон, бусад харилцагч, түншлэгчээс өгч байгаа үнэлгээнд үндэслэсэн тухайн иргэний өөрийнх нь хувийн үнэлэмж юм.

**Ажил хэргийн нэр хүнд:** Энэ нь нийгэм-эдийн засгийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хамааралтай ойлголт бөгөөд тухайн этгээд ажил мэргэжлийн болон албан тушаалын үүрэг, гэрээгээр хүлээсэн үүрэг болон бусад үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас

а

<sup>119</sup> Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 93 дэх тал

<sup>120</sup> ХЗДХЯ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2005 он. 72 дахь тал.

шалтгаалан үүсэх үнэлэмж юм. Хувь хүн болон хуулийн этгээд нь эдгээр үүрэгтээ шударга хандаж, түүнийгээ хэрэгжүүлж байвал ажил хэргийн нэр хүнд тогтвортой байдаг.

Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт:

- бодит байдалд нийцэхгүй мэдээлэл тараах;
- ийм мэдээллийг өөр хэн нэгэн этгээдэд дамжуулан мэдээлсэн байхыг ойлгоно.

Ийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан гэж үзэхгүй бөгөөд уг мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр, мөн тухайн иргэний ажлын байран дээр тараасан, ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотой буюу амаар өөр этгээдэд хүргэсэн байхыг ойлгоно.

Түүнчлэн бодит байдалд нийцсэн, үнэн мэдээлэл боловч хувь хүний нууцад хамаарах мэдээллийг иргэний өөрийн зөвшөөрөлгүй нийтэд тараасан бол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзнэ.

## **2. Эмчийн ёс зүй болон тусгай зөвшөөрөл**

### **2.1. Гиппократын болон Женевийн тангараг**

Гиппократын тангараг<sup>121</sup> нь эртний Грекийн эмч Косын Гиппократэс (МЭӨ 460-370 он)-ийн нэрээр нэрлэгдсэн бөгөөд грек хэлээр бичигдсэн Эмчийн тангараг буюу эмчийн ёс зүйг албан хэллэгт буулгасан анхны бичгийн өв билээ. Уг тангарагийн зохиогчийн эрх тодорхой бус. Анх удаа 1 дүгээр зуунд латин хэлээр хэвлэгдсэн байдаг.

Уг тангаргийг уламжлалт хэлбэрээр нь өнөөдөр эмч нар хэрэглэдэггүй боловч Дэлхийн эмч нарын холбооны Женевийн тунхаг мэтийн бусад орчин цагийн тангарагийн бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Ёс заншил, өвчтөнд хохирол үл учруулах, дуугүй байх үүрэг хүлээх, өвчтөнтэй бэлгийн ажилллагаанд орохыг хориглох г.м. өнөөдөр ч хэвээр мөрдөгдөж байгаа ёс зүйн олон элементийг агуулдаг. Зарим хэсэг нь өнөөгийн нөхцөл байдалд үл зохицох болсон тул өөрчлөгдсөн байна. Жишээлбэл, давсагны чулуу авах мэс засал (тухайн үед мэс ажилбар эмчийн ажилд тооцогддоггүй байж), жирэмслэлтийг зогсоох, идэвхтэй үхлийн тусламж зэргийг Гиппократын тангарагт хатуу хориглосон байжээ.

Герман Улсад Гиппократын тангараг болон Женевийн тангарагийн аль алиныг албан журмаар мөрддөггүй боловч ёс суртахууны чиг баримжааны хүрээнд ёс зүйн хэм, хэмжээний нотолгоо болгон ашигладаг.

Женевийн тунхаг<sup>122</sup> буюу Женевийн тангарагийг 1948 оны 9 дүгээр сард Швейцарь Улсын Женев хотноо хуралдсан Дэлхийн эмч нарын холбоо (ДЭНХ)-ны II ерөнхий чуулганаас баталсан юм. Уг тунхаг нь Гиппократын тангарагийн цаг үедээ нийцсэн, шашны агуулгаас ангид хувилбар бөгөөд олон удаа (1968, 1983, 1994, 2005, 2006 болон 2017 онд) засагдсан байдаг. Германы эмчийн мэргэшлийн дүрэмд уг тунхагийг багтааж, удиртгал хэсэгт нь оруулсан байдаг.

“Хүн өөрөө надаас гуйсан ч гэсэн би хэнд ч үхэлд хүргэх хор өгөхгүй” гэсэн Гиппократын тангарагт байдаг үг бол дэлхий даяар эмчийн ёс суртахууны үндсэн дүрэм болж, эмчийн ажилбарын үзэл санааны дээд оргилыг илэрхийлдэг<sup>123</sup>. Энэхүү амьдралыг хамгаалах ямар ч

а

<sup>121</sup> Eid des Hippokrates-германаар [https://de.wikipedia.org/wiki/Eid\\_des\\_Hippokrates](https://de.wikipedia.org/wiki/Eid_des_Hippokrates)

<sup>122</sup> Genfer Deklaration des Weltärztebundes-германаар [https://de.wikipedia.org/wiki/Genfer\\_Deklaration\\_des\\_Welt%C3%A4rztebundes](https://de.wikipedia.org/wiki/Genfer_Deklaration_des_Welt%C3%A4rztebundes)

<sup>123</sup> Австрийн Эмчийн Холбооны ерөнхийлөгч Артур Векселбергийн байр суурь, “Эмчийн сонин”, Австри-Standpunkt-Präs. Artur Wechselberger-германаар [www.aerztezeitung.at/archiv/oeaez-2014/oeaez-20-25102014/standpunkt-praes-artur-wechselberger-hippokratischer-eid-menschenrechte-sterbebegleitung.html](http://www.aerztezeitung.at/archiv/oeaez-2014/oeaez-20-25102014/standpunkt-praes-artur-wechselberger-hippokratischer-eid-menschenrechte-sterbebegleitung.html)

болзолгүй, гагцхүү үүрэг хариуцлага нь мэргэжлийн дүрэм болон хэдэн мянган жил болжээ. Гэвч амьдрал болон эрүүл мэндийг хамгаалахаас гадна хүсэл зоригийн эрх чөлөө болон зөв ажилбар зэрэг бусад ёс суртахууны суурь үнэ цэнийг баримтлан эмч хүн шийдвэрээ гаргадаг. Тэгвэл 1981 онд ДЭНХ-ны баталсан Лисабоны тунхагт өвчтөний холбогдох эрхүүдийг тусгасан байдаг. Түүнд өвчтөний хүсэл зоригийн эрх чөлөө болон хувь хүнд хамаарах шийдвэрийг өөрөө бие даан гаргах, цаашилбал ихэмсэг, нэр төртэйгээр<sup>124</sup> үхэх эрх багтсан байдаг. Өвчтөнд мэргэжлийн асаргаа, сувилгаа үзүүлэх болон түүний зовлон, шаналалыг намдаах үүргийн дагуу эмчийн гаргасан шийдвэрийн хүрээнд түүний санал болгосон оношилгоо, эмчилгээг өвчтөн зөвшөөрч эсхүл татгалзаж болно. Харин үхэлд хүргэх аливаа эрүүл мэндийн арга хэмжээ нь өвчтөний эрхэд үл хамаарна.

Европын Хүний эрхийн Дээд шүүхийн тогтоосноор, үхэх эрх нь өөрийгөө тодорхойлох эрхэд багтах хэдий ч амиа хорлох эрхээс ондоо юм. Хэдийгээр тухайн хүн өөрийгөө тодорхойлох эрхийн дагуу амьдруулах арга хэмжээнээс татгалзаж болох ч хорвоогоос одуулах арга хэмжээг дэмж гэсэн үг биш. Хүний эрхийн конвенцийн 2 дугаар зүйлд заасан амьд явах эрхийн дагуу эмч нь тухайн өвчтөнийг асрах, сувилах, өвчтөний зовлон, шаналалыг намдаах, түүнд тусламж, дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ. Уг конвенцийн 3 дугаар зүйлд тусгасан хүний ёсноос гажууд эсхүл нэр төр гутаан доромжилсон үйлдлээс хамгаалах эрхийн дагуу эмч нь энэхүү үндсэн зарчмыг баримтлан ашиг тус үл өгөх эсхүл учирч болох эрсдэл болон хүлээгдэж буй үр дагаварт үл хамаарах эмчилгээ хийж болохгүй. Европын зөвлөлийн аргачлалд заасан амьдралыг төгсгөх шийдвэр гаргахыг тодорхойлсоноор, эмч нь өвчтөнд харьцангуй болон нөхцөл байдалд тохирсон эмчилгээний арга хэмжээг сонговол зохино.

## **2.2. Анагаах мэргэшлийн зөвшөөрлийн бичиг (апробаци)<sup>125</sup>**

ХБНГУ-д хүний их эмч, шүдний эмч, сэтгэцийн эмч, сэтгэц мэдрэл засалч, хүүхэд-залуусын сэтгэц мэдрэл засалч, эмийн санч, амьтны (малын) эмчийн албыг улсаас тусгай зөвшөөрөл авсаны үндсэн дээр эрхлэх бөгөөд тухайн чиглэлээр мэргэжсэн, бие даан хариуцлага хүлээх чадамжтай байх шаардлага тавигддаг. Мэргэжлийн шаардлагыг хангаж, тусгай зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн мэргэжлийн ажлыг гүйцэтгэх эрхтэй болдог. Апробацийн холбогдох хуулийг (Холбооны эмчийн мэргэшлийн дүрэм, Шүд анагаах ухааныг хаших тухай хууль, Сэтгэц мэдрэлийн засалчийн тухай хууль, Холбооны эмийн санчийн мэргэшлийн дүрэм, Холбооны малын эмчийн мэргэшлийн дүрэм) үндэслэн Холбооны Улсын Эрүүл мэндийн Яам олгодог.

### **ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **Эрүүл мэндийн салбарын эмч ажилтны нэр төрд халдах асуудлаарх олон улсын хууль эрх зүйн зохицуулалтын нийтлэг жишиг**

Эмч, эмнэлгийн ажилтны алдаа дутагдлын талаар хуулийн байгууллага шалгаж гэм буруутай нь тогтоогдоогүй байхад хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдахтай холбоотой асуудлаар олон улсад тусгайлан гаргасан, дагнасан хууль байхгүй байна. Иймд дээрх асуудлыг ихэвчлэн хүний нэр төрийг гутаах, хүнийг гүтгэх, доромжлох, гүжирдэх зэрэг гэмт үйлдэлд хамааруулан авч үздэг байна.

Энэ талаар ХБНГУ, Азербайжан, Польш, БНХАУ-ын туршлагыг УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын 2016 оны 11 дүгээр сард ирүүлсэн хүсэлтийн дагуу Г.Алтан-Оч, И.Жаргал-заяабямба нарын хийж гүйцэтгэсэн “Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, бусад орнуудын туршлага” сэдэвт СТ-17/201 тоот судалгаанаас дэлгэрүүлэн үзнэ үү.

а\_\_\_\_\_

<sup>124</sup> Würde-германаар

<sup>125</sup> Approbation (Heilberufe)-германаар [https://de.wikipedia.org/wiki/Approbation\\_\(Heilberufe\)](https://de.wikipedia.org/wiki/Approbation_(Heilberufe))

Судалгаанаас үзэхэд, гадаадын улс орнуудад эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдах асуудлыг ихэвчлэн Эрүүгийн хууль, Иргэний хууль, Хүний нэр төрд халдахын эсрэг хууль болон Хэвлэл, мэдээллийн тухай хуулиар зохицуулдаг байна. Тухайлбал, Испани, Итали, Норвеги, Польш, Финланд, Филиппин зэрэг орнуудад хүний нэр төрд халдах асуудлыг Эрүүгийн хуулиараа зохицуулж байгаа бол Беларусь, Болгар, Орос, Япон зэрэг улсуудад энэ асуудлыг Эрүүгийн хуулиас гадна Иргэний хуулиар давхар зохицуулдаг байна.

Харин Израил, Их Британи, Сингапур, Шинэ Зеланд зэрэг улсад “Хүний нэр төрд халдахын эсрэг” тусгайлсан хууль буюу “Defamation Act”-ийг мөрддөг байна. Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд цахим ертөнц дэх мэдээллийн сүлжээний хэрэглээ эрс өссөнтэй холбоотойгоор зарим улс оронд энэ төрлийн мэдээллийн эх сурвалжийг хэрхэн ашиглах талаар хуульчилсан байна. Тухайлбал, Индонез, Энэтхэг, Тайланд зэрэг улсуудад цахим сүлжээ, түүний хэрэглээг хэрхэн зохицуулах бие даасан хуулиуд баталсан бөгөөд тус хуулиудад цахим мэдээллийн сүлжээг ашиглан хүний нэр төрд халдах асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хуульчилсан байна.<sup>126</sup>

## **АВСТРИ БОЛОН ЛИХТЕНШТАЙН**

Австрийн Эрүүгийн тухай хуульд тодорхойлсноор, хэн нэгэн үнэн биш гэдгийг нь мэдэж байсан ч гэлээ бусдын нэр төр, алдар хүнд, алдар нэрийг гутаах нотолгоо гаргаж тавихыг **гүтгэх** гэмт хэрэг гэж үзнэ<sup>127</sup>. Австрид тухайн буруушаалт нь гэмт үйлдэлд хамаарах бөгөөд тухайн холбогдогч нь хуулийн байгууллагаар мөрдүүлэх эрсдэлд орсон байх нөхцөл байдал үүссэн байдалтай байна.

### **Австрийн Эрүүгийн тухай хуулийн 297 дугаар зүйл. Гүтгэх гэмт хэрэг<sup>128</sup>:**

(1) Хэн нэгэн бусдыг хуулийн байгууллагаар мөрдүүлэх эрсдэлд оруулсан бол нэг жил хүртэлх хугацаагаар баривчлах ял, эсхүл 720 хүртэлх өдрийн хувь хэмжээтэй дүйцэх мөнгөн торгууль оногдуулна. Хэрэв худал гүтгэсэн гэмт үйлдэл нь нэг жилээс дээш хугацааны баривчлах ялтай бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар баривчлах ял оногдуулна.

(2) Хуулийн байгууллагаас мөрдлөг явуулж эхлэхээс өмнө сайн дураар хуулийн байгууллагаар мөрдүүлэх эрсдэлийг зайлуулсан хүнд 1 дэх хэсэгт заасан ял шийтгэлийг оногдуулахгүй.

Австри болон Лихтенштайн Улсын Эрүүгийн хуульд тодорхойлсоноор, **нэр төр гутаах** гэмт хэрэг нь нэгэн төрлийн доромжлол бөгөөд явагдах хэлбэр нь өөр байдаг<sup>129</sup>. Нэр төр гутаах гэмт хэргийн хувьд ялангуяа нэр төр, алдар хүнд, алдар нэрийг гутаах үйлдлийн нотолгоог ял шийтгүүлэхээр гаргаж тавьсан байдаг. Энд (буруушаасан) үйлдэл нь “баталгаатай үнэн” биш байх нь шийдвэрлэх ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, үнэн гэх баталгаа байхгүй гэсэн үг.

**Австри болон Лихтенштайны Эрүүгийн тухай хуулийн 111 дүгээр зүйл. Нэр төр гутаах гэмт хэрэг:** “Хэн нэгэн бусдын талаар гуравдагч этгээдэд мэдэгдэхүйц байдлаар түүнийг олон нийтийн дунд жигшүүртэй байдалд оруулах, эсхүл алдар хүндийг нь бууруулах зорилгоор жигшихүйц зантай, эсхүл санаа бодолтой хэмээн, эсхүл алдар хүнд, нэр хүндэд харш харьцаатай хэмээн, эсхүл ёс заншлыг зөрчсөн хэмээн буруушаасан бол 6 сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл 360 хүртэлх хоногийн хувь хэмжээтэй тэнцэх мөнгөн торгуулийн ял оногдуулна.”

а

<sup>126</sup> <http://kellywarnerlaw.com/defamation-around-the-world/>

<sup>127</sup> Гүтгэлэг-Verleumdung (Österreich)-*германаар* [https://de.wikipedia.org/wiki/Verleumdung\\_\(%C3%96sterreich\)](https://de.wikipedia.org/wiki/Verleumdung_(%C3%96sterreich))

<sup>128</sup> Гүтгэх гэмт хэрэг, Эрүүгийн тухай хууль-§ 297 StGB Verleumdung-*германаар*  
<https://www.jusline.at/gesetz/stgb/paragraf/297>

<sup>129</sup> Нэр төр гутаалт-Üble Nachrede (Österreich und Liechtenstein)-*германаар*  
[https://de.wikipedia.org/wiki/%C3%9Cble\\_Nachrede\\_\(%C3%96sterreich\\_und\\_Liechtenstein\)](https://de.wikipedia.org/wiki/%C3%9Cble_Nachrede_(%C3%96sterreich_und_Liechtenstein))

Хэрэв нотолгоо үнэн гэж тогтоогдсон, эсхүл үйлдэгч нь сайн санааны үүднээс ажилласан (111 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг<sup>130</sup>) бол тухайн үйлдэл нь ял шийтгэлгүй байна.

Хэрэв нэр төр гутаасан үйлдэл нь өргөн олонд хүрсэн бол ял шийтгэлийн хэмжээ 1 жил, эсхүл 720 өдрийн хувь хэмжээтэй тэнцэх торгууль (111 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг) болон нэмэгдэж, давж заалдах эрх хасагдана.

Австрид нэр төр гутаах гэмт хэргийг гүтгэх гэмт хэргээс ялгах хил зааг нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу мөрдлөг явуулахад хүргэх буруушаалтаар гүтгэлэг хязгаарлагддагт оршино.

## **ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС**

Германы эрх зүйд Австри, Лихтенштайн Улсын адил гүтгэлэг, нэр төр гутаалтыг гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хуулиар зохицуулдаг. Харин эдгээр улсаас ялгаатай нь “доромжлох” үйлдлийг эрүүгийн хэрэг гэж үздэг бөгөөд нэр хүндэд халдах гэмт хэрэгт хамаатуулан Эрүүгийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт тусгасан байдаг<sup>131</sup>.

**Эрүүгийн тухай хуулийн 185 дугаар зүйл. Доромжлох гэмт хэрэг:** “Доромжлох гэмт хэрэг үйлдсэн бол 1 жил хүртлэх хугацаагаар хорих, эсхүл мөнгөн торгууль оногдуулах буюу хэрэв бусдад гэмтэл учруулсан бол 2 жил хүртэл хорих, эсхүл мөнгөн торгууль оногдуулах ял эдлүүлнэ.”

## **БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)–д эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдах асуудлыг “Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний тухай”<sup>132</sup> хууль (Framework Act on Health and Medical Services), “Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний тухай хуулийг дараж мөрдөх журам” (Enforcement Decree of the Framework Act on Health and Medical Services), “Эрүүгийн хууль”<sup>133</sup> (Criminal act), “Мэдээлэл холбоо, сүлжээний хэрэглээг дэмжих болон мэдээллийг хамгаалах тухай”<sup>134</sup> хууль (Promotion of Information and Communication Network Utilization and Information Protection) зэрэг хуулиудаар зохицуулж байна.

### **“ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ” ХУУЛЬ**

#### **46 дугаар зүйл “Маргааныг шийдвэрлэх”**

1. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд эрүүл мэнд, эмчилгээ үйлчилгээтэй холбогдон гарах маргааныг түргэн шуурхай, шударгаар шийдвэрлэхэд шаардагдах бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний улмаас үүдэн гарсан хохирлыг арилгах, засч залруулахад шаардлагатай бодлогыг боловсруулах эрхтэй.

#### **“Эрүүгийн хууль”–ийн 33 дугаар бүлэг: Хүний нэр хүндэд халдсан гэмт хэрэг. 307**

а

<sup>130</sup> Нэр төр гутаах гэмт хэрэг, Эрүүгийн тухай хууль-§ 111 StGB Üble Nachrede-германаар <https://www.jusline.at/gesetz/stgb/paragraf/111>

<sup>131</sup> И.Жаргалзаяабямба, Г.Алтан-Оч “Цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төрийг гутаах, гүтгэх, доромжлох, хуурамч мэдээлэл тараах үйлдэлд хүлээлгэх хариуцлага, бусад орнуудын туршлага” СТ-17/201, УИХТГ-ын Судалгааны эмхэтгэл XXIV боть, УБ 2017 он, 519-527 дахь тал

<sup>132</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=38919&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38919&lang=ENG)

<sup>133</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=40950&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40950&lang=ENG)

<sup>134</sup>

[https://en.wikisource.org/wiki/Act\\_on\\_Promotion\\_of\\_Information\\_and\\_Communication\\_Network\\_Utilization\\_and\\_Information\\_Protection#Article\\_61\\_\(Penal\\_Provisions\)](https://en.wikisource.org/wiki/Act_on_Promotion_of_Information_and_Communication_Network_Utilization_and_Information_Protection#Article_61_(Penal_Provisions))



### **дугаар зүйл (Хүний нэр төрд халдах)**

1. Хүний нэр төрийг олон нийтийн дунд баримттайгаар гутаан доромжилсон этгээдийг 2 хүртэлх жилийн хугацаагаар хорих, эсхүл 5 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

2. Хуурамч баримтыг нотолгоо болгон хүний нэр төрийг олон нийтийн дунд гутаан доромжилсон этгээдийг 5-аас дээшгүй жилийн хугацаагаар хорих, эсхүл 10 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

### **309 дүгээр зүйл (Хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр хүний нэр төрд халдах)**

1. Энэ хуулийн 307 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэгт холбогдсон этгээд нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (Үүнд, сонин, сэтгүүл, радио болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл) ашиглан хүний нэр төрд халдсан бол 3-аас дээшгүй жилийн хугацаагаар хорих, эсхүл 7 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

2. Энэ хуулийн 307 дугаар зүйлийн 2-т заасан гэмт хэрэгт холбогдсон этгээд нь энэ зүйлийн 1-д тодорхойлсон аргаар үйлдсэн бол 7-оос дээшгүй жилийн хугацаагаар хорих, 15 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

### **310 дугаар зүйл (Цагаатгах)**

Хэрэв 307(1)-д дурьдсан баримт, мэдээлэл нь үнэн зөв бөгөөд нийтийн ашиг сонирхлын төлөө бол энэ хэргийг хэрэгсэхгүй болгоно.

### **311 дүгээр зүйл (Хүнийг доромжлох)**

Хүнийг олон нийтийн дунд доромжилсон этгээдийг 1 жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл 2 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

### **312 дугаар зүйл (Гомдол гаргах)**

1. Энэ хуулийн 308-311 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдэд хохирогч этгээд гомдол гаргасан тохиолдолд гэмт этгээдэд шийтгэл оногдуулна.

2. Энэ хуулийн 307-309 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүдэд хохирогч эсэргүүцсэн тохиолдолд гэмт этгээдэд шийтгэл оногдуулахгүй байж болно.

## **“МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО, СҮЛЖЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ” ТУХАЙ ХУУЛЬ**

### **9 дүгээр бүлэг. 61 дүгээр зүйл (Хариуцлага хүлээлгэх)**

1. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг ашиглан гүтгэх зорилгоор баримт, нотолгоог дэлгэж хүний нэр төрийг гутаан доромжилсон этгээдийг 3 хүртэлх жилийн хугацаагаар хорих буюу 20 саяас хэтрэхгүй воноор торгох шийтгэл оногдуулна.

2. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг ашиглан гүтгэх зорилгоор баримт, нотолгоог дэлгэж хүний нэр төрийг гутаан доромжилсон этгээдийг 7 хүртэлх жилийн хугацаагаар хорих, эсхүл 10 хүртэлх жилийн хугацаагаар үйл ажиллагааны эрхийг хасах буюу 50 саяас хэтрэхгүй воноор торгоно.

## **ЯПОН УЛС**

Япон Улсад эмч, эмнэлгийн ажилтны нэр хүндэд халдах асуудлыг “Эрүүгийн хууль” (Penal code)<sup>135</sup> болон “Иргэний хууль” (Civil code)<sup>136</sup>, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

### **“Эрүүгийн хууль”-ийн 34 дүгээр бүлэг: Хүний нэр төрд халдсан гэмт хэрэг (Хүний нэр төрд халдах) 230 дугаар зүйл**

1. Хүний нэр хүндийг олон нийтийн дунд баримттайгаар гутаан доромжилсон тохиолдолд тухайн баримт нь үнэн, эсхүл худлыг үл харгалзан 3 хүртэлх жилийн хугацаагаар хорих буюу 500.000-аас хэтрэхгүй иеэнээр торгох шийтгэл оногдуулна.

### **(Олон нийтийн эрх ашгийн төлөө асуудал) 230-2 дугаар зүйл**

1. Өмнөх зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдэгдсэн бол тухайн баримтын үнэн эсхүл худлыг тогтоож, хэрэв баримт нь үнэн бол шийтгэл оногдуулахгүй.

### **231 дүгээр зүйл**

Хэрэв хүнийг олон нийтийн дунд баримт нотолгоогүйгээр гутаан доромжилсон бол хорих ялаар шийтгэх буюу торгууль оногдуулна.

### **232 дугаар зүйл**

1. Энэ бүлэгт заасан гэмт хэрэгт хохирогч гомдол гаргасан тохиолдолд шийтгэл оногдуулна.

### **“Иргэний хууль”-ийн 5 дугаар бүлэг (Иргэний эрхийг зөрчих) 709 дүгээр зүйл**

Санаатайгаар буюу санамсаргүйгээр бусдын эрхийг зөрчсөн, эсхүл хуулиар хамгаалагдсан эрхэнд халдсан этгээд нь үүнээс үүдэн гарсан аливаа хохирлыг арилгах, нөхөн төлөх үүрэгтэй.

### **(Эд хөрөнгөнөөс бусад хохирлыг нөхөн төлөх) 710 дугаар зүйл**

Дээрх зүйлд зааснаар бусдад эд хөрөнгө болон бусад төрлийн (бие махбодь, эрх чөлөө, нэр хүнд гэх мэт) хохирол учруулсан этгээд нь хохирлыг арилгах, нөхөн төлөх үүрэгтэй.

### **(Нэр хүндийг сэргээх) 723 дугаар зүйл**

Хохирогчийн хүсэлтээр шүүхээс хүний нэр хүндийг унагасан этгээдэд учирсан хохирлыг төлөх болон хохирогчийн нэр хүндийг сэргээх тодорхой арга хэмжээ авахыг үүрэг болгоно.

### **(Нэр хүндээ сэргээлгэх эрхийн хугацаа) 724 дүгээр зүйл**

Хохирогч болон хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэр хүндэд нь халдсан гэж үзсэнээс хойш 3 жилийн хугацаанд гомдол гаргаагүй тохиолдолд тухайн хэргийг хэрэгсэхгүй.

a

<sup>135</sup><http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&ft=3&re=02&dn=1&ia=03&x=65&y=22&bu=16&ky=&page=9&vm=02>

<sup>136</sup> <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2057&re=02&vm=02>  
<http://kellywarnerlaw.com/japan-defamation-laws/>

## **5. ШИНЭ ЗЕЛАНД УЛС**

Шинэ Зеланд Улсад эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдсан асуудлыг 1992 онд батлагдсан “Хүний нэр төрд халдахын эсрэг” (Defamation Act)<sup>137</sup> хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

“Хүний нэр төрд халдахын эсрэг” хуульд зааснаар хохирогч нь хохирлын хэмжээгээ тодорхойлон батлах шаардлагагүй бөгөөд тухайн хүний нэр хүндэд халдсан мэдээлэл нийтлэгдсэн л бол тодорхой хэмжээгээр хохирол амссан гэж үзнэ. Гомдол гаргагчид учирсан хохирлыг дараах байдлаар барагдуулна. Үүнд:

- Нөхөн төлбөр олгох;
- Нэр хүндэд нь халдсан мэдээллийг дахин хэвлэхийг хориглох;
- Залруулга хийх;
- Гэмт этгээдэд мөнгөн торгууль оногдуулах зэрэг болно.

## **БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС**

Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ) –д эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдсан асуудлыг хүний нэр төрд санаатайгаар болон санамсаргүйгээр халдсан гэмт хэргийг зохицуулах “Эрүүгийн хууль” (Penal Code), “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хууль (Criminal Procedure Code) болон “Мэдээллийн технологийн тухай” (Information Technology Act) хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна.<sup>138</sup>

“Мэдээллийн технологийн тухай” хуулийн 66А дугаар зүйлд цахим сүлжээ ашиглан хүний нэр төрд санаатайгаар халдан, тухайн хүнд хохирол учруулсан тохиолдолд гэмт этгээдийг 3 хүртэлх жилийн хугацаагаар хорих буюу мөнгөн торгууль оногдуулна гэжээ.

## **ТАЙЛАНД УЛС**

Тайланд Улсад эмч, эмнэлгийн ажилтны нэр төрд халдсан асуудлыг хүний нэр төрд халдах асуудлыг зохицуулсан “Эрүүгийн хууль” (Thai Criminal Code)<sup>139</sup>-ийн 326, 328 дугаар зүйл, “Иргэний хууль” (Thai Civil and Commercial Code)<sup>140</sup>-ийн 423, 448 дугаар зүйл, “Компьютер ашиглан гэмт хэрэг үйлдэх тухай” хууль (Computer Crime Act)<sup>141</sup>, “Хэвлэлийн тухай” хууль (Press Registration Act)<sup>142</sup> болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна.

“Компьютер ашиглан гэмт хэрэг үйлдэх тухай” хуулиар хууль бус мэдээлэл цахим сүлжээгээр цацсан оператор, мэдээллийг зохиогчийн хамт хариуцлага хүлээнэ. Мэдээллийг цахим сүлжээнд 2 цаг байршуулаад устгасан ч тухайн мэдээллийг хүмүүс үзсэн тохиолдолд энэ нь хэрэг үүсгэх үндэслэл болно гэжээ. Тайланд Улсад хүний нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл олон нийтийн сүлжээгээр тараах нь хууль бус юм.

2007 онд батлагдсан “Хэвлэлийн тухай” хуулиар сонин, сэтгүүлийн редактор, хэвлэгч, нийтлэгч нар хүний нэр төрд халдсан мэдээлэл нийтэлсэн тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд тухайн мэдээллийг бичсэн этгээд дангаар хариуцлага хүлээнэ гэж заажээ.

## **МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Монгол Улсад эмчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалахтай холбоотой харилцааг

а

<sup>137</sup> <http://www.legislation.govt.nz/act/public/1992/0105/25.0/DLM280687.html>

<sup>138</sup> <http://kellywarnerlaw.com/india-defamation-laws/>

<sup>139</sup> <https://www.thailandlawonline.com/laws-in-thailand/thailand-criminal-law-text-translation>

<sup>140</sup> <http://library.siam-legal.com/thai-civil-and-commercial-code/>

<sup>141</sup> <http://kellywarnerlaw.com/thailand-defamation-laws/>

<sup>142</sup> <http://slideplayer.com/slide/10973756/>

дараах хууль тогтоомжийн холбогдох заалтаар зохицуулж байна. Үүнд:

1.	<b>Зөрчлийн тухай хууль</b>	<p><b>6.21 дүгээр зүйл. Гүтгэх</b></p> <p>1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
2.	<b>Иргэний хууль</b>	<p><b>21 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах</b></p> <p>21.2.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.</p> <p>21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ.</p>
3.	<b>Эрүүл мэндийн тухай хууль</b>	<p>43.2.Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:</p> <p>43.2.8.эрүүл мэндийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байхад саад учруулахгүй, нэр хүнд, бие махбодид нь халдахгүй байх;</p> <p>43.2.9.эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, эрүүл мэндийн байгууллагын нэр хүндийг унагаах зорилго бүхий ташаа мэдээлэл өгөхгүй байх.</p>
4.	<b>Төрийн албаны тухай хууль</b> <b>2017 он</b> /шинэчлэн баталсан/	<p><b>61 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа</b></p> <p>61.1.Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана:</p> <p>61.1.4.<b>албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан</b> хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, <b>гүтгэх</b> болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах.</p>

## ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ: ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Ц.Болормаа

### АГУУЛГА

#### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

1. ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНДЭСЛЭЛ (ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН ҮҮДНЭЭС)
  - 1.1. Эрх зүйн философи дахь “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн үндэс
  - 1.2. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээ
  - 1.3. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт
2. ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА):
  - 2.1. ХБНГУ;
  - 2.2. ОХУ;
  - 2.3. АНУ.
3. ЭРХ ЗҮЙН ОНОЛ ДАХЬ “ХУВЬ ХҮН”, “БИЕ ХҮН” ГЭХ ОЙЛГОЛТУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ, ЯЛГАА

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны 1-р хэсэгт, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн онолын үндсийг эрх зүйн философийн үүднээс товч авч үзсэн бөгөөд тус эрхийн үндэсний болон олон улсын эрх зүйн тодорхойлолт, эрхийн бүрэлдэхүүн /хүрээ, хязгаар/, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт зэрэг ойлголтуудыг авч үзэв.

Судалгааны 2-р хэсэгт, ХБНГУ, АНУ, ОХУ зэрэг улс орнуудын Үндсэн хуульд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хэрхэн тодорхойлсон, түүний хүрээ хязгаар, ямар хуулиудаар зохицуулдаг зэрэг асуудлыг тусгав.

Судалгааны 3-р хэсэгт, эрх зүйн онол дахь “хувь хүн”, “бие хүн”-ий тухай ойлголт, тэдгээрийн ялгаатай талыг авч үзэв.

“Халдашгүй, чөлөөтэй байх эрх” нь онолын хувьд хүний салгаж үл болох **үндсэн эрх** гэх ойлголтод хамаарах эрх зүйн философийн үндсэн ухагдахуун бөгөөд **жам ёсны эрхийн онолд** хамаарна. “**Халдашгүй эрх**” нь “*inviolability*”, болон “*immunity*”, “*privacy*”, “*inviolability of individual life*”, “*inviolability of home*” зэрэг хууль зүйн нэр томьёо, ойлголтуудаар илэрхийлэгддэг өргөн хүрээтэй ойлголт бөгөөд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт”-д тунхагласан байдаг.

Хүн халдашгүй, чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх бөгөөд энэхүү эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулдаг, хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй **туйлын эрх** юм. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх” нь:

- (1) Эрх чөлөөтэй байх (*чөлөөтэй байх халдашгүй эрх ч гэдэг*);
- (2) Бие, махбодийн халдашгүй эрх;
- (3) Орон байрны халдашгүй байдал;
- (4) Нууцын халдашгүй эрх;
- (5) Нэр төрийн халдашгүй байдал;
- (6) Өмчийн халдашгүй байдал гэсэн 6 төрлийн эрхээс бүрдэнэ.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг бүрдүүлж буй эдгээр эрх нь тус бүрдээ өөр өөрийн гэсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд дэлгэрэнгүйг судалгааны тайлангаас үзнэ үү.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн зарим хэсгийг Үндсэн хууль болон үндэсний холбогдох хууль тогтоомжоор заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно. Гэвч ямар ч нөхцөлд хязгаарлаж болохгүй эрх байдаг байна. /Эдгээр болон бусад мэдээллийг дэлгэрэнгүйг судалгааны тайлангаас үзнэ үү./

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН



## НЭГ. ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Эрх зүйн философи дахь “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн үндэс

Онолын хувьд, “хүний эрх” гэдэг нь *хүнд өөрт нь байдаг төрөлх шинж, мөн чанар*<sup>143</sup> бөгөөд нийгмийн мөн чанар, улс төрийн дэглэмээс хамааран хууль, журмаар хүнд олгосон хэм, хэмжээний цогц ойлголт юм.

Хүний “халдашгүй, чөлөөтэй байх эрх” гэдэг нь онолын хувьд хүний салгаж үл болох **үндсэн эрх** гэх ойлголтод хамаардаг. Хүний салгаж үл болох үндсэн эрх нь эрх зүйн философийн үндсэн судлагдахууны нэг бөгөөд **жам ёсны эрхийн онолд** хамаарах ойлголт юм.

Хүний үндсэн эрх, тэр дундаа халдашгүй чөлөөтэй байх эрхийг тодорхойлсон өргөн ба явцуу хүрээний маш олон тодорхойлолтууд байх бөгөөд эдгээр нь цаг хугацаа, нийгмийн болон сэтгэлгээний хөгжлөөс шалтгаалан харилцан адилгүй байх ч хүний салгаж үл болох жам ёсны эрхэд суурилсан үндсэн цөм нь хувирашгүй юм.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх нь хууль зүйн шинжлэх ухааны хэд хэдэн салбарт хамаарах ойлголт бөгөөд тухайлбал, эрх зүйн философи, үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй (*эрх зүйн бүлээс шалтгаалан зарим улсад хувийн болон нийтийн эрх зүй*)- н асуудал, нарийвчлан авч үзвэл, эрүүгийн болон иргэний процессийн эрх зүйд хамаарах асуудал юм.

Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу уг асуудлыг хүний халдашгүй эрхийн онолын суурь болох эрх зүйн философи талаас нь авч үзнэ. Жам ёсны эрхийн онол (*legal nature, natural law, lex naturalis*) нь МЭӨ V зууны үед эртний Грекийн ертөнцийг үзэх үзлийн нөлөөгөөр софистууд (Протагор, Гиппий, Алкидам, Антифонт г.м) **ёс суртахууны сэтгэлгээнд үндэслэн шударга ёсонд хүрэхийн** тулд жам ёсны эрхийн үзэл санааг анх гаргасан<sup>144</sup> гэж үздэг.

Жам ёсны эрх<sup>145</sup>-ийн гол үзэл санаа нь “ертөнцөд байгалийн болон нийгмийн гэсэн хоёр харилцаа зэрэгцэн оршиж байгаа бөгөөд хамгийн шударга хууль нь байгалийн хууль юм” гэх үзэл юм. Жам ёсны эрхийн онолоор позитив хууль буюу нийгмийн хууль нь жам ёсны эрхэд үндэслэх ёстой бөгөөд жам ёсны эрх нь төрөөс тогтоосон шинж агуулдаггүй, хуулиас үүдэлтэй бус харин хүний мөн чанартай холбоотой байдаг. Жам ёсны эрх болон позитив эрхийн ойлголт, ялгааг тодорхойлон гаргасан хүн нь Эртний Грекийн сэтгэгчдийн нэг Аристотель бөгөөд түүний энэхүү үзэл нь орчин үеийн жам ёсны эрхийн онолын үндэс болсон.

Аристотель “**жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрсөн ч, эс зөвшөөрсөн ч хаана ч хэзээ ч үл өөрчлөгдөх, мөнх оршиж, дээд хүчин чадалтай байдаг эрх**”<sup>146</sup> гэж тодорхойлоод жам ёсны эрх нь ёс суртахууны аливаа шалгууруудтай нийцэж байдаг учраас позитив эрхийн үндэс гэж үздэг.

Өөрөөр хэлбэл, заншлын эрх зүйн хэм, хэмжээнээс орчин цагийн эрх зүйн хэм, хэмжээ хүртэлх үй олон дэг журмын цаана хэн ч тогтоогоогүй дээд үзэл санааны эрх зүй оршдог<sup>147</sup> нь жам ёсны эрх юм. Тухайлбал Ж.Локк “**амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхийг хүний**

а\_\_\_\_\_

<sup>143</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2017 он. 191 дэх тал.

<sup>144</sup> Х.Сэлэнгэ нарын хамтын бүтээл. “Эрх зүйн философи” 2013 он.

<sup>145</sup> Жам ёсны эрхийн онолын дараа үеийн төлөөлөгчид нь А.Фома, Г.Гроций, Т.Гоббс, Б.Спиноз, Ж.Локк, Ш.Монтескье, Ж.Ж.Руссо, И.Кант зэрэг сэтгэгчид болно.

<sup>146</sup> Х.Сэлэнгэ нарын хамтын бүтээл. “Эрх зүйн философи” 2013 он 162 дахь тал

<sup>147</sup> Н.Лүндэндорж. JURISPRUDENCE Эрх зүй судлал: Философи, онол. УБ хот. 2011 он. 30 дахь тал.

**салшгүй, төрөлх эрх**” гээд **“эдгээр эрхийг хүнд төр засаг өгдөггүй”**<sup>148</sup> юм гэж номлож байсан нь анхдагч эрх буюу хүний салгаж үл болох үндсэн эрхийн гол үзэл санаа юм.

Хүний салгаж үл болох үндсэн эрх нь төрөөс үл хамаарч, хүний төрөлх мөн чанарт үндэслэсэн үнэт зүйл, зарчим, дэг журам, эрхэд тулгуурладаг. Жам ёсны эрхийн онолын сэтгэлгээ нь байгалийн философи, Ромын эрх зүйн уламжлалд тулгуурлан хөгжсөн байдаг.

Эртний Ромын хуульчдын томоохон төлөөлөл болох Гай, Паниниан, Павел, Ульпиан, Сабиниан зэрэг сэтгэгчдийн үзлээр эрх зүй нь жам ёсны хуулиас эх үндэстэй бөгөөд жам ёсны эрх зүйн дагуу хүн бүр хувийн эрх чөлөөтэй төрдөг гэж үздэг. Харин дундад зууны үеийн Ромын сэтгэгч А.Фома *“Хүн бол оюун ухаантай амьтан. Оюун ухаан бол бүх эрх чөлөөний үндэс”* гээд жам ёсны хуулийн гол үзэл санаа нь хүний жам ёсны анхдагч хэрэгцээг хангаж, хамгаалах шаардлага гэж үзэж байсан.

Жам ёсны эрхийн онолыг хөгжлийн 4 түвшин<sup>149</sup>-д авч үздэг бөгөөд *сэргэн мандалтын үе*<sup>150</sup> гэгддэг дундад зууны үед *хүний эрхийг эрх зүйн үнэт зүйлийн тогтолцооны төвд тавьж, жам ёсны эрхийн байгууламжид хувь хүний эрхийг байрлуулснаар субъектив эрхийн үзэл санаа* хөгжих үндсийг бүрдүүлсэн.

Ингэснээр субъектив эрх буюу хүний салгаж үл болох үндсэн эрх (жам ёсны эрх)-ийг хангах нь орчин үеийн эрх зүйт төрийн шинж гэх үзэл хандлага дэлгэрч, улмаар 1776 онд Нэгдсэн Улсын тусгаар тогтнолын тунхаг, Хүний ба иргэний эрхийн тунхаглал, Эрхийн тухай Виржинийн тунхаглалаар хүний эрхийн жагсаалтыг тодорхойлсон. Аливаа улс орон хүний жам ёсны эрхийг Үндсэн хуулиар хамгаалснаар түүнийг үндсэн эрх гэж нэрлэх болсон байдаг. Үүнтэй хамт орчин үеийн *үндсэн эрхийн тухай орчин үеийн үзэл баримтлал* бий болжээ.

Үүнээс хойш **үндсэн эрх** нь төрийн үндэс суурь, иймд **төрийн эрх мэдэл үндсэн эрхээр хязгаарлагдах ёстой** гэсэн санаа шинэ үзэл баримтлалын цөм болж<sup>151</sup> улс орнуудын үндсэн хуульд тусгалаа олж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, үндсэн эрхийг төр засгийн дур зоргоос хамгаалах нь аливаа улс орнуудын үндсэн хуулийн нэн тэргүүний зорилт, дэлхий нийтийн үнэт зүйл болсон гэж хуульчид үздэг. Хүний үндсэн эрх гэгддэг жам ёсны эрхийг Үндсэн хуулийн эрх зүйгээр тогтоодог биш, харин хүлээн зөвшөөрдөг<sup>152</sup>.

Хүний эрхийг жам ёсны эрх болохынх нь хувьд тухайн тодорхой улсын иргэн эдлэхээс гадна нутаг дэвсгэрт нь оршин суудаг хүн бүр эдлэх боломжтой. Жам ёсны эрхэд амьд явах; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх; эрүүл мэндээ хамгаалуулах; итгэл, үнэмшилтэй байх; шашин шүтэх, эс шүтэх; эрх тэгш байх; *халдашгүй, чөлөөтэй байх*; гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах; *орон байр халдашгүй байх*; *хувийн захидал, харилцааны нууцыг хамгаалах*; өмчтэй байх, хувийн өмчийг дайчлан авбал нөхөх олговор авах; гомдол гаргаж шийдвэрлүүлэх зэрэг эрх хамаарна.

Иймээс жам ёсны эрхийн онолын үзэл баримтлалд дэвшүүлсэн хүний үндсэн эрхийг дэлхийн улс орнууд *Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (холбогдох заалтуудыг Судалгааны дараагийн хэсгээс үзнэ үү)* болон холбогдох бусад олон улсын гэрээ, конвенцид тунхаглан, цаашлаад улс орон бүр өөрийн Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн байдаг. Ийнхүү хүлээн зөвшөөрөн, тунхаглахын учир нь улс орнуудын өөрсдийн нийгэмд шударга ёс, энх тайван, амар амгалан байдлыг цогцлоох

а\_\_\_\_\_

<sup>148</sup> Мөн тэнд.

<sup>149</sup> Н.Лүндэндорж. JURISPRUDENCE Эрх зүй судлал: Философи, онол. УБ хот. 2011 он. 37 дахь тал.

<sup>150</sup> Мөн тэнд.

<sup>151</sup> Ц.Сарантуяа “Үндсэн хуульт төр ба үндсэн эрх, эрх чөлөө”. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал. 2017 он.138 дахь тал.

<sup>152</sup> Ц.Сарантуяа “Үндсэн хуульт төр ба үндсэн эрх, эрх чөлөө”. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал. 2017 он.139 дахь тал.

хүсэл, зорилго юм. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арванзургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт хүний, халдашгүй чөлөөтэй байх эрхийг тунхагласан.

**“Халдашгүй эрх”** нь үг зүйн хувьд латин хэлний *ямар нэгэн зүйлээс чөлөөтэй байх* гэсэн утгыг илэрхийлдэг “immunitas” гэх үгээс гаралтай гэгддэг бөгөөд англи хэлний “inviolability”, болон “immunity”, “privacy”, “inviolability of individual life”, “inviolability of home” зэрэг хууль зүйн нэр томьёо, ойлголтуудаар илэрхийлэгддэг, өргөн хүрээтэй ойлголт юм.

**Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн тодорхойлолт:** Монгол Улсын хууль зүйн ухааны доктор, профессор Г.Совд “Хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх. Халдашгүй, чөлөөтэй байх эрх бол хүн бүрт Үндсэн хуулиар баталгаажуулсан, хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй **туйлын эрх**<sup>153</sup>...” гэж тодорхойлсон.

Хүний халдашгүй эрх гэж өөрийнх нь төрөлх, жам ёсны хэрэгцээнээс үүдэлтэй, мөн чанарын хувьд төрөөс тогтоосон биш зөвшөөрсөн байх бөгөөд эрх зүйн хэм, хэмжээгээр бэхжигдэж, хамгаалагдсан, хөндлөнгийн хэн ч дур мэдэн хөндөж, хязгаарлаж үл болох хэд хэдэн туйлын эрхийн цогц юм<sup>154</sup> гэх зэргээр тодорхойлсон байдаг.

## 1.2. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн бүрдэл (хүрээ)

Эрх зүйн онолд тодорхойлсны дагуу хүний эрхийн тухай олон улсын гэрээ, конвенц болон аливаа тусгаар улсуудын Үндсэн хуульд “хүний халдашгүй эрх” эсхүл “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн хүрээ хязгаарыг тодорхойлсон байдаг.

Тухайлбал, Монголын Улсад 1968 оны 01 дүгээр сарын 05-ны гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад халдашгүй чөлөөтэй байх эрх болон түүний хүрээг тодорхойлсон байдаг. Энэхүү олон улсын пактыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

**“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”**-д хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

а\_\_\_\_\_

<sup>153</sup> Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх. Харьцуулсан эрх зүй. УБ хот. 1999 он. 51 дэх тал.

<sup>154</sup> Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ. 2002 он. 14 дэх тал.

### 9 дүгээр зүйл

1. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.

2. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

3. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.

4. Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

5. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

Түүнчлэн тус пактын 17 дугаар зүйлд халдашгүй, чөлөөтэй байх эрхийн бүрэлдэхүүн буюу хүрээг дараах байдлаар томъёолсон байдаг. Үүнд:

### 17 дугаар зүйл<sup>155</sup>

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

гэж заасан байдаг. Үүнээс үзвэл олон улсын эрх зүйд “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийг бүрдүүлж буй нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн дараах элементүүд байна:

- 1) хувийн амьдралын халдашгүй байдал;
- 2) гэр бүлийн амьдралын халдашгүй байдал;
- 3) орон байрны халдашгүй байдал;
- 4) захидал харилцааны нууц;

5) нэр төр<sup>156</sup>, алдар хүнд<sup>157</sup>-ийн халдашгүй байдал гэх таван хүрээнд тодорхойлсон байна.

а\_\_\_\_\_

<sup>155</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт.

<sup>156</sup> **Dignity буюу нэр төр** нь нийгмийн зүгээс бодгальд өгсөн ёс суртахууны үнэлэлт, түүнчлэн хүн өөрөө өөрийгөө үнэлсэн үнэлгээг тэмдэглэсэн ухагдахуун юм. Нэр төр нь хүний төрснөөс хамааралтай бөгөөд бусдад шилжүүлж, дамжуулж болдоггүй **эдийн бус баялгийн** нэг. Иргэний нэр төрийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ нотолж чадахгүй бол мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүргийг Иргэний хуульд заасны дагуу хүлээнэ. *С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 326 дахь тал.*

<sup>157</sup> **Honour буюу алдар хүнд** гэж бие хүний хүндэтгэл ба өөрийгөө хүндэтгэх ёс суртахуун-зан суртахууны категори

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 3 дугаар зүйлд халдашгүй байх эрхийг амьд явах эрхтэй дүйцүүлэн авч үзсэн бол 12 дугаар зүйлд эрхийн хүрээг дээрхтэй ижил байдлаар томьёолсон байдаг.

### 3 дугаар зүйл

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

### 12 дугаар зүйл

Хэний ч **хувийн болон гэр бүлийн амьдралд** хөндлөнгөөс дур мэдэн оролцох, **орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд** нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг дараах байдлаар хуульчлан бэхжүүлсэн:

*“13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан.*

Энэ нь хүний:

- хүний бие;
- эд хөрөнгө;
- нэр төр;
- хувийн болон гэр бүлийн нууц;
- захидал харилцаа;
- орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур

зоргоороо аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулсан учраас эдгээр эрх чөлөөнд хэн боловч хуульд заасан үндэслэл, журмаас гадуур халдах эрхгүй байна.<sup>158</sup>

Монгол Улсын хуульч эрдэмтэд “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийг бүрдүүлдэг эрхийг тодорхойлохдоо:

- (1) Эрх чөлөөтэй байх (*чөлөөтэй байх халдашгүй эрх ч гэдэг*);
- (2) Бие, махбодийн халдашгүй эрх;
- (3) Орон байрны халдашгүй байдал;
- (4) Нууцын халдашгүй эрх;
- (5) Нэр төрийн халдашгүй байдал;
- (6) Өмчийн халдашгүй байдал гэсэн 6 хүрээг хамарна гэж үзсэн байдаг<sup>159</sup>.

Түүнчлэн зарим судлаачид<sup>160</sup> халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээний талаар өөр өөрийн

юм. Алдар хүнд нь тухайн хүн өөрөө буюу хүрээлэн буй хүмүүс түүнийг бие хүний хувьд хэрхэн хүлээн авч, үнэлж байгаагаас үл шалтгаалан түүнд хамаарах дээд үнэ цэнэ бүхий хүнээс огт салгаж болшгүй шинж. Иргэний эрх зүйн үүднээс авч үзвэл *эдийн бус баялагийн* нэг, түүнийг бусдад шилжүүлж ба дамжуулж болшгүй төрөлхийн шинжтэй байдаг. Иргэн өөрийн нэр төр ба алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол шүүхээр няцаалгах эрхтэй. Үндсэн хуулийн эрх зүйд хүний нэр төр ба алдар хүндийг хүндэтгэх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг болдог. *С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 32 дахь тал.*

<sup>158</sup> Г.Совд нарын хамтын бүтээл. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2000 он. 110 дахь тал.

<sup>159</sup> Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 90 дэх тал.

<sup>160</sup> Б.Бат-Эрдэнэ нар. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй: Ерөнхий анги. УБ.1996.



санаа бодлыг дэвшүүлсэн байдаг ч энэхүү судалгаанд олон улсын чиг хандлага болон үндэсний эрх зүйн тогтолцоонд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн ангилалт болон Монгол Улсын гавьяат хуульч Г.Совд, Б.Цэрэндорж, Н.Жанцан, С.Жанцан, С.Төмөр, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа нарын эрдэмтдийн Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарууд, холбогдох нэг сэдэвт бүтээлүүд, эрх зүйн толь бичиг, эрүүгийн эрх зүй дэх нэр томъёоны тайлбар, онолын чиг хандлагыг баримталсан болохыг анхаарна уу.

**(1) Эрх чөлөөтэй байх:** Эрх чөлөөтэй байх эрх нь дээр дурьдсан Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын холбогдох заалт болон Монгол Улсын Үндсэн хуульд харьцангуй бие даасан байдлаар тусгасан бөгөөд агуулга нь хүн бүр адил эрх чөлөөтэй байх агуулгаар тодорхойлогдсон. Хүний эрх чөлөө нь тодорхой хууль, журмаар баталгаажсан, тодорхойлогдсон боломжийг ямар нэг *алагчлал, хориг, албадлагагүйгээр өөрийн ухамсар, хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлэх* тухай ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, ямар ч үед хувийн болон гэр бүл, ахуй амьдралын хүрээн дэх өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа нь хөндлөнгийн аливаа хяналтаас ангид байна. Хүний эрх чөлөөнд хэн ч дур мэдэн халдаж, хүсэл зоригийг нь алдагдуулж, эрхшээлдээ оруулж болохгүй бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

“Эрх чөлөө”-ний тухай эрх зүйн философийн олон төрлийн үзэл санаа, хандлага, тодорхойлолт байдаг. Үүнээс Английн сэтгэгч Ж.Локк эрх чөлөөг “жам ёсны эрх чөлөө” ба “нийгэм дэх эрх чөлөө” гэсэн хоёр төрөлд ангилсан.

*Жам ёсны эрх чөлөө* гэж хүн бусдын дур зорго, эрх чөлөөнөөс хараат бус байж гагцхүү *байгалийн хуульд* захирагдах явдал гэж тодорхойлсон. Харин *нийгэм дэх эрх чөлөө* нь хүн өөрийн хүлээн зөвшөөрч итгэл хүлээлгэсэн хууль *тогтоох засаглалаас* өөр засаглалд үл захирагдахыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Харин Гегель “Эрх чөлөө бол дур зорго бус. Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хийж байгаа зүйлийнхээ хүрээ, хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал” гэжээ. Түүнчлэн Монтескье “...*Эрх чөлөө гэдэг нь хуулиар зөвшөөрөгдсөн зүйлийг хийх эрх*” гэж тус тус тодорхойлсон байна.

**(2) Бие махбодийн халдашгүй эрх:** Эрх зүйн онол, Үндсэн хуульд тунхагласан үндсэн эрхийн үүднээс авч үзвэл “*ямар ч тохиолдолд хэн ч эрх чөлөөт хүнийг аливаа үйлдэл хийлгэх, эс хийлгэхийн тулд дарамтлах, хувийн нууцийг олж мэдэх, үг хэлүүлэх, мэдүүлэг өгүүлэх зорилгоор албадах, бие сэтгэлийг шаналгаж, өвтгөн зовоох хэлбэрээс ямагт ангид байх туйлын шинжийг агуулна.*”<sup>161</sup>

Аливаа ардчилсан улсуудад хүнийг зодох, биед нь гэмтэл учруулах, албадан хөдөлмөрлүүлэх, хүний эд эрхтэнг ашиг олох зорилгоор худалдах, худалдан авах, амь насыг нь бүрэлгэх, тарчлаан зовоох, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандах зэргийг нийгэмд аюултай гэмт хэрэг гэж үзэн тодорхой хууль тогтоомжоор хориглосон, хүний бие махбодийн халдашгүй байдлыг хамгаалсан байдаг.

Бие махбодийн халдашгүй эрхийг:

- Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль;
- Зөрчлийн тухай;

---

Д.Баянбилэг. Хүний эрхийн төвийн гүйцэтгэх захирал. Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ. 2002 он.

<sup>161</sup> Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 91 дэх тал.



- Гүйцэтгэх ажлын тухай;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай;
- Хөдөлмөрийн тухай;
- Хүүхдийн эрхийн тухай болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц болон холбогдох бусад хууль тогтоомжоор хамгаалдаг. Иймд Үндсэн хуулиар хамгаалсан бусдын бие махбодийн халдашгүй эрхэд халдахын тулд:

**Нэгт** хуульд зааснаар уг ажиллагааг явуулах хангалттай үндэслэлтэй байх;

**Хоёрт** хуулиар эрх олгосон төрийн тусгай албан тушаалтан байх;

**Гуравт** хуульд заасан нөхцөл, журмын дагуу хийсэн байх ёстой гэсэн үндсэн шаардлага тавигдана.

Хэрэв эдгээр нөхцөл байдлыг бүхэлд нь буюу аль нэгийг нь зөрчих замаар хүний халдашгүй байх эрхийг алдагдуулсан бол гэм буруутай этгээд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үүднээс авч үзвэл бие махбодийн халдашгүй эрх гэдэг нь **эрүүгийн байцаан шийтгэх аливаа ажиллагаанд төрийг төлөөлөн оролцож буй эрх бүхий этгээдүүд** ямар ч нөхцөлд, хэнийг ч үйлдсэн буюу сэжиглэгдэж байгаа хэргийнх нь талаар мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, эсхүл ул мөр, эд мөрийн бусад баримт (хурууны хээ, цус, үрийн шингэн, үтрээний арчдас гэх мэт) гаргуулах зорилгоор албадах, санаатайгаар, хүчтэйгээр бие махбодид нь халдаж болохгүй туйлын эрх<sup>162</sup> гэж үздэг.

Түүнчлэн, Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 02-нд **“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц”**<sup>163</sup>-д нэгдэн орсноор хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хангах, тэр дундаа хүний бие махбодийн болон нэр төр, алдар хүндийн халдашгүй эрхийг хамгаалах чиглэлд томоохон үүрэг хүлээсэн.

Энэ эрх нь хүний амар тайван, зовиур шаналгаагүй байж аз жаргалтай амьдрах гэсэн туйлын хүсэл эрмэлзлээс эхтэй учир хүн бүр ямар ч нөхцөлд аливаа хүч хэрэглэсэн үйлдлээс ангид байх ёстой. Энэ эрх нь хүүхдэд ч хамаатай. Иймд дэлхийн улс орнууд:

- хүнийг зодох;
- биед нь гэмтэл учруулах;
- хүний эд эрхтэнг ашиг олох зорилгоор худалдах, худалдан авах;
- амь насыг нь хохироох;
- тарчлаах;
- мөрдөн мөшгих;
- үндэслэлгүйгээр баривчлах, хорих, нэгжлэг хийх;
- бие сэтгэлийг шаналгах үйлдлүүдийг гэмт хэрэг, зөрчил гэж үзэн үндэсний хууль тогтоомжоор хамгаалсан байдаг.

а

<sup>162</sup> Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ хот. 2002 он. 22 дахь тал.

<sup>163</sup> Тус конвенцын 1 дүгээр зүйлд зааснаар “Эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу албан үүргээ гүйцэтгэж байгаа этгээд, түүний хатгалгаар буюу илээр, далдуур зөвшөөрснөөр аливаа нэг хүнийг, түүнээс буюу гуравдагч этгээдээс үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа хэргийн талаар мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, шийтгэхийн тулд түүнчлэн тухайн этгээдийг буюу гуравдагч этгээдийг аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар айлгах, албадах, санаатайгаар хүчтэйгээр өвтгөх буюу бие махбодь, сэтгэл санааны хувьд тарчлаан зовоосон аливаа үйлдлийг ойлгоно.” гэж заасан байна.

Харин хуулийн цээрлэл, тохиолдлоор үүдсэн өвдөлт, шаналгааг эрүүдэн шүүх гэдэг ойлголтод оруулахгүй байхаар тусгасан байдаг.

**(3) Орон байрны халдашгүй байдал:** Орон байрны халдашгүй байдал гэдэг нь тухайн хувь хүний буюу гэр бүлийн гишүүдийн хууль ёсоор амьдран сууж буй гэр байшин, өрөө тасалгаанд оршин суугчийнх нь зөвшөөрөлгүйгээр хэн ч орохгүй байх эрхийг хэлнэ.<sup>164</sup>

Олон улсад “*inviolability of the home*” гэж нэрлэгддэг орон байрны халдашгүй байдал нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний хувийн үндсэн эрхийн нэг бөгөөд тэнд оршин суугчдын хүсэл зоригоос гадуур хэн ч нэвтрэн орох ёсгүй, шаардлагатай тохиолдолд зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулалж, уншиж танилцуулснаар нэгжлэг хийх<sup>165</sup> хууль зүйн баталгаагаар хангагдсан туйлын эрх юм.

Энэхүү эрх нь хүний өөрийнх нь мөн чанар, хүний анхдагч жам ёсны хэрэгцээтэй салшгүй холбоотой байдаг учраас “орон байр” гэдэгт байнга амьдардаг гэр, байшин, өрөө тасалгаанаас гадна түр хугацаагаар оршин суух зориулалт бүхий сууцны төрлийг ч мөн оруулна.

Орон байрны халдашгүй эрхийн агуулга нь:

- ✚ тухайн орон байранд тодорхой нэг этгээд болон гэр бүлийн гишүүд нь хууль ёсоор амьдарч байгаа;
- ✚ түүнд нь хэн ч оршин суугчийн зөвшөөрөлгүй нэвтрэн орох эрх үл эдлэх;
- ✚ оршин суух хугацаанаас нь үл хамаарч хүний орон байрнаас албадан гаргахгүй байх;
- ✚ ямар ч тохиолдолд хураан авах битүүмжлэхгүй байх явдлаар тус тус тодорхойлогдоно.

Зөвхөн хуульд заасан тохиолдолд, хуульд заасан үндэслэлээр хүний хууль ёсоор оршин суугаа орон байранд оршин суугчдын хүсэл зоригоос үл хамааран нэвтрэн орж болох бөгөөд үүнээс бусад үед “халдашгүй” гэж үзнэ.

Орон байрны халдашгүй эрх нь онц болон дайны байдлын үед хязгаарлагдаж болох бөгөөд тус эрхийн хүрээний тухайд эрүүл орчинд амьдрах эрх болон эрх зүйн дэг журмыг зөрчсөн орчин нь (орц, хонгил, хогийн цэг г.м) орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн гэх ойлголтод хамаарахгүй.

Түүнчлэн орон байранд дур зоргоороо нэвтрэн орох бүх тохиолдол нь зөвхөн нийгмийн аюулгүй байдал, бусдын амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн ноцтой ба илэрхий аюулыг зайлуулах нөхцөлд л хийгдэнэ. Орон байрны халдашгүй байдлыг онц болон дайны байдлын үед хязгаарлаж болно.

**(4) Нууцын халдашгүй эрх:** Хүний халдашгүй эрхийн нэг бүрдэл болох хувь хүний нууцын халдашгүй байдлыг бие даасан хуулиар зохицуулдаг. 1995 онд батлагдсан Хувь хүний нууцын тухай хуулиар “Хувь хүний нууц” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.<sup>166</sup>

Хувь хүний нууцыг ямар мэдээлэл агуулснаар нь:

- 1/ захидал, харилцааны нууц;
- 2/ эрүүл мэндийн нууц;
- 3/ хөрөнгийн нууц;
- 4/ гэр бүлийн нууц;

а

<sup>164</sup> Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 91 дэх тал.

<sup>165</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 356 дахь тал.

<sup>166</sup> Хувь хүний нууцын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан байдаг.

5/ хуулиар тогтоосон бусад нууц гэж ангилна.


**Захидал, харилцааны нууц:** гэж захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийн нууцыг хэлнэ. Иргэдийн утас, цахилгаан, факс, цахим шуудан, захидал харилцааны нууц бол хүний хувийн халдашгүй эрх учраас бусдын хувийн захидал харилцаа, шуудан, цахим харилцааны нууцыг задруулах ёсгүй.

**Эрүүл мэндийн нууц:** тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг эрүүл мэндийн нууц гэж ойлгоно.

**Хөрөнгийн нууц:** зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг хөрөнгийн нууцад хамааруулна.

**Гэр бүлийн нууц:** бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг гэр бүлийн нууцад хамааруулна. Гэр бүлийн нууц гэдэгт эхнэр нөхөр хоёрын болон эцэг эх, үр хүүхдийн хоорондын харилцаанд бусдаас болон өвөр хоорондоо нууцалдаг ахуйн болон амьдралын ямар ч нууц байж болно.<sup>167</sup>

**Хуулиар тогтоосон бусад нууц:** Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно. Нууцыг хэнд хамаарах байдлаар нь:

 гэр бүлийн;

 зөвхөн өөрт хамаарах гэж ангилна.

Хүний нууцын асуудал нь хүний салгаж үл болох эрх мөн бөгөөд хүн хоорондын харилцаанд эерэг болон сөрөг байдлаар хүчтэй нөлөөл үзүүлж байдгыг харгалзан эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хувь хүн хэн ч мэдрэмжтэй, хүлээцтэй хүндэтгэлтэй хандах шаардлагатай. Харин бусдад хохирол учруулсан, гэм буруутай үйлдэл нь нууцын хамрах хүрээний асуудал биш бөгөөд эрүү, иргэн захиргааны журмаар шийдвэрлэх асуудал болно.

Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/ -ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно гэж зохицуулсан байдаг.

Түүнчлэн дэлхийн улс орнуудад хувь хүний нууцын тухай ойлголтыг “*privacy*” болон “*inviolability of individual life*” буюу “хувийн амьдралын халдашгүй байдал” гэх ойлголт, нэр томъёогоор илэрхийлдэг. Тухайлбал, “*privacy*” гэх нэр томъёо нь хүний хувийн амьдрал, хувийн дотно харилцаа буюу амрагийн харилцааны нууц ба халдашгүй байхыг илэрхийлэх Үндсэн хуулийн эрх зүйн ойлголт бөгөөд англо-саксоны эрх зүйн бүлд түлхүү хэрэглэгддэг. Цаашлаад тухайн улсад хувийн амьдрал гэдэгт юуг ойлгох, түүний нууцын болон халдашгүй байдлын хүрээг тогтоох, хязгаарлах тохиолдол бий эсэх, хэрэв тийм бол ямар тохиолдол байх зэргийг энэ судалгааны хоёрдугаар хэсэгт авч үзнэ.

**(5) Нэр төрийн халдашгүй эрх:** Монгол Улсын хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нэр төр, алдар хүндийн халдашгүй байдал гэж аль алиныг нь нэрлэн зааж, хамгаалалтад авсан байдаг. Монгол улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн

а

<sup>167</sup> Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх: харьцуулсан эрх зүй. 1999 он. 71 дэх тал.

13 дахь хэсэгт тунхагласан халдашгүй эрхийн хүрээнд нэр төрийн халдашгүй байдлыг нэрлэн заасан бөгөөд Иргэний хуулиар илүү өргөн хүрээнд зохицуулсан байдаг.

Жам ёсны эрхийн онолын үүднээс хүний нэр төрийн халдашгүй эрх гэдэг нь хүн бүр ямар ч нөхцөл байдалд, элдэв ялгаваргүйгээр өөртэй нь бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэн хүнлэг ёсоор хандах мөн чанарыг агуулж байдаг.<sup>168</sup>

Нэр төр, алдар хүнд нь иргэний эрх зүй болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн судлагдахуун болохын хувьд Иргэний хуулийн 20, 21 дүгээр зүйлд “*Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах*” тухай заасан. Энэ зүйлээр:

- иргэний нэр;
- нэр төр;
- алдар хүнд;
- ажил хэргийн нэр хүнд гэх 4 тусдаа ойлголтыг хуулиар хамгаалсан.

Эдгээр ойлголтууд нь өөр хоорондоо нягт уялдаатай боловч бие даасан агуулгатай байна. Нэр төр, алдар хүнд нь иргэнд хамааралтай байдаг бол ажил хэргийн нэр хүнд нь иргэн, хуулийн этгээдийн аль алинд хамааралтай ойлголт.

*Иргэний нэр:* Иргэн өөрийн нэртэй байх явдал нь иргэний салшгүй эрх юм. Нэр гэдэг нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан, хүн төрснөөр түүнийг бодьгалжуулж буй нэгэн төрөл элемент юм. Иргэн нэртэй байхыг иргэний хуулиар хүлээн зөвшөөрч байгаа нь түүнийг эрх зүйн харилцаанд оролцох нөхцөлийг хангадаг<sup>169</sup>. Иргэний нэрийг хууль бусаар ашиглах нь тухайн иргэний өөрийн нэрээр олж авсан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаврыг бий болгодог тул хуулиар хамгаална.

*Нэр төр:* нэр төр нь иргэний зан суртахуун, ёс зүй, ажил үйлс, мэргэжлийн шинжийн талаарх эерэг үнэлгээ юм.

*Алдар хүнд:* Алдар хүнд нь нэр төртэй салшгүй холбоотой ойлголт юм. Алдар хүнд нь тухайн иргэнд нийгэм, найз нөхөд, хамт олон, бусад харилцагч, түншлэгчээс өгч байгаа үнэлгээнд үндэслэсэн тухайн иргэний өөрийнх нь хувийн үнэлэмж юм.

*Ажил хэргийн нэр хүнд:* Энэ нь нийгэм-эдийн засгийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хамааралтай ойлголт бөгөөд тухайн этгээд ажил мэргэжлийн болон албан тушаалын үүрэг, гэрээгээр хүлээсэн үүрэг болон бусад үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас шалтгаалан үүсэх үнэлэмж юм. Хувь хүн болон хуулийн этгээд нь эдгээр үүрэгтээ шударга хандаж, түүнийгээ хэрэгжүүлж байвал ажил хэргийн нэр хүнд тогтвортой байдаг.

Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэдэгт:

- бодит байдалд нийцэхгүй мэдээлэл тараах;
- ийм мэдээлийг өөр хэн нэгэн этгээдэд мэдээлсэн байхыг ойлгоно.

Харин тийм мэдээ, мэдээллийг иргэнд өөрт нь мэдээлснийг гутаасан гэж үзэхгүй. Уг мэдээ, мэдээлэл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, электрон шуудангаар, хурал цуглаан дээр төдийгүй тухайн иргэний ажлын байран дээр тараасан, ажил байдлын тодорхойлолт, өргөдөл, албан тоотоор буюу амаар өөр этгээдэд хүргэсэн байхыг ойлгоно.

а

<sup>168</sup> Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2009 он. 93 дэх тал.

<sup>169</sup> ХЗДХЯ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2005 он. 72 дахь тал.

Түүнчлэн бодит байдалд нийцсэн, үнэн мэдээлэл боловч хувь хүний нууцад хамаарах мэдээллийг иргэний өөрийн зөвшөөрөлгүй нийтэд тараасан бол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзнэ.

**(6) Өмчийн халдашгүй байдал:** Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын Үндсэн хуульд өмчийн халдашгүй байдлыг баталгаажуулсан.

Өмч нь үг зүйн хувьд ямар нэгэн этгээдэд оногдсон зүйл гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд төр, нийгэм, хувь хүний амьдралын хэвийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой эд юмсын материаллаг зүйл юм.

Өмчийн халдашгүй байдал нь яагаад хүний халдашгүй эрхийн бүрэлдэхүүнд багтаж байгааг олон зүйлээр тайлбарлаж болох ч жам ёсны эрхийн онолын үүднээс хүн гэгч байгалийн амьтны амьд явах анхдагч хэрэгцээ, шаардлагаар тайлбарлагдана. Цаашилбал, либертари үзлийн үүднээс авч үзвэл өмч нь хүний жам ёсны хамгийн анхдагч эрхээ эдлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэгч тул хүний хувийн эрхийн салшгүй хэсэг мөн гэж үздэг.

### 1.3.Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт

*“Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн өөрийн үйлдлийн хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал”* гэсэн Германы сонгодог философич Г.В.Гегелийн үгнээс эрх, эрх чөлөө нь тодорхой хүрээ хязгаартай гэдгийг харж болно. Өөрөөр хэлбэл, эрх зүйн үүднээсээ хүний эрх нь ямар ч тохиолдолд хэмжээ хязгааргүй дур зоргыг илэрхийлдэггүй.

Хүний халдашгүй эрх чөлөөнд хөндлөнгийн хэн нэг хүн, эсхүл албан тушаалтан хэн боловч дур зоргоороо халдах эрх байхгүй боловч төр, нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, хохирсон хүний эрхийг хамгаалж хууль биелүүлэх зорилгоор хуулиар эрх олгосон этгээд, хуульд заасан үндэслэл бүхий нөхцөлд, хуулиар тогтоосон журмын дагуу халдах хэрэгцээ шаардлага гардаг.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах олон улсын болон үндэсний эрх зүйн үндэс нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т<sup>170</sup>, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт<sup>171</sup> хуульчлагдсан байх бөгөөд аливаа улс оронд оршин суугаа хүн бүр хүний нэр алдар, нэр хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх үүргийг Үндсэн хуулиараа хүлээсэн байдаг.

Дэлхийн нийтлэг чиг хандлагаас үзэхэд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, түүний бүрэлдэхүүний зарим эрхийг хуульд заасан журмын дагуу тодорхой хүрээнд хязгаарлах дараах нийтлэг тохиолдлууд байна. Үүнд:

- а. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон, улс орнуудын Үндсэн хуульд заасанчлан бусдын эрх, эрх чөлөөгөөр хязгаарлагдах (*энэ нь тухайн эрхийг хязгаарлаж байгаа бус хүрээг тогтоож байгаа хэрэг юм*);
- б. Төрийн болон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд хүний халдашгүй эрхийг хязгаарлах;
- в. Хүний эрхийг хамгаалж, хууль биелүүлэх зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд хүний халдашгүй эрхийг хязгаарлах;
- г. Дайны болон дайн бүхий байдал, онц байдал зарласан үед төр болон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн зарим

а\_\_\_\_\_

<sup>170</sup> Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтанд л захирагдана.

<sup>171</sup> Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй. Мөн хүний нэр алдар, нэр хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх үүрэгтэй.



хэсгийг (захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны болон орон байрны халдашгүй байдал) хуульд заасан хүрээнд, хуулиар тогтоосон журмын дагуу хязгаарлах тохиолдлууд байна.

Хүний халдашгүй эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулийн түвшинд тодорхойлогддог бол “хязгаарлалтын хязгаарлалт” нь хуулийн албадлага болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд тодорхойлогдоно. Онолын хувьд хязгаарлалтын хязгаарлалт гэдэг нь эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд тогтоодог хязгаарлалттай холбоотой ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, тус эрхийн хязгаарлалтыг дараах үндсэн хоёр хэсэгт авч үзэж болохоор байна:

- (1) Онцгой дэглэмийн үеийн хүний халдашгүй эрх;
- (2) Эрх зүйн зөрчлөөс үүдэн гарах халдашгүй эрхийн хязгаарлалт.

### ***Онцгой дэглэмийн үеийн хүний халдашгүй эрх:***

Юуны өмнө онцгой дэглэм гэдэгт онц<sup>172</sup> болон дайны<sup>173</sup> байдлыг ойлгох бөгөөд Монгол Улсад онцгой дэглэмийн үеийн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалтыг Онц байдлын тухай хууль, Дайны байдлын тухай хуулиар тус тус зохицуулна. Эрх зүйн онцгой дэглэмийн үед хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа халдашгүй эрх нь Үндсэн хуулийн агуулга, үзэл санаанд нийцсэн зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд тодорхойлогдоно.

Эрх зүйн онцгой дэглэмийн үед хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх бүрэн хязгаарлагдахгүй бөгөөд харин тус эрхийн бүрэлдэхүүний зарим хэсгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлана. Түүнчлэн ***хүний нууцын болон нэр төрийн халдашгүй эрх, бие махбодын халдашгүй эрхийг ямар ч тохиолдолд хэн ч хязгаарлах эрхгүй байдаг онцлогтой.*** Харин халдашгүй, чөлөөтэй байх эрхийг бүрдүүлж буй бусад элементүүдийн хувьд<sup>174</sup> халдашгүй эрхийн хязгаарлалт дараах байдалтай байна:

***Чөлөөтэй байх халдашгүй эрх:*** Эрх зүйн онцгой дэглэмийн үед хүнийг өөрийн эрх мэдэлгүйгээр, өөрийн болон бусдын эрхшээлд байлгаж болохгүй. Түүнчлэн онц болон дайны байдал тогтоосон ч хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, эх орноос нь буюу оршин сууж байгаа газраас нь хөөн зайлуулахыг шууд хориглоно. Харин эрх зүйн онцгой дэглэмийн үед хүний зарим чөлөөт үйлдлийг шууд хориглоно. Тухайлбал, ажил хаях, зохих зөвшөөрөлгүйгээр хурал, цуглаан, жагсаал, нийтийг хамарсан арга хэмжээ зохиох, ороцлох, ажилтан, албан хаагчдыг өөрсдийнх нь хүсэлтээр ажлаас өөрчлөх, халахыг хориглоно. Мөн тодорхой нутаг дэвсгэрт зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, орох гарах, аж төрөхөд аюултай нутаг дэвсгэрээс түр нүүлгэн шилжүүлэх, хорио цээр тогтоох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хязгаарлана. Түүнчлэн эрх бүхий төрийн тусгай албан хаагч сэжиг бүхий хүнийг баривчлах, саатуулах, үзлэг хийх эрхтэй.

а\_\_\_\_\_

<sup>172</sup> **МУҮХ-ийн 25.2.** Дараах онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:

1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2/ Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон.

<sup>173</sup> **МУҮХ-ийн 25.3.** Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.

<sup>174</sup> Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ хот. 2002 он. 90-101 дэх тал.



*Бие махбодийн халдашгүй эрх:* Эрх зүйн онцгой дэглэмийн үед тогтоосон тодорхой журмыг сахиулахын тулд хүний бие махбодод шууд хүч хэрэглэх байдлаар халдахыг улс орнууд хуулиар хориглодог. Олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйн нийтлэг жишгээр эрх зүйн онцгой дэглэм тогтоосон үед ч бие махбод халдашгүй дархан байна.

*Орон байрны халдашгүй байдал:* Орон байрны халдашгүй эрх нь хүний өөрийн орон зай, ахуйтай байх, үр удмаа үлдээх, нэр алдар, нэр хүнд болон хувийн нууцтай байх гэсэн жам ёсны хүснл зоригоос эхтэй учир эрх зүйн онцгой дэглэмийн үед төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хүний хууль ёсоор ажиллаж, амьдарч байгаа орон байрыг зөвхөн нөхөх олговортойгоор ашиглаж болно. Хэнийг ч хүн ёсноос гадуур орох оронгүй болгож үл болно. Харин улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийтийн аюулгүй байдлыг хамгаалах шаардлагаар хуулийн дагуу орон байрыг нөхөх олговортойгоор ашиглах, үзлэг нэгжлэх хийх, дайчлан авах, сонсох болон харах техник хэрэгсэл суурилуулах, ажиглалт хийж болох бөгөөд бусад тохиолдолд хүний орон байр халдашгүй дархан байна.

*Өмчийн халдашгүй эрх:* Мөн чанарын хувьд хүний хувийн өмч халдашгүй учраас хэний ч эд хөрөнгийг эрх зүйн онцгой дэглэмийн үед ч *дураар* хураах болон дайчлан авахыг хориглодог. Гэхдээ онцгой дэглэмийн үед төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, техник болон хүнс тэжээлийн нөөцийг нөхөх олговортойгоор дайчлах эрхтэй. Ингэхдээ төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг заавал төлөх ёстой. Харин хуулиар эрх олгогдоогүй этгээд бол хэн ч бай хүний эд хөрөнгийг дайчлан авах замаар өмчийн халдашгүй эрхийг хязгаарлаж болохгүй. Учир нь онц байдал зарласан нь хүний өмчийн халдашгүй эрхийг шууд хязгаарлах хууль зүйн үндэслэл болохгүй. Түүнчлэн дайны болон онц байдлын аль ч үед, ямар ч тохиолдолд хүний өмчийн халдашгүй бүрэн эрх үгүйсгэгдэхгүй харин зарим материаллаг эд юмсыг өмчлөх эрх хязгаарлагдаж болдог.

### **Эрх зүйн зөрчлөөс үүдэн гарах халдашгүй эрхийн хязгаарлалт:**

Эрх зүйн аливаа зөрчлөөс үүдэн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хуулийн хүрээнд, хуулийн дагуу халдах, хязгаарлах нь *эрүүгийн байцаан шийтгэх, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны эрх зүйн журам зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажлын тухай* зэрэг холбогдох салбарын хуулиудаар нарийвчлан зохицуулагддаг. Түүнчлэн нарийн мэргэшил, мэдлэг шаардсан онцгой ажиллагаа байдаг. Бусад улс оронд ч ийм жишиг байх бөгөөд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хууль бусаар халдагчдад эрүүгийн, иргэний болон захиргааны шийтгэл ногдуулдаг.

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдаж болох эрх бүхий албан тушаалтан гэдэгт шүүх засаглалын эрх мэдлийг шууд хэрэгжүүлэгч болон энэ ажиллагаанд туслалцаа үзүүлж оролцох дор дурьдсан төрийн **тусгай албан тушаалтнууд** байна:

1. Бүх шатны шүүхийн шүүгчид;
2. Хэрэг бүртгэгчид;
3. Мөрдөн байцаагчид;
4. Прокурорууд<sup>175</sup>;

5. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хуульд заасан үндэслэл, хүрээ хязгаар, журмын дагуу хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлана. Бусдын халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах үндэслэл нь:

**Нэгт:** тухайн этгээд гэмт хэрэг, зөрчил гаргасан газар дээрээ баригдсан;

а

<sup>175</sup> Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/. УБ. 1999. 52 дахь тал.

**Хоёрт:** гэмт хэрэг үйлдсэн байж болох хангалттай сэжиглэл байгаа;

**Гуравт:** гэмт хэрэг үйлдсэн буюу зөрчил гаргасан нь нотлогдсон байх явдлууд юм.

Эдгээр үндэслэлүүд байгаа нь хангалттай тогтоогдоогүй нөхцөлд “байж магадгүй” гэх хардалтаар хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн аль нэгд халдаж огт болохгүй. Харин хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах эрх бүхий албан тушаалтан нь хангалттай үндэслэл байгаа нөхцөлд халдах ажиллагааг хийхдээ зөвхөн хуулиар тогтоосон журмыг чанд баримтална.

## **ХОЁР. ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

### **2.1.ХБНГУ-ын туршлага**

ХБНГУ-д хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, түүний хязгаарлалтыг Үндсэн хуулиар тогтоосон бөгөөд эрхийн зөрчлөөс үүсэн гарах бусад харилцааг хувийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, нийтийн эрх зүйн холбогдох (*Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний процессийн тухай хууль, захиргааны хууль болон салбарын бусад*) хууль тогтоомжоор зохицуулна.

**Эрхийн хамрах хүрээ:** Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээ, хязгаар болон хязгаарлалтын тухай асуудлыг ХБНГУ-ын Үндсэн хуулиар тунхагласан байдаг.

ХБНГУ-ын Үндсэн хууль нь “Үндсэн эрх” гэсэн нэгдүгээр бүлгээр эхлэх бөгөөд энэ бүлэгт хүний 17 төрлийн үндсэн эрхийг тунхагласан байдаг. Үүнээс онолын хувьд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн бүрэлдэхүүнд хамаарах дор дурьдсан 4 төрлийн эрхийг тунхагласан байна:

- (1) Хүний нэр төр;
- (2) Хувийн эрх чөлөө (бие махбодын халдашгүй эрх);
- (3) Захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны нууц;
- (4) Орон байрны халдашгүй байдал.

Энэ нь ХБНГУ-ын хувьд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээг тодорхойлсон бөгөөд манай улсаас онцлог нь дараах байдлаар тус тусад нь зохицуулсан байна:

### **Нэгдүгээр зүйл. Хүний нэр төрийн халдашгүй эрх (*Human dignity*)<sup>176</sup>**

- (1) Хүний нэр төрийн халдашгүй байна. Хүний нэр төрийг хүндэтгэх ба хамгаалах нь бүх төрийн эрх мэдэлтний үүрэг мөн.
- (2) Германы ард түмэн хүний эрхийг халдашгүй ба салшгүй хэмээн үзэж, ийнхүү хүлээн зөвшөөрөх нь аливаа нийгэм, даян дэлхийн энх тайван, шударга ёсны үндэс суурь хэмээн хүлээн зөвшөөрч байна.<sup>177</sup>
- (3) Дээр дурьдсан үндсэн эрх нь хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалд шууд хамаарах хуулийн хэрэгжилтээр хангагдана.

### **Хоёрдугаар зүйл. Хувийн эрх чөлөө (*Personal freedoms*)**

- (1) Хүн бүр өөрийгөө чөлөөтэй хөгжүүлэх эрхтэй ба ингэхдээ бусдын эрх, эсхүл Үндсэн хуулиар тогтоосон дэг журам, эсхүл ёс суртахууны хэм, хэмжээг зөрчиж үл болно.

а\_\_\_\_\_

<sup>176</sup> Албан бус орчуулга. Ж.Золмаагийн албан бус орчуулга болон ХБНГУ-ын англи хэл дээрх эхийг харьцуулан үзэв.  
<https://www.bundesregierung.de/Content/EN/StatistischeSeiten/breg/basic-law-content-list.html>

<sup>177</sup> Жам ёсны эрхийн онолын үндсэн үзэл санааг Үндсэн хуулиараа тунхагласан байна.

(2) Хүн бүр амьд явах эрхтэй бөгөөд хүний бие махбод халдашгүй байна. Хүний хувийн эрх чөлөө халдашгүй байна. Зөвхөн хуулийн дагуу эдгээр эрхэд халдаж болно.

**Аравдугаар зүйл. Захидал харилцаа, шуудан болон цахилгаан холбооны нууц** (*Privacy of correspondence, posts and telecommunications*)

- (1) Захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны нууц халдашгүй байна.
- (2) Зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.

Хэрэв хязгаарлалт нь чөлөөт ардчилсан үндсэн журам эсхүл Холбоо болон Мужийн оршин тогтнол, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн бол хуулийн дагуух хязгаарлалтын тухай холбогдох этгээдэд мэдэгдэхгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд шүүхийн ерөнхий журмаар шийдвэрлэхгүй харин хууль тогтоох байгууллагаас томилсон тусгай байгууллага хяналт тавина.

**Арван гуравдугаар зүйл. Орон байрны халдашгүй байдал** (*Inviolability of the home*)

- (1) Орон байр халдашгүй байна.
- (2) Нэгжлэг хийх зөвшөөрлийг гагцхүү шүүхээс олгох бөгөөд хэрэв аюул занал шууд тулгарсан бол хуулиар тогтоосон эрх бүхий бусад байгууллагаас зөвхөн тогтоосон журмын дагуу нэгжлэг хийнэ.
- (3) Хэрэв хэн нэгэн этгээд хуулиар тодорхойлсон гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй тохиолдолд мөрдөн шалгах бусад аргыг хэрэглэхэд харьцангуй хүндрэлтэй эсхүл үр ашиггүй нь тогтоогдвол гэм бурууг нотлох, гэмт хэргийг мөрдөн шалгах зорилгоор шүүхийн шийдвэрээр сэжигтний орон гэр, ажлын байранд сонсох төхөөрөмжийн техник хэрэгсэл суурилуулж болно. Зөвшөөрлийн хугацаа хязгаартай байна. Журмыг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр тогтооно. Яаралтай тохиолдолд нэг шүүгч дангаар шийдвэр гаргаж болно.
- (4) Нийтийн аюулгүй байдал, ялангуяа олон нийтийн амьдралд ноцтой хохирол учруулах аюулыг арилгах, таслан зогсоох зорилгоор зөвхөн шүүхийн журмаар бусдын орон байр, ажлын байранд ажиглалтын техникийн арга хэрэгсэл ашиглаж болно. Яаралтай тохиолдолд хуулиар тогтоосон эрх бүхий бусад этгээд энэ төрлийн арга хэмжээг нэн дариу авч болох бөгөөд арга хэмжээ авсаны дараа шүүхийн шийдвэрийг цаг алдалгүй нөхөн авна.
- (5) Хэрэв тухайн орон байранд албан ёсоор оршин суугчдыг хамгаалах зорилгоор техник хэрэгсэл хэрэглэх бол уг арга хэмжээг хуулиар тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлнэ. Олж авсан мэдээллийг зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх зорилгоор, эсхүл аюулаас зайлсхийх зорилгоор хэрэглэнэ. Олж авсан мэдээллийг шүүхээр хууль ёсны болох нь тогтоогдсон тохиолдолд хэрэглэнэ. Яаралтай тохиолдолд шүүхийн шийдвэрийг нэн даруй гаргуулна.
- (6) Холбооны Засгийн газар нь энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасан техник хэрэгсэл хэрэглэсэнтэй холбоотой мэдээллийг жил тутам Бундестагт тайлагнах бөгөөд энэ зүйлийн (4) дэх хэсэгт заасны дагуу Холбооны харьяалах шүүхийн зөвшөөрөл авсан байх шаардлагатай.
- (7) Орон байрны халдашгүй эрхийн хязгаарлалт нь зөвхөн нийтэд болон хувь хүний амьдралд тулгарсан аюулыг арилгах, эсхүл олон нийтийн аюулгүй байдал, нийтээр дагаж мөрдөх дэг журамд учирсан ноцтой хор аюулыг арилгах, голомтот халдварт өвчинтэй тэмцэх, хүүхэд залуусыг эрсдэлээс хамгаалах тохиолдолд зөвшөөрөгдөнө.

**Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт:** ХБНГУ-ын Үндсэн хуульд үндсэн эрхийг “хасах”, үндсэн эрхийг “хязгаарлах” асуудлыг тусад нь хуульчилснаараа онцлог. Үндсэн эрхийг хэр хэмжээнд хасахыг Үндсэн хуулийн шүүх тогтоох бөгөөд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхээс зөвхөн захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны нууцын халдашгүй байдлыг хасч болдог байна. Гэхдээ зөвхөн Үндсэн хуулиар өөрт олгогдсон **эрхээ урвуулан ашиглах замаар чөлөөт ардчилалын суурь зарчмыг зөрчсөн** гэх үндэслэлээр дор дурьдсан эрхийг хасна.

#### **Арван наймдугаар зүйл. Үндсэн эрхээ хасуулах (*Forfeiture of basic rights*)**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялангуяа хэвлэлийн эрх чөлөө (5-р зүйлийн 1-р заалт), багшлах (5 дугаар зүйлийн 3 дахь заалт), хурал цуглаан хийх (8-р зүйл), эвлэлдэн нэгдэх (9-р зүйл), захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны нууц (10-р зүйл), өмчлөх (14-р зүйл), эсхүл орогнох эрх (16а зүйл)-ээ урвуулан ашиглаж чөлөөт ардчилалын үндсэн (суурь) зарчмыг зөрчсөн бол үндсэн эрхээ хасуулна. Үндсэн эрх хасах болон түүний хэр хэмжээг Холбооны Үндсэн хуулийн шүүх тогтооно.

ХБНГУ-ын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалтын тухайд Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд дараах байдлаар заасан:

#### **Арван есдүгээр зүйл. Үндсэн эрхийн хязгаарлалт – хууль зүйн хамгаалалт (*Restriction of basic rights - Legal remedies*)**

- (1) Энэхүү Үндсэн хуульд заасны дагуу үндсэн эрх нь хуулиар хязгаарлагдаж болно. Хүний үндсэн эрхийг хязгаарласан хууль нь тодорхой нэг тохиолдолд хэрэглэх бус нийтлэг шинжтэй байх ба аль зүйлд заасан үндсэн эрхэд нөлөөлөхийг хуульд тусгайлан заана.
- (2) Үндсэн эрхийг хязгаарлахдаа үндсэн хуулийн агуулга, мөн чанарыг хөндөж үл болно.
- (3) Үндсэн эрхүүд нь жам ёсны эрхийн агуулгаар хүлээн зөвшөөрөгдсөн хүрээндээ дотоодын хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.
- (4) Төрийн эрх бүхий этгээд хэн нэгэн хүний эрхийг зөрчсөн тохиолдолд тэрээр шүүхэд хандах эрхтэй. Хэрэв хэргийн тусгай харьяалалыг тогтоогоогүй бол шүүхийн ердийн журмаар шийдвэрлэнэ. Аравдугаар зүйлийн 2 дахь заалтын 2 дугаар догол мөр<sup>178</sup> энэ заалтаар хөндөгдөхгүй.

## **2.2. ОХУ-ын туршлага**

ОХУ-ын Үндсэн хуулийн холбогдох хэсгээс үзэхэд хүний эрхийг “хүний эрх” болон “иргэний эрх, эрх чөлөө” гэсэн хоёр хэсэгт авч үзсэн байдаг. Тус улсын Үндсэн хуулийн “Хүний болон иргэний эрх, эрх чөлөө” гэх хоёрдугаар бүлэгт хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг дор дурьдсан байдлаар хуульчилсан:

#### **Хорин нэгдүгээр зүйл (*нэр төрийн болон бие махбодын халдашгүй эрх*)**

1. Хүний нэр төрийг Төрөөс хамгаална. Хүний нэр төрийг гутаан доромжилж үл болно.
2. Хэнийг ч эрүүдэн шүүх, хэрцгий догшин хандах, гутаан доромжлох, шийтгэхийг хориглоно. Хэнийг ч өөрийнх нь сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлэгийн, шинжлэх ухааны болон бусад туршилтад оруулахыг хориглоно.

а

<sup>178</sup> Захидал харилцаа, шуудан, цахилгаан холбооны нууц.

### **Хорин хоёрдугаар зүйл** (хувийн эрх, эрх чөлөөний халдашгүй эрх)

1. Хүн бүр хувийн халдашгүй эрх<sup>179</sup> болон эрх чөлөөтэй<sup>180</sup> байх эрхтэй.
2. Баривчлах, түр саатуулах болон цагдан хорих ажиллагааг зөвхөн шүүхийн шийдвэрээр зөвшөөрнө. Шүүхийн шийдвэргүйгээр хүнийг 48 цагаас дээш хугацаагаар хорьж болохгүй.

### **Хорин гуравдугаар зүйл** (хувийн амьдрал, нэр төр, алдар хүндийн болон захидал харилцаа, шуудан цахилгаан холбооны халдашгүй эрх)

1. Хүн бүр өөрийн хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, өөрийн нэр төр, алдар хүндийг хамгаалах эрхтэй.
2. Хүн бүр захидал харилцаа, телефон яриа, шуудан, цахилгаан холбоо болон бусад харилцааны нууцлалыг хадгалах эрхтэй. Энэ эрхийг зөвхөн шүүхийн шийдвэрээр хязгаарлана.

### **Хорин дөрөвдүгээр зүйл** (хувийн амьдралын халдашгүй эрх)

1. Өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэн нэг хүний хувийн амьдралын мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглахыг хориглоно.
2. Хуульд өөрөөр заагаагүй бол хүн бүр өөрийн эрх, эрх чөлөөнд шууд нөлөөлж буй баримт бичиг, материалыг олж авах эрхтэй бөгөөд төрийн болон орон нутгийн байгууллагууд, түүний албан тушаалтнууд тус бичиг баримт, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

### **Хорин тавдугаар зүйл** (орон байрны халдашгүй байдал)

1. Орон байр халдашгүй байна. Холбооны хуулиар тогтоосон, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэхээс бусад тохиолдолд хэн ч өөрийн хүсэл зоригийн эсрэг хэнийг ч өөрийн орон байранд нэвтрүүлэхгүй байх эрхтэй.

**Эрхийн хамрах хүрээ:** ОХУ-ын Үндсэн хуульд жам ёсны эрхийн онолын хувьд хүний “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийг бүрдүүлдэг эрхийг тус тусад нь хуульчилсан байх бөгөөд түүнээс үзэхэд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хүрээ нь:

- (1) нэр төрийн халдашгүй эрх;
- (2) бие махбодын халдашгүй эрх;
- (3) хувийн эрх, эрх чөлөөний халдашгүй эрх;
- (4) хувийн амьдрал болон захидал харилцаа, шуудан цахилгаан холбооны халдашгүй эрх;
- (5) хувийн амьдралын халдашгүй эрх;
- (6) орон байрны халдашгүй эрхийг хамарч байна.

**Эрхийн хязгаарлалт:** ОХУ-ын Үндсэн хуульд зааснаар тодорхой гурван нөхцөлд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болох бөгөөд тэгэхдээ хүний эрхийн хязгаарлалт үр нөлөөтэй байх цаг хугацаа, хүрээг тогтоох ёстой байдаг. Түүнчлэн ямар ч нөхцөлд хязгаарлаж үл болох зарим эрхүүд байх бөгөөд тэдгээрийг Үндсэн хуульд нэг бүрчлэн заасан байна. Тухайлбал:

### **Тавин зургадугаар зүйл** (Эрхийн хязгаарлалт)

а \_\_\_\_\_

<sup>179</sup> personal inviolability.

<sup>180</sup> freedom.



1. Холбооны Үндсэн хуулийн дагуу онц байдлын үед, эсхүл иргэдийн аюулгүй байдлыг хангах болон үндсэн хуулийн дэг журмыг хамгаалахын тулд хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болох бөгөөд хязгаарлалтын хүрээ, хугацааг тодорхойлно.

3. Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 20, 21, 23 (1), 24, 28, 34 (1), 40(1) болон 46-54 дугаар зүйлүүдэд тодорхойлсон эрх, эрх чөлөөг хязгаарлаж болохгүй.

Үндсэн хуульд заасны дагуу хүний зарим эрх, эрх чөлөөг хэзээ ч, ямар ч нөхцөлд хязгаарлаж болохгүй бөгөөд энэ нь жам ёсны эрхэд хамаарах эрх байна. Тухайлбал, *амьд явах эрх* (ҮХ §20), *хүний нэр төрийн болон бие махбодын халдашгүй эрх* (ҮХ §21), *хүний хувийн болон хувийн амьдрал, гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх* (ҮХ §23.1), *хувийн амьдралын халдашгүй эрх* (ҮХ §24), *шашин шүтэх эс* (ҮХ §28), *өөрийн ур чадварыг чөлөөтэй ашиглах эрх* (ҮХ §34.1), *хүн бүр орон байртай байх эрх* (ҮХ §40.1), *эрх, эрх чөлөөгөө шүүхээр хамгаалуулах эрх* (ҮХ §46), *хууль зүйн туслалцаа авах эрх* (ҮХ §48), *гэм бурууг нь шүүхээр тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх* (ҮХ §49) зэрэг 16 эрхийг хязгаарлаж үл болно. Хязгаарлаж үл болох 16 эрхэд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн бүрэлдэхүүнд багтаж буй 6 эрхээс 4 эрх нь хамаарч байна.

**Тухайн харилцааг зохицуулж буй эрх зүйн акт:** ОХУ-д хүний халдашгүй, чөлөөтэй эрхтэй холбоотой харилцааг Үндсэн хууль, ОХУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ<sup>181</sup> соёрхон баталсан протокол, Иргэний хууль, Хувийн мэдээллийн тухай хууль<sup>182</sup>, Иргэний эрх зүйн байдлын тухай хууль<sup>183</sup>, Иргэний эрүүл мэндийг хамгаалах тухай хууль<sup>184</sup>, Харилцаа холбооны тухай хууль<sup>185</sup>, Хууль зүйн мэргэжил, өмгөөллийн тухай хууль<sup>186</sup>, Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хууль<sup>187</sup>, Мэдээлэл, Мэдээллийн технологи болон мэдээллийн хамгаалалтын тухай хууль<sup>188</sup>, Захиргааны зөрчлийн тухай хууль<sup>189</sup>, Эрүүгийн хуулиар зохицуулна.

### **2.3. АНУ-ын туршлага**

1776 онд Виржиниа муж улсын улс төрч Жорж Масон Америкын анхны эрхийн тунхаглал болох “Виржиниагийн эрхийн тунхаглал”-ын төслийг (*Virginia Declaration of Rights*) боловсруулсан байна. Тус эрхийн тунхаглалыг 1689 оны Английн эрхийн тунхаглал болон Ж.Локкийн зохиолуудад суурьлан боловсруулсан байна.

Виржиниагийн эрхийн тунхаглалын төслийн 12 заалтыг Конгресс хүлээн авсан бөгөөд 1791 оны 12 дугаар сарын 15-нд зохих тооны мужууд хүлээн зөвшөөрсөнөөр 10 заалтыг нь Үндсэн хуульд нэмэлт болгон оруулсан байна. Тус нэмэлтийг Эрхийн тунхаглал<sup>190</sup> гэж нэрлэдэг.

АНУ-д хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг “privacy” гэх хууль зүйн нэр томъёогоор илэрхийлэх бөгөөд энэ нь хүний хувийн мэдээлэл, хувийн амьдралын болон гэр бүл, шуудан, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг илэрхийлнэ. Харин хүний нэр

а\_\_\_\_\_

<sup>181</sup> Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенци, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт.

<sup>182</sup> Federal Law No 152-FZ of the Russian Federation on Personal Data.

<sup>183</sup> Federal Law No 143-FZ of the Russian Federation on Acts of Civil Status.

<sup>184</sup> Federal Law No 323-FZ of the Russian Federation on the Health Care of Citizens.

<sup>185</sup> Federal Law No 126-FZ of the Russian Federation on Communication.

<sup>186</sup> Federal Law No 63-FZ of the Russian Federation on the Legal Profession and Advocacy in the Russian Federation.

<sup>187</sup> Law No 2124-1-FZ of the Russian Federation on Mass Media.

<sup>188</sup> Federal Law No 264-FZ of the Russian Federation on Information, Informational Technologies and Protection of Information

<sup>189</sup> Code of Administrative Violations.

<sup>190</sup> Bill of rights of the United States of America (1791).

<http://www.billofrightsinstitute.org/founding-documents/bill-of-rights/>



төрийн халдашгүй байдлыг “human dignity” гэх хууль зүйн нэр томъёогоор илэрхийлдэг ч Үндсэн хуульд тусгайлан заагаагүй байна.

АНУ-ын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “*Муж улс бүрийн иргэн бусад Муж улсын иргэдийн нэгэн адил бүх эрх ямба, халдашгүй эрхийг эдлэнэ.*” гэж заасан.

Мөн хүний эрхийг тунхагласан Үндсэн хуулийн нэмэлтүүдэд (эрхийн тунхаглал) хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг дор дурьдсанаар тунхагласан:

### **Гуравдугаар нэмэлт**

Энх тайвны цагт нэг ч цэрэг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн айлын гэр оронд байрлан суух ёсгүй, дайны үед болох боловч гагцхүү хуулиар тогтоосон журмын дагуу байрлана.

### **Дөрөвдүгээр нэмэлт**

Хувь хүн, орон байр, бичиг барим, эд хөрөнгө халдашгүй байх ард түмний эрхийг үндэслэлгүй нэгжлэг хийх буюу баривчлан зөрчиж болохгүй бөгөөд зөвшөөрлийн бичгийг тангараг буюу албан ёсны мэдэгдлээр баталгаажуулахгүйгээр нэгжлэг хийх газар, баривчлах хүн, хураах эд зүйлийг тодорхой заасан хангалттай үндэслэлгүйгээр олгож үл болно.

### **Тавдугаар нэмэлт**

... Үйлдсэн эрх зүйн нэг зөрчлийн төлөө хэний ч амь насыг хохироох, **бие махбодыг зовоох** ял ногдуулахаар заналхийлж, хоёр удаа шийтгэж болохгүй. ... Зохих ёсны эрх зүйн байцаан шийтгэх ажиллагааны журамгүйгээр хүний амь насыг бусниулж, эрх чөлөөг нь хасаж, өмчийг нь хурааж болохгүй. Хувийн өмчийг шударга нөхөн олговор, үнэгүйгээр нийгмийн хэрэгцээнд хураан авч болохгүй. гэж тус тус заасан.

Олон улсын эрх зүйн хэм, хэмжээгээр тодорхойлогдсон хүний бүхий л эрхээс хүний хувийн халдашгүй эрх, түүний хүрээ хязгаарыг тодорхойлох нь хамгийн хэцүү байдаг. АНУ-д хувь хүний халдашгүй эрх нь үндсэн эрх учраас хүн бүр чухалчлан үздэг бөгөөд түүний бүрдэл нь библийн сургаалиас эхтэй гэж судлаачид тодорхойлдог байна. Мөн хувийн халдашгүй эрхийн хамгаалалт нь эртний Еврей, сонгодог Грек болон эртний Хятад улсын соёлоос үндэслэсэн гэж үздэг. АНУ-д хувь хүний хувийн халдашгүй эрхийг дараах агуулгаар авч үзнэ:

- 1) **Мэдээллийн халдашгүй эрх:** зээлийн мэдээлэл, эмнэлгийн бүртгэл зэрэг хувь хүний мэдээлэл хамаарах бөгөөд хувийн мэдээллийг цуглуулах, зохицуулахтай холбоотой дүрэм журмыг төрөөс тусгайлан тогтооно;
- 2) **Бие махбодын халдашгүй эрх:** хэн ч хүний биед өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр халдах эрхгүй бөгөөд тухайн хүний зөвшөөрөлгүйгээр хавдрын шинжилгээ, мансууруулах бодисын шинжилгээ хийх, хагалгаанд оруулахыг хориглоно.
- 3) **Харилцаа холбооны халдашгүй эрх:** шуудан, телефон, цахим шуудан болон харилцаа холбооны бусад хэлбэр нь халдашгүй бөгөөд аюулгүй байна.
- 4) **Орон зайн халдашгүй эрх:** хэн ч хүний хувийн дотоод орчин болон ажлын байр гэх мэт бусад хүрээлэн буй орчинд нэвтрэх, халдан орох эрхгүй.

**Тухайн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин:** АНУ-д хүний бүхий л эрх нь “хувийн халдашгүй эрх”-д хамаарна гэж үздэг үзэл хандлага давамгайл байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч **хувийн** болон **гэр бүлийн амьдралд** хөндлөнгөөс дур мэдэн оролцох, **орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд** нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.” гэж заасан нь АНУ-д мөн адил үйлчилнэ.

Түүнчлэн бүс нутгийн түвшинд “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах” тухай 1950 оны

конвенцын 8 дугаар зүйлд заасны дагуу тус эрх хэрэгжинэ. Тус заалт нь:

- (1) Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байр, захидал харилцааг хүндэтгэн үзүүлэх эрхтэй гэж заасан.

Түүнчлэн АНУ эрх зүйн бүлийн хувьд англо-саксоны эрх зүйн бүлд хамаарах бөгөөд шүүхийн прецедент нь эрх зүйн эх сурвалж болдогоос хамаарч хүний халдашгүй эрхийн эрх зүйн орчны хувьд онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, хүний халдашгүй эрхтэй холбоотой харилцааг 1964 оны Иргэний эрхийн тухай хууль болон АНУ-ын Дээд шүүхийн практик, жишгийн эрх зүйгээр зохицуулдаг байна.

### **ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОНОЛ ДАХЬ “ХУВЬ ХҮН”, “БИЕ ХҮН” ГЭХ ОЙЛГОЛТУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ, ЯЛГАА**

“Бие хүн” болон “хувь хүн” гэх ойлголтын талаар маш олон төрлийн тодорхойлолт байдаг бөгөөд эрх зүйн онол болон хууль зүйн шинжлэх ухаан талаас нь дараах байдлаар тодорхойлсон байна.

*Эрх зүйн ерөнхий тайлбар толиудад:*

“Хувь хүн” (*individual person; natural (physical, private) person*) гэж хамтын бүрэлдэхүүн болсон хуулийн этгээдээс ялгагдах иргэний эрх зүйн субъект болох иргэнийг ойлгоно.

“Бие хүн” (*personal*) гэж нийгмийн харилцааны идэвхтэй субъект, нийгмийн гишүүн болохыг илтгэсэн хүний эрхийн ухагдахуун. Бие хүнийг аливаа хувь хүнээр бус харин өөрийн ухамсар нь хангалттай хөгжсөн байхаар ойлгодог. Нөгөө талаас бусадтай харилцан, хамтран ажиллаж, амьдрах чадвар төлөвшсөн хүн гэж тодорхойлжээ.<sup>191</sup>

Блэкийн хууль зүйн толь бичигт “Хувь хүн” (*individual person; natural person*) гэж аливаа бүлэг, ангиас ялгагдах нэг хүнийг илэрхийлэх бөгөөд хүний хувийн шинжийг илтгэх ойлголт. Түүнчлэн нөхөрлөл, корпораци, нийгэмлэгээс ялгагдах байгалийн уугуул шинжийг агуулсан хүнийг хувь хүн гэнэ” гэжээ.

Эрх зүйн ерөнхий онолд “бие хүн”-ийг эрх зүйн харилцааны нэгж субъект гэж үздэг бөгөөд бие хүн нь тухайн улсын иргэн, гадаадын иргэн, хоёрдмол иргэний харьяалалтай болон харьяалалгүй хүн байна<sup>192</sup> гэжээ. Өөрөөр хэлбэл иргэн гэдэг нь хуулиар тогтоосон насанд хүрсэн аль нэг улсад харьяалагдаж иргэний харьяалал олж авсан, эрх зүйн чадвар, чадамжтай байх шаардлага хангасан этгээдийг ойлгоно<sup>193</sup> гэжээ.

Харин жам ёсны эрхийн онолын үүднээс хүн бүр эрх зүйн этгээд байх бөгөөд эрх зүйн харилцаанд бие даан оролцох боломж, чадвар хязгаарлагдмал байдгаас үүдэн тухайн харилцааны субъект байх нөхцөл нь бүрэн хангагдаагүй байдаг.

а

<sup>191</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007 он. 82, 538 дахь тал.

<sup>192</sup> Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. 2017 он. 276 дахь тал.

<sup>193</sup> МУИС-ХЗС Эрх зүйн үндэс. 2015 он. 14 дэх тал.

**“Хувь хүн” болон “бие хүн” ялгаа**

**Хувь хүн:**

- хүн гэх байгалийн уугуул шинжийг агуулагч нэгж;
- хүн бүр хувь хүн байна;
- хүн гэх байгалийн амьтны шинжийг илэрхийлэх ойлголт
- эрх зүйн чадвар, чадамж шаардахгүй.

**Бие хүн:**

- нийгмийн харилцааны идэвхтэй субъект;
- хууль зүйн насанд хүрсэн байх;
- эрх зүйн чадвар, чадамжтай байх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### **Олон улсын гэрээ, конвенци:**

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенци;
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенци, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт.

### **Хуулиуд:**

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Иргэний хууль;
- Хувь хүний нууцийн тухай хууль;
- Гүйцэтгэх ажиллагааны тухай хууль;

### **Гадаад орны хуулиуд:**

- Constitution of the Russia.
- [https://www.constituteproject.org/constitution/Russia\\_2014?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en)
- Constitution of the Germany.
- [https://www.constituteproject.org/constitution/German\\_Federal\\_Republic\\_2014?lang=en](https://www.constituteproject.org/constitution/German_Federal_Republic_2014?lang=en)
- Constitution of the United State of America
- [https://www.constituteproject.org/constitution/United\\_States\\_of\\_America\\_1992?lang=en](https://www.constituteproject.org/constitution/United_States_of_America_1992?lang=en)
- Federal Law No 152-FZ of the Russian Federation on Personal Data.
- [https://iapp.org/media/pdf/knowledge\\_center/Russian\\_Federal\\_Law\\_on\\_Personal\\_Data.pdf](https://iapp.org/media/pdf/knowledge_center/Russian_Federal_Law_on_Personal_Data.pdf)
- Federal Law No 143-FZ of the Russian Federation on Acts of Civil Status.
- Federal Law No 323-FZ of the Russian Federation on the Health Care of Citizens.
- Federal Law No 126-FZ of the Russian Federation on Communication.
- Federal Law No 63-FZ of the Russian Federation on the Legal Profession and Advocacy in the Russian Federation.
- Law No 2124-1-FZ of the Russian Federation on Mass Media.
- Federal Law No 264-FZ of the Russian Federation on Information, Informational Technologies and Protection of Information
- Code of Administrative Violations.
- Bill of rights of the United States of America (1791).

### **Ном, зохиолууд:**

- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017.
- Д.Лүндээжанцан., Н.Жалбажав., Х.Сэлэнгэ., Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ., 2014.
- Х.Сэлэнгэ ба бусад. Эрх зүйн философи. УБ., 2013.
- Н.Лүндэндорж. JURISPRUDENCE Эрх зүй судлал: Философи, онол. УБ., 2011 он.
- С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2007.
- Г.Совд., Н.Жанцан., Ж.Амарсанаа., С.Жанцан. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000.
- Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2009 он. Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи.
- Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал. УБ., 2017. ҮХЦ.
- Монгол Улсын иргэний хуулийн тайлбар. УБ., 2005.

- Г.Совд. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх: харьцуулсан эрх зүй. УБ., 1999 он.
- Б.Бат-Эрдэнэ ба бусад. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй: Ерөнхий анги. УБ., 1996.
- Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. УБ., 2002.
- Ч.Нямсүрэн. Эрх зүйн үндэс. УБ., 2015.
- Эрх зүйн ерөнхий онол. МУИС-ХЗС. УБ., 2017.

**Цахим хаяг:**

- Privacy in the Russian legislation. <https://www.law.uw.edu/media/1394/russia-intermediary-liability-of-isps-privacy.pdf>
- An International Survey of Privacy Laws and Practice <http://gilc.org/privacy/survey/intro.html>
- Constitutional Dialogue and Human Dignity: States and Transnational Constitutional Discourse  
<https://scholarship.law.georgetown.edu/cgi/viewcontent.cgi?article=1112&context=facpub>

# 3 БҮЛЭГ

---

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

*Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D), Ц.Болормаа  
Д.Жигваагүнсэл, Б.Нандингэрэл,  
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

### АГУУЛГА

### УДИРТГАЛ

1. БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛС
2. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС
3. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС
4. БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС
5. БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС
6. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС
7. БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС
8. БҮГД НАЙРАМДАХ ГРЕК УЛС
9. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
10. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Энэхүү судалгааны захилгад дурьдсан парламентын засаг бүхий Словак, Латви, ХБНГУ, Австри, Болгар, Польш, Грек, Финланд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт хийгээд улс төрөөс хэрхэн ангид байдаг талаар, ерөнхийлөгчийн засаг бүхий БНСУ, Турк Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно. Мэдээллийн хайлт хийх явцад БНСУ, Турк Улс нь улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан холбогдох мэдээ, мэдээллийг нийтэд ил болгоогүй байна.

Дэлхийн орнуудын Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын хувьд харьцангуй ижил төстэй байдаг бол Ерөнхийлөгч буюу төрийн тэргүүний ажлын аппарат нь улс орнуудад ялгаатай байдлаар зохион байгуулагдаж байна. Энэ нь тухайн улсын хууль эрх зүйн орчин, уламжлал, тухайн үеийн төрийн тэргүүний хэрэгцээ, шаардлага, хувь хүнээс хамаардгаараа онцлог юм. Хэдийгээр бүтэц, зохион байгуулалтын хувьд ялгаатай байгаа ч улс орнуудын төрийн тэргүүний ажлын аппарат нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Стратеги төлөвлөгөө, төлөвлөлт;
- Бодлогын уялдаа холбоог хангах;
- Хууль, эрх зүй;
- Олон нийттэй харилцах;
- Зарим хяналтын чиг үүрэг;
- Бодлогын шинжилгээ, зөвлөгөө;
- Техник үйлчилгээ;
- Дотоод ажлын удирдлага.

Ерөнхийлөгчийн баг (personal staff) нь бүтэц, орон тооны хувьд нэлээдгүй ялгаатай байж болох ч дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

- Улс төрийн болон бодлогын зөвлөх;
- Төрийн тэргүүний үг бэлдэх;
- Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах.

Судлаачид Төрийн тэргүүний ажлын аппаратын институцийн ой санамж алдагдахаас сэргийлж улс төрийн томилгоо болон төрийн албан хаагчдыг хослуулсан холимог бүтэц, бүрэлдэхүүнтэй байх хувилбарыг илүүд үздэг байна.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсын хувьд Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, зөвлөхүүд нь төрийн **улс төрийн албан тушаалтан** юм. Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд **төрийн жинхэнэ албан хаагчийн** үйл ажиллагаанд хориглох зүйлсийг хуульчилсны дотор “15.1.1. албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар **нам**, төрийн бус болон шашны **байгууллагын үйл ажиллагаанд** төрийн албан хаагчийн хувьд оролцох;”-ыг хориглосон байдаг. Харин “**намын үйл ажиллагаанд оролцох**”-ыг хориглосон энэхүү хориг нь **улс төрийн** болон **үйлчилгээний албан хаагчид** хамаарахгүй юм.

Гэвч, “...намын үйл ажиллагаанд оролцох...” гэдэг нь намын дотоод үйл ажиллагаанд оролцох эрх нь нээлттэй гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд харин улс төрийн албан хаагч “төрийн үйл хэргийг удирдан явуулахдаа улс төржих эрх нээлттэй” гэсэн агуулгыг илэрхийлэхгүй юм.

Түүнчлэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд нийтийн албан дахь **төлөөлөлтэй холбоотойгоор** албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг, албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж

ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно гэж заасан байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь

төрийн Үйлчилгээний албаны ангилалд багтах байнгын төрийн албан хаагч байх бөгөөд улс төрийн хувьд төвийг сахих зарчмыг баримтална (Словак), Төрийн дээд байгууллагуудын Ажлын албаны дарга, түүний орлогч зэрэг албан тушаалтан нь улс төрийн нам, улс төрийн намын эвслийн ажил хавсран гүйцэтгэхийг хориглоно (Литва), Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь төрийн улс төрийн албан хаагч тул шалтгаан заахгүйгээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөн огцрох боломжтой (ХБНГУ), Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь нийтийн албан тушаалтан байна (Болгар).

Дэлгэрүүлэн судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ерөнхийлөгчийн ажлын албаны эрх зүйн үндсийг тогтоосон байдаг. Хуульд<sup>194</sup> “Ерөнхийлөгчийн ажлын алба нь тамгын газар мөн” гэж заасан бөгөөд тамгын газрын дүрэм, бүтцийг зардлынхаа төсөвт багтаан Ерөнхийлөгч баталж тогтооно.


Ерөнхийлөгч нь:

- ✚ Тамгын газрын дарга;
- ✚ зөвлөхийг томилно.

Ерөнхийлөгчийн зөвлөхүүд нь Ерөнхийлөгчид захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд Тамгын газарт харьяалагдахаар хуульд заажээ. Түүнчлэн Ерөнхийлөгч үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж болох бөгөөд шаардлагатай гэж үзсэн бусад асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хамтлагаар судалгаа хийлгэж болно.

2017 оны байдлаар Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна:

**Зураг 1: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч**



<sup>194</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль. 1993 он.

Мөн Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан нь Тамгын газрын дарга, зөвлөхөөс бусад ажилтныг ажлаас нь өөрчлөх үндэслэл болохгүй.” гэж заасан ч, 17 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Тамгын газрын ерөнхий менежер нь **Тамгын газрын орон тоо**, цалингийн санг Ерөнхийлөгчийн зардлын төсөвт багтаан **тогтооно**.” гэж заасан нь хуулийн зөрчлийг<sup>195</sup> үүсгэж байна.

### **Ерөнхийлөгчийн Тамгын газрын удирдлага улс төрөөс ангид байх тухай:**

2012 онд шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн төрийн албан тушаалыг:

- 1) төрийн улс төрийн;
- 2) төрийн захиргааны;
- 3) төрийн тусгай;
- 4) төрийн үйлчилгээний гэж ангилсан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд Төрийн **улс төрийн албан тушаалыг** тодорхойлохдоо “*6.1.Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх*” албан тушаалтан байна гээд хуулийн:

6.1.9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

6.1.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхийг төрийн улс төрийн албан тушаалд нэрлэн заажээ.

Гэвч, Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгч нь ард түмнээс шууд сонгогдох бөгөөд “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэж тодорхойлсноос үүдэн Ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа улс төрийн намын харьяаллаас түдгэлзэх хууль зүйн үр дагавар үүсдэг. Иймд Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга, зөвлөхүүд нь улс төрийн сонгуулиар сонгогдож буй албан тушаалтанд нь “өөрт нь үйлчлэх” гэдэг агуулгаар улс төрийн албан тушаалын ангилалд багтаж байгаа нь харагдаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд **төрийн жинхэнэ албан хаагчийн** үйл ажиллагаанд хориглох зүйлсийг хуульчилсны дотор “*15.1.1. албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар **нам**, төрийн бус болон шашны **байгууллагын үйл ажиллагаанд** төрийн албан хаагчийн хувьд оролцох;*”-ыг хориглосон байдаг. Харин “**намын үйл ажиллагаанд оролцох**”-ыг хориглосон энэхүү хориг нь **улс төрийн болон үйлчилгээний албан хаагчид** хамаарахгүй юм.

Гэвч, “...намын үйл ажиллагаанд оролцох...” гэдэг нь намын дотоод үйл ажиллагаанд оролцох эрх нь нээлттэй гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд харин улс төрийн албан хаагч “төрийн үйл хэргийг удирдан явуулахдаа улс төржих эрх нээлттэй” гэсэн агуулгыг илэрхийлэхгүй юм.

Төрийн албаны тухай хуульд:

- ✚ ардчилсан ёс;
- ✚ шударга ёс;
- ✚ эрх чөлөө;
- ✚ тэгш байдал;
- ✚ үндэсний эв нэгдлийг хангах;

а

<sup>195</sup> “**Зөрчил**” гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг ойлгоно.

хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн гэж заасан.

Түүнчлэн, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх зорилго бүхий Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд нийтийн албан дахь **төлөөлөлтэй холбоотой дараах хязгаарлалтыг** хуульчилсан байдаг. Үүнд:

- Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно;
- Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно гэж заасан байна.

## **1. БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛС**

Бүгд Найрамдах Словак Улс нь парламентын засагтай ардчилсан улс бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалд хамаарна. Словакийн Ерөнхийлөгч нь бүх ард түмнээс шууд сонгогдох бөгөөд ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг таван жил тутам нэг удаа зохион байгуулна. Ерөнхийлөгчийг нэг удаа улируулан сонгож болно.

Словакийн Ерөнхийлөгчийн бүрэн эрх, статус болон Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа харилцааг Словакийн Үндсэн хуулийн 6 дугаар бүлгийн нэгдүгээр хэсэгт тодорхойлсон байдаг.

Словак Улс нь эрх зүйн тогтолцооны хувьд ромын эрх зүйн бүлд хамаарагдах бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд зөвхөн бичигдмэл хуулийг албан ёсны эх сурвалж гэж үздэг. Албан ёсны эх сурвалж гэж үздэг бичигдмэл хуулиудыг хууль зүйн хүчин чадлын хувьд “Кельзений хэм, хэмжээний пирамид”-ын зарчмаар системчилсэн байна. Үүнд:

- Үндсэн хууль ба Үндсэн хуульчилсан хуулиуд<sup>196</sup>;
- хуульд заасан журмын дагуу парламентын соёрхон баталсан олон улсын гэрээ, хэлэлцээр;
- парламентаас баталсан хуулиуд;
- үүсмэл хууль тогтоомж (засгийн газрын тогтоол, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас нийтэд хандан гаргасан эрх зүйн акт) гэсэн дараалалтай байна.

Энэхүү пирамидын доод шатлалын эрх зүйн актууд нь хамгийн дээд түвшний хуульд (Үндсэн хууль болон Үндсэн хуульчилсан хууль) нийцсэн байх ёстой. Үндсэн хууль болон Үндсэн хуульчилсан хуулиудыг Европын холбооны гишүүнчлэлийн асуудалтай холбоотойгоор өөрчилсөн бөгөөд үндэсний хууль тогтоомж нь Европын холбооны хууль тогтоомжтой зөрчилдвөл Европын холбооны хууль тогтоомж нь илүү хүчин чадалтай байна.

✓ Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, дотоод гадаадад улсаа төлөөлдгийн хувьд **улс төржилт, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхтай** холбоотой харилцааг Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хуулиудын нэг болох **“Төрийн албан тушаалтны үйл ажиллагаанд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай Үндсэн хуульчилсан хууль” (357/2004)**<sup>197</sup>-аар;

а

<sup>196</sup> “Үндсэн хуульчилсан хууль” гэж Үндсэн хуулийн хэмжээний хүчин чадалтай, нэмэлт өөрчлөлт оруулах тусгай дэг бүхий хууль тогтоомжийг ойлгоно.

<sup>197</sup> Constitutional Act on the Protection of Public Interest by the Performance of Offices of Public Officials No. 357/2004, as



✓ Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга нь төрийн үйлчилгээний албан хаагчийнхаа хувьд улс төрөөс ангид байх асуудлыг **Төрийн албаны тухай хуулиар**<sup>198</sup> тус тус зохицуулдаг байна.

Словакийн Үндсэн хуулийн 101 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу:

- **Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Словакийн төрийн тэргүүн байна;**
- **Ерөнхийлөгч нь дотоод, гадаадад Бүгд Найрамдах Словак Улсыг төлөөлнө;**
- **Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүн чанар, дотоод итгэл үнэмшлийн дагуу хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг журмаар хязгаарлахгүй** гэж Ерөнхийлөгчийн эрх зүйн статусыг тодорхойлжээ.

### **1.Бүгд Найрамдах Словак Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт**

Словакийн Ерөнхийлөгч нь Үндсэн хуулиар тодорхойлсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хоёр ажлын албатай байна:

- 1) Ерөнхийлөгчийн ажлын алба (Тамгын газар);
- 2) Ерөнхийлөгчийн цэргийн алба.

Ерөнхийлөгчийн ажлын алба (Тамгын газар) нь 1993 онд баталсан **Бүгд Найрамдах Словак Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны тухай**<sup>199</sup> хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулна.

Цэргийн алба нь **Бүгд Найрамдах Словак Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн Ерөнхийлөгчийн Цэргийн алба**<sup>200</sup>-ны тухай холбогдох зүйл заалтуудын дагуу зохион байгуулагдана.

а) **Ерөнхийлөгчийн цэргийн алба** нь Ерөнхийлөгчийг Бүгд Найрамдах Словак Улсын зэвсэгт хүчний “ерөнхий командлагч”-ийн албан үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх, Ерөнхийлөгчийн хүндэт харуулыг командлах, Бүгд Найрамдах Словак Улсын зэвсэгт хүчний тухай хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд мэргэжил, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

б) **Ерөнхийлөгчийн ажлын алба (Тамгын газар)** нь Бүгд Найрамдах Словак Улсын Ерөнхийлөгчөөс хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь:

- мэргэжил;
- зохион байгуулалт;
- техникийн туслалцаа үзүүлнэ.

Ажлын албаны үндсэн үүрэг нь дараах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Үүнд:

- Ерөнхийлөгчийг Бүгд Найрамдах Словак Улсын Үндсэн хуульд заасан чиг үүргээ Үндсэн хуульчилсан хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хэрэгжүүлэх;

---

amended by Constitutional Act No. 545/2005.

<sup>198</sup> Act of Civil Service 312/2001.


<sup>199</sup> Act No. 16/1993 Coll. on the Office of the President of the Slovak Republic.

<sup>200</sup> the Military Office of the President of the Slovak Republic, under of Act No. 321/2002 Coll. on the Armed Forces of the Slovak Republic

- Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн улс төрийн болон олон нийтийн үйл ажиллагааг Үндсэн хуульчилсан хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн явуулах нөхцөлийг тус тус бүрдүүлэх нь ерөнхийлөгчийн ажлын албаны үндсэн үйл ажиллагаа болно.

Түүнчлэн Ерөнхийлөгчийн ажлын албанаас үзүүлдэг бас нэг үйлчилгээ нь Ерөнхийлөгч болон түүний гэргийн Үндсэн хуулийн дагуух үйл ажиллагааг зохион байгуулах явдал юм. Мөн байгууллагын дүрэмд тусгайлан заасан мэргэжил, зохион байгуулалт, техникийн бусад туслалцаа үзүүлнэ. Тамгын газар нь (ажлын алба) нь Бүгд Найрамдах Словак Улсын төсвийн тухай хуулиар тусгайлан заасан төсөвт байгууллага бөгөөд хуулийн этгээд мөн. Ерөнхийлөгчийн ажлын алба нь дараах бүтэцтэй байна:

**Зураг 2: Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч<sup>201</sup>**



<sup>201</sup> <https://archiv.prezident.sk/index61e1.html?organisational-structure>

## 2.Ерөнхийлөгчийн тамгын газар, түүний удирдлагын үйл ажиллагаа улс төрөөс ангид байх эрх зүйн орчин

Словакийн Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар тус хуулийн үйлчлэлд хамаарах төрийн албыг дараах байдлаар ангилна:

- Бэлтгэл төрийн алба (*preparatory civil service*);
- Байнгын төрийн алба (*permanent civil service*);
- Түр төрийн алба (*temporary civil service*).

Харин парламентын гишүүд, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд, Дээд Аудитын ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, шүүгчид, прокурорууд, энэ хуульд заасан Үйлчилгээний албаны тухай бүлгийн 2 болон 4 дүгээр хэсэгт заагаагүй албан хаагч нарт төрийн албаны тухай хууль үйлчлэхгүй гэжээ.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн Үйлчилгээний алба<sup>202</sup>-нд хамаарах 11 төрлийн төрийн албыг нэр заан тоочсон бөгөөд тэдгээрийн нэг болох “*төрийн байгууллага, албан тушаалтны ажлын алба*” хэсэгт 6 байгууллагыг хуульчилсан байна:

**Энэ хуульд заасан Үйлчилгээний алба гэдэгт:**

1. яам болон бусад төрийн захиргааны төв байгууллага;
2. төрийн үйл хэргийг эрхлэн явуулдаг дараах байгууллага, албан тушаалтны ажлын алба:
  - парламентын ажлын алба;
  - ерөнхийлөгчийн ажлын алба;
  - дээд аудитын ажлын алба;
  - Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба;
  - шүүхийн ажлын алба;
  - Ерөнхий прокурорын ажлын алба, бүсийн прокурорын ажлын алба, Цэргийн дээд прокурорын ажлын алба, Дүүргийн Цэргийн прокурорын ажлын алба...

Дээрх хуулийн заалтын дагуу **Ерөнхийлөгчийн тамгын газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаалтан төрийн үйлчилгээний албан хаагч** байна. Үйлчилгээний албаны дарга<sup>203</sup>-ын албан тушаалын тодорхойлолтыг тус хуулийн 10.1-ээр тодорхойлж; Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга нь үйлчилгээний албан хаагч болохыг 10.4-т нэр заан хуульчилсан байна.

10.1-т “Энэ хуульд заасан Үйлчилгээний албаны дарга гэдэгт Үйлчилгээний албанд хамаарах бүх албан хаагчдын удирдах албан тушаалтныг ойлгоно. Албаны даргын (*Head of the Office*) албан тушаал нь **байнгын төрийн албаны** албан хаагч байна. Ажлын албаны дарга нь Үйлчилгээний албаны үйл ажиллагаа, төрийн албаны ажил эрхлэлттэй холбоотой харилцааг

а\_\_\_\_\_

<sup>202</sup> Service Office - (2) Civil service, for the purposes of this Act, shall be the performance of state administration tasks or the performance of state affairs in the scope of activity laid down by special regulations, carried out by a civil servant at a Service Office (7) in the relevant sector, if such performance of his/her tasks includes:

- a) management
- b) decision making
- c) inspection
- d) professional preparation of decisions
- e) professional preparation of legislation drafts and other generally binding legal regulations including professional activities related to discussion and approval of the above or
- f) professional preparation of requirements for the performance of state affairs.

<sup>203</sup> Head of Service Office. §10.

зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй” гэж заасан.

10.4-т “... **Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга нь Үйлчилгээний албаны дарга байна...**” гэж заасан нь Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга нь төрийн үйлчилгээний

Төрийн албанд:

- a) мэргэжлийн (professionalism);
- b) улс төрийн хувьд төвийг сахисан (political neutrality);
- c) үр нөлөөтэй (effectiveness);
- d) уян хатан (flexibility);
- e) алагчлалгүй байх (impartiality);
- f) ёс зүйтэй (ethics) байх зарчмыг баримтална гэж Төрийн албаны тухай хуульд заасан.

Словакийн Төрийн албаны тухай хуулийн иш татсан дээрх заалтуудыг нэгтгэн дүгнэвэл: **Ерөнхийлөгчийн ажлын алба (Тамгын газар)-ны дарга нь Словакийн төрийн Үйлчилгээний албаны ангилалд багтах байнгын төрийн албан хаагч байх бөгөөд улс төрийн хувьд төвийг сахих зарчмыг баримтлан албан үүргээ гүйцэтгэдэг байна.**



## **2. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС**

Латви нь Парламентын Бүгд найрамдах Улс бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалд хамаарна. Ерөнхийлөгч нь Сейм (Парламент)-ийн гишүүдийн 51-ээс багагүй гишүүдийн саналаар (энгийн олонхи) 4 жилийн хугацаатай сонгогддог. Ерөнхийлөгчийн бүрэн эрх, статус болон Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад харилцааг Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулна.

**Ерөнхийлөгчийн ажлын алба:** Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд юм. Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ажлын албаны дарга (*Head of the Chancery of the President*), Ажлын албаны даргын орлогч (*Deputy Head of the Chancery of the President*) болон бусад ажилтнаас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь орон тооны 6 зөвлөхтэй ба өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой чиглэлээр зөвлөл болон хороо байгуулж болно.

**Ерөнхийлөгчийн Ажлын алба, түүний удирдлагын үйл ажиллагаа улс төрөөс ангид байх эрх зүйн орчин:** Төрийн албан хаагчийн үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд 25 төрлийн төрийн өндөр албыг **төрийн албан хаагч** байна гэж тусгайлан заасан байдаг.<sup>204</sup> Тодруулбал, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгчийн Ажлын албаны дарга, түүний орлогч (*The Head of the Chancellery of the President and his or her deputy*) Сейм (парламент)-ийн Ажлын албаны дарга, түүний орлогч нар нь төрийн албан хаагч байна гэж заасан.

Мөн хуулийн 2 дугаар бүлгээр төрийн албан хаагчийн хавсран гүйцэтгэх (combining нэгтгэх) албан үүрэгт хязгаарлалт тогтоосон байна. Энэхүү хязгаарлалт нь:

-  ерөнхий хязгаарлалт (general restrictions);
-  тусгай хязгаарлалт (special restrictions) байна.

**Төрийн албаны чиг үүргийг хавсрахад** тавигдах тусгай хязгаарлалтыг тус хуулийн 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлд заасан бөгөөд 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт **төрийн улс төрийн албан тушаалд** хамаарах Сеймийн гишүүн, Ерөнхий сайд, Шадар сайд нар, Сайд нар, Онцгой үүрэг

а—

<sup>204</sup> Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials

гүйцэтгэгч сайд нар, Яамдыг хариуцсан Парламентын Нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалтнуудад дараах 5 төрлийн үүргийг хавсран гүйцэтгэхийг зөвшөөрсөн байна.<sup>205</sup> Үүнд:

- ✚ Сеймээс соёрхон баталсан хууль, Олон Улсын гэрээ, хэлэлцээрт тусгасан чиг үүрэг,
- ✚ Энэ хэсгийн 14 дэх <sup>206</sup> хэсэгт заасан албан тушаалтнаас бусад албан тушаалтан нь өөрийн чиг үүрэгт харьяалагдах үйлдвэрчний эвлэл, эвсэл, холбоо, улс төрийн нам, улс төрийн намын эвсэл, шашны байгууллагын ажил;
- ✚ Багшлах, эрдэм шинжилгээний ажил, шинжлэх ухааны доктор, мэргэжлийн спорт, бусад бүтээлч ажил;
- ✚ Засгийн газрын тогтоол, шийдвэр, Сейм болон түүний харьяа байгууллагын шийдвэрээр тодорхой заагдсан Сейм болон Засгийн газрын чиг үүрэгт харьяалагдах ажил болон бусад ажил;
- ✚ Парламентын тогтоол, Засгийн газрын шийдвэрт тодорхой заагдсан олон улсын байгууллага, институтын ажил зэрэг юм.

Харин парламентаас сонгогддог Ерөнхийлөгчид дээрх 5 төрлийн албан үүргийг хавсрахыг хориглосон бөгөөд “Ерөнхийлөгчийн хавсран гүйцэтгэж болох албан үүргийг зөвхөн Үндсэн хуулиар зохицуулна”<sup>207</sup> гэж заасан байна. Үндсэн хууль дахь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зохицуулсан хэсгийг үзэхэд хавсран гүйцэтгэх албан үүргийн талаар тусгайлан заагаагүй бөгөөд ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тогтоосон хэсэгт:

*Ерөнхийлөгч нь:*

- Ерөнхийлөгч нь Олон Улсын харилцаанд улсаа төлөөлнө.
- Ерөнхийлөгч нь Латви Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байна.
- Ерөнхийлөгч нь Засгийн газрын ээлжит бус хуралдааныг зарлах, даргалах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох эрхтэй.
- Ерөнхийлөгч нь хууль санаачлах эрхтэй.

.... гэж эрх зүйн статусыг нь тодорхойлсон ба энэ нь Ерөнхийлөгчийг улс төрийн аливаа үйл ажиллагаанаас ангид байх гол үндэслэл болдог байна.

Тиймдээ ч Төрийн албан хаагчийн үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: ... Латви Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны тэргүүн, түүний орлогч нь зөвхөн дор дурьдсан ажлуудыг хавсран гүйцэтгэхийг зөвшөөрсөн байна. Үүнд:

- ✚ Парламентын тогтоол болон Засгийн газрын шийдвэрийн дагуу соёрхон баталсан хууль, олон улсын гэрээнд заасан чиг үүрэг,
- ✚ Багшлах, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн спорт, бусад бүтээлч ажил,
- ✚ Ашиг сонирхлын зөрчилгүй гэдэг нь тогтоогдсон, эрх бүхий албан тушаалтны бичгээр гаргасан зөвшөөрөлтэйгээр олон улсын байгууллага болон түүний төлөөлөгчийн газар, бусад улсын захиргаанд экспертийн болон зөвлөхийн ажил хийх.

Ерөнхийлөгчийн Ажлын албаны дарга улс төрөөс ангид байх нөхцөлийг тус хуулийн 7 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Төрийн дээд байгууллагуудын Ажлын албаны дарга, түүний орлогч,

a—

<sup>205</sup> Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials. **Section 7**

<sup>206</sup> Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials, **Section 7.14** *In addition to those public officials, who by other laws and by this Section are not permitted to combine their public official office with an office in a political party or association of political parties, this type of combination of offices is also not permitted for the **Director of the State Chancellery and his or her deputies**, State Secretaries and their deputies, as well as members of boards and councils of State capital companies.*

<sup>207</sup> Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials, **Section 7.1** *Combining the office of the President with another office shall be determined by the Constitution of the Republic of Latvia.*

Төрийн Нарийн бичгийн дарга, түүний орлогч, Төрийн өмчит компанийн зөвлөл болон хорооны гишүүд зэрэг албан тушаалтан нь улс төрийн нам, улс төрийн намын эвслийн ажил хавсран гүйцэтгэхийг хориглоно гэж тодорхой заасан байна.

### **3. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС**

ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Германы Холбооны Ерөнхийлөгчийн алба (“төрийн захиргааны төв байгууллага” гэж ойлгож болно) бөгөөд хамгийн дээд түвшний холбооны алба юм.<sup>208</sup> Тус газар нь ХБНГУ-ын Төрийн тэргүүнд туслах, ажил үйлд нь дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь тус албаны удирдагч бөгөөд төрийн нарийн бичгийн даргын түвшний төрийн улс төрийн албан хаагч юм.

Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын чиг үүрэгт нь Холбооны ерөнхийлөгчийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь зөвлөх, Холбооны ерөнхийлөгчийг улс төрийн үйл явдлын талаар мэдээллээр хангах, Холбооны ерөнхийлөгчийн шийдвэр гаргах бэлтгэлийг хангах болон Холбооны ерөнхийлөгчийн хийх төрийн айлчлалын бэлтгэлийг хангах зэргээр түүний өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх ажлууд багтдаг байна.

ХЕТГ-ын бүтэц нь 3 газраас бүрдэнэ. Үүнд:

1. “Зэт”<sup>209</sup> газар-төв хэрэг эрхлэх;
  2. I газар-дотоод улсын хэрэг эрхлэх;
  3. II газар-гадаад улсын хэрэг эрхлэх.
- Зэт газар нь захиргаа, техник болон ёслолын чиглэлээр төвлөрсөн асуудлыг хариуцна. Тус газар нь 100 шахам ажилтантай. Хүний нөөц, захиргаа үйлчилгээ, мэдээлэл-холбооны техник, ёслол, үндсэн хууль ба эрх зүй г.м. 5 хэлтэстэй.
  - I газар нь дотоод бодлогын чиглэлийг хариуцна. Тус газар нь тус бүрдээ 6 хүртэлх ажилтан бүхий 8 хэлтсээс бүрдэнэ. Үүнд: стратеги төлөвлөлт, харилцаа холбоо ба тоон технологийн үндсэн асуудал, дотоод бодлого, иргэний товчоо, аж ахуй, боловсрол, шинжлэх ухаан, гэр бүл, төрийн одон, шагнал, нийгмийн бодлого г.м.
  - II газар нь гадаад бодлогын асуудлыг хариуцах бөгөөд Гадаад хэргийн яамтай нягт хамтран ажилладаг. Тус газар нь 13 ажилтантай бөгөөд 3 хэлтэстэй. Үүнд:
    - Гадаад бодлогын үндсэн асуудал, Америк, Ойрхи дорнод, умард Африк, олон улсын болон олон талт байгууллага, төрийн бус байгууллагуудыг хариуцсан 20 дугаар хэлтэс.
    - Европын улсууд болон Кавказын харилцаа, европын бодлогыг хариуцсан 21 дүгээр хэлтэс.
    - Ази, Австрали болон Африкийн Дэд-сахарын харилцаа, хөгжлийн бодлогын үндсэн асуудлыг хариуцсан 22 дугаар хэлтэс.

Мөн Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтцэд Батлан хамгаалахын сайдын томилсон ёслолын үйл ажиллагааг хариуцсан тэнгисийн цэргийн хошууч буюу ахмад цолтой штабын офицер байж, Холбооны армитай холбогчийн үүрэг гүйцэтгэдэг. Тэрээр Холбооны ерөнхийлөгчид батлан хамгаалах бодлогын асуудлаар зөвлөдөг.

Түүнээс гадна Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын удирдлага дор Холбооны ерөнхийлөгчийн спикер болон хэлэх үг, текстийг хариуцсан штаб ажиллана. Холбооны

а\_\_\_\_\_

<sup>208</sup> Холбооны ерөнхийлөгчийн тамгын газар-Bundespräsidialamt-германаар  
<https://de.wikipedia.org/wiki/Bundespr%C3%A4sidialamt>

<sup>209</sup> Z-Zentrale Angelegenheiten-германаар



ерөнхийлөгчид өөрт нь мөн хувийн товчоо байна. Мөн амьд сэрүүн байгаа өндөр настан Холбооны ерөнхийлөгч нарын тамгын газар Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газарт багтана.

Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газарт 180 орчим хүн ажиллаж байна. Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь 1953 оноос хойш Төрийн албан хаагч-төрийн нарийн бичгийн дарга (ТАХ-ТНБД) байдаг болсон. Тэрээр Холбооны хэмжээнд хамгийн дээд түвшний ТАХ-ТНБД бөгөөд Холбооны засгийн газар болон Холбооны аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд ажиглагчаар оролцдог. Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь төрийн улс төрийн албан хаагч тул шалтгаан заахгүйгээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөн огцрох боломжтой юм. Тухайлбал, Холбооны Ерөнхийлөгч солигдсон тохиолдолд.

#### **4. БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС**

Австрийн Ерөнхийлөгчид дэмжлэг үзүүлдэг (туслах аппарат) байгууллагыг Австрийн Ерөнхийлөгчийн Тамгын газар гэдэг.<sup>210</sup> Австрийн Ерөнхийлөгчийн Тамгын газар нь 1946 оноос хойш Вена хотын Хофбургт байрлаж байна.

Тамгын газар нь доорх “бүлгүүдэд” хуваагдана. Үүнд:

- Европын болон олон улсын хэрэг, ёслол болон зохион байгуулалтын бүлэг;
- Эрх зүй, нийгэм болон захиргааны хэргийн бүлэг;
- Дотоод хэрэг болон адъютантын бүлэг.

Австрийн Холбооны ерөнхийлөгчийн адъютант нь Холбооны армийн офицер байх бөгөөд Ерөнхийлөгчид аюулгүй байдлын асуудлаар зөвлөдөг. Мөн тэрээр зэвсэгт хүчний ерөнхий командлагч болох Холбооны Ерөнхийлөгч болон Холбооны арми хоёрын дунд холбогчийн үүрэг гүйцэтгэнэ. Мөн дотоодод гадаадын төлөөлөгчдийг хүлээн авах болон гадаадын айлчлалд цэргийн протоколын дагуу Холбооны ерөнхийлөгчийн дэргэд дагалдана. Адъютант нь бас Хофбург дэх адъютантын албыг удирдана. Гэхдээ Холбооны ерөнхийлөгчийн бие хамгаалалтыг Холбооны цагдаа хариуцдаг.

Австрийн Ерөнхийлөгчийн Тамгын газрын үндсэн чиг үүрэг нь төрийн тэргүүн ажил үүргээ гүйцэтгэхэд нь түүнд дэмжлэг үзүүлэх юм. Австрийн Ерөнхийлөгчийн Тамгын газрыг Танхимын захирал<sup>211</sup> удирдана.

#### **5. БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС**

1991 онд батлагдсан Үндсэн хуульд заасны дагуу Бүгд Найрамдах Болгар Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн илэрхийлэл мөн бөгөөд гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлнө. Ерөнхийлөгч нь хуульд заасан журмын дагуу ард түмнээс шууд сонгох бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байна. Болгар Улсын Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Парламент (Үндэсний Ассамблей)-ын гишүүнээр сонгогдох шалгуурыг хангасан Болгар Улсын уугуул иргэнийг сонгоно. Болгар Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгч нь Парламентын гишүүний үүргийн хавсран гүйцэтгэхгүй бөгөөд бусад аливаа төр, олон нийт, эдийн засгийн үйл ажиллагаа явуулахгүй, мөн аливаа улс төрийн намыг удирдах үйл ажиллагаанд оролцохгүй гэж заажээ.

**Ерөнхийлөгчийн ажлын алба:** Бүгд Найрамдах Болгар Улсын 1991 онд батлагдсан Үндсэн хуулийн 102 дугаар зүйлийн 102.3.5 дахь заалтад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд өөрийн

а

<sup>210</sup> Ерөнхийлөгчийн тамгын газар-Präsidentschaftskanzlei-германаар  
<https://de.wikipedia.org/wiki/Pr%C3%A4sidentschaftskanzlei>

<sup>211</sup> Kabinettsdirektor-германаар

албадуудын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, тэдгээрийн албан хаагчдыг томилох асуудлаар зарлиг гаргана гэж заажээ.

Болгар Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар зарлигаар *Ерөнхийлөгчийн Тамгын газар (Кабинет)-ын бүтэц, зохион байгуулалтыг* баталсан. Тус зарлигт Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Үндсэн хууль, олон улсын гэрээ, хууль тогтоомж, хууль дээдлэх ёс, ард түмний ашиг сонирхлыг дээдлэн, нээлттэй ил тод байдал, түргэн шуурхай, үр дүнтэй болон **улс төрийн хувьд төвийг сахих** зарчмыг баримтлан үйл ажиллагааг явуулна гэж заажээ.<sup>212</sup>

2017 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Ерөнхийлөгчийн 103 дугаар зарлигаар батлагдсан Бүгд Найрамдах Болгар Улсын *Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны дүрэм*<sup>213</sup>:

- 3-р зүйлд Ерөнхийлөгчийн Тамгын газар нь хууль дээдлэх ёс, нээлттэй, ил тод, хариуцлагатай, **улс төрийн хувьд төвийг сахисан**, үр дүнтэй, захирах захирагдах ёс, бодитой, шударга байх зарчмуудыг үндэслэн үйл ажиллагаагаа явуулна.
- 52.9-р зүйлд Ерөнхийлөгчийн Тамгын газарт улс төрийн намд үндэсний хэмжээнд удирдах, хяналтын албан тушаал эрхэлж буй албан тушаалтанг томилохгүй.
- 54-р зүйлд Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан хаагчид өөрсдийн ажил үүргийн хүрээнд болон Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Ерөнхий Нарийн бичгийн дарга, Тамгын газар (Кабинет)-ын дарга, болон шууд удирдлагын хууль ёсны тушаал, зааврын дагуу үйл ажиллагаа явуулна гэж тус тус заажээ.

### **Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт**

Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дараах албан тушаалтан, нэгжээс бүрдэнэ.

- 1.1. Ерөнхий Нарийн бичгийн дарга;
- 1.2. Ерөнхийлөгчийн Кабинетын дарга;
- 1.3. Дэд Ерөнхийлөгчийн Кабинетын дарга;
- 1.4. Ерөнхийлөгчийн нарийн бичгийн дарга нар:
  - Гадаад бодлогын нарийн бичиг;
  - 2018 онд Болгар Европын холбооны зөвлөлийг даргалах асуудал хариуцсан;
  - Батлан хамгаалах, аюулгүй байдлын;
  - Хуулийн бодлогын;
  - Хууль, эрх зүй, авлигатай тэмцэх асуудал хариуцсан;
  - Шашин, соёлын асуудал хариуцсан;
  - Бүс нутгийн хөгжлийн асуудал хариуцсан;
  - Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан;
  - Нийгмийн бодлого, эрүүл мэндийн асуудал хариуцсан;
  - Боловсрол, шинжлэх ухаан, инновацийн асуудал хариуцсан;
  - Дотоод бодлого, иргэний нийгмийн асуудал хариуцсан;
  - Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан;
- 1.5. Ерөнхийлөгчийн зөвлөхүүд;
- 1.6. Ерөнхийлөгчийн Кабинет;

а

<sup>212</sup> <https://www.president.bg/cat8/Administration/>

<sup>213</sup> <https://www.president.bg/docs/1510662769.pdf>

- 1.7. Дэд ерөнхийлөгчийн Кабинет;
- 1.8. Ерөнхий нарийн бичгийн даргын Кабинет;
- 1.9. Санхүү, эдийн засаг, мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс: Санхүүгийн алба, Эдийн засгийн алба, Мэдээлэл, харилцаа холбооны алба;
- 1.10. Протоколын хэлтэс;
- 1.11. Бичиг хэргийн хэлтэс: Хүлээн авах алба, Логистик болон техникийн үйлчилгээний алба;
- 1.12. Хууль, эрх зүйн хэлтэс;
- 1.13. Олон нийттэй харилцах хэлтэс;
- 1.14. Ерөнхийлөгчийн хөтөлбөр хариуцсан нэгж;
- 1.15. Стратеги бодлого, шинжилгээ, прогнозын нэгж;
- 1.16. Дотоод аудитын нэгж;
- 1.17. Санхүүгийн хянагч;
- 1.18. Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан;
- 1.19. Иргэний харьяаллын асуудлаарх хороо;
- 1.20. Уучлалын хороо;
- 1.21. Улс төрийн орогнолын хороо;
- 1.22. Санхүүгийн өршөөлийн хороо;
- 1.23. Үндэсний ач холбогдол бүхий объект, газар, сууриныг нэрлэх хороо;
- 1.24. Гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын зөвлөл;
- 1.25. Хууль, эрх зүйн зөвлөл;
- 1.26. Шашин, соёлын зөвлөл;
- 1.27. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн зөвлөл;
- 1.28. Шинжлэх ухаан, боловсрол, инновацийн зөвлөл;

2010 онд батлагдсан Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг тогтоох тухай хуулийн 3 дугаар зүйд “нийтийн албан тушаалтан”-д Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтнууд багтана гэж заасан байна. Мөн хуулийн 4 дүгээр зүйлд Нийтийн албан тушаалтан нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн ашиг сонирхлыг дээдлэн, үнэнч, шударга, хариуцлагатай, алагчлахгүй байх зарчмыг баримтална гэж заажээ.

Болгарын **Төрийн албаны тухай хууль**<sup>214</sup>-д заасны дагуу төрийн албан хаагч нь төрийн байгууллагад цалин хөлстэй ажилд захирамжлах баримт бичгээр томилогдон, төрийн байгууллагад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх этгээдийг хэлнэ. Хуулийн 3 дугаар зүйлд улс төрийн кабинетын гишүүн, эсхүл түүний зөвлөх, экспертүүд төрийн албан хаагч биш байна гэж заажээ. Хуулийн 18 дугаар зүйлд Төрийн албан хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд нийцсэн, үнэнч, хариуцлагатай, тогтвортой, **улс төрийн төвийг сахисан**, захирах захирагдах ёсны зарчмуудыг баримтална. Мөн хуулийн 42 дугаар зүйлд Тусгай хуулиар хориглосноос бусад тохиолдолд аливаа төрийн албан хаагч аль ч улс төрийн намын гишүүн байх эрхтэй байна. **Төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа өөрийн гишүүнчлэл бүхий намынхаа эрх, ашиг сонирхолд хөтлөгдөх, хамгаалах үйл ажиллагаа явуулахгүй** гэж заасан байна.

Мөн хуулийн 118 дугаар зүйлд Төрийн албанд ажилласанд тооцох тухай заалтад доор заасан албан тушаал хашсан хугацааг төрийн албанд ажилласнаар тооцно гэж заажээ. Үүнд: Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейн гишүүн, Үндсэн

а—

<sup>214</sup> <https://www.mi.government.bg/en/library/civil-servants-act-381-c25-m258-1.html>

хуулийн шүүхийн шүүгч, Ерөнхий прокурор, Ерөнхий сайд, Дэд ерөнхий сайд, Засгийн газрын сайд, дэд сайд, орон нутгийн захирагч, хотын дарга, мөн улс төрийн кабинетын гишүүн, зөвлөх, эксперт багтаж байна.

Дээрхээс үзэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь төрийн албан хаагч биш харин нийтийн албан тушаалтан байна. Нийтийн албан тушаалтан нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн ашиг сонирхлыг дээдлэн, үнэнч, шударга, хариуцлагатай, алагчлахгүй байх зарчмыг баримтална гэж заажээ. Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны дүрэмд улс төрийн хувьд төвийг сахисан байна, мөн Ерөнхийлөгчийн Тамгын газарт улс төрийн намд удирдах албан тушаал хашиж буй хүнийг томилохгүй гэж тус тус заасан байна. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагч нь улс төрийн намын гишүүнээс түдгэлзэх албагүй бөгөөд ажил үүргээ гүйцэтгэхдээ намынхаа эрх сонирхолд хөтлөгдөх, хамгаалах үйл ажиллагаа явуулахгүй гэж заасан байна.

### **БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС**

Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хуулийн 143 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Ерөнхийлөгч Үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй байгууллага юм.<sup>215</sup> Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийг батлах бөгөөд Тамгын газрын даргыг томилох болон чөлөөлөх эрхтэй. 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн Ерөнхийлөгчийн 01 дүгээр зарлигаар Тамгын газрын дүрмийг баталсан.<sup>216</sup> Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дараах бүтэцтэй байна:

- Ерөнхийлөгчийн зөвлөхүүд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Ерөнхийлөгчийн ажлын алба;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын ажлын алба;
- Яаралтай хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх алба;
- Иргэдтэй харилцах алба;
- Хилийн чанад дахь Польш иргэдийн асуудал хариуцсан алба;
- Ерөнхийлөгчийн илтгэлийг бэлдэх алба;
- Соёл, өв уламжлалыг хамгаалах алба;
- Зохион байгуулалт хариуцсан алба;
- Иргэншил, харьяатын алба;
- Шагналын алба;
- Хэвлэл мэдээллийн алба;
- Хууль эрх зүйн алба;
- Гадаад харилцааны алба;
- Захиргаа, санхүүгийн алба;
- Ерөнхийлөгчийн архив;
- Тамгын газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төв.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

а\_\_\_\_\_

<sup>215</sup> [https://www.constituteproject.org/constitution/poland\\_2009?lang=en](https://www.constituteproject.org/constitution/poland_2009?lang=en)

<sup>216</sup> <http://www.president.pl/en/chancellery/>

**Ерөнхийлөгчийн ажлын алба:** Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгч Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон үүргийнхээ хүрээнд явуулах үйл ажиллагааг зөв зохион байгуулах үүрэгтэй. Ажлын алба нь Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн түүнчлэн Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргын өдөр тутмын ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ. Үүнд, Ерөнхийлөгчийн айлчлал, уулзалт, арга хэмжээний хуваарийг боловсруулах гэх мэт ажлууд орно. Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын хэсэг, баримт бичиг боловсруулах хэсэг, зохион байгуулалтын хэсгүүдээс бүрдэнэ.

**Хүний нөөцийн алба:** Энэхүү алба нь Үндсэн хууль болон бусад хуулиар Ерөнхийлөгчид олгосон эрхийн хүрээнд тодорхой төрийн гүйцэтгэх албан хаагчдыг болон төрийн бусад албанд Ерөнхийлөгчийг төлөөлж буй хүмүүсийг томилох болон чөлөөлөх зэрэг ажил үүргийг зохион байгуулж гүйцэтгэх үүрэгтэй.

#### **Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын үүрэг:**

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь Ерөнхийлөгчийн Сенат, Засгийн газрын гишүүд, төрийн албаны бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах ажиллагааг зохион байгуулж ажиллана.
- Бусад улс төрийн хүчнүүдтэй хамтран ажиллах чигийг гарган зохицуулж ажиллана.
- Ерөнхийлөгчийн ажил үүргийг тогтсон хуваарийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.

#### **6. БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС**<sup>217</sup>

Бүгд Найрамдах Финланд Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааг Финланд Улсын Үндсэн хуулиар<sup>218</sup> зохицуулсан байна. Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын байнгын Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгч томилдог. Ерөнхийлөгчийн тамгын газар нь туслах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий 2 албатай бөгөөд тэдгээр нь Ерөнхийлөгчийн албан үүргээ хэрэгжүүлэхэд нь бүхий л талын туслалцааг үзүүлэх үүрэгтэй байна.

**Ерөнхийлөгчийн зөвлөх алба:** Тус алба нь Ерөнхий нарийн бичгийн дарга, зөвлөхүүд, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан дарга, Тусгай зөвлөх нараас бүрдэнэ. Ерөнхийлөгчийн зөвлөх алба нь Ерөнхийлөгчийн чиг үүрэг болон бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэгдэх асуудалд хяналт тавьж энэ талаар Ерөнхийлөгчид мэдээлж, зөвлөлдөнө. Ерөнхийлөгчөөс өгсөн чиглэлийн дагуу Ерөнхийлөгчийг албан үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

Ерөнхийлөгчийн зөвлөх алба нь аливаа асуудалтай холбоотой зарлиг, шийдвэрийн төслийг бэлтгэх болон танилцуулах үүрэггүй бөгөөд аливаа асуудлаар хариу өгөх эрхгүй. Тухайн асуудлыг холбогдох яаманд тавих бөгөөд хаана харьяалагдах нь тодорхой бус тохиолдолд Ерөнхий сайдын албаны Мэдээллийн үйлчилгээ хариуцсан хэсэгт хандана.

**Ерөнхийлөгчийн туслах алба:** Энэхүү алба нь Захиргаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, 3 туслахаас бүрдэх ба Ерөнхийлөгчийг албан үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, Ерөнхийлөгчийн албан уулзалтууд болон бусад зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, Ерөнхийлөгчөөр ажиллах хугацааны архивын сан бүрдүүлэх, Ерөнхийлөгч болон түүний гэр бүлийнхэнд шаардлагатай туслалцааг үзүүлэх үүрэгтэй. Түүнчлэн Ерөнхийлөгч болоод хамаарал бүхий этгээдүүдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Финланд Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн албаны заалтуудын дагуу бүх төрийн эрх бүхий

а

<sup>217</sup> <http://www.tpk.fi/public/default.aspx?nodeid=44835&culture=en-US&contentlan=2>


<sup>218</sup> <http://www.presidentti.fi/halonen/Public/defaultd9d4.html?nodeid=41453&contentlan=2&culture=en-US>

байгууллагууд, төрийн албан хаагчид нь өөрсдийн чадамжийн хүрээнд хүсэлтийн дагуу туслан гүйцэтгэх үүрэгтэй. "Туслан гүйцэтгэх" гэдэг нь Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд<sup>219</sup> заасан мэдээлэл, эсхүл Ерөнхийлөгчийн албан үүргээ биелүүлэхэд шаардлагатай бусад тайлан, албан ёсны баримт бичиг болон бусад арга хэмжээгээр хангахыг хэлнэ.

## 7. БҮГД НАЙРАМДАХ ГРЕК УЛС

Бүгд Найрамдах Грек улсын Ерөнхийлөгчийн тамгын газар<sup>220</sup> нь удирдлагын болон санхүүгийн хувьд бие даасан байна. Түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг Ерөнхийлөгчийн 351/91 дүгээр зарлигаар тогтоосон. Тамгын газар нь Ерөнхийлөгчийн хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй байна.

### Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт



**Тамгын газрын дарга:** Тамгын газрын дарга нь Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Тамгын газрын албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавина. Ерөнхийлөгчийн Тамгын газар нь дараах бүтэцтэй байна.

**Ажлын алба:** Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийг албан үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах, түүний хувийн болон албаны захидал харилцааг зохицуулах, хувийн уулзалтуудыг

<sup>219</sup> Үндсэн хуулийн 32-р зүйл<sup>219</sup> буюу Ашиг сонирхлын зөрчил гэсэн хэсэгт Төлөөлөгч нь өөртэйгээ холбоотой аливаа асуудлаар хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцож болохгүй. Гэхдээ энэ асуудлаар УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт оролцож болно. Үүнээс гадна Төлөөлөгч нь албан үүргээ шалгахтай холбоотой асуудлыг аливаа Хороогоор шийдвэрлэхэд оролцохыг хориглодог талаар заажээ.

<sup>220</sup> [http://www1.presidency.gr/en/armod\\_graf.htm](http://www1.presidency.gr/en/armod_graf.htm)



зохион байгуулахад нь туслах үүрэгтэй.

Ерөнхийлөгчийн ажлын алба нь хэвлэлийн болон олон нийттэй харилцах дэд албадтай байна.

- **Хэвлэлийн алба:** Хэвлэлийн алба нь Ерөнхийлөгчийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй харилцах харилцааг хариуцдаг.
- **Олон нийттэй харилцах алба:** Олон нийттэй харилцах алба нь Ерөнхийлөгчийн олон нийттэй уулзах уулзалт, арга хэмжээ, Ерөнхийлөгчийн өргөөнд зохион байгуулагдах үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг хариуцан ажиллана.

**Хуулийн хэлтэс:** Хуулийн хэлтэс нь хууль батлах, зарлиг гаргах, уучлал үзүүлэх, шүүхээс оногдуулсан ялын хэмжээг багасгах зэрэг Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар хууль зүйн үүднээс зөвлөх үүрэг гүйцэтгэнэ.

**Дипломат үйлчилгээний хэлтэс:** Дипломат үйлчилгээний хэлтэс нь Ерөнхийлөгчийн гадаад улсад хийх айлчлал, гадаад улсын төрийн тэргүүн, дипломат төлөөлөгчид, Олон улсын байгууллага, гадаадад амьдарч байгаа иргэдтэй уулзалт зохион байгуулах зэрэг олон улсын харилцаатай холбогдох бүх л асуудлаар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах үүрэгтэй.

**Зэвсэгт хүчний асуудал хариуцсан хэлтэс:** Зэвсэгт хүчний асуудал хариуцсан хэлтэс нь Ерөнхийлөгчийг Зэвсэгт хүчний тэргүүний хувьд холбогдох асуудлаар мэдээллээр хангах зэрэг зэвсэгт хүчинтэй холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Ерөнхийлөгчийн хамгаалалт нь тус хэлтэст хамаарна.

**Захиргаа, удирдлагын хэлтэс:** Захиргаа, удирдлагын хэлтэс нь Ерөнхийлөгчийн тамгын газрын захиргааны асуудал, албан хаагчид, Ерөнхийлөгчийн албан байр, өргөөтэй холбогдох бүхий л асуудлыг хариуцна.

**Санхүүгийн хэлтэс:** Санхүүгийн хэлтэс нь Тамгын газрын үйл ажиллагааны төсөв боловсруулах, санхүүгийн удирдлага, албан хаагчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, худалдан авалт, хуваарилалт зэрэг санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг хариуцан гүйцэтгэнэ.

**Бусад чиг үүрэг хариуцсан хэлтэс:** Ерөнхийлөгч, түүний гэр бүл, албан тасалгаа, өргөө, Ерөнхийлөгчийн урилгаар айлчлал хийх гадаад улсын төрийн тэргүүний аюулгүй байдлыг хариуцсан аюулгүй байдлын болон шуудан, харилцаа холбооны алба нь Тамгын газрын даргын шууд удирдлагын дор үйл ажиллагаа явуулна.

## **8. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

БНСУ-ын Үндсэн хуулийн 78 дугаар зүйлийн дагуу Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд зааснаар төрийн албан тушаалтнуудыг ажилд томилно.<sup>221</sup> Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх хэд хэдэн агентлагуудтай. Ерөнхийлөгчийн Тамгын газрыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга тэргүүлэх бөгөөд тэрээр Засгийн газрын гишүүнтэй дүйцэхүйц эрх мэдэлтэй байна.<sup>222</sup>

Түүний удирдлага доор дурьдсан асуудлуудыг хариуцсан 8 ахлах нарийн бичгийн дарга а

<sup>221</sup> [https://www.constituteproject.org/constitution/Republic\\_of\\_Korea\\_1987?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en)

<sup>222</sup> [https://books.google.mn/books?id=7DSPBAAAQBAJ&pg=PA40&lpg=PA40&dq=duties+of+presidential+secretariat+south+korea&source=bl&ots=WOwbq6n7ym&sig=2Y2wlh-9kCbt\\_msLcS4A\\_umJ53l&hl=mn&sa=X&ved=0ahUKEwjQ3t-60MrXAhWDVbwKHWBEB0YQ6AEIYTAG#v=onepage&q=duties%20of%20presidential%20secretariat%20south%20korea&f=false](https://books.google.mn/books?id=7DSPBAAAQBAJ&pg=PA40&lpg=PA40&dq=duties+of+presidential+secretariat+south+korea&source=bl&ots=WOwbq6n7ym&sig=2Y2wlh-9kCbt_msLcS4A_umJ53l&hl=mn&sa=X&ved=0ahUKEwjQ3t-60MrXAhWDVbwKHWBEB0YQ6AEIYTAG#v=onepage&q=duties%20of%20presidential%20secretariat%20south%20korea&f=false) page 40

ажилладаг байна. Үүнд:

- улс төрийн асуудал;
- эдийн засгийн асуудал;
- нийгмийн асуудал;
- иргэдийн асуудал;
- боловсон хүчний менежмент;
- ажлын байр бий болгох;
- нийгмийн шинэчлэл;
- олон нийтийн асуудал.

Ахлах нарийн бичгийн дарга нар нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажил үүргийн хүрээнд нэлээдгүй эрх мэдэлтэй байдаг. Ерөнхийлөгч нь аливаа хууль тогтоомжийг харгалзалгүй нарийн бичгийн даргын албан тушаалын орон тоог бий болгон эдгээр албан тушаалд хүмүүсийг томилох бүрэн эрхтэй. Ерөнхийлөгчийн Тамгын газар нь 400 гаруй ажилтан, албан хаагчидтай.<sup>223</sup>

## 9. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалд хамаарах улс төрийн албан тушаалтан байна. Тус улс нь 1982 онд батлагдсан Бүгд Найрамдах Турк Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар 2017 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр ард нийтийн санал асуулга явуулж, Ерөнхийлөгчийн засаглалтай болохыг дэмжсэн. Үндсэн хуулийн 107 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн Тамгын газартай холбоотой асуудлыг тусгасан бөгөөд Тамгын газар байгуулах, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны зарчим, албан хаагчдыг томилох асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно гэж заажээ.<sup>224</sup>

Үндсэн хуулийн 128 дугаар зүйлд “төрийн албан хаагч” гэсэн тодорхойлолтыг хэрэглэсэн байна. Төрийн албан хаагч нь төрийн байгууллагад тодорхой албан үүргийг бодит утгаар нь тогтмол хэрэгжүүлж байгаа хүний нөөцийг төрийн албан хаагч гэнэ. Төрийн албан хаагч нь ажил үүргээ хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Төрд чин үнэнчээр зүтгэж, бие даасан байх: Улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэж, ямарваа улс төрийн нам, хүчин, нийгмийн бүлгийн эрх ашгийг дээдэлсэн болон хөндсөн зан үйл, хандлага, үйл ажиллагаа явуулахгүй байх. Эрх үүргээ хэрэгжүүлэх явцад үзэл бодол, шашин шүтлэг, нас, хүйс, үндэс угсаагаар ялгаварлахгүй байх.
- Үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах: Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангана.

Өнөөдрийн байдлаар БНТУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, түүний бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүний талаарх мэдээллийг нийтэд ил болгоогүй бөгөөд 2016 оны 2 дугаар сарын байдлаар Ерөнхийлөгч 23 зөвлөхтэй гэж мэдээлж байсан.<sup>225</sup> 2017 онд сөрөг хүчин болох Бүгд найрамдах ардын намын дэд даргаас Ерөнхийлөгчийн Тамгын газарт түүний бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, цалин хөлсний асуудлаар мэдээлэл хүсэхэд энэхүү асуудал нь олон нийтээд хамааралгүй, мэдээллийн ил тод байдлын тухай хуульд хамаарахгүй гэж Ерөнхийлөгчийн Тамгын газраас хариу өгч байсан байна.<sup>226</sup>

a

<sup>223</sup> [https://en.wikipedia.org/wiki/Presidential\\_Secretariat\\_\(South\\_Korea\)](https://en.wikipedia.org/wiki/Presidential_Secretariat_(South_Korea))

<sup>224</sup> [https://global.tbmm.gov.tr/docs/constitution\\_en.pdf](https://global.tbmm.gov.tr/docs/constitution_en.pdf)

<sup>225</sup> <https://news.sol.org.tr/turkish-president-erdogans-advisors-cloak-secrecy-172553>

<sup>226</sup> <http://www.hurriyetdailynews.com/information-on-erdogans-chief-advisors-cannot-be-released-turkish-presidency-says-117929>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль. 1993 он.
- Constitutional Act on the Protection of Public Interest by the Performance of Offices of Public Officials No. 357/2004, as amended by Constitutional Act No. 545/2005.
- Act of Civil Service 312/2001.
- Act No. 16/1993 Coll. on the Office of the President of the Slovak Republic.
- Act No. 321/2002 Coll. on the Armed Forces of the Slovak Republic
- <https://archiv.prezident.sk/index61e1.html?organisational-structure>
- Law on Prevention of Conflict of Interest in Activities of Public Officials
- <https://www.president.bg/cat8/Administration/>
- <https://www.president.bg/docs/1510662769.pdf>
- <https://www.mi.government.bg/en/library/civil-servants-act-381-c25-m258-1.html>
- [https://www.constituteproject.org/constitution/poland\\_2009?lang=en](https://www.constituteproject.org/constitution/poland_2009?lang=en)
- <http://www.president.pl/en/chancellery/>
- <http://www.tpk.fi/public/default.aspx?nodeid=44835&culture=en-US&contentlan=2>
- <http://www.presidentti.fi/halonen/Public/defaultd9d4.html?nodeid=41453&contentlan=2&culture=en-US>
- [http://www1.presidency.gr/en/armod\\_graf.htm](http://www1.presidency.gr/en/armod_graf.htm)
- [https://www.constituteproject.org/constitution/Republic\\_of\\_Korea\\_1987?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en)
- [https://books.google.mn/books?id=7DSPBAAQBAJ&pg=PA40&lpg=PA40&dq=duties+of+presidential+secretariat+south+korea&source=bl&ots=WOWbq6n7ym&sig=2Y2wlh-9kCbt\\_msLcS4A\\_umJ53l&hl=mn&sa=X&ved=0ahUKEwjQ3t-60MrXAhWDVbwKHWBEB0YQ6AEIYTAG#v=onepage&q=duties%20of%20presidential%20secretariat%20south%20korea&f=false](https://books.google.mn/books?id=7DSPBAAQBAJ&pg=PA40&lpg=PA40&dq=duties+of+presidential+secretariat+south+korea&source=bl&ots=WOWbq6n7ym&sig=2Y2wlh-9kCbt_msLcS4A_umJ53l&hl=mn&sa=X&ved=0ahUKEwjQ3t-60MrXAhWDVbwKHWBEB0YQ6AEIYTAG#v=onepage&q=duties%20of%20presidential%20secretariat%20south%20korea&f=false)
- [https://en.wikipedia.org/wiki/Presidential\\_Secretariat\\_\(South\\_Korea\)](https://en.wikipedia.org/wiki/Presidential_Secretariat_(South_Korea))
- [https://global.tbmm.gov.tr/docs/constitution\\_en.pdf](https://global.tbmm.gov.tr/docs/constitution_en.pdf)
- <https://news.sol.org.tr/turkish-president-erdogans-advisors-cloak-secrecy-172553>
- <http://www.hurriyetdailynews.com/information-on-erdogans-chief-advisors-cannot-be-released-turkish-presidency-says-117929>

# ЗАРИМ УЛСЫН ХОТЫН МЭРИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУС БА ХОТЫН БОНДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

*Д.Халиун, Ц.Болормаа,  
Д.Жигваагүнсэл, Ц.Элбэгзаяа*

## АГУУЛГА

НЭГ. ЗАРИМ УЛСЫН ХОТЫН МЭРИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУСЫН ТУХАЙ

ХОЁР. ХОТЫН БОНДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

ХАВСРАЛТ

MOODY'S SUB-SOVEREIGN RATINGS LIST

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ЗАРИМ УЛСЫН ХОТЫН МЭРИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУСЫН ТУХАЙ БОЛОН ХОТЫН БОНДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

### НЭГ. ЗАРИМ УЛСЫН ХОТЫН МЭРИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУСЫН ТУХАЙ

#### Онолын зарим асуудал:

Эрх зүйн тайлбар толь бичгүүдээс үзэхэд хотын захирагч буюу Мэр гэх ойлголт, албан тушаалыг тодорхойлохдоо “**Мэр** (*mayor*) нь АНУ, Их Британи, Франц ба бусад хэд хэдэн улсад муниципалитетийн дээд албан тушаалтан /хотын нутгийн өөрийн удирдлагын тэргүүн/ байна. Мэрийг орон нутаг өөрөө, заримдаа хүн амаас шууд сонгох бөгөөд зарим улсад түүнийг төв засгийн газраас албан тушаалд томилох буюу батална. Франц болон зарим улсад Мэр нь засгийн газрын төлөөлөгч болж, муниципалитетийн засаг захиргааг тэргүүлнэ”<sup>227</sup> гэж тодорхойлсон байна.

Түүнчлэн Жон Хопкинсийн Их Сургуулийн (John’s Hopkins University) доктор, профессор Tom Magstadt-ийн “**Үндэстнүүд ба Засгийн газрууд**” номонд “...Францын өөр нэг арга барил нь сайд нар нь ихэвчлэн томоохон хотуудын мэрийн албыг нэгэн зэрэг хашдаг явдал юм. Тухайлбал, Jacques Chaban – Delmas 1969-1972 онд Ерөнхий сайд байхдаа Бордо хотын мэр, 1986-1988 онд Ерөнхий сайд байхдаа Парис хотын мэрийн албыг давхар хашиж байсан.”<sup>228</sup> тухай тодорхой жишээ иш татсан байдаг. Энэ мэтчилэн олон мэрүүд Засгийн газрын сайд, эсхүл сенатын албыг давхар хашиж байсан туршлагыг олон ном, судалгааны бүтээлүүдэд<sup>229</sup> дурьдсан байна.

ХХ зууны үед АНУ, Их Британи, Ирланд зэрэг улсад нийслэл хотын болон томоохон хотуудын Мэр нь нэгэн зэрэг Засгийн газрын гишүүн, эсхүл парламентын доод танхимын гишүүний албыг давхар хашиж болдог байсан ч “ашиг сонирхлын зөрчил үүсгэж байна” гэх шалтгаанаар Ирланд болон АНУ-ын зарим мужид сонгуулийн тухай хууль, Нутгийн удирдлагын тухай хууль зэрэг органик хуулиудаар хориглосон байна.

Нөгөө талаас хотын Мэр нь Засгийн газрын бүрэлдэхүүнд багтаж, Засгийн газрын гишүүн байх асуудал нь “хоёрдмол мандат” /“dual mandat”/-ын асуудлыг хөнддөг. Иймд энэ асуудал нь засгийн газрын гишүүн давхар алба хаших эсэх Үндсэн хуулийн эрх зүйн асуудалтай холбогдох бөгөөд энэ талаар Европын холбооны түвшинд нэлээд судлагдсан байна. Тухайлбал, 2012 онд Венийн Комиссоос гаргасан 54 улсын Үндсэн хуулийн хэмжээнд хийсэн судалгаа<sup>230</sup>-наас үзэхэд Бельги, Босни Герцеговени, БНСУ, Лихтенштэйн, Португал, ОХУ, Сан Марино, Тунис, Алжир зэрэг 9 улсын Үндсэн хуульд Засгийн газрын гишүүний хавсарч үл болох ажил албан тушаалд хориг тавиагүй бөгөөд бусад 45 улсын Үндсэн хуулиар Засгийн газрын гишүүн төрийн бусад алба болон ашгийн төлөөх ажил, албан тушаал хавсарч болохгүй байхаар заасан байна. Нэр дурьдсан 9 улсаас Бельги нь хоёрдмол мандатын хүчтэй хэлбэр бүхий улс бөгөөд нутгийн өөрийн удирдлагын байгууллагын гишүүн нь давхар парламентын гишүүн байх асуудал нээлттэй байдаг байна. Бельгийн Вант Улсын Нутгийн удирдлагын тухай хуульд зааснаар Бельгийн Мэр нь орон нутагтаа Холбооны Засгийн газрыг төлөөлнө гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар Засгийн газрын гишүүний хавсарч үл болох ажил, албан тушаалыг тодорхойлоогүй улсын практикт хотын Мэр нь засгийн газрын гишүүн байсан туршлагууд байна.

а

<sup>227</sup> С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” анхны хэвлэл. УБ хот, 2007 он. 295 дахь тал.

<sup>228</sup> Tom Magstadt. “Nations and Governments” comparative politics and regional perspective. Sixth edition. 2011. Cengage Learning. 146 дахь тал.

<sup>229</sup> Friedrich Lenger “European cities in the Modern Era 1850-1914”. 2012. Munich. 137 дахь тал.

<sup>230</sup> [http://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2012\)027-e](http://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2012)027-e)

Түүнчлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсаас онцлог, Холбооны улсуудын төв Засгийн газар нь нийтлэг засгийн газруудаас өргөн бүрэлдэхүүнтэй байх тохиолдол байна. Тухайлбал, Испанийн Вант Улсын Үндсэн хуулийн 98 дугаар зүйлийн 98.1 дэх хэсэгт заасанчлан **“Засгийн газар нь тэргүүн, дэд тэргүүн, сайд нар болон хуулиар тогтоосон бусад гишүүдээс бүрдэнэ. Засгийн газрын бусад гишүүнийг хуулиар тогтооно”** гэж заасан байдаг. Засгийн газрын хуулиар тогтоосон бусад гишүүнд ямар албан тушаалтан багтахыг тодруулах зорилгоор Засгийн газрын тухай хууль, нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийг хайсан ч тус хуулиуд англи хэл дээр олдоогүй юм.

Испанийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагатай холбоотой аливаа харилцааг Нутгийн захиргааны суурь хууль, Мадридын тусгай дэглэм, нийслэлийн статусын тухай хууль зэрэг 7 төрлийн органик хууль<sup>231</sup>-аар зохицуулдаг байна.

Мөн Румын, Польш, Итали, БНХАУ зэрэг улсын засгийн газар өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Румын Улсын Засгийн газар нь ерөнхий сайд, сайд нар, хуулиар тогтоосон бусад гишүүдээс бүрддэг.

### **Бусад улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээ:**

Хотын Мэр нь засгийн газрын бүрэлдэхүүнд багтдаг эсэх асуудлыг тодруулахаар Латви, Литва, Польш, Унгар, Румын, Болгар, Чех, Вьетнам, Итали, Ирланд, Франц, Бельги, Казахстан, Кыргыз, Испани, Япон, Канад, Хорват, Серб зэрэг 19 улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай болон нийслэл хотын эрх зүйн байдлын тухай холбогдох хуулиудыг үзэхэд “Хотын мэр нь Засгийн газрын гишүүн байна” гэж тодорхойлсон заалт олдсонгүй. Харин Мэр нь “тухайн нутаг дэвсгэртээ засгийн газрын төлөөлөл болно”, “гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байна” гэх мэтчилэнгээр Мэрийн статусыг тогтоосон байна. ХБНГУ-ын Берлин, Хамбург, Бремен хотуудын Мэр нь тухайн нутаг дэвсгэрийн засгийн газрын тэргүүн байна. Нэр дурьдсан 19 улсын нийслэлийн эрх зүйн байдал, нутгийн захиргаатай холбоотой харилцааг зохицуулсан органик хуулиудад Мэрийн статус, Үндсэн хуульд засгийн газрын бүрэлдэхүүнийг хэрхэн тогтоосныг доорх 7 улсын жишээгээр үзүүлэв.

### **Хотын Мэрийн (mayor) талаарх зохицуулалт**

	Улсын нэр	Хууль	Хотын захирагч (mayor) талаарх хууль эрх зүйн зохицуулалт	Засгийн газрын бүрэлдэхүүнд ордог эсэх
1	Бельги	Үндсэн хууль <sup>232</sup>	Мэр (Голланд: <i>Burgemeester</i> , Франц: <i>Bourgmestre</i> ; Герман: <i>Bürgermeister</i> ) нь хотын захиргааны тэргүүн байх бөгөөд <b>орон нутгийн түвшинд Бүс нутгийн болон Холбооны Засгийн газрыг төлөөлнө.</b>  Мэр нь өөрийн нутаг дэвсгэрийн	Үндсэн хууль 99 дүгээр зүйл Сайд нарын зөвлөл нь 15 гишүүнээс бүрдэнэ.

а—

<sup>231</sup> Law 7/1985, of April 2nd, regulating the Bases of Local Government;

Organic law 5/1985, of June 19th, on the General Electoral System;

Royal legislative decree 781/1986, of April 18th, approving the amended text of the regulations in force on local government;

Law 18/2001, of December 12th, on budget stability;

Royal legislative decree 2/2004, of March 5th, approving the amended text of the law regulating Local Treasuries;

Law 1/2006, of March 13th, regulating the special organisational system for the municipality of Barcelona;

Law 22/2006, of July 4th, on Capital Status and Special Regime of Madrid.

<sup>232</sup> [https://www.constituteproject.org/constitution/Belgium\\_2014?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Belgium_2014?lang=en)



			засаг захиргаанд нийтийн хэв журам сахиулах үүрэгтэй. Тэрбээр тус бүс нутгийн онцлогоос шалтгаалан Мэрийн коллегий болон хотын коллегийг даргална. <sup>233</sup>	
2	Польш	-Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль 1990 Local self-government act 1990	-Хотын мэр Засгийн газрын гишүүн байх эсэх тухай зохцуулалт байхгүй.	Үндсэн хууль 147.1.Сайд нарын Зөвлөл нь Сайд нарын зөвлөлийн дарга, сайд нараас бүрдэнэ. 147.2.Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сайд нарын орлогч дарга нарыг оруулж болно. 147.4.Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд хуульд тодорхойлсон комиссын дарга нарыг оруулж болно.
3	Румын	- Үндсэн хууль <sup>234</sup>  - Нутгийн нийтийн захиргааны тухай хууль <sup>235</sup>	Румыны муж болон хотын мэрийг “ <i>primar</i> ” гэнэ. Мэр болон орон нутгийн зөвлөлийн эрх үүргийг Орон нутгийн нийтийн захиргааны тухай хуулиар зохицуулдаг.	<b>Үндсэн хууль 102.3. Засгийн газар нь Ерөнхий сайд, сайд нар болон органик хуулиар тодорхойлсон бусад гишүүдээс бүрдэнэ.</b>
4	Чех	Үндсэн хууль <sup>236</sup> Хотын захиргааны тухай хууль <sup>237</sup> (act on Municipalities)	Хотын захиргааны тухай хууль 103 дугаар зүйл. Хотын мэр нь гадаад харилцаанд тухайн орон нутгийг төлөөлнө. Мөн хуулийн 103-108-р зүйлээр хотын Мэрийн үйл ажиллагаа, эрх үүргийг ерөнхийд нь зохицуулсан боловч Засгийн газрын гишүүн байх тухай заалт байхгүй.	ҮХ-ийн 67-р зүйлд зааснаар Засгийн газар нь Ерөнхий сайд, дэд сайд, сайд нараас бүрдэнэ.
5	Болгар	- Үндсэн хууль <sup>238</sup> - Нутгийн өөрийн удирдлага болон нутгийн захиргааны тухай хууль <sup>239</sup>	5-р бүлэг 38 дугаар зүйл.  Хотын Мэр /mayor/ нь орон нутагт гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байна.	ҮХ-ийн 108-р зүйлд зааснаар Сайд нарын зөвлөл нь ерөнхий сайд, дэд сайд, сайд нараас бүрдэнэ.
6	Унгар	-Нутгийн засаг захиргааны тухай хууль <sup>240</sup>	Мэр нь орон нутгийн засаг захиргааны улс төрийн болон захиргааны албыг тэргүүлнэ. Орон нутагт Үндэсний Ассамблейг төлөөлдөг, орон нутгийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй.	ҮХ-ийн 16.1 Засгийн газрын бүрэлдэхүүнд ерөнхий сайд, сайд нар байна.

a

<sup>233</sup> [https://en.wikipedia.org/wiki/Municipalities\\_of\\_Belgium](https://en.wikipedia.org/wiki/Municipalities_of_Belgium)

<sup>234</sup> [https://www.constituteproject.org/constitution/Romania\\_2003?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Romania_2003?lang=en)

<sup>235</sup> Law no. 215/2001 on local public administration- <https://lege5.ro/Gratuit/gmzdzqzuyq/law-no-215-2001-on-local-public-administration/3>

<sup>236</sup> [https://www.constituteproject.org/constitution/Czech\\_Republic\\_2013?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Czech_Republic_2013?lang=en)

<sup>237</sup> <http://www.mvcr.cz/soubor/act-on-municipalities-2000-pdf.aspx>

<sup>238</sup> [https://www.constituteproject.org/constitution/Bulgaria\\_2015?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Bulgaria_2015?lang=en)

<sup>239</sup> <http://www.promise-project.net/wp/wp/project-library/doc/03-Bulgarian-Legislation/Local%20Self-Government%20and%20Local%20Administration%20Act.pdf>

<sup>240</sup> [www.ola-europe.com/...local/...local.../Hongrie\\_systeme\\_local\\_](http://www.ola-europe.com/...local/...local.../Hongrie_systeme_local_)

## ХОЁР. ХОТЫН БОНДЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ЛАВЛАГАА

Орон нутгийн засаг захиргааны (ОНЗЗ)-ны санхүүгийн зах зээлээс авах урт хугацааны зээллэгийн хамгийн түгээмэл хэлбэрүүд нь нийтлэг болон төрөлжсөн банк зэрэг санхүүгийн байгууллагаас авч буй санхүүгийн аж ахуйн нэгжийн зээл (Европ), мөн хотын бонд (АНУ) юм. Дээрх хоёр хэлбэр нь олон улсад түгээмэл хэрэглэгддэг боловч ОНЗЗ-г санхүүгийн зах зээлээс зээл авахыг дотоодын хууль тогтоомжоор хориглох буюу хязгаарлаж болно. Зээл авахыг хориглоогүй ч санхүүгийн зах зээлд оролцоход санхүүгийн удирдлага зохих түвшинд хүрсэн байх, боловсронгуй болсон байх зэрэг шаардлагууд тавигддаг.

Практикт хөгжиж буй орнуудын ОНЗЗ-д зээл авах боломж хэд хэдэн шалтгааны улмаас хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, санхүүгийн зах зээл хангалттай хөгжөөгүй, төрөөс ОНЗЗ-нд үзүүлэх бодлогын болон зохицуулалтын дэмжлэг дутмаг, ОНЗЗ-ны зээлийн хариуцлага хүлээх чадвар сул зэрэг шалтгаан бий. ОНЗЗ-ны зээл авах чадвар нь улс төрийн болон санхүүгийн төвлөрлийг сааруулах явцтай нарийн холбоотой байдаг. Түүнээс гадна дэд бүтцийн санхүүжилтэд шаардлагатай урт хугацааны санхүүжилтийн хувилбарууд ихэнх тохиолдолд хөгжиж буй орнуудад бүрдээгүй байдаг.

Нэлээд оронд ОНЗЗ нь донор байгууллагуудаас санхүүждэг Хотын хөгжлийн сан буюу Хотын дэд бүтцийн сан зэргээр дамжуулан зээл авах боломжтой байдаг боловч дээрх байгууллагууд нь ихэнхдээ тодорхой төрлийн төслүүдийг дэмжих зорилгоор байгуулагдсан байдаг тул ОНЗЗ-ны бүхий л төслүүд, үүнд тэргүүлэх зорилтын төслүүдийг ч мөн санхүүжүүлэх боломжгүй байж болох юм.<sup>241</sup>

### *Хотын бондын гаргаж буй олон улсын туршлагаас*

Хотын бонд буюу municipal bond-ыг муж улс, нийслэл, хот болон засгийн газраас дооших түвшинд улсын аж ахуйн нэгж болон төрийн бусад байгууллагууд өөрийн дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргадаг бөгөөд ОНЗЗ-ны санхүүгийн зах зээлээс авах урт хугацааны зээллэгийн түгээмэл хэлбэрийн нэг юм.

АНУ нь Засгийн газраас дооших нэгжийн (*sub-sovereign*) бондын зах зээлийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг ба 2017 оны байдлаар хотын бондын зах зээлд эзлэх хэмжээ 3,8 триллион ам.доллар байна. Тус улсад 50,000 гаруй муж, хот, эмнэлэг, тусгай дүүрэг болон бусад нэгжүүд хотын үнэт цаас гаргадаг бөгөөд хотын бондын эзэмшигчдийн дунд хувь иргэд, хамтын болон мөнгөний зах зээлийн сан (*money market funds*)-ууд, даатгалын компани болон арилжааны банкууд дийлэнх хувийг эзэлж байна. Хотын бондууд ихэнхдээ зам, гүүр, сургууль, хурдны зам, төмөр замын систем, сургууль, цэвэрлэх байгууламж, ус, цахилгаан хангамж зэрэг дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд хэрэглэгддэг бөгөөд АНУ-ын хувьд Голден гейт гүүр, Гуверын усан цахилгаан станц, Нью Йорк хотын метро зэрэг томоохон төслүүдийг хотын бондоор санхүүжүүлсэн байдаг. Сүүлийн үеийн томоохон бүтээн байгуулалтын хувьд 2012 онд Калифорни мужийн хууль тогтоох байгууллагаас Сан Франциско болон Лос Анжелес хотуудыг холбосон хурдны төмөр замын 210 км (130 миль) хэсгийг барихад 2,6 тэрбум ам.долларын бонд гаргахыг шийдвэрлэсэн байна. АНУ-д хотын бондын орлогыг холбооны, зарим тохиолдолд мужийн татвараас чөлөөлсөн байсан боловч 2017 оны татварын хуулийн шинэтгэлээр хотын зарим зээллэгийг хязгаарлаж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулснаар хотын бондын зах зээл 30-40 хувиар хумигдаж болзошгүй гэж тооцоолсон байна.<sup>242</sup>

Канадын хувьд Квебек, Онтарио зэрэг мужууд нь хотын бондоо олон улсын бондын зах зээл дээр 90 гаруй жил арилжаалж байна. Хотын бондууд нь татвараас чөлөөлөгдөхгүй боловч,

а

<sup>241</sup> Орон нутгийн засаг захиргааны хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн гарын авлага,

<http://documents.worldbank.org/curated/en/654101468149684064/pdf/656000NWP00PUB07B0UDS13CIP00PUBLIC0.p>

<sup>242</sup> US municipal bond sales set to surge as curbs loom in tax reforms, Dec 5, 2017

<https://www.ft.com/content/71cbe636-d979-11e7-a039-c64b1c09b482>

ОНЗЗ-ын санхүүгийн зах зээлээс авах түгээмэл хэрэгслийн нэг юм. Канадын мужууд нь татвар болон бодлогын шийдвэр гаргах эрхийн хувьд Европын орнуудтай харьцуулахад харьцангуй өргөн эрхийг эдэлдэг буюу хүчтэй байдаг бол Европын орнуудын хувьд дээрх эрхийг төв Засгийн газраас хязгаарласан байдаг. Энэ нь Канадын үнэт цаас гаргагчдыг санхүүгийн зах зээлд гаргах боломж бололцоог нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдыг татахад эерэгээр нөлөөлдөг байна. Үүнээс гадна АНУ-ын зах зээлтэй ойрхон байрладгийн хувьд хотын бондын хөгжсөн зах зээлийг ашиглан олон улсад гарах боломж нь нээлттэй байдаг. Түүнчлэн Канадын хотууд нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах тал дээр нэлээдгүй анхаардаг бөгөөд хотын бондын баталгааг Канадын Засгийн газраас (Бритиш Колумб мужаас бусад) Хотын санхүүгийн корпораци (*Municipal Finance Corporations*) дамжуулан гаргадаг. Ингэснээр зээлээ төлөх чадвар сул хотуудад үнэт цаасаа зах зээлд гаргах боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Европын орнуудын хотын бондын зах зээл нь АНУ-ын дараа орох томоохон зах зээл бөгөөд үнэт цаас гаргагчдын тооны хувьд 1990 – 2017 оны хооронд 19-өөс 28 болтлоо өссөн байна. Тус бүс нутагт Герман, Испани, Итали, Их Британи болон Франц Улсууд нь үнэт цаас гаргагчийн хувьд томд тооцогддог байна. Түүнчлэн Зүүн Европын орнууд болох ОХУ, Словак, Словени, Румын, Эстони зэрэг улсууд нь дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэхэд хотын бонд гаргаж байна. Европын холбооны хувьд хотын бондын зах зээл тэлж, өргөжиж байгаа хэдий ч нийтлэг болон төрөлжсөн банк зэрэг санхүүгийн байгууллага болон санхүүгийн аж ахуйн нэгжийн зээл нь хотын санхүүжилтийн гол эх үүсвэр хэвээр байна.

АНУ болон Европтой харьцуулахад дэлхийн бусад бүс нутагт бондын зах зээл нь харьцангуй жижиг байгаа юм. Тэдгээрээс Латин Америкийн бүс нутаг нь давамгайл байр суурийг эзэлж байгаа бөгөөд *sub-sovereign* бондын зах зээлийн хэмжээ 9,1 тэрбум ам.долларт хүрч байгаа юм (2007).

Азийн бүс нутгийн хувьд Япон, Малайз, Өмнөд Солонгос, Энэтхэг, Хятад зэрэг улсууд хотын бонд гаргаж байна. Японы хувьд хотын бондууд нь түгээмэл ашиглагддаг хэрэгсэл бөгөөд сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор нэлээдгүй зохион байгуулалт, шинэтгэл явуулж ирсэн. Үүнд олон нийтэд санал болгож буй бондын хамгийн бага хэмжээг нэмэгдүүлэх, төлбөр тооцооны сүлжээг байгуулах (JBNet) байгуулах, андеррайтенгийн хураамжийг бууруулах, тэдгээрийг зөвхөн дуусгавар болох хугацаанд нь эргүүлэн авах боломжтой болгох зэрэг багтаж байна. Тус бүс нутгийн дэд бүтцийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлагатай харьцуулахад маш бага байгаа нь хөгжиж буй орнуудын хувьд эрх зүйн орчин, санхүүгийн зах зээлийн хөгжлөөс ихээхэн хамаарч байна гэж судлаачид үзжээ.

### ***Хотын бондын эрх зүйн зохицуулалт***

Хотын бондын эрх зүйн зохицуулалтын хувьд улс орон бүрт ялгаатай байдлаар зохицуулагдсан байна. Хотын бондын асуудал нь хөрөнгийн зах зээл, орон нутгийн удирдлага, нийтийн санхүү зэрэг олон талын асуудлыг хамардаг учир олон салбарын хууль тогтоомжоор, эсхүл бие даасан хуулиар зохицуулагдаж байна. Тухайлбал, Польш Улсын хувьд хотын бондыг Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль (*The Self-Government Act 1990*), Бондын тухай хууль (*The Bonds Act 1995*), Нийтийн асуудлын тухай хууль (*The Public Issue Act 2005*), Нийтийн санхүүгийн тухай хууль (*The Public Finance Act 2009*)-иар, Румын Улсад Орон нутгийн санхүүжилтийн тухай хууль (*The Local Public Finance Law 2006*), Орон нутгийн удирдлагын тухай хууль (*Local Public Administration Law 2001*), Хөрөнгийн зах зээлийн тухай хууль (*Law on Capital Markets 2004*)-иар тус тус зохицуулж байна. Харин Словени Улсад хотын бондын асуудлыг Моргежийн бонд болон хотын бондын тухай хууль (*Mortgage Bond and Municipal Bond Act*)-иар зохицуулсан байна.

### **Польш Улсын туршлага**

Польш Улсын бондын зах зээлийн хөгжлийн суурийг 1995 онд батлагдсан Бондын тухай хууль тавьсан бөгөөд тус хуулиар коммун буюу орон нутагт хөрөнгийн зах зээлд бонд гаргах эрхийг

нээж өгсөн. Польшийн засаг захиргааны нэгжийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсны дараагаар дээрх хуульд 2000 онд нэмэлт өөрчлөлт оруулж бонд гаргах эрх бүхий нэгжүүдийн жагсаалтыг гаргасан байна. Үүнд коммун, тойргууд, муж улсууд, бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн холбоо, нийслэл хот Варшав багтсан байна. Дээрх бонд гаргах эрх бүхий нэгжүүдийг нэг бүлэг болгон тоймлон “орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгж” (*local self-government entity*) гэж нэрлэсэн байна.

Бондын тухай хуульд заасны дагуу бонд гэдэг нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа заасан хүүтэйгээр эргүүлэн төлөхийг амлаж байгааг баталсан үнэт цаасыг хэлдэг. Бонд гаргагч нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгж байх тохиолдолд эдгээр бондуудын тусгай шинж чанарыг бий болгох бөгөөд “хотын бонд” гэж нэрлэн бусад бондоос ялгаж өгдөг. Хотын бондын зориулалт, холбогдох эрсдэл зэрэг онцлох шинж чанарыг дараах тодорхойлолт харуулж байна. *Хотын бонд нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас тэдгээрийн хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргаж буй улсын өрийн үнэт цаас юм.*

Бондын тухай хуулиас гадна орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгжийн бонд гаргах асуудлыг 2009 онд батлагдсан Нийтийн санхүүгийн тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулиар орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгжүүд нь тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх, эсхүл тухайн төсвийн жилийн орлогоос санхүүжүүлэх боломжгүй зардлуудыг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн байна. Мөн хууль нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагын нэгжийн өрийн тааз буюу зээлийн тодорхой хязгаарлалтуудыг тогтоож өгсөн байна.<sup>243</sup>

Тухайлбал, 83-р зүйлийн 1 дэх хэсэгт - орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан үнэт цааснаас үүсэх нийт зээл, өр төлбөр нь Төсвийн хуулиар тогтоосон хязгаараас хэтрэхгүй байна.

83-р зүйлийн 2, 3 дахь хэсэгт орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас кредит буюу зээл авах өргөдөл гаргах тохиолдолд, эсхүл орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас үнэт цаас гаргахаар төлөвлөж буй тохиолдолд тухайн байгууллагын гүйцэтгэх засаглалын байгууллага нь бүс нутгийн хяналтын танхимаас (*regional chamber of control*) кредит, эсхүл зээлийг эргэн төлөх буюу үнэт цаасыг эргүүлэн авах чадамж, бололцооны асуудлаар санал, дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ. Дээрх дүгнэлт нь хөрөнгө оруулагчдад нээлттэй байна.

169-р зүйлд<sup>244</sup>—жилийн нийт зээлийн төлбөр, зээл, баталгааны нийт төлбөр тэдгээр кредитийн хүү, зээлийн хүү, аж ахуйн нэгжээс гаргасан үнэт цаас, тухайн жилийн төсөвт төлөх зардал гаргасан үнэт цаасны эргэн төлөлт нь тухайн төсвийн жилд төлөвлөсөн орлогын 15 хувиас

а\_\_\_\_\_

<sup>243</sup> Local self-government - The Public Finance Act – 2009

-the limited aims of loans & municipality bonds,

- debt limits – 15% (total amount of credit installments may not exceed 15% of the planned revenues in the particular budgetary year) e.g. 50 million € local budget → 8 million € of installments

- 60%(total debt may not exceed 60% of revenues in the particular budgetary year)

-public debt/GDP ≥ 55% → local budget's deficit only for EU projects ^ only 12% limit for annual installments

- public debt/GDP ≥ 60% → no deficit at the local level;

<sup>244</sup> Art. 169 – total annual payments of credits, loans and contingent warrants including interest due on those credits and loans and interest due on discounts applicable to securities issued by the entity, and expenditures payable in a given budgetary year due to redemption of issued securities must not exceed 15 per cent of the entity's revenue planned for a given budgetary year. In the case when the ratio of the country's total public debt and expected payments, due to warrants and guaranties given by public finance entities to the Gross Domestic Product, would exceed 55 per cent, the total credit charges of a given self-government entity mentioned above must not exceed 12 per cent of its planned revenue, unless total charges result from liabilities incurred before the date of announcement of this ratio by the Minister of Finance. The said restrictions are not applied to credits and loans raised due to funds defined by a contract with entities dealing with structural funds or the European Union Cohesion Fund, and also securities issued with such a purpose, warrants and guaranties given to self-government legal persons that perform tasks of a self-government entity using the EU funds;

хэтрэхгүй байна.

Улсын нийт өрийн хүлээгдэж буй төлбөрийн ДНБ-тэй харьцах харьцаа 55 хувиас хэтрэх тохиолдолд дээд дурьдсан орон нутгийн өөрөө удирдах байгууллагын зээлийн төлбөр Сангийн яамнаас тухайн харьцааг зарлахаас өмнө үүссэн өр төлбөрөөс бусад тохиолдолд 12 хувиас хэтрэхгүй байна. Мөн дээрх хязгаарлалт нь бүтцийн сан, эсхүл Европын Холбооны Нэгдлийн Сангаас авсан кредит, зээл болон ЕХ-ны санхүүжилтийг ашиглаж орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа явуулан гаргасан үнэт цаас, баталгаа, батлан даалтад хамаарахгүй.

170-р зүйлд – дээрх хязгаарлалтыг үл харгалзан төсвийн жилийн эцсийн байдлаар нийт өрийн хэмжээ тухайн нэгжийн тухайн төсвийн жилд олсон орлогын 60 хувиас хэтрэхгүй байна.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” анхны хэвлэл. УБ хот, 2007 он. 295 дахь тал.
- Tom Magstadt. “Nations and Governments” comparative politics and regional perspective. Sixth edition. 2011. Cengage Learning. 146 дахь тал.
- Friedrich Lenger “European cities in the Modern Era 1850-1914”. 2012. Munich. 137 дахь тал.
- [http://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2012\)027-e](http://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2012)027-e)
- Law 7/1985, of April 2nd, regulating the Bases of Local Government;
- Organic law 5/1985, of June 19th, on the General Electoral System;
- Royal legislative decree 781/1986, of April 18th, approving the amended text of the regulations in force on local government;
- Law 18/2001, of December 12th, on budget stability;
- Royal legislative decree 2/2004, of March 5th, approving the amended text of the law regulating Local Treasuries;
- Law 1/2006, of March 13th, regulating the special organisational system for the municipality of Barcelona;
- Law 22/2006, of July 4th, on Capital Status and Special Regime of Madrid.
- [https://www.constituteproject.org/constitution/Belgium\\_2014?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Belgium_2014?lang=en)
- [https://www.constituteproject.org/constitution/Romania\\_2003?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Romania_2003?lang=en)
- Law no. 215/2001 on local public administration- <https://lege5.ro/Gratuit/gmzdnzgy/law-no-215-2001-on-local-public-administration/3>
- [https://www.constituteproject.org/constitution/Czech\\_Republic\\_2013?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Czech_Republic_2013?lang=en)
- <http://www.mvcr.cz/soubor/act-on-municipalities-2000-pdf.aspx>
- [https://www.constituteproject.org/constitution/Bulgaria\\_2015?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Bulgaria_2015?lang=en)
- <http://www.promise-project.net/wp/wp/project-library/doc/03-Bulgarian-Legislation/Local%20Self-Government%20and%20Local%20Administration%20Act.pdf>
- [www.ola-europe.com/...local/...local.../Hongrie\\_systeme\\_local\\_](http://www.ola-europe.com/...local/...local.../Hongrie_systeme_local_)
- <http://business.inquirer.net/166027/developing-the-municipal-bond-market>
- <http://documents.worldbank.org/curated/en/654101468149684064/pdf/656000NWP00PUB07B0UDS13CIP00PUBLIC0.pdf>
- [http://www.scielo.br/scielo.php?script=sci\\_arttext&pid=S0034-75902012000600010](http://www.scielo.br/scielo.php?script=sci_arttext&pid=S0034-75902012000600010)
- [http://pdc.ceu.hu/archive/00001591/01/Local\\_borrowing,\\_regulation\\_and\\_practices.pdf](http://pdc.ceu.hu/archive/00001591/01/Local_borrowing,_regulation_and_practices.pdf)
- <http://www.ecbc.eu/uploads/attachements/110/64/3.30%20Slovenia.pdf>
- [https://www.moody.com/researchdocumentcontentpage.aspx?docid=PBC\\_124094](https://www.moody.com/researchdocumentcontentpage.aspx?docid=PBC_124094)
- <http://documents.worldbank.org/curated/en/654101468149684064/pdf/656000NWP00PUB07B0UDS13CIP00PUBLIC0.pdf>
- <https://www.ft.com/content/71cbe636-d979-11e7-a039-c64b1c09b482>

УИ.МН  
СУДАЛГААНЫ САН



# ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНД ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Г.Билгээ, Ц.Болормаа  
Д.Халиун

## АГУУЛГА

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Парламентын гишүүний парламентын хуралдаанд оролцох үүрэг, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэх хариуцлага, хариуцлага ногдуулах эрх бүхий субъект

#### 1.1. Парламентын гишүүдийн чуулганы хуралдаанд оролцох үүрэг

- Ирцтэй холбоотой шийтгэлүүд (санхүүгийн торгууль)
- Бусад шийтгэлүүд
- Шийтгэл ногдуулах эрх бүхий субъект

#### 1.2. Парламентын гишүүний сахилга бат

- Сануулах, донгодох, хуралдаанд оролцох эрхийг хасах шийтгэл
- “Naming” шийтгэл
- Нэмэлт шийтгэлүүд
- Шийтгэл ногдуулах эрх бүхий субъект

#### 1.3. Парламентын гишүүний ёс зүйн дүрэм

- Их Британи загварын ёс зүйн дүрэм
- Бусад хувилбарууд
- Ёс зүйн дүрэм зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага

2. Гадаадын зарим улсын парламентын гишүүнд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт

- Франц
- Болгар
- Словак

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## ХАВСРАЛТ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхийн ихэнх улсын парламентад парламентын гишүүн нэгдсэн чуулган болон байнгын хорооны хуралдаанд биечлэн оролцохыг журамласан хуулийн зохицуулалттай байна. Үүнийг зарим орнууд Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулсан байдаг бол ихэнх парламентын хувьд дэг, үйл ажиллагааны дүрмээр зохицуулдаг.

Зөрчил гаргасан парламентын гишүүнд ногдуулах хариуцлагын төрлүүд болон хариуцлага тооцох механизм нь улс орнуудын хувьд харилцан адилгүй байна.

Парламентын дэг болон ёс зүйн дүрэм зөрчсөн парламентын гишүүдэд хүлээлгэх хариуцлагыг дараах төрлүүдэд авч үзнэ.

<b>Санхүүгийн торгууль:</b>	<ul style="list-style-type: none"><li>- цалингийн тодорхой хувь хэмжээгээр суутгах (<i>парламентын чуулганы хуралдааныг тасалсан гишүүдийн</i>);</li><li>- санхүүгийн торгууль ногдуулах (<i>зөвхөн нэгдсэн чуулганы хуралдааны санал хураалтад оролцоогүй, хуралдааныг тасалсан гишүүдэд</i>);</li><li>- тогтоосон хэмжээгээр мөнгөн торгууль ногдуулах.</li></ul>
<b>Сахилгын шийтгэл:</b>	<ul style="list-style-type: none"><li>- гишүүний бүрэн эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх;</li><li>- гишүүний бүрэн эрхийг хэсэгчлэн түдгэлзүүлэх;</li><li>- гишүүнийг эгүүлэн татах зохицуулалт;</li><li>- гишүүнийг огцруулах.</li></ul>
<b>Бусад төрлийн хариуцлагын механизм:</b>	<ul style="list-style-type: none"><li>- гишүүдийн ирцийн мэдээг хэвлэн нийтлэх;</li><li>- хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих;</li><li>- парламентын зарим үйл ажиллагаанд оролцох эрхийг нь хасах;</li><li>- гишүүнийг чуулганы болон байнгын хорооны хуралдаанд албадан ирүүлэх;</li><li>- сануулах болон нэр дуудах (naming);</li><li>- донгодох (хатуу донгодох);</li><li>- тодорхой хугацаагаар хуралдаанд оролцох эрхийг хасах шийтгэл;</li><li>- үг хэлэх, асуулт асуух эрхийг түдгэлзүүлэх;</li><li>- тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх, асуулт асуух эрхийг хасах;</li><li>- албан ёсоор уучлал гуйлгах.</li></ul>
<b>Ёс зүйн шийтгэл</b>	<ul style="list-style-type: none"><li>- парламентын дэг зөрчигсдөд хүлээлгэх сахилгын шийтгэлтэй ижил;</li><li>- давуу эрх хасах;</li><li>- хорих шийтгэл оногдуулах,</li><li>- тодорхой хугацаагаар гишүүний эрхийг түдгэлзүүлэх,</li><li>- гишүүнийг парламентын бүрэлдэхүүнээс хасах.</li></ul>

Эдгээр хариуцлагын төрлийг хэрэглэх нөхцөл буюу үндэслэл, хариуцлага оногдуулах эрх бүхий этгээд (субъект), хариуцлага оногдуулах механизм (хэрхэн ногдуулах) нь мөн л харилцан адилгүй байна. Тухайлбал, Францад хамгийн хөнгөн шийтгэлийн хэлбэр нь сануулах бол, цаашлан шат дараатай арга хэмжээ авах, зөрчлийг давтан гаргасан, эсхүл бусад эрх бүхий этгээд (Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд г.м.)-ийг доромжлох зөрчилд гишүүний эрхийг түдгэлзүүлдэг байна. Германы Бундестагийн хувьд гишүүн хэлэлцүүлгийн явцад хуралдааны дэг зөрчсөн бол сануулах, эсхүл тухайн хэлэлцэж буй асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах, ноцтой зөрчлүүдэд гишүүнийг тухайн хэлэлцүүлэгт оролцох эрхийг хасах, эсхүл мөнгөн торгууль ногдуулах зэрэг шийтгэлүүдийг тусгасан байна. Словак болон Болгарт гишүүн бусдын картыг ашиглан, өөр гишүүний өмнөөс санал өгсөн бол сахилгын шийтгэл ногдуулахаар заасан байна.

Улс орнуудад парламентын гишүүн хуралдааныг тасалсан болон парламентын үйл ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол гишүүдийн ирцийн мэдээг нийтлэх, сануулах, санхүүгийн торгууль ногдуулах (зөрчил гаргасан гишүүний цалин хөлснөөс суутгах), гишүүний үг хэлэх, парламентын үйл ажиллагаанд оролцох эрхийг хасах, парламентын гишүүнийг огцруулах,

эгүүлэн татах зэрэг шийтгэлүүдийг ногдуулж байна. Тухайлбал, гишүүний суугаагүй хуралдааны тоо, парламентын үйл ажиллагаанд оролцоогүй хугацааг улс орон бүр харилцан адилгүй тогтоосон байх бөгөөд *хамгийн багадаа нэг сард 5 удаагийн хуралдаан тасалсан, хамгийн ихдээ нэг жил парламентын үйл ажиллагаанд оролцоогүй бол* парламентын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай заасан байна.

Нөгөө талаас хуралдаанд суугаагүй болон парламентын үйл ажиллагаа (*parliament work* гэж нэрлэсэн байх ба үүнд: *чуулган, байнгын хороо, бүлгийн хуралдаан болон гишүүний бүрэн эрхэд хамаарах бусад ажил үүрэг*)-д оролцоогүй үндэслэлээр парламентын гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохдоо:

- Эрх бүхий албан тушаалтан болон Спикерээс бичгээр зөвшөөрөл авах;
- Хүндэтгэн үзэх шалтгаан гэсэн үндсэн хоёр нөхцөлийг харгалзан үзнэ.

Ихэнх орны хувьд ёс зүйн дүрэм зөрчсөн парламентын гишүүнд хүлээлгэх хариуцлага нь парламентын дэг журмыг зөрчигсдөд хүлээлгэх сахилгын шийтгэл байх боловч зарим парламент “ёс зүйн алдаа” гаргасан гишүүдэд тусгай шийтгэл ногдуулдаг байна. /Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү./

# 1. ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ПАРЛАМЕНТЫН ХУРАЛДААНД ОРОЛЦОХ ҮҮРЭГ, САХИЛГА, ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН ГИШҮҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ХАРИУЦЛАГА НОГДУУЛАХ ЭРХ БҮХИЙ СУБЬЕКТ

## 1.1. Парламентын гишүүний чуулганы хуралдаанд оролцох үүрэг

Парламентын гишүүн нэгдсэн чуулган болон байнгын хорооны хуралдаанд оролцох журмыг зарим улс орнууд Үндсэн хууль болон бусад хуулиудад тусгасан байдаг бол ихэнх орны хувьд парламентын үйл ажиллагааны дэгээр зохицуулсан байна. Тухайлбал, **Германы** Бундестагийн дэг (*Rules of Procedure of the German Bundestag and Rules of Procedure of the Mediation Committee*)-ийн 13.2-р хэсэгт зааснаар гишүүдийг чуулганы хуралдаанд оролцох нь түүний үүрэг байх бөгөөд тус заалтыг зөрчсөн гишүүнд Бундестагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль (*Members of the Bundestag Act Members of the European Parliament Act*)-д заасан хариуцлага тооцохоор заасан байна (14 дүгээр зүйл).

Зарим улс орнуудад чуулганы хуралдаанд оролцох гишүүний үүргийг тусгайлан шаардлага болгож хуульчлаагүй ч гэсэн чуулганы хуралдааныг удаа дараа зөвшөөрөлгүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан гишүүнд санхүүгийн шийтгэл ногдуулах зохицуулалт бүхий цөөнгүй парламент байна.

Ирцтэй холбоотой ямар нэгэн хариуцлагын механизмгүй цөөн хэдэн парламент байдаг нь Бельгийн Сенат, Европын Зөвлөлийн Парламентын чуулган байна. Дээрх парламентуудад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганы хуралдааныг удаа дараа тасалсан гишүүнд хариуцлага тооцдоггүй байна.

Дэлхийн ихэнх парламентад гишүүдийн ирцийн асуудалтай холбоотойгоор “хүндэтгэн үзэх шалтгаан”-д хуралдаанд оролцох боломжгүй нөхцөлүүдийг тусгасан байдаг. “Хүндэтгэн үзэх шалтгаан”-ыг хууль, дэгээр нарийвчлан тогтоох нь ховор байна<sup>245</sup>. Ихэнх парламентад хуралдаан даргалагч нь тохиолдол тус бүрийг хянан үзэж, хүндэтгэн үзэх шалтгаан мөн эсэхийг шийдвэрлэдэг байна. Тухайлбал, **Францын** Сенатад гишүүд тойрогтоо ажиллах тохиолдлуудыг хүндэтгэн үзэх шалтгаанд тооцдог. **Словак** Улсад гишүүний ирцийг шалгах, бүртгэх эрх нь Үндэсний Зөвлөлийн Ерөнхийлөгч (Парламентын дарга), Хорооны хувьд хорооны дарга эдлэх ба сар бүрийн эцсээр гишүүдийн хуралдаанд оролцоогүй шалтгааныг хэлэлцэж, хүндэтгэн үзэх шалтгаан мөн гэж хүлээж аваагүй тохиолдолд санхүүгийн шийтгэл ногдуулдаг байна. **Кипрт** Дэг сахиулах хороо нь гишүүний чуулганы хуралдаанд оролцоогүй болох шалтгааныг хүндэтгэн үзэх шалтгаан мөн эсэхийг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

### **Ирцтэй холбоотой санхүүгийн шийтгэлүүд**

Улс орнуудын хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр парламентын чуулганы хуралдааныг тасалсан гишүүдийн цалин хөлснөөс тодорхой хувь хэмжээгээр суутгах нь тус зөрчилд ногдуулах шийтгэлийн хамгийн түгээмэл хэлбэр байна. (Коста Рика, Кипр, Франц, Габон, Герман, Гватемал, Унгар, Йордан, Люксембург, Парагвай, Польш, Өмнөд Солонгос, Испани, Уругвай гм.)

Санхүүгийн торгууль нь ихэвчлэн тасалсан цагтай уялдах буюу хувь тэнцүүлэн тооцогдоно. Тухайлбал, **Польшийн** Сеймийн дэгийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Парламентын Маршал

а

<sup>245</sup> **Хүндэтгэн үзэх шалтгаан (reasonable excuse, justifiable, important reason)** – Монгол Улсын хууль тогтоомжид заасан олонтаа хэрэглэгддэг хууль зүйн хэвшмэл хэллэг. Хуулийн эх бичвэрийн холбогдох заалтын утга санаанд анхаарал хандуулах боловч хүндээр өвчилсөн, өвчтэй хүн асарсан, томилолтоор гадаад ба дотоодод ажилласан, сургалтад хамрагдсан, хорио цээр тогтоогдсон, байгалийн гамшиг тохиолдсон, гэнэтийн осолд орсон болон эдгээртэй адилтган үзэх бусад нөхцөл байдлыг хамааруулан үзнэ. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. 2015. 575 дахь тал.

(Дарга) нь: 1) гишүүний хүндэтгэн үзэх шалтгаангүй Парламентын чуулганы хуралдааныг тасалсан өдөр тутамд, эсхүл тухайн өдрийн санал хураалтын 1/5-аас доошиход оролцсон бол цалингийн 1/30-тэй тэнцэх, 2) тухайн сард хорооны хуралдааны 1/5-ээс дээшихийг хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй бол Хорооны хуралдааныг тасалсан өдөр тутмын цалингийн 1/30-тэй тэнцэх хэмжээг гишүүний цалин хөлснөөс суутгахаар заасан байна. **Канадын** Парламентын тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар “Парламентын аль нэг танхимын гишүүн нэг сарын дотор, эсхүл нэг чуулганы хугацаанд 21-ээс дээш хоног тасалсан тохиолдолд тасалсан хоног бүрт гишүүний цалин хөлснөөс 120 долларыг суутгана”<sup>246</sup> гэж заасан байна. **Казахстаны** Парламентын дэгийн тухай хуулийн 110 дугаар зүйлд зааснаар гишүүн нэг чуулганы хугацаанд Парламентын Танхимуудын хамтарсан хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй тохиолдолд түүний хуралдаанд оролцоогүй өдрийн хөдөлмөрийн хөлсийг олгохгүй гэж заасан байна.

Зарим улсад гишүүнд ногдуулах санхүүгийн торгуулийн дээд хэмжээг тогтоож өгсөн байна. Тухайлбал, **Бельгийн** Төлөөлөгчдийн танхимын гишүүн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй удаа дараа тасалсан бол санхүүгийн торгууль ногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ цалингийн 60 хувиас хэтрэхгүй байна.

Ихэнх парламентад зөвхөн нэгдсэн чуулганы хуралдааны санал хураалтад оролцоогүй, хуралдааныг тасалсан гишүүдэд санхүүгийн торгууль ногдуулахаар заасан байна.

**Францын** Үндэсний Ассамблейн Дэгийн 42 дугаар зүйлд зааснаар гишүүд хуралдаанд заавал оролцоно. Хэрэв гишүүн нь сард 2-оос дээш удаа хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр суугаагүй, тасалсан бол гишүүний тухайн сарын хөдөлмөрийн хөлсний 25 хувьтай тэнцэх хэмжээг суутгана гэж заасан байна.

### **Бусад шийтгэлүүд**

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй гишүүдэд ногдуулах шийтгэл нь зөвхөн санхүүгийн торгууль бус сахилгын шийтгэлийн хэлбэртэй байна.

**Гишүүнийг эгүүлэн татах** зохицуулалтууд<sup>247</sup> Их Британи, АНУ, Канад (Сенат) болон Венесуэл зэрэг улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид<sup>248</sup> тусгагдсан байна.

Парламентын гишүүнийг “эгүүлэн татах” (recall) асуудалтай холбоотойгоор хөндөгддөг Үндсэн хуулийн эрх зүйн онолын дараах асуудлууд хөндөгддөг:

1. “гишүүний мандат”-ын хэлбэр буюу “императив мандат” болон “чөлөөт мандат”-ын асуудал;
2. ардчиллын хэлбэр буюу “шууд ардчилал”, “төлөөллийн ардчилал”.

**Нэгт:** Сонгуультныг эгүүлэн татах ойлголтыг XIX зууны сүүлч, XX зууны эхнээс Швейцар, АНУ зэрэг орнууд хуульчилж, хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Харин 1990-ээд оноос Латин Америкийн орнуудад төлөөллийн болон оролцооны ардчиллыг хослуулах үзэл санаа өргөн дэлгэрснээс үүдэн хэд хэдэн орны үндсэн хуульд сонгуультныг иргэдийг санаачилгаар эгүүлэн татах тухай тусгасан байдаг. Тухайлбал,

а

<sup>246</sup> <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/p-1/page-10.html#h-37>

<sup>247</sup> Судлаачдын дунд гишүүнийг эгүүлэн татах асуудал нь онц арга хэмжээ гэхээс илүүтэйгээр улс төрийн зориулалтаар ашиглагдаж болзошгүй гэх болгоомжлол их байдаг.

<sup>248</sup> Парламентын гишүүнийг эгүүлэн татах тухай хууль, Их Британи (Recall of MPs Act 2015) <http://www.legislation.gov.uk/ukpga/2015/25>

*Швейцарт нийт холбооны улсын хэмжээнд сонгуультныг эгүүлэн татдаггүй, харин 26 кантоны 6 нь сонгуультныг сонгогчийн саналаар эгүүлэн татах хууль үйлчилдэг.*<sup>249</sup>

Мөн,

*АНУ-д мөн холбооны хэмжээнд биш муж улсуудын түвшинд 1903 оноос эхлэн сонгуультныг эгүүлэн татах хуулиуд батлагдан үйлчилж эхэлсэн байдаг. Нийт 19 муж улсад ийм хууль бий.*

Гэвч, парламентат ёсны хөгжлийн үйл явцад парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах нь парламентын бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх болсон учир олон улсууд үндсэн хуулиараа парламентын үйл ажиллагаа, хараат бус байдлыг бататган өгчээ.

Үүний нэг нь олон улс парламентын гишүүний **императив (захирагдмал) мандатын** хэлбэрийг халсан явдал юм. Өдгөө дэлхийн цөөн тооны улс парламентын гишүүний императив мандатыг хэрэгжүүлдэг. Парламентын гишүүн хэрэв императив мандатын агуулга нь **“тухайн гишүүн сонгогчийнхоо захиа даалгаврыг шууд биелүүлэх үүрэгтэн, тэдний өмнө хариуцлага хүлээгч”** мөн гэх үзэл онол юм.

Императив мандатыг халсан анхны улс нь Франц Улс бөгөөд 1789 онд тус мандатыг халсан явдлаа Францын их хувьсгалын үндсэн ололтын нэг гэж үздэг. Бельги 1830 онд, Пруссийн Вант Улс 1850 онд, Германы Эзэнт Улс 1871 онд тус тус Үндсэн хуулиараа парламентын бие даасан байдлыг баталгаажуулж, парламентын гишүүний репрезентатив (чөлөөт) мандатын хэлбэрийг хуульчилсан байдаг.

Харин **“чөлөөт мандат”**-ын хэлбэр нь парламентын гишүүн нь зөвхөн тойргийн сонгогчдыг бус, нийт ард түмнийг төлөөлөх статустай гэж үздэг. Иймд өөрөө хүсэлт гаргасан буюу нас барснаас бусад шалтгаанаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэхгүй гэж үздэг бөгөөд энэ нь аливаа нэгэн парламентын гишүүний эрхийг хамгаалахад бус, харин парламентын бие даасан, хараат бус байдлыг хангахад чиглэсэн зарчимтай холбоотой гэж үздэг ажээ.

**Хоёрт:** Парламентын гишүүнийг “эгүүлэн татах” нь **шууд ардчиллын нэг процедур** бөгөөд өөрсдийнх нь сонгосон албан тушаалтан, сонгуультныг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө эгүүлэн татахаар төрийн эрх мэдэл бүхий байгууллага, эсхүл тодорхой тооны иргэдийн зүгээс сонгогчдод хандаж, сонгогчид санал, санаачилга гаргасныг үндэслэн эгүүлэн татах процедур юм. Манай улс бол **төлөөллийн ардчиллыг** хэрэгжүүлэгч орон бөгөөд харин Швецарь Улс нь шууд ардчиллын гол төлөөллүүдийн нэг болдог.

Эгүүлэн татах нь шууд ардчиллын хэрэгсэл болохынхоо хувьд иргэдийн зүгээс сонгуультны үйл ажиллагаанд сэтгэл хангалтгүй байгаагаа илэрхийлж, сонгогчийн эрхээ хэрэгжүүлж буй улс төрийн үйлдэл юм. Шууд ардчиллын процедуруудаас эгүүлэн татах асуудал нь төдийлөн өргөн хэрэглэгддэггүй процедур бөгөөд цөөн тооны орны Үндсэн хууль болон бусад хуулиудад сонгуультныг сонгогчдын саналаар эгүүлэн татах тухай тусгасан байна.

Парламентын гишүүнийг (сонгуульт албан тушаалтныг) сонгогчдын саналаар эгүүлэн татах 2 хэлбэр байна. Үүнд:

- 1) Сонгогчдын саналаар шууд эгүүлэн татах. Энэ тохиолдолд тухайн сонгуулийн тойргийн бүртгэгдсэн сонгогчдын хэчнээн хувийн санаачилгаар санал асуулга юм уу гарын үсэг

а—

<sup>249</sup> Charley Coleman and Neil Johnston, Recall elections, Library House of Commons, SN/PC/05089, 2013.



цуглуулах процессыг эхлүүлэх, хэчнээн хувийн санал, эсхүл гарын үсэг цугласнаар сонгуультныг эгүүлэн татах зэргийг хуульчлан зохицуулсан байна.

- 2) Холимог арга. Сонгогчдын санаачилга, саналыг үндэслэн парламент болон бусад эрх бүхий байгууллагаас гишүүнийг эгүүлэн татах шийдвэр гаргах, эсхүл эрх бүхий байгууллагаас гаргасан эгүүлэн татах шийдвэрийг сонгогчид референдумыг замаар дэмжих буюу няцаах хэлбэр юм.

Парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татдаг эсэх асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд хэрхэн зохицуулсныг 149 орны Үндсэн хуульд түүвэр судалгаа хийв. Судалгааны үр дүнд 149 орноос 23 нь Үндсэн хуулиар тус харилцааг зохицуулсан бол 126 орон нь парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах зохицуулалтыг хуульчлан тогтоогоогүй байдаг<sup>250</sup>.

**Гишүүнийг огцруулах (forfeiture)** зохицуулалт нь төдийлөн түгээмэл бус ч Их Британийн парламентын уламжлал бүхий улс орнуудад түгээмэл байна. Тухайлбал, Энэтхэгийн Лок Сабха (Доод танхим)-гийн гишүүд хуралдааныг зөвшөөрөлгүй 60-аас дээш хоног тасалсан тохиолдолд тухайн гишүүний суудлыг суларсанд тооцно. Зимбабвед парламентын гишүүн чуулганы хуралдааныг 21 хоног дараалж тасалсан бол тухайн гишүүнийг парламентын бүрэлдэхүүнээс хасна. Австралийн Үндсэн хуулийн 20, 38 дугаар зүйлд заасны дагуу парламентын чуулганы хуралдааныг 2 сар дараалан тасалсан Сенатор, Төлөөлөгчдийн танхимын гишүүний орон гарсанд тооцно. Шри Ланкад дээрх хугацаа 3 сар байх бол, Сейшелд Спикерээс бичгээр зөвшөөрөл авалгүй 90-ээс дээш хоног тасалсан бол тус шийтгэлийг ногдуулахаар заасан байна.

Гишүүнийг огцруулах шийтгэл нь зөвхөн Хамтын нөхөрлөлийн орнуудын (Commonwealth) парламентаар хязгаарлагдахгүй бөгөөд Албани, Армен, Австри, Кыргыз, Япон, Тайланд, Турк зэрэг улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, дүрэмд тусгагдсан байна. Туркийн Парламентын гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, эсхүл чөлөө авалгүйгээр нэг сарын дотор нийт таван удаагийн нэгдсэн хуралдааны үйл ажиллагаанд оролцоогүй бол Их хурлын удирдах хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар гишүүнийг огцруулах (loss of mandate) эсэхийг нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Дээрхээс үзэхэд огцруулах, эгүүлэх татах шийтгэл нь гол төлөв нэгдсэн чуулганы хуралдааныг удаан хугацаагаар, удаа дараа тасалсан тохиолдлуудад хамаарах боловч зарим улсад хорооны хуралдааныг тасалсан тохиолдлуудад мөн дээрх шийтгэлийг ногдуулж байна. Энэ төрлийн шийтгэл нь Кот Д'Ивуар, **Францын** Сенат болон Португалийн Парламентад байна. Португалийн хувьд парламентын гишүүн нэгдсэн чуулганыг 4 удаа хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх бол нэг чуулганы хугацаанд хорооны хуралдааныг 4 удаа тасалсан бол гишүүний цалингийн 1/30-тэй тэнцэх хэмжээг суутгана. Гишүүн хорооны хуралдааныг 4-өөс дээш удаа тасалсан бол тухайн хорооны гишүүнчлэлийг нь түдгэлзүүлнэ. **Францын** Сенатад Байнгын хорооны гишүүн хорооны хуралдааныг 3 удаа хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан бол Байнгын хорооны товчоо<sup>251</sup> уг асуудлыг Сенатын Ерөнхийлөгчид танилцуулах бөгөөд Ерөнхийлөгч нь тухайн гишүүнийг гишүүнийг Байнгын хорооноос огцорсон гэж бүртгэнэ. Байнгын хорооны гишүүний гарсан оронг тухайн чуулганы хугацаанд нөхөхгүй бөгөөд тус сенаторын цалинг дараагийн ээлжит чуулган эхлэх хүртэл 50 хувиар бууруулах зохицуулалттай.<sup>252</sup>

а—

<sup>250</sup> УИХТГ, "Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдох судалгаа, мэдээлэл, лавлагаа". 2017 он. номоос дэлгэрүүлэн үзнэ үү.

<sup>251</sup> Сенатын Байнгын хорооны товчоо - Сенатын Байнгын хороод тус бүр товчоотой байх бөгөөд Товчоонд тухайн Байнгын хорооны ерөнхийлөгч, 8 дэд ерөнхийлөгч, 5 хүртэлх нарийн бичгийн дарга нараас бүрдэх бөгөөд Байнгын хорооны ажлын ачаалал, хэлэлцэх асуудлын тов, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах үүрэгтэй. [www.loc.gov/law/help/national-parliaments/france.php](http://www.loc.gov/law/help/national-parliaments/france.php)

<sup>252</sup> Article 15.3, Standing order of the Senate., France, 2014

Дээр дурьдсан санхүүгийн торгууль болон сахилгын шийтгэлүүдээс гадна өөр төрлийн хариуцлагын механизмууд зарим парламентын холбогдох хууль журамд тусгагдсан байна. Тухайлбал, **Эстони, Словак, Болгар** болон Гайтид гишүүдийн ирцийн мэдээг хэвлэн нийтлэх нь нэг төрлийн шийтгэлд тооцогддог байна. Харин Гайтигийн парламентын гишүүн хуралдаанд удаа дараа тасалсан бол түүнийг Товчоо, парламентын бүлгэм зэрэг парламентын зарим үйл ажиллагаанд оролцох эрхийг нь хасах зохицуулалттай байна.

Үүнээс гадна маш цөөн тохиолдолд парламентын ирцийг албадан бүрдүүлэх зохицуулалтууд зарим орны Үндсэн хууль, холбогдох хууль журамд туссан байна. Тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн 1-р хэсгийн 5-р зүйлд заасны дагуу “Танхим бүр сонгууль, түүний үр дүн болон өөрийнх нь гишүүд шаардлагад нийцсэн эсэхийг өөрөө хянана. Танхим бүрийн гишүүдийн ердийн олонхи нь ажлаа явуулах ирцийн бүрдэлтийг хангана. Гэхдээ түүнээс цөөн тооны гишүүдийн ирцтэй байвал хуралдааныг өдөр өдрөөр хойшлуулж болох бөгөөд тэдэнд тухайн Танхимын тогтоосон журам болон шийтгэлийн арга хэмжээг хэрэглэн эзгүй байгаа гишүүдийг албадан авчирч хурлын ирцийг бүрдүүлэх эрх олгож болно. Танхим бүр хуралдааныхаа дэгийг тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь төлөө гишүүнээ шийтгэж, мөн гуравны хоёрын саналаар гишүүнийг бүрэлдэхүүнээсээ хасаж болно. Танхим бүр хуралдааныхаа явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, түүнийгээ тогтмол нийтлэх ёстой бөгөөд түүндээ нууцын шаардлагад хамаарна гэж өөрсдийн үзсэнээс бусад зүйлийг оруулна; Аливаа асуудлаар аль ч Танхимын гишүүдийн “төлөө” болон “эсрэг” өгсөн саналыг хуралдаанд оролцогчдын тавны нэгийн хүсэлтээр сэтгүүлд нийтэлнэ.” гэж заажээ. Дээрхтэй төстэй зохицуулалт Филиппиний хоёр танхимын тус бүрийн Дэгд тусгагдсан байна.

Парламентын гишүүнд сахилгын хариуцлага ногдуулах нь шат дараатай, ил тод явагдах ёстой бөгөөд хүнд шийтгэлийг зөвхөн онц ноцтой зөрчлүүдэд оногдуулна. Европын зөвлөлийн Сайд нарын хороо болон Ардчилсан институт, хүний эрхийн алба/Улс төрийн намын үйл ажиллагааны удирдамжид “шийтгэлүүд нь үр дүнтэй, гэм буруу, ял шийтгэл тэнцвэртэй, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд (*dissuasive*) чиглэсэн байна” гэж заажээ.

Судалгаануудад парламентын хэвийн үйл ажиллагааг хангахад шинээр сонгогдсон гишүүд болон тэдгээрийн ажилтнуудад зориулсан ёс зүйн болон чиглүүлэх сургалтуудын ач холбогдлыг онцолсон байна.<sup>253</sup>

### ***Шийтгэл ногдуулах эрх бүхий субъект***

Дээрхээс үзэхэд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах зэрэг ноцтой шийтгэлүүдийг парламент өөрөө шийдвэрлэдэг байна. Ингэхдээ шийдвэрийг нийт гишүүдийн олонхийн саналаар (Турк), эсхүл нийт гишүүдийн дийлэнх олонхийн (2/3) саналаар шийдвэрлэдэг байна. **Македоны** Үндсэн хуульд гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 6 сараас дээш хугацаагаар хуралдааныг тасалсан бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж заажээ.

Ихэнх тохиолдолд шийдвэрийн төслийг тусгай хороод боловсруулах бөгөөд эдгээр нь Замбид Ирцийн асуудал хариуцсан Хороо, **Японд** Сахилгын байнгын хороо, эсхүл хороо өөрөө хариуцлагатай холбоотой шийдвэр гарах эрхтэй байдаг (Израил) байна. Зарим парламентад шийдвэр гаргах эрхийг парламентын дарга (Беларусь), эсхүл Товчоо (Румын) эдэлдэг байна.

Их Британийн парламентын уламжлал бүхий орнуудад хуралдааны ирц бүрдүүлэх асуудлыг нам хариуцдаг бөгөөд дээрх орнуудад whip буюу “ташуур” хэмээх онцгой эрх бүхий албан тушаалтан нь намын дотоод сахилга батыг хангах, хяналт тавих болон ирц бүрдүүлэх асуудлыг хариуцдаг

а

<sup>253</sup>Background Study: Professional and Ethical Standards for Parliamentarians., OSCE., 2012.  
[www.senat.fr/fileadmin/Fichiers/Images/Ing/Standing\\_orders\\_of\\_the\\_Senate.pdf](http://www.senat.fr/fileadmin/Fichiers/Images/Ing/Standing_orders_of_the_Senate.pdf)

байна.

## **1.2. Парламентын гишүүдийн сахилга бат**

Зарим улсад парламент өөрийн үйл ажиллагааны Дэгийг тогтоох асуудлыг Үндсэн хуульд тусгасан байдаг бол зарим орны хувьд парламент өөрийн үйл ажиллагааны дэгээ тогтоох нь парламентын өөрийн үйл ажиллагаагаа бие даан явуулах эрхийн зүй ёсны үргэлжлэл гэж үздэг байна.

Ихэнх орны парламентын дэгд парламентад хүч хэрэглэхийг хориглосон зохицуулалт туссан байдаг бол **Словакийн** Дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлд дээрхээс гадна галт зэвсэг биедээ авч явахыг хориглосон байна.

Мөн парламентад айлган сүрдүүлэх, өөрийн саналыг дэмжүүлэх буюу бусдын саналыг үгүйсгэх зорилгоор шахалт үзүүлэх зэргийг хориглосон байна.

Гишүүдийн сахилгад хамаарах нэгэн чухал зохицуулалт бол хуралдааныг явуулахад саад учруулж буй үйлдлүүдийг хязгаарлах, хориглох явдал байна. Үүнд, гишүүд хуралдааны дэгийг удаа дараа зөрчих, хуралдааныг хэвийн явуулахад үг хэл, үйлдлээр саад учруулах, хуралдаан даргалагчийн зөвшөөрөл олгоогүй байхад үг хэлэх буюу асуулт тавих, индэр чөлөөлөхгүй байх, хуралдаан даргалагчийн шаардлагыг биелүүлэхгүй байх, илтгэл, асуудалд хамааралгүй мэдээ, мэдээлэл оруулах зэрэг үйлдэл орж байна.

Мөн “парламентын нэр хүнд” (parliamentary dignity)-тэй холбоотой асуудлыг парламентын дэгээр зохицуулах бөгөөд ихэнх орны парламентад бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, үйлдэл гаргахыг хориглосон байна. Зарим орны хувьд, гол төлөв Их Британийн парламентын уламжлал бүхий орнуудад (Канад, Египет, Замби, Зимбабве) “парламентын нэр хүнд” дотор гишүүдийн хувцаслалттай холбоотой заалтууд тусгагдсан байна. Тухайлбал, Энэтхэгийг Раджья Сабха (Дээд танхим)-н дэгд парламентын ёс зүй (parliamentary etiquette)-тэй холбоотой асуудлыг бие даасан бүлгээр зохицуулсан байх бөгөөд үүнд гишүүн хүрмээ гар дээрээ тохон хуралдааны танхимд орж ирэхийг гишүүний ёс зүйд нийцэхгүй үйлдэл гэж үзсэн байна.

### ***Сануулах, донгодох, хуралдаанд оролцох эрхийг хасах шийтгэл***

Сахилгын зөрчил гаргасан парламентын гишүүнд шаардлага тавих (a call to order) шийтгэл нь шийтгэлийн хамгийн хөнгөн бөгөөд түгээмэл хэлбэрийн нэг байна. Тус шийтгэлийг гол төлөв хэлэлцүүлгийг үймүүлсэн, хуралдааны дэгийг зөрчсөн зөрчилд ногдуулна. Тус шийтгэлийг ихэвчлэн хуралдаан даргалагч ногдуулах эрхтэй байдаг ч хуралдаан даргалагч нь парламентын дарга (спикер) байх албагүй байна.

Францын парламентын уламжлал бүхий орнуудад шаардлага тавих шийтгэлийн дараагийн шат нь хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих шийтгэл байна. **Францын** Үндэсний Ассамблейд Ерөнхийлөгч (дарга) нь дээрх шийтгэлийг тухайн хуралдаанд шаардлага тавих шийтгэл авсан, эсхүл бусдыг доромжлох, сүрдүүлэх, бусдыг өдөөн турхирсан зөрчилд ногдуулах бөгөөд тус шийтгэлээр гишүүний сарын цалинг 25 хувиар хасна. **Францын** Сенатад дээрх шийтгэлийг тухайн хуралдаанд сануулга авсан гишүүнд ногдуулах боловч сенаторын цалингаас суутгахгүй байна.

Зарим улсад (Грек, Люксембург, Словени, АНУ зэрэг) анхааруулга, сануулга авсан гишүүд хуралдааны дэгийг үргэлжлүүлэн зөрчсөн бол түүний үг хэлэх, асуулт асуух эрхийг нь түр түдгэлзүүлнэ. Тухайлбал, АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн гишүүний тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх, асуулт асуух эрхийг нь хасна.

Ихэнх парламентад хуралдаан даргалагч нь бүдүүлэг, зохисгүй, “парламентын бус үг хэллэг”-г

хуралдааны тэмдэглэлээс хасуулах эрхтэй байна (Бельги, Кипр, Энэтхэг, АНУ зэрэг).

Францын парламентын уламжлал бүхий орнуудад донгодох сахилгын шийтгэлийг шийтгэлийн 3 дугаарт эрэмбэлэх бөгөөд **Францын** Үндэсний Ассамблейд сануулга авч, хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих шийтгэл хүлээсэн гишүүн хуралдааны дэгийг зөрчсөн, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан зөрчилд ногдуулна. Тус шийтгэл нь харьцангуй хүнд хэлбэрийн шийтгэл бөгөөд шийтгэл ногдуулах асуудлыг Ассамблей шийдвэрлэнэ. Үүнтэй адил шийтгэл Сенатын танхимд мөн үйлчлэх бөгөөд дээр дурьдсан зөрчлөөс гадна бусдыг доромжлох, сүрдүүлэх, бусдыг өдөөн турхирсан, гишүүний мандатыг хэрэгжүүлэхээс бусад зорилгоор ажлын байрыг ашигласан зэрэг зөрчилд ногдуулдаг байна. Дээрх хоёр тохиолдолд гишүүний сарын цалин хөлснөөс тодорхой хувь хэмжээг (Үндэсний Ассамблейд – цалингийн 50 хувь, Сенатад - цалингийн 1/3) суутгана.

Францын парламентын уламжлал бүхий орнуудад донгодох болон гишүүний бүрэн эрхийг түр түдгэлзүүлэх шийтгэл нь хамгийн сүүлийн арга хэмжээнд тооцогдоно. Энэхүү шийтгэлийг **Францад** хоёр буюу түүнээс дээш донгодох шийтгэл авсан, хуралдаанд хүч хэрэглэсэн, парламент, эсхүл парламентын даргыг доромжилсон, БНУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Үндсэн хуульд заасан бусад албан тушаалтанг доромжлох, сүрдүүлэх, өдөөн турхирсан сенатор болон депутатад ногдуулна. **Болгарт** Үндэсний ассамблейн Спикер гишүүний хуралдаанд оролцох эрхийг гишүүн хуралдаан даргалагчийн ногдуулсан сахилгын шийтгэлийг бүдүүлэг, зохисгүй байдлаар эсэргүүцсэн, нэгдсэн чуулганы хуралдааныг хэвийн явуулахад удаа дараа саад учруулсан, мөн **бусдын картаар санал өгсөн** зэрэг тохиолдолд гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасах эрхтэй байна.

### ***“Нэр дуудах” шийтгэл***

“Нэр дуудах” буюу naming шийтгэл нь Их Британийн уламжлал бүхий улс орнуудад (Австрали, Канад, Кени, АНУ гм.) түгээмэл хэрэглэгддэг шийтгэлийн хэлбэр бөгөөд хурал даргалагчийн ногдуулж болох хамгийн хүнд шийтгэл байна. Канадад Спикерийг үл хүндэтгэсэн, бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн, холбогдолгүй, хамааралгүй асуудлаар ярих, үг хэлж буй гишүүний яриаг тасалж буй гишүүнд дээрх шийтгэлийг ногдуулна. Тус шийтгэлийг ногдуулахаас өмнө Спикер тухайн гишүүнд сануулга өгнө. Хэрэв гишүүн уучлал гуйж, Спикер хүлээн авсан тохиолдолд цааш ямар нэгэн арга хэмжээ авахгүй, харин тус шийтгэлийг ногдуулсан тохиолдолд Спикер тухайн гишүүнийг хуралдаанд оролцуулахгүй байх, эсхүл Парламент шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авахыг хүлээж болно. Спикер хоёрдугаар хувилбарыг сонгосон тохиолдолд өөр нэг гишүүн, ихэнх тохиолдолд Танхим дахь Засгийн газрын тэргүүн-гишүүнийг хуралдаанд оролцох эрхийг хасах саналыг нэн даруй оруулах бөгөөд тухайн саналыг хэлэлцэхгүй, өөрчлөлгүйгээр санал хураалт явуулна. Саналыг дэмжсэн тохиолдолд гишүүн Танхимаас гарч явах үүрэгтэй.

### ***Нэмэлт шийтгэлүүд***

Дээр дурьдсан шийтгэлүүдээс гадна дараах гурван төрлийн нэмэлт шийтгэл байж болно. Үүнд: мөнгөн торгууль, албан ёсоор уучлал гуйх болон loss of seniority буюу давуу эрхээ алдах зэрэг байна.

Мөнгөн торгууль хоёр төрөл байж болох бөгөөд зарим парламентад торгууль нь өөрөө шийтгэлийн нэгэн хэлбэр болох бол (Габон, АНУ), зарим парламентад сахилгын шийтгэл нь цалин хөлсийг тодорхой хугацаанд хасах, суутгах арга хэмжээг агуулж байдаг (Франц – донгодох гм).

Цөөнгүй орнуудад хуралдаан даргалагч нь гишүүнд албан ёсоор уучлал гуйхыг тушааж болох бөгөөд энэ төрлийн шийтгэл нь Азийн орнуудад түгээмэл (**Япон, Лаос, Өмнөд Солонгос**) байх бөгөөд **Словак, АНУ** зэрэг бусад орнуудад мөн хэрэглэгддэг байна.

АНУ-ын Төлөөлөгчдийн танхим нь зөрчил гаргасан гишүүнд нэгэн онцгой төрлийн шийтгэл ногдуулдаг бөгөөд энэ нь давуу эрхийг хасах шийтгэл юм. Тус шийтгэлийг гишүүнд сахилгын шийтгэл гэхээс илүүтэйгээр гишүүний “ёс зүй”-н дүрмийг зөрчсөн тохиолдлуудад ногдуулах бөгөөд энэ нь “ёс төдий” шийтгэл бус байна. Давуу эрх гэдэг нь тодорхой эрх эдлэх, албан тушаалд томилогдох зэрэгт шалгуур болдог байна. Тухайлбал, өрөө тасалгаа хуваарилах, байнгын хорооны даргаар сонгогдох гм.

### ***Шийтгэл ногдуулах эрх бүхий субъект***

Дээр дурьдсанчлан хамгийн хөнгөн шийтгэлийг хуралдаан даргалагч ногдуулах эрхтэй байна. Хуралдаан даргалагч нар нь хуралдааныг хэвийн явуулах, сахилга батыг хангуулах үүрэгтэй учир дээрх эрхийг эдэлдэг байна. Тухалбал, **Францад** гишүүнд зөвхөн Ерөнхийлөгч (Парламентын дарга) сануулга өгөх эрхтэй байх бөгөөд бусад хүнд төрлийн шийтгэл (донгодог, гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасах гм)-ийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент шийдвэрлэнэ. Люксембургт хуралдаанд оролцох эрхийг хассан донгодох шийтгэлээс бусад сахилгын шийтгэлийг хуралдаан даргалагч ногдуулна. Хуралдаан оролцох эрхийг хасах шийтгэлийг хуралдаанд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар ногдуулна. Гишүүн бусад гишүүдийг доромжилсон, хүч хэрэглэсэн бол Хөдөлмөрийн байнгын хороо нь донгодох, хуралдаанд оролцох эрхийг түр түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Дийлэнх улсын парламентад хөнгөн зөрчилд хуралдаан даргалагч шийтгэл ногдуулах зохицуулалттай байгаа хэдий ч зөрчил гаргасан гишүүн гомдол гаргах зохицуулалт мөн туссан байна. Тухайлбал, Бельгийн Сенатад шийтгэл хүлээсэн гишүүн нь Сенатын Товчоонд гомдол гаргаж болно гэж заажээ. Энэтхэгийн Лок Сабха (Доод танхим)-д Спикер нь гишүүнд сануулга өгөх эрхтэй байх бол хуралдаанд оролцох бүрэн эрхийг түр түдгэлзүүлэх асуудлыг парламент шийдвэрлэх, мөн тухайн шийдвэрийг хэрэгсэхгүй болгох эрхтэй байна. АНУ-д Спикер нь бүдүүлэг үг хэллэг хэрэглэсэн гишүүнд хариуцлага тооцох бөгөөд үүнд гишүүн гомдол гаргаж болох бөгөөд эцсийн шийдвэрийг парламент гаргана.

АНУ-ын шийтгэл ногдуулах процедурын өөр нэгэн өвөрмөц шинж нь шийтгэл ногдуулах санаачилга гаргах эрхийг Спикерээс гадна бусад гишүүд эдэлдэгт оршино. Аль ч гишүүн зөрчил гаргасан гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах, сануулга өгүүлэхийг санаачлах, санал болгох эрхтэй байна. Дээрх нь мөн бусад оронд хэрэглэгддэг байна. Тухайлбал, **Румынд** ноцтой, эсхүл удаа дараа давтагдаж буй зөрчлийг Хууль зүйн байнгын хороо шийдвэрлэдэг байна. Ингэхдээ шийтгэл ногдуулах өргөдлийг парламентын бүлэг, сенатор, депутат гаргаж болно. Хууль зүйн байнгын хороо нь Товчоонд мэдэгдэх бөгөөд Товчоо шийдвэр гаргана. Үүнтэй төстэй зохицуулалт **Словакийн** холбогдох хууль журамд туссан бөгөөд Гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын хороо нь өөрөө, эсхүл өөрийгөө хохирогч гэж үзсэн гишүүн өргөдөл гарган шийдвэрлүүлдэг байна.

Маш цөөн тохиолдолд бүх сахилгын шийтгэлийг парламентын даргын санал болгосноор парламент шийдвэрлэдэг байна (Чад). Ихэнх тохиолдолд зөвхөн хүнд шийтгэлүүд болох хуралдаанд оролцох бүрэн эрхийг түр түдгэлзүүлэх, парламентын бүрэлдэхүүнээс хасах асуудлыг парламент шийдвэрлэх бөгөөд зарим тохиолдолд тусгай кворум шаардлагатай байна. Филиппинд гишүүний эрхийг 60 хоногоос дээш хугацаагаар түдгэлзүүлэхгүй бөгөөд асуудлыг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Дээрхээс гадна цөөн тооны орнуудад шийтгэл ногдуулах асуудлыг Товчоо, эсхүл түүнтэй адилтгах байгууллага (Лаос), эсхүл тусгай хороо шийдвэрлэнэ. Израилийн Кнессетэд Спикер нь сануулга өгөх арга хэмжээ авч болдог ч илүү хүнд шийтгэлийг Ёс зүйн хороо ногдуулна. **Өмнөд Солонгост** Парламентын Спикер нь гишүүдийн сахилгатай холбоотой асуудлыг Ёс зүйн тусгай хороонд шилжүүлэх бөгөөд хороо нэгдсэн чуулганд танилцуулж, парламент эцсийн шийдвэрийг



гаргадаг байна. Ёс зүйн хороо бүхий парламентуудад дээрх хороод нь ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

### 1.3. Парламентын гишүүний ёс зүйн дүрэм

Гишүүдийн ёс зүйн дүрэм “code of conduct” гэх парламентын гишүүдийн ёс зүйтэй холбоотой бүхий л асуудлыг зохицуулж буй хэм, хэмжээний хувьд Их Британийн уламжлал бүхий улс орнуудад түгээмэл байна. Ихэнх орнуудын хувьд парламентын гишүүний ёс зүйтэй холбоотой зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжуудаар зохицуулсан байна (хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байх гм).

Гадаадын зарим орны парламентын гишүүдийн ёс зүйтэй холбоотой зохицуулалтыг Хавсралтаас үзнэ үү.

#### **Их Британи загварын ёс зүйн дүрэм**

Их Британийн парламентын хувьд Ёс зүйн дүрэм нь харьцангуй шинэ үзэгдэл (1996) боловч ашиг сонирхлын зөрчил болон ямар нэгэн төрлийн нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх нь парламентын үйл ажиллагааны зарчим байсаар ирсэн. Парламентын гишүүний “ёс зүйн дүрэм”-ийн зорилго нь гишүүний үйл ажиллагаа гишүүний ёс зүйд нийцэх эсэхийг тогтооход оршино. Ёс зүйн дүрэм нь гишүүний улс төрийн үүргийг нарийвчлан тогтоодог байна. Үүнд: Эзэн хаан/Хатан хаанд үнэнч байх, хууль дээдлэн сахиж, улс орон нэн ялангуяа сонгогчдын ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулах зэрэг байна.

Ёс зүйн дүрмээр гишүүд (түүнчлэн Засгийн газрын гишүүд, quango<sup>254</sup>-ийн удирдлагууд) өөрсдийн үйл ажиллагаандаа “долоон зарчим” (*seven principles of public life*) болох бие даасан байдал, шударга байдал, бодитой байх, хариуцлагатай байх, ил тод байдал, шударга ёс, манлайллын зарчмыг баримтлахыг заасан байна. Гишүүний хувийн ашиг сонирхол, нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөж байвал гишүүн нийтийн ашиг сонирхлыг дээдэлнэ.

Их Британи загварын ёс зүйн дүрэм нь Филиппинд байх бөгөөд ёс зүйн дүрэм бүхий хууль нь нийтийн болон төрийн бүхий л албан тушаалтанд хамаарна.

#### **Бусад хувилбарууд**

Тринидад Тобагод Парламентын болон Засгийн газрын гишүүдийн ёс зүйн кодекс, Замби Улсад Парламент болон Засгийн газрын гишүүдийн ёс зүйн дүрмийн тухай хуультай байна. Бусад орнуудад (Израил, Япон) болон Европын Парламентад ёс зүйн дүрэм нь дээрхээс бага зэрэг ялгаатай байна.

Европын Комиссын Ёс зүйн дүрэм нь 2018 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан байна. Шинэчлэгдсэн Ёс зүйн дүрмээр ёс зүйн дүрмийг тодорхой болгож, ил тод байдлыг нэмэгдүүлж, Ёс зүйн тусгай хороог бие даасан Ёс зүйн байнгын хороогоор сольсон байна.

Израилийн Кнессентын гишүүн нь бусад цалин хөлс бүхий ажил үүрэг гүйцэтгэхгүй, албан тушаал хаших хориотой байдаг ба энэ нь цалин хөлс бүхий ажил, албан тушаалд хамаарах боловч, гишүүд цалин, хөлсгүй дараах ажил, албан тушаал эрхлэхээс татгалзана. Үүнд: 1)

а —————  
<sup>254</sup> Quango нь quasi-NGO буюу хагас-ТББ-ын товчилсон нэрээс үүсчээ. Ердийн ТББ-ууд хандив, тэдний үйл ажиллагааг дэмждэг бусад байгууллагын хөрөнгөөр санхүүждэг бол нь хагас-ТББ нь засгийн газраас санхүүгийн болон бусад дэмжлэгтэйгээр засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Quango-г ялангуяа Их Британи, Ирланд, Австрали, бусад орны албан бус хэлэнд засгийн газар эрх шилжүүлсэн байгууллагуудыг нэрлэхэд хэрэглэдэг байна. Их Британид албан ёсны нэр нь “яамны бус статустай улсын салбарын байгууллага”.



Парламент, эсхүл гишүүний дүр төрхийг гутаасан; 2) парламентын гишүүний статусыг ашиглан хөрөнгө хуримтлуулах, эсхүл давуу эрх авах; 3) ашиг сонирхлын зөрчил үүсгэх.

**Германы** Бундестаг нь 1972 онд Гишүүний ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд тус дүрмээр парламентын гишүүний бусад албан тушаал хаших, ажил эрхлэхтэй холбоотой зарчим, ингэхдээ гишүүн аливаа ашиг орлого бүхий үйл ажиллагаагаа ил тод болгохоор заагдсан байна. Түүнчлэн ёс зүйн дүрэмд гишүүн тодорхой мэдээлэл, мэдээллийг ил болгох нөхцөл болон хандив, үнэтэй бэлэг дурсгал авахад хязгаар тогтоож өгсөн байна.

**Японы** Парламентын гишүүний үйл ажиллагааны стандарт (Standard of Conduct for Diet Members)-д гишүүд аливаа ёс зүйн алдаа гаргахгүй байх, мөн тэдгээрийн үнэнч, шударга байдалд харшлах аливаа үйлдэл гаргахгүй байхыг шаардлага болгодог байна.

### ***Ёс зүйн дүрэм зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага***

Парламентын гишүүн нь ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх болон хэн хариуцлага ногдуулах ёстой вэ гэх асуулт зүй ёсоор гарч ирнэ. Үүнд гишүүний гэмт хэрэг үйлдсэн тохиолдлыг хамруулаагүй болно.

Ихэнх орны хувьд ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь парламентын дэг журмыг зөрчигсдөд хүлээлгэх сахилгын шийтгэлтэй адил байх боловч зарим парламент “ёс зүйн алдаа” гаргасан гишүүдэд тусгай шийтгэл ногдуулдаг байна.

Их Британид ёс зүйн зарим дүрмийг зөрчсөн үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэнд тооцдог бөгөөд онолын хувьд Нийтийн танхим нь зөрчил гаргасан гишүүнд хорих шийтгэл оногдуулах, тодорхой хугацаагаар гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүнийг парламентын бүрэлдэхүүнээс хасах эрхтэй байх боловч практик дээр дээрх шийтгэлүүдийг төдийлөн хэрэгждэггүй байна. Ёс зүйн дүрэм зөрчсөн эсэхийг тогтоож, шийтгэл ногдуулах асуудлыг зөвхөн тусгай хороогоор (*Select Committee on Standards and Privileges*) дамжуулан Танхим шийдвэрлэнэ.

Дээрхтэй адил зохицуулалт Израилийн Кнессетэд байх бөгөөд зөвхөн Ёс зүйн хороо ёс зүйн алдаа гаргасан гишүүнд хариуцлага тооцох эрхтэй байна. Зөрчил гаргасан гишүүнд гомдол хүлээж авсныг мэдэгдэх үүрэгтэй бөгөөд зөрчил гаргасан гишүүн бичгээр хариу өгөх эрхтэй байна. Мөн тэдгээр нь Хорооны сонсголд үг хэлэх, өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй байна.

**Японд** ёс зүйн дүрэм зөрчигсдөд хариуцлага тооцох асуудлыг Улс төрийн ёс зүйн зөвлөлдөх зөвлөл (*The Deliberative Council on Political Ethics*) шийдвэрлэнэ. Дээр дурьдсанчлан зөрчил гаргасан гишүүн хорооны сонсголд үг хэлэх эрхтэй байна. Гишүүнийг ёс зүйн дүрэм зөрчсөн гэж шийдвэрлэсэн тохиолдолд дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд: 1) цаашид ёс зүйн дүрмийг баримтлах шаардлага тавих (тушаах); 2) гишүүний хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хасах; 3) гишүүнийг тодорхой өндөр албан тушаалаас огцрохыг шаардах зэрэг байна. Нөгөөтэйгүүр, Зөвлөл нь гомдлыг хянан шалгасны дүнд гишүүнийг гэм буруугүйд тооцсон тохиолдолд гишүүний нэр хүндийг “сэргээх” арга хэмжээ авч болно.

Дээрхээс үзэхэд ёс зүйн дүрэм зөрчсөн, ёс зүйн алдаа гаргасан гишүүнд хариуцлага тооцох, эсхүл тус асуудлыг нэгдсэн чуулганаар оруулах үүргийг тусгай хороо гүйцэтгэж байна гэж үзэж болохоор байна. Гэхдээ зарим тохиолдолд хуралдаан даргалагч шийдвэр гаргах эрхтэй байдаг байна. Тухайлбал, **Германы** Бундестагийн Ерөнхийлөгч (дарга) нь гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх эрхтэй байна. Түүнчлэн, зарим улсад ёс зүйн дүрэм зөрчсөн гишүүнд шүүхээс хариуцлага ногдуулж болдог байна. Тухайлбал, Замбид парламентын гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн Дээд шүүх, эсхүл Өндөр дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байсан шүүгч дундаас томилсон гурван шүүгчээс бүрдэх шүүх шийдвэрлэдэг байна.

**Болгарт** Авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан хороо болон Парламентын ёс зүйн хороо нь гишүүнийг ёс зүйн алдаа гаргасан эсэхийг хянан шалгаж, зөрчил гаргасан гишүүдэд дараах сахилгын шийтгэлийг хүлээлгэнэ. Үүнд: донгодох, хатуу донгодох, хорооны 3 хүртэлх хуралдаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх зэрэг байна. Хороо нь дээрх шийтгэлийг ногдуулахдаа зөрчлийн төрөл, зөрчил гаргаж буй давтамжийг харгалзан үзнэ. Хорооны хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүний оролцоогүй хуралдааны цалинг олгохгүй.

Парламентын гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, анхааруулгыг парламентын аль ч гишүүн, хувь хүн, эсхүл хуулийн этгээд Авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан хороо болон Парламентын ёс зүйн хороонд гаргах эрхтэй байна.

## **2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **ФРАНЦ УЛС**

- Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ)-ын Үндсэн хуульд зааснаар Парламентын доод танхим болох Үндэсний ассамблейн гишүүдийн тоо 577-оос хэтрэхгүй байх ба тэд шууд сонгогдоно.<sup>255</sup>
- Үндэсний ассамблейн гишүүдийн хуралдаанд оролцох, ямар үйлдлийг зөрчил гэж тооцож хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг Үндэсний ассамблейн дэгийн тухай регламент<sup>256</sup> буюу Дэгээр зохицуулна. Уг Дэгийг Үндэсний ассамблей 1959 оны 6 дугаар сарын 3-ны өдөр баталж, Үндсэн хуулийн зөвлөл 6 дугаар сарын 24-ний өдөр БНФУ-ын Үндсэн хуультай нийцэж байгааг хүлээн зөвшөөрсөн байна.

Үндэсний ассамблейн дэгийн 42 дугаар зүйлд зааснаар гишүүд хуралдаанд заавал оролцоно. Хэрэв гишүүн нь сард 2-оос дээш удаагийн хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр суугаагүй бол гишүүний 1 сарын хөдөлмөрийн хөлснөөс 25 хувийг суутгана.

2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр энэ Дэгийн 70 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөөр дараах үйлдэл хийсэн Үндэсний ассамблейн гишүүдийг зөрчил гаргасан гэж үзэн сахилгын шийтгэл оногдуулна. Үүнд:

- дэг журам зөрчсөн жагсаал, цуглаан, үймээн өдөөх;
- бусад гишүүнийг доромжлох, эсхүл тэдэнд заналхийлэх;
- нээлттэй хуралдаан дээр хүчирхийллийг өдөөх;
- Үндэсний ассамблей болон Үндэсний ассамблейн Ерөнхийлөгчийг доромжлох, эсхүл өдөөн турхирах;
- БНФУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын болон Парламентын гишүүдийг доромжлох, эсхүл өдөөн турхирах, эсхүл тэдэнд заналхийлэх;
- Үндэсний ассамблейн байранд халдлага зохион байгуулах;
- Үндэсний ассамблейн дэгд заасан бусад ёс зүйн зөрчил гаргах.

Зөрчил гаргасан гишүүдэд дараах сахилгын шийтгэлийг хүлээлгэнэ. (Дэгийн 71-р зүйл) Үүнд:

- шаардлага тавих;
- хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих;
- арга хэмжээ авах /донгодох/;
- гишүүний эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлэх.

а

<sup>255</sup> БНФУ-ын 1958 оны Үндсэн хуулийн 24 дүгээр зүйл. [www.legifrance.gouv.fr/Droit-francais/Constitution](http://www.legifrance.gouv.fr/Droit-francais/Constitution)

<sup>256</sup> Règlement de l'Assemblée Nationale. [www2.assemblee-nationale.fr](http://www2.assemblee-nationale.fr)

Энгийн шаардлагыг Үндэсний хурлын Ерөнхийлөгч (цаашид Ерөнхийлөгч гэх) тавина.

Хуралдааны тэмдэглэлээр шаардлагыг Үндэсний ассамблейн товчоо<sup>257</sup> (цаашид Товчоо), эсхүл Ерөнхийлөгч тавина. Тухайлбал, Ерөнхийлөгчийн саналаар, эсхүл өөрийгөө хохирогч хэмээн үзсэн гишүүний бичгээр гаргасан гомдлын дагуу Товчоо нь хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавина. (Дэгийн 72-р зүйл)

Энгийн арга хэмжээ авах болон түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээг Товчооны саналаар гаргах ба үүнийг хэлэлцэхгүй Үндэсний ассамблейд сонсгоно. (Дэгийн 72-р зүйл)

Зарим сахилгын шийтгэлээр Үндэсний ассамблейн гишүүнд олгогдсон эрхийг хэсэгчлэн түдгэлзүүлнэ. Тухайлбал, хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих нь гишүүний эрхийн 1/4-ийг түдгэлзүүлэх бол энгийн арга хэмжээ авах нь гишүүний бүрэн эрхийн тэн хагасыг 1 сарын турш тус тус түдгэлзүүлэх үр дагавартай. (Дэгийн 73-р зүйл)

Мөн түр хугацаагаар түдгэлзүүлэх сахилгын шийтгэл нь гишүүний эрхийн тэн хагасыг 2 сарын турш түдгэлзүүлэх үр дагавартай бөгөөд энэ нь сахилгын шийтгэл оногдуулсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд Үндэсний ассамблейн үйл ажиллагаанд оролцох, Үндэсний ассамблейн ордонд хүрэлцэн ирэхийг тус тус хориглоно. Харин тухайн гишүүнд энэ сахилгын шийтгэлээр давтан хариуцлага хүлээх бол хугацааг 30 хоног хүртэл сунгана. (Дэгийн 73-р зүйл)

Сахилгын шийтгэлтэй хугацаандаа бусад гишүүн, эсхүл гишүүдэд дахин халдах болон Ерөнхийлөгчийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй бол дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана. Цаашлаад ноцтой халдлагыг үйлдвэл Ерөнхийлөгч нь нэн даруй Ерөнхий прокурорыг дуудах ёстой. (Дэгийн 77-р зүйл)

Хуралдаан дээр санал хураалтыг залилах тохиолдолд гишүүний эрхийн 1/4-ийг 1 сарын турш түдгэлзүүлэх ба мөн хуралдаан дээрээ санал хураалтын журмыг дахин зөрчвөл дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана. (Дэгийн 77-р зүйл)

**Хүснэгт 1. Сахилгын шийтгэлийн төрөл**

<b>Сахилгын шийтгэлийн төрөл</b>	<b>Хариуцлага хүлээлгэх субъект</b>	<b>Санаачилга гаргах эрх бүхий субъект</b>	<b>Гишүүний эрхийг хэсэгчлэн түдгэлзүүлэх</b>	<b>Тайлбар</b>
Шаардлага тавих	Ерөнхийлөгч	Товчооны саналаар		
Хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавих	-Товчоо, -Ерөнхийлөгч	-Ерөнхийлөгчийн саналаар, -өөрийгөө хохирогч хэмээн үзсэн гишүүний бичгээр гаргасан гомдлын дагуу	гишүүний эрхийн 1/4-ийг түдгэлзүүлэх	
Арга хэмжээ авах /донгодох/	Товчоо	Товчооны саналаар	гишүүний эрхийн тэн хагасыг 1 сарын турш түдгэлзүүлэх	
Гишүүний эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлэх	Товчоо	Товчооны саналаар	гишүүний эрхийн тэн хагасыг 2 сарын турш түдгэлзүүлэх	-Үндэсний ассамблейн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно, -Үндэсний ассамблейн ордонд хүрэлцэн ирэхийг хориглоно

а  
<sup>257</sup> Үндэсний ассамблейн товчоо - Үндэсний ассамблейн зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдлагаар хангах хамтын дээд байгууллага ба Үндэсний ассамблейн Ерөнхийлөгч, 6 дэд ерөнхийлөгч, 3 квестор, 12 нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ.

	Товчоо	Нарийн бичгийн даргын саналаар	гишүүний эрхийн 1/4-ийг 1 сарын турш түдгэлзүүлэх	санал хураалтын журмыг зөрчсөн тохиолдолд
--	--------	--------------------------------	---	---

## **БОЛГАР УЛС**

- Бүгд Найрамдах Болгар Улсын Үндсэн хуульд зааснаар Үндэсний ассамблейн гишүүдийн тоо 240 байх ба гишүүд шууд сонгогдоно.
- Парламент дахь сахилга баттай холбоотой харилцааг Үндсэн хууль (77.1.3) болон Үндэсний ассамблейн дэгийн 3-р бүлэг (155-164 дүгээр зүйл)-ээр зохицуулна.

Парламентын дэг (Үндэсний Ассамблейн зохион байгуулалт болон үйл ажиллагааны дэг - *Rules of Organisation and Procedure of the National Assembly*<sup>258</sup>)-ийг 2017 оны 5 дугаар сарын 2-ны өдөр баталж мөн өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн байна. Дэг нь 12 хэсэг, 154 зүйлээс бүрдэх бөгөөд Үндэсний ассамблейн гишүүн гэх 12 дугаар бүлэг нь эрх зүйн байдал, ёс зүйн дүрэм, парламентын горим (сахилга бат) гэх гурван хэсгээс бүрдэж байна.

Гишүүний чуулганы хуралдаанд оролцох үүрэгтэй холбоотой асуудлыг Дэгийн Парламентын гишүүний эрх зүйн байдал дэд хэсгийн 130, 136 дугаар зүйлд тусгасан байна. Үндэсний ассамблейн гишүүн бүр Үндэсний ассамблейн бүтцийн нэгжид сонгогдох эрхтэй байх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээнэ (130 дугаар зүйл):

- 1) Үндэсний ассамблейн гишүүн нь Үндэсний ассамблейн чуулганы хуралдаан болон өөрийн сонгогдсон Байнгын хороодын хуралдаанд оролцох үүрэг хүлээнэ;
- 2) Үндэсний ассамблейн гишүүн хуралдааныг дуусахаас өмнө гарах, эсхүл хоцрох бол хариуцсан Нарийн бичиг, эсхүл холбогдох Байнгын хорооны удирдлагад мэдэгдэнэ;
- 3) Гишүүн Үндэсний ассамблейн, эсхүл Байнгын хорооны хуралдаанд “хүндэтгэн үзэх шалтгаан”-аар оролцох боломжгүй бол Парламентын дарга, эсхүл холбогдох байнгын хорооны даргад урьдчилан мэдэгдэнэ (136 дугаар зүйл).

Мөн дэд хэсэгт парламентын гишүүний хавсран гүйцэтгэж болох ажил, мэргэжил, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг тусгасан байна.

12 дугаар бүлгийн 2 дугаар дэд хэсэгт Гишүүний ёс зүйтэй холбоотой асуудлыг зохицуулсан байна. Тус дэд бүлэгт гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хуулийг дээдлэн сахих, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нээлттэй, хариуцлагатай, ил тод байх зарчмуудыг баримтална гэж заажээ.

Парламентын гишүүн нь улс төрийн үзэл бодол, албан тушаал, санаа бодлыг үл харгалзан ард иргэдэд хүндэтгэлтэй хандана. (143 дугаар зүйл)

Авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан хороо болон Парламентын ёс зүйн хороо нь энэхүү дэд хэсэгт заасан зохицуулалтыг зөрчсөн (ёс зүйн алдаа гаргасан) эсэхийг хянан шалгаж, зөрчил гаргасан гишүүдэд дараах сахилгын шийтгэлийг хүлээлгэнэ. (153 дугаар зүйл) Үүнд:

- донгодох (reprimand);
- хатуу донгодох (censure)<sup>259</sup>;
- Хорооны 3 хүртэлх хуралдаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх.

Хороо нь дээрх шийтгэлийг ногдуулахдаа зөрчлийн төрөл, зөрчил гаргаж буй давтамжийг

a\_\_\_\_\_

<sup>258</sup> <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

<sup>259</sup> “reprimand” expressly involves a lesser level of disapproval of the conduct of a Member than that of a “censure,” and is thus a less severe rebuke by the institution. Expulsion, Censure, Reprimand, and Fine: Legislative Discipline in the House of Representatives., <http://archives-democrats-rules.house.gov/archives/r131382.pdf>

харгалзан үзнэ. Хорооны хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүний оролцоогүй хуралдааны цалинг олгохгүй.

Парламентын аль ч гишүүн, хувь хүн, эсхүл хуулийн этгээд ёс зүйн асуудлаар гомдол, анхааруулгыг Авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан хороо болон Парламентын ёс зүйн хороонд гаргах эрхтэй байна. (154 дүгээр зүйл)

12 дугаар бүлгийн 3 дугаар дэд хэсэгт парламентын горим (*parliamentary behavior*)-той холбоотой асуудлыг тусгасан бөгөөд Үндэсний ассамблейн гишүүд нь Үндэсний ассамблейн эрх мэдлийг харгалзан бусад гишүүд болон хүмүүст хүндэтгэлтэй хандана. 2) Үндэсний ассамблейн гишүүд нь өөрсдийн суудлаас спикерийн үгийг тасалдуулахгүй байх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх үйлдэл гаргахгүй байх, бусдыг сүрдүүлэхгүй байх, хувийн амьдралтай холбоотой, эсхүл иргэдийн нэр хүндэд хохирол учруулах мэдээллийг ил болгох, мөн хуралдааны дэгийг зөрчсөн аливаа үйлдэл гаргахыг хориглоно.

Зөрчил гаргасан парламентын гишүүнд дараах шийтгэлийг хүлээлгэнэ. (156 дугаар зүйл). Үүнд:

- сануулах (remider);
- донгодох (reprimand);
- хатуу донгодох (censure);
- үг хэлэх эрхийг нь хасах;
- хуралдаан оролцох эрхийг хасах;
- 3 хүртэлх хуралдаанд оролцох эрхийг хасах зэрэг байна.

Хэлэлцүүлгийн асуудлаас гажсан парламентын гишүүнд Спикер сануулга өгнө. (157 дугаар зүйл)

Донгодох шийтгэлийг Спикер бусад гишүүдийг доромжилсон үг хэллэг хэрэглэсэн, үйлдэл гаргасан, эсхүл бусдыг сүрдүүлсэн гишүүнд ногдуулна. (158 дугаар зүйл)

Хатуу донгодох шийтгэлийг Спикер хуралдааны дэгийг зөрчсөн, эсхүл чуулганы танхимд эмх замбараагүй байдал үүсгэсэн гишүүнд ногдуулна. (159 дугаар зүйл)

Спикер дараах тохиолдолд гишүүний үг хэлэх эрхийг хасна. (160 дугаар зүйл) Үүнд:

- тухайн хуралдааны хугацаанд гишүүнд 156.1-3-т заасан шийтгэлийн 2-ийг ногдуулсан;
- үг хэлэх/асуулт асуух хугацаа хэтэрч, Спикер яриагаа дуусгавар болгохыг санал болгосон ч үргэлжлүүлсэн бол.

Спикер дараах тохиолдолд гишүүний хуралдаанд оролцох эрхийг хасна. (160 дугаар зүйл) Үүнд:

- ногдуулсан сахилгын шийтгэлийг бүдүүлэг, зохисгүй байдлаар эсэргүүцсэн;
- нэгдсэн чуулганы хуралдааныг хэвийн явуулахад удаа дараа саад учруулсан бол;
- бусдын картаар санал өгсөн бол.

Спикер дараах тохиолдолд гишүүнд 1-3 хуралдаанд оролцох эрхийг хасна. (161 дүгээр зүйл) Үүнд:

- Үндэсний ассамблей, Сайд нарын зөвлөл, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон төрийн бусад байгууллагыг доромжилсон бол;
- Чуулганы танхим, Үндэсний ассамблейд хүч хэрэглэсэн, хэрэглэхийг уриалсан бол.

Хуралдаанд оролцох эрхийг хассан шийтгэл ногдуулсан гишүүний тухайн хуралдаанд оролцоогүй өдрийн хөлсийг олгохгүй.

Сахилгын шийтгэл хүлээн авсан гишүүн шийтгэл ногдуулснаас хойш 3 хоногийн дотор Спикерт тухайн шийтгэлийг эсэргүүцэн гомдол гаргах эрхтэй байх ба Спикер гомдлыг хүлээн авах, хэрэгсэхгүй болгох, эсхүл ногдуулсан сахилгын шийтгэлийг өөрчлөх эрхтэй байна.

Парламентын гишүүдэд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг Үндэсний ассамблейн вeб хуудсанд нийтэлнэ. (163 дугаар зүйл)



Үндэсний ассамблейн веб хуудсанд Байнгын хороо, дэд хороо, ажлын хэсэг болон холбогдох нэгдсэн чуулганы хуралдааныг хүндэтгэн үзэх шаалтгаангүй тасалсан талаарх мэдээллийг сар бүр нийтэлнэ. Мэдээллийг тухайн сар дууссанаас хойших 7 хоногийн дотор нийтэлнэ. (164 дүгээр зүйл)

Дэгийн хавсралтаар Үндэсний ассамблейн төсөв, санхүүгийн дүрэм, гишүүдийн цалин хангамжтай холбоотой асуудлыг зохицуулсан байна. Хавсралтын 13 дугаар зүйлд гишүүн нэгдсэн чуулганы хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан бол гишүүний цалин хөлснөөс тохирсон хувийг (хувь тэнцүүлэн), гишүүн Байнгын хороо, дэд хороо, Парламентын ажлыг хэсгийг хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан бол гишүүний цалингийн холбогдох хувийг тус тус суутгахаар заасан байна. Гишүүн тухайн сард хуралдааныг 3 дараалж, эсхүл нийт 5 хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан бол цалингийн 2/3-ыг хасах, цалин хөлсний нэмэгдлийн (гишүүнд цалингийн 2/3-тай тэнцэх нэмэгдлийг гишүүдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд олгоно. Үүнд: зөвлөх үйлчилгээ, шинжээчдийн дүн шинжилгээ, өрөө тасалгаа түрээслэх зардал гм.) 1/3-аас илүүгүйг олгоно. Гишүүдийн ирц бүрдээгүйн улмаас чуулганы хуралдаан хуралдаагүй бол хүрэлцэн ирээгүй гишүүдийн тухайн өдрийн цалингийн 2/3-ыг суутгана.

### **СЛОВАК УЛС**

- Бүгд Найрамдах Словак Улсын Үндсэн хуульд зааснаар Үндэсний зөвлөл (Парламент) гишүүдийн тоо 150 байх ба гишүүд шууд сонгогдоно.
- Парламент дахь сахилга баттай холбоотой харилцааг Үндсэн хууль (75 дугаар зүйл Парламентын гишүүний тангараг) болон Үндэсний зөвлөлийн дэгийн тухай хуулийн 20 дугаар бүлэг (2, 32, 39, 57, 135-139 дүгээр зүйл)-ээр зохицуулна.

Парламентын дэгийн тухай хууль (*Act on rules and Procedure of the National council*<sup>260</sup>)-ийг 1996 онд баталсан. 1997 оны 1-р сарын 1-ий өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд 1998-2017 онуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Дэгийн тухай хууль нь 23 бүлэг, 152 зүйлээс бүрдэх бөгөөд парламентын гишүүний сахилга баттай холбоотой асуудлыг “Сахилгын арга хэмжээ” гэх 20 дугаар бүлэгт тусгасан байна.

Гишүүний чуулган болон хороодын хуралдаанд оролцох үүрэгтэй холбоотой асуудлыг Дэгийн тухай хуулийн 8 дугаар бүлэг 63-р зүйлээр зохицуулсан байна. Гишүүн нэгдсэн чуулганы хуралдаан болон өөрийн сонгогдсон байнгын хороодын хуралдаан, үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээнэ. Гишүүн өвчин, эсхүл бусад ноцтой шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй бол Парламентын дарга (Үндэсний зөвлөлийн дарга, эсхүл холбогдох байнгын хорооны дарга)-д оролцож чадахгүй шалтгаан болон хугацааг бичгээр мэдэгдэнэ. Парламентын дарга нь гишүүний өргөдлийг хүлээн авч шалтгааныг хүндэтгэн үзэх мөн эсэхийг шийдвэрлэнэ. Гишүүдийн ирцтэй холбоотой асуудлыг сар бүрийн эцсээр шийдвэрлэх бөгөөд гаргасан шийдвэрийг Парламентын дарга гишүүнд мэдэгдэж, Тамгын газар нь тусгай хуульд заасны дагуу арга хэмжээ авч, тухайн гишүүний парламентын бүлэгт мэдэгдэнэ. (Үндсэн хуулийн байгууллагын албан хаагчийн цалин хөлсний тухай хуульд<sup>261</sup> заасан санхүүгийн торгууль) Холбогдох хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний зөвлөл, эсхүл холбогдох байнгын хорооны хуралдааныг 1 сарын хугацаанд 2 удаа хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан гишүүний тухайн сарын цалинг тал хувиар бууруулна.

Парламентын дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд заасны дагуу дараахь зөрчилд парламентын гишүүнд сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

- парламентын хэвийн үйл ажиллагааг тасалдуулсан бол;

а

<sup>260</sup> [https://www.nrsr.sk/web/Static/en-US/NRSR/Dokumenty/rules\\_of\\_procedure.pdf](https://www.nrsr.sk/web/Static/en-US/NRSR/Dokumenty/rules_of_procedure.pdf)

[https://www.nrsr.sk/web/Static/sk-SK/NRSR/Doc/zd\\_rokovaci-poriadok.pdf](https://www.nrsr.sk/web/Static/sk-SK/NRSR/Doc/zd_rokovaci-poriadok.pdf)

<sup>261</sup> <http://www.epi.sk/zz/1993-120>



- өөр бусад гишүүний өмнөөс санал өгсөн бол;
- гишүүн өргөсөн тангаргаа ноцтой зөрчсөн зэрэг орж байна.

Хуралдааныг хэвийн явуулахтай холбоотой зөрчил гаргасан гишүүнд Хуралдаан даргалагч дор дурьдсан арга хэмжээг авна (32 дугаар зүйл). Үүнд:

- хэлэлцэж буй асуудлын сэдвээс гажсан бол сануулах (32.1);
- зөвшөөрөл олгосон минутаас хэтрүүлэн ярьсан бол гишүүний үгийг таслах, гишүүн биеэ зүй бус авч явсан бол шаардлага тавих, шаардлагыг хүлээн аваагүй бол Спикер зөрчил гаргасан гишүүнийг тухайн өдрийн хэлэлцүүлэгт оролцох эрхийг нь хасна. Гишүүн санал хураалтад оролцох эрхтэй байна. (32.2);
- галт зэвсэг, тэсрэх бодис, мэдээ алдуулах төхөөрөмж болон бодис, эсхүл зөөврийн харилцаа холбооны хэрэгслийг Нэгдсэн чуулганы танхимд оруулахыг хориглоно, энэхүү заалтыг зөрчсөн этгээдийн тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг нь хасна (32.3);
- 32.2-3-т заасны дагуу хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүнийг тухай өдрийн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй хуралдааныг тасалсанд тооцно;
- 32.1-3-т заасан шийтгэл хүлээсэн гишүүн шийтгэл ногдуулмагц гомдол гаргах эрхтэй байх бөгөөд гомдлыг Үндэсний зөвлөл шийдвэрлэнэ.

Өөр бусад гишүүний өмнөөс санал өгөх зөрчилд донгодох, торгууль, огцруулах зэрэг шийтгэлүүдийг тусгасан байна.

- санал хураалтад аль ч гишүүнийг өөр бусад гишүүд, эсхүл өөр этгээд орлохыг хориглоно. Өөр гишүүний өмнөөс санал өгсөн гишүүнд 136.2.b-д заасан журмын дагуу шийтгэлийг ногдуулна.(39.6);
- гишүүний бүрэх эрх, халдашгүй байдлын хороо нь гишүүнийг өөр гишүүний өмнөөс санал өгснийг тогтоосон тохиолдолд Үндэсний зөвлөлд гишүүнд донгодох шийтгэл, мөн 1000 еврогийн торгууль ногдуулахыг санал болгоно. (139.2);
- гишүүний бүрэх эрх, халдашгүй байдлын хороо нь гишүүнийг тангаргаа ноцтой зөрчсөн, эсхүл гишүүний өмнөөс санал өгөхийг хориглосныг зөрчсөн нь тогтоодвол гишүүнийг огцруулах санал гаргаж болно. (139.3).

Парламентын гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлаар дараахь зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- Гишүүний бүрэх эрх, халдашгүй байдлын хороо нь парламентын гишүүнийг ёс зүйн алдаа гаргасан гэж тооцсон тохиолдолд зөрчил гаргасан гишүүнд 500 хүртэл еврогийн торгууль ногдуулахыг Үндэсний зөвлөлд санал болгоно.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

*МХШҮХ-ийн Судалгаа, Мэдээлэл Лавлагааны албаны судалгаа:*

1. “Парламентын гишүүдийг чуулган болон байнгын хорооны хуралдаанд биечлэн оролцуулах хууль зүйн зохицуулалт” (СТ-17/207)
2. “Парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгөх талаарх бусад орнуудын хуулийн зохицуулалт, техник, зохион байгуулалт” (СТ-17/403)
3. “Гадаадын зарим орны парламентын гишүүдийн ёс зүйн талаарх зохицуулалт” (СТ-09/204)

*Ном:*

4. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. 2015.
5. Л.Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй. 2010 он
6. Marc Van der Hulst., The parliamentary mandate, A global comparative study. IPU. 2000.

*Хууль тогтоомжийн холбоосууд:*

7. [www.assemblee-nationale.fr](http://www.assemblee-nationale.fr)
8. [http://www.parliament.nz/NR/rdonlyres/65E97824-9EED-447E-832A-E4A4418EAEA2/252153/standingorders2011\\_5.pdf](http://www.parliament.nz/NR/rdonlyres/65E97824-9EED-447E-832A-E4A4418EAEA2/252153/standingorders2011_5.pdf)
9. <http://www.diputados.gov.ar/frames.jsp?mActivo=institucional&p=http://www1.hcdn.gov.ar/dependencias/dip/congreso/regladip.pdf>
10. [www.parlam.kz/ru/Home/status](http://www.parlam.kz/ru/Home/status)
11. [www.lex.uz/](http://www.lex.uz/)
12. [www.kenesh.kg/RU/Articles/1099-Reglament.aspx](http://www.kenesh.kg/RU/Articles/1099-Reglament.aspx)
13. [www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=rus](http://www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=rus)
14. [http://www.congreso.es/portal/page/portal/Congreso/Congreso/Hist\\_Normas/Norm/standing\\_orders\\_02.pdf](http://www.congreso.es/portal/page/portal/Congreso/Congreso/Hist_Normas/Norm/standing_orders_02.pdf)
15. <http://www.ipu.org/pdf/publications/eparl16-en.pdf>
16. [http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs\\_Albanian-Assembly\\_English.pdf](http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf)
17. <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
18. [http://en.camera.it/application/xmanager/projects/camera\\_eng/file/RULES\\_OF\\_PROCEDURE\\_CHAMBER\\_OF\\_DEPUTIES.pdf](http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf)
19. <https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>
20. <http://www.independent.co.uk/news/uk/politics/electronic-voting-in-for-mps-in-parliament-could-improve-accuracy-of-how-votes-are-recorded-a6875766.html>
21. [http://www.legco.gov.hk/general/english/library/stay\\_informed\\_parliamentary\\_news/electronic\\_recording\\_of\\_divisions.pdf](http://www.legco.gov.hk/general/english/library/stay_informed_parliamentary_news/electronic_recording_of_divisions.pdf)
22. <http://www.lop.parl.gc.ca/content/lop/researchpublications/prb0028-e.htm#CBiometrics>
23. <http://www.haaretz.com/news/mks-reject-fingerprint-proposal-for-knesset-voting-1.92126>
24. [http://www.parliament.go.ug/images/stories/constitution/rules\\_2012.pdf](http://www.parliament.go.ug/images/stories/constitution/rules_2012.pdf)
25. <http://www.kontrax.bg/en/>
26. [http://computerworld.bg/inenglish/articles/34695\\_it\\_green\\_technologies\\_healthrelated\\_hightech\\_products\\_and\\_services\\_are\\_key\\_areas\\_for\\_bulgaria](http://computerworld.bg/inenglish/articles/34695_it_green_technologies_healthrelated_hightech_products_and_services_are_key_areas_for_bulgaria)
27. <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>  
[www.constituteproject.org](http://www.constituteproject.org)
28. Règlement de l'assemblée nationale Disponible au format pdf (version mise à jour en novembre 2017), <http://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.asp>
29. The Congress of Parliament [http://www.assemblee-nationale.fr/connaissance/fiches\\_synthese/septembre2012/national-assembly.pdf](http://www.assemblee-nationale.fr/connaissance/fiches_synthese/septembre2012/national-assembly.pdf)
30. Rules of procedure, <http://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap6>

31. Rules of procedure of the National Assembly **January 2007**,  
[http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France\\_Rules\\_Procedure\\_NationalAssembly\\_2007htm/preview](http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview)
32. RÈGLEMENT DU SÉNAT ET INSTRUCTION GENERALE DU BUREAU Mise à jour : 16  
janvier 2018, <https://www.senat.fr/reglement/reglement.html>
33. <http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/p-1/page-10.html#h-37>
34. Парламентын гишүүнийг эгүүлэн татах тухай хууль, Их Британи (Recall of MPs Act 2015)  
<http://www.legislation.gov.uk/ukpga/2015/25>
35. <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
36. <http://archives-democrats-rules.house.gov/archives/rl31382.pdf>

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ<sup>262</sup>

Нэг. Нийтлэг зохицуулалт

Хүснэгт 3

№	Улс	Ямар эрхийн актаар зохицуулагддаг	Ёс зүйн асуудлаарх бүтэц	Хариуцлага тооцох арга, механизм
1	Австрали	Парламентын ёс зүйн кодекс 1998 он, Гишүүдийн дагаж мөрдөх улс төрийн ёс зүйн кодекс (A code of ethics for parliament, Political ethics Codes of conduct Members )	1984 оноос Төлөөлөгчдийн танхимд Сонирхлын хороо байгуулагдан ажиллаж буй	Гишүүдийн ёс зүйн зөрчлийн талаарх санал гомдлыг Сонирхлын хороо хүлээн авч шалган саналаа Танхимын даргад танилцуулна. Түүний зөвшөөрснөөр зөрчил гаргасан гишүүнийг уг хороогоор хэлэлцэн анхааруулах, сануулах, донгодох зэрэг сахилгын шийтгэл ногдуулах, хэрэв гишүүний гаргасан зөрчил гэмт хэргийн шинжтэй байвал түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Танхимын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ
2	АНУ	Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн дагаж мөрдөх кодекстой. 1989 онд баталсан Ёс зүйн дүрмийн шинэчлэлтийн тухай хуулиар Холбооны төрийн нийт албан хаагчдын ёс зүйн талаар баримтлах хэм, хэмжээг нэгдсэн нэг системд оруулсан.	Конгрессын Төлөөлөгчдийн танхимд Ёс зүйн хороотой	Ёс зүйн зөрчил гаргасан гишүүнд анхааруулах, донгодох, торгох зэрэг сахилгын шийтгэл болон гишүүний нэмэлт эрхийг хязгаарлах, бүрэн эрхийг зогсоох хүртэл арга хэмжээ авдаг. Үндсэн хуульд зааснаар шийдвэрийг танхимын гишүүдийн гуравны хоёрын саналаар гаргана.
3	Бельги	Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд гишүүдийн биеэ авч явах дүрмийн талаар заасан байдаг. Төлөөлөгчдийн танхимын гишүүний эрх зүйн байдлын 55, Сенатын гишүүний эрх зүйн байдлын 70 дугаар заалтаар зохицуулагдана	Ёс зүйн асуудал эрхэлсэн тусгай бүтэц байхгүй.	Депутатуудын сахилгын болон ёс зүйн зөрчлийг Мандатын хорооны дэргэдэх Санал гомдлын комисс хүлээн авч Танхимын хуралдаанд танилцуулна. Зөрчил гаргасан депутатын асуудлыг тухайн Танхимын дэгийн дагуу шийдвэрлэнэ.

а\_\_\_\_\_

<sup>262</sup> Гадаадын зарим орны парламентын гишүүдийн ёс зүйн талаарх зохицуулалт, СТ-09/204, Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв

4	Их Британи	Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн дагаж мөрдөх кодекс 1996 он (Code of Conduct of Members, House of Commons), Лордын танхимын гишүүдийн дагаж мөрдөх кодекс 2001 он (House of Lords Code of Conduct )	Ёс зүйн тусгай хороо болон Парламентын ёс зүйн бүрэн эрхт төлөөлөгч ажилладаг	Парламентын гишүүдийн ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн санал, гомдлыг Парламентын ёс зүйн бүрэн эрхт төлөөлөгч урьдчилан шалгаж үндэслэлтэй гэж үзвэл тусгай хороонд илтгэнэ. Тусгай хороо уг асуудлыг авч үзээд холбогдох гишүүнд зохих сахилгын шийтгэл оногдуулах тухай санал гарган Танхимын хурлаар хэлэлцүүлнэ.
5	Канад	Сенат болон Төлөөлөгчдийн танхимын дэг, Канадын парламентын акт, Гэмт хэргийн кодексоор зохицуулагддаг. (Art.34-41 of the Parliament of Canada Act, art.121-122 of the Criminal Code, Standing Orders of the House of Commons and Rules of the Senate)	Ёс зүйн асуудал хариуцсан тусгай хороо, комиссын бүтэц парламентад байхгүй. Харин Засгийн газарт Ёс зүйн зөвлөх ажилладаг	Танхимын гишүүд дэг зөрчсөн тохиолдолд хуралдаан даргалагчийн зүгээс анхааруулах, сануулах, хуралдаанаас гаргах зэрэг сахилгын шийтгэл хүлээлгэх, харин удаа дараа зөрчил гаргах болон хуралдааныг хүндэтгэх шалтгаангүй таслах, санал хураалтад оролцохгүй байх тохиолдолд торгуулийн арга хэмжээ оногдуулдаг.
6	Литва	Улс төрчдийн баримтлах кодекс 2006 он (Code of Conduct of Political Ethics)	Парламентын доод танхим болох Сеймд Ёс зүйн байнгын комисстой	Парламентын гишүүдийн ёс зүйн зөрчлийн талаарх санал гомдлыг Ёс зүйн байнгын комисс хэлэлцэж зохих сахилгын шийтгэл ногдуулах ба уг комиссын гаргасан шийдвэр, дүгнэлтийг “Төрийн мэдээ” товхимолд нийтэлнэ
7	ОХУ	Төрийн Думын депутатын ёс зүйн кодекс 2007 он, Төрийн Дум, Холбооны Зөвлөлийн хуралдааны дэгийн холбогдох зүйл заалтаар зохицуулагддаг	Төрийн Думын мандатын асуудал болон Депутатын ёс зүйн асуудлын Байнгын хороотой	Депутат нь сонгуулийн өмнөх ухуулга сурталчилгаанд хийсэн амлалт, сонгогчидтой байнгын холбоо харилцаатай ажиллах болон иргэдийг хүлээн авч уулзах, тэдний тавьсан санал хүсэлтийг авч үзэхээс зайлсхийхэд зан суртахууны хариуцлага хүлээлгэнэ. Кодексийн хэм, хэмжээг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл хүлээлгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх, Депутатад сахилгын шийтгэл хүлээлгэхдээ хуралдаанд үг хэлэх эрхийг хасах, 10 хүртэл хоног хуралдаанд оролцуулахгүй байх шийтгэл хүлээлгэдэг байна.
8	Өмнөд	Ёс зүйн тусгай кодекс,	Үндэсний хуралд Төрийн	ёс зүйн зөрчил гаргасан

	Солонгос	дүрэм байхгүй. Үндэсний хурлын дэг, Үндсэн хуулийн 43,46 дугаар зүйлээр зохицуулагдана (Rule of conduct of Members of the National Assembly)	албаны ёс зүйн хороотой	депутатад сахилгын шийтгэл ногдуулдаг. Үндсэн хуульд зааснаар гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох асуудлыг нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ
9	Польш	Сеймийн гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, Сенатын дэг болон Үндсэн хуулийн 103, 227 дугаар зүйлээр зохицуулагдана (Code of Conduct of Members of the Deputy Seim, Rule and Regulations of the Senate)	Сеймийн депутатын асуудал ба дэгийн хороо нь ёс зүйн асуудлыг хариуцдаг	Депутатын ёс зүйн талаарх санал гомдлыг Дэгийн хороо авч хэлэлцээд анхааруулах, сануулах, донгодох шийтгэл ногдуулах саналыг танхимын хуралд оруулж шийдвэрлүүлнэ
10	Умард Ирланд	Гишүүний ёс зүйн тухайлсан хууль, кодекс байхгүй, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай (1995) хуулиар бусад төрийн албан хаагчийн нэгэн адил зохицуулагддаг	Депутатуудын сонирхлын хороотой. Мөн Сангийн сайдын харьяалдаг Төрийн албаны комиссын гишүүнд Парламентын доод танхимын дарга, Дээд танхимын нарийн бичгийн дарга ордог	Гишүүдийн ёс зүйн байдлын талаарх санал гомдлыг Төрийн албаны комисс авч үзээд үндэслэлтэй гэж үзвэл Депутатуудын сонирхлын хороонд илтгэнэ. Хороо нь Төлөөлөгчдийн танхимд хэлэлцүүлнэ. Танхимаас сануулга өгөх, депутатын бүрэн эрхийг 30 хүртэл хоногийн хугацаагаар түр зогсоож шүүхэд шилжүүлнэ
11	ХБНГУ	Бундестагийн ёс зүйн дүрэм 1972 он, Бундесратын дэгийн 18 дугаар зүйл (Code of Conduct for Members of the German Bundestag, Rule of Procedure of the Bundesrat),	Гишүүдийн ёс зүйн талаарх асуудлыг Бундестагийн Ерөнхийлөгч эрхлэх чиг үүргийнхээ дагуу хариуцдаг ба бүрэн эрхийн асуудлыг Мандатын комисс хариуцна	Ёс зүйн дүрэм зөрчсөн гишүүдэд сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Тухайлбал, Бундестагийн хуралдааны үед дэг зөрчсөн, бусдыг бүдүүлэг үг хэллэгээр доромжилсон бол хуралдаан даргалагч урьдчилан сануулах, тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасах арга хэмжээ авна. Харин гишүүн гэмт хэрэгт холбогдсон, эсэх асуудлын талаар хэлэлцэхдээ Бундестагийн Ерөнхийлөгчөөс томилогдсон тусгай комисс урьдчилан шалгасны дараа асуудлыг Танхимын хуралдаанаар хэлэлцүүлж нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар бүрэн эрхийг түдгэлзүүлнэ
12	Энэтхэг	Гишүүдийн ёс зүйн тусгай кодекс байхгүй. Парламентын хоёр танхимын тус бүрийн дэгд гишүүдийн парламентад	Ёс зүйн асуудал хариуцсан тусгай бүтэц байхгүй. Шаардлагатай үед хяналтын комисс томилогдон ажиллуулдаг	Хуралдааны дэг зөрчсөн, хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа хуралдаан тасалсан гишүүдэд сахилгын шийтгэл, торгууль



		ажиллах үедээ баримтлах ёс зүйн хэм, хэмжээг зохицуулсан байна (Rule of Procedure and Conduct of Business in Lok Sabha, 222-228, Rule of Procedure and Conduct of Business in Rajya Sabha, 187-203)		хүлээлгэнэ. Харин авлигатай холбогдсон нь шүүхээр нотлогдсон гишүүний мандатыг хүчингүй болгон шүүхээр ял оногдуулна.
--	--	---	--	---

Хоёр. Ёс зүйн зарим тодорхой хэм, хэмжээний талаарх зохицуулалт

Хүснэгт 4

№	Улс	Сонирхлын зөрчил	Давхар ажил эрхлэлт	Бэлэг дурсгал
1	Австрали	Парламентын гишүүдийн санхүүгийн сонирхлыг зохицуулах акт 1992 он, <i>Members of Parliament (financial interests) Act 1992</i> , Үндсэн хуулийн 44 дүгээрт зүйлд зааснаар депутатууд өөрсдийн ашиг сонирхолд хамаарах асуудлаар санал өгөхийг хориглодог	Депутатууд бүрэн эрхийнхээ хугацаанд өөр ажил алба эрхлэх(гишүүн сайдаас бусад нь), сонгуулийн комисст ажиллах, өөртөө ашиг, орлого олох ямарваа гэрээ хэлцэл хийхийг хориглодог. Парламентын гишүүн нь улсын болон улсын өмчийн оролцоотой компаний захирлаас сайн дураараа огцрох ёстой	500 австрали доллараас дээш үнэтэй бэлэг дурсгалыг албан ёсоор авсан бол, 200 австрали доллараас дээш үнэтэй бэлэг дурсгал албан бус шугамаар авсан бол мэдүүлэх ёстой. Төрөл төрөгсөд, дотны найз нөхдийн өгсөн бэлэг дурсгал албан бус бэлэг дурсгалд хамаарахгүй
2	АНУ	Конгрессын гишүүн албан тушаалын хүрээнд ямар нэг шууд ба шууд бус шан харамж авахыг хориглодог	Конгрессын гишүүн нь Холбооны төрийн байгууллагад ямарваа албан тушаал хаших, өмгөөлөгч зэрэг итгэлцэл хүлээх аливаа мэргэжлийн ажил давхар эрхлэхийг хориглодог. Бизнесийн компани, корпорацийн удирдах болон захирлуудын зөвлөлийн гишүүний урамшуулал, нэмэгдэл, бусад хөлс авах нь хориотой. Бусад нэмэгдэл орлогын нийт хэмжээ гишүүний сарын цалингийн 15 хувиас хэтрэхгүй байх	Конгрессын гишүүд эрхэлж буй ажил албаны талаар ямар нэг сонирхлын зөрчил үүсгэж болохуйц бэлэг дурсгалын зүйл авахыг хориглодог. Нэг бүрийн үнэ нь 50 доллараас илүүгүй бэлгийг авч болно. Гэхдээ нэг хүнээс авсан бэлэг дурсгал нь нийт дүнгээрээ 100 доллараас илүүгүй байх ёстой.
3	Бельги	Парламентын гишүүд өөрийн ашиг сонирхлыг хөндсөн, зөрчилтэй асуудал хэлэлцэхэд хуралдаанд урьдчилан мэдэгдэж уг асуудлаарх санал хураалтад оролцохгүй	Парламентын Дээд, Доод танхимын гишүүд нь төрийн өмчид тулгуурласан улсын корпораци, Үндэсний банк, орон нутгийн хөрөнгө оруулалттай компани, Бельгийн төмөр замын компани зэрэг зарим бие даасан улсын компаний удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй.	Парламентын гишүүн өөрийн эрхэлж буй албан үүргийн дагуу гадаад, дотоодын байгууллага, хувь хүнээс авсан бэлэг дурсгалын зүйлээ үнэн зөв мэдүүлэн бүртгүүлэх үүрэгтэй. Бэлэг дурсгалын зүйлд үнийн дүнгийн хязгаарлалт заасан зүйлгүй байна
4	Дани	Фолкетингийн гишүүдийн	Үндэсний банк, санхүүгийн	Парламентын гишүүн нь

		санхүүгийн сонирхол болон ажил эрхлэлтийн зохицуулалтын тухай дагаж мөрдөх журам 2001 онд батлагдсан. Хувийн аливаа компанид удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй.	байгууллага, хувь нийлүүлсэн болон хувийн компанид давхар ажил эрхлэхийг хориглодог	өөрийн албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өгсөн бэлэг дурсгалын зүйлийн талаарх мэдээллийг бүрэн дүүрэн хийх талаар заасан боловч үнийн дүнгийн доод хэмжээний босгыг тогтоогоогүй байна.
5	Их Британи	Парламентаар хэлэлцэх асуудал депутатын сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй тохиолдолд тухайн депутат энэ тухайгаа хуралдаанд мэдэгдэн хэлэлцүүлэгт оролцохгүй	Парламентын гишүүд зэвсэгт хүчин, цагдаа болон төрийн бусад алба, шүүхийн зарим албан тушаал давхар хашихыг хориглодог	Парламентын гишүүн өөрөө болон түүний гэр бүл эрхэлж буй гишүүний албан тушаалтай холбогдуулан бусдаас авсан 125 фунт стерлингээс дээш үнэтэй бэлэг дурсгал, гишүүний цалингийн 0.5 хувиас дээш үнэтэй урамшил, шагналын тухай заавал мэдүүлнэ.
6	Канад	Сонирхлын зөрчлөөс сэргийлэх болон бүрэн эрхийн хугацаа дууссаны дараахь хөдөлмөр эрхлэлтийн тухай кодекс 1994 он  Танхимын тогтоолоор гишүүний ашиг сонирхол хөндсөн аливаа асуудлаар санал өгөхийг хориглодог	Парламентын гишүүн-сайд нь арилжааны компани, санхүүгийн корпорацийн захирал, удирдах бусад албан тушаал болон ҮЭ, мэргэжлийн холбоодын удирдах сонгуульт ажил эрхлэхийг хориглодог. Парламентын гишүүн нь төрийн байгууллагын зарим сонгуульт ажил, шүүгч, орон нутгийн хууль тогтоох байгууллагын гишүүнээр давхар ажиллаж болохгүй	200 канад доллараас дээш үнэтэй бэлэг дурсгал болон бэлэн бус төлбөр тооцооны тухай Ёс зүйн зөвлөхөд мэдэгдэх үүрэгтэй
7	Молдов	2007 онд батлагдсан Сонирхлын зөрчлийн тухай хуулиар депутат нь ашиг хонжоо олох зорилгоор аливаа бизнесийн үйл ажиллагаанд депутатын нэр, эрх мэдлийг ашиглахыг хориглох, үнэт цаас, эд хөрөнгө олох давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулахыг хориглосон	Депутатын бүрэн эрхийн хугацаанд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохгүй бөгөөд сонгогдохоос өмнө ийм төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байсан бол түүнийгээ итгэмжлэгдсэн хүний нэр дээр шилжүүлнэ. Депутат байх хугацаандаа хувийн болон улсын компани, аж ахуй эрхлэгчдийн холбооны төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгуульт ажил үүрэг хүлээхийг хориглоно	Тодорхой зохицуулагдаагүй
8	Өмнөд Солонгос	Төрийн албаны ёс зүйн тухай хуулиар сонирхлын зөрчлийн тухай асуудлыг зохицуулна. Тухайлбал, хэлэлцэж буй хуулийн төсөлтэй холбоотой асуудлаар өөртөө ашигтай байдал буй болгохыг	Депутатууд Засгийн газрын зарим албан тушаал, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагын нөлөө бүхий гишүүн байх, зэвсэгт хүчин болон улсын компани, хөдөө аж ахуй,	Гадаадын иргэн, хуулийн этгээдээс авсан 100.000 воноос дээш үнэтэй бэлэг дурсгал, бэлэн бус төлбөр тооцооны талаар мэдүүлэх үүрэгтэй.

		хориглодог байна	загас агнуурын хоршооллын удирдах албан тушаал, сонгуулийн бусад байгууллагад давхар алба хашихыг хориглодог.	
9	Польш	Үндэсний хурлын хуульд сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна. Харин сонирхлын зөрчилтэй асуудал хэлэлцэхэд хэрхэн оролцохыг тусгайлан заасан зүйл үгүй	Депутат нь Засгийн газрын гишүүн, Төрийн нарийн бичгийн даргаас бусад албан тушаал, шүүгч, прокурор зэрэг албыг давхар хашихыг хориглодог.	Бэлэг дурсгалын зүйлд ямар нэг хязгаарлалт байхгүй байна
10	Умард Ирланд	Сонирхлын зөрчилтэй гишүүд тухайн асуудал хэлэлцэхэд болон санал хураалтаас өмнө мэдэгдэх үүрэгтэй	Зэвсэгт хүчин, цагдаа болон төрийн зарим албан тушаал, Улсын хянан шалгагч, ерөнхий байцаагч болон шүүгчээр ажиллах хориотой	500 фунтээс дээш үнэтэй бэлэг дурсгалыг мэдүүлнэ. Үүнд гэр бүлийн гишүүд, дотнын найз нөхдийн өгсөн бэлэг дурсгал хамаарахгүй
11	ХБНГУ	Сонирхлын зөрчилтэй аливаа асуудлын талаар хуралдаанаар хэлэлцэхээс өмнө гишүүд заавал урьдчилан мэдэгдэх ёстой бөгөөд гагцхүү үүний дараа тухайн асуудал хэлэлцэх, санал хураалтад оролцож болдог	Бундэстагийн гишүүн нь Холбооны муж улсын сайд, Холбооны хянан шалгах газрын гишүүн, шүүгчид болон Бундесратын гишүүн давхар хашиж болохгүй	Нийт дүнгээр 10.0 мянган маркаас дээш үнэтэй бэлэг дурсгалын талаар заавал мэдүүлнэ.
12	Энэтхэг	Сонирхлын зөрчлийн асуудлаар тусгайлан заасан зүйл үгүй	Зэвсэгт хүчин болон төрийн бусад албан тушаал давхар хашихыг хориглодог	Авилгатай тэмцэх тухай хуульд зааснаар төрийн бүх албан тушаалтан хуульд зааснаас бусад аливаа шан харамж авахыг хориглодог

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЯАМДЫН НЭРИЙГ НЭРЛЭН ЗААДАГ ЭСЭХ,  
ЕРӨНХИЙ САЙДЫН ЯАМ БАЙГУУЛАХ ЭРХ БОЛОН ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН  
ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ**

*Г.Алтан-Оч (Ph.D), Г.Билгээ  
Д.Жигваагүнсэл, Д.Халиун*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

- Нэг. Үндсэн хуульд яамдын нэрийг нэрлэн заадаг эсэх
- Хоёр. Үндсэн хуульд Ерөнхий сайд зарим яам байгуулахаар парламентад санал оруулах эрхтэй холбоотой зохицуулалт
- Гурав. Үндсэн хуульд төрийн албаны төв байгууллагын нэрийг нэрлэн заасан, уг байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалт байдаг эсэх

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгаанд Яамдын нэрийг нэрлэн заасан зохицуулалтыг дэлхийн 143 орны Үндсэн хууль, Ерөнхий сайд зарим яам байгуулахаар парламентад санал оруулах эрх болон төрийн албаны төв байгууллагын нэрийг нэрлэн заасан, уг байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалтыг парламентын бүгд найрамдах болон парламентын хаант засагтай 53 орны Үндсэн хуулийн хүрээнд тус тус судалсан болно.

*Судалгааны 1-р хэсэгт:* Яамдын нэрийг нэрлэн заасан зохицуулалтыг дэлхийн 143 орны Үндсэн хуулийг түүвэрлэн судлан үзэхэд 21 орны Үндсэн хуульд яамдын нэрс, тоо, бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой зохицуулалтыг тодорхой байдлаар тусгасан байдлаар тусгагдсан байна. Үүнд:

1	<b>Зарим сайд нарын албан тушаалыг дурьдсан – 4 улс</b>	Босни-Герцеговин, Герман, Ирланд, Швейцар
2	<b>Бусад албан газрын нэрийг дурьдсан – 3 улс</b>	Австри, Герман, Швейцар
3	<b>Яамд, сайд нарын тоог тусгасан – 7 улс</b>	Бельги, Вануату, Ирланд, Науру, Балба, Норвег, Самоа
4	<b>Хуулиар тогтоохоор тусгасан – 5 улс</b>	Грек, Ирак, Латви, Серб, Унгар
5	<b>Яамдын тоо болон чиг үүргийг хуваарилах асуудлыг тодорхой субъектын бүрэн эрхэд тусгасан – 2 улс</b>	Исланд, Дани

Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг нэгтгэн харуулсныг тайлангийн холбогдох хэсгээс үзнэ үү.

*Судалгааны 2-р хэсэгт:* Ерөнхий сайд зарим яам байгуулахаар парламентад санал оруулах эрхтэй холбоотой асуудлыг парламентын бүгд найрамдах болон парламентын хаант засагтай 53 орны Үндсэн хуулийн хүрээнд судалсан болно. Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг нэгтгэн харуулсныг тайлангийн холбогдох хэсгээс үзнэ үү.

*Судалгааны 3-р хэсэгт:* Үндсэн хуульд төрийн албаны төв байгууллагын нэрийг нэрлэн заасан, уг байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалт байдаг эсэх асуудлыг парламентын бүгд найрамдах болон парламентын хаант засагтай 51 орны Үндсэн хуулийн хүрээнд судалсан болно. Судалгаанд хамрагдсан орнуудаас 17 улсад төрийн албаны төв байгууллагын нэр болон эрх зүйн байдлыг тодорхойлон заасан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны холбогдох хэсгээс үзнэ үү.

УИХ-ЫН  
СУДАЛГААНЫ САН

**Нэг. Үндсэн хуульд яамдын нэрийг нэрлэн заадаг эсэх**

№	Улсын нэр	Үндсэн хуульд яамдын нэрийг нэрлэн заасан эсэх
1.	<b>Австри</b>	Тусгагдаагүй, харин “Холбооны Гүйцэтгэх засаглал” 3-р бүлэгт, 1. Холбооны ерөнхийлөгч; 2. Холбооны Засгийн газар; 3. <b>Холбооны аюулгүй байдлын алба</b> ; 4. <b>Холбооны зэвсэгт хүчин</b> ; 5. <b>Холбооны бага, дунд боловсролын газар</b> ; 6. <b>Их, дээд сургуулиуд</b> гэсэн чиг үүргийг тусгайлан тодорхойлж, бүтцийг тусгасан байна.
2.	<b>Балба</b>	76.9-р зүйл. Ерөнхийлөгч Ерөнхий сайдын санал болгосноор оролцооны зарчмыг баримтлан Холбооны <b>Парламентын гишүүд дундаас 25-аас дээшгүй тооны сайд</b> бүхий Сайд нарын зөвлөлийг байгуулна.
3.	<b>Бельги</b>	Тусгагдаагүй <b>96-р зүйл:</b> Хаан нь сайд нарыг томилж, чөлөөлнө. <b>99-р зүйл:</b> Сайд нарын зөвлөл нь <b>15 сайдаас илүүгүй</b> бүрэлдэхүүнтэй байна. Ерөнхий сайдаас бусад нь адил тооны голланд хэлтэй буюу франц хэлтэй гишүүнээс бүрдэнэ.
4.	<b>Босни-Герцеговин</b>	5-р хэсэг 4-р зүйл. Даргалагч нар Сайд нарын зөвлөлийн даргыг дэвшүүлж, Төлөөлөгчдийн танхим зөвшөөрснөөр албан тушаалдаа томилогдоно. Дарга нь <b>Гадаад хэргийн сайд, Гадаад худалдааны сайд</b> болон шаардлагатай бол бусад сайд нарыг дэвшүүлж, Парламент томилно.
5.	<b>Вануату</b>	40-р зүйл. Сайд нарын зөвлөл Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон бусад сайд нараас бүрдэнэ. <b>Сайд нарын тоо</b> /Ерөнхий сайдыг оролцуулан/ <b>Парламентын гишүүдийн дөрөвний нэгээс илүүгүй</b> байна.
6.	<b>Герман</b>	Тусгагдаагүй Харин Холбоо нь өөртөө зайлшгүй байлгах удирдлагын чиг үүргийг тодорхойлсон байна. Үүнд: <b>65а-р зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбооны Батлан хамгаалахын сайд нь Зэвсэгт хүчнийг командлах эрх эдэлнэ. <b>87-р зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбоо нь өөрийн удирдлагын бүтэц бүхий <b>гадаад харилцаа</b> , Холбооны <b>санхүүгийн</b> удирдлага болон 89-р зүйлд заасан хүрээнд Холбооны усан зам болон усан онгоцны тээврийн удирдлагын чиглэлээр өөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Холбооны хуулийн хүрээнд Холбооны <b>хил хамгаалах</b> алба, <b>Цагдаагийн мэдээлэл болон өргөн нэвтрүүлэг, Эрүүгийн цагдаа, Үндсэн хуулийг хамгаалах</b> болон Холбооны нутаг дэвсгэрт хүч хэрэглэх буюу түүнд чиглэсэн бэлтгэл ажлын хүрээнд ХБНГУ-ын <b>гадаадын эрх ашигт заналхийлж буй ажиллагаанаас хамгаалах зорилгоор мэдээ баримт цуглуулах эрх бүхий</b> төв байгууллагуудыг байгуулж болно. <b>87-р зүйлийн 2 дахь хэсэг:</b> Нийтийн эрхзүйн дагуу Холбооны салшгүй хэсэг болох нэг улсын хил хязгаараас давсан <b>нийгмийн даатгалын</b> байгууллагатай байна. <b>87а дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбоо нь <b>батлан хамгаалах зорилгоор зэвсэгт хүчинтэй</b> байна. Түүний бие бүрэлдэхүүний тоо болон зохион байгуулалтын үндсэн бүтэц нь төсвийн төлөвлөлтөөс урган гарна. <b>87д дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Агаарын тээврийн удирдлагыг Холбооны удирдлага хэрэгжүүлнэ. <b>87е дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбооны нутаг дэвсгэр дээрх <b>төмөр замын тээврийн</b> удирдлагыг Холбооны өөрийн удирдлага хэрэгжүүлнэ.



		<b>87ф дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбооны зөвлөлийн зөвшөөрсний дагуу холбооны хуулийн хүрээнд Холбоо нь <b>шуудан болон холбоо харилцааны</b> чиглэлээр нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан болон хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ. <b>88-р зүйл:</b> Холбоо нь Холбооны банк нэртэй валютын болон мөнгөний банк байгуулна.
7.	Грек	81-р зүйл. <b>Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүргийг хуулиар тогтооно.</b>
8.	Дани	14-р зүйл. Хаан Ерөнхий сайд болон бусад сайд нарыг томилж чөлөөлнө. <b>Мөн тэрээр сайд нарын тоо болон Засгийн газрын чиг үүргийг сайд нарт хуваарилах асуудлыг шийднэ.</b>
9.	Израил	5-р хэсэг. с/ Сайд нар нь яамыг хариуцна. <b>Яамгүй сайд байж болно.</b>
10.	Ирак	85-р зүйл. <b>Яамдын зохион байгуулалт, тэдгээрийн чиг үүрэг, чиглэл, сайд нарын эрх үүргийг хуулиар тогтооно.</b>
11.	Ирланд	28-р зүйл. <b>Засгийн газар нь 7-оос доошгүй, 15-аас дээшгүй тооны гишүүнтэй байх</b> ба Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч томилно. 28-7-р зүйл. а/ Ерөнхий сайд (Taoiseach), Шадар сайд (Tánaiste), Сангийн яам хариуцсан Засгийн газрын гишүүн (Department of Finance) нар доод танхимын гишүүн байна.
12.	Исланд	15-р зүйл. Ерөнхийлөгч сайд нарыг томилж, чөлөөлнө. <b>Тэрээр тэдгээрийн тоо болон чиг үүргийг тогтооно.</b>
13.	Итали	95-р зүйл. <b>Зөвлөлийн удирдлага, яамдын тоо, эрх үүрэг болон зохион байгуулалтыг хуулиар тогтооно.</b>
14.	Латви	57-р зүйл. <b>Яамдын тоо, тэдний үүрэг хариуцлагын хамрах хүрээ, түүнчлэн төрийн байгууллагуудын хоорондын харилцааг хуулиар тогтооно.</b>
15.	Маршаллын Арлууд	5-р зүйл. Ерөнхийлөгч нь үүрэгт ажлаа авснаас хойш Засгийн газрын гишүүдэд /хүсвэл өөрийгөө оролцуулан/ <b>Сангийн сайд, Гадаад харилцааны сайд, Харилцаа холбоо, зам тээврийн сайд, Нөөц баялаг ба хөгжлийн сайд, Нийгмийн хамгааллын сайд, Дэд бүтцийн сайдын</b> суудал хуваарилах бөгөөд шаардлагатай гэж үзсэн бусад аль ч яам, эсхүл Засгийн газрын үйл ажиллагааг Засгийн газрын гишүүнд хариуцуулж болно.
16.	Науру	19-р зүйл. Ерөнхийлөгч үүрэгт ажлаа хүлээж авснаас хойш Парламентын <b>4-5 гишүүнийг</b> Кабинетын сайдаар томилно.
17.	Норвег	12-р зүйл. Хаан өөрөө Төрийн зөвлөлийг сонгох ба Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд болон бусад <b>долоогоос доошгүй гишүүнээс</b> бүрдэнэ.
18.	Самоа	32.26-р зүйл. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын саналыг үндэслэн <b>8-аас доошгүй, 12 дээшгүй тооны Парламентын гишүүнийг сайдаар</b> томилно.
19.	Серби	136-р зүйл. Төрийн удирдлагын асуудал <b>болон яамдын тоог хуулиар тогтооно.</b>
20.	Унгар	17-р зүйл. 1. <b>Яамдын жагсаалтыг хуулиар тогтооно.</b> 2. Засгийн газраас тогтоосон үүргийг гүйцэтгэх <b>Яамгүй сайдыг томилж болно.</b>
21.	Швейцар	Тусгааргүй Харин “Эрх мэдэл” гэсэн 2-р бүлэгт, 1.Гадаад харилцаа; 2.Аюулгүй байдал, батлан хамгаалах, иргэний хамгаалалт; 3.Боловсрол, судалгаа шинжилгээ ба соёл; 4.Байгаль орчин ба газар төлөвлөлт; 5.Нийтийн барилга байгууламж ба тээвэр; 6.Эрчим хүч ба холбоо харилцаа; 7.Эдийн засаг; 8.Орон сууц, хөдөлмөр

		эрхлэлт, нийгмийн халамж ба эрүүл мэнд болон 3-р бүлэг: Санхүүгийн систем гэсэн чиг үүргийг тусгайлан тодорхойлж, бүтцийг тусгасан байна.
--	--	---

**Хоёр. Үндсэн хуульд Ерөнхий сайд зарим яам байгуулахаар парламентад санал оруулах эрхтэй холбоотой зохицуулалт**

№	Улсын нэр	Үндсэн хуульд Ерөнхий сайд зарим яам байгуулахаар парламентад санал оруулах эрх мэдэл байдаг эсэх
1.	<b>Австри</b>	Тусгагдаагүй <b>70-р зүйлийн 1 дэх хэсэг:</b> Холбооны канцлерын санал болгосноор Холбооны засгийн газрын гишүүнийг Холбооны ерөнхийлөгч томилно. <b>74-р зүйлийн 1 дэх хэсэг:</b> Хэрэв Үндэсний зөвлөл илээр санал хурааж, Засгийн газар буюу түүний гишүүнд итгэл үл үзүүлсэн бол чөлөөлнө.
2.	<b>Албани</b>	97-р зүйл. 104-105-р зүйлд заасан журмын дагуу томилогдсон Ерөнхий сайд, томилогдсоноос хойш 10 өдрийн дотор Парламентад Сайд нарын зөвлөлийн мөрийн хөтөлбөр, Сайдын нарын зөвлөлийг бүтцийн хамт батлуулахаар оруулна.
3.	<b>Балба</b>	Тусгагдаагүй
4.	<b>Бангладеш</b>	Тусгагдаагүй
5.	<b>Бельги</b>	Тусгагдаагүй <b>96-р зүйл:</b> Хаан нь сайд нарыг томилж, чөлөөлнө. <b>99-р зүйл:</b> Сайд нарын зөвлөл нь 15 сайдаас илүүгүй бүрэлдэхүүнтэй байна. Ерөнхий сайдаас бусад нь адил тооны голланд хэлтэй буюу франц хэлтэй гишүүнээс бүрдэнэ.
6.	<b>Болгар</b>	Тусгагдаагүй
7.	<b>Босни-Герцеговин</b>	Тусгагдаагүй
8.	<b>Бостван</b>	Тусгагдаагүй
9.	<b>Вануату</b>	Тусгагдаагүй
10.	<b>Герман</b>	Тусгагдаагүй <b>64-р зүйл:</b> Холбооны сайдыг Холбооны канцлерын санал болгосноор Холбооны ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.
11.	<b>Грек</b>	Тусгагдаагүй
12.	<b>Дани</b>	Тусгагдаагүй
13.	<b>Доминикан</b>	Тусгагдаагүй
14.	<b>Израил</b>	7-р зүйл. Шинэ Засгийн газрыг байгуулахад Төрийн тэргүүн нь Парламент дахь намын бүлгүүдийн төлөөлөгчидтэй зөвлөлдсөний үндсэн дээр тухайн үүргийг хүлээхэд бэлэн гэдгийг мэдэгдсэн Парламентын гишүүнд Засгийн газрыг байгуулахыг үүрэг болгоно.
15.	<b>Ирак</b>	Тусгагдаагүй
16.	<b>Ирланд</b>	Тусгагдаагүй
17.	<b>Исланд</b>	Тусгагдаагүй
18.	<b>Итали</b>	Тусгагдаагүй
19.	<b>Кирибати</b>	Тусгагдаагүй
20.	<b>Киргиз</b>	Тусгагдаагүй
21.	<b>Латви</b>	Тусгагдаагүй
22.	<b>Ливан</b>	Тусгагдаагүй
23.	<b>Ливи</b>	Тусгагдаагүй
24.	<b>Маврикий</b>	Тусгагдаагүй
25.	<b>Македон</b>	Тусгагдаагүй
26.	<b>Мальт</b>	Тусгагдаагүй

27.	<b>Маршаллын Арлууд</b>	Тусгагдаагүй
28.	<b>Микронез</b>	Тусгагдаагүй
29.	<b>Молдов</b>	Тусгагдаагүй
30.	<b>Науру</b>	Тусгагдаагүй
31.	<b>Нидерланд</b>	43-р зүйл. Ерөнхий сайд болон бусад сайд нарыг Хааны зарлигаар томилж, чөлөөлнө.
32.	<b>Норвег</b>	Тусгагдаагүй
33.	<b>Өмнөд Африк</b>	Тусгагдаагүй
34.	<b>Пакистан</b>	Тусгагдаагүй
35.	<b>Самоа</b>	Тусгагдаагүй
36.	<b>Серби</b>	127-р зүйл. Парламент нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Ерөнхий сайд, ЗГ-ийн гишүүдийг нэгэн зэрэг сонгоно.
37.	<b>Сингапур</b>	Тусгагдаагүй
38.	<b>Словак</b>	Тусгагдаагүй
39.	<b>Словени</b>	Тусгагдаагүй
40.	<b>Сомали</b>	Тусгагдаагүй
41.	<b>Суринам</b>	Тусгагдаагүй
42.	<b>Тринадад Тобаго</b>	Тусгагдаагүй
43.	<b>Тунис</b>	89-р зүйл. Ерөнхийлөгч олонхын санал авсан намын нэр дэвшигчид Засгийн газраа бүрдүүлэх үүрэгч өгч, Парламент дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд болон сайд нарыг томилно.
44.	<b>Унгар</b>	Тусгагдаагүй
45.	<b>Финланд</b>	Тусгагдаагүй <b>61-р хэсэг. Засгийн газрыг бүрдүүлэх:</b> Ерөнхий сайдын санал болгосноор сайдуудыг Улсын ерөнхийлөгч томилно.
46.	<b>Хорват</b>	Тусгагдаагүй <b>110-р зүйл:</b> Улсын ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн хүн Засгийн газрын бүрэлдэхүүний талаар санал гаргаж, мөрийн хөтөлбөрийн хамтаар парламентад өргөн барина. Парламентаас Засгийн газарт итгэл үзүүлбэл, Ерөнхий сайдыг Улсын ерөнхийлөгч томилж, Ерөнхийлөгчийн давхар гарын үсэгтэйгээр засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд томилно.
47.	<b>Чех</b>	Тусгагдаагүй <b>68-р зүйл:</b> Ерөнхий сайдын санал болгосноор сайдыг Ерөнхийлөгч томилно. Засгийн газар томилогдсоноос хойш 30 хоногийн дотор парламент Засгийн газарт итгэл үзүүлэх эсэхээр санал хурааж баталгаажуулна.
48.	<b>Чрна Гора</b>	Тусгагдаагүй <b>103-р зүйл:</b> Ерөнхийлөгчийн санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигч нь засгийн газрын хөтөлбөр болон бүрэлдэхүүний талаарх саналаа Парламентад өргөн барьж, шийдвэр гаргуулна.
49.	<b>Швед</b>	Тусгагдаагүй <b>6-р бүлгийн 3-р хэсгийн 6-р зүйл:</b> Ерөнхий сайд сайдуудын нэрийг парламентад нэн даруй өргөн барина.
50.	<b>Швейцар</b>	Тусгагдаагүй Холбооны гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллага буюу Засгийн газар нь Холбооны зөвлөл бөгөөд тэр нь 7 гишүүнтэй. Холбооны зөвлөлийн гишүүнийг Холбооны чуулганаас 4 жилийн хугацаагаар сонгоно. Холбооны ерөнхийлөгч нь Холбооны зөвлөлийг удирдана. Холбооны зөвлөлийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг Холбооны чуулганаас өөрийн гишүүдийнх нь дундаас 1 жилийн

		хугацаагаар сонгоно.
51.	<b>Энэтхэг</b>	Тусгагдаагүй
52.	<b>Эстони</b>	Тусгагдаагүй <b>89-р зүйл:</b> Ерөнхий сайдын санал болгосноор засгийн газрын бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч томилно. <b>90-р зүйл:</b> Ерөнхий сайдын саналаар Ерөнхийлөгч засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.
53.	<b>Япон</b>	Тусгагдаагүй

**Гурав. Үндсэн хуульд төрийн албаны төв байгууллагын нэрийг нэрлэн заасан, уг байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалт байдаг эсэх**

№	Улсын нэр	Үндсэн хуульд Төрийн албаны төв байгууллагын нэрийг заасан, уг байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон зохицуулалт байдаг эсэх
1.	<b>Австри</b>	Тусгагдаагүй Гэхдээ төрийн албан хаагч л зөвхөн Үндэсний зөвлөл болон Холбооны зөвлөл ("Англи бус" парламентын 2 танхим. Г.А.)-ийн гишүүнээр сонгогдох эрхтэй. Үндсэн албан байгууллагаасаа цалин авна. <b>58-р зүйл:</b> Холбооны зөвлөлийн гишүүн нь үүрэгт ажлын хугацааны туршид илгээсэн улсынхаа хурал чуулганы гишүүний бүрэн эрхийг эдэлнэ. <b>59а дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Төрийн албан хаагч нь Үндэсний зөвлөлийн гишүүнээр сонгогдохоор өрсөлдөж байгаа бол санал цуглуулах хугацаанд нь ажлаас нь чөлөө олгоно. <b>2 дахь хэсэг:</b> Үндэсний зөвлөл болон Холбооны зөвлөлийн гишүүнээр сонгогдсон төрийн албан хаагч нь өөрийн хүсэлтээр гишүүний үүргээ гүйцэтгэх хугацаанд ажлаас чөлөөлөгдөх буюу эсхүл халагдана. Хэрэв чөлөөлөгдсөн бол үндсэн ажлын цалингийн 75% хүртэлх хэмжээтэй нөхөн олговор үндсэн байгууллагаасаа авна. Халагдсан бол цалин хөлс авахгүй. <b>59б дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</b> Үндэсний зөвлөл буюу Холбооны зөвлөлийн гишүүнээр сонгогдсон төрийн албан хаагчид олгох цалин хөлсний асуудалд хяналт тавих зорилгоор парламентын тамгын газрын дэргэд Комисс ажиллуулна.
2.	<b>Албани</b>	Тусгагдаагүй
3.	<b>Балба</b>	<b>242-р зүйл. Төрийн албаны комисс /Public Service Commission/</b> 1. Төрийн албаны комисс нь Дарга болон 4 гишүүнээс бүрдэнэ. 2. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн зөвлөлийн саналыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн дарга болон гишүүнийг томилно. 3. Төрийн албаны комиссын 50-иас доошгүй хувийн гишүүд нь төрийн албанд 20-иос доошгүй жил ажилласан байх, бусад гишүүд нь шинжлэх ухаан, технологи, урлаг, уран зохиол, эрх зүй, төрийн удирдлага, социологи зэрэг салбарт судалгаа хийсэн, багшилдаг, эсхүл томоохон хувь нэмэр оруулсан, нэр төртэй этгээд байна. 4. Төрийн албаны комиссын дарга болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа томилогдсоноос хойш 6 жил байна. 5. 2-р заалтын дагуу томилогдон Дарга болон гишүүдийг дахин томилохгүй. <b>243-р зүйл. Төрийн албаны комиссын чиг үүрэг, эрх хэмжээ</b> 1. Төрийн албаны комисс нь төрийн албанд сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтыг зохион байгуулна. /Төрийн албан хаагч нь Цэрэг, холбооны цагдаа, эсхүл зэвсэгт цагдаа болон төрийн албан хаагчийн албанд тушаалд хамрахгүй.
4.	<b>Бангладеш</b>	2-р бүлэг. Төрийн албаны комисс 137-р зүйл. Комисс байгуулах

		<p>Бангладеш Улсад нэг болон түүнээс дээш тооны төрийн албаны комисс байгуулахыг хуулиар тогтооно. Комисс бүр дарга болон хуулиар тогтоосон тооны бусад гишүүдээс бүрдэнэ.</p> <p>138. Гишүүдийг томилох</p> <p>1.Төрийн албаны комисс тус бүрийн дарга, бусад гишүүдийг Ерөнхийлөгч томилно:</p> <p>Комиссын гишүүдийн талаас доошгүй хувь нь Бангладешийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан аливаа Засгийн газрын үйл ажиллагаанд 20-иос дээш жил ажилласан хүмүүс байна.</p> <p>2. Төрийн албаны комиссын дарга болон гишүүдийн үйл ажиллагааны нөхцөлийг хуульд заасны дагуу Ерөнхийлөгч зарлигаар тогтооно.</p> <p>139 дүгээр зүйл.</p> <p>1.Төрийн албаны комиссын дарга, бусад албаны бусад гишүүний бүрэн эрхийн хугацаа энэ зүйлд заасны дагуу, түүний албан тушаалд томилогдсон өдрөөс хойш тав (5) жилийн дараа, эсхүл жаран таван нас хүрснээр, /аль нь түрүүлснээр/ дуусгавар болно.</p> <p>2. Комиссын дарга болон бусад гишүүдийг албан тушаалаас огцруулах асуудлыг Дээд шүүхийн шүүгчтэй адил зарчим, үндэслэлээр шийдвэрлэнэ.</p> <p>3. Төрийн албаны комиссын дарга болон бусад гишүүн нь огцрох өргөдлөө бичгээр Ерөнхийлөгчид гаргана.</p> <p>4. Төрийн албаны комиссын гишүүн нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд дахин төрийн алба хашихгүй. Дараах нөхцөлтэй байна.</p> <p>А.а дарга нь чөлөөлөгдсөн бол дахин нэг удаа улиран томилогдох эрхтэй байна;</p> <p>В.а гишүүн (даргаас бусад) дахин нэг удаа улиран томилогдох, эсхүл даргаар томилогдох эрхтэй байна.</p> <p>140-р зүйл Комиссын чиг үүрэг_1. Төрийн албаны комиссын чиг үүрэг: а / Бүгд Найрамдах Улсын төрийн албанд сонгон шалгаруулахдаа мэргэжлийн шалгалт авна;</p> <p>б/ Төрийн албаны комисс Ерөнхийлөгчид нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх ба (2), эсхүл комиссын ерөнхийлөгч түүнтэй холбоотой чиг үүргийн асуудлаар зөвлөлдөх,</p> <p>с/ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.</p> <p>2. Парламентаас гаргасан хууль тогтоомж, журмын дагуу (үл нийцэх) комисстой зөвлөлдөн Ерөнхийлөгч шийдвэрийг гаргаж болно. Ерөнхийлөгч комисстой хамт зөвшилцөлд хүрэх хэд хэдэн асуудлууд байна. Үүнд:</p> <p>а/ Бүгд Найрамдах Улсын хэмжээнд ажилд авахад мэргэжилтэй холбоотой асуудалд тавигдах шаардлага;</p> <p>б/ тухайн төрийн албанд томилохдоо дагаж мөрдөгдөх зарчмууд, тухайн салбарт сэлгэн ажиллуулах, томилолт ба урамшуулал авах, өөрөөр хэлбэл: томилолт авсан төрийн албан хаагч / нэр дэвшигч/ сэлгэн ажиллуулах тохирох;</p> <p>г/ хувь хүний эрхтэй холбоотой нөхцөл, болзол; д / төрийн албаны сахилга бат, эмх журам зэрэг болно.</p>
5.	<b>Бельги</b>	Тусгагдаагүй
6.	<b>Болгар</b>	<p>116-р зүйл. 1.Төрийн албан хаагч нь үндэсний ашиг сонирхол, хүсэл зоригийг хэрэгжүүлнэ. Албан үүргээ хэрэгжүүлэх үедээ хуульд захирагдаж, улс төрийн хувьд төвийг сахина.</p> <p>2. Төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх нөхцөл, улс төрийн нам болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллах, ажил хаях эрх нь хуулиар тодорхойлогдоно.</p>
7.	<b>Босни-Герцеговин</b>	Тусгагдаагүй

8.	<b>Ботсван</b>	109-р зүйл Төрийн албаны Комисс 1.Ботсван Улсын Төрийн албаны Комисс нь Дарга, 2-оос доошгүй, 4-өөс дээшгүй тооны гишүүдээс бүрдэнэ. 2.Төрийн албаны Комиссийн гишүүдийг Ерөнхийлөгч томилно. 13. Комиссийн үйл ажиллагааг хуулиар тогтоох ба хуульд заасны дагуу Комисс үйл ажиллагааны журмаа өөрөө тогтоож болно. 15. Комиссийн бүх шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар гаргана.
9.	<b>Вануату</b>	59-р зүйл. Төрийн албаны зөвлөл нь 5 гишүүдээс бүрдэх ба Ерөнхийлөгч Ерөнхий сайдтай зөвлөлдөн 3 жилийн хугацаагаар томилно. 60-р зүйл Төрийн албаны комиссын чиг үүрэг 1.Төрийн албаны комисс нь төрийн албан хаагчийг томилох, дэвшүүлэх, Вануату Улсад, эсхүл гадаадад суралцах хүмүүсийг сонгон шалгаруулна. Үүний тулд шалгалтыг зохион байгуулж болно. 2.Комисс нь төрийн албан хаагчдын сахилга дэг журмыг хангуулна. 3. Комисс нь шүүгч (зэвсэгт хүчин, цагдаа, сургалт явуулах)-д холбоотой асуудлыг хамаарахгүй. 4.Комисс нь хараат бус байх ба үйл ажиллагаагаа бие даан явуулна.
10.	<b>Герман</b>	Тусгагдаагүй
11.	<b>Грек</b>	2-р бүлэг. Захиргааны байгууллагын эрх зүйн байдал 103-р зүйл. 1.Төрийн албан хаагч нь Үндсэн хуульдаа тангараг өргөж, эх орондоо хүчин зүтгэх төрийн хүсэл зорилгыг гүйцэтгэгч байх бөгөөд ард иргэдэд үйлчилнэ. Төрийн албан хаагчид тавигдах шаардлага болон төрийн албанд томилох асуудлыг хуулиар тогтооно. 2.Хэнийг ч хуульд заагаагүй аливаа албан тушаалд томилохыг хориглоно.
12.	<b>Дани</b>	Тусгагдаагүй
13.	<b>Доминикан</b>	6-р бүлэг Төрийн байгууллага 84-р зүйл. Төрийн албаны комисс 11. Комиссын гишүүн нь өөрийн албан үүргээ гүйцэтгэх, албан тушаалын тангараг өргөсөн байна. 12. Комисс нь энэхүү Үндсэн хуулийн дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, бусдын эрх мэдэл, удирдлаганд орж болохгүй. 13.Комиссыг журмаар зохицуулах ба Ерөнхий сайдын зөвшөөрөлтэйгээр эрх мэдэл, албан тушаалтан, Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой.
14.	<b>Израил</b>	Тусгагдаагүй
15.	<b>Ирак</b>	Тусгагдаагүй
16.	<b>Ирланд</b>	Тусгагдаагүй
17.	<b>Исланд</b>	Тусгагдаагүй
18.	<b>Кирибати</b>	<b>4.49. Төрийн зөвлөл</b> 1. Төрийн Зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн дарга, Ерөнхий шүүгч, хурлын дарга байх хугацаандаа ажиллаж байгаа хүмүүсээс бүрдэнэ. 2. Бэрэтитэнти (Ерөнхийлөгч) нь албан ажлаасаа түдгэлзсэн тохиолдолд уг Үндсэн хуулийн 33-р хэсгийн (b) эсвэл (c) мөрөнд зааснаар Төрийн зөвлөл нь Бэрэтитэнти болон бусад Засгийн Газрын Гүйцэтгэх Байгууллагуудын үүргүүдийг Бэрэтитэнтигийн дараагийн сонгуулиар сонгогдсон хүн ерөнхий сонгуулийн дараа ажлаа хүлээж авах хүртэл гүйцэтгэнэ.
19.	<b>Киргиз</b>	Тусгагдаагүй
20.	<b>Латви</b>	Тусгагдаагүй
21.	<b>Ливан</b>	4-р бүлэг. <b>Сайд нарын Зөвлөл</b> 65-р зүйл. Гүйцэтгэх эрх мэдлийг Сайд нарын Зөвлөлд хэрэгжүүлэх бөгөөд Зэвсэгт хүчин түүнд захирагдана. Дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:



		65.3 Төрийн албан хаагчдыг хуульд заасны дагуу томилж, чөлөөлж, огцруулна.
22.	<b>Ливи</b>	Тусгагдаагүй
23.	<b>Маврикий</b>	88-р зүйл. <b>Төрийн албаны комисс</b> Төрийн албаны комисс нь Ерөнхийлөгчийн томилсон 2 дэд арга, бусад 4 комиссараас бүрдэнэ. 89-р зүйл. <b>Төрийн албан хаагчийг томилох</b> Энэхүү Үндсэн хуулийн дагуу төрийн алба тушаалд ажиллах хүмүүсийг томилох (төрийн албан хаагчийн томилгоог батлах), чөлөөлөх, албан тушаалтан буюу албан хаагчдад сахилгын арга хэмжээ авах, тэдгээрийг албан тушаалаас нь чөлөөлөхийг Төрийн албаны комисст шийдвэрлэнэ.
24.	<b>Македон</b>	Тусгагдаагүй
25.	<b>Мальт</b>	<b>109-р зүйл. Төрийн албаны комисс</b> 1. Мальт Улсын Төрийн албаны комисс нь дарга, дэд даргын, нэгээс гурав хүртэлх гишүүнээс бүрдэнэ. 2. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийг ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Сөрөг хүчний удирдагчидтай зөвшилцсөний дараа томилно. 3. Парламентын нарийн бичгийн дарга, төлөөлөгч, эсвэл төлөөлөгчдийн танхимд сонгогдох нэр дэвшигч, орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллагын гишүүн эсвэл төрийн албан тушаалтан нь Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр сонгогдохгүй. 4. Төрийн албаны комиссын гишүүн нь гишүүнээр ажилласан сүүлийн өдрөөс эхлэн 3 жилийн дотор төрийн аливаа албан тушаалд томилогдох эсвэл ажиллах эрхгүй байна. 6. Төрийн албаны комиссын гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөмжийн дагуу Ерөнхийлөгч чөлөөлөх ба ингэхдээ гагцхүү албан тушаалаа хаших боломжгүй болсон (Оюун ухаан, бие махбодийн болон бусад аливаа шалтгаанаар), эсхүл сахилга бат алдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлнө. 7. Төрийн албаны комиссын гишүүний албан тушаал сул, эсхүл гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон шалтгаанаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зөвлөмжийн дагуу, Сөрөг хүчний удирдагчтай зөвлөлдсөний дараа комиссын түр гишүүнээр ажиллах чадвартай хүнийг томилж болно.
26.	<b>Маршаллын Арлууд</b>	5-р хэсэг. Төрийн албаны комисс 5-р хэсэг. 1. Маршаллын арлуудын төрийн албаны комисст нь Дарга болон 2 гишүүнээс бүрдэнэ. 2. 1. Төрийн албаны зөвлөлийн дарга, бусад гишүүдийг Засгийн газар томилж, Парламент зөвшөөрч тогтоолоор батламжилна. 3. Төрийн албаны комиссын гишүүдийн доод тал нь 2 гишүүн нь БНУлсын иргэн байх ба, зөвлөлийн гишүүнээр томилогдохдоо БНУлсын иргэн байсан бол харьятаас гарсан ч албан тушаалаас чөлөөлөхгүй. 4. Парламентын гишүүн төрийн албаны комиссын гишүүн байхгүй, эсхүл комиссын гишүүнээр томилогдохгүй. 1. Төрийн албаны комиссын гишүүн нь аль ч төрийн албыг зэрэг хашихгүй. 2. Төрийн албаны комиссын гишүүнийг улируулан томилох эрхтэйгээр 3-аас дээшгүй жилээр томилно.
27.	<b>Микронез</b>	Тусгагдаагүй
28.	<b>Молдов</b>	Тусгагдаагүй
29.	<b>Науру</b>	68-р зүйл. Төрийн албанд томилох 1. 69-р зүйлд зааснаас бусад тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга дараах эрхийг хэрэгжүүлнэ: а. Төрийн албан ажиллах этгээдийг томилох;

		<p>б. Эдгээр албан ажиллаж буй этгээдэд сахилгын хяналт тавих; в. эдгээр этгээдийг ажлаас чөлөөлөх.</p> <p><b>69-р зүйл. Төрийн албаны зөвлөл байгуулах Парламентын эрх</b> Парламент нь 68.1-2-р заасан Ерөнхий нарийн бичгийн даргын эрхийг Ерөнхий нарийн бичгийн даргаар даргалуулсан, хоёроос доошгүй Парламентын гишүүн бус бүрэлдэхүүн бүхий Төрийн албаны зөвлөлд шилжүүлж болно.</p>
30.	<b>Нидерланд</b>	<p>3-р зүйл. Нидерланд Улсын иргэд төрийн албанд томилогдох адил тэгш эрхтэй байна.</p> <p>109-р зүйл Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Парламентаас баталсан хуулиар тогтооно. Төрийн албан хаагчдын хөдөлмөр хамгаалал, төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.</p>
31.	<b>Норвег</b>	Тусгагдаагүй
32.	<b>Өмнөд Африк</b>	<p>196-р зүйл. <b>Төрийн албаны комисс /Public Service Commission/</b></p> <p>6. БНУ нь Төрийн албаны комисстой байна.</p> <p>7. Комисс нь бие даасан, хараат бус байх ба эрх үүргээ хэрэгжүүлэхдээ айдасгүй, төрийн удирдлагын үр дүнтэй, үр ашигтай, төрийн албан дахь ёс зүй, мэргэжлийн өндөр стандартыг хангуулж ажиллана. Комиссын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.</p> <p>8. Төрийн бусад байгууллагууд хууль тогтоох болон бусад арга замаар Комиссын бие даасан, хараат бус, үр дүнтэй байдал, нэр төрийг хангахад Комисст туслалцаа үзүүлж, хамгаална. Аль ч иргэн, төрийн байгууллага Комиссын үйл ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулахыг хориглоно.</p> <p>5. Комисс нь үйл ажиллагаагаа Парламентад тайлагнана.</p> <p>7. Комисс нь 14 комиссартай байх ба тэдгээрийг Ерөнхийлөгч дараах байдлаар томилно.</p> <p>- 5 комиссарыг 8а заалтад заасны дагуу Парламент, - 8б заалтад заасны дагуу мужийн Засгийн газрын тэргүүний санал болгосноор /9 мужаас/ тус бүр 1 комиссарыг томилно.</p>
33.	<b>Пакистан</b>	<p>242-р зүйл. Төрийн албаны комисс <b>Public Service Commission</b></p> <p>- Парламент нь Холбооны, Мужийн парламент нь мужийн Төрийн албаны комисс байгуулах асуудлыг хуулиар тогтооно.</p> <p>1а. Холбооны комиссын даргыг Ерөнхий сайдын саналыг үндэслэн Ерөнхийлөгч томилно.</p> <p>1б. Мужийн комиссыг мужийн сайдын саналыг үндэслэн Засаг дарга томилно.</p>
34.	<b>Самоа</b>	<p>84-р зүйл. Төрийн албаны комисс нь гурваас дээшгүй гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн Ерөнхийлөгч Ерөнхий сайдын саналыг үндэслэн томилох ба нэг гишүүнийг даргаар томилно.</p> <p>87-р зүйл. Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүний нөөцийн төлөвлөлт,</li> <li>2. Хүний нөөцийн бодлого,</li> <li>3. Төрийн албаны хүний нөөцийн хяналт, үнэлгээ</li> </ol> <p>б. Хуульд заасан бусад эрх</p>
35.	<b>Серб</b>	Тусгагдаагүй
36.	<b>Сингапур</b>	<p>105-р зүйл. Төрийн албаны комисс <b>/Public Service Commission/</b></p> <p>1. Төрийн албаны комисс нь дарга болон 5-аас доошгүй 14-өөс дээшгүй тооны гишүүдээс бүрдэх ба Ерөнхийлөгч Ерөнхий сайдтай зөвшилцөн томилно.</p>
37.	<b>Словак</b>	Тусгагдаагүй
38.	<b>Словени</b>	<p>120-р зүйл. Төрийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаа</p> <p>Төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, эрх мэдэл, албан тушаалтныг томилох асуудлыг хуулиар тогтооно.</p>

		Захиргааны байгууллагууд нь Үндсэн хууль, болон бусад хууль тогтоомжийг үндэс болгон бие даан ажиллана. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас иргэд, байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулна.
39.	<b>Сомали</b>	Тусгагдаагүй
40.	<b>Суринам</b>	Тусгагдаагүй
41.	<b>Тринадад Тобаго</b>	Тусгагдаагүй
42.	<b>Тунис</b>	Тусгагдаагүй
43.	<b>Унгар</b>	23-р зүйл. Унгар Улсын иргэн бүр өөрийн чадвар, мэргэжил, боловсролд тохирсон төрийн алба хаших эрхтэй байна. Улс төрийн намын гишүүн, эсхүл албан тушаалтны эрхлэхийг хориглосон төрийн албан тушаалыг хуулиар тогтооно.
44.	<b>Финланд</b>	Тусгагдаагүй
45.	<b>Хорват</b>	Тусгагдаагүй
46.	<b>Чех</b>	Тусгагдаагүй
47.	<b>Чрна Гора</b>	Тусгагдаагүй
48.	<b>Швед</b>	Тусгагдаагүй
49.	<b>Швейцар</b>	Тусгагдаагүй
50.	<b>Эстони</b>	Тусгагдаагүй
51.	<b>Япон</b>	15-р зүйл. Ард түмэн нийтийн албан тушаалтнаа сонгох болон огцруулах салшгүй эрхтэй. Бүх нийтийн албан тушаалтнууд нь аль нэг бүлэгт бус олон нийтэд бүхэлд нь үйлчлэх үүрэгтэй. Нийтийн албан тушаалтны сонгуульд оролцох эрхээр бүх насанд хүрсэн иргэн хангагдсан байна. Бүх сонгуульд нууц санал хураалтын зарчмыг зөрчиж болохгүй. Сонгогч нь өөрийн хийсэн сонголтынхоо төлөө нийтийн болон хувийн сэдэлтээр хариуцлага хүлээхгүй. 16-р зүйл. Хүн бүр хохирлоо нөхөн төлүүлэх, нийтийн албан тушаалтныг огцруулах, хууль, тогтоол гаргах, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад асуудлаар тайван замаар гомдол гаргах эрхтэй ба аливаа этгээдийг энэхүү гомдол гаргасных нь төлөө ялгаварлан гадуурхахыг хориглоно. 17-р зүйл. Нийтийн албан тушаалтнуудын хууль бус үйлдлийнх нь учирсан хохирлыг хохирсон этгээд төрийн болон нийтийн байгууллагад хохирлыг барагдуулах тухай гомдол гаргах эрхтэй.